

ААРОНЫ ПРИСТИЙН ЗЭРЭГТЭН

Гарын авлага 2

ААРОНЫ ПРИСТИЙН ЗЭРЭГТЭН

Гарын авлага 2

© 1993, 1994 by Intellectual Reserve, Inc. (онд хэвлэв).
Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм
Бүх эрхийг эдэлнэ.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.
Англи эхийн зөвшөөрөл: 5/94
Орчуулгын зөвшөөрөл: 5/94
Aaronic Priesthood: Manual 2-ын орчуулга

Агуулга

Хичээлийн Дугаар ба Гарчиг	Хуудас
Зөвлөхөд хандах нь	v
1 Би Хэн Бэ?	1
2 Тэнгэр дэх Эцэгээ Мэдэх нь	4
3 Есүс Христэд Итгэх Итгэл	8
4 Ариун Сүнстэй Хамт Байх нь	12
5 Сонголт	15
6 Христийн Адил Үйлчлэл	18
7 Гэр Бүлүүдийн Мөнхийн Чухал Байдал	23
8 Сүнслэг Байдал	26
9 Наманчлал ба Есүс Христийн Цагаатгал	30
10 Судруудаас Суралцах нь	34
11 Сатан, Түүний Уруу Таталтууд	39
12 Залбирал	43
13 Мацаг Барилт	46
14 Бурханд Дуулгавартай Байх нь	50
15 Гэрээнүүдийг Дагаснаас Ирэх Өргөмжлөл	54
16 Аравны Нэг ба Өргөлүүд	58
17 Патриархын Адислалууд	62
18 Аароны Пристийн Зэргийн Багшийн Үүрэг	67
19 Харууссан Зүрх ба Гэмшсэн Сэтгэл	71
20 Ариун Ёслолыг Гүйцэтгэх нь	75
21 Мелкизэдэк Пристийн Зэрэгт Бэлтгэх нь	77
22 Гэрийн Патриархын Удирдагч	81
23 Номлолын Дадлага Бэлтгэл	87
24 Хөдөлмөрөөс Ирэх Адислалууд	91
25 Хувийн Сахилгаар Цэвэр Ариун Байх нь	95
26 Зохистой Бодлууд	101
27 Их Эзэний Эрүүл Мэндийн Хууль	106
28 Хүндэтгэлийн Өдөр	110
29 Амьдралын Зорилго	114
30 Энэрэл	119
31 Уучлал	124
32 Сүнсний Бэлгүүдийг Хөгжүүлэх нь	128

33	Суралцахыг Эрмэлзэх нь	133
34	Үлгэр Жишээний Хүч	137
35	Хуулийг Сахих, Хүндэтгэх, Дэмжих	141
36	Бүх Зүйлд Талархлаа Илэрхийл	144
37	Эмэгтэй Хүний Үүргийг Ойлгох нь	148
38	Шударга Бус Дэлхийд Шударгаар Амьдрах нь	151
39	Ёс Суртахууны Зориг	155
40	Уруу Таталтаас Зайлсхийх ба Даван Туулах	159
41	Ариун Ёслол: Түүнийг Дурсан Санахад Зориулагдсан	163
42	Ах Нарыг Дагах нь	166
43	Номлолд Сүнслэг Байдлаар Бэлтгэх нь	171
44	Ариун Сүмийн Гэрлэлтэнд Одооноос Бэлтгэх нь	176
45	Үр Ашигтай Гэрийн Багшлалт	180
46	Мэдээллийн Хэрэгслийн Зохисгүй Нөлөөнөөс Зайлсхийх	184
47	Цэвэр Боловсон Хэл Яриа	190
48	Зөв Шударга Жишгүүдийг Баримтлах нь	196
49	Шударга ба Зарчимч Байдал	201
50	Тахир Дутуу Хүмүүсийг Үнэлж, Урамшуулах нь	205
51	Зөвлөхөд хандах нь: Ерөнхий Чуулганы Яриануудаар Хичээл Бэлтгэх нь	209
	Зурагнууд	213

Зөвлөхөд Хандах нь

Эдгээр хичээлүүд нь залуу эрэгтэйчүүдэд сайн мэдээнээс суралцаж, Аароны Пристийн зэрэгтний цуглаануудыг тэдэнд сонирхолтой утга учиртай болгоход туслах зорилготой юм. Та энэхүү гарын авлагыг пристийн, багш нарын болон диконуудын чуулгуудад тус бүрт нь, эсвэл гурван чуулгын бүлгүүдэд бүгдэд нь заахад ашиглаж болно. Та хичээл тус бүрийг залбирч бэлтгэснээр залуу эрэгтэйчүүдэд Аароны Пристийн Зэрэг дэх дуудлагаа хэрхэн эрхэмлэн биелүүлж, Бурханы хөвгүүд болоход нь тусалж чадна (С ба Г 84:26–42 ба Иохан 1:12–13-ыг үз).

Тус гарын авлагад нэг жилийн дотор зааж амжихааргүй олон хичээл буюу тавин нэгэн хичээл орсон байгаа. Та хичээл заахдаа залуу эрэгтэйчүүдийнхээ хэрэгцээнд нийцэх хичээлүүдийг залбирч сонгоорой. Зарим хичээлүүд нь пристүүдэд илүүтэй тохирч, зарим нь диконууд, багш нарт илүү тохирч болно.

ҮР ДҮНТЭЙ ЗААХЫН ТҮЛХҮҮР

Тус гарын авлагын хичээлүүдийг сайн ашиглахын тулд үр дүнтэй заах дараах түлхүүрүүдийг хэрэглэнэ үү:

1. *Аврагч дээр төвлөр.* Та залуу эрэгтэйчүүдэд Христийн шавь байх тухай зааж байна. Тэдэнд зөвхөн пристийн зэрэгтний үүрэг эсвэл жинхэнэ зарчмыг заах нь хангалтгүй; энэ нь Түүнд итгэх итгэл, хайрын улмаас өөрийнх нь шавь нарын хувьд Их Эзэний хийлгэхийг хүсэж байгаа зүйлийг ойлгохыг тэднээс шаарддаг юм.
2. *Сүнсийг эрэлхийл.* Эдгээр хичээлийг бэлтгэж заахдаа Тэнгэрлэг Эцэгийн тусламжийг гуй. Сүнс та нарт итгэлийн залбирлаар өгөгдөх болно, та нар Сүнсийг эс хүлээж авах бөгөөс хичээлийг бүү заа гэж Их Эзэн заасан билээ (С ба Г 42:14). Та нар Христийг гэрчилж, шавь байх тухай заан, түүний шавь нарын хувьд туршлагаа гэрчилж, заах үед Сүнс хамгийн их хүчтэй байх болно.
3. *Чуулгын ерөнхийлөгчдийг оролцуул.* Аароны Пристийн Зэрэгтний чуулгын ерөнхийлөгчид чуулгынхаа гишүүдэд пристийн зэрэгтнүүдийн үүрэг хариуцлагыг заах ёстой (С ба Г 107:85–87-г үз). Чуулгын ерөнхийлөгчид таны тусламжтайгаар ямар хичээлүүдийг ямар дарааллаар заахыг шийднэ. Чуулгын нарийн бичгийн дарга нар хичээлүүдийг давхардуулахгүйн тулд бүртгэл хөтөлж байх бөгөөд үүнийг хуанли дээр тэмдэглэж болно.
4. *Залуу эрэгтэйчүүдийг хайрла.* Зааж буй залуу эрэгтэй бүрийг хайрлах жинхэнэ хайраа хөгжүүл. Ангид болон ангиас гадна аль алинд нь хийж байгаа болгондоо хайраа харуул. Залуу эрэгтэй нэг бүрийг, түүний сонирхол, бэрхшээлүүдийг мэдэж ав.
5. *Бэлтгэлтэй Бай.* Хичээл бүрийг заахдаа доод тал нь хоёроос гурван долоо хоногийн өмнө унш. Хэрэв та эдгээр хичээлийг заахад бэлтгэж амжилгүй өмнөх Бямба гарагийг нь хүргэсэн бол хичээл тань үр дүн багатай байх болно. Хичээл бүрийн эхэнд байгаа “Бэлтгэл” хэсгийг онцгой анхаар.

Түүхүүд байгаа хэсгүүдийг хичээлээ бэлтгэж байхдаа хэд хэдэн удаа унш, тэгвэл та тэдгээрийг сайн ойлгож, амжилттай сайн заах болно.

Хичээлээ баяжуулахын тулд тохиромжтой үед нь *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* (34285 ба 34287) товхимол ба картыг ашигла. Залуу эрэгтэйчүүдэд товхимолд буй жишгүүдийг сайн мэддэг болоход нь тусал. Залуу эрэгтэйчүүдийг үүнийг тогтмол уншиж, үүнд заасан жишгүүдийг дагаж байхад нь урамшуулан дэмж.

**НЭМЭЛТ
ЗӨВЛӨМЖ**

Дараах зөвлөмж нь хичээл бүрийг илүү сонирхолтой ба үр өгөөжтэй болгоход тусална:

1. *Судруудыг ашигла.* Долоо хоног бүр пристийн зэргийн цуглаанд судруудаа авчирч байхыг залуу эрэгтэйчүүдэд зөвлө. Хичээл бүрт тэдэнд тэмдэглэл хийх харандаа өгч бай.
2. *Ярилцлагыг дэмж.* Залуу эрэгтэйчүүдийг чөлөөтэй хариулж, асуулт тавихыг хүс. Залуу эрэгтэй бүрийг цаашдаа оролцох хүсэлтэй байлгахын тулд оролцоог нь сайшаан дэмж.
3. *Хичээлүүдийг нөхцөл байдалдаа тохируул.* Залуу эрэгтэйчүүдийн сонирхлыг татах заах аргыг ашигла. Залуу эрэгтэйчүүдэд тохирохоор өөрийнх нь болон таньж мэдэх хүмүүсийнх нь амьдрал дахь үйл явдал, туршлагыг эрж хай. Заримдаа та түүх ба жишээнүүдийг соёл, зан заншил, нөхцөл байдалд тохируулах хэрэгтэй байж болно.

Залуу эрэгтэйчүүдэд амьд бошиглогчдын үгсийг суралцахад нь туслахын тулд та ерөнхий чуулганы ярианаас ашиглан хичээл бэлтгэж болно. 51-р хичээлийн удирдамжийг ашиглан хөгжүүлснээр та чуулгынхаа залуу эрэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцүүлж чадна.

Зарим хичээлийг хичээлийн нэг цагт багтааж заахад хэтэрхий их материал агуулсан байж болно. Ийм нөхцөлд залуу эрэгтэйчүүдэд хамгийн шаардлагатай материалуудыг нь сонго эсвэл энэ хичээлээ нэгээс илүү цуглаанд заа.

4. *Гарын авлага дахь зурагнуудыг ашигла.* Гарын авлагын ард байгаа зурагнуудыг гарын авлагын хамт байлга. Тэдгээрийг бүү урж ав. Тэдгээрийг тохирох хичээлүүдэд нь хэрэглэ. Гарын авлага дахь ихэнх зураг нь Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга (34730363)-д байгаа. Та уг цуглуулгыг Солт Лэйкийн Хангамжийн Төвөөс захиалах буюу цуглааныхаа байрны номын сангаас авч болно. Мөн цуглааны байрны номын санд судрын түүхүүдийг батжуулахад ашиглаж болох зурагнууд байж болно.
5. *Самбар, шохой, ашигла.* Хичээл бүрийн өмнө хичээлээ бататгахын тулд самбарыг хамгийн үр ашигтай хэрхэн ашиглаж болох талаар бод. Самбар ашиглахдаа урт өгүүлбэрүүдээс зөвхөн түлхүүр үгсийг л бич.
6. *Уриалга гаргаж, үр дүнг ярилц.* Хичээл бүрийг тусгай уриалгаар өндөрлө. Залуу эрэгтэйчүүдтэй үр дүнг ярилцаж, уриалгыг биелүүлэхэд нь дэмж. Уриалгыг биелүүлэхдээ гаргасан амжилтынх нь талаар тэднээс мэдэгдэхийг хүс.
7. *Сүмийн сэтгүүлүүдийг ашигла.* Энэхүү гарын авлага дахь тодорхой хичээлүүдийг бататгахад тусалж болох олон сайхан түүх ба нийтлэлүүд олон улсын сэтгүүлүүд дээр байдаг. Ялангуяа ерөнхий чуулган дээр Сүмийн Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн хэлсэн үг бүхий дугаарууд тустай.
8. *Тараах материал ашигла.* Залуу эрэгтэйчүүдэд сайн мэдээний зарчмуудыг сурч санаж байхад нь туслах зорилго бүхий тараах материалууд зарим хичээлийн төгсгөлд байгаа. Шаардлагатай үед тараах материалыг хувилж хичээлдээ ашигла.

**ХҮҮХДИЙН
ХЭСГИЙН
ХИЧЭЭЛД
ДИКОНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗӨВЛӨЛ СУУХ НЬ**

Диконы чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл нь бусад залуу эрэгтэйчүүдийг пристийн зэрэг хүлээж авахад нь бэлтгэх үүрэгтэй. Ерөнхийлөгчийн зөвлөлийг эдгээр залуу хөвгүүдийн явдаг Хүүхдийн Хэсгийн ангид хэдэн товч танилцуулга хийхийг уриал. Эдгээр танилцуулга нь гурван зорилготой байх ёстой:

1. Диконы чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлд залуу хөвгүүдэд зааж сургах туршлага олгох.
2. Пристийн зэргийг хүлээн авахаар бэлтгэж байгаа залуу хөвгүүдэд Аароны Пристийн Зэрэгтний үүрэг ба адислалуудыг ойлгоход нь туслах. Мөн чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл нь үйлчлэл ба сайн үлгэр дууриалал болсноор ирэх баяр баясгалан, сэтгэл хангалуун байдлыг тодотгох нь чухал.

3. Залуу хөвгүүд чуулгад хэрэгтэй гэдгийг ойлгоход нь тэдэнд туслах.

Ерөнхийлөгчийн зөвлөл доорх хоёр зөвлөмжийн адил зүйлийг зааж болно.

Дикон Бусдад Үйлчилдэг

Диконы чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл нь диконууд пристийн зэргийн үүргээ биелүүлж, бусдад хэрхэн үйлчилдэг болон энэхүү үйлчлэлээс ирэх баяр баясгалан, сэтгэл хангалуун байдлыг тайлбарласан хорин минутын танилцуулга бэлтгэж болно. Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл ариун ёслол хэрхэн түгээх ба мацгийн өргөл цуглуулах нь хэсгийн гишүүдийн амьдралыг хэрхэн адисладгийг тайлбарлаж болно; мөн тусгай үйлчлэлийн ажлын тухай илтгэж болно.

Үлгэр Дууриал Бол

Диконы чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл нь Есүс Христийг төлөөлж буй пристийн зэрэгтнүүдийн хувьд үзүүлэх сайн үлгэр дууриалын ач холбогдлын тухай хорин минутын танилцуулга бэлтгэж болно. Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл хувцаслалт ба үйлдлээрээ, ялангуяа ариун ёслол түгээх ба мацгийн өргөл цуглуулах үедээ сайн үлгэр дууриал болохын чухлыг тайлбарлаж болно.

Ерөнхийлөгчийн зөвлөлийг хичээл заахаас нь өмнө та диконы чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлтэй хамтран хичээлийг төлөвлөхөөр Хүүхдийн Хэсгийн багштай уулзах ёстой. Хүүхдийн Хэсгийн ангиудад очихын өмнө Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчтэй зөвлөлдсөн байх ёстой.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр өөрийгөө Бурханы Хүү ба Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болж чадна гэдгийг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

Шаардагдах материалууд:

1. Залуу эрэгтэй бүрт судар.
2. Залуу эрэгтэй бүрт *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* (34285 ба 34287) товхимол болон картыг өг.

ТАЙЛБАР

Өөрийгөө зөвхөн одоо үед төсөөлөн харж буй залуу эрэгтэйн ухаалаг шийдвэр гаргах, зөв хандлага болон зуршлаа хөгжүүлэх чадвар нь түүнийг амьдралаа мөнхийн ирээдүйд харж буй нэгнээс хамаагүй сул дорой байлгадаг. Эхнийх нь бол түр зуурын цэнгэл хөөцөлдөж мөнхийн сайн сайхнаа сүйтгэж болох сонголтуудыг хийж болно. Нөгөөдөх нь итгэл болон тэвчээрийг хөгжүүлж, хийж буй сонголтууд нь түүнийг мөнхийн амьдрал руу дэвшихэд нь тусалж болох юм. Залуу эрэгтэй бүрийн энэ амьдрал нь ирэх мөнхийн амьдралд нь нөлөөлнө гэдгийг онцолж хэл. Түүнд мөнхийн ирээдүйг хөгжүүлэхэд нь тусал.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Ишлэл

Залуу эрэгтэй бүр Тэнгэр дэх Эцэгтэйгээ адил болж чадна.

Есүс Христийн үнэний Сүм хожмын өдрүүдэд дахин сэргээгдсэн цагаас хойш, Сүмийн гишүүд өөрсдийнхөө үүсэл гарал ба заяа тавиланг, Бурханы хүүхдүүд гэдгээ мэдэж авсан. Хожмын үеийн бошиглогч Лорензо Снөү уг сургаалыг ойлгомжтойгоор дүгнэн хэлэхдээ, “Бурхан нэгэнтээ хүн байсан; Хүн Бурхан болж болох юм” гэжээ. (Thomas C. Romney, *The Life of Lorenzo Snow* [Salt Lake City: Deseret News Press, 1955], p.46).

Түүх

Дахин сэргээгдсэн Сүмээс гадуурх олон хүмүүс өөрсдийгөө Бурханы охид хөвгүүд гэдгээ ойлгодоггүй гэдгийг тайлбарлаж өг. Тэгээд дараах түүхийг хэл:

“Арван Хоёрын Чуулгын хуучин гишүүн [Ахлагч] Жоон А.Видцөү Дэлхийн Нэгдүгээр Дайны үеэр Англи руу явсан ба түүнтэй ярилцсан Английн хилийн байцаагч түүнд хэлэхдээ, ‘Бид танд нэвтрэх зөвшөөрөл өгөхгүй. Бид танай номлогч нарыг оруулж байгаа гэхдээ ямар ч удирдагч нарыг оруулахыг хүсэхгүй байна’ гээд Тэрээр түүнийг ‘Сууж бай’ гэлээ. [Ахлагч] Видцөү суулаа.

“Хэдэн минутын дараа байцаагч түүнийг дахин дуудаад, ‘Хэрэв би танд нэвтрэх зөвшөөрөл өгвөл та манай хүмүүст юу заах вэ?’ гэж хэллээ.”

- Хэрэв та нар Ахлагч Видцөүгийн оронд байсан бол юу гэж хариулах байсан бэ?

“[Ахлагч] Видцөү хэлэхдээ, ‘Би, тэд хаанаас ирсэн, яагаад тэд энд байгааг, мөн тэд хаашаа явахыг заах болно’ гэж хэлэхэд байцаагч түүн рүү хараад, ‘Танай Сүм үүнийг заадаг гэж үү?’ хэмээн асуув. Ахлагч Видцөү ‘Тийм ээ’ гэхэд,

“‘За, Минийх үгүй ээ,’ гэж хэлсэн ба тэрээр паспортон дээр нь тамга дарж, гарын үсгээ зураад, ‘Та орж болно’ гэж хэллээ” (Le Grand Richards, “Patriarchal Blessings,” *New Era*, Feb. 1977, p.4).

Ярилцлага

Зарим Залуу эрэгтэйчүүдийг дээр дурдсан (Бид хаанаас ирсэн? Яагаад бид энд байгаа? Бид хаашаа явах вэ? гэсэн гурван асуултуудад товчхон хариулахыг урь.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол эдгээр гурван асуултын зөв хариултыг заадаг дэлхий дээрх цорын ганц сүм гэдгийг гэрчил.

Бурхан Бидэнд Түүнтэй Адил Болоход Тусалдаг

Судрууд ба
арилцлага

Залуу эрэгтэйчүүдэр Абрахам 3:22–25-ыг уншуулж тэмдэглүүл.

- Бид яагаад дэлхийд ирсэн бэ? (Өөрсдийгөө батлахаар)

Бид Их Эзэний тушаасан бүхнийг хийх ба түүнд бүхий л зүрх, сэтгэл хүч чадлаараа үйлчлэхээ харуулахын тулд дэлхийд ирсэн гэдгийг тайлбарла.

Нэг залуу эрэгтэйгээр Матай 5:48-ыг уншуул.

- Энд ямар зарлигууд өгөгдсөн байна вэ?
- Есүсээс өөр ямар нэгэн хүн төгс амьдралаар амьдарсан уу? (Үгүй)
- Аврагчийн бидэнд төгс бай гэж хэлсэнийг та нар юу гэж бодож байна вэ?

Доорх түүхэнд бид Тэнгэрлэг Эцэгтэй адилхан болох чадварыг дүрслэн үзүүлсэн.

Түүх 1

“Бошиглогч Инос дуудагдахдаа, тэрээр яагаад гэж бодсон ба ‘Би жаахан шүү дээ, бүх хүмүүс намайг үзэн яддаг; Би ярихдаа удаан’ (Мосе 6:31) Бурханы хувьд сорилт нь бидний чадвар бус харин бидний бэлэн байдал гэдгийг Инос мэдэж байсан. Инос Бурханы зарлигуудыг сахисан ба өөрийнх нь боломжийг харуулсан Их Эзэний үзэгдэлд итгэж бүх хугацааны агуу хотыг баригч болсон. Хүн төрөлхтний түүхэнд бүх хүмүүс нь зөв шударга байдлаасаа хэзээ ч ухраагүй цорын ганц тохиолдол байсан нь Инокын Хотынхон байсан юм. Эдгээр бүх зүйлүүд өөртөө итгэл багатай залуу эрэгтэйгээс эхэлсэн” (Neal A. Maxwell, “I Am But a Lad,” *New Era*, May 1981, p.4)

Самбар дээр дараах мэдээллийг бич: *Их Эзэн бид нарын боломжийг мэддэг учраас бидний чадавхид бус харин бэлэн байдалд маань санаа тавьдаг.* Залуу эрэгтэйчүүдтэй энэ тухай ярилц. Тэд ямар нэгэн зүйлийг хийхээр дуудагдсан ба үүнийгээ хийх чадалгүй ч Их Эзэний тусламжтайгаар дуусгасан хувийн тохиолдлоосоо хуваалцахыг хүс.

- Та Их Эзэний өмнө хэрхэн бэлэн байдалтай байж чадах вэ? (Залбирал, наманчлал, судруудыг унших, дуудлагаа биелүүлэх.)
- Бид хэрхэн Их Эзэний ажлыг хийх чадвартай болох вэ? (Хийж чадах бүхнээ хийж, Их Эзэний тусламжийг эрэлхийлж.)

Түүх 2

“Солонгосын Дайны үеэр залуу Ри Хо Нам Америкийн цэргийн ангид туслах үүрэгт томилогдсон байлаа. . . . Тэр үед, түүний жирийн амьдралаас тасархай байдал нь сүйрэл мэт байсан. Тийм ч гэсэн Хо Нам эртний Египетэд Иосефийн даван туулсны адил бэрхшээлүүдийг даван гарсан. Тэрээр англи хэлийг хоёр дахь хэлээ болгон хөгжүүлсэн. Мөн Америкийн цэргүүдийн хийж байсан зүйлүүд ялангуяа Хо Намын бишрэлийг ихээхэн төрүүлсэн, цэргүүд дундаасаа ‘ялгаатай’ байсан ХҮГ дэслэгчийг ихэд ажигласан. Тэд байнга ярилцдаг байв. Нэг өдөр дэслэгч нь Хо Намаас амьдралынх нь зорилгыг асуув. Ри Хо Нам хариулж чадалгүй философичид энэ асуултанд олон зууны туршид хий хоосон түүртсэн гэж л хэлэв. Үүний дараа байцаагч цаас гаргаж ирээд авралын төлөвлөгөөг тайлбарлан зурлаа. Яг тэр мөчид Их Эзэн өөрийн Сүнсний хүчээр Ри Хо Намын зүрхэнд Америк эрийн түүнд хэлснийг үнэн гэдгийг гэрчилсэн. Хо Нам үүнийг судлаад дараа нь Сүмд нэгдэж, онцгой үеийн үнэт дурсамж болгож цаасаа олон жил хадгалсан аж.

“Солонгосын дайн удалгүй дуусаж, Хо Намын амьдрал Сүмд дөнгөж эхэлсэн. Ри Хо Нам гучаад насандаа Азийн эх газар дахь Сүмийн анхны гадасны, анхны ерөнхийлөгч болсон. Тэрээр [удалгүй] Пусан, Солонгост номлолын ерөнхийлөгчөөр нэр төртэйгээр үйлчилж өөрийн хүмүүсийн дунд гайхамшигтай удирдагч байсан” (“I Am But a Lad,” p. 5).

- Бэрхшээл зовлон Ри Хо Намд суралцаж, өсөхөд нь хэрхэн тусалсан бэ?
- Их Эзэн Хо Намын ямар боломжуудыг мэдэж байсан бэ?

Хэрэв тэд Их Эзэнд үйлчлэхдээ байнга бэлэн байвал тэдний өмнө чухал дуудлагууд байна гэдгийг залуу эрэгтэйчүүдэд онцол.

Түүх 3

“Хэдэн жилийн өмнө Италид ХҮГ номлогчдыг итали залуучууд доромжилсон. Хоёр тохиолдолд Филес Лотито гэдэг залуу тэдний дунд байлаа. Нэгэн зоригт ахлагч түүнийг нутгийн ХҮГ-ийн салбарт ирэхийг урьж, ингэснээр тэр өөрийгөө шүүж чадсан юм. Филесийн зөвшөөрсөн зүйл бол зориг гаргасан явдал байв. Тэрээр ирээд сонссон. Мөн судлаад тэр итгэсэн. Тэр усан баталгаа хийлгэв. Тэрээр удалгүй Англид номлолоор явсан ба тэнд итгэлээ хөгжүүлж, англи хэлтэй болсон юм. Тэрээр нэр төртэй үйлчилж, гэртээ ирж хөөрхөн итали охинтой Швейцарийн Ариун Сүмд гэрлэсэн ба Италид семинари институтийн хөтөлбөрийн нэг захирал болсон. . . .

“1980 оны долоодугаар сард Филес Лотито 32 насандаа Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Итали дахь Падова Номлолын ерөнхийлөгч боллоо! Филесийн өөрийнх нь бүрэн таниагүй байсан боломжуудыг Бурхан харсан юм. Дөнгөж саяхан тэрээр номлогч нарт төвөг удаж байсан ч гэсэн түүнд сайн мэдээ заахад үнэнч сэтгэлээр үүнд итгэх оюун ухаан Филест байсан. Их Эзэн Филес Лотитод хүрсэн бөгөөд тэрээр мянга мянган нутаг нэгтнүүддээ хүрч хэдхэн жилийн өмнө түүний тэгж их шүүмжлэлтэй хандаж байсан хэдэн зуун номлогчид хүрч чадсан (“I’m But a Lad” p. 5-6).

- Тэдгээр замаа алдсан хүмүүсийг Их Эзэн хөгжил дэвшлийн зам дээр буцаан авчирсныг та нар хэрхэн харсан бэ?

Залуу эрэгтэй бүрт *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө*-г өг. Тэргүүн Зөвлөлийн мэдэгдлийг товч давтаад энэхүү удирдамж нь залуу эрэгтэй бүрийг Их Эзэний жишгийг дагаж түүнтэй илүү адил болоход туслах болно гэдгийг тайлбарла.

Дүгнэлт

Гэрчлэл

Хичээлд заасан үнэнүүдээс гэрчлэлээ хуваалц. Залуу эрэгтэй бүрийг Их Эзэн ямар болж чадах мөн тэднийг чадавхидаа хүрэхэд нь тусална гэдгийг тэмдэглэн хэл. Өөрсдийнхөө сэтгэл ханамжгүй байдлыг үл харгалзан Их Эзэнд итгэх нь чухал болохыг залуу эрэгтэй бүрт ойлгуул. Тэдний одоогийн амьдралдаа хийж байгаа зүйлс нь мөнх бус амьдралд болон ирэх амьдралд нь нөлөөлнө. Мөн тэд Тэнгэрлэг Эцэгтэйгээ адил болтлоо өсөж хөгжиж чадна гэдгийг сануул.

Ишлэл

Ахлагч Брюс Р.МакКонкийн дараах мэдэгдлийг унш:

“Төгс төгөлдөр ганцхан хүмүүн байсан, Их Эзэн Есүс. Хэрэв хүн төгс ба [мөнхийн амьдралд орохын тулд] бүх л хуулиудаар чанд, ариунаар, бүрэн төгс амьдарвал ганцхан хүн л мөнхөд аврагдах байсан. Бошиглогч [Иосеф Смит], бидний авралын ажилд үхсэний дараа ч гэсэн хийх зүйл олон байгаа гэж заасан.

“Тэгээд энэ амьдралд бид юу хийх вэ гэвэл мөнхийн амьдрал руу хөтлөгч замын заагч болдог. Тэр зам нь бодитойгоор эндээс, одоо эхэлж ирээдүйд үргэлжилдэг. Энэ цагаас хойш бид зөв зохистойгоор өөрсдийнхөө бүх л чадал, боломжоороо урагшлах болно гэдгээ сэтгэл зүрхэндээ шийдэх ёстой. Ингэснээр бид Бурхан ба Христийн байгаа газарт очиж чадна. Хэрвээ бид буцалтгүйгээр шийдэж, үүргээ биелүүлэхээр замнавал амьдралын дараа мөнхийн оршихуйд хүрэх замаа үргэлжлүүлэх болно” (“The Seven Deadly Heresies,” 1980 Devotional Speeches of the Year [Provo, Utah: Brigham Young University Press, 1981], pp.78- 79).

- Хэрэв бид энэ амьдралдаа төгс төгөлдөр байдалд хөтлөх зам дээр байж байгаад төгс төгөлдөр болохоосоо өмнө үхвэл Ахлагч МакКонки энэ тухай юу болно гэж хэлсэн бэ?

Бидний хэн ч мөнх бус амьдралын төгсгөл хэзээг мэдэхгүй гэхдээ хэрэв бид зөв замаар явбал Тэнгэр дэх Эцэг шигээ болтлоо үргэлжлүүлэх ба бид сэлэсчел хаант улсад түүнтэй хамт үүрд байх боломжтой гэдгийг тайлбарла.

Уриалга

Залуу эрэгтэй бүрийг өглөө бүр өөрсдийнхөө Тэнгэрлэг боломжийг санахад мөн өдөр тутмынхаа үйл ажиллагааг мөнхийн ирээдүйнхээ тухай бодолтойгоор хэрэгжүүлэхэд нь уриал. Тэдэнд чадавхиа ашиглахад нь туслахын тулд *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* дээрх жишгүүдийг үргэлж давтахыг уриал.

2

Тэнгэр дэх Эцэгээ Мэдэх нь

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр Бурханы хүүхэд ба пристийн зэргийг атгагч тэрээр чухал хариуцлагуудтай гэдгийг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд: залуу эрэгтэй бүрт судар.
 2. Та нэг залуу эрэгтэйгээр “Яагаад пристийн зэрэггүй залуугаас биш пристийн зэрэгтэй залуу эрэгтэйгээс илүү ихийг шаарддаг вэ?” сэдвээр хоёроос гурван минут яриа өгүүлж болно.
 3. Үзүүлэн зураг 1 бэлтгэ, Иосеф Смит Мэргэн Ухааныг Библиэс Эрсэн нь (мөн 402-р зураг Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга [34730]).
-

ТАЙЛБАР

Энэхүү хичээлийн зорилго нь залуу эрэгтэй бүрийг Тэнгэр дэх Эцэгийн чухал хүү гэдгийг мэдрэхэд нь туслах юм. Залуу эрэгтэй болгон өөрсдийгөө Бурханы энхрий халамжинд байна гэж боддоггүй ба үүнийг хэлэхэд нь тэднийг урамшуулж залуу эрэгтэй бүрийг Эцэгийнх нь тэдэнд өгсөн пристийн зэргийн үүргээ биелүүлэхэд туслах нь таны үүрэг юм.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Түүх

Тэнгэрлэг Эцэг Бид Бүхэнд Хэмжээлшгүй Их Хайртай

Залуу эрэгтэйчүүдэд дараах нөхцөлийн тухай буюу төстэй зүйлийн талаар ярьж өг: Эцэг хүү хоёр хамтдаа зугаалж байлаа. Тэднийг хязгааргүй оддыг харж байхад сэрүүхэн цэлмэг орой байсан ба задгай гал унтарч байлаа. Аав нь “Хүү минь, чи юун тухай бодож байна?” гэж асуулаа.

“Өө, би зүгээр л бодож байлаа. Бүх зүйлүүд сэтгэлд багтахгүй байх шиг. Эдгээр одод үүрд байх болно. Бурхан эдгээр нар, сар, одод, бусад ертөнцийг бүтээж чадсан юм чинь, над шиг нэг хүнийг яагаад түүнд огт хамаагүй юм бол доо л гэж гайхаж байна.”

Аав нь инээгээд, “Давид Хаан ‘Хүний Хүү гэгч юу болоод та түүнийг халамжилна вэ?’ гэж бичихдээ яг үүнтэй чинь адил зүйлийг бодож байсан (Дуулал 8:4). Яагаад гэвэл бид түүний хүүхдүүд юм” гэж хэлэв.

- Та нар яагаад бид бүгд Тэнгэрлэг Эцэгт сайхан уулс, од, мөн байгалийн зүйлсээс илүү чухал гэж бодож байна вэ? (Бид бүхэн түүний хөвгүүд. Бид бодож сэтгэж, мэдэрч, хайрлаж, мөн юмсыг хийж чадна.)

Залуу эрэгтэйчүүдийг хувьдаа Тэнгэрлэг Эцэгийн хайрыг тэд яаж мэддэг болсон туршлагаасаа хуваалцахыг урь.

Судар

Залуу эрэгтэйчүүдээр Мосе 1:39-ийг уншуулан тэмдэглүүлж, дараа нь яагаад бидний Тэнгэр дэх Эцэг бидэнд энэ их зүйлсийг өөрийн хүч чадлаа зориулан хийж өгч байгаа тухай ярилц. Нэг гол шалтгаан нь бол бид түүний хөвгүүд. Бидний энэ дэлхий дэх эцэг маань гэр бүлээ хангахын төлөө ажилладаг ба хүүхдүүдээ зохистой өсгөхийн төлөө цагаа зориулдаг шиг бидний Тэнгэрлэг Эцэг өөрийнхөө бүх л эрч хүч мөн чадвараа агуу их гэр бүлээ өсгөж хангахын төлөө зориулдаг.

Түүх

Дараах түүхийг өөрийн үгээр ярь:

“Тэрээр энэ санаа хаанаас гарсныг сайн мэдэхгүй байлаа. Гэвч залуу эрэгтэй ямар нэгэн байдлаар Бурханы бүтээсэн сайхан байгальд очиж Тэнгэрлэг Эцэгтэй ярилцвал тус болно гэж бодож байсан. Тийм ч учраас тэрээр өглөө эрт модны доор дээш харан юу хийснээ хэлэн зогсож байлаа. . . .

“Тэрээр үнэхээр өөртөө тусламж хэрэгтэй гэж мэдэрсэн ба хэнд хандахаа мэдэхгүй байлаа. Тиймээс түүнд залбирах санаа төрж, тэрээр үүнийг хийхээр төлөвлөн барууны жижигхэн хотоос гарч ойролцоох мод руу явлаа.

“Тэр өглөө тэрээр тэнд дээш харан зогсож, Их Эзэнтэй ярилаа. Түүний хүсэлт энгийн байсан. . . .

Тэрээр “Би зүгээр л дээшээ хараад Их Эзэнд, ‘Бурхан минь хэрэв та намайг хүлээж авахад бэлэн бол би таныг хүлээн авахад бэлэн байна’ гэж хэлсэн” хэмээн намуухан хэлэв.

“Тэнд хэлж болон үзүүлж буй гайхал төрүүлэх хариулт юу ч байгаагүй. Тэрээр юу ч хараагүй ба ямар ч дуу хоолой сонссонгүй. Тэнд сэвэлзүүр салхитай өглөө байсан ба түүний зүрх нь цохилж байлаа. Гэсэн хэдий ч тэрээр түүнийг сонссон гэдгийг мэдэж, хариулт нь удахгүй ирнэ гэсэн гүнзгий итгэлтэйгээр буцаж явсан.

“Тэр өглөө хотхон руугаа явахаар автобусанд жолоочийн ард суухад, хариултынхаа эхний хэсгийг тэрээр авсан. Тэр хүн түүнд, ‘Хүү минь Миний бодлоор би чамд олж өгч тусалж чадах зүйлийг чи хайж байгаа бололтой гэж хэллээ.’ Ингэж энэхүү яриа эхэлсэн нь залуу хөвгүүн Есүс Христийг ба түүний дахин сэргээсэн Сүмийг эргэж буцалтгүйгээр хүлээн зөвшөөрөх явдалд хөтөлж түүний амьдралыг бүрэн өөрчилсөн.

“Тэр мөчөөс тэрээр шавь нарынхаа дунд даруу зангаар ажиллаж явахад амьдрал агуу утга учиртай болсон ба энэ нь түүний нинжин сэтгэл, хүч чадлыг нь идэвхжүүлсэн юм . . . ” (Marion D. Hanks, “ I Am Ready for You,” *Improvement Era*, Oct. 1968, p.56).

Иосеф Смит Мэргэн Ухааныг Библиэс Эрсэн нь, зураг 1-ийг үзүүл.

- Ойн цоорхойд очиж Тэнгэрлэг Эцэгт хандан залбираад хариулт авсан залуу хөвгүүн хэн байсан бэ? (Иосеф Смит.)
- Залбирлын хариултууд нь бидэнд Тэнгэрлэг Эцэгийн хайрыг хэрхэн үзүүлдэг вэ?

Залуу эрэгтэйчүүдээр Иосеф Смитийн Түүх 1:17-г уншуул.

- Энэ шүлэг нь Тэнгэрлэг Эцэг Иосеф Смитийг биечлэн мэддэгийг хэрхэн үзүүлж байна вэ?
- Тэнгэрлэг Эцэг та нарыг хэр сайн мэддэг вэ? (Залуу эрэгтэйчүүд Тэнгэрлэг Эцэг зөвхөн тэдний нэрийг мэдээд зогсохгүй мөн хүн нэг бүрийнх нь бодол, санаа, хүсэл, мөн үйлдлийг мэддэг гэдгийг ойлгосон эсэхийг нь шалга. Тэрээр өөрийн хүүхдүүдийг нэг бүрчлэн биечлэн сонирхдог.)

Залуу эрэгтэйчүүдээс хэн нэгнийг нь залбирлын хариулт авсан туршлагаасаа хуваалцахыг хүс.

Ерөнхийлөгч Хью Б.Брауны дараах түүхийг унших буюу ярьж өг:

“Миний бодлоор залуу эрэгтэйчүүдийн нэн түрүүнд хийх зүйлүүдийн нэг бол Бурханыг таньж мэдэхээр чармайх явдал юм. Бид Түүнд очиж түүнээс бидэнд хэрэгтэй байгаа ямар ч тусламжаа . . . авах боломжтой гэсэн утгаар нь хэлж байна. Намайг номлолд явахад ээж минь ингэж хэлснийг би санаж байна. . . . ‘Миний хүү, чи одоо надаас хол явах гэж байна. Чи хүүхэд байхдаа муу зүүд зүйдлээд түүнээсээ их айдаг байснаа санаж байна уу?’ гэж тэр хэлсэн. Чиний унтлагын өрөө минийхээс холгүй байдаг байсан ба байн байн шөнө уйлаад , “Ээж ээ та тэнд байна уу?” гэхэд би, “Тийм ээ, Миний хүү, Би энд байна. Бүх юм зүгээр. Нөгөө тал руугаа эргээд унт” гэдэг байсан. Чи үргэлж үүнийг хийдэг байсан. Намайг дэргэд чинь байгааг чи мэдэж зориг ордог байсан.

“Одоо чи ойролцоогоор 6000 мил хол байх ба над руу хандан уйлбал би хариулж чадахгүй’ гэж тэр хэлэв. Харин чи дуудвал, хариулж чадах нэг хүн бий, Чамайг дуудахад тэр сонсох болно гэж тэрээр нэмж хэлсэн. Тэр чиний хүсэлтэнд хариулах болно. Чи зүгээр л “Аав аа, та байна уу?” гэж хэлэхэд л намайг чамд хариулахад чиний жаахан байхдаа мэддэг байсан тэр л тайвшруулалт тайтгарал зүрх сэтгэлд чинь ирэх болно.’

Зураг, судар
ба ярилцлага

Түүх

“Тэр цагаас хойш олон удаа янз янзын нөхцөлд би ‘Аав аа, та байна уу?’ гэж хашгирч байсан ба номлолын талбарт бараг орой бүр биднийг дээрэмдүүлдэг байсан тул бид нэг газраас нөгөө газар луу нүүхдээ би тэрхүү гуйлтыг хийдэг байсан гэдгээ залуу эрэгтэйчүүд та бүхэнд хэлэхийг хүсэж байна. Бид хотоос хөөгдөж, зодуулдаг байсан ба бидэнд заналхийлдэг байсан. Цуглаанд явах болгондоо би ‘Аав аа, та байна уу?’ гэж хэлдэг байсан. Түүний биеийг хараагүй, дуу хоолойг нь сонсдоггүй байсан ч, Тэрээр надад тайвшрал, Тэр дэргэд байгаа гэсэн баталгаа болон гэрчлэлээр хариулдаг байсан гэдгийг би залуу эрэгтэйчүүд та бүгдэд хэлэхийг хүсэж байна” (“Father Are You There?” [address given at Brigham Young University, 8 Oct. 1976], pp. 5–6).

Ярилцлага

- Тэнгэр дэх Эцэгээ дуудахад хариулт авна гэдэгт Хью Б.Брауны ээж яагаад ийм их итгэлтэй байсан бэ? (Тэрээр Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай ба чин сэтгэлийн залбирал бүрт хариулдаг гэдгийг мэддэг. С ба Г 6:14–15-ыг үз.)
- “Аав аа, та байна уу?” гэж бид хэзээ дуудаж болох вэ? (Бид ганцаардсан, айсан, уруу таталтад орсон ба бидэнд тайтгарал мөн өөртөө итгэх итгэл хэрэгтэй үед.)
- Бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ сайн харилцаатай байхын тулд юу хийж болох вэ?
- Бидний залбиралд хариулахаас гадна Тэнгэрлэг Эцэг бидэнд хэрхэн хайраа үзүүлдэг вэ? (Залуу эрэгтэй бүрийн хариултыг самбар дээр бичиж тус бүрийг ярилц.)

Пристийн Зэрэгтэй Байх нь Залуу Эрэгтэйн Тэнгэр дэх Эцэгийн Өмнө Хүлээх Хариуцлагыг Нэмэгдүүлдэг

Ярилцлага

Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай гэдгээ үзүүлсэн нэг зам нь бол бусдад үйлчлэх болон бусдыг адислах пристийн зэргийг өгсөн.

- Пристийн Зэрэг атгадаггүй залуу эрэгтэйгээс пристийн зэрэг атгадаг залуу эрэгтэйд яагаад илүү зүйлс шаардагддаг вэ?

Энэ асуултыг товчхон ярилцсанаа дараа урьдчилан томилогдсон залуу эрэгтэйгээр хоёроос гурван минут яриул.

Ишлэл

Дараах мэдэгдэл нь Бурханы пристийн зэргийг атгах хариуцлагуудыг ойлгоход тусална:

“Эрэгтэй хүүхэд болгоны эхэлдэг суурь нь тэр бол сэтгэл зүрхэндээ ямар нэгэн тэнгэрлэг зүйлийг агуулсан жинхэнэ Бурханы бүтээл мөн гэдгийг хүлээн зөвшөөрөх явдал юм. Бүх хүмүүс Бурханы хүүхэд бөгөөд гэхдээ та нарт илүү зүйл байдаг. Та нарт Түүний нэрийн өмнөөс ажиллах эрх мэдэл байгаа. Энэ нь та нарыг дэлхийн хэсгээс тусгаарлаж байна. Энэ нь та нарыг шуудхан бусдаас илүү болгохгүй, гэхдээ энэ нь та нарт бусдаас илүү дээр амьдрах хариуцлага өгч байгаа юм.

“Ийм агуу адислал байхгүй тэдгээрээс илүү зүйлийг чамаас шаарддаг, яагаад гэвэл та нар Бурханы хүүхэд гэдгээ мэднэ мөн түүний пристийн зэргийг атгадаг” (Victor L. Brown, Conference Report, Apr. 1972, p.101; or *Ensign*, July 1972, p. 90).

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр Сургаал ба Гэрээний 82:3-ыг уншуулж, тэмдэглүүлж ярилц.

- Сүмийн гишүүн бус хүмүүс хүлээж аваагүй ямар зүйлүүдийг пристийн зэрэгтэн бид хүлээн авсан бэ? (Ариун Сүнсний амлалт, нэмэлт судар, илүү их мэдлэг, амьд бошиглогч болон пристийн зэргийн удирдагч нарын удирдамж, Бурханы нэрээр үйлдэх хүч ба эрх мэдэл.)
- Яаж пристийн зэрэгтэн сургууль дээрээ биеэ авч явах вэ? Гэртээ? Уралдаан тэмцээнүүдэд?
- Та нар пристийн зэргийг атгадаг учраас та нарын амьдралд ямар адислалууд ирдэг вэ? (Залуу эрэгтэйчүүд нь ариун ёслолыг бэлтгэх ба гэрийн багшаар явах гэсэн тодорхой зүйлүүдээс гадна бусдад үйлчлэх агуу боломж, сүнслэг адислалууд нэмэгдэх зэргийг гаргаж ирэх ёстой гэдгийг анхаар.)

Уриалга

Дүгнэлт

Залуу эрэгтэй бүрийг ирэх долоо хоногт Тэнгэрлэг Эцэгтэй харьцах харьцаагаа дээшлүүлэхийг мөн пристийн зэрэгтнийхээ хувьд түүний өмнө хүлээсэн үүрэг хариуцлагуудаа сайн гүйцэтгэхийг уриал. Дараах санааг өг:

1. “Би Бурханы Хүүхэд” гэх мэтийн бидний Тэнгэр дэх Эцэгтэй харьцах харьцааны тухай дууллын үгсийг цээжлүүл (Сүмийн Дуулал ба Хүүхдийн Дуунууд, дугаар 58), “Эцэг минь ээ” (Сүмийн Дуулал ба Хүүхдийн Дуунууд дугаар 42).
2. Залбирлаа илүү утга учиртай болго. Тэнгэрлэг Эцэгтэйгээ чин сэтгэлээс ярилцаж, мөн хариултандаа Ариун Сүнсний шивнээг анхааралтай сонс.
3. Гэрчлэлээ өдрийн тэмдэглэлдээ бич.
4. Гэрчлэлээ мацаг барилтын болон гэрчлэлийн цуглаан дээр эсвэл гэр бүлийн гишүүдтэйгээ хуваалц.
5. Үйлчлэл үзүүл.
6. Сүмийн цуглаан болон олон нийтийн үйл ажиллагаанд сүмийн гишүүн бус хүмүүсийг урь.

3

Есүс Христэд Итгэх Итгэл

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр Цагаатгалыг илүү сайн ойлгосноор Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл нь бэхжих болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд: залуу эрэгтэй бүрт судар.
2. Зураг 2, Есүсийн Тэнгэрт Өргөгдсөн нь (мөн зураг 236, Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга [34730])-ийг үзүүлэх.
3. Хэрэв танай бүсэд *Family Home Evening Video Supplement 2* (53277) байгаа бол “Та Христийн Тухай Юу Гэж Боддог вэ?” 8-р хэсгийг үзүүл.

ТАЙЛБАР

Энэхүү хичээл нь залуу эрэгтэй бүрт Аврагчийн амьдрал ба үүргийг ойлгоход нь туслах боломжийг танд өгч байна. Зарим залуу эрэгтэйчүүд Есүс Христийг цагаатгалыг мөн мөн тэдний болон бусдын амьдралыг ямар замаар адисладгийг ойлгохгүйгээр номлолын талбарт хөл тавьдаг.

Энэхүү хичээлийн санаануудыг шаардлага хангахаар заахад нэгээс илүү пристийн цуглаан шаардагдаж магадгүй. Залуу эрэгтэйчүүд Их Эзэн Есүс Христэд хайраа нэмэгдүүлэн хөгжүүлж түүний амьдрал ба цагаатгалын золиослолд нь талархлаа нэмэгдүүлж байгааг нь бататгахын тулд чадах бүхнээ хий.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Ярилцлага

Оршил

Залуу эрэгтэйчүүдээс дараах нөхцлүүд итгэлийн жишээ хэрхэн болж байгааг асуу.

1. Нэгэн хүн эрдэнэшишийн үр тариад усалж бас зэрлэгийг нь зулгаадаг (Тэр үр ургах болно гэж итгэсэн учраас л тарьж хайрлаж хамгаалсан. Итгэл бол найдлага ба хэрэгжүүлэлт юм.)
2. Нэгэн хүү гимнастикаар өдөрт гурван цаг хичээллэдэг, яагаад гэвэл тэрээр Олимпод үзээд алдахыг хүсэж байна (Тэрээр Олимпод уралдаж чадна гэж итгэсэн учраас өөрийнхөө чадварыг хөгжүүлэхээр цаг зарцуулсан. Итгэл бол найдлага ба хэрэгжүүлэлт юм.)
3. Залуу эрэгтэй сар бүр номлолдоо мөнгө хураадаг. (Тэрээр номлолд явна гэж итгэдэг. Тэр мөнгө хураасан, тийм учраас тэр номлолд явж чадна. Итгэл бол найдлага ба хэрэгжүүлэлт юм.)

Итгэл бол биднийг ямар нэгэн юм хийхэд, мөн ямар нэгэн юм болоход өдөөдөг хүчтэй найдвар гэдгийг тайлбарла.


Бид Есүс Христэд Итгэлтэй Байх Ёстой

Судар, самбар
ба ярилцлага

Агуу Их Үнэт Сувд судрын төгсгөлд буй итгэлийн тунхгийн дөрөвдүгээрхийг залуу эрэгтэйчүүдээр хамтад нь уншуул.

- Бид ерөнхийд нь итгэх ёсгүй, гэхдээ хэнд онцгойлон итгэх ёстой вэ? (Их Эзэн Есүс Христэд.)

Дахин Амилалт ба *Цагаатгал* гэсэн үгсийг хасаад, дараах үзүүлэнг самбар дээр тавь.



Даиграмм нь мөнхийн амьдрал хэрхэн олж авахыг үзүүлж байгааг тайлбарла.

- Мөнхийн амьдрал олж авахын тулд бид юуг даван туулах ёстой вэ? (Бие махбодь болон оюун санааны үхэл.)
- Бие махбодийн үхэл гэж юу вэ? (Бие болон сүнсний салалт.)
- Оюун санааны үхэл гэж юу вэ? (Бурханаас хагацах.)
- Энэхүү хоёр төрлийн үхлийг давахын тулд бид юу хийж чадах вэ? (Бид Есүс Христийн цагаатгалд итгэлтэй байж түүний хүслийг дагах ёстой.)

Гүүрийг *Есүс Христийн Цагаатгал* гэж хаягла. Христийн цагаатгал нь бидний Бурханы өмнө эргэж очих замд гүүр болон холбож өгч байгааг тайлбарла. Бид ганцаараа өөрсдийнхөө хичээл зүтгэлээр мөнхийн амьдрал олж авч чадахгүй харин Цагаатгалд итгэж, Бурханы зарлигуудыг сахих ёстой.

- Бурханы бүх зарлигуудыг сахих гэдэг нь юу гэсэн үг вэ? (Та итгэлийн тунхгийн дөрөв рүү эргэн орж бид Бурханы зарлигуудыг сахиж, түүний ёслолуудыг хүртэж, мөн эцсээ хүртэл тэвчих ёстойг онцолж хэл.)
- Есүс Христийн цагаатгал гэж юу вэ? (Есүс бидний нүглийн төлөө зовон шаналж, үхээд дахин амилсан нь биднийг нүглээ наманчилж дахин амилах боломжтой болгосон.)

Ярилцлагыг нүглээ наманчлахыг боломжтой болгосон Христийн цагаатгалд итгэлтэй байх ёстой гэсэн дүгнэлтээр төгсгө. Энэхүү итгэл нь биднийг нүглээ наманчлахад залж мөн оюун санааны үхлийг даван туулах боломжийг өгдөг. Христийн дахин амилалтаар бид бүхэн бие махбодийн үхлийг даван туулж чадна.

Түүх

Залуу эрэгтэйчүүдээс Аврагч бидний нүглийг өөртөө авахад ямар байсан тухай тэднийг дүрсэлж бодохыг хүс. Ахлагч Оорсон Ф. Витнигийн дараах дүрслэлийг унш:

“Тэгээд дээд Эх Сурвалжаас сануулга болох хайхралгүй орхиж боломгүй гайхамшигтай илрэл ирсэн. Энэ бол Пинселвани мужийн Ланкастер дүүргийн жижигхэн хот Колумбид орондоо хэвтэж байхад минь зүүд буюу зүүдэнд ирсэн үзэгдэл байсан. Би Гетсеманы Цэцэрглэгт Аврагчийн зовон тарчлалтын гэрч болсон мэт санагдсан. Би Түүнийг урьд өмнө нь хэзээ ч хэнийг ч харж байгаагүйгээр тод

харж байв. Би модны ард зогсож газраас дээр зогсож буй Есүс, Петр, Иаков, Иоханыг миний баруун гар талын явган хаалгаар бууж ирэхийг харсан юм. Гурван Төлөөлөгчдөө өвдөг сөгдөн залбир гэж хэлэн тэнд үлдээсний дараа Бурханы Хүү нөгөө талд нь очоод Тэр бас өвдөг сөгдөн залбирав. Энэ нь Библи уншагчдад танил 'Аав минь, хэрэв боломжтой бол энэ аягыг надас холдуулаач, гэвч миний хүслээр биш таны хүслээр болог' гэсэн тэрхүү залбирал байв.

"Миний өмнө зогсоод Түүнийг залбирахад нулимс нүүрийг даган урсав. Үүнийг харан сэтгэл маань ихэд хөдөлж ариун хайраар уйлав. Миний бүх зүрх сэтгэл Түүн рүү очив. Би бүх зүрх сэтгэлээрээ Түүнд хайртай ба Түүнтэй хамт байхаас өөр юу ч хүсэхгүй байв.

"Дараа нь Тэр босож ирээд өвдөглөсөн чигээрээ дорхноо унтчихсан Төлөөлөгч нар луугаа алхав. Тэр тэднийг зөөлхөн сэгсэрч сэрээгээд, уур болон хүлээцгүй байдлаа үзүүлэлгүй намуухан дуугарч тэднээс, та нар надтай хамт ганцхан цаг ч цуг байж чадахгүй нь үү гэж гутрангуйгаар асуув. Тэнд тэр дэлхийн гэм нүглийн аймшигт хүнд жинг мөрөн дээрээ үүрч, Түүний эмзэг сүнс бүх эрэгтэй, эмэгтэй, хүүхэд бүрийн хүчтэй өвдөлтийг хурцаар мэдэрч байхад тэд Түүнтэй хамт ганцхан цаг сэрүүн байж чадсангүй (*Through Memory's Halls* [Independence, Mo.: Zion's Printing and Publishing Co., 1930], p. 82).

Судар ба ярилцлага

- Христийн бидний нүглийн төлөө зовсныг бид хэрхэн санаж мөн талархаж чадах вэ?
- Цагаатгалыг амьдралдаа үр дүнтэй болгохын тулд бид юу хийх ёстой вэ?

Самбарт *Хиламан 14:13*-ыг бичиж нэг залуу эрэгтэйгээр чангаар уншуул.

- Хэрэв бид Есүс Христэд үнэнээсээ итгэвэл бид юу хийх вэ?

Самбарт *С ба Г 58:43*-ыг бичиж нэг залуу эрэгтэйгээр чангаар уншуул.

- Энэхүү судрын дагуу нүглээ үнэхээр наманчилсан хүн юу хийх ёстой вэ?

Самбарт *С ба Г 19:16–19*-ийг бичиж энэхүү шүлгүүдийг нэг залуу эрэгтэйгээр чангаар уншуул.

- Есүс Христ та нарын нүглийн төлөө шаналж зовсон бөгөөд хэрвээ та нар нүглээ наманчилбал та нар тэдний төлөө зовохгүй байх болно гэдгийг мэдэх нь та нарт ямар санагдаж байна?

Есүс Христэд Итгэх Итгэл нь Биднийг Үүргээ Илүү Сайн Биелүүлэхэд Уриалдаг

Судар ба ярилцлага

- Бид түүнд итгэлтэй байгаагаа Их Эзэнд хэрхэн үзүүлж чадах вэ? (сайн ажлаар.)

Иаков 2:17–18-ыг хамтдаа уншиж залуу эрэгтэйчүүдээр энэхүү шүлгийг тэмдэглүүл.

- Есүс Христэд итгэлтэй залуу эрэгтэй нь биеэ авч явах байдлаараа итгэлгүй нэгнээс хэрхэн ялгарах вэ?
- Итгэл чинь та нарын амьдралд хэрхэн өөрчлөлт оруулсан бэ?

Тэнгэрлэг Эцэг зөвхөн итгэхээс гадна Аароны Пристийн зэрэгтнээс илүү ихийг шаарддагийг онцолж хэл.

- Есүс Христэд итгэлтэй залуу эрэгтэй Аароны Пристийн Зэрэгтний үүргийг биелүүлэхийн төлөө яагаад илүү шаргуу ажилладаг вэ? (Тэрээр пристийн ажилдаа бусдад туслах хүсэлтэй байх болно. Тэрээр пристийн зэргээ хүндэтгэж, даалгавраа биелүүлж, бусадтай сайн мэдээг хуваалцаж, мөн даалгавар хүлээн авах хүсэлтэй байх болно.)

Нөхцлийн судалгаа

Аароны Пристийн зэрэгтэн пристийн зэрэг дэх дуудлагаа эрхэмлэн биелүүлснээр Есүс Христэд итгэх итгэлээ хэрхэн харуулж болохыг илүү тодорхой үзүүлэхийн тулд залуу эрэгтэйчүүдээр дараах нөхцлийн судалгаануудыг хэлэлцүүл.

1. Роберт хэсэгт нүүж ирсэн цагаасаа хойш идэвх султай байсан. Эхний хэдэн сард тэрээр пристийн зэрэгтний цуглаанд тогтмол очдоггүй байв. Харин одоо чуулганы гишүүдтэйгээ улам бүр бага ярьж, сургууль дээрээ тэднээс зайлсхийх болсон.

- Хэрэв та нар Робертийн чуулганд гишүүн нь байсан бол Есүс Христэд итгэх итгэлээ харуулан хэрхэн хандах байсан бэ?

Хэрэв танд идэвх султай залуу эрэгтэйчүүд байгаа бол идэвхтэй залуу эрэгтэйчүүдийг тэдэнтэй нөхөрлүүлж мөн тэднийг идэвхтэй болоход нь туслахаар төлөвлөх оновчтой цаг байж болох юм.

2. Холмэс ах эгч хоёр дөч гаруй жил Сүмдээ идэвхтэй байгаа. Одоо тэд хоёулхнаа амьдардаг. Тэдний бүх хүүхдүүд нь өсөж том болоод хол байдаг хотуудад амьдардаг. Холмэсуудад нэлээн том талбай мөн цэцэрлэг байдаг ба Холмэс ах өнгөрсөн жил цус харвахаасаа өмнө үүнийгээ сайн арчилдаг байлаа.

- Та өөрийгөө тэдний гэрийн багш нарын нэг байсан гэж бод. Есүс Христэд итгэх итгэлээ харуулахаар та нар хариу үйлдэл хэрхэн хийх байсан бэ?

- Холмэсуудын Есүс Христэд итгэх итгэлийг нь хүчтэй болгохын тулд та нар юу хийж болох вэ?

3. Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөх чуулганы цуглаан дээр хэлэхдээ, “Тусламжийн ферм дээр хагас сайн өдөр дөрвөн цаг ажиллаж өгөх Аароны пристийн зэрэгтэн гурван ах надад хэрэгтэй байна. Энэ үүрэгт ажилд хэн явмаар байна?” гэлээ.

- Есүс Христэд итгэлтэй Аароны Пристийн зэрэгтэн энэ тусламжийн хүсэлтэд хэрхэн хариулах вэ?

- Энэхүү үүрэгт ажилд сайн дураар хамрагдах нь яагаад Есүс Христэд итгэлээ харуулах зам болж байна вэ?

- Аароны Пристийн зэрэгтэн нь итгэлээ хөгжүүлэх болон хүчтэй болгохын тулд юу хийж болох вэ? (Итгэлийн төлөө залбирах; Есүс Христийн амьдрал ба үүргийг судалж ойлгох; бусдад үйлчлэх, Есүс агуу үйлчлэгч байсныг санах; Есүсийн заасан зарлигуудыг сахих ба Бурханаас үүний үнэний тухай асуух; пристийн зэргийн үүрэг даалгавраа сайн биелүүлэхэд илүү чармайлт гаргах.)

Дүгнэлт

Зөвлөхийн танилцуулга

Хэрэв тэд Есүс бол Аврагч гэсэн итгэлтэй байвал тэд нүглээ наманчилж мөн Аврагчийн цагаатгалын адислалуудыг хүлээн авахад зохистой амьдрах болно гэдгийг залуу эрэгтэйчүүдэд тайлбарла. Хэрвээ тэд Есүст бусдын амьдралыг адислах хүч байгаад итгэлтэй байвал Түүний, тэдэнд бусдын амьдралыг адислахаар өгсөн пристийн зэргийн хүчийг ашиглахыг хичээж бас тэд пристийн зэргээ хүндэтгэх болно. Тэд түүнд итгэлээ үзүүлж, зарлигуудыг сахиж, бусдад түүнд итгэлтэй бай гэж зааж, мөн пристийн зэргийн ёслолуудыг хийж бусдад тусалснаар бид Аврагчийн үр нөлөөтэй төлөөлөгч нар болсон.

Уриалга

Залуу эрэгтэйчүүдийг Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэхийг уриал. Та тэд нараас дараах зүйлсийг хийхийг хүсэж болно:

1. Та нар дараагийн удаа ариун ёслолыг бэлтгэхдээ, үүнийг Аврагчид итгэлээ үзүүлэх замаар хийж байгаа юу гэж өөрөөсөө асуу.
2. Есүс Христийн цагаатгалд итгэх итгэлд чинь нийцээгүй, та нарын хийдэг ямар нэгэн зүйлийг тодорхойл. Сайжирч, илүү их итгэлтэй болохын төлөө залбирахаа амла; тэгээд амлалтаа биелүүл.

4

Ариун Сүнстэй Хамт Байх нь

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр Ариун Сүнснээс өдөр тутмын тусламж хүлээн авч чадна гэдгийг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

Шаардагдах материалууд: залуу эрэгтэй бүрт судар.

ТАЙЛБАР

Сүмийн олон залуу эрэгтэйчүүд Ариун Сүнсний бэлгийг өөрсдийн чадах тогтмол байдлаар хэрэглэдэггүй. Бэлэг нь тэднийг өдөр бүр адислаж залахаар байдаг, харин үүнийг хэрэглэхэд зүтгэл чармайлт хэрэгтэй. Энэ хичээл нь залуу эрэгтэйчүүдийг Ариун Сүнсний бэлгийг илүү их ашиглаж мөн тэднийг итгэлтэйгээр ашиглахад нь урамшуулна.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Ярилцлага

Ариун Сүнсний Бэлэг нь Бурханы Үнэт Бэлэг Мөн

- Олон цаг бодож хайсны дараагаар та гэр бүлийнхээ гишүүнд өгөх төрсөн өдрийн бэлгийг арай гэж шийдлээ гэж бод. Та түүнийг үүнд дуртай байх бөгөөд хэрэглэх болно гэдэгт эргэлзээгүй байлаа. Та бэлгээ түүнд өгөхөд тэрээр, “Баярлалаа,” гэж хэлээд хойш нь тавьчихав. Хэдэн долоо хоногийн дараа тэрээр үүнийг нэг ч удаа хэрэглээгүйг та ажигласан. Танд ямар сэтгэгдэл төрөх вэ? Яагаад?

- Та нарыг усаар батлуулахад Тэнгэрлэг Эцэг ямар бэлэг өгсөн бэ? (Ариун Сүнсний бэлэг.)

- Энэ чухал бэлгийг та нар хэрхэн хэрэглэж байна вэ?

- Энэ бэлгээ та нар хэрэглэхгүй бол Тэнгэрлэг Эцэгт ямар сэтгэгдэл төрж болох вэ?

Бид Сүмийн гишүүнээр батлуулахдаа үүрдийн хамтрагч байх Ариун Сүнсийг хүлээн авсан гэдгийг тайлбарла. Ариун Сүнсний бэлэг нь бид Тэнгэрлэг Эцэгийн өмнө буцаж очиход туслахад зайлшгүй хэрэгтэй. Энэхүү бэлгийг ухаалаг ашиглахын тулд бид үүний талаар чадах бүхнээ сурч мөн энэ нь хэрхэн яаж ажилладгийг сурах ёстой.

Судар ба ярилцлага

- Ариун Сүнс гэж хэн бэ? (Бурхан тэргүүтний гурав дахь гишүүн.)

- Хэрэв та нар үүнийг мэдэхгүй хүнд Ариун Сүнсний талаар тайлбарлавал юу гэж хэлэх вэ?

Залуу эрэгтэйчүүдээр Сургаал ба Гэрээний 130:22-ыг уншуулж тэмдэглүүл. Тэднийг Ариун Сүнс бол хүний дүрстэй сүнсэн бие гэдгийг ойлгоход анхаар.

Ишлэл ба ярилцлага

Ерөнхийлөгч Лорензо Снөугийн дараах мэдэгдлээс тэд Ариун Сүнсний тухай юу сурч чадах талаар сонсохыг залуу эрэгтэйчүүдээс хүс:

“Бид сайн мэдээг хүлээн авч усан баталгааны ус руу орж, дараа нь бидэн дээр гараа тавьж Ариун Сүнсний бэлэг өгсөн цагаас хойш хэрэв бид буруу зүйл хийж эдгээрийг өөрсдөөсөө холдуулахгүй бол бидэнд найз байгаа. Тэр найз бол Ариун Сүнс бөгөөд Бурханы зүйлсийг хүртдэг ба тэднийг бидэнд үзүүлдэг Ариун Сүнс юм” (in Conference Report, Apr. 1899, p. 52).

- Бид энэ мэдэгдлээс Ариун Сүнсний тухай юу сурч чадах вэ?

Тэр бидний нөхөр ба түүнтэй хамтрагч байхын тулд бид зохистой амьдрах ёстой гэдгийг онцол.

- Зохистой амьдрах гэж юу вэ?

Энэхүү асуултыг залуу эрэгтэйчүүдээр ярилцуул. Та тэдний хариултуудыг самбар дээр бичиж болно.

Зохистой амьдрах гэдэгт шүтэн бишрэх, залбирал, муу муухай зүйлсгүйгээр өөрсдийнхөө биеийг цэвэр ариун байлгах, бүдүүлэг байдлаас зайлсхийх зэрэг зүйлс хамрагдана. Бид тохиромжтой бус газар очиж мөн шударга бус нөхцөлтэй өөрсдийгөө орооцолдуулбал бидний Ариун Сүнсний захиасыг хүлээн авах нь муудаж болох ба бид ямар ч харилцаагүй болж болох юм.

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр 1 Нифай 16:10-ыг уншуул.

- Тэр луужин буюу бөмбөрцгийг юу гэж нэрлэж байсан бэ? (Лиахона)

Тэднээр 1 Нифай 16:28-ыг уншуул.

- Ямар нөхцөлд Лиахона саадгүй ажилладаг вэ? (Итгэл, хичээл зүтгэл, мөн анхаарал тавихад)

Залуу эрэгтэйчүүдээр 1 Нифай 16:11–12-ыг уншуул.

- Лэмэн, Лэмүэл хоёр Нифайг хүлэхэд Лиахона яасан бэ?(Энэ нь тэдний нүглээс болж ажиллахаа больсон.)

Залуу эрэгтэйчүүдээр 1 Нифай 18:21-ийг уншуул.

- Лиахона хэзээнээс дахин ажиллаж эхэлсэн бэ?
- Эцэст нь Лиахона Нифай болон түүний гэр бүлийг хааш нь хөтөлсөн бэ? (Амласан газар луу.)
- Ариун Сүнс нь бидний хувийн Лиахона хэрхэн болдог вэ? (Мөн тэрээр бидний итгэл болон зөв шударга байдлаас хамаарч ажилладаг. Хэрэв бид түүний өдөөлтийг дагавал амласан газар болох сэлэсчел хаант улс руу хөтлөгдөх болно.)

Бид Ариун Сүнсний Нөлөөг Таньж Сурах Ёстой

Зөвлөхийн танилцуулга

Ариун Сүнсний ятгалгыг сонсдог, ойлгодог болоход дадлага болон чармайлт хэрэгтэй. Ер нь бид Ариун Сүнснээс дуу хоолойгоор болон гэнэтийн илрэлээр тусламжийг хүлээж авдаггүй. Голдуу бидний ухамсраар дамжин Ариун Сүнсний шивнээ ирдэг. Зааварчилгааг нь дагалддаг тайван мэдрэмжээр түүнийг таньж болдог тул Ариун Сүнсийг заримдаа “намуухан, чимээгүй дуу” гэж хэлдэг. Тэрээр бидний санаа бодол мөн зүрх сэтгэлд нөлөөлдөг (С ба Г 8:2–3; 85:6-г үз).

Ишлэл

Ахлагч Боид К.Пакер Сүмийн залуу үеийнхэнд дараахыг гэрчлэн хэлсэн:

“Та нар залуудаа эцэг эх, багш нар, удирдлагуудынхаа зөвлөгөөг сонсвол, бүхнээс сайн залагч болох Ариун Сүнсний шивнээг хэрхэн дагахыг сурч чадна. Энэ нь хувийн илчлэлт юм. Сүнслэг аюулаас бид сэргэмжлэгдэж болох үе шат байдаг. . . .

“Хэрэв бид та нарт энэ сүнслэг харилцаануудыг сонсохыг зааж чадвал та нар хамгаалагдах болно. . . . та нар өндрөөс залагдахад ямархуу мэдрэмжтэй байдаг талаар сурч чадна. Энэ сүнслэг урам нь одоо, зөвхөн та нарын Сүмийн ажлууд төдийгүй бусад бүх л үйл ажиллагаануудад, сургууль дээр, мөн болзоонд явахад чинь ирж болно.

“Одооноос залбирах болон залбирлынхаа хариултыг хэрхэн хүлээн авахыг сур. Та нар ямар нэгэн зүйлийн төлөө залбирахдаа түүнийхээ хариултыг авахын өмнө тэвчээртэйгээр урт удаан хугацаагаар хүлээх ёстой. Зарим залбирал нь баталгаатай байхын тулд тэр дороо хариулагдсан байх хэрэгтэй байдаг ба зарим өдүүлбэр нь та нарыг залбираа ч үгүй байхад ирдэг. . . .

“Та нарын залуудаа хийх ёстой зүйл бол сүнсээрээ хүчтэй байж бусдаас хамаарахгүй болохын тулд та нарыг удирдах зааварчилгаанд дуулгавартай байх явдал юм. Хэрэв та нар тэднийг сахиж мөн үүнийг хүссэн сэтгэлээр хийвэл, та нар нарийн, мэдрэмтгий, сүнслэг өдүүлбэрүүдэд итгэж сурна. Мөн тэдгээр нь байнга, хувиршгүйгээр та нарыг шударга зүйлсийг хийхэд удирдаж байна гэдгийг мэдэх болно” (in Conference Refort, Apr. 1976, pp. 46–47; or *Ensign*, May 1976, pp. 31–32).

- Ариун Сүнсний шивнээг дагахыг бид яаж сурч чадах вэ? (Багаасаа эцэг эх болон удирдагчдынхаа зөвлөгөөг дагаснаар.)
- Ариун Сүнснээс ирэх сүнслэг урам нь ямар төрлийн үйл ажиллагаанд та нарт тусалсан бэ?
- Та нар Ариун Сүнсний урмыг хэзээ мэдэрсэн бэ?

Ариун Сүнс Хамгаалж, Тайвшруулж мөн Сүнслэг Урам Хайрлах Болно

Зөвлөхийн танилцуулга

Өөрийн амьдралдаа Ариун Сүнсээр хамгаалагдаж, тайвшруулагдаж, мөн сүнслэг урам хүлээн авсан тухайгаа хуваалцаж, залуу эрэгтэйчүүдийг бас хуваалцахыг урь. Өөртөө байгаа цагаас шалтгаалж, мөн ярилцлагын байдлаас хамааруулан та дараах яриаг ашиглаж болно.

Түүх

Билл сургууль дээрээ ярианы хичээл авч байсан бөгөөд маргаантай сэдвээр яриа өгөхөөр томилогдсон байв. Яриа нь түүний дүнгийн хагаст тооцогдох юм. Сэдвээ шийдвэрлэж чадаагүй тул Билл тусламж гуйн залбирлаа. “Хэрэв та нар маргаантай сэдэв хайж байгаа бол Мормоны Номыг сонго” гэсэн сэтгэгдэл түүнд ирэв.

Хэн нэгнийг гомдоохгүй хэмээн найдаж Билл танилцуулгаа номын түүх болон агуулгын тухай тайлбарласнаар эхлэв. Гэвч дахиад Сүнс түүнд ирлээ. “Надад юу тохиолдох нь хамаагүй ба миний дүн ямар байх нь хамаагүй. Мормоны Ном бол үнэн тэд бүгд үүнийг мэдэх хэрэгтэй” гэж тэрээр дотроо бодов. Тэгээд тэрээр сонирхогч нартай ярилцаж байгаа мэт Мормоны Номын өөрийн гэрчлэлээ хуваалцан тэдэнд зааж эхэллээ.

Тэрээр дуусгасныхаа дараа бусад оюутнууд түүнийг шоолохыг хүлээж байлаа. Гэтэл харин ч тэд маш эерэг хариулжээ. “Та нар ярьсан үнэндээ намайг бараг итгүүлчихлээ” гэж хэд нь бичжээ. Өөр нэг оюутан “Би танай сүмийн талаар үнэхээр илүү ихийг мэдэхийг хүсэж байна” гэж бичлээ (Gene R. Cook, “Trust the Lord,” *Ensign*-аас авав. Mar. 1986, p. 79).

Түүх

Роберт дэрэндээ нүүрээрээ шигдэв. Түүний хоолой боож өвдөж байлаа. Тэрээр уйлмаар байв. Оршуулга дууссанаас хойш тэр оройжингоо ийн байлаа. Энэ нь маш шударга биш санагдаж байв.

Түүний аав нь нас барахаар тийм хөгшин биш байсан ба энэ нь хүн бүхнийг гайхуулав. Энэ гарзаас болж тэрээр уй гашууд автсан ба түүний нулимс гарч буйг тэрээр мэдэрсэн. Дараа нь тэр залбираагүйгээ санатгуут орноосоо гулсан бууж өвдгөн дээрээ сөхрөөд заншсанаасаа өөрөөр залбирч эхэллээ. Гэнэт тэрээр Их Эзэнтэй жинхэнээсээ ярьж байсан ба түүнд өөрийнхөө зүрхний өвдөлт болон мөн түүнийг ойлгодоггүй тухайгаа хэлсэн. Тэрээр “Яагаад? Яагаад энэ зүйл болох болсон бэ?” гэж дахин дахин асуулаа.

Тэнд ямар ч дуу чимээ, гэрэл, мөн мэдэгдэхүйц хариулт байсангүй, гэхдээ Роберт гэнэт тайвширч, амар амгаланг мэдрэв. Тэрээр түүний аавд бүх зүйлс сайн байх болно гэдгийг мэдсэн ба үүнийг дагалдах ганцаардлын хэцүү мөчүүд болон дотны хүмүүсээ алдахыг эс тооцвол Тэнгэрлэг Эцэг түүний нөхцөлийг мэдэж байсан ба Ариун Сүнсээр түүнд бүх зүйл сайн байх болно гэсэн баталгааг өгсөн юм.

- Тусламж хэрэгтэй хүмүүсийг Ариун Сүнс хэрхэн тайвшруулдаг вэ?

Дүгнэлт

Гэрчлэл ба уриалга

Ариун Сүнсний өдүүлбэрийг хүлээн авахын тулд зохистой амьдрахыг мөн намуухан, чимээгүй дуу тэдний үйлдлийг залдаг тул сонсохыг залуу эрэгтэйчүүдэд сануул. Үүнийг хийснээр залуу эрэгтэйчүүд олон асуудлаас зайлсхийж чадах ба амьдралдаа агуу баяр баясгалан болон аз жаргалыг олох болно гэдгийг гэрчил.

Залуу эрэгтэйчүүдийг Ариун Сүнсний удирдамжийг анхааралтай сонсож, мөн өдрийн тэмдэглэлдээ онцгой тохиолдлуудаа бичиж байхыг уриал.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр сонголтоо ашиглаж зөвийг сонгосноор өөрийн хувийн эрх чөлөөг нэмэгдүүлж чадахыг сурах болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаанууд.
2. Самбар дээр Ерөнхийлөгч Дэвид О.МакКэйн мэдэгдлийн дармал хэсгийг бич.
3. Хэрэв танай бүсэд *Family Home Evening Video Supplement* (53276) байгаа бол “Бидний Сонголтын Үр Дагавар (Шахуурга)” 6-р хэсгийг үзүүл.

ТАЙЛБАР

Египет рүү худалдагдсан Иосефийн түүхийг залбирч унш (Эхлэл 37; 39–45-ыг үз). Түүний амьдрал бидэнд сонголт болон эрх чөлөөний тухай ихийг заадаг. Хэдийгээр тэрээр бие махбодиороо эрх чөлөөгүй байсан ч өөрийнхөө сүнслэг эрх чөлөөг хадгалж бас үнэнхүү итгэлтэй байсан. Түүний жишээ бол Аароны Пристийн зэрэгтэн бүрийн дагах ёстой нэг зүйл юм.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Самбар ба
ярилцлага

Оршил

Дараах тэмдгийг самбар дээр зур:



Залуу эрэгтэйчүүдээс тэднийг усанд сэлэх газар хайж очиход нь тийм тэмдэг байсан гэж төсөөлөхийг хүс.

- Иймэрхүү тэмдэг бидний эрх чөлөөг хязгаарлах уу?
- Энэ нөхцөлд бидэнд ямар сонголтууд байж болох вэ? (Бид өөр ямар нэгэн газар сэлж болно; бид гэртээ харьж болно; бид тэмдгийг үл тоомсорлон аюултай газар усанд сэлж болно.)
- Эргүүлэг биднийг шүүрэн доош татан оруулбал бидэнд ямар сонголтууд байж болох вэ?
- Хэдийгээр бид үйлдлээ чөлөөтэй сонгодог ч гэсэн, үйлдлийнхээ үр дагавар, уршигийг ихэвчлэн сонгож болдоггүй. Яагаад ийм байдаг вэ? (Уршиг үр дагавартай.)

Ишлэл	<p>Ерөнхийлөгч Дэвид О.МакКэйн дараах мэдэгдлийг унш:</p> <p>“Амьдралыг шагнал болгон өгсний зэрэгцээ, тэрхүү амьдралыг удирдах эрхийг нь олгосон явдал бол хүмүүнд өгсөн Бурханы агуу бэлэг. . . . <i>Сонгох эрх чөлөө бол дэлхийн өгч чадах ямар ч эд хөрөнгөөс илүү үнэт зүйл юм</i>” (in Conference Report, Apr. 1950, p. 32).</p> <ul style="list-style-type: none"> • Бид өөрсдийн сонгох эрх чөлөөг хэрхэн илүү их үнэлж чадах вэ?
Судар унших ба тэмдэглэх	<p>Залуу эрэгтэйчүүдийн нэгээр Хиламан 14:30-ийг чангаар уншуул. Залуу эрэгтэйчүүдийг <i>та нар чөлөөтэй; та нар өөрсдийнхөө төлөө үйлдэхээр зөвшөөрөгдсөн, Бурхан та нарт мэдлэгийг өгч, мөн тэрээр та нарыг чөлөөтэй болгосон</i> гэсэн үгсийг тэмдэглэхийг зөвлө.</p> <ul style="list-style-type: none"> • Энэхүү шүлэг нь та нарын хувьд ямар утгатай вэ? <p>Хүн бүхэн сонголттой гэдгийг ойлгоход нь залуу эрэгтэйчүүдэд тусал. Бид бүхэн сайн муугийн хооронд сонголт хийж болох боловч сонголт хийснийхээ дараа үүнийхээ үр дагаврыг хүлээн зөвшөөрөх ёстой.</p>

Судраас суралцах ба ярилцлага	<p>Сонголтыг Зөвөөр Хэрэглэх нь Бидний Хувийн Эрх Чөлөөг Нэмэгдүүлдэг</p> <p>Залуу эрэгтэйчүүдээр Эхлэл 37-г гаргуулж чимээгүй уншуул. Тэд судруудад гардаг агуу хүмүүсийн нэг болох Египетэд худалдагдсан Иосефийн үйлдлийг судлах болно гэдгийг тайлбарла.</p> <p>Дараах асуултууд нь залуу эрэгтэйчүүдэд судраас тэдний анзааралгүй өнгөрөөж болох ямар нэгэн юмыг харахад нь туслах зорилгоор зөвлөхөд туслахаар өгөгдсөн. Эдгээр асуулт болон үүнтэй төстэй бусад асуултуудыг хэрэглэ. Эдгээрийг гарын авлагаас бүү унш.</p> <ul style="list-style-type: none"> • Хэн нь хамгийн их эрх чөлөөтэй бэ? Иосеф үү, түүний ах нар уу? • Иосеф аль талаараа эрх чөлөөгүй вэ? • Иосеф аль талаараа эрх чөлөөтэй вэ? • Иосефийн ах нар ямар талаар эрх чөлөөтэй вэ? • Тэд ямар талаар эрх чөлөөгүй вэ? <p>Залуу эрэгтэйчүүдээр Эхлэл 39:1–4-ийг уншуул.</p> <ul style="list-style-type: none"> • Иосеф Тэрээр Потифарт анх худалдагдаж байхдаа ямар замаар эрх чөлөөтэй байсан бэ? • Тэр ямар замаар эрх чөлөөгүй байсан бэ? • Түүний зөв шударга байдлаас болж Иосеф ямар ямар эрх чөлөөг олж авсан бэ? <p>Залуу эрэгтэйчүүдээр Эхлэл 39:7–20-ийг уншуул.</p> <ul style="list-style-type: none"> • Иосеф Потифарын эхнэрийн уруу таталтыг эсэргүүцсэнээр ямар эрх чөлөөг алдсан бэ? • Иосеф ямар эрх чөлөөг олж авсан бэ? • Потифарын эхнэр аль талаараа эрх чөлөөтэй байсан бэ? • Тэр ямар талаараа эрх чөлөөгүй байсан бэ? <p>Залуу эрэгтэйчүүдээр Эхлэл 39:21–22-ыг уншуул.</p> <ul style="list-style-type: none"> • Иосеф шоронд байхдаа ямар ямар эрх чөлөөг олж авсан бэ? • Тэр энэхүү эрх чөлөөгөө хэрхэн олж чадсан бэ? <p>Залуу эрэгтэйчүүдээр Эхлэл 40:8–15, 20–23-ыг уншуул.</p> <ul style="list-style-type: none"> • Ахлах үйлчлэгч шоронг орхиж явахад нь Иосеф ямар эрх чөлөөтэй болно гэж бодсон бэ? • Фараоны зүүдийг тайлсны дараа Иосеф ямар эрх чөлөөг олсон бэ?
-------------------------------	--

- Биеийн болон сүнслэг эрх чөлөөг хоёуланг нь авч үзвэл Египетэд хэн нь хамгийн эрх чөлөөтэй хүн байсан бэ?

Залуу эрэгтэйчүүдээр Эхлэл 42:1–3-ыг уншуул.

- Иосефийн гэр бүл аль талаараа эрх чөлөөгүй байсан бэ? (Тэд бие махбодийн гачланд байсан, учир нь тэдэнд хоол байгаагүй.)

Залуу эрэгтэйчүүдээр Эхлэл 50:15–21-ийг уншуул.

- Иосефийн ах нар арван таваас илүү жил ямар төрлийн гачланд байсан бэ?
- Хэрэв Иосеф өширхөн өөрийн ах нараас өшөөгөө авахыг оролдсон бол ямар эрх чөлөөг алдах байсан бэ?
- Яагаад Иосеф өөрийг нь бие махбодийн гачланд оруулсан зүйлүүдийг хийж сонголтоо ашигласан гэж та нар бодож байна вэ?
- Иосеф бидэнд зөв сонголтууд ба тэдгээрийн үр дагаврын талаар ямар зөвлөмжүүд өгөх байсан гэж та нар бодож байна вэ?

Дүгнэлт

Гэрчлэл ба уриалга

Их Эзэнийг дагахаар өөрийн сонголтоо ашигласнаар ирэх эрх чөлөөний талаар өөрийн бодол санаагаа хуваалц. Боломжтой бол энэхүү зарчмыг дэмжиж хувийн туршлагаа ярь.

Залуу эрэгтэйчүүдэд дараах уриалгыг өг:

1. Иосефийн түүхийг дахин уншиж, тэр ухаалаг сонголт хийснээр хэрхэн сайн зүйлийн хүчтэй зэмсэг болсныг тунгаан бод.
2. Өөрийн болон эргэн тойрныхны амьдралаас сонголтуудын эрх чөлөөнд нөлөөлдөг замуудыг ярилц.
3. Энэ долоо хоногт сайн санааны нэг гол үйлдэл буюу үйлчлэл хийж Их Эзэний зарлигуудад хүсэлтэйгээр дуулгавартай байхаа харуул. Үр дүнг нь хувийн тэмдэглэлдээ тэмдэглэ.

6

Христийн Адил Үйлчлэл

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр пристийн зэргийн үүргээ биелүүлснээр бусдад үйлчлэх хүсэлтэй болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаа.
 - в. Хоёр ба гурван багаж аль эсвэл багажны зураг.
-

ТАЙЛБАР

Энэ хичээл нь Аврагчийн амьдралын үйлчлэлийг залуу эрэгтэй бүрт жишээ болгон холбож өгөх боломжийг танд өгч байна. Есүс Христ бусдад үйлчилж мөн тэдэнд сайн мэдээг заахад амьдралаа зориулсан. Тэрээр биднийг нүглээс аварч өөрийн амиа сайн дураар золиосолсноор агуу үйлчлэлээ хийсэн (1 Нифай 11:13–33; 3 Нифай 27:13–16; С ба Г 76:40–42). Бид Христ шиг үйлчлэл хийснээр Христэд өөрийн итгэлээ үзүүлдэг гэдгийг залуу эрэгтэй бүрт ойлгуул.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Үзүүлэнтэй хичээл
ба ярилцлага

Пристийн Зэргийн Үүргийн Мөн Чанар Бол Үйлчлэл Юм

Хэдэн багаж болон багажны зургийг үзүүл.

- Эдгээр багажийг юу ажиллуулдаг вэ?

Эдгээр багаж ямар ч зорилготой байсан гэсэн зөвхөн хүний гарт л ажиллаж чадна гэсэн дүгнэлтэнд хүрэхэд нь залуу эрэгтэйчүүдэд тусал.

Ишлэл

Ахлагч Марион Д.Хэнкс Тэнгэрлэг Эцэгийн ажиллахдаа хэрэглэх ёстой нэгэн багажийг тайлбарласан:

“Их Эзэн өөрийн үйлчлэгчдийнхээ тухай хэлсэн нь, ‘Тэдний гар нь миний гар байх болно’ [С ба Г 35:14]. Та нар энэ талаар бодож үзсэн үү? . . . Их Эзэн миний энэ гарыг түүний гар гэсэн. Энэ бодол санаа, хэл яриа, гар, хөл, энэ түрийвч бол намайг санаа тавьж байсан цагт түүний хэрэглэж ажиллах багажууд юм. . . . Та нарыг санаа тавьж буй цагт та нарын гар, та нарын нөөц, та нарын оюун ухаан, та нарын хэл яриа, та нарын эрч хүч бол зөвхөн Их Эзэнтэй ажиллах багажууд юм” (Service, Brigham Young University Speeches of the Year [Provo, 15 Oct. 1948], p. 3).

- Энэхүү мэдэгдэл нь та нарын хувьд ямар утгатай вэ?

Ишлэл

Ерөнхийлөгч Томас С.Монсон бид бол Их Эзэний багажууд гэж илүү тодотгон хэлсэн:

“Пристийн зэрэгтэн бүр . . . үйлчлэх дуудлагатай, тэрээр бүхий л хүчин чармайлтаа үүрэгт ажилдаа зориулдаг. Ямар ч даалгавар, Их Эзэний ямар ч ажил бага биш, учир нь бүгд л мөнхийн үр дагавартай. Ерөнхийлөгч Жоон Тэйлор бидэнд анхааруулахдаа: ‘Хэрэв та нар өөрсдийнхөө дуудлагыг эрхэмлэн биелүүлэхгүй бол Бурхан та нарын биелүүлэх ёстой үүрэг байсан та нарын аварч болох байсан хүмүүсийн төлөө та нарт хариуцлага хүлээлгэнэ. Мөн бидний хэн нь хүмүүний сүнсний мөнхийн амьдралыг хойшлуулахыг хариуцах вэ?’ . . .

“Хуучны зүйр үг мөнхөд үнэн байдаг: ‘Хийж чадахынхаа хэрээр сайн хий; бусдыг нь Бурхандаа даатга.’

“Пристийн зэрэгтнүүдийн өгч буй ихэнх үйлчлэл нь дуу шуугиан бололгүй, зарлаж мэдээлэлгүйгээр гүйцэтгэгддэг. Нөхөрсөг инээд, дулаахан алга ташилт, үнэний чин сэтгэлийн гэрчлэл нь бүрэн утгаар амьдралыг өргөж, хүмүүний мөн чанарыг

өөрчилж, үнэт нандин сүнсүүдийг авардаг” (in Conference Report, Apr. 1992, p. 70; or *Ensign*, May 1992, p. 48).

- Пристийн зэрэгтэн бүр ямар дуудлагатай байдаг вэ?

Үйлчлэх Хүсэлтэй Байх нь Бидний Бусдад Үзүүлэх Хайрыг Харуулдаг

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр Мозая 2:17-г уншуулж тэмдэглүүл. Тэдэнд Матай 25 болон Сургаал ба Гэрээ 42-ыг тэмдэглэхийг зөвлө.

- Энэхүү судрын гол санаа нь юу вэ?
- Бид хэнд үйлчлэхэд амар байдаг вэ?
- Хэнд үйлчлэхэд хэцүү байдаг вэ?
- Та нарын бодлоор Есүс яагаад бид хамгийн багад нь хийж өгч байгаа бол түүнд хийж байгаа гэсэн үг юм гэж заасан бэ? (Хүн бүхэнд хайртай Есүс, бид ч гэсэн бусдыг хайрлаж үйлчлэх ёстой, бүүр бидний дунд буй “хамгийн багынхаа” тухай бодож байх ёстой гэж онцолсон.

Түүх ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр хөгшин загасчны тухай дараах түүхийг уншуул аль эсвэл тэдэнд хэлж өг.

“Манай гэр Балтиморт Жоонс Хопкинсийн Эмнэлгийн орох хаалганы эсрэг талд байдаг байсан. Бид доод давхартаа амьдарч эмнэлгийн гадуур өвчтөнүүдэд дээд давхраа хөлслүүлсэн юм.

“Зуны нэг орой намайг оройн хоол хийж байтал хаалга тогшив. Би хаалга онгойлготол үнэнхүү муухай харагдах хөгшнийг харлаа.

“Түүний хорчийсон биеийг харахдаа би ‘Яагаад энэ хүн миний найман настай хүүгээс бараг өндөр биш байна’ гэж бодсон.

“Гэвч айдастай зүйл бол улайж цус шүүрснээс болж түүний нэг талын хацар нь хавдсан байлаа.

“Оройн мэнд. Намайг ганцхан орой хонуулчих газар та нарт байгаа болов уу гэж бодоод би ирсэн юм. Би Зүүн эргээс өнөө өглөө эмчилгээнд ирсэн юм, гэхдээ маргааш өглөө болтол автобус байхгүй байна’ гэж түүний дуу хоолой аядуухан байлаа.

“Тэр өрөө олохоор өдрөөс хойш хайсан боловч ямар ч амжилт гарсангүй надад гэж хэлсэн. ‘Миний нүүрнээс болсон байх гэж би тааж байна. Энэ нь аймшигтай харагдаж байгаа л даа гэхдээ эмч маань өөр хэдэн эмчилгээ хийх болно. . . .’ гэсэн.

“Тэр мөчид би түдгэлзсэн боловч түүний дараагийн ‘Би энэ үүдний саравчин доор байгаа савлуурт сандал дээр унтаж болно. Автобус өглөө эрт явах болно’ хэмээн хэлсэн үгнүүд намайг үнэмшүүлсэн.

“Түүнийг үүдний саравчинд амарч байх хооронд бид түүнд унтах ор бэлтгэх болно гэж би түүнд хэллээ. Дараа нь би гэртээ ороод оройн хоолоо хийж дуусав. Тэгээд хоолоо идэхэд бэлэн болчихоод би түүнээс бидэнтэй хамт хооллох уу? гэж асуусан.

“Зүгээр, баярлалаа. Надад зөндөө байна’ гэж тэр бор цаасан ууттай юм өргөв.

“Аяга тавгаа угааж дуусаны дараа би гадаа гарч үүдний саравчинд түүнтэй хэдэн минут ярилаа. Тэр хөгшний жаахан биенд багтахааргүй том зүрхтэйг нь олж мэдэхэд нэг их хугацаа зарцуулсангүй.

“Надад хэлэхдээ тэрээр, өөрийн охин түүний таван хүүхэд болон нурууны гэмтлээс болж найдваргүй тахир дутуу болсон түүний нөхрийн амьдралыг дэмжихийн тулд загасчилдаг гэлээ. Тэрээр үүнийг гомдол мэтээр хэлээгүй бөгөөд түүний хэлсэн өгүүлбэр болгонд Бурханд өгсөн адислалуудынх нь төлөө талархсан байдал байлаа. Түүний өвчнийг ямар ч өвдөлт дагалдаагүйд тэр их талархаж байлаа. Энэ нь арьсны хорт хавдрын нэг хэлбэр байв. Тэрээр Бурханд түүнд цааш явах хүч чадлыг өгдөгт нь талархлаа.

“Унтах цаг болоход бид хүүхдийн өрөөнд аяллын ор хөнжил түүнд тавьж өгөв. Намайг өглөө босоход унтсан ороо сайн эвхэн хураасан ба тэр хөгшин үүдний саравчинд байлаа. Өглөөний хоолноос татгалзаж автобус руу явахынхаа яг өмнөхөн нь тэрээр маш их чухал туслалцаа гуйж байгаа мэтээр эргэлзэнгүй, ‘Дараагийн удаа би эмчилгээнд ирэхдээ танайд байж болох уу? гэж хэлэв. Би та нарт төвөг учруулахгүй. Би сандал дээр зүгээр унтаж чадна.’ Жаахан дуугүй байснаа тэр, ‘Танай хүүхдүүд намайг гэртээ байгаа юм шиг байлгасан’ гэж нэмж хэлэв. Том хүүхдүүд миний нүүрэнд санаа зовсон, харин багачууд нь үүнийг тоогоогүй юм шиг байсан.

“Би түүнд дахин ирээрэй гэж хэлсэн. Дараа нь тэр ирэхдээ өглөөний долоон цаг жоохон өнгөрөөж ирсэн. Тэр бидэнд бэлэг болгон нэг том загас мөн миний урьд өмнө нь хэзээ ч харж байгаагүй тийм том хясааг авчирсан байсан. Тэрээр өглөө явахынхаа өмнө эдгээрийг шинэ сайхан байлгахын тулд бэлтгэсэн гэж хэллээ. Түүний явах автобус нь өглөөний 4 цагт хөдлөх байсныг би мэдсэн бөгөөд тэр өглөө хэдэн цагт босч энэ бүхнийг бэлтгэсэн болоо хэмээн би гайхаж байсан юм.

“Олон жилийн турш тэр манайд ирж бидэнтэй хоног өнгөрөөдөг байхдаа загас хясаа болон цэцэрлэгээсээ ногоо авчирдаггүй үе байгаагүй.

“Заримдаа шуудангаар бид илгээмж хүлээн авдаг байсан ба тэр нь үргэлж загас, хясаа мөн навч бүрийг нь сайтар цэвэрлэсэн шинэ бууцай болон байцаа хайрцагласан тусгай илгээмж байдаг байсан. Үүнийг илгээхийн тулд гурван милл газар алхдаг ба хэр зэрэг бага мөнгөтэйг нь мэддэг болохоор энэ нь явуулсан бэлгүүдийг улам их үнэ цэнэтэй болгож байлаа.

“Эдгээр дурсагдах зүйлүүдийг би авах болгондоо анхны өглөө түүнийг явахад манай хажуугийн хөршийн хэлсэн зүйлсийг би байнга боддог. ‘Тэр муухай царайтай хүнийг та нар урьд шөнө гэртээ оруулсан уу? Би түүнийг хөөсөн. Иймэрхүү хүмүүс оруулснаараа хөлслөгчдөө алдаж болно’ гэж тэр хэлсэн.

“Магадгүй нэг хоёр удаа тэгсэн байж болох юм. Гэхдээ хэрэв тэд түүнийг мэдэх л юм бол тэдэнд өвчин зовлонгоо даахад илүү хялбар байх байсан байх аа. Бидний гэр бүл түүнийг мэдсэндээ байнга талархах болно гэдгийг би мэднэ; бид түүнээс мууг гомдоллолгүй хүлээн авч, сайныг Бурханд талархалтайгаар хүлээн авахыг сурсан” (Mary Bartels, “The Old Fisherman,” *Instructor*, May 1968, pp. 180-81).

- Энэхүү түүхэнд ямар ямар төрлийн үйлчлэлийг үзүүлсэн бэ?
- Өгөгч нь хэн бэ? Авагч нь хэн бэ?
- Бусдад үйлчилснээр та нар хэрхэн адислагдсан бэ?

Түүх ба ярилцлага

Үйлчлэлийн ихэнх үйлдэл даалгавар шаарддаггүй гэдгийг тайлбарла. Их Эзэний ажилд өгөөмөр гар, хайраар хандах хандлага, Аврагчийн заасныг харах хараатай байх хэрэгтэй. Ерөнхийлөгч Томас С.Монсон гадасныхаа нэгэн бэлэвсэн эмэгтэйгээс хүлээн авсан дараах захианы тухай хэлсэн:

“Эрхэм хүндэт Ерөнхийлөгч Монсон гуай,

“Би та нарт надад тохиолдсон нэгэн гайхамшигтай явдлаас хэлье. Арван нэгдүгээр сарын эхээр бүх бэлэвсэн эмэгтэйчүүд ба настай хүмүүс нэг сайхан оройн хоолонд очих урилга хүлээн авлаа. Хэсгийн залуучууд унаа гаргах болохоор биднийг унааны талаар санаа зовох хэрэггүй гэлээ.

“Товлосон цаг болоход нэгэн сайхан залуу хонх дарж намайг болон өөр нэг эгчийг Гадасны төв рүү авч явав. Тэрээр машинаа зогсоогоод бас нэг өөр хоёр залуу бид хоёртой хамт сүм рүү орж хоёр эмэгтэй бидний гадуур хувцсыг тайлж соёлын танхимд аваачиж бид хэдэн минут суулаа. Тэгээд хоёр талаараа залуу эрэгтэй болон эмэгтэйг суулгасан ширээнд биднийг аваачиж суулгав. Үүнийхээ дараа бидэнд сайхан оройн хоолоор үйлчлээд . . . дараа нь маш сайхан хөтөлбөр үзүүлэв. . . .

“Энэ нь маш сайхан үдэш байлаа. Бидэнд үзүүлсэн хайр болон хүндэтгэлд нь бидний ихэнх нь ганц, хоёр нулимс унагав.

“Ерөнхийлөгч Монсон гуай, Залуу хүмүүс эдгээр залуусын адил бусадтай харьцахыг харахдаа би Сүмийг сайн гарт байна гэж би мэдэрдэг” (in Conference Report, Oct. 1989, p. 60; or *Ensign*, Nov. 1989, 46).

- Энэ төрлийн үйлчлэл ямар замаар хайрыг үзүүлдэг вэ?
- Хайр болон үйлчлэл хоёр юугаараа холбоотой вэ?
- Үйлчлэл та нарын бусдыг хайрлах хайрыг хэрхэн нэмэгдүүлсэн бэ?

Түүх ба ярилцлага

Ахлагч П.Мелвин Хаммондын дараах түүхийг унш.

“Би Боливид номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байхад нэгэн гайхамшигтай ахлагч надтай ирж уулзсан юм. Түүний номлол дуусахад ойрхон байлаа. Тэрээр сэтгэл санаагаар маш их унасан байв. . . .

“Тэрээр номлолын ажлынхаа эхэнд хийж байсан бүх л зүйлүүд болох сайн ажиллах, байнга залбирах, бүх дүрмийг дагах, мэдээж, зуу зуун усан баталгаануудаар шагнуулна гэж итгэж байсан тухайгаа надад хэллээ. Гэвч харамсалтай нь усан баталгаанууд түүнд ирсэнгүй. Тэрээр аажим аажмаар бага ажиллаж эхлэв. . . .

“Арга нь барагдсан тэрээр надад, ‘Би хэн ч биш! Би юу ч хийсэн ямар ч ялгаа гаргахгүй. Дараа нь цаашлуулан ‘Тийм үү, Ерөнхийлөгч Хаймонд гуай?’ гэж хурдан асуув. Тэр агшинд миний дотор ижил төстэй асуултууд орж ирэв. Тэр ялгаа гаргаж чадах уу? Би чадах уу? Бусад нь чадах уу? Нэг хүний юу хийх нь хамаатай гэж юу?

“Дараа нь би санаандаа өөрчлөлт гаргасан хэмжээлшгүй их хүмүүс болон үйл явдлуудыг харлаа. Түүнд би астрономийн ухаанд эргэлт гаргасан Коперник; энх тайван, хайрыг номлон Энэтхэг орондоо эрх чөлөөг авчирсан Моханда К.Гандигийн тухай санууллаа.

“Би түүнд Иосеф Смит хэрхэн Амьд Бурхан болон Есүс Христийг харсан тухай хэлэв. . . . Тэдгээрийн сануулгыг хэрэгжүүлэн нэгэн хүү ба нэгэн эр дахин сэргээгдсэн сайн мэдээг үндэстэн, ястан, хэлтэн, хүмүүс бүрт номлох замыг бэлтгэх гайхамшигт зорилгыг эхэлсэн.

“Тэгээд би бүхнээс хамгийн чухал болох сүүлийн хэсэгт ирэв. Тэрээр Эцэгийн бие махбодтой . . . цорын ганц Хүү байсан. Нэг л хүн! Мөнхийн Бурханы хүү чамайг болон намайг Мөнхийн Амьдралд найдан дахин амьдруулахын тулд тэрээр өөрийгөө олон зүйлд өргөн барьсан.

“Би гараа залуу номлогч дээр тавиад түүнээс ажлын талбар руугаа буцаж гарахад бэлэн байгаа эсэхийг нь асуулаа. Тэнгэрлэг Эцэгийн Боливын онцгой хүүхдүүдийн амьдралд өөрчлөлт хийж чадах уу? гэж би түүнээс асуусан. . . .

“Хэдийгээр тэр сул дорой байсан ч гэсэн би дотроо түүнд итгэж байлаа. Боливын хамгийн хэцүү ба алслагдсан Бермихо гэгдэх жижигхэн тосгонд . . . түүнийг томилсондоо би өөрөө ч гайхсан. . . . Тэнд нэг хэсэг ажил маш муу явсан. . . .

“Долоо хоногийн тайландаа уг номлогч хүмүүстэй уулзахад ба тэдэнд сайн мэдээг номлоход гаргасан өөрийн чармайлтын талаар хэлсэн байв. Тэднийг сонсохдоо удаавтар байгааг тэр онцлон хэлсэн ба гэхдээ тэр итгэлтэйгээр үүрэг даалгавраа үргэлжлүүлсээр байна гэжээ. . . .

“Гэтэл ийм юм тохиолдлоо. Урьд шөнө нь ууланд маш их бороо орсноос тосгоны хажуугаар урсдаг жижиг гол усаар дүүрч өмнө байгаагүйгээр үерлэв. Айл гэрүүд үерт автаж хүмүүс усанд живэв. Гол замыг хоттой холбосон ганцхан гүүр нь усны үерээс болж хэмхэрч гол даган урсав. Тэнд эмх замбараагүй байдал хаа сайгүй бий болов.

“Хоёр залуу номлогч бужигнаан дунд орсон байв. ‘Хүн өөрчлөлт хийж чадна’ гэдгийг санаж байсан нэг нь живж буй тэдгээр олон хүмүүсийг аврахаар агуу ус руу өөрийгөө оруулж; мөн байшинд дарагдсан хүмүүсийг гаргаж; шархадсан нэгэнд тусалж, өлсөж буйд тусалсан юм.

“Гайхамшиг тохиолдлоо. Тэрээр баатар болов. Түүний авч явсан захиас болон түүнийг саяхан үгүйсгэж байсан хүмүүс түүнийг эрж байлаа. . . . Тэд түүний Есүс

Христийн хүчтэй гэрчлэл болон Иосеф Смитээр дамжуулан дахин сэргээгдсэн сайн мэдээг хүлээн зөвшөөрлөө.

“Тэрээр номлолынхоо үлдсэн хэдэн сард олон гайхамшигтай хүмүүсийг Сүмд авчирсан. Өнөөдөр Бермиход сайхан сүм сүндэрлэж байдаг. Энэ нь Хүндэтгэлийн өдөр өнөөх өөрчлөлт хийсэн итгэлтэй ахлагчийг санасаар байгаа сүмийн гишүүдээр дүүрсэн байдаг” (“You Can Make a Difference,” *New Era*, Mar. 1991, pp. 45–47).

- Бусдын үйлчлэл та нарт хэрхэн нөлөөлсөн бэ?
- Бусдын үйлчлэлээр та нар хэрхэн адислагдсан бэ?
- Бид пристийн зэргийн албан зарлигууддаа хэрхэн утга учиртай үйлчилж болох вэ?

Ишлэл

Залуу эрэгтэйчүүдтэй дараагийн ишлэлийг уншиж ярилц.

“Их Эзэн биднийг анхаарч, биднийг харж ханддаг. Гэхдээ ихэвчлэн тэр бидний хэрэгцээг хангаж чадах бусад хүмүүсээр дамжуулан үүнийг хийдэг” (Spencer W. Kimball, “President Kimball Speaks Out on Service to Others,” *New Era*, Mar. 1981, p.47).

Дүгнэлт

Ишлэл

Ахлагч Марвин Ж.Аштоны дараах мэдэгдлийг хуваалц: “Цаас болон харандаа аваад долоо хоног бүрийн эхэнд амьдралд хайраа бусдад илэрхийлж болох бодит арга замуудыг жагсаан бич. *Хайр* гэдэг нь хийсвэр үг юм. Хайрын үр шимийг хүртэхийн тулд онцгой арга хэмжээ авах ёстой” (“Yellow Ribbons and Charted Courses,” *New Era*, July 1981, p.17).

Самбар ба
ярилцлага

Самбарт дараах үгсийг бич:

Эцэг эхчүүд Ах эгч нар Хөршүүд Хамт олон Хэсэг
--

- Энэ хэсэг бүрт бид ямар төрлийн үйлчлэлүүд хийж болох вэ? Үг бүрийн ард хариултуудыг жагсаа.
- Бид Аврагчийн үйлчлэлийн жишээг хэрхэн сайн дагаж болох вэ?

Уриалга

Самбар дээрх жагсаалтаас эхний хоёрыг дугуйл: *Эцэг эхчүүд* ба *Ах эгч нар*. Өнөөдрийн ярилцсан зүйлүүдээс дор хаяж нэгийг нь эцэг эх болон гэр бүлдээ хийж, байнгын зуршил болгоход нь залуу эрэгтэйчүүдийг урамшуулан дэмж. Аврагчийн үйлчлэлийн жишээг дагахад хүч чадалтай байхын төлөө болон удирдамжийн төлөө залбирахад тэднийг урамшуул.

Гэр Бүлүүдийн Мөнхийн Чухал Байдал

7

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр гэр бүл нь одоо болон мөнхөд маш чухал байгууллага болохыг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

- Шаардагдах материалууд:
 - Залуу эрэгтэй бүрт судар.
 - Судар тэмдэглэх харандаа.
 - Залуу эрэгтэй бүрт цаас эсвэл карт.
 - Хэрэв танай бүст *Family Home Evening Video Supplement* (53276) байгаа бол “Гэр Бүлээ Хүчирхэгжүүл” 1-р хэсгийг та үзүүлж болно.
-

ТАЙЛБАР

Энэ мөчийг хүртэл залуу эрэгтэйчүүдийн амьдралд гэр бүлийн гаднах тогтолцоотой харьцаж байсан тохиолдол байсан байх аа. Гэхдээ тэд илүү бие дааж ба эрх чөлөөтэй болох тусам гэрээсээ гарах нь ихэсч бусад зүйлүүдийг сонирхож янз бүрийн үйл ажиллагаануудад оролцох нь улам нэмэгддэг. Хэдийгээр бусад үйл ажиллагаанууд залуу эрэгтэйчүүдэд хэрэгтэй, чухал боловч гэр бүл нь энэ цаг үе болон мөнхөд гол үүрэг гүйцэтгэдэг. Өөрийн зааж буй залуу эрэгтэйчүүдийн гэр бүлийн нөхцөл байдлыг нарийн мэдэрдэг бай.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Гэр Бүл Бол Одоо болон Мөнхөд Хамгийн Чухал Тогтолцоо Мөн

Самбар

Дэлхий дээр клуб, эвсэл холбоод болон олон төрлийн байгууллагууд дүүрэн бий гэдгийг тайлбарла.

- Бидний орчин тойронд ямар ямар төрлийн клуб, байгууллагууд байна вэ?

Залуу эрэгтэйчүүдийн хариултыг самбар дээр жагсаан бич. *Гэр бүл* гэсэн үг жагсаалтан дээр байх ёстойг анхаар.

Ярилцлага

- Энэ жагсаалтаас аль тогтолцоо нь хамгийн чухал нь вэ? (Гэр бүл гэсэн дүгнэлтэнд хүрэхэд нь тэдэнд тусал.)

- Та нарын харьяалагдаж буй тогтолцоонуудаас гэр бүл яагаад хамгийн чухал нь вэ? (Яагаад гэвэл энэ нь мөнхийн; Энэ нь Бурханаар өгөгдсөн. Бид гэртээ өөрсдийнхөө хамгийн сайн зуршлууд болон зан чанарыг хөгжүүлж чадна.)

Ишлэл ба ярилцлага

Ерөнхийлөгч Спенсер В.Кимболл хэлэхдээ “Гэр бүл бол дэлхий дээрх Бурханы хаант улсын үндсэн нэгж мөн” гэжээ (in *Conference Report*, Apr. 1978, p. 67; or *Ensign*, May 1978, p. 45).

- Тэнгэрлэг Эцэг яагаад биднийг гэр бүлтэй болгосон гэж та нар бодож байна вэ?
- Гэр бүлүүд Бурханы хаант улсыг байгуулахад хэрхэн тусалж чадах вэ?
- Та нар гэр бүлийн нэгэн хэсэг байснаар хэрхэн адислагдсан бэ?

Самбарын үйл ажиллагаа

Дараах гарчгуудыг самбарт бич:

Гэр бүл
Сүм
Сургууль
Бусад газрууд

Доор жагсаасан зүйлсийг унш, тэгээд залуу эрэгтэйчүүдээр тус бүрийг анх хаана сурсныг хэлүүл.

идэх	нөхөрсөг байх	цэвэрч байх
явах	итгэлтэй байх	зоригтой байх
ярих	уучилдаг байх	боловсон байх
тоглох	бодлоготой байх	бишрэнгүй байх
залбирах	зөлдөг байх	хүндэтгэл үзүүлдэг байх
хайрлах	үнэнч байх	тусч байх
	шударга байх	

- Эдгээр зүйлүүдийг та нар гэртээ хэрхэн сурсан бэ?
 - Гэрээ сайхан газар болгоход та нар хэрхэн тусалж чадах вэ?
- Залуу эрэгтэйчүүдээр 1 Иохан 3:1-ийг уншуулж тэмдэглүүл.
- Энэ судар бидний Тэнгэрлэг Эцэгтэй харьцах харьцааны тухай юу хэлдэг вэ? (Бид түүний хүүхдүүд ба тэр бидэнд хайртай.)
- Энэхүү харьцааны талаар цааш нь онцлон ярихын тулд залуу эрэгтэйчүүдээр Еврей 12:9-ийг уншуулж тэмдэглүүл.
- Аль талаараа бид бүгд ахан дүүс вэ?
 - Энэ дэлхийгээс гадна өөр хаана гэр бүлүүд байх вэ? (Сэлэсчел хаант улсын дээд түвшинд.)
 - Биднийг нас барсны дараа гэр бүлийн харилцаа үргэлжлэхийг та нар яагаад чухал гэж бодож байна вэ?

Судар ба ярилцлага

Та Нар Гэр Бүлдээ Өөрчлөлт Хийж Чадна

Самбар ба ярилцлага

- Гэр бүлээ мөнхийн, сэлэсчел гэр бүл болгоход нь тусалж бид юу хийх ёстой вэ?
- Холбогдсон ба Зохистой* байх гэж самбар дээр бич.

Түүх ба ярилцлага

Залуу эрэгтэйн гэр бүл нь мөнхөд холбогдоход түүний адислалыг хэрхэн мэдэрсэн тухай дараах түүхийг хэлж өг.

Ерөнхийлөгч Филлип Сонтаг Шинэ Зеландад номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байх үеийнхээ түүхийг хэлсэн. Шинэ номлогч түүнд, тэдний гэрийнхэн Шотландад амьдарч байхдаа номлогч нараар сайн мэдээг заалгасан тухай тэр яриу. Түүний ааваас бусад нь бүгд Сүмд нэгджээ. Залуу эрэгтэй тэнд өсөж торнисон ба номлолын дуудлагад дуудагдсан юм. Дараа нь тэднийх Австрали руу нүүв.

Залуу эрэгтэй номлолын адислал хүртэж байхад гадасны ерөнхийлөгч түүнд хэрэв тэр номлол хийх хугацаандаа итгэлтэй сайн ажиллавал түүний гэр бүл сайн мэдээнд нэгдэж цаашилбал Ариун Сүмд холбогдох болно гэж амлав. Залуу ахлагч үүнийг энэ дэлхийн зүйлүүдээс хамгийн их хүсэж байна гэдгээ хэлэв.

Тэрээр Ерөнхийлөгч Сонтагтай ярилцлаганд орох болгондоо “Ерөнхийлөгч өө, би сайн номлогч уу?” гэж асуудаг байв. Эцэст нь түүний номлолд гурван сар үлдэхэд ахлагч маань ерөнхийлөгчөөсөө “Ерөнхийлөгч өө, Манай аав яагаад Сүмд

нэгдсэнгүй вэ?” гэсэн өөр асуулт асуулаа. Ерөнхийлөгч Сонтаг Их Эзэн өөрийн амлалтаа биелүүлнэ гэж түүнд батлан хэлэв. Ахлагч “За тэгвэл Би илүү сайн номлогч байх хэрэгтэй” гээд нулимс унаган тэрээр нэмж “Би сэрүүн байх цаг бүртээ ажиллах болно тэгснээр би гэрээн дэх өөрийн үүргийг дүүргэх болно” гэв.

Тэрээр үүнийг хийсэн юм. Хэд хэдэн гэр бүлийг усан баталгаа хийлгэхэд тэр багаж нь болсон юм. Цаг хугацаа хурдан өнгөрөв. Явахаасаа долоо хоногийн өмнө номлолоо дуусгах гэж буй ахлагч нар номлолын ерөнхийлөгчтэй галын дэргэдэх онцгой ярилцлага хийхээр номлолын гэрт хүргэгдэв.

Цуглааны дараа ахлагч маань маш их сандарсан байсан ба дахин ярилцлаганд орохыг хүсэв. Ерөнхийлөгч Сонтаг түүнийг унтлагын өрөөнд аваачихад ахлагч “Ерөнхийлөгч өө Би аав руугаа ярьж болох уу?” гэж асуусанд Ерөнхийлөгч Сонтаг зөвшөөрөв.

Ахлагч хоёр цагийн дараа залгахад ээж нь утсаа авав. Сэтгэл хөөрсөн мэндийн дараа ахлагч “Ээж ээ, аав юу болж байна?” гэж асуув. Түүний ээж нь хариулахдаа тэрээр ямарч өөрчлөлт алга гэв. Ахлагч чимээгүй болсноо “Би аавтай ярья” гэж хэлэв.

Аав нь утас авахад ахлагч “Аав аа, Би чадахаараа ажилласан ба амжилт гаргасан, гэхдээ хэрэв миний гэр бүл Сүмд нэгдэхгүй л юм бол номлол маань юу ч биш гэлээ. Тэгэхлээр би дараагийн хагас сайн өдөр онгоцноос буухдаа таныг усаар батлуулахыг уриалж байна” гэлээ.

Удаан хүлээсний дараа “Хагас сайн уу, Хүү минь” гэх үгс гарав.

“Тийм ээ, Аав аа. Хагас сайн өдөр.”

Бас дахин удаан хүлээсний эцэст, “За хүү минь, за” гэв.

Утсаа бараг буцаан тавьж амжаагүй байтал номлолын гэрийн дээврийг нурчих шахам баяр хөөртэйгээр хашгирав.

Дараагийн хагас сайн өдөр Ахлагч маань онгоцны буудал дээр ирэхэд түүнийг угтсан хэн ч байсангүй. Эцэст нь бишоп хүрэлцэн ирж түүнд бүх юм зүгээр гэдгийг мэдэгдэв. Тэд гадасны төв рүү машинаар очоод бишоп усан сангийн хаалгыг түлхэхэд цагаан хувцастай аав нь усан дотор зогсож байлаа. Ахлагч цагаан хувцсаа өмсөөд нүдэндээ нулимстайгаар гараа өнцөг гарган өргөж аавыгаа усаар батлав.

Тэд хувцасласны дараа ахлагч аавыгаа сүмийн гишүүнээр батлав. Хажууд зогсож байсан гадасны ерөнхийлөгч, “Ахлагч аа, та манай өрөөнд орж ирнэ үү би таныг номлогчоос чинь чөлөөлье” гэв.

- Номлогч маань гэр бүлдээ санаа тавьж тэднийг мөнхийн гэр бүл болгохыг хүссэнээ харуулсан бэ? (Тэр аавыгаа усаар батлуулахыг хүссэн. Тэр гэр бүлдээ хайртай. Номлогчийн хувьд тэрээр шаргуу ажилласан. Тэр аавыгаа усаар батлуулахыг уриалсан.)
- Та нар гэр бүлээ мөнхийн гэр бүл болоход юу хийж чадах вэ?
- Та нар гэртээ хайрын сүнснийг авчрахын тулд юу хийж чадах вэ?

Уриалга

Дүгнэлт

Саяын номлогч гэр бүлээ нэгдмэл болгохын тулд хангалттай зүйл хийсэн гэдгийг тайлбарла. Ингэснээр залуу эрэгтэй бүр гэр бүлдээ хувь нэмэр оруулж чадна.

Залуу эрэгтэй бүрээр, гэр бүлдээ талархлаа илэрхийлж мөн тэднийг нэгдмэл болгохыг хүссэн ямар нэгэн зүйл хийхийг шийдүүл. Энэ ажил нь бүх гэр бүл эсвэл ганц гишүүнийг хамруулж болно. Залуу эрэгтэй бүрт өөрийн хүлээх үүргийг бичих цаас эсвэл карт өг. Дараагийн долоо хоногийн пристийн зэргийн цуглаанд үүнийг авчирч өөрт нь болон гэр бүлд нь яаж нөлөөлснийг ярихад бэлтгэхийг хүс.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр сүнслэг байдал гэж юу болох мөн үүнийг хэрхэн тордохыг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

Шаардагдах материалууд:

1. Залуу эрэгтэй бүрт судар.
2. Судар тэмдэглэх харандаа.

ТАЙЛБАР

Энэхүү хичээлийн зорилго нь сүнс болон биеийн хоорондын зөв харьцааг хэвээр байлгах нь сүнслэг байдлын нэгэн хэсэг мөн гэдгийг залуу эрэгтэй бүрт ойлгуулах явдал юм. Өөрийн сүнслэг байдлын эрэл болон залуу эрэгтэйчүүдийн төлөөх Тэнгэрлэг Эцэгийн хайр ба тэдний сүнслэг байдлыг хөгжүүлэх түүний хүслийн талаарх мэдрэмж тань энэхүү хичээлийг амжилттай болоход нөлөөлнө.

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

Асуулт Хариулт

Оршил

Залуу эрэгтэйчүүдэд асуулт тавьж хичээлийг эхлэхийг хүсэж байгаагаа тайлбарла. Энэ нь хувийн асуулт бөгөөд тэд асуултыг зөвхөн дотроо хариулах болно. Асуулт ахих тусам илүү хэцүү болно мөн тэдгээрийг нухацтай авч үзвэл залуу эрэгтэйчүүд үлдсэн хичээлийг ойлгож, хөгжихөд илүү бэлтгэлтэй болох болно.

Эдгээр асуулт нь залуу эрэгтэйчүүдийг өөрийгөө хянах тухай илэрхий байдлаас бодлоготой ойлголт руу хөтлөх болно.

1. Та нар өөрийгөө алхуулж чадах уу?
2. Та нар өөрийгөө дуулуулж эсвэл шүгэлдүүлж чадах уу?
3. Та нар өөрийгөө сэлүүлж чадах уу?
4. Та нар өөрийгөө инээлгэж эсвэл хүссэн цагтаа уйлуулж чадах уу?
5. Та нар өөрийгөө зөв дасгал хийлгүүлж чадах уу?
6. Та нар өөрийгөө өглөө эрт орноосоо босгож чадах уу?
7. Та нар өөрийгөө дор хаяж хоёр удаагийн хоол ундгүй явуулж чадах уу?
8. Та нар өөртөө эм хэрэглүүлэхгүй байж чадах уу?
9. Та нар өөрийгөө сөхрөн суулгаж, залбируулж өдөр бүр судраас уншуулж чадах уу?
10. Та нар өөрийгөө муу ёрын бодолд автагдахгүй байлгаж чадах уу?
11. Та нар өөрийгөө уурлах, мэндлэх, үзэн ядах, атаархах, жөтөөрхөх, мөн бардамнах явдалд зөв хариулуулж чадах уу?
12. Та нар өөрийгөө Ариун Сүнсний өдүүлбэрт нааштай хариу өгүүлж чадах уу?

Ярилцлага

- Та нар хариулахдаа бусдаасаа арай хэцүү асуултууд олов уу? Яагаад? (Хариулах хугацаа өг.)

Сүнслэг Байдал Гэж Юу Вэ?

Самбар, асуулт
ба ярилцлага

Сүнслэг байдал гэж юу вэ?

Сүнслэг байдлыг залуу эрэгтэйчүүдээр тодорхойлуул. Та самбар дээр тэдний хариулыг хураангуйлан бичиж болно.

Ерөнхийлөгч Дэвид О.МакКэй сүнслэг байдлыг “ухамсар чинь өөрийг тань ялах, мөн Бурханы зоогоос хүртэх явдал юм” гэж тодорхойлсон (*Gospel Ideals* [Salt Lake City: Improvement Era, 1953], p. 390).

- Ерөнхийлөгч МакКэй хэлснийг та нар ямар утгатай гэж бодож байна вэ?

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр Сургаал ба Гэрээний 88:15-ыг чимээгүй уншуул.

- Хүмүүний “сүнсийг” ямар хоёр зүйл бүтээж байна вэ?

- Хэрэв хүн үнэхээр сүнслэг байвал энэ хоёрын аль нь хяналтанд байх вэ? Түүний сүнс эсвэл бие?

Галат 5:16–25-ыг уншиж ярилц. Гол хэсгийг дурд, ялангуяа 16-р шүлэг мөн хэцүү үгсийг тодорхойлоход тусал.

- Махан биеийн үйлс гэж юу вэ?

- Сүнсний жимсүүд гэж юу вэ?

Залуу эрэгтэйчүүдийг 22 ба 23-р шүлгийг тэмдэглэхийг зөвлө.

Тэд сүнслэг байдлаа хөгжүүлж, мөн Сүнсний жимсэнд баясахдаа сүнслэг байдаг харин махан биеийн үйлсийг дагавал сүнслэг бус байдаг гэдгийг залуу эрэгтэйчүүдэд ойлгоход тусал.

Самбар

Дараах тодорхойлолтыг самбарт бич: *Сүнслэг байдал бол бидний сүнс Ариун Сүнсний удирдамжаар биеийг минь удирдахыг хэлнэ.*

Бид Бүхэн Сүнслэг Байдлыг Хөгжүүлж Чадна

Ишлэл ба ярилцлага

Ерөнхийлөгч Бригэм Янгийн дараах мэдэгдлийг уншиж тайлбала:

“Хэрэв сүнс биенд бууж өгвөл, Муу ёрын сүнс тэр хүний бие болон сүнсийг эзэмдэх хүчтэй болж тэрээр хоёуланг нь алддаг.

“Та бүгд, хүн нэг бүр, нүгэл хилэнц та нарыг уруу татахдаа, тэр та нарын зүрх сэтгэлд бий болоход энэ нь биеэр дамжуулан бий болдог гэдгийг санагтун. Та нарыг уруу татагдахад, хүнд цохилтонд ороход, замаасаа хазайхад; алдаа хийх болон бодолгүй үйлдэл хийхэд; та нар нүгэл хилэнцийн шохоорхлоор дүүрэхдээ болон түүнд бууж өгөхийг хүсэхдээ үүнийг больж Бурханы та нарын биенд хийж өгсөн сүнсээр удирдуул. Хэрэв та нар тэгэх юм бол та нар бүх нүгэл хилэнцийг даван гарч мөнхийн амьдралыг авах болно гэдгийг би та нарт амлаж байна. Гэвч олон, маш олон хүмүүс сүнсээр бие махбодидоо бууж өгч ялагдан устгагддаг” (*Discourses of Brigham Young*, comp. John A. Widtsoe [Salt Lake City: Deseret Book Co., 1954], p. 70).

- Та нарын Сүнс биеийг тань хянах илүү чадвартай байхын тулд та нар юу хийж чадах вэ?

- Энэхүү хянах чадварыг олж авахын тулд Их Эзэний тусламжийг эрж хайх нь яагаад чухал вэ?

- Биеэ илүү сайн хянах чадвартай болоход Их Эзэн та нарт хэрхэн тусалдаг вэ?

Хариулуул. Зөвхөн ерөнхий зарчмыг бус залуу эрэгтэйчүүдийн өдөр тутмын амьдралд тулгарах тодорхой жишээнүүд дээр ярилц.

- Та нар сүнслэг зүйлүүдэд яаж илүү мэдрэмтгий болж чадах вэ?

Түүх ба ярилцлага

Дараах түүхийг ярь:

Нэгэн залуу эрэгтэй сүнслэг байдал гэж юу болохыг ойлгохгүй их хэцүү байлаа. Тэрээр зөв зүйлс хийхээрээ сэтгэлд нь сайхан байж зүрх сэтгэлдээ хайр болон амар амгаланг мэдэрдэг гэдгээ мэдэж байв. Мөн тэрээр буруу ямар нэг юм хийхээрээ сайн мэдрэмж авдаггүй гэдгээ бас мэддэг. Хэдийгээр энэ нь буруу гэдгийг мэдсээр байж буруу зүйл хийхийг хүсэх нь юу гэсэн үг вэ гэдгийг тэр мэдсэн ч заримдаа үүнийг үл ойшоон бурууг хийдэг. Дараа нь тэр ичиж өмнөхөөсөө дорой байдлыг мэдэрдэг.

Нэгэн бүтэн сайн өдөр Сүмийн цуглааных нь сүнс маш хүчтэй, зоригжуулсан байдалтай байсан ба тэрээр үнэхээр илүү сайныг хийхийг хүсэж, сайныг үйлдэхийг мөн тэр мөчид мэдэрч байсан шигээ байнга тийм байхаар шийдсэн.

Залуу эрэгтэй гэртээ хариад өөрийн хүндэлж биширдэг өвөөгөөсөө түүний насны хүн сүнслэг байдлыг хөгжүүлэхийн тулд юу хийж болох талаар асуухаар шийдсэн. Ухаалаг өвөө нь ач хүүгийнхээ тухай бодлоо. Тэр амьдралыг арван дөрвөн настны нүдээр харахыг үнэнээсээ хичээн хэсэг хугацаа өнгөрөв. Гэвч тэр бодолд автан өөрийн залуу үеийнхээ амьдралыг дурсан бодож буйгаа олж мэдэв.

“Миний бие өөрчлөгдөж эхэлж байсныг би санаж байна” гэж түүний өвөө хэлэв. “Би олон төрлийн мэдрэмж болон санаа зовоосон зүйлүүдтэй байснаа санаж байна. Заримдаа би эцэг эхтэйгээ сайн таардаггүй байсан. Ихэнх тохиолдолд би яаж мэдрэх болон юу хийхээ мэддэггүй байсан. Би бас нэлээн санаа зовдог байсан. Тэр үед манай аав фермийн ажилд туслахаар морь худалдан авав. Энэхүү гайхамшигтай амьтныг сургаж ажиллуулах хариуцлага над дээр буув. Би айлын том хүүхэд нь болохоор тэр морьтой хэрхэн харьцахыг сурч чадна гэж аав мэдэж байсан гэдгээ хэлэв. Тэгэхэд би 105 паунд тэр морь ойролцоогоор 1800 паундын жинтэй байсан. Би түүнийг хариуцаж байгаа бөгөөд үүнийг морь мэдэж байгаа тул морь бид хоёр бие биенгүйгээр хийж чадахгүй ажлыг амжуулж чадна гэдгийг аав сануулав. Бид хамтдаа газар хагалж, тэгшилж мөн гэр бүлдээ хэрэгцээний зүйлсийг нь авчирдаг байлаа.

“Би өдөр бүр тэр том морьтой ажилладаг байснаа санаж байна. Би түүнийг сайн мэдэж авсан. Анхандаа тэр өөрийг нь дуулгавартай байлгах миний бүх зүтгэл чармайлтыг эсэргүүцдэг байсан ба өөрийнхөө хүссэнээр байхын тулд чадах бүхнээ хийж байсан боловч аавын хэлсэн үгс миний дотор байнга байсан: ‘Хүү минь Түүний хийж болохгүй гэж мэдэж байгаа зүйлсийг бүү хийлгэ. Өөрийн чинь л хүссэн л зүйл биш бол морио дураар нь бүү тавь. Хэрэв тэр өөрөө хариуцаж байна гэж бодвол та нар алдсан гэсэн үг’ Надад тэр морьтой ажиллахад хэрэгцээт бүх л зүйлс байлаа: хазаар, тоног, ногт сур болон эмээл. Эдгээр бүх зүйл тус болсон ч хэрвээ би дуулгавартай байдалд шахаагүй бол юу ч хэрэг болохгүй байсан. Би хариуцах ёстой байсан ба морь үүнийг мэдэх ёстой байв. Би түүнтэй ажиллаж байхад тэрээр юу шаардагдсан, юуг хийж болох, юуг болохгүйг сурсан. Бид сайн нөхөд болж тэр бид хоёрын хэн нь хариуцдагийг хоёулаа мэдэж байсан.”

• Та нарын бодлоор өвөө нь өөрөө болон морь, сүнс болон биеийн хооронд ямар харьцуулалт хийж байна вэ?

“Нэг өдөр, талбай хагалж байхдаа, өнөөх том морь болон би хамтдаа ажилласнаар ажлаа амжуулж байсан тухай гүнзгий бодолд автсан байлаа. Энэ нь би том хүн болоод агуу зүйлүүдийг бүтээхийг хүсвэл багаасаа юу хийх ёстой тухай байлаа. Миний сүнс аль зөв, аль сайныг нь хийх гэж оролдож буй морьтой адил байсан биеийг маань эзэмдэхийг оролдож байсныг би ухаарав. Энэ нь жолоогоо сайн барилгүй морио дураар нь тавихтай адил юм. Сүнсний удирдамжаар сүнс болон бие маань хамтдаа ажиллахад би маш олон зүйл хийх боломжтой байдаг ба сайхан мэдрэмжтэй байдаг. Зарим үед миний бие миний сэтгэлийн гүнд болохгүй гэж мэддэг байсан юмыг идэх, ямар нэгэн юм хэлэх, хийхийг хүсдэг байв. Миний сүнс хэзээ, хэр зэрэг, мөн би ямар нэгэн юмыг хийж болох болохгүйг хэлдэг юм шиг санагддаг. Сүнсийг байнга сонсож дагах л юм бол би зүгээр байдаг.

“Би өсөж эрийн цээнд хүрээд бусдыг ажиглаж судлах олон боломж надад олдсон. Би хоол ундаа тохируулдаггүй, архидалтыг тэсвэрлэж чаддаггүй эсвэл хараал мөн бүдүүлэг түүх ярьдаг хүмүүсийг харсан. Би үүний тухай бодохдоо өөрөөсөө Яагаад? Яагаад эдгээр хүмүүс биеэ сүнсээр удирдуулахгүй харин эргэн тойронд буй өөр арга замаар удирдуулдаг юм бэ гэж асуудаг.

“Мөн эргэн тойронд байхдаа надад сайхан сэтгэгдэл төрүүлдэг, бусдын төлөө санаа тавьдаг, бусдад сайн зүйл хийж цаг зарцуулдаг миний мэдэхээс олон сайн зүйлс бүтээсэн хүмүүсийг харсан. Эдгээр хүмүүсийг судлаад, тэд тус бүрдээ хоёр хоёроор бүрдсэн багууд байсныг би олж харсан. Яг морь бид хоёр шиг багаар хамтдаа ажиллаж агуу зүйлс бүтээж чадахын адил өөрийн сүнсийг сонсож бие болон сүнсээ хамтад нь ажиллуулсан хүн агуу зүйлс бүтээж чадна. Би өсвөр

насандаа энэ бол миний дуриаллаа болгохыг хүссэн тэр л төрлийн хүн юм байна гэж мэдсэн.”

- Бидний бие сүнснээсээ удирдамж авахын тул хэр зэрэг чармайлт шаардагдах вэ?

Бид энэ төрлийн амжилтанд хүрэхийн төлөө сайн ажиллах ёстой гэдгийг ойлгуул. Хэдэн жил өөрийнхөө сүнсийг дагахаар чармайлт гаргасан хүний хувьд энэ нь магадгүй сайн зуршил болж болох юм. Яг одооноос үүнийг хийхээр шийдсэн хүнд энэ нь хэсэг хугацаанд нэлээд чармайлт шаардах болно. Тэр хүн их хүчтэй эсвэл сул дорой байсан ч агуу их шагналууд нь шаардагдсан ямар ч зүйлтэй тэнцэнэ.

- Бид өөрсдийн биеийг ариун сүнсний удирдамжийг сонсож, дагаж сургахын тулд өдөр бүр яаж ажиллаж болох вэ? (Хариултанд дараах зүйлсийг хамруулна: хүч чадлын төлөө өглөө орой залбирах; өөрт тулгарч буй асуудал болон хүслээ Тэнгэрлэг Эцэгтэй шударгаар ярилц; агуу хүмүүсийг харж тэднээс суралц; хэцүү зүйлүүдийг хий; болж болох мөргөлдөөнүүдийг хэрхэн давах талаар урдчилан төлөвлө; уруу таталтанд ормоор санагдвал арав хүртэл тоол эсвэл Сүмийн нандин дуулал болон судраас дотроо бод; тогтмол судруудаас суралц; ээж, аав эсвэл бишопоо, мөн тэд хэрхэн хандах талаар бод; уруу таталтанд орж болохуйц нөхцөлөөс хол байх.)

Судар ба ярилцлага

Галат 5:16–25-ыг тоймлоод асуу:

- Та нар ямар амьдралыг хүсэж байна вэ?
- Та нар гэрлэж өөрийн гэр бүлтэй болохдоо ямархуу айл болохыг хүсэж байна вэ? Яг одоо ямар айл гэрийг та нар хүсэж байна вэ?
- Сүнсийг дагах нь гэр орныг чинь сайхан газар болгоход хэрхэн тусалдаг вэ?

Дүгнэлт

Гэрчлэл

Биднийг дэвшихэд Тэнгэрлэг Эцэг туслахад бэлэн байгаа гэсэн өөрийн сэтгэгдэл болон гэрчлэлээ хуваалц. Өөрийн бие ба сүнсийг холбож сурснаараа та хүч чадал ба агуу баяр хөөрийг хэрхэн хүлээн авснаа илэрхийл. Биеийг сүнсээ сонсож сургахыг одооноос эхлэхийг залуу эрэгтэйчүүдэд сануул.

Түүх

Дараах түүхийг ярь:

“Нэгэн аав хүүтэйгээ хамт талбай дахь хожуулыг авахаар явсан. Түүний хүү нь хөшүүрэгний нөгөө үзүүр дээр дэвхцэн том хожуулыг сугалахыг оролдож байлаа. Аав нь хүү рүүгээ ирж, ‘Хүү минь, чи өөрийн бүх хүчээ хэрэглэж байна уу? гэж асуусан.’

“‘Тийм ээ’ гэж хүү хэлэв.

“‘Үгүй л байна даа’ гэж түүний аав хэлэхэд

“‘Тиймээ аав аа’ гэв.

“‘Хүү минь, чи ааваасаа тусламж хүсээгүй цагт өөрийнхөө бүх хүчийг хэрэглээгүй. Би байнга туслахад бэлэн байна. Зүгээр л надаас асуу. Намайг дууд тэгээд би тусална.’

“Их Эзэнийг дуудаагүй цагт бид өөрсдийн хүч чадлаа бүрэн дүүрэн хэрэглэдэггүй” (A. Theodore Tuttle, *Spirituality: The Challenge of Today*, Brigham Young University Speeches of the Year [Provo, 28 Mar. 1967], p. 67).

Уриалга

Залуу эрэгтэйчүүдийг уриал:

1. Энэ долоо хоногт үзэж харах кино, ном мөн зурагтын хөтөлбөрүүдийн “махан биеийн үйлс”-ээс зайлсхийн дүгнэлт хий.
2. Энэ долоо хоногт хүлээн авах бүх л сүнслэг өдүүлбэрүүдийг мэдэж тэдгээрт анхаарал тавь.
3. Өөрсдийн бие махбодь болон оюун ухааны ажиллагаандаа хяналт тавьж сурах.
4. Биеэ хянахад Их Эзэнээс үргэлж тусламж эрэлхийл.
 - Та нар гэр бүлээ мөнхийн гэр бүл болоход юу хийж чадах вэ?
 - Та нар гэртээ хайрын сүнсийг авчрахын тулд юу хийж чадах вэ?

9

Наманчлал ба Есүс Христийн Цагаатгал

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр наманчлалын утга учир болон энэхүү эрхэм бэлгийг хэрэгжүүлэх шаардлагатайг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаа.
 2. (Сонголтоор) Уут эсвэл чемодан олж авах тэгээд аяны зүйлс болон чулуугаар дүүргэх.
 3. *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимлын 17, 18-р хуудаснаас нүглээ наманчлах тухай зөвлөгөөг тоймлох.
-

ТАЙЛБАР

Энэ хичээл нь залуу эрэгтэйчүүдэд, бид Есүс Христийн цагаатгалаар дамжуулан нүглээсээ ангижирсан гэдэг сэтгэгдэл төрүүлэх боломжийг танд гаргаж байна. Исаиа бичихдээ:

“Чамайг угаая, цэвэрхэн болгож; та нарын хийсэн муу ёрын зүйлсийг холдуулья. . . .

“Тэгснээр та нарын нүгэл час улаан юм шиг болж, час шиг цагаан болох болно” (Исаиа 1:16, 18).

Энэхүү агуу адислал нь зөвхөн Аврагчийн золиослолоор боломжтой болсон юм. Залуу эрэгтэйчүүдэд нүглээ наманчлахын агуу адислалыг ойлгож талархахад нь тусал.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Судар ба ярилцлага

Оршил

- Хэрэв та нарт дэлхийн хүмүүс бүгд нэгэн зэрэг анхаарал тавибал та нар юу гэж хэлэх вэ?

Залуу эрэгтэйчүүдээр товч хариулуул. Алма 29:1–2-ыг уншиж тэдний хариултыг Алмагийн хэлсэнтэй харьцуул.

- Алма нүглээ наманчлах нь яагаад тийм чухал захиас гэж бодож байна вэ? (Хэрэв бүх хүмүүс нүглээ наманчилбал энэ дэлхий дээр ямар ч харуусал байхгүй байх болно.)

- Нүглээ наманчлах нь харууслыг хэрхэн үгүй болгох вэ?

Самбар ба ярилцлага

Самбарт *Мартаж Орхигдуулах* ба *Үүрэг* гэж бич.

- Эдгээр үгс юу гэсэн утгатай вэ? (*Мартаж Орхигдуулах* гэдэг нь ямар нэг юмыг хийлгүй орхих болон хийлгүй үлдээхийг хэлдэг ба *бурууг хийх* гэдэг нь хийх ёсгүй зүйл хийхийг хэлдэг.)

- Мартаж Орхигдуулахын болон үүргээ санаатайгаар биелүүлээгүйн нүглийн ямар жишээ байдаг вэ?

Хариултуудыг самбарт хураангуйлан бич. Байж болох зарим хариултыг дараах хүснэгтэнд бичсэн байна.

Мартаж орхигдуулахын нүгэл	Үүргээ санаатайгаар бие-лүүлээгүйн нүгэл
1. Аравны нэгээ төлөхгүй байх	1. Тамхи татах
2. Сүмдээ явалгүй гэртээ байх	2. Шударга бус байх
3. Пристийн зэргийн үүргээ сайн гүйцэтгэхгүй байх	3. Хараал хэлэх
4. Залбирал хэлэхгүй байх	4. Бэлгийн харьцааны нүглүүд
5. Хайраа умартах	
6. Уучлахаа умартах	

Судрууд ба ярилцлага

• Хүмүүс ямар нэгэн хийх ёсгүй зүйлийг хийчихээд, мөн хийх ёстой ямар нэг зүйлийг хийгээгүй бол юу мэдэрдэг вэ? (Гэм буруу)

• Гэм буруутай мэдрэмж нь яагаад муу вэ? Тэдгээр нь ямар байдлаар сайн байх вэ?

Өнөөдөр ихэнх хүмүүс гэм буруугийн мэдрэмжийг муу гэж хэлдэг. Хэдий тийм ч, гэм буруугийн мэдрэмжийн тухай маш чухал зүйлийг Алма өөрийн хүү Кориантонд хэлжээ. Алма 42:29–30-ийг залуу эрэгтэйчүүдээр уншуулж тэмдэглүүл.

• Алма нүглүүд нь түүнийг зовоогоосой гэж Кориантонд яагаад хэлсэн бэ? (Гэм буруутайгаа мэдрэх нь наманчлах зам руу хөтөлдөг.)

• Бид хэрэв гэм буруутайгаа мэдрэх ёстой вэ? (Бид ямар нэг буруу юм хийсэн ба наманчлах хэрэгтэй үед.)

• Гэм буруутайгаа мэдэрснээр ямар сайн зүйл ирэх ёстой вэ? (Бид гэм нүглүүдээ хүлээн зөвшөөрч тэднийгээ наманчлах ёстой.)

• Алма, хийсэн гэм нүгэлдээ шалтаг олохгүй байхыг Кориантад яагаад хэлсэн бэ?

• Бид өөрсдийн нүглүүдэд шалтаг олох ба харахгүй өнгөрөхийг өөрсөддөө хэрхэн итгүүлж болох вэ?

2 Нифай 25:26-г залуу эрэгтэйчүүдээр уншуулж тэмдэглүүл.

• Бидэнд наманчлах боломжийг хэн өгсөн бэ? (Есүс Христ)

• Үүнийг тэр хэрхэн хийсэн бэ? (Цагаатгал ба зовлон шаналлаараа)

• *Цагаатгал* гэдэг үг та нарын хувьд ямар утгатай вэ? Та нар Цагаатгалыг хэрхэн илүү сайн ойлгож чадах вэ?

Тэд судалж, залбирч, наманчилснаар Христийн цагаатгал хүн бүрт ямар их чухал болох тухай болон тэд хэрхэн жинхэнээсээ талархаж чадахыг залуу эрэгтэйчүүдэд ойлгуул.

• Аврагчийн цагаатгалыг ойлгох нь та нарт хэрхэн тусалсан бэ?

• Түүний цагаатгалын золиослолд талархаж байгаагаа та нар хэрхэн үзүүлэх вэ?

Наманчлал нь Аз Жаргал ба Хөгжил Өөд Хөтөлдөг

Ишлэлүүд

“*Наманчлал* бол . . . Христийн шашны үгийн санд *итгэлийн* дараах хамгийн их урам зориг хайрладаг үг юм” (Jeffrey R. Holland, “For Times of Trouble,” *New Era*, Oct. 1980, p. 11).

• Наманчлал хэрхэн “урам зориг оруулам” байж чадах вэ?

Ярилцлагын явцад, наманчлал нь өсөлтөд, сайжрал, хөгжил дэвшилтэд урьдаг гэдгийг ойлгуул. Жинхэнэ наманчлалын үр дүн бол амар амгалан, сайн сайхан, аз жаргал юм.

Наманчлал бол зөв зүйтэй зарчим ба зориг оруулам, сэтгэл өргөм бөгөөд энэ нь өвтгөхгүй гэдгийг тайлбарла. Үнэндээ наманчлал нь заримдаа маш их сэтгэл өвтгөдөг.

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболлын дараах мэдэгдлийг унш:

“Наманчлал нь . . . гэм нүглийг шоолдоггүй. . . . Энэ нь алдааны ноцтой байдлыг багасгадаггүй. . . .

“Өөрийгөө зовохыг, нулимс асгарахыг, зүрх сэтгэлээ хашраахыг зөвшөөрөх нь чухал. Гэм нүглээ өчүүхэн ч гэсэн зөвтгөхийг бүү оролд” (“What Is True Repentance?” *New Era*, May 1974, pp. 4-5).

Судар ба ярилцлага

- Наманчлах гэж юу гэсэн үг вэ?

Сургаал ба Гэрээ 58:42–43-ыг залуу эрэгтэйчүүдээр уншуул. Эдгээр шүлгүүдийг тэмдэглэхийг зөвлө.

- Нүглээсээ салж түүнийгээ наманчлах гэж юу гэсэн үг вэ?

Хэрэв хүсвэл наманчлалын талаар зөвлөсөн *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* 17 ба 18-р хуудсуудыг уншаад ярилцаж болно.

Үзүүлэнтэй хичээл
(сонголтоор)

- Мөнхийн ирээдүйд наманчлах нь наманчлахгүй байснаас яагаад амархан байх вэ?

Амьдрал нь чемодан юмуу цүнх бариад урт аянд явахтай адил гэдгийг тайлбарла. (Хэрэв та нар “Бэлтгэл” хэсэгт зөвлөснөөр цүнх юмуу чемодан бэлтгэсэн бол залуу эрэгтэйчүүдэд үзүүл.) Та нар цүнхэнд хоол хүнс, хувцас, орны хэрэгсэл гэх зэрэг хэрэгцээтэй юмнуудаа авч яваа учраас цүнх маш хүнд гэдгийг тайлбарла. Хэн ч цүнхэндээ чулуу юмуу өөр хэрэгцээгүй хүнд зүйл авч явахыг хүсэхгүй. Тэгвэл зай эзлээд илүү ачаатай болно.

- Бид заримдаа амьдралынхаа аянд ямар илүү ачааг авч явдаг вэ? (Гэм нүгэл.)
- Бид энэ ачаануудаас хэрхэн салж чадах вэ? (Наманчлалаар дамжуулан. Хэрэв бид гэм нүглээ наманчилбал Христ бидний төлөө ачааг маань үүрэх болно.)

Цүнхнээсээ хэдэн чулуунуудыг авч хая.

- Энэ нь бидний аянд ямар өөрчлөлт гаргах вэ? (Аян зам нь урт удаан, хэцүү хэвээрээ боловч чулуутай байснаас илүү хөнгөхөн байна.)

Түүх ба ярилцлага

Нүглээ наманчлахгүй байснаас гарч ирэх уршгийн тухай дараах түүхээр өгүүлснийг тайлбарла:

“Цасан шуурга ерөнхийдөө аюулгүй байв. Үнэндээ, хэд хэдэн цахилгааны утас тасарч, замын хажууд гэнэт осол болов. Гадагшаа гарна гэдэг нь хэцүү, тэгээд ч тийм сайхан зүйл биш байв. Энэ нь байж боломгүй цаг агаар байсан боловч тийм ч ноцтой биш байв. Ер нь салаалсан мөчрүүдтэй наргил модны самрыг маш амархан унагаж чадахаар байв. Голд нь байсан төмөр шаантаг үүнийг гэмтээх шалтгаан болсон юм.

“Төмөр шаантагны түүх олон жилийн өмнө цагаан үст тариачин эцгийнхээ гэрт хэвтэж байснаас эхэлжээ. Мод хөрөөдөх газрыг саяхан л тосгоноос нүүлгэсэн ба оршин суугчид энд тэндгүй тарсан багаж болон төхөөрөмжийн хэсгүүдийг олсоор байв.

“Тэр өдөр түлээчний өргөн, хавтгай, хүнд, тохой ч байна уу түүнээс урт шаантаг хүчтэй цохиж цангинаж байв. Түүний харих замд түлээний амбаар таарахгүй ба тэр оройн хоолондоо оройтсон учир хөвгүүн урд хаалганы хажууд аавынхаа тарьсан зулзган модны мөчрүүдийн хооронд шаантагаа орхив. Тэр шууд оройн хоолны дараа эсвэл тэр хавиар явахдаа шаантагаа амбаарт хийнэ гэж бодов.

“Тэр үнэхээр тэгнэ гэж бодож байсан боловч хэзээ ч үүнийгээ хийсэнгүй. Түүнийг том эр болтол тэр нь тэнд мөчирнүүдийн хооронд бат бэх байсаар л байв. Түүнийг гэрлэж, аавынхаа фермийг өвлөн авахад тэр нь тэндээ бат бөх зуурсан байв. Модны доор тариа хураалтынх нь оройн хоолоо идэж байх тэр өдөр тэр мод руугаа бараг ургасан байлаа. Тэгээд өвөл болж цас, мөсөн шуурга ирэхэд шаантаг модондоо улам шигдэн ургаж мод бүрэн эдгэрсэн байв.

“Маш хүйтэн өвлийн чимээгүй тэр шөнө манан дунд бороо доош шигшрэн бууж доороо хөлдөж байсан ба гурван том мөчрийн нэг нь их биеэсээ салж газарт унан бутрав. Энэ нь үлдсэн оройн хэсгийг тэнцвэргүй байдалд оруулж тэр бас салж доош унав. Шуурга зогсоход тэр бахархал болж байсан том модноос мөчир ч үлдсэнгүй.

“Дараачийн өглөө фермийн эзэн гарч ирэн алдсан зүйлдээ харуусав. ‘Энэ нь мянган доллароор ч төлж баршгүй гарз’ гээд ‘Тосгондоо хамгийн сайхан мод байсан юм’ гэж хэлэв.

“Тэгээд түүний нүдэнд сүйрсэн зүйл дотор ямар нэгэн юм тусав. ‘Шаантаг’ хэмээн тэр зэмлэнгүй аман дотроо бувтнав. Миний урд бэлчээрээс олсон шаантаг!’ Халт харсан зүйл түүнд мод яагаад унасныг хэлжээ. Модны их биенд шигдэн орсон шаантаг мөчрийн судлуудыг холбоотой байхад нь саад болжээ” (Samuel T. Whitman, “Forgotten Wedges,” quoted by Spencer W. Kimball, in Conference Report, Apr. 1966, pp. 70-71; or *Improvement Era*, June 1966, pp. 523-24).

- Бидний амьдралд ямар янзын шаантаг байдаг вэ? (Наманчлаагүй гэм нүгэл.)
- Цасан шуургатай харьцуулж болох ямар дарамтууд бидний амьдралд байдаг вэ? (шударга бус байх уруу таталтууд, өөрөөр хэлбэл ёс суртахуунгүй байх г.м.)
- Хэрэв бид наманчлаагүй гэм нүглээ тээгээд яваад байвал бидэнд маш амархнаар юу тохиолдож болох вэ? (Модтой адилхнаар бид хүчгүй болж, уруу таталтанд орж болох юм.)
- Тэдгээр гэм нүглүүд бидний урагшлах, өсөж хөгжих ёстой замд хэрхэн саад болох вэ? (Нэг ноцтой үр дагавар нь бидэнд зөвийг хийхийг зааж өгч ухаантай шийдвэр гаргахад тусалдаг Ариун Сүнсний нөхөрлөл үгүй болно. Энэ нь яваандаа биднийг сэлэсчел хаант улсаас холдуулдаг.)

Судрын түүх
ба ярилцлага

Ноцтой алдаа хийсэн боловч наманчлалын хүчээр амьдралаа өөрчилж, тэгснээр Их Эзэний гайхамшигт үйлчлэгч болж, амьдралдаа гайхамшигт баяр баясгалан, аз жаргал авчирсан залуу хүмүүсийн олон сайхан жишээ судруудад байдгийг тайлбарла. Тэдний нэг нь Бага Алма байсан. Тэр агуу их удирдагч ба бошиглогчийн хүү байсан учраас маш их нөлөөтэй байсан. Харамсалтай нь тэр энэ нөлөөгөө сайн зүйлд ашиглахын оронд харин ч нууцаар найзуудтайгаа нийлж Сүмийг устгахыг хичээж мөн аавынхаа хийсэн бүх сайн сайхан ажлыг сүйтгэжээ. Эцэст нь тэд Сүмийн өсөлтөнд маш хүчтэй саад болж байсан тул Их Эзэн тэдний хэрэгт оролцож зогсоох хэрэгтэй болсон. Их Эзэн тэдэнд нүглээ наманчил, үгүй бол устгана гэж хэлүүлэхээр тэнгэрийн элч нараа илгээсэн.

Залуу эрэгтэйчүүдтэй хамт Алма 36:6–21-ийг унш.

- Алмагийн зовлон түүнд юу учруулсан бэ? (Бусармаг явдалтайгаа хамт Бурханы өмнө зогсох айдас.)
- Алмагийн баяр баясгалангийн эх булаг юу байсан бэ? (Есүс Христ)
- Түүний аз жаргал хэр их агуу байсан бэ? (Үүний сайхан нь түүний зовлон зүдгүүр гашуун байсан хэмжээтэй адил.)
- Тэр тохиолдлын дараа Алмагийн амьдрал өөрчлөгдсөнийг та нар хэрхэн үзэж байна вэ? (Тэр “дахин төрж” агуу бошиглогч болсон)

Дүгнэлт

Ишлэл

Ахлагч А.Теодор Татлын дараах мэдэгдлийг унш:

“Наманчлал бол яг савантай адил. Энэ нь амьдралын саван юм. Савантай адил амьдралын гэм нүглүүдийг угаадаг. Хэрэгцээнийхээ хэрээр үүнийг ойр ойрхон хэрэглэж болно. Гэхдээ буруу ашиглах буюу дутуу цэвэрлэх ба дутуу сэтгэлээр хандсан чармайлтын үр дүн нь саарал байна гэдгийг санах ёстой. Зөв хэрэглэсэн саван бүхлээр нь, юу ч үлдээлгүй, байнга угааж байдаг. . . .

“Нэг л өдөр бид Их Эзэний шүүлтийн газар очих болно. Бид тэнд заваан, бохир, цэвэр бус байж ч болно, аль эсвэл цэвэрлэгдэх агуу гайхамшигт бэлэг болох амьдралын савангаа хүлээн авч хэрэглэснээр Их Эзэний өмнө цэвэр, өршөөгдсөн, ариунаар зогсох болно. Дараагийн удаа та нар саван хэрэглэхдээ мөн бүх нийтийн наманчлалын хууль болох амьдралын саванг хэрэглэж өөрийн сүнсийг цэвэрлэх тухай бодож болох юм” (“Repentance,” *Improvement Era*, Nov. 1968, pp. 64, 67).

Уриалга

Залуу эрэгтэйчүүдийг Христийн цагаатгалыг заасан судраас суралцаж, наманчлалыг илүү сайн ойлгохын төлөө залбирахыг уриал. Амьдралаа анхааралтайгаар эргэн харж хийсэн гэм нүглээ даруй наманчлахыг тэднээс хүс.

10

Судруудаас Суралцах нь

ЗОРИЛГО

Бүх залуу эрэгтэйчүүд судруудыг залбиралтайгаар болон тогтмол уншихаар амлах болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Залуу эрэгтэй бүрт харандаа.
2. Залуу эрэгтэй бүрт “Сэдвүүд ба Судрын Заалтууд”-ын хувийг бэлтгэ.
3. Залуу эрэгтэйчүүдэд 1 Нифай 3–5-ыг суралцахыг даалга.
4. Та залуу эрэгтэйчүүдийн нэгээс Лихайн хүүхдүүд гуулин ялтсуудыг авахаар Иерусалим руу буцсан түүхийг ярьж өгөхийг хүсэж болно.
5. Энэ хичээлийн төгсгөлд гол үйл ажиллагаа байгаа. Үүнд хичээлийн цагаас доод тал нь хориос хорин таван минут гарга.
6. Иосеф Смит Мэргэн Ухааныг Библиэс Эрсэн нь, 1-р зургийг үзүүл (Мөн Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга, 402 [34730]).

ТАЙЛБАР

Энэ хичээл танд Мормоны Ном уншихын чухлыг онцлон хэлэх боломжийг өгнө. Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон “1832 онд эртний зарим номлогчид хөдөлмөрийнхөө талбараас эргэж ирэхэд Их Эзэн тэдэнд Мормоны Номыг илүүтэйгээр авч үзэхийг дахин сануулсан. Тэр хандлагынхаа үр дүнд, тэр хэлэхдээ тэдний бодол санаа харанхуй болсон байна гэжээ. . . . Тэгээд Их Эзэн хэлэхдээ “тэд нүглээ наманчлах ба шинэ гэрээ Мормоны номыг хүртэл санахаас нааш зэмлэл дор байна” гэжээ (С ба Г 84:54–57) (in Conference Report, Oct. 1986, pp. 3-4; or *Ensign*, Nov. 1986, p.4).

Энэ зэмлэлд орохын оронд залуу эрэгтэйчүүд Мормоны Номыг судалснаар маш их адислалыг олж чадна. Мөн ерөнхийлөгч Бэнсон “Залуус аа, Мормоны Ном та нарын амьдралыг өөрчилж чадна. Энэ нь та нарт өнөөдрийн муу ерын өдрийн эсрэг бэхлэлт болно. Бусад номын авчрахгүй тэр сүнслэг байдлыг бидний амьдралд авчирна. Энэ нь та нарын номлолдоо болон амьдралдаа бэлтгэхээр уншсан хамгийн хэрэгтэй ном байх болно. Мормоны номыг мэддэг, хайртай, түүнийг хэд хэдэн удаа уншсан, түүнийг үнэн гэдэг гэрчлэл олж авсан, заасан зүйлийг нь амьдралдаа хэрэглэдэг залуу хүмүүс муу ёрын сүнсний нарийн заль мэхний эсрэг зогсох ба Их Эзэний гарт байгаа хүчтэй зэвсэг байх болно” гэжээ (in Conference Report, Apr. 1986, p. 56; or *Ensign*, May 1986, p. 43).

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Судрын түүх
ба ярилцлага

Судрууд Үнэт Зүйлсийг Агуулдаг

- Үнэт зүйл гэж юу вэ?
- Хэрэв гэр чинь шатаад та нар зөвхөн гартаа л юм авч гарч чадах бол юу авч гарах вэ?

Ямар ч байсан залуу эрэгтэйчүүд тэдний маш их хайрладаг үнэтэй гэсэн зүйлээ авч гарна гэдгийг тайлбарла.

Хүмүүс заримдаа мөнгө ба үнэт эдлэлээс өөр зүйлийг үнэт зүйл гэж тооцдогийг тайлбарла. Өнгөрсөн удаа томилсон залуу эрэгтэйгээр Лихайн хөвгүүд гуулин ялтсуудын төлөө буцаж явсан түүхийг дахин хэлүүл.

Бусад залуу эрэгтэйчүүд түүхийг ярихад тусалж болох юм.

- Лихай ба Нифай юуг хайрласан бэ? (Их Эзэний үг)
- Лихай ба Нифай гуулин ялтсан дээр бичигдсэн Их Эзэний үгийг дээдэлж байсныг ямар үйл явдлаар үзүүлсэн бэ? (Нифайн аяллаар явахад бэлэн байсан ба түүний амьдралын аюул; хэдийгээр хоёр удаагийн оролдлого бүтэлгүй болсон ч ялтсуудыг авна гэсэн Нифайн шийдэмгий байдал; ялтсуудыг сольж авахын тулд бүх алт мөнгө болон хайртай зүйлээ өгөхөд бэлэн байдал; хэдийгээр хүсээгүй ч Нифай Лабаныг алсан явдал)

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр 1 Нифай 5:21–22-ыг уншуулж мөн доогуур нь зуруулж Лабанаас ялтсуудыг авсны дараа Нифай юу мэдэрч байсан тухай олуул.

- Гуулин ялтсуудын үнэ цэнийн талаар Нифай юу хэлсэн бэ?
- Тэд яагаад маш их үнэ цэнэтэй вэ? (Яагаад гэвэл хүмүүс Их Эзэний зарлигуудтай байж чадна.)

Мормоны Номонд судар байхгүй Муликайтэс гэдэг өөр нэг бүлэг хүмүүсийн тухай өгүүлдгийг тайлбарла. Залуу эрэгтэйчүүдээр Омнай 1:15-17-г уншуул.

- Судрууд байхгүй учраас бүхэл үндэстэнд юу тохиолдсон бэ? (Тэдний хэл эвдэрч, тэд Бурханыг үгүйсгэсэн.)
- Судрууд яагаад чухал ач холбогдолтой вэ?

Залуу эрэгтэйчүүдийн хариултыг самбарт бич. Шаардлагатай бол тэдний бодсоныг урамшуул. Байж болох зарим хариулт нь: Судар нь Есүсийг Христ ба Аврагч гэдгийг гэрчилдэг, Тэнгэрлэг Эцэгтээ хэрхэн буцаж очихыг бидэнд хэлдэг, бидэнд бусдыг яаж аз жаргалтай байлгахыг хэлдэг, дуулгавартай байснаар ирэх адислал ба дуулгаваргүй байснаар ирэх гэм зэмийг зааж өгдөг ба бидний бэлтгэх ирээдүйд юу болохыг хэлдэг.

Гэрчлэл

Судрууд бол үнэ цэнэтэй баялаг ба бүх залуу эрэгтэйчүүдийн авралын замд хэрэг болох мэдлэг юм гэдгийг гэрчил.

- Судраас суралцах нь та нарт яаж тусалсан бэ?

Залбирлаар Болон Үргэлж Судалснаар Бид Судрын Үнэ Цэнийг Ойлгож Чадна

Судар ба ярилцлага

- Чи хэр ойр ойрхон идэх дуртай вэ?
- Залуу эрэгтэйчүүдээр 2 Нифай 31:20-ыг чимээгүй уншуулж доогуур нь зуруул.
- “Найрлах ба зууш идэх” хоёрын хоорондох ялгаа юу вэ?
 - Христийн үгийг зууштай адилаар идэх ба найрлаж идэх хоёрын ялгаа ямар байх вэ?
 - Христийн үгийг бид хаанаас олж болох вэ? (Есүс Христийн Сүмийн судрууд дээрээс)
 - Бид судруудыг хэр ойрхон судлах ёстой вэ?

Ишлэлүүд

Ерөнхийлөгч Харолд Б.Ли өдөр бүр судраас уншихыг тушааж хэлэхдээ: “Хэрэв бид судраас өдөр бүр уншихгүй юм бол бидний гэрчлэл нимгэрч, бидний сүнслэг байдал гүнээр өсөхгүй” гэжээ (Regional Representatives’ seminar, 12 Dec. 1970).

- Судраас уншсанаар та нарын гэрчлэл хэрхэн өссөн бэ?
- Судраас уншихаа сайжруулахын тулд та нар юу хийж чадах вэ?

Залуу эрэгтэйчүүд судраас яаж судлахыг илүү ойлгоход нь туслахаар дараах мэдээллийг хэрэглэ.

“Бурханы бүх ариун хүмүүс Бурхан болон сургаалыг хэрхэн сурч мэдсэнийг би бага зэрэг мэдсэн. Энэ бол сонгосон хэдхэн бэлэг биш харин дуулгавартай байдлын хууль, удаан хугацаа ба судлалд өгсөн адислал юм.

“Би судраас уншсанаар тунгаан бодох ба эрэлхийлэх зарим энгийн зүйлийг сурсан.

- “1. Судруудыг уншиж эхлэхээсээ өмнө үргэлж залбир. Энэ дэлхийгээс ангид байж оюун санаагаа төвлөрүүл. Мөн асуулттай үедээ юмуу сургаалын зарим төсөөллийг өөрийн зүрх сэтгэлдээ гэгээрүүлэхийн тулд уншиж байх үедээ залбир. Эцгээсээ асуухаасаа бүү эргэлз.
- “2. Уншиж байх үедээ цаас харандааг гарын доор байлга. Энэ бол гэгээрэх үйл ажиллагаа бөгөөд ойрын зорилго, сэтгэл татам үзэл бодол, шинэ бодлууд хуучирсан оюун ухаанд орж ирэх болно.
- “3. Удаан унш! Энэ сургалт уралдаан биш. Унтахаасаа өмнө зөвлөсөн бүлгийг дуусгах ёстой. Хэд хэдэн өдрийг ганц бүлэг юмуу ишлэлд зориул. Судар цээжилбэл та нарын өнөөдрийн амьдралд ухаарч мэдээгүй нууцлаг утгууд цэцэглэх болно.
- “4. Судар уншиж байхдаа асуулт асуу. . . . Асуу тэгээд Их Эзэнийг дууд. Намайг асуулт асуухад зүрх сэтгэлийн минь үүд нээгдэж Ариун Сүнс надад орших зай тавьж өгдөг.
- “5. Өдрийн турш олон удаа зогсож гүн гүнзгийгээс олж авсан ганц бодлоо эргэцүүлэн бод. Жишээ нь: хөршөө өөр шигээ хайрла гэсэн үнэнийг авч үзье. Судраа олон давтан хэл, өөрийн үйлдэл бүртээ асуулт тавь! Өөрийн бодлоо жижиг цаасан дээр хадгал.

“Энэ бүхэн өөртөө цаг гаргах өдөр тутмын шинэтгэл юм. Та нарын алсыг харах үзлийг чинь дахин сэргээсэнд та нар баярлах болно. Та нарын амьдралд шинэ зүг чигийг заах өдөр тутмын илчлэлт байх болно.

“Бидний хайрт бошиглогч Иосеф Филдинг Смит ‘Бүх амьдралынхаа турш би Их Эзэний хуулиудаар амьдрахыг хичээж сургаалын зарчмуудыг судалж бас эргэцүүлэн боддог байсан. Үр дүнд нь миний зүрх сэтгэлд түүнд болон түүний ажил ба энэ ертөнц дээрх ирээдүйн зорилгоо эрэлхийлэгч бүхнийг хайрлах агуу хайр ирсэн юм.’ (Conference Report, Oct. 1971, p. 6.)

“Эргэцүүлэн бодох цаг гарга. Энэ бол мөнх бус амьдралын итгэмээргүй аз жаргал, мэдлэгийн түлхүүр юм.

“[Аврагч хэлэхдээ,] Намайг ойр байхад намайг дууд гэсэн энэ зарлигийг зүрх сэтгэлдээ тунгаан бод гэж та нарт үлдээе гэжээ.

“‘Надад ойрхон бай би чамтай ойрхон байна’ (С ба Г 88:62–63.)” (Susan Hill, “Pondering Isn’t Preposterous,” *New Era*, May 1976, pp. 49-50).

Гэрчлэл

Судруудыг эргэцүүлэн бодох нь бидний баяр баясгаланг нэмэгдүүлж, судруудад хайртай болгох ба биднийг Аврагчид ойртуулна гэдгийг гэрчил. Ариун Сүнс судруудыг бичсэн хүмүүст онгод оруулдаг.

- Та нар судруудыг уншихдаа Ариун Сүнсийг ямар хэсэгт тоглохыг зөвшөөрөх ёстой вэ? (Ариун Сүнс бидэнд онгод оруулж, судруудыг ойлгоход туслахыг зөвшөөрөх хэрэгтэй).

- Та нарыг судраас судлахад Ариун Сүнс яаж тусалж байсан бэ?

Үйл ажиллагаа

Өдөрт 15 минут унших эсвэл өдөрт нэг бүлэг унших гэхчлэн судар судлах олон янзын арга байдгийг тайлбарла. Зарим хүмүүс цөөн хэдэн бадаг уншаад тэдгээр бадгуудын тухай эргэцүүлэн бодож бас залбирдаг. Зарим нь судар судлахдаа нэг сэдэв сонгож аваад тэр сэдвийн тухай бүх судруудыг уншдаг. Аль ч арга хэрэглэсэн гэсэн зөвхөн нэг юмуу хоёр шүлэг уншсан ч хамаагүй бид судраас ямар нэг юм заавал унших нь чухал.

Хэсэг бүрт хоёр юмуу гурван залуу эрэгтэй байхаар ангийг бүлгүүдэд хуваа. Залуу эрэгтэй бүрт “Сэдвүүд ба Судрын Заалтууд”-аас нэг ширхгийг өгч бүлэг бүрт нэг сэдэв өг.

Залуу эрэгтэйчүүдээр заалт бүрээс юу сурсныг нь бичүүл. Тэднээс сэдвийнхээ дагуу бүлгийн илтгэл өгөхийг асуу.

Илтгэлүүд

Бүлэг бүрээр сэдвийн тухай юу сурсан тухай илтгэл хийлгүүл. Бүлгийн гишүүн бүрээс өөрийн тэмдэглэлээс ямар нэг юм илтгэж хувь нэмэр оруулах асуултыг асуу.

- Өнөөдөр та нарын хэд нь нэг шинэ зүйл сурсан бэ?
- Та нар юу сурсан бэ?

Уриалга

Дүгнэлт

Залуу эрэгтэйчүүдэд жагсаалт дахь өөр сэдвийг судлахыг уриал.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр Сатаны хүч нь бодитой байдаг ч бид уруу таталтыг нь эсэргүүцэж чадна гэдгийг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

Шаардагдах материалууд:

1. Залуу эрэгтэй бүрт судар.
 2. Судар тэмдэглэх харандаанууд.
-

ТАЙЛБАР

Энэ хичээлийн зорилго бол Сатаны арга замыг танин мэдсэнээр уруу таталтыг нь илүү эсэргүүцэхэд залуу эрэгтэйчүүдэд туслах. Энэ болон дараагийн хичээлийг дараалсан ням гаригуудад заах ёстой.

Залуу эрэгтэйчүүд Сатаныг бодитой гэдгийг ойлгох ёстой хэдий ч та түүний тухай хэт их эсвэл муу ёрын сүнсний хүчтэй холбоотой хувийн тохиолдлоос ярих ёсгүй. Сүнсстэй холбоотой үйл ажиллагааны тухай ярилцахаас зайлсхий. Хэрэв залуу эрэгтэйчүүд үхэгсдийн сүнсстэй холбоо тогтоох болон Сатаныг шүтэх гэсэн сэдвүүд сөхөн гаргаж ирвэл тэдэнд эдгээр нь Сатаны зэвсэг ба бидэнд тийм зүйлээс хол байх ёстой хэмээн зөвлөсөн гэдгийг хэлэх ёстой. Тэгээд ярилцлагаа хичээл рүү буцааж эргүүл.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Түлхүүрүүд

Оршил

Дараах түлхүүрүүдийг унш. Хэрэв тэд хэнийг дүрсэлж байгааг тань мэднэ гэж бодож байвал гараа өргө гэж залуу эрэгтэйчүүдэд хэл. Түлхүүрүүдийг уншиж дуустал хэн ч юу ч хэлэх ёсгүй.

Би бол чамайг миний сүнсний ах болгодог Бурханы сүнслэг хүүхэд мөн.

Би Тэнгэрийн Зөвлөлд танилцуулагдсан.

Би дэлхий рүү явж хүн төрөлхтнийг аврахыг санал болгосон.

Би та нарыг надтай адил болохыг хүсэж байна.

Би та нарыг намайг дагахад урамшуулахын тулд шаргуу ажилласан.

• Би хэнийг дүрсэлж байна вэ? Хариулахыг нь хүлээ. Тэгээд сүүлчийн түлхүүрийг унш.

Би та нарын мөнх бусын дайсан.

• Одоо та нар намайг хэнийг дүрсэлсэн гэж бодож байна? (Сатан, муу ёрын сүнс)

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр Мосе 4:1–4-ийг уншуул.

• Сатан эхнээсээ юу хүссэн бэ? (Бидний чөлөөт сонголтыг устгахыг)

• Тэр чадсан уу? (Үгүй)

• Түүнд юу тохиолдсон бэ? (Тэр тэнгэрээс хөөгдөж чөтгөр болсон.)

• Одоо тэр юу хийж байгаа вэ? (Хүмүүсийг буруу замаар хөтлөхийг хичээж байгаа.)

• Хэн түүний хоригдол вэ? (Бурханаа дагахаас илүү түүнийг дагагсад.)

Тэнгэрт дайн эхэлснээс хойш тэр нь одоо болтол үргэлжилсээр байгааг тайлбарла. Сатан Бурханы эсрэг тэмцсээр байгаа ба тэр биднийг өөрийгөө дагахад ятгахыг хичээж байгаа.

- Сатан бодитой байдаг ба түүний төлөвлөгөө бодитой гэдгийг мэдэх нь яагаад чухал вэ? (Сатаныг бодитой гэж мөн түүний зорилго, уруу таталтыг мэдэх нь бидэнд түүний арга барилыг танин мэдэж эсэргүүцэхэд тусалж чадна.)

Сатан Бодитой

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр 2 Нифай 28:22-ыг уншуул.

- Сатан биднийг өөрийнхөө тухай юунд итгүүлэхийг хүсдэг вэ? (Түүнийг байдаггүй гэдэгт.)

Сатантай тулалдах эхний алхам бол түүнийг бодитойгоор байдгийг мэдэх явдал юм гэдгийг тайлбарла. Ихэнх хүмүүс өнөөдөр Сатаныг үлгэр домог, ердөө л хүмүүсийн муу чанарыг төлөөлж байгаа гэдэгт итгэдэг.

- Сатан биднийг түүнд итгэхийг яагаад хүсдэггүй вэ? (Хэрэв бид түүнд хөнгөн хандвал түүнийг эсэргүүцэх бэлтгэлгүй байх болно.)

Сатаны энэ үзэл бодлыг Иосеф Смитийн тохиолдолтой харьцуул. Залуу эрэгтэйчүүдээр Иосеф Смит-Түүх 1:15–16-г уншуул.

- Иосеф Смитийг залбирч эхлэхэд юу тохиолдсон бэ? (Тэр хилэнцэтийн хүчинд ялагдсан)
- Тэр хилэнцэтийн хүч хэн байсан бэ? (Сатан)
- Бошиглогч Сатаны хүчийг хэрхэн дүрсэлсэн бэ? (Тэрээр хэлэхдээ тэр хүч бол бодитой байдаг ба түүний урьд өмнө мэдэрсэн ямар ч хүчнээс илүү хүчтэй байсан гэжээ.)
- Сатаны хүчнээс Иосеф хэрхэн ангижирсан бэ? (Тэр зүрх сэтгэлдээ залбирсан.)

Ишлэл

Дараах мэдэгдлийг унш.

“Ихэнх амьдралынхаа турш залуу хүмүүстэй ажиллахдаа миний мэдэж авсан зүйл нь залуу хүмүүсийг хүнд байдалд оруулдаг нэг зүйл бол тэд Сатаныг хангалттай үнэлээгүй явдал юм. Түүнд маш их хүч байгаа ба бид түүнийг байхгүй гэж мэдэрсэн үед, бид өөрсдийнхөө асуудлыг өөрсдөө зохицуулж чадна гэж бодсон үед хүнд байдалд орж болно” (William H. Bennet, in Conference Report, New Zealand Area Conference 1976, p. 14).

- Та нар энэ хэлсэнтэй санал нэг байна уу? Яагаад тийм эсвэл яагаад үгүй вэ?
- Зарим хүмүүс яагаад Сатаны хүчийг асуудал болгон авч үздэггүй вэ?

Сатаны Ажил Бол Биднийг Устгах Зорилготой

Судар ба ярилцлага

Сатан мөнх бус амьдралын өмнөх амьдралд бидний чөлөөт сонголтыг устгах гээд бүтэлгүйтсэн боловч хэрэв тэр биднээр тэр чөлөөт сонголтыг буруу ашиглуулж чадах юм бол тэр биднийг устгаж чадна гэдгийг мэднэ.

Залуу эрэгтэйчүүдээр 2 Нифай 2:27-г уншуул.

- Зөвийг сонгосны үр дүн юу вэ? (эрх чөлөө ба мөнхийн амьдрал.)
- Сатаныг дагасны үр дүн юу вэ? (Олзлогдол ба үхэл.)
- Сатаныг дагаснаар хүмүүс хэрхэн олзлогдохыг та нар харсан уу?
- Сатаныг дагасан хүмүүс хэрхэн үхдэг вэ? (Тэр Бурханаас салж сүнсээр үхдэг.)
- Сатаны туйлын зорилго юу вэ? (Тэр бүх хүмүүсийг өөр шигээ өрөвдмөөр болгох.)

Ишлэл ба ярилцлага

Ахлагч ЭлРэй Л.Кристиансен Сатаны зарим арга барилыг тодорхойлохдоо: “Сатан бүх заль мэхийг мэднэ. Тэр бидний уруу татагдах эмзэг газрыг, хэрхэн нүгэл хилэнц хийлгэхээр уруу татахыг мэднэ. Тэр ба түүний элч нар нүгэл хилэнцийг зсанал болгож, гэм нүглийн ноцтой байдлыг багасгаж, нүгэл хилэнцийг сэтгэл татам болгодог” (in “Q and A,” New Era, July 1975, p. 49).

Самбар ба
ярилцлага

- Ямар гурван арга барилыг Ахлагч Кристиансен онцгойлон дурдсан бэ? (Сатан гэм нүглийг санал болгодог, гэм нүглийн ноцтой байдлыг багасгадаг ба түүнийг сэтгэл татам болгодог.)

Самбарт нүглийг санал болгодог гэж бич.

- Сатан ихэвчлэн ямар гэм нүглийг залуу хүмүүст санал болгодог вэ? Хариултуудыг самбарт бич. Байж болох зарим хариултууд: архи уух, тамхи татах, хуурах, худлаа хэлэх, дэлгүүрээс хулгай хийх, хар тэмхи хэрэглэх, хараал хэлэх ба ёс суртахуунгүй бэлгийн харьцаатай байх зэрэг болно.

- Өнөөдөр залуу хүмүүст Сатан хэрхэн нөлөөлөхийг оролдож байна вэ?

Самбарт нүглийн ноцтой байдлыг багасгах гэж бич.

Гэм нүглийн жагсаалт руу буцаж ор. Гэм нүгэл бүрд Сатаны ноцтой байдлыг бууруулахыг зөвтгөдөг шалтгааны жишээг залуу эрэгтэйчүүдээр гаргуул. Гэм нүгэл бүрийн баруун талд тэдний хариултуудыг бич. Байж болох хариулт нь:

“Үүнийг хүн бүхэн л хийж байна.”

“Энэ нь хэнд ч гэмгүй болохоор үүнд буруу нь юу байгаа юм бэ?”

“Ганцхан удаа хийх нь гэм болохгүй.”

“Энэ нь зөвхөн намайг л эмзэглүүлнэ.”

“Хоёр хүн бие биендээ хайртай байх нь буруу биш.”

- Эдгээр шалтгуудын буруу нь юу байна вэ? (Тэд өөрийгөө хүндэтгэх байдлаа алдах, сүнслэг байдлаа алдах, номлолд явах, ариун сүмд гэрлэж, сэлэсчел хаант улсад орж чадахаа болих ба эцэг эх болон бусад хүмүүсийн сэтгэлийг өвтгөх гэсэн урт хугацааны уршгийг тооцдоггүй явдал болно.)

Хэрэв цаг байвал та шалтаг бүрт үнэлэлт өгч үүний зарим бүтэлгүй хүчин зүйлийг онцлон авч үзэж болно.

Самбарт нүглийг сэтгэл татам болгох гэж бич.

- Сатан эдгээр гэм нүглүүдийг хэрхэн сэтгэл татам болгодог вэ? (Тэр гэм нүглийн аятайхан талыг онцолж тэдэнд нийтлэг зүйл хийж байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг.)

- Сатан гэм нүглийг сэтгэл татам харагдуулахын тулд ямар хэрэгслийг ашигладаг вэ? (Телевиз, кино, ном, сэтгүүл, найз нөхдийн ятгалга.)

- Зарим реклам сурталчилгаа гэм нүглийг сэтгэл татам болгохыг хэрхэн оролддог вэ? (Согтууруулах ундаа, тамхийг эд хөрөнгө, алдар нэр, зугаа цэнгэлтэй нэг хэсэг мэт үзүүлдэг. Эдгээр бүтээгдэхүүнүүдийг алдар нэртэй, сэтгэл булаам хүмүүс хэрэглэж байгаагаар сурталчилдаг.)

Ишлэл

Сатан биднийг болон сул талыг маань мэддэгийг тайлбарла. Тэрээр биднийг яаж мөн хэзээ уруу татахыг болон биднийг ядарсан ба хүнд хэцүү үед яаж уруу татахаа мэддэг. Ерөнхийлөгч Дэвид О.МакКэй хэлэхдээ: “Сатан та нарыг уруу татахыг оролдох, та нарыг ялахаар оролдох, тэр мөч та бүхний хувьд хамгийн хэцүү мөч байх ба хэрэв энэ үед та нар өөрсдийгөө сул дорой болговол түүнд уруу татагдахад амар болно” (“The Temptations in Life,” *Improvement Era*, July 1968, p. 3).

Бодох асуултууд

- Та нарын хамгийн том сул тал чинь юу вэ? Тэр сул талаараа хэрхэн уруу татагдаж байсан бэ? Та нар энэ сул талаа засахын тулд юу хийж чадах вэ? (Залуу эрэгтэйчүүдээр чангаар хариулуулах хэрэггүй.)

Ярилцлага

- Уруу таталтыг дийлэх чадвар маань ямар үед хамгийн бага байдаг вэ? (Санаагаар унасан үед; бие болон оюун санаагаар ядарсан үед; Их Эзэний туслалцаагүйгээр уруу таталтыг давж чадна гэж бодсон үедээ; найз нөхөд, эцэг эх болон Сүмийн удирдагчидтай маргалдсан үед зэрэг хариултууд орох ёстой.)

Сатаны хамгийн үр дүнтэй арга бол биднийг аажмаар зөвийг хийхээс буруу зүйл хийх зам уруу хөтөлдөг гэдгийг тайлбарла. Түүний зөвлөгөөг сонсоход дуртай болж л байвал ноцтой гэм нүгэл үйлдэхэд хоёр долоо хоног, хоёр жил шаардах нь түүний хувьд чухал биш.

Хэрэв Сатан та нарыг ноцтой гэм нүгэл үйлдэхэд анх удаа уруу татахад та нар үүнийг анзаарахгүй. Тэр эхлээд бага, ноцтой биш мэт гэм нүгэл үйлдүүлэхээр уруу татна. Тэгээд аажим аажмаар улам бүр ноцтой гэм үйлдүүлсээр байгаад дараа нь анхандаа та нарын бодоо ч үгүй гэм нүглийг үйлдтэл уруу татах болно.

- Сатан янз бүрийн уруу таталтыг энэ замаар хийдгийг та нар хэрхэн мэдэх вэ?

Бид Сатаныг Эсэргүүцэж Чадна

Судрын түүх

Бошиглогч Мосе Бурхантай нүүр тулан уулзсан тухай ярилцлагыг Агуу Их Үнэт Сувданд бичсэн байдаг. Бурхан явсны дараа Сатан Мосе дээр ирэн, өөрийгөө шүтэн бишрэхийг тушаадаг. Бурханы алдрыг харсан Мосе Сатаныг мэхлэгч болохыг таньсан.

Мосе 1:18–22-оос Мосегийн Сатанд өгсөн хариултыг унш.

- Сатаны хүч чадлаас Мосе хэрхэн ангижирсан бэ? (Тэр Бурханыг тасралтгүй дуудаж Сатаныг зайлахыг тушаасан.)
- Сатаны уруу таталтыг амжилттай давахын тулд та нар юу хийсэн бэ?

Ишлэл

“Сатан соригдсон үедээ Мосед уурладгийн адил уурладаг. Тэрээр чанга дуугаар хашгирч, уурлан чичирсээр *итгэлтэй үнэнч* Мосегоос зайлан одсон. . . . Түүнд өөр арга байгаагүй. Та нарыг “надаас зайл, Сатан” гэж хэлэхэд тэр зайлах болно. *Хэрэв тухайн хүн шийдвэр төгс бол мөнх бус хүн бүр Сатанаас хүчтэй*” (Spencer W. Kimball, “The Blessings and Responsibilities of Womanhood,” *Ensign*, Mar. 1976, p. 71; italics added).

Дүгнэлт

Уриалга

Сатан болон түүний уруу таталтыг эсэргүүцэх шийдвэртээ тууштай байхыг залуу эрэгтэйчүүдэд уриал. Хэрэв бид түүнийг эсэргүүцэх юм бол Сатан биднийг удирдах хүчгүй байх болно гэдгийг дахин онцол.

Тэдний амьдралд Сатан ямар сул тал руу нь дайралт хийхийг оролдож болохыг нухацтайгаар бодож үзэх талаар залуу эрэгтэйчүүдийг урамшуул. Тэдэнд тэмдэглэлийнхээ дэвтэрт энэ сул талаа давах хоёр аргыг бичихийг зөвлө.

ЗОРИЛГО

Чин сэтгэлийн залбирлаар дамжуулан Тэнгэрлэг Эцэгтэйгээ ойртож чадна гэдгийг залуу эрэгтэй бүр ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд: залуу эрэгтэй бүрт судар.
2. “Бурхантай Ярилцах Урилга” гэсэн тараах материалыг залуу эрэгтэй бүрт хувилж өг.
3. Иносын Залбирал 3-р зургийг үзүүл (мөн Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга дахь 305-р зургийг [34730]).

ТАЙЛБАР

Зарим залуу эрэгтэйчүүд хувийн залбирлыг ховорхон, аль эсвэл хэзээ ч хийдэггүй. Тэр ч бүү хэл өдөр болгон залбирдаг ч үнэн сэтгэлээсээ биш байж болох юм. Зарим хүн Тэнгэрлэг Эцэгтэй залбирснаар ирэх адислалыг хүртээгүй байдаг. Зарим нэгэн нь залбирлынхаа олон хариултыг авсан байдаг. Аароны Пристийн зэрэгтнүүдийн хувийн туршлага хэдий өөр ч энэ хичээлийн зорилго бол Тэнгэрлэг Эцэгтэй өдөр бүр талархан залбирах ба залбирлаар дамжуулан тусламж, адислалууд авахад оршино.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Түүх ба ярилцлага

Оршил

Дараах түүхийг унших буюу ярь:

“Рон Кларк тэр өдрийг хэзээ ч мартахгүй. Тэрээр замын хажуу дахь горхины дэргэд хоёр тонны даацтай ачааны машины доор хэвтэж байв. Түүний хажууд хэдэн нөхөд нь үхсэн хэвтэж байлаа. Түүний эргэн тойрон 45 хүний үнэт амь насыг авч явсан машин хад мөргөж тэр ослоос болж цусан далай болсон байлаа. 45 хүний 12 нь амь үрэгджээ. 20 нь шархадсан байв. Рон өөрөө ачааны машины толгойн урд хамгийн их жинтэй хэсгийн хажууд унасан байлаа. Машин онхолдох үед тэр эрүүгээ хэд хэд цохьсон бөгөөд зүүн хөл нь машинд бяц дайрагджээ. . . .

“Роныг ачааны машинаас хамгийн сүүлд гаргасан. Түүнийг Пэнгүйчийн (Юта) эмнэлэгт хүргэсэн даруй гэр бүл нь Провогоос (Юта) ирсэн юм.

“‘Ээж ээ би зүгээр ээ,’ гэж тэр хэлэв.

“16-тай энэ Скаут хүү ихээхэн зориг тэвчээр гаргажээ. Хэдэн өдрийн дараа тэр үүнээс ч илүү зориг тэвчээр гаргах хэрэгтэй болов.

“Хэдэн өдрийн дараа түүнийг эмнэлгээс амаа бараг хөдөлгөж чадахгүй учир гуурсаар хооллодог байхад нь гэрт нь гаргав. Тэр арай ядан ярьж байв. Тэр дуулж ч чадахгүй байв. Энэ нь Роны хувьд маш их хэцүү байлаа. Түүний амьдралын туршид түүний зүйрлэшгүй сайхан хоолойг нь сонссон хүмүүст тэр аз жаргал авчирдаг байсан юм. . . .

“Тэгээд удахгүй Гордоны болон бусад 5 нөхдийнх нь оршуулга болох байлаа. Гадасны ерөнхийлөгч Бэн И. Люис түүнийг дуудахад тэр суга таягны тусламжтайгаар бага зэрэг л эргэж харах чадвартай байв.

“‘Рони, нас барагсдын гэр бүлүүд чамайг оршуулган дээр дуулахыг хүсэж байна,’ гэв.

“Тэр яаж чадах юм бэ? Түүний ам хөдөлж ч болохгүй их хавдсан байлаа. . . .

“‘Хэрэв чи залбирч бас их хүсэх юм бол чадна,’ хэмээн ерөнхийлөгч Люис амаллаа.

“Тэр үнэхээр хүсэж байлаа. Дараагийн хэдэн өдрийн турш залбирав. Тэр зөвхөн Их Эзэн энэ боломжгүй зорилгыг биелүүлэхэд тусалж чадна гэдгийг мэдэж байв.

“Оршуулга болох өглөө тэр юу ч идэж чадсангүй. Түүний ам их өвчтэй байсан ба шүдээ зуун ярьж байв. Урьдчилан бэлтгэл хийсэн нь бүтэлгүйтэв. Шүд нь зуурч тэр ямар ч авиа гаргаж чадахгүй байсан ба хүчгүй байв. Гэвч тэр ам өгсөн байсан.

“Провогийн Табэрнэклийн найрал дуун дээр Боб ахтайгаа индэрт цуг суух хүртлээ тэр чин сэтгэлээсээ залбирсаар байв.

“Дуулахаас хэдхэн минутын өмнө Рон гэнэт ер бусын амгалан тайвныг мэдэрч, тэр ах руугаа эргэн харж, ‘Би амаа хөдөлгөж чадаж байна,’ гэж шивнээд, ‘Зүв зүгээр болчихсон юм шиг байна,’ гэлээ.

“Тэр таягаа авч орган руу хазганаж очоод аргон тоглож буй Байрон Жэнсэн ах руу сулхан инээмсэглэн дохив. Залуу скаут эгцлэн зогсож бараг амьдралынхаа туршид нөхөрлөсөн таван нөхрийнхөө цэцгээр чимэглэсэн авс руу харлаа. Тэр яаж дуулах вэ?

“Түүний хоолой цээлхэн сайхнаар гарч эхлэв. ‘Их Эзэн та нарыг ивээж хамгаалаг. . . .’ тодхон аяс Табернеклийг дүүргэж зуны зөөлөн салхитай тэнгэрт хөөрөв. ‘Юу ч тохиолдсон, маргаашийн сайхнаар мөрөөдлөө дүүргэ. . . .’ Эцсийн мөч хүртэл аялгуу маш тод байв гэтэл . . . тэр цааш нь үргэлжлүүлж чадахаа болив. Тэр дайвалзан, ‘тэгээд биднийг дахин уулзтал’ гэж шивнэлээ.

“Табернеклд цугларсан мянга таван зуун гашуудаж буй хүмүүсийн хацрыг даган нулимс урсан уйлж байлаа. Нулимс зөвхөн өнгөрсөн 5 хүүхдийн төлөө ч бус мөн хавдсан амтай залуу Шинжээчийн зориг тэвчээрийн төлөө асгарч байв.

“Эрүүний тухайд гэвэл, яг дууны дараа ам нь дахиад түгжигдэн хаагдсан ба Роныг амаа нээж чадах болтол нилээд хэдэн долоо хоног өнгөрчээ.

“Ронд гайхамшиг тохиолдоогүй гэж хэн ч хэлж чадахгүй. . . . Гэвч гайхамшиг зүгээр л тохиолдчихоогүй. Үүнд жинхэнэ итгэл, чин сэтгэлийн залбирал, хувийн маш их чармайлт шаарддаг юм. Энэ залуу хөвгүүн эдгээр бүхнийг элбэг дэлбэг харуулж чадсан юм” (LoyeWright, “With Trust in God,” *Improvement Era*, Aug, 1967, pp. 42-43).

- Энэ залуу хөвгүүн залбирлын хүчийг хэрхэн мэдсэн бэ? Яагаад?
- Та нар хийж чадахгүй гэсэн зүйлээ хийхэд залбирал хэрхэн тусалж байсан бэ?

Залуу эрэгтэйчүүдээс тохиолдсон зүйлээсээ ярихыг хүс. Энэ түүхэнд гарсан шиг гайхамшиг агуу байх хэрэггүй харин өдөр тутмын амьдралд залбирсан учраас тусалсан тохиолдол байж болно. Хэрэв шаардлагатай бол ярилцлага өрнүүлэхийн тулд өөрт тохиолдсон зүйлээ ярихад бэлтгэлтэй бай.

Залбирал Бол Тэнгэр дэх Эцэгтэй Холбох Холбоос Юм

Ярилцлага

- Хэдийд залбирвал амар хялбар байдаг бэ? Яагаад?

Залуу эрэгтэйчүүдээр тодорхой хариулуул.

- Хэзээ залбирахад хэцүү байдаг вэ? Яагаад?

Залуу эрэгтэйчүүдээр тодорхой хариулуул.

- Арай ядан залбирал хэлэх болон үнэн сэтгэлээсээ залбирах хоёр ямар ялгаатай вэ?

Судрын үйл ажиллагаа

“Бурхантай Ярилцах Урилга” тараах материалыг залуу эрэгтэй бүрт өг. Тараах материал дахь шүлэг болгоныг уншаад ярилц. Залуу эрэгтэйчүүдээр судраас гол утгыг нь олуулж судрын заалтын баруун гар талд бичүүл.

- Бид хэрхэн “тогтмол залбирч” болох вэ?

Ишлэл ба ярилцлага

- Зүрх сэтгэлдээ залбирах гэж юу гэсэн үг вэ? Бид нарт чанга залбирах хэрэгтэй гэж заагаагүй бил үү?

Дараах ишлэл энэ тухай ярилцахад чинь тус болно:

“Мэдээж та нар Их Эзэнтэйгээ уруулаа хөдөлгөлгүй ярьж болно. Та нар ангидаа сууж, залбирлаа бодож эсвэл сургуулийнхаа талбайд холхиж байхдаа дотроо Их Эзэнтэйгээ ярьж болно. Олон хүмүүсийн дунд чимээгүй залбирч болно. Гэхдээ хааяа хааяа өрөөндөө өвдөглөн суугаад Их Эзэнтэй чангаар ярьж бай. Зүрх сэтгэлийн гүн дэх зүйлээ бүгдийг ярилцаарай. Өөрийн шаналал, өсөн нэмэгдэх

хүсэл, мөрөөдөлдөө хүрэх хүслээ түүнд хэл. Заяа тавилангаа олохын тулд юу хийх ёстойг чинь илчилж өгөхийг түүнээс хүс" (George Durrant, *Someone Special, Starring YOUth* {Salt Lake City: Bookcraft, 1976}, p. 63).

- Зүрх сэтгэлдээ залбирах нь та нарт хэрхэн тусалж байсан бэ?

Дүгнэлт

Ишлэл

Түүнтэй ойртох чармайлтанд маань туслахын тулд Тэнгэрлэг Эцэг өнөө үеийн удирдагчаар дамжуулан хэрхэн залбирахыг бидэнд зааж өгсөн. Бишоп Х.Бөөрк Пэтэрсоны зөвлөснийг уншаад ярилц:

"Их Эзэнтэй дотносохыг хүсвэл, түүнтэй хийх уулзалтынхаа чанарыг өсгөх буюу залбирахыг хүсэж байвал би та нарт дараах үйл явцыг зөвлөгөө болгож байна. Ганцаараа байж болох, бодож болох, өвдөглөн сууж болох, түүнтэй чангаар ярилцаж болох газар оч. Угаалгын өрөө, унтлагын өрөө эсвэл хувцасны өрөө ч байж болно. Тэгээд түүнийг дотроо төсөөл. Хэнтэй ярьж буйгаа бодож, бодол санаагаа удирдаж хамаагүй зүйл бүү бод. Эцэг, найздаа хандаж буй мэт байгтун. Одоо түүнд хэлье гэж бодсон зүйлээ, гэхдээ хоосон зүйлийг биш үнэн сэтгэлээсээ, чин зүрхнээсээ ярилц. Түүнд итгэж, өршөөл гуй, тэгээд хариултыг сонс. Сонсох бол залбирлын зайлшгүй нэг хэсэг юм. Хариултууд Их Эзэнээс чимээгүй, маш чимээгүй ирдэг. Үнэндээ хэдхэн хүн л түүний хариултыг чихээрээ тод сонсдог. Бид маш анхааралтай сонсох ёстой, тэгэхгүй бол түүнийг хэзээ ч таньж мэдэж чадахгүй. Ихэнх хариулт нь Их Эзэнээс бидний зүрхэнд дулаан таатай мэдрэмж болон ордог, аль эсвэл бидний оюун санаанд бодол болон ирдэг. Тэдгээр нь бэлтгэлтэй байгаа болон тэвчээртэй хүмүүст ирдэг" (in Conference Report, Oct. 1973, p. 13; or *Ensign*, Jan. 1974, p. 19).

Уриалга

Уриалга дахь судруудын хоёрыг нь одоор тэмдэглээд залбирлын эдгээр тал дээр энэ долоо хоногт онцгойлон ажиллахыг уриал.

Бурхантай Ярилцах Уриалга

Хэн:	Моронай 7:48
Яагаад:	2 Нифай 32:9 1 Тесалоник 5:18 Иаков 1:5 Матай 7:7–8 3 Нифай 18:15
Яаж	3 Нифай 19:6 Моронай 10:4
Хаана:	Матай 6:6 С ба Г 19:28
Хэзээ:	Алма 34:21 1 Тесалоник 5:17
Амлалт:	Алма 37:37 3 Нифай 18:20

ЗОРИЛГО

Жинхэнэ мацаг барилт нь агуу сүнслэг хүчийг авчрах ба Их Эзэнээс ирэх адислалуудыг өсгөнө гэдгийг залуу эрэгтэй бүр ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Залуу эрэгтэй бүрт харандаа, цаас.
2. Исаиа 58:6–10-ыг анхааралтай судал.
3. Хэрэв танай бүсэд *Family Home Evening Video Supplement* (53276) байгаа бол “Мацгийн Хууль” гэсэн 15-р хэсгийг үзүүлэхэд бэлтгэ.

ТАЙЛБАР

Өсч яваа хөвгүүнд мацаг барилт гэсэн үг нь маш олон янзын сэтгэгдэл болон мэдрэмжийг төрүүлдэг. Түүний хоол идэх дур нэмэгдэх үед түүнд зөв мацаг барьж сурах нь хэцүү байж болох юм. Мацаг барилтын ашигтай талуудыг онцлон хэл. Залуу эрэгтэйчүүд мацаг барилт ба залбирал хоёрын хоорондох холбоог болон мацаг барилтын хуулийг сахих байдлаа сайжруулж чадна гэдгээ ойлгох ёстой.

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

Асуулт Хариулт

Зөв Мацаг Барилт

Залуу эрэгтэй бүрт цаас, харандаа өг. Залуу эрэгтэйчүүдээр цаасан дээр нэгээс арав хүртэл дугаарлуул. Тэдэнд “зөв буруу” гэсэн богинохон сорилт өгч тэдний мацаг барилтын тухай хэр их мэддэгийг үзнэ гэдгээ тайлбарла.

Зөв ба Буруу

1. Мацаг барилт нь үргэлж хорин дөрвөн цагийн турш байх ёстой.
2. Мацаг барилт үргэлж залбиралтай хамт байх ёстой.
3. Олон янзын шалтгаанаар мацаг барьж болно.
4. Мацаг барих нь сүнсэнд сайн боловч биенд муу.
5. Мацаг барилт бол зарлиг.
6. Мацаг барилт бол зөвхөн хоолноос бүрэн татгалзахыг хэлнэ.
7. Эрүүл мэнд нь ямар байхаас үл хамааран наймаас дээш насныхан мацаг барих ёстой.
8. Мацаг барилт нь залбирлыг илүү утга төгөлдөр болгодог.
9. Залбирал нь мацаг барилтыг илүү утга төгөлдөр болгодог.
10. Мацаг барилт нь амархан.

Залуу эрэгтэйчүүдээр өөрсдийнх нь бичсэнийг засуул. Тайлбарыг богино хий. Зөв хариултууд:

1. Буруу. Заримдаа бүтэн хорин дөрвөн цаг мацаг барих нь боломжгүй байдаг (Joseph F. Smith, *Gospel Doctrine* [Salt Lake City: Deseret Book Co., 1939], p. 244-ийг үз).
2. Зөв (*Gospel Doctrine*, 238-р хуудсыг үз.)
3. Зөв (үүнийг хичээл дээр ярилцана).
4. Буруу
5. Зөв (С ба Г 88:76-г үз.)

6. Буруу. Мацаг барилт бол хоол болон ундны зүйлээс татгалзахыг хэлнэ (*Gospel Doctrine*, 243-р хуудсыг үз)
7. Буруу (*Gospel Doctrine*, 244-р хуудсыг үз)
8. Зөв
9. Зөв
10. Тухайн хүний сурсан мацаг барих дадлаас шалтгаалан зөв, буруугийн аль нь ч байж болно.

Мацаг барилтын Ням Гарагийн зөв мөрдлөг бол хоёр удаагийн хоол ба унднаас бүрэн татгалзаж, мацаг барилт гэрчлэлийн цуглаанд оролцож, бишоптоо өгөөмөр сэтгэлийн мацаг барилтын өглөгөө гачигдалтай хүмүүст туслахаар хандивлах юм гэдгийг тайлбарла. Мэдээж мацаг барилтын Ням Гарагаас бусад өдөр бас мацаг барьж болно.

Мацаг Барьснаар Гайхамшиг Тохиолдож Болно

Судрын түүх

Нэгэн эцэг биенд нь муу ёрын сүнс орсон хүүгээ Есүст авчирчээ. Тэр хүн хүүгээ Есүсийн төлөөлөгч нарт аваачсан боловч тэд муу ёрын сүнсийг хөөж чадаагүйг хэлэв. Есүс хүүгээс түүнийг гаргасны дараа төлөөлөгч нар нь түүн дээр хүрч ирээд ганцаарчлан “Яагаад бид тэр сүнсийг зайлуулж чадсангүй вэ?” гэж асуужээ (Марк 9:28).

- Есүс төлөөлөгч нартаа юу гэж хэлсэн бэ? (Залуу эрэгтэйчүүдийн нэгээр Марк 9:29 дэх хариултыг уншуул: “Энэ төрөл нь зөвхөн залбирлаар гарч чадна.”)

Түүх

“Хонолууд бидний нэг найз байдаг юм. . . . Тэр тэндхийн залуухан бишоп, тун чинээлэг, залуу хүн хирнээ маш их төлөв түвшин Түүнийг нэг өдөр Хатан Хааны Эмнэлгээс полиотой нэгэн хүүг ирж адислаж өгөөч гэж дууджээ. Нутгийн нэг эгч түүнийг дууджээ. Тэр түүний бишоп байсан ба тэр эмэгтэй, ‘Бишоп оо, энд ирээч, миний хүү полио өвчинд нэрвэгдээд байгаа ба би таныг энд ирж, түүнд ёслолыг гүйцэтгэж, түүнийг адислаж өгөхийг хүсэж байна’ гэжээ. Бүхэл өдөржингөө тэр түүнийг хүлээсэн авч бишоп огт үзэгдсэнгүй. Шөнөжингөө бас л үзэгдсэнгүй, маргаааш өглөө нь тэр ер харагдаагүй боловч үдээс хойш арай эртхэн ирлээ. Тэр эмэгтэй түүн рүү урсгаж гарав. Тэр бодсоноороо л түүнийг хэлж байлаа. ‘Та миний бишоп. Би танд хүү минь энд полио өвчинд нэрвэгдчихээд байна гэж хэлээд таныг дуудуулсан биз дээ. Та бол өөрөө өөртөө дарга, та өөрийн гэсэн машинтай, танд сайхан дарвуулт онгоц бий, танд хүссэн бүхэн чинь байдаг, цаг тань ч бас таных, тэгээд үзэгдэж харагдсангүй шүү. Та одоо бүхэл бүтэн өдрийн дараа нэг юм ирж байна.’ Дуусгасныхаа дараа түүнийг бас өөрөөр дуудах юмаа бодож олсонгүйд бишоп инээмсэглээд ‘За, би өчигдөр харилцуураа өлгөчихөөд мацаг барьж эхэлсэн, би хорин дөрвөн цаг мацаг барьж, залбирч байлаа. Би одоо хүүг чинь адислахад бэлэн байна’ гэж хэлэв. Үдшийн таван цагт хүү полио өвчнөөс бүрэн ангижирч эмнэлгээс гарчээ. ‘. . . Ийм юм тохиолдоод байдаггүй ч мацаг барилт ба залбирлаар бол болдог юм.’

“Хэрэв тэр өмнөх өдөр нь тэнд яваад очсон бол юу болох байсан бол гэж би одоо ч гэсэн их эргэлздэг юм. Залбирал, мацаг барилт хэрэгтэй байсан байжээ гэж би боддог” (*Matthew Cowley, Matthew Cowley Speaks [Salt Lake City: Deseret Book Co., 1954], x. 149-50*).

Түүх

Адислал авахаар Ерөнхий эрх мэдэлтэнд хүүгээ авчирсан эцэг эхийн тухай дараах түүх өгүүлж байгааг хэл.

“Жил гаруйн өмнө нэг хос жижигхэн хүүгээ дагуулсаар манай өрөөнд ирсэн юм. Аав нь надад ‘Эхнэр бид хоёр хоёр өдөр мацаг барьж байгаа бөгөөд хүүдээ адислал авахаар авчирсан юм. Тэгээд биднийг тан руу явууллаа’ гэж хэлсэн юм.

“‘Тэр яасан юм бэ?’ гэж би асуув.

“Тэд хүүхэд нь хараагүй, дүлий сонсголгүй, булчингаа зохицуулах чадваргүй, 5 настай байхдаа мөлхөж ч чадахгүй байсан гэлээ. Би өөртөө ингээд л гүйцээ гэж хэлсэн. Энэ төрлийн өвчин мацаг барилт ба залбирлаар аврагдахгүй гэж хэлсэн юм. Энэ эцэг эх хоёрын мацаг барилт ба залбиралд маш их итгэж байв. Би тэр

хүүхдийг адисласан ба хэдэн долоо хоногийн дараа: ‘Каули ах аа, бид таныг манай жаахан хүүг хараасай гэж маш их хүсэж байна. Тэр мөлхөж байна. Биднийг шалан дээгүүр бөмбөг шидэхэд тэр араас нь мөлхөж байна. Тэр харж чадаж байна. Биднийг түүний толгой дээр алгаа ташихад тэр үсэрч байна. Тэр сонсож чадаж байна. Эрүүл мэндийн шинжлэх ухаан ялагдал хүлээлээ. Бурхан яллаа’ гэсэн захиа хүлээж авсан юм” (Matthew Cowley, *Miracles*, Brigham Young University Speeches of the Year [Provo, Utah, 18 Feb. 1953], pp. 7-8).

- Мацаг барилтаар дамжуулан ид шид хэрхэн ирдгийг та нар харсан уу?
- Мацаг барьснаар та нар хэрхэн адислагдаж байсан бэ?

Мацаг барилт бүхэн гайхамшигтайгаар эдгэрэх үр дүнд хүрдэггүй гэдгийг тайлбарла. Өөр маш олон төрлийн мацаг барих шалтгаан байдаг. Үнэндээ маш олон хүмүүс өвчнийг эдгээхээс бусад өөр шалтгаанаар мацаг барьдаг.

Мацаг Барих нь Зүгээр Хоолгүй Явахаас Илүү

Залбирал гэдэг үгийг самбарт бичээд залуу эрэгтэйчүүдээр тэдний мэдэх, хүмүүсийн залбирч болох зорилгуудыг жагсааж бичүүл.

- Хэрэв бид *залбирал* гэдэг үгийн оронд *мацаг барилт* гэсэн үг бичвэл эдгээр зорилго нь тохирох уу?

Мацаг барих эхний оролдлого хэцүү ба сэтгэлээр унагаж болно гэдгийг тайлбарла. Энэ нь хоол ундгүйгээр явахтай адил байж магадгүй. Хэдий тийм ч мацаг барилтын тухай суралцаж сүнслэг туршлагатай болох нь жинхэнэ сэтгэл ханамжтай байх боломж олгодог.

Сайн мэдээг сурах хамгийн сайн зам бол түүгээр амьдрах юм. Эхэндээ ихэнх залуус болон хүүхдүүд тэдний гэр бүл хийдэг учраас юмуу энэ нь хийх ёстой зөв зүйл гэж боддог учраас зүгээр л мацаг барьдаг. Магадгүй тэд яагаад хоол ундыг өөрсдөөсөө хорих тухай боддоггүй байж болно. Үнэндээ зарим хүмүүс мацаг барилтын Ням Гарагт тэд ийш тийш холхин, өөрсдийгөө өрөвдөн, тэр өдрийг хэзээ дуусахыг хүлээж байдаг. Энэ төрлийн бодол мэдрэмжүүд нь энгийн зүйл гэдгийг тайлбарла. Хэдий тийм ч бид мацаг барилтын хуулийг ёсоор нь үргэлжлүүлэн сахвал энэ нь утга учиртай болно.

- Мацаг барилтаа илүү утга учиртай болгохын тулд та нар юу хийж чадах вэ? Самбар дээр *утга учиртай мацаг барилт* гэж бичээд залуу эрэгтэйчүүдийн хариултуудыг бич. Дараах санаанууд багтсан эсэхийг анхаар.

1. Мацаг барилтыг зорилготой байлгах.

Зорилгогүйгээр мацаг баривал бидний мацаг барилт өлсөхөөс өөр юу ч биш гэдгийг тайлбарла. Хэрэв зөвхөн хоолгүй явах нь зорилго байх юм бол хоол нь бидний төвлөрөх зүйл болдог. Нөгөөтэйгүүр, хэрэв бидний мацаг барилтын хамгийн энгийн нь ч зорилготой байх юм бол зорилго нь бидний анхаарлын төвд байх болно.

- Юу ч идэхгүй байх, мацаг барих хоёр ямар ялгаатай вэ? (Мацаг барилт бол сайн дураараа хоол унднаас татгалзаж өөрсдийгөө даруусган Тэнгэрлэг Эцэгтээ ойртохыг хэлнэ)

Дараах судруудаас залуу эрэгтэй бүрт нэг юмуу хоёрыг даалга. Хэдэн минутын турш тэдэнд даалгасан судруудыг унших хугацаа өг. Судар бүр мацаг барилтын зорилгыг агуулсан байгаа. Залуу эрэгтэй бүрээр түүний судар мацаг барилтын ямар шалтгаан агуулж байгааг хэлүүл. Бүх хариулт болон заалтуудыг самбарт бичиж болно. Залуу эрэгтэйчүүдтэй ямар зорилгоор мацаг барих ёстой тухай ярилцахдаа энэ жагсаалтыг хэрэглэ.

2 Самуел 12:15–16 (Өвчтөнийг эдгээхэд туслахад)

Исаиа 58:6–7 (Ядууст туслахад)

Үйлс 13:2–3 (Ёслолуудыг гүйцэтгэхэд туслахад)

Мозая 27:22–24 (Нүглээ наманчлахад туслахад)

Самбар ба
ярилцлага

Судрын үйл
ажиллагаа

Алма 5:46 (Илчлэлт ба гэрчлэлийн төлөө)

Алма 6:6 (Гишүүн бус хүмүүст туслахад)

Алма 17:3 (Илчлэлт ба илүү сайн пристийн зэрэгтэн болоход туслахаар)

Алма 17:9 (Илүү сайн номлогч болоход туслахаар)

Алма 45:1 (Бишрэн шүтэх болон талархлаа илэрхийлэхэд)

Хиламан 3:35 (Илүү их төлөв түвшин болж Христэд итгэхийн тулд)

Хиламан 9:10 (Уй гашуутай үед хүчтэй байхын тулд)

С ба Г 88:76 (Их Эзэний зарлигуудыг сахихад)

• Эдгээр зорилгын аль нэгний төлөө мацаг барих нь та нарт хэрхэн тусалсан бэ?

2. Залбирлаа мацаг барилттай хослуул.

• Хайлш гэж юу вэ? (Дангаараа, анхны байдлаасаа илүү хатуу, металлуудын холимог эцсийн бүтээгдэхүүн.)

• Мацаг барилт ба залбирлыг хослуулах нь та нарыг хүчтэй болгоход хэрхэн тусалсан бэ?

Ишлэл

Бид залбиралдаа мацаг барилтыг нэмэх нь тамирчин хүн хүч нэмэхтэй адилхан гэдгийг тайлбарла.

“Тамирчид байгаа бүхнээ хийсний дараа нэмэлт хүч чадал ба хоёр дахь хүч нэмсэн тухай олонтаа ярьдаг. Жишээ нь: Маш их ядарсан сагсан бөмбөгчийн тоглолт улам бүр удаашрах юмуу эсвэл хэдийгээр тэр маш их ядарсан ч үргэлжлүүлэн сайн тоглож чадна. Хэрэв тэр сүүлчийнхийг нь сонгож үргэлжлүүлэн сайн тогловол хоёр дахь буюу нэмэлт хэмээн нэрлэгддэг эрч хүчийг авч болно. Тоглогч бүх л хүчээ шавхаж, мөн түүн дээр бас жаахныг нэмэхээс нааш энэ нэмэлт хүч нь ирдэггүй” (John H. Vandenberg, “Fasting,” *Improvement Era*, Feb. 1969, p.71).

3. Гэрчлэлээ хуваалц.

Үүнийг мацаг болон гэрчлэлийн цуглаан дээр, найз нөхөддөө, гэр бүл дотроо болон хувийн тэмдэглэлдээ хийж болно.

4. Чухал зүйлсийг эргэцүүлэн бодох цаг гарга.

Бид адислалуудаа эргэн тоолж, зөв шударга зорилгоо тоймлон харж өөрсдийгөө сайжруулах төлөвлөгөө гаргах ёстой.

5. Мацаг барилтаа залбирлаар дуусга.

Дүгнэлт

Ишлэл ба ярилцлага

Ахлагч Торпе В.Исааксон ийн хэлжээ: “Мацаг барилт нь хоол унднаас бүрэн татгалзахаас бүрдэнэ. Мацаг барилт нь түүний дагалдагч залбиралтай хамт сүнслэг байдлыг нэмэгдүүлэх, Бурханы хайр ба хайр халамжийг тэтгэх, хүн төрөлхтний зүрх сэтгэлд итгэлийг нэмэгдүүлэх, хүнийг гэмшүүлэх ба төлөв түвшин байдлыг урамшуулах, зөв шударгыг олж авахад туслах, хүмүүст Бурханд найдахыг заах, мацаг барилтын хуулийг зөвөөр сахиж мөрддөг хүмүүст авралын замыг түргэлүүлэхийн тулд зориулагдсан” (in Conference Report, Apr. 1962, p. 67).

Дараах асуултуудыг залуу эрэгтэйчүүдээс асуу.

- Бид мацаг барихдаа хэр хэмжээний хоол унднаас татгалзах вэ? (Бүрэн)
- Мацаг барилтын дагалдагч нь юу вэ? (Залбирал)
- Мацаг барилт нь та нарын сүнслэг байдал ба итгэлийг хэрхэн өсгөдөг вэ?
- Та нарыг илүү даруухан болоход мацаг барилт хэрхэн тусалсан бэ?
- Та нар Бурханаас хамаардаг гэдгээ сурахад мацаг барилт хэрхэн тусалсан бэ?

Дүгнэлт

Уриалга

Дараагийн удаа мацаг барихдаа залбирлыг гол хэсгээ болгож, онцгой зорилго сонгон мацаг барихыг залуу эрэгтэйчүүдэд уриал.

14

Бурханд Дуулгавартай Байх нь

ЗОРИЛГО

Бид Их Эзэнд хайртай учраас Түүнийг дуулгавартай дагадаг ба энэ нь бидэнд аз жаргал, эрх чөлөө авчирдаг гэдгийг залуу эрэгтэй бүр ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаа.
2. Та хичээл дэх дөрвөн төрлийн нөхцөлийн судалгааг өөр өөр залуу эрэгтэйчүүдэд даалга. Дааж авсан хүн тус бүрээр судалгааных нь нөхцөлийг яриулж ярилцлагыг удирдуул.

ТАЙЛБАР

Энэ дэлхий дээр Бурханд дуулгавартай байсныхаа төлөө ихэнхдээ шоолуулан амьдардаг гэдгийг тайлбарла. Хэдий тийм ч Хожмын Үеийн Гэгээнтнүүд зөвхөн Бурханы хуулиудыг сурч дуулгавартай байснаараа жинхэнэ аз жаргал ба эрх чөлөөг олж авч чадна гэдгийг мэднэ. Хэдийгээр бид үүрэг хариуцлага гэж бодох буюу хүндэтгэсэндээ дуулгавартай байж болох боловч Их Эзэнд хайртай учраас түүнд дуулгавартай байх ёстой. Бид Тэнгэрлэг Эцэгтээ хэр их хайртай байна төдий чинээ түүний зөвлөмж болон жишээг дагах болно. Зөвхөн Бурханы агуу хуулиудад дуулгавартай байснаар тэд хайж буй аз жаргалаа олж авах болно гэдгийг зөвлөхийн хувьд та залуу эрэгтэйчүүдэд батлах үүрэгтэй.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Түүх ба ярилцлага

Оршил

Дараах түүхийг унших буюу ярьж өг.

Лорэнс фермийнхээ хажуу дахь голын эрэгт суугаад загасчилж байв. Энэ нь маш сайхан өдөр байлаа. Тэр гэр бүлээ энэ фермд нүүж ирснээс хойшхи гурван жилийн тухай бодож байлаа. Тэр эргэн тойрны нам гүм байдалд, гэр бүлтэйгээ байсан сайхан мөчүүдэд болон ан амьтдад хайртай байжээ. Тэр ч бүү хэл зав чөлөөгүй ажиллаж байсан үеүдэд тэр ихэнхдээ сэтгэл ханамжтай байлаа.

Тэрээр энэ өдөр маш их баяр хөөртэй байв. Хэдэн өдрөөр хот уруу явсан аав нь буцаж ирнэ. Гэнэт тэр босов. Шинээр авчрах тугал хийх хуучин хороогоо засахыг аав нь түүнээс гуйсныг тэр бараг мартаж шахсан байв. Лорэнс чадах чинээгээрээ гэр лүүгээ гүйв. Хоёр цагийн дараа тэр ядрангуй сууж байв. Тэр аавынхаа хий гэж гуйсан зүйлийг дуусгасан байлаа. Одоо тэр амарч болно.

- Яагаад Лорэнс аавынхаа гуйсан зүйлийг хийхээр загасчлахаа шууд зогсоосон гэж та нар бодож байна вэ?
- Лорэнсийн аавтайгаа өнгөрөөсөн мөчүүд нь түүний даалгавраа дуусгах хүслийн шалтгаан хэрхэн болсон бэ?

Бид Их Эзэнд Хайртай Учраас Түүнд Дуулгавартай Байх Ёстой

Самбар ба ярилцлага

Самбарт дараах үгсийг бич: *Үүрэг хариуцлага нь биднийг юм хийлгүүлдэг; хайр нь юмсыг сайн хийлгүүлдэг.*

- Хүний дуулгавартай байдал нь яагаад түүний хайраас хамаардаг вэ?
- Та нар хэзээ үүрэг хариуцлагаас эсвэл айснаас болж дуулгавартай байсан бэ?
- Та нар ямар үед хайртай учраас дуулгавартай байсан бэ?

Судар ба ярилцлага	Нэг залуу эрэгтэйгээр Иохан 14:15-ыг уншуул. Утгыг нь ярилц. Залуу эрэгтэйчүүдэд энэ шүлгийг тэмдэглэхийг зөвлө. <ul style="list-style-type: none"> • Их Эзэнд хайртай боловч түүний зарлигуудыг сахихыг нэг их хичээдэггүй хүмүүс хэр зэрэг чин сэтгэлтэй байдаг бэ?
Судар дахь нөхцлийн судалгаанууд	Их Эзэнд хайртай учраас түүнд дуулгавартай олон хүмүүсийн жишээ сударт байдгийг тайлбарла. Хэрэв та урьдчилан даалгасан бол залуу эрэгтэйчүүдээр дараах нөхцөлийн судалгаануудыг яриул үгүй бол өөрөө тэдэнд ярь.
Нөхцлийн судалгаа 1	Бошиглогч Елиагийн амьдрал Хатан Хаан Иезебелийн гарт орсон байв. Их Эзэн Елиад өөрийгөө Херит горхинд нуу гэж хэлжээ. Сударт гайхамшигт үнэнийг энгийнээр: “Тэгээд тэр явж Их Эзэний үгийн дагуу үйлдлээ” (1 Хаадын дээд 17:5) гэж тэмдэглэжээ. Залуу эрэгтэйчүүдэд судар дээрээ энэ өгүүлбэрийг тэмдэглэхийг зөвлө. Самбарт <i>Елиа явж үйлдсэн</i> гэж бич. Елиа маргалгүй, шалтаг эрэлгүй харин зүгээр л “явж үйлдсэн” гэж тайлбарла.
Нөхцлийн судалгаа 2	Лихай бошиглогч ба эцэг Их Эзэний илчилсэн заавруудыг хүүхдүүддээ өгсөн. Лэмэн, Лэмүүл хоёр тэднээр хийлгэхийг хүссэн зүйл нь дэндүү хэцүү зүйл гэж хариулаад маргалдан хүлээж аваагүй (1 Нифай 3:5-ыг үз). Нифай Тэнгэр дэх Эцэгээ мэдэхийг хүсэн Тэнгэрлэг Эцэг ба энэ дэлхийн эцэгтээ маш их хайртай байсан тул “Би явж Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно,” гэж хариулсан. (1 Нифай 3:7). Залуу эрэгтэйчүүдийг судар дээрээ энэ өгүүлбэрийг тэмдэглэхийг зөвлө. Самбарт <i>Нифай-Би явж биелүүлнэ</i> гэж бич.
Нөхцлийн судалгаа 3	Залуу Иосеф Смит тэнгэрийн элч Моронайг сонсож бүтэн шөнийг өнгөрүүлсэн. Дараачийн өглөө шөнийнхөө явдлаас сульдсан Иосефийг буцан явж тохиолдсон Явдлаа эцэгтээ ярь гэж тушаасан. “Би дуулгавартай байж талбай дээр байсан эцэгтээ буцан очиж бүх болсон явдлыг түүнд хэлсэн” гэсэн залуу Иосефийн үгийг сонс (Иосеф Смит-Түүх 1:50). Залуу эрэгтэйчүүдэд судрыг тэмдэглэхийг зөвлөөд самбарт <i>Иосеф Смит-дуулгавартай байсан</i> гэж бич.
Нөхцлийн судалгаа 4	Есүс Христ Гетсеманы цэцэрлэгт бүх хүн төрөлхтний гэм нүглийн төлөө шаналан зовоходоо тэр “Эцэг минь, хэрэв боломжтой бол Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч миний хүслээр биш, харин таны хүслээр болог” гэж залбирсан (Матай 26:39). Залуу эрэгтэйчүүдэд энэ шүлгийг тэмдэглэхийг зөвлөж самбарт <i>Есүс таны (Тэнгэрлэг Эцэгийн) хүслээр</i> гэж бич.
Гэрчлэл	Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгтээ хайртай бол түүнд дуулгавартай байхыг хүснэ гэж гэрчил. Хэрэв бидэнд дуулгавартай байх нь хэцүү бол бид Их Эзэнийг хайрлах хайраа хүчтэй болгох ёстой. <ul style="list-style-type: none"> • Та нар Тэнгэрлэг Эцэгээ хайрлах хайраа яаж хүчтэй болгож чадах вэ?

Дуулгавартай Байдал нь Эрх Чөлөө ба Аз Жаргал Авчирдаг

Дуулал, судар, самбар ба ярилцлага	Залуу эрэгтэйчүүдээр “Үүнийг Мэдэж Ав, Хүн Бүр Эрх Чөлөөтэй” гэдэг дууллын эхний бадгийг уншуул (Дуулал, 240). <ul style="list-style-type: none"> • “Бурхан хэнийг ч тэнгэр лүү албадахгүй” гэдэг нь юу гэсэн үг вэ? Залуу эрэгтэйчүүдээр Иохан 8:31-ийг уншуул. <ul style="list-style-type: none"> • Та нар хэрхэн Аврагчийн үгийг “үргэлжлүүлэх” вэ? • Шавь болохын тулд та нар юу хийж чадах вэ? Залуу эрэгтэйчүүдээр Иохан 8:32-ыг уншуул. <ul style="list-style-type: none"> • Хэрэв бид үнэнийг үл ойшоож амьдралдаа хэрэгжүүлэхгүй бол үнэн бидэнд яаж нөлөөлөх вэ?
------------------------------------	--

Самбарт дараах үгсийг бич.

Үнэн биднийг эдгээрээс чөлөөлж чадна.

Үнэн биднийг эдгээрт чөлөөтэй байлгаж чадна.

Залуу эрэгтэйчүүдээр мэдээлэл тус бүрийн доор аль болох олон үг жагсаан бичүүл.
Зарим жишээнүүд:


Нүглээс чөлөөлөх
Гэм нүглээс чөлөөлөх
Төөрөгдлөөс чөлөөлөх
Санаа зовохоос чөлөөлөх
Эргэлзээнээс чөлөөлөх
Хайхрамжгүй байдлаас чөлөөлөх
Чөлөөтэйгөөр ухаалаг сонголт хийх
Чөлөөтэйгөөр пристийн зэрэгт ахих
Чөлөөтэйгөөр номлолд явах
Чөлөөтэйгөөр ариун сүмд гэрлэх

Сургаал ба Гэрээ 130:20–21-ийг залуу эрэгтэйчүүдээр уншуул.

• Дуулгавартай байхын үр дүн юу вэ? (Адислал.)


Самбарын үзүүлэн

Самбарт дараах үзүүлэнгүүдийг байрлуул.



- Бид адислалуудыг авч баяр жаргалтай болохдоо яагаад дуулгавартай байх илүү их хүсэлтэй болдог вэ?
- Бидний дуулгавартай байдал нэмэгдэхэд юу болдог вэ?(Бидний адислал нэмэгддэг.)
- Илүү их адислалуудыг хүлээж авахдаа бид юу мэдэрдэг вэ?

Самбарын үзүүлэнд дараах үгсийг нэмж бич.



- Бид ямар байдалтайгаар дуулгавартай байх ёстой вэ?
Залуу эрэгтэйчүүдээр Сургаал ба Гэрээ 58:29-ийг уншуул.
- Эргэлзсэн байдалтайгаар зарлигуудыг нь сахидаг хүнд Тэнгэрлэг Эцэг ямар шан өгдөг вэ?

Дүгнэлт

Ишлэл

Дараах мэдэгдлийг унш: “Дуулгавартай байдал нь бүх зөв шударга ба хөгжил дэвшлийн тулгын чулуу болох тэнгэрийн хамгийн анхны хууль юм. Энэ нь тэнгэрийн хуулийг мөрдөх, оюун ухаан болон Бурханы хүсэлтэй нийцсэн байдаг” (Bruce R. McConkie, *Mormon Doctrine*, 2nd ed, {Salt Lake City: Bookcraft, 1966}, p. 539).

Гэрчлэл ба уриалга


Зарлиг болгоныг сахих нь насан туршид аз жаргал авчирдгийг гэрчил. Залуу эрэгтэй бүрээс бүрэн ойлгоогүй учраас сахихад хэцүү нэг зарлигийг хэлэхийг хүс. Тэр зарлигаа бүтэн нэг сарын турш сахиж, ойлгохын тулд залбирч, суралцаж итгэлтэй болохыг залуу эрэгтэйчүүдэд уриал.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр өөрийгөө өргөмжлөлд бэлтгэх хүсэлтэй болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаанууд.
2. Хоёр зурагт хуудас бэлтгэ. Нэг зурагт хуудсан дээр *Үхэшгүй амьдрал бол төгсгөлгүй амьдрал дахь махан ба ясан биеийн дахин амилалт гэж бич. Энэ дэлхий дээрх хүн бүрт үнэгүй өгөгдсөн үхэшгүй амьдралын бэлэг бол Есүс Христийн дахин амилалтын үр дүн юм. Нөгөө зурагт хуудсан дээр Өргөмжлөл бол Бурханы амьдралтай адил мөнхийн амьдрал. Энэ нь мөнхийн амьдрал дахь гэр бүлийн нэгжийн үргэлжлэлээс бүрдэнэ. Үүнийг хүлээн авсан хүн нь Сэлэсчел хаант улс дахь гурван тэнгэрийн дээдийг өвлөн авах болно. Энэ өв нь зөвхөн онцгой шаардлагыг хангасан хүнд өгөгдөх болно гэж бич.*
3. Пристийн зэргийн цуглаан эхлэхээс өмнө самбар дээр дараах зүйлийг бэлд.



4. Энэ хичээлд хэрэглэгдэх тараах материалын хувиудийг бэлд (сонголтоор).

ТАЙЛБАР

Бидний хүлээн авч болох хамгийн дээд бэлэг бол өргөмжлөл буюу мөнхийн амьдрал юм. Өргөмжлөлийн мөн чанар нь бидний ойлголт болон мөрөөдлөөс хамаагүй хол боловч бид энэ нь Их Эзэнтэй онцгой гэрээнүүдийг хийж, сахих явдал юм гэдгийг мэднэ.

Өргөмжлөлийг хүлээн авна гэсэн та нарын хүчтэй хүсэл, залуу эрэгтэйчүүдийг энэхүү зорилтыг эрэлхийлэхэд нь урам өгөх түлхүүр болно. Тэдэнд өргөмжлөлийг олж авах боломжтой гэсэн итгэл ба түүнд хүрэх шийдвэрээ илэрхийл.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Зурагт хуудас
ба ярилцлага

Энэ Дэлхийд Төрсөн Хүн Бүхэн Үхэшгүй Амьдралыг Хүлээн Авна; Зөвхөн Дуулгавартай Байсан нь Өргөмжлөлийг Хүлээн Авна

Зуун зууны турш хүн төрөлхтөн үхлийн дараах амьдралын тухай бодож ирснийг тайлбарла. Зарим хүмүүс үхлийн дараах амьдралд огт итгэхгүй байхад зарим нь ямар нэг амьдрал байдагт найдаж байдаг.

Үхэшгүй амьдралын тодорхойлолттой зурагт хуудсыг үзүүл. Дараах асуултуудыг асуу (зурагт хуудсан дээр хариулт байгаа)

- Үхэшгүй амьдралыг авахын тулд та нар юу хийх ёстой вэ?
- Хэн үхэшгүй амьдралыг авах вэ?
- Энэ бэлгийг хэн боломжтой болгож өгсөн бэ?
- Энэ бэлгийг хэрхэн боломжтой болгосон бэ?

Олон хүмүүс ямар нэг өөр зүйл байдгийг мэддэггүй учраас зөвхөн үхэшгүй амьдралыг эрж олох хүсэлтэй байдаг. Өргөмжлөлийн тодорхойлолттой зурагт хуудсыг үзүүл. Үхэшгүй амьдрал ба өргөмжлөл хоёр хоёулаа Тэнгэрлэг Эцэгийн бэлэг юм.

- Өргөмжлөл үхэшгүй амьдралаас ямар ялгаатай вэ?
- Өргөмжлөлийг олж авахын тулд та нар юу хийх хэрэгтэй вэ?

Үхэшгүй амьдралд тавигдах шаардлагыг өргөмжлөлд тавигдах шаардлагатай харьцуул.

Судар ба ярилцлага

Сургаал ба Гэрээ 14:7-д өргөмжлөл ба мөнхийн амьдралын (заримдаа ингэж хэлэгддэг) үнэ цэнийг бидэнд хэлж өгдөг гэж тайлбарла. Залуу эрэгтэйчүүдээр судрыг тэмдэглүүл.

- Энэ сударт бид өргөмжлөлийг олж авахын тулд юу хийх хэрэгтэй гэдэг вэ?

Ярилцлагын энэ хэсэгт “Миний зарлигуудыг сахь” гэсэн судрын хэсгийг онцолж хэл.

Өргөмжлөл нь Ёслолууд ба Гэрээнүүдийг Шаарддаг

Ярилцлага

Тэнгэрлэг Эцэг биднээс зарлигуудыг нь хэрхэн сахихыг хүсдгийг ойлгохын тулд *ёслол* ба *гэрээ* гэсэн хоёр үгийн утгыг бид мэдэх хэрэгтэй.

- Ёслол гэж юу вэ? (Дотоод итгэл болон шийдвэрийг усан баталгаа мэтийн гаднах үйлдлээр билэгддэг.)
- Гэрээ гэж юу вэ? (Бурхан хүн хоёрын хоорондох амлалт бөгөөд хүн зарим зүйлийг хийхээр амлаж, Бурхан тодорхой үр шимийг амладаг.)

Ишлэл, самбар
ба ярилцлага

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл бид бүгдийн эрт дээр үед хийсэн нэг гэрээг тайлбарлаж өгсөн. Залуу эрэгтэйчүүд хэзээ амлалт өгч, Тэнгэрлэг Эцэгтээ юу амласныг тэдэнд сонсго:

“Бид энэ мөнх бус амьдралд ирэхээсээ өмнө тэнгэрт тангараг, няцашгүй тангараг тавьсан. . . .

“Бид гэрээнүүд хийсэн. Бид энэ дэлхий дээр өөрсдийнхөө байдлыг хүлээн авахаасаа өмнө тэдгээрийг хийсэн. . . .

“Бид Тэнгэрлэг Эцэгт хэрэв тэр биднийг энэ дэлхийд илгээж, бие махбодийг өгч, энэ дэлхийд амьдрах үнэлж баршгүй их боломжийг өгвөл бид амьдралаа цэврээр хадгалж, ариун сүмд гэрлэж, гэр бүлээ өсгөж, тэдэндээ зөв шударгыг заана гэж амласан. Энэ бол няцашгүй тангараг, няцашгүй амлалт байсан” (“Be Ye Therefore Perfect” [devotional address, Salt Lake Institute of Religion, 10 Jan. 1975], p. 2).

- Ерөнхийлөгч Кимболлын ярьсан энэ гэрээг та нар хэзээ хийсэн бэ?
- Тэнгэр дэх Эцэгтээ та нар юу амласан бэ?

Мөнх бус байдлын өмнөх амьдралыг дүрсэлсэн дугуйны доор хариултуудыг бич (Энэ бүлгийн төгсгөл дэх самбарын үзүүлэнг үз.)

Ахлагч Ховард В.Хантер өргөмжлөлийг хүлээн авахын тулд мэдэж, мөн биелүүлэх хэрэгтэй зарим зүйлийн талаар тайлбарлахдаа: “Өргөмжлөлд хүрэх зам маш сайн тогтоогдсон юм. Бидэнд Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлтэй байх ба түүний заасан зүйлд таарахгүй зүйлүүдийг наманчлах хэрэгтэй гэж хэлсэн. Энэ оюун санааны өөрчлөлтийн дараа, бөх бат шийдвэртэй байдлаар бид Их Эзэнтэй гэрээ хийж түүний зарлигуудыг сахихаар усан баталгааны ус уруу орохыг хатуу шийдсэнээ тунхаглан мэдэгдэх ёстой” (Conference Report, Oct. 1960, p. 109).

• Ахлагч Хантерын хэлснээр өргөмжлөлийг авахын тулд бид юу хийх ёстой вэ?

“Дэлхийн амьдралыг” төлөөлж буй тойргийн доор тэдний хариултыг жагсаа (самбарын үзүүлэнгийн загварыг үз).

Залуу эрэгтэйчүүд усан баталгаа хийлгэхдээ ийнхүү гэрээ хийдэг:

1. Бусдын ачааг үүрэлцэх

2. Бурханы гэрчлэгч байх

3. Зарлигуудыг сахих

(Мозая 18:8–10-ыг үз)

Хэрэв бид гэрээнүүдээ сахвал Тэнгэрлэг Эцэг Сүнсээ өгнө гэж амласныг тайлбарла.

• Усан баталгааны гэрээгээ та нар хэрхэн шинэчлэх вэ? (Зохистойгоор ариун ёслолоос хүртэн)

• Та нарыг усан баталгааны гэрээгээ сахихад туслахын тулд Тэнгэрлэг Эцэг та нарт юу өгсөн бэ? (Ариун Сүнсний бэлэг)

• Ариун Сүнс та нарыг өргөмжлөгдөхөд хэрхэн туслах вэ? (Та нарыг зөвийг хийхэд өдөөж, бүх үнэнийг зааж, Бурхан Есүс Христийг мэдэхэд тусалж, нүгэл үйлдэх хүсэлгүй болгож, та нарын зүрх сэтгэлийг өөрчилнө [Мозая 5:2-ыг үз]).

Залуу эрэгтэйчүүдээр Сургаал ба Гэрээ 76:56–57-г уншуул.

• Өргөмжлөлийг авахын тулд залуу эрэгтэйчүүд өөр юу хийх ёстой вэ? (Мелкизэдэк Пристийн Зэргийг хүртэж дээдлэх)

Өргөмжлөлд хэрэгтэй өөр нэг ёслол бол ариун сүмд хүлээн авдаг индаумент гэдгийг тайлбарла. Индаумент нь хүнийг Бурханы хаант улсад дэвшихэд нь тусалдаг онцгой сүнслэг адислал юм. Индаументийг хүлээн авахдаа бид усан баталгаа хийлгэхтэй адил гэрээнүүдийг хийдэг.

Ишлэл

Залуу эрэгтэйчүүдэд ариун сүмд индаументийг хүлээн авахдаа хийдэг амлалтуудыг сонсго.

Бид Их Эзэнд хуулийг шулуун ба ариун журамтайгаар, ариун явдалтайгаар, нигүүлсэнгүйгээр, нинжин сэтгэлээр, хүлцэнгүй тэвчээртэйгээр, цэвэр ариунаар, сахиж; үнэнийг түгээхэд авьяас чадвар эд материалаа зориулж; Их Эзэн Есүс Христ Хаанаа энэ дэлхий хүлээн авах энэ агуу бэлтгэлд бүх боломжтой замаар тусална гэж амладаг” (James E. Talmage, *The house of the Lord*, p. 84).

• Та нар индаумент хүлээн авахдаа юу амладаг вэ?

Дээрх ишлэлийг хар. Үүнийг самбарт нэмж бич.

• Үнэнийг түгээхэд авьяас чадвар эд материалаа зориулна гэж юу гэсэн үг вэ?

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэй бүх ёслолуудыг хүлээн авч бүх гэрээнүүдийг хийсэн ч түүнд өргөмжлөлийг амладаггүй. Залуу эрэгтэй өөр юу юу хийх ёстойг мэдэхийн тулд залуу эрэгтэйчүүдийн нэгээр Сургаал ба Гэрээ 14:7-г дахин чангаар уншуул.


• Шаардлагатай ёслолуудыг хүлээн авч шаардлагатай гэрээнүүдийг хийснийхээ дараа зарлигуудыг сахиж эхлээд та нар юу хийх ёстой вэ? (Эцсээ хүртэл тэвчих.)

Эцсээ хүртэл тэвчихдээ өөр олон чухал зарлигуудыг бид сахих ёстой гэдгийг тайлбарла.

• Эдгээр нь ямар ямар зарлигууд вэ?

“Дэлхийн амьдрал” гэсэн гарчгийн доор зай үлдвэл хариултуудыг самбарт жагсааж бич. Байж болох зарим хариултанд Гэр бүлийн түүх, аравны нэг, Мэргэн Ухааны Үг, зөв шударга байдал зэрэг орно.

Дүүрсэн самбар ингэж харагдана:



Өргөмжлөл нь Хайрт Тэнгэрлэг Эцэгтээ Дуулгавартай Байснаар Ирнэ

Судар ба ярилцлага

Өргөмжлөлд шаардагдах жагсаалтыг залуу эрэгтэйчүүдээс харахыг хүс.

- Та нар энэ бүгдийг хийж Эцсээ хүртэл тэвчих нь яагаад хэрэгтэй вэ?

Сургаал ба Гэрээ 132:20–24-т дуулгавартай байснаар ирэх зарим адислалыг тайлбарласан. Нэг залуу эрэгтэйгээр судрыг чангаар уншуул.

- Өргөмжлөгдөхүйц зөв зохистой амьдарч байгаа хүмүүсийг ямар ямар адислалууд хүлээж байдаг вэ? (Бурханлаг болно, тэдэнд бүх юм хамааралтай болно, Бурхантай хамт амьдарч, мөнхийн гэр бүлтэй болно.)

- Та нар зарлигуудыг сахиснаар хэрхэн адислагдсан бэ?

Эцэгт нь байгаа бүхэн Есүс Христэд амлагдсантай адил бид ч мөн бүх хүч чадал, эрх мэдлийг хүлээн авч, өөр сүнснүүд ба дэлхийнүүдийг бүтээгчид болж чадна гэдгийг тайлбарла.

Судар ба ярилцлага

Нэг залуу эрэгтэйгээр 1 Коринт 2:9-ийг уншуул.

- Их Эзэнийг хайрладаг ба түүний зарлигуудыг сахисан хүмүүст бэлтгэгдсэн зүйлсийн талаар эдгээр шүлгүүд юу хэлдэг бэ? (Тэдгээрийн ямар сүр жавхлантайг нь бид төсөөлж ч чадахгүй)

Дүгнэлт

Гэрчлэл

Өргөмжлөл бол хүлээн авахыг хүсдэг хүмүүсийн хувьд гайхамшигт бэлэг, адислал ба хэн бүрийн төсөөлж чадахаас ч хамаагүй илүү гэдгийг гэрчил.

Хэрэв тэд чин сэтгэлээсээ зарлигуудыг сахиж, гэрээгээ мөрдөж, бусад хүмүүст хайртай байвал хайрт Тэнгэрлэг Эцэгийн хамгийн дээд бэлэг болох өргөмжлөлд хүрч чадна гэдгийг залуу эрэгтэйчүүдэд баталж хэл.

Уриалга

Энэ хичээлийг залуу эрэгтэйчүүдийн оюун санаанд батжуулахын тулд дараагийн удаа ариун ёслолоос хүртэхдээ оюун санаандаа санаж, төрсөн сэтгэгдлийг тэмдэглэлдээ бичихийг тэдэнд уриал.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр аравны нэг ба өргөлүүдийг төлснөөр Бурханы хаант улсын өсөлтөнд хэрхэн хувь нэмэр оруулж чадахаа болон сүнслэг болон эд материалын адислалуудыг хэрхэн хүлээн авч чадахаа ойлгох болно.

БЭЛТГЭЛ

Шаардагдах материалууд:

1. Залуу эрэгтэй бүрт судар
2. Судар тэмдэглэх харандаанууд
3. Аравны нэгийн дугтуй ба хандивын хуудас

ТАЙЛБАР

Аароны пристийн зэрэгтнүүд зарим үед мөнгөөрөө юу хийх вэ гэсэн чухал шийдвэртэй тулгардаг. Их Эзэний асуусныг өгөх тэдний хүслийг нь баталгаажуул. Хэрэв тэд үүнийг хийвэл Их Эзэн тэднийг адислах болно.

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

Түүх ба ярилцлага

Оршил

Ерөнхий чуулган дээр Ахлагч Боид К.Пакер Дараах түүхийг ярьсан:

“Хэдэн жилийн өмнө би номлолуудынхаа нэгэнд очсон юм. Хоёр номлогч нэг сайхан айлд зааж байсан ба тэд усан баталгаа хийлгэх хүсэлтэйгээ илэрхийлсэн ч гэнэт больжээ. Гэрийн эзэн аравны нэгийн тухай мэдсэнийхээ дараа номлогч нартай уулзах дараагийн бүх уулзалтуудаа зогсоожээ. . . .

“Уруу царайлсан хоёр ахлагч салбарын ерөнхийлөгчдөө энэ тухай илтгэжээ. Салбарын ерөнхийлөгч нь өөрөө шинэхэн гишүүн байсан ба тэрээр салбартаа ийм сайхан гэр бүлийг хамруулаагүй байв.

“Хэдэн хоногийн дараа салбарын ерөнхийлөгч тэдгээр ахлагч нарыг дагуулаад тэр гэр бүлтэй дахин очиж уулзахыг ятгав.

““Таныг Сүмд элсэн орохоо болихоор шийдсэн гэж би ойлгосон” гэж тэрээр гэрийн эзэнд хэлэв.

““Тийм ээ, үнэн” гэж тэр хариуллаа.

“Ахлагч нар надад хэлэхдээ, таны санааг аравны нэг зовоож байгаа гэж хэлсэн.”

“Тийм ээ, тэд бидэнд үүний тухай хэлээгүй. Тэгээд би үүний тухай суралцсаныхаа дараа “Одоо энэ чинь дэндүү их хүсэлт байна. Манай сүм үүн шиг зүйл хэзээ ч хүсэж байгаагүй,” гэж хэлсэн. Энэ бол арай хэтэрхий их байна, бид Сүмд орохгүй гэж бодож байна” гэв.

“Тэд та нарт мацгийн өргөлийн тухай хэлсэн үү?” гэж тэр асуув.

“Үгүй, тэр чинь юу юм бэ?” гэж тэр хүн хэллээ.

“Сүмд, бид сар болгон хоёр хоолноосоо татгалзан мацаг барьж, тэр хоолныхоо үнэ, мөнгийг ядуучуудад туслахын тулд өгдөг юм.”

“Тэд бидэнд үүний тухай хэлээгүй” гэж нөгөө хүн хариуллаа.

“Тэд та нарт халамжийн хөтөлбөрийн тухай тайлбарласан уу?”

Үгүй, тэр чинь юу вэ? гэж тэр асуулаа.

“Бид бие биендээ туслах хэрэгтэй гэдэгт итгэдэг. Хэрэв хэн нэгэнд тусламж хэрэгтэй бол эсвэл өвчтэй, ажлаасаа гарсан, ямар нэг асуудалтай тулгарсан бол

бид тэдэнд зохион байгуулалттайгаар тусалдаг ба та ч гэсэн тэр тусламжинд найдаж болно. . . .’

“Тэд мөн бидэнд мэргэжлийн лам хуврагууд байхгүй гэж танд хэлсэн үү? Бид бүгдээрээ өөрсдийн цаг, авьяас, хөрөнгө мөнгө болон үйл ажиллагаагаараа энэ ажилд туслахаар хувь нэмэр оруулдаг юм. Тэгээд бид үүнийхээ төлөө хөлс авдаггүй.

“Тэд нар энэ бүгдийн талаар бидэнд юу ч хэлээгүй гэж аав нь хэлэв.

“‘Хэрэв та аравны нэг болох өчүүхэн жижиг зүйлээс болж сүмээс буруулж байгаа бол та нар энэ Сүмд ороход бэлэн биш гэдэг нь тодорхой байна. Магадгүй та зөв шийдвэр гаргаж, сүмд нэгдэхгүй байх’ хэмээн салбарын ерөнхийлөгч хэлэв.

“Явахынхаа өмнө тэрээр эргэж хараад, ‘Хүмүүс яагаад эдгээр зүйлүүдийг хүслээрээ хийдэг тухай та урьд өмнө нь бодож байсан уу? Аравны нэгийн тооцооны хуудсыг хэзээ ч хүлээн авч байгаагүй. Үүнийг цуглуулах үүрэгт хэнийг дуудаж байгаагүй. Бид аравны нэгээ төлж бусад бүх зүйлүүдийг хийхдээ үүнийгээ агуу их эрх дарх гэж тооцдог.’

“‘Хэрэв та яагаад гэдгийг нь олж мэдэж чадвал агуу их үнэт сувданд хүрэх болно. Энэ нь юу хэмээвээс, Их Эзэн худалдаачин эрд үүнийг олж авахын тулд өөрт буй бүгдийг зар хэмээн хэлсэн тэр агуу их үнэт сувд юм.’

“Гэвч энэ нь таны сонголт. Би зөвхөн, таныг үүний тухай залбирах байх гэж найдаж байна’ гэж салбарын ерөнхийлөгч хэллээ.

“Хэд хоногийн дараа тэр хүн салбарын ерөнхийлөгчийн гэрт ирэв. Тэр номлогч нартай дахин цаг тохирохыг хүссэнгүй. Тэр нь шаардлагагүй байв. Тэр гэр бүлийнхээ усан баталгааны өдрийг товлохыг хүсжээ. Тэд залбирсаар, хүчтэй залбирсаар байлаа.” (Conference Report, Oct. 1974, pp. 126-27; or Ensign, Nov. 1974, pp 88.)

- Тэр гэр бүлийг Сүмд орохгүй гэсэн шийдвэрээ өөрчлөхөд юу нөлөөлсөн бэ?
- Зарим хүмүүс хэлэхдээ аравны нэгийг төлөхөд мөнгө биш итгэл шаарддаг гэж хэлдэг. Та нар үүнтэй санал нэг байна уу, үгүй юу? Яагаад?

Бид Аравны Нэг Болон Хандивуудаа Төлж Сурах Ёстой

Судар ба ярилцлага

Сургаал ба Гэрээ 119:3–4-ийг залуу эрэгтэйчүүдээр уншуул. Энэ судрыг тэмдэглэхийг зөвлө.

- Аравны нэг гэж юу вэ? (Жилийн ашгийн аравны нэг)
- Өргөлүүд гэж юу вэ? (Хэрэгцээний дагуу Сүмд хэрэглэгдэх мацаг барилт зэрэг аравны нэгээс их, бага хэмжээгээр өгдөг мөнгө.)
- Та нар бага залуугаасаа эхлэн аравны нэг ба өргөлүүдээ төлж эхэлбэл ашигтай тал нь юу байдаг вэ? (Аравны нэг ба өргөлүүдээ төлөх нь хэвшил болох ба зарлигуудыг сахихад амар болно.)

Түүх

Дараах түүх нь Ерөнхийлөгч Дэвид О.МакКэй хүүхэд байхдаа аравны нэгээ шударгаар төлөхийн чухлыг хэрхэн сурсан тухай харуулдгийг тайлбарла. Ерөнхийлөгч МакКэй хүүхэд ахуй цагт ихэнх хүмүүс мөнгөгүй байсан учраас тэд аравны нэгээ өөр зүйлээр төлдөг буюу тэд бишоптоо амьтан юмуу бүтээгдэхүүн өгдөг байжээ.

“Аравны нэгийг эд зүйлээр төлдөг байсан тэр цагт би төрсөн эцгийнхээ түүний өвсний талбайд хоёр хүүдээ өгсөн сургаалд нь үргэлж баярлаж байдаг. Бид талбай дээгүүр явж арав дахь баглаа өвсөө цуглуулахаар ес дэх баглаагаа авсан тэр нугын тачирхан, хатсан өвснүүдийг авах гэж байв. Биднийг өвсөө баглаж эхэлтэл аав маань дуудаад, ‘Үгүй дээ хөвгүүд минь өндөр газар оч,’ гэв. Тэнд өндөр өвс ургасан байв. Гэвч нэг хүү нь эргэж хараад (тэр нь би байв), ‘дайралдсаныг нь л авья,’ гэж хэлэв.

“‘Үгүй ээ Дэвид, тэр чинь арав дахь баглаа, Бурханд бид хамгийн сайнаа өгнө,’ гэв.

“Тэр бол миний амьдралдаа аравны нэгийн талаар сонссон хамгийн нөлөө бүхий сургаал байсан юм” (*Cherished Experiences in the Writhings of President David O. Mc Kay*, comp. Clare Middlemiss [Salt Lake City: Deseret Book Co., 1955], pp. 19-20).

Ярилцлага	Ерөнхийлөгч МакКэйн аав түүнд юу сургасан бэ? (Бид Тэнгэр дэх Эцгээ хайрлахдаа Түүнд хамгийн сайнаа өгөхийг хүсдэг.) <ul style="list-style-type: none"> • Бид аравны нэгээ төлөхдөө энэ зарчмыг хэрхэн ашиглаж чадах вэ? (Бид хэрэгцээгээ хангасны дараа сарын эцэст үлдсэн мөнгөө төлөх бус, мөн хүлээлгэлгүйгээр хамгийн түрүүнд аравныхаа нэгийг төлөх ёстой.)
Үйл ажиллагаа	Залуу эрэгтэйчүүдэд хандивын дугтуй ба хуудсыг үзүүл. Залуу эрэгтэйчүүдээс хандивын хуудсыг хэрхэн зөв бөглөхийг тайлбарлахыг хүс. Хандивын хуудсыг бүрэн, алдаагүй бөглөх ба тэр бүрдээ өөрсдийнхөө нэрийг ижилхэн бичихийн чухлыг онцлон хэл.
Ишлэл	“Хүн бүр аравны нэгээ хэрхэн бүрэн төлж сурах нь боломжтой юм. . . . Аравны нэгээ бүрэн төлж сурсан тэр хүн аз жаргалтай хүн” (Harold B. Lee, <i>Cram for life's Finest Examination</i> , Brigham Young University Speeches of the Year [provo, 5 Jan. 1954], p 6).

Шударга Аравны Нэгийн Төлбөр Сүмийг Дэмжихэд Тусалдаг

Гэрчлэл	Аравны нэгийн тухай ба Сүмийн хөгжил, өсөлтийг дэмжих онцгой эрхийн талаар өөрийн гэрчлэлийг хуваалц. Сүмд аравны нэг ба өргөлүүдийг маш олон зорилгоор ашигладаг.
Ярилцлага	Залуу эрэгтэйчүүдээс аравны нэгийг юу юунд ашигладгийг асуу. Байж болох хариултууд: <ol style="list-style-type: none"> 1. Номлолын ажлаар дамжуулан сайн мэдээг түгээхэд. 2. Ариун сүм, шүтээний байр болон бусад барилга байгууламжуудыг барих ба засахад. 3. Сүмийн сургууль, семинар, институтын үйл ажиллагаа явуулахад. 4. Хичээлийн материалуудыг хувилж, тараахад. 5. Гэр бүлийн түүх ба ариун сүмийн ажлыг санхүүжүүлэхэд. <p>Сүм аравны нэгийн сангийн талаар хатуу журамтай гэдгийг залуу эрэгтэйчүүд ойлгоход туслах нь чухал. Ерөнхий эрх мэдлээс аравны нэгийн талаар их залбирч, төлөвлөж, бодсоны дараа нарийн зарцуулдаг. Сүм аравны нэгийг өсөж, өргөжихдөө зориулан хэрэглэдэг. Сайн мэдээг дэлхий даяар түгээснээр ирэх адислалууд бид бүгдэд хэрэгтэй.</p>

Аравны Нэгийн болон Өргөлүүдийн Шударга Төлөлт нь Адислалуудыг Авчирдаг

Судар ба ярилцлага	Залуу эрэгтэйчүүдээр Малахи 3:10-ыг уншуулж, судраа тэмдэглэхийг зөвлө. <ul style="list-style-type: none"> • Ашгийнхаа аравны нэгийг Түүнд эргүүлж өгсөн хүмүүст Их Эзэн юу амласан бэ? (Тэр тэнгэрийн цонхыг нээж тэдний дээрээс агуу адислалуудыг асгах болно.)
Ишлэл	Таныг Ахлагч Жоон А.Видцөүгийн аравны нэг ба өргөлүүдийг төлснөөр ирэх адислалуудын тухай дараах мэдэгдлийг уншихад залуу эрэгтэйчүүдээс сонсохыг хүс. <p>“Аравны нэгээ төлөгч Их Эзэнтэй чин сэтгэлийн холбоо үүсгэдэг. Энэ бол хамгийн сайхан шагнал юм. Бусад хуулиудын адил аравны нэгийн хуулийг дуулгавартай сахих нь гүн гүнзгий, дотоод сэтгэлийн баяр баясгалан, өөр ямар ч замаар олж авч чадахгүй ойлголт ба сэтгэл ханамжийг өгдөг. Хүн хэдий даруу ч гэсэн, хүн төрөлхтний авралд зориулсан асар их, мөнхийн хөтөлбөрт Их Эзэнтэй жинхэнэ хамтрагч болдог. Үнэний зарчим оюун ухаанд тодорч, түүгээр амьдрах нь илүү амархан биелэгдэнэ. Шинэ ойртолт хүн болон түүнийг Бүтээгчийн хооронд үүссэн. Залбирал амархан болно. Эргэлзээ үгүй болж, итгэл нэмэгдэж, зүрх сэтгэлд эргэлзээгүй байдал ба зориг хөвөн ирнэ. Сүнслэг мэдрэхүй хурц болж, мөнхийн дуу хоолой илүү тод сонсогдоно. Хүн Тэнгэр дэх Эцэгтэйгээ илүү адил болно” (in Church Section, <i>Deseret News</i>, 16 May 1936, p. 5).</p>

Самбарын
хураангуйлал

Ахлагч Видцөүгийн хэлсэн дараах адислалуудыг самбарт жагсааж бич:

АРАВНЫ НЭГИЙГ ТӨЛСНӨӨР
ИРЭХ АДИСЛАЛУУД

Их Эзэнтэй холбоо тогтооно
Дотоод баяр баясгалан
Их Эзэнтэй түнш болно
Үнэнийг гүнзгий ойлгоно
Залбирал илүү амархан болно
Итгэл өснө
Залбирлууддаа хариулт авна
Бурханлаг зан чанарыг олж авна

Ярилцлага

- Аравны нэг ба өргөлүүдийг төлөх нь Бурхан ба бидний хоорондох харьцааг яагаад хүчтэй болгодог гэж та нар бодож байна?
- Аравны нэг ба өргөлүүдээ төлөх нь бидний итгэлийг хэрхэн өсгөх вэ?
- Аравны нэгээ төлснөөр та нар хэрхэн адислагдсан бэ?

Ишлэл

Ахлагч Мэфью Коули аравны нэг төлснөөр ирэх адислалууд ба Их Эзэнтэй түнш байх тухай ярьсныг тайлбарла:

“[Бурхан] бол маш гайхамшигтай түнш тийм биз дээ? Тэр маш гайхамшигтай. Би амьдралдаа түүн шиг хамтрагчтай байхыг ямар их хүсэж байна аа. Бизнес би түүнтэй адил, над дээр ирж ингэж хэлэх түнштэй болохыг хүсдэг, ‘Хөө би бизнес эхлэх бүх мөнгөө оруулчихлаа. Би бүх адислалуудаар хангана. Тэгээд та нар бизнесээ авч яв. Намайг битгий мартаарай. Ашиг олохоороо та нар ерэн хувийг аваад надад арван хувийг нь өгөөрэй. та нар ерэн хувиа өөрийнхөө хүссэнээр зарцуулж болно. Харин би арван хувиа буцаагаад бизнестээ оруулна.’ Үнэхээр тийм бол мөн сайхан аа? Энэ Сүмд үнэхээр тийм түнш бидэнд байгаа. Бид ерэн хувиа өөртөө авч, хүссэнээрээ заримдаа өөрсдийнхөө сүйрэлд зарцуулдаг. Бид түүнд арван хувиа өгч түүгээр энд ч ариун сүм, тэнд ч табэрнекл босдог. Тэр мөнгөө буцаагаад бизнес рүүгээ, өөрийнхөө бизнес рүү зориулдаг. Ах эгч дүү нар аа, хэрэв та нар сайн мэдээний зарчмуудыг дуулгавартай дагавал Бурхан энэ Сүмийг санхүүжүүлдэг юм” (*Matthew Cowley Speaks* [Salt Lake City: Deseret Book Co., 1954], pp. 76-77).

Ишлэл

Залуу эрэгтэйчүүдийг Ахлагч Хибэр Ж.Грантын хэлсэн үгийг сонсоод, дараа нь үүнийг өөрийнхөө үгээр ярихад бэлтгэхийг хүс. “Би эрэгтэй эмэгтэй хүмүүс Бурхантай чин шударга байж, аравны нэгээ төлснөөр мэргэн ухааныг хүлээн авч үлдсэн аравны есөн хувиа ашиглах боломжтой болж тэдэнд энэ нь илүү их ач холбогдолтой болж, үүгээрээ тэд Их Эзэнд шударга бус байхаасаа илүү ихийг хийж гүйцэтгэдэг хэмээн гэрчилж, гэрчилж байгаагаа үнэн гэдгийг би мэднэ” (in Conference Report, Apr. 1912, p. 30).

Залуу эрэгтэйчүүдэд энэ мэдэгдлийн талаарх сэтгэгдлээ өөрийн үгээр хэлэх боломж олго.

Дүгнэлт

Гэрчлэл

Аравны нэг төлөхийн чухал болон аравны нэг төлснөөр та нарт ирсэн адислалуудын талаар гэрчил.

Уриалга

Залуу эрэгтэйчүүдэд аравны нэг бүрэн төлөх ба бусад өргөлүүдээ төлөх талаар бишоп буюу салбарынхаа ерөнхийлөгчтэй ярилцахыг уриал.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр патриархын адислалын үнэ цэнэ болон үүнийг авахад бэлтгэх тухай ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Залуу эрэгтэй бүрт цаас ба харандаа
2. Патриархын адислал авсан Залуу эрэгтэйг адислал авахдаа хэрхэн бэлтгэсэн талаар яриулахаар томилж болно. Хэрэв Залуу эрэгтэйчүүдийн хэн нь ч патриархын адислал аваагүй бол та өөрөө хэрхэн авсан тухайгаа ярихаар бэлтгэ.

ТАЙЛБАР

Патриархын адислал бол маш хувийн ба нандин зүйл юм. Хүн патриархын адислалыг зөвхөн ганц удаа авах учраас энэ нандин тохиолдлыг залуу эрэгтэйчүүд энэ амлалтын дагуу амьдрахад бэлэн болсон гэж бодсон ба үүнийг авахыг хүссэн үедээ авах ёстой. Зарим залуу эрэгтэйчүүд патриархын адислалаа авчихсан байж болно. Хэдий тийм ч зарим нь үүнийг авах насанд хүрсэн, бусад нь хүрч амжаагүй байж болно. Залуу эрэгтэйчүүдийг яг одоо ав гэж шахах хэрэггүй ба тэдний патриархын адислал авах хүслийг нь дэмж.

Патриархын адислал нь хувийн шинж чанартай учраас өөрийнхөө патриархын адислалыг залуу эрэгтэйчүүдэд уншиж өгөх ба нарийвчлан ярилцах хэрэггүй. Хэдий тийм ч энэ хичээлийг заахад зориулж өөрийн патриархын адислалаа судал.

Бишопын зөвлөлийн зөвшөөрөлтэйгээр та патриархыг патриархын адислалын талаар тав арван минут яриулахаар урьж болно. Тэр патриархын адислалуудыг ерөнхийд нь эсвэл дуудлагаа хэрхэн гүйцэтгэж байгаа талаар ярьж болох юм.

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

Ярилцлага

Оршил

- Хэзээ нэг цагт та нар Их Эзэн амьдралд чинь чиглэл өгөхийг хүсэж байсан уу?
- Бидний амьдралд Их Эзэн хэрхэн хувийн илчлэлт өгдөг вэ? (Судруудаар, залбирлаар, Ариун Сүнсээр, эцэг эхээр, Сүмийн удирдагч нараар ба патриархын адислалаар.)

Бид Бурханы хүүхдүүд гэдгийг тайлбарла. Биднийг тэнгэр дэх гэрээ орхиод энэ дэлхийд ирэхэд Тэнгэрлэг Эцэг биднийг мартаагүй. Харин ч тэр биднийг гэртээ, түүнд буцаж ирэхийн тулд адислаж, чиглүүлэхийг хүсэж байдаг. Бурхан өөрийн дуудсан патриархуудаараа дамжуулан бидний энэ амьдралын заавар болон амар амгаланд зориулсан хувийн илчлэлт өгдөг. Энэ илчлэлтийг патриархын адислал гэдэг.

Патриархын Адислал бол Тэнгэрлэг Эцгээс Ирсэн Хувийн Илчлэлт

Асуулт Хариулт

Залуу эрэгтэй бүрт цаас харандаа өгөөд тэдний патриархын адислалын талаар хэр их мэддэгийг нь тодорхойлохоор дараах асуултуудыг өг. Тэднээр нэгээс арван хоёр хүртэл дугаарлуулаад таныг мэдэгдэл бүрийг унших хооронд *үнэн юмуу худал* гэж тэмдэглүүл.

1. Патриархын Адислалын нэг зорилго бол Их Эзэн чамаас юу хүсэж байгааг хэлдэг. (Үнэн.)
2. Амьдралдаа зөвхөн ганцхан удаа патриархын адислал авна. (Үнэн).
3. Патриархын адислал та нарын удам угсааг тодорхойлдог. (Үнэн).
4. Патриархын адислал ба эцгийн адислалын хоорондох ялгаа бол зөвхөн хоёр өөр хүн өгч байгаад юм. (Худал).
5. Патриарх та нарыг биечлэн таньдаггүй л бол та нарт адислалыг нарийн хэлж өгч чадахгүй. (Худал).
6. Патриархын адислал авахын тулд та нар наанадаж арван есөн настай байх ёстой. (Худал, гэвч та нар номлолын талбарт орохоосоо өмнө авах ёстой).
7. Та нар патриархын адислал авахын тулд бишопоос зөвшөөрөл авах ёстой. (Үнэн.)
8. Мацаг барилт патриархын адислал авах бэлтгэлд чинь тусалж чадна. (Үнэн.)
9. Хэрэв найзууд чинь хүсвэл та нарын патриархын адислалыг чинь унших боломжтой байх ёстой. (Худал.)
10. Патриархын адислалаа ойр ойрхон уншиж байх нь амьдралдаа тавьсан зорилгодоо хүрэх, илүү сайхнаар амьдрахад чинь та нарыг урамшуулж чадна (Үнэн.)
11. Та нар патриархын адислал чинь хэрхэн биелэхийг үргэлж хэлэх ёсгүй. (Үнэн.)
12. Та нарын патриархын адислал та нарын юу хийж байгаагаас үл хамааран ирэх болно. (Худал.)

Ярилцлага

Асуулт хариултын дараа мэдэгдлүүдээ дахин уншаад залуу эрэгтэйчүүдийн хариултуудыг ярилц. Дараах материал нь асуулт бүрт танд хариулахад тусална. Та бүх материалуудыг ашиглах шаардлагагүй. Мөн та энэ материалуудын заримыг нь залуу эрэгтэйчүүдээр уншуулж болно.

1. Патриархын Адислалын нэг зорилго бол Их Эзэн чамаас юу хүсэж байгааг хэлдэг (Үнэн.)

Ишлэл

Ахлагч Лигранд Ричардс хэлэхдээ: “Хэрэв бид хаанаас ирсэн, яагаад энд байгаа, бид хаашаа явж байгаагаа ойлгох юм бол хүссэн зорилгодоо хүрч болно. Тэр бол бид яагаад энд байгаа болон биднээс юу хүсэж байгааг Бүхнийг Чадагчийн илчлэлтээр бидэнд тайлбарлаж, илчлэх патриархын адислалын жинхэнэ зорилго юм” (*Patriarchal Blessing*, *New Era*, Feb. 1977, p. 4).

Патриархын адислал нь бидэнд зөвхөн адислал амладаггүй, бас бидний авьяас ба чадамжийг тодорхойлдог бөгөөд бидэнд бишопын зөвлөгөө, анхааруулга, чигийг өгдөг гэдгийг тайлбарла.

2. Амьдралдаа зөвхөн ганцхан удаа патриархын адислал авна (Үнэн).

Ишлэл

1947 онд Тэргүүн Зөвлөл бүх гадасны ерөнхийлөгчдөд: “Ийм бүх адислалыг бичсэн байх ёстой ба ерөнхийдөө хүн бүрийн амьдралд энэ ганц адислал нь хангалттай юм” гэж бичжээ (in Bruce R. McConkie, *Mormon Doctrine*, 2nd ed. [Salt Lake City: Bookcraft, 1966], p. 558).

3. Патриархын адислал та нарын удам угсааг тодорхойлдог. (Үнэн.)

Ишлэл, судар, ярилцлага

Удам гэдэг нь “ерөнхий нэг өвөг дээдсээс доош буусан жагсаалт” гэсэн утгатай юм (Daniel H. Ludlow, “The House of Israel,” *Ensign*, Jan. 1991, p. 52).

Абрахам 2:9–10-ыг уншаад ярилц. Хэрэв бид Сүмийн гишүүдийн хувьд зөв зохистой амьдарвал бид сайн мэдээний бүх адислалуудыг хүлээн авах эрхтэй гэдгийг тайлбарла. Зөвхөн Абрахамын шууд удмынхан л төрөхөөсөө энэ эрхийг хүлээн авдаг. Хэдий тийм ч зарим Сүмийн гишүүдийг Абрахамын шууд үр удам биш ч гэсэн үнэний сайн мэдээг зөвшөөрсөн учраас Израилын овогт өргөж авдаг (Галат 3:26–29-ийг үз).

4. Патриархын адислал ба эцгийн адислалын хоорондох ялгаа бол зөвхөн хоёр өөр хүн өгч байгаад юм. (Худал.)

Ишлэл

Ерөнхийлөгч Иосеф Филдинг Смит бичихдээ: “Мелкизэдэк зэрэгтэй итгэлтэй эцэг өөрийн хүүхдүүдийг адислаж болох ба энэ нь (эцгийн) патриархын адислал болно. Ийм адислалыг гэр бүлийнхээ тэмдэглэлд бичиж болох ч Сүмийн архивт хадгалдаггүй. Пристийн зэрэгтэй үнэнч эцэг бүр гэрийнхээ патриарх юм. Үүнээс гадна хүүхдүүд томилогдсон патриархаас адислал авч болно. Хэрэв эцэг нь өөрийнхөө хүүхдийг адислаж байхдаа илчлэлт авах юм бол хүүхдийнхээ удмыг тодорхойлж болно” гэжээ (*Doctrines of Salvation*, comp. Bruce R. McConkie, 3 vols. [Salt Lake City: Bookcraft, 1954-56], 3:172).

Ихэвчлэн эцгүүд удам тодорхойлдоггүй ба хэдийгээр эцгүүд илчлэлт авснаар удмыг тодорхойлох эрхтэй ч томилогдсон патриарх үүнийг ихэвчлэн хийдэг гэдгийг тайлбарла. Мөн түүнчлэн зөвхөн томилогдсон патриархын өгсөн адислал Сүмд бичигддэг. Аароны зэрэгтэн бүр патриархын адислал авахдаа адислалынхаа өөрийн хувийг авдаг. Хэрэв тэр үүнийг гээвэл өөр хувийг Сүмийн Түүхийн Хэлтсээс авч болдог.

5. Патриарх та нарыг биечлэн таньдаггүй л бол та нарт адислалыг нарийн хэлж өгч чадахгүй (Худал.)

Түүх

Патриархын адислал патриархаас биш Их Эзэнээс ирдэг гэдгийг тайлбарла. Үүнийг Ахлагч Лигранд Ричардс тодруулж дараах түүхийг ярьсан юм.

“Саяхан би нэг патриархын очсон юм. Тэр нэг номлолоос ирсэн эмэгтэйд адислал өгсөн тухайгаа ярьсан юм. Олон зүйл хэлсний дотор тэр эмэгтэйд түүний өвөг дээдэс хожмын үед сайн мэдээг авчрахад агуу хувь нэмэр оруулсныг хэлжээ. Адислал өгсний дараа тэр эмэгтэй, ‘Би таныг энэ удаа алдаа хийлээ гэж бодож байна. Би Сүмд хөрвүүлэгдэгч, гэрээсээ би хамгийн түрүүнд Сүмд орсон,’ гэжээ.

“‘За за, би энэ талаар юу ч мэдэхгүй. Миний мэдэж байгаа бүх л зүйл бол би эдгээрийг танд хэлэхээр өдөөгдсөнөө л мэдэрсэн,’ гэж патриарх хэлжээ. Түүнийг энэ түүхийг надад ярьж байх үед нөгөө эмэгтэй дөнгөж ургийн номын санд суугаад түүний зарим хамаатнууд болох өвөө эмээ, элэнц хуланц нь дээр үед Сүм анх байгуулагдах үед агуу золиослол хийснийг мэдэж өөрийгөө эртний анхдагч нарын үр удам болохыг мэджээ. Патриарх үүнийг өөрөө мэдээгүй байлаа. Тэр Ариун Сүнсний илчлэлтээр ярьсан юм” (“Patriarhal Blessings,” p. 6).

6. Патриархын адислал авахын тулд та нар наанадаж арван есөн настай байх ёстой. (Худал, гэвч та нар номлолын талбарт орохоосоо өмнө авах ёстой.)

Ишлэл

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон залуу эрэгтэйчүүдэд тэд Аароны Пристийн Зэрэгт байхдаа патриархын адислалаа авахыг зөвлөсөн:

“Аароны Пристийн зэрэгтэн ах нар та нарыг би патриархын адислал авахыг зөвлөж байна. Үүнийг анхааралтай судал, үүнийгээ хувийнхаа судар гэж бод. Патриархын адислал бол патриархаар өгөхөөр өдөөгдсөн адислалууд, анхааруулга болон сануулгыг оролцуулан та нарын амьдралын үүргийн урам хайрласан бөгөөд бошигын мэдэгдэл юм. Залуу эрэгтэйчүүд ээ, патриархын адислалаа мацаг барилт ба залбирлын нөлөөн доор хүлээн авч та нарт зориулсан Бурханы хүслийг мэдэхийн тулд байнга үүнийгээ унш” (in Conference Refort, apr. 1986, p. 56; or *Ensign*, May 1986, pp. 43-44).

7. Патриархын адислал авахын тулд та нар бишопоос зөвшөөрөл авах ёстой. (Үнэн.)

Хэн нэгэн нь патриархын адислал авахад бэлэн боллоо гэж санасан үедээ бишоп юмуу салбарын ерөнхийлөгчтэйгээ ярих ёстой.

8. Мацаг барилт та нарын патриархын адислал авах бэлтгэлд чинь тусалж чадна. (Үнэн.)

Ишлэл

“Патриархын адислал авахыг эрэлхийлж буй хүн тэр адислалаар дамжуулан амьдралдаа илүү бүрэн дүүрэн аз жаргалтай болохыг, Их Эзэний ажилд илүү төгс үйлчлэхийг чин сэтгэлийнхээ залбирлаар эрэлхийлэх ёстой. . . . Цэвэр бус, дуулгаваргүй хүн патриарх дээр очихоосоо өмнө дуулгавартай байдлыг сурч

өөрийгөө ариусгах ёстой” (John a. Widsoe, *Evidences and Reconciliation*, 3 vols. [Salt Lake City: Bookcraft, 1943], 1:75).

Залуу
эрэгтэйчүүдийн
илтгэл

Урьдчилан томилогдсон залуу эрэгтэйг патриархын адислал авахдаа түүний хэрхэн бэлтгэсэнийг яриул. Хэрэв залуу эрэгтэйчүүдийн хэн нь ч патриархын адислал аваагүй бол тэдэнд та өөрийнхөө патриархын адислалыг авахад хэрхэн бэлтгэсэн талаар ярьж өг.

Ярилцлага

- Патриархын адислал авахын тулд бидний хүн тус бүр өөр юу бэлтгэж болох вэ? (Байж болох хариултанд Их Эзэний адислалуудыг авахын тулд сайн мэдээнээс суралцаж хүслээ нэмэгдүүлэх ба түүнийг авахын тулд бид юу хийх ёстойг ойлгох, патриарх болон бид өөрсдөө Ариун Сүнсээр нэгэн хэмнэлд байхын төлөө залбирах, Их Эзэний бидэнд бэлдсэн ямар ч адислалуудыг авахуйц зохистой байхын тулд зарлигуудыг сахихаар мэрийх гэх мэт багтана.)

9. Хэрэв найзууд чинь хүсвэл та нарын патриархын адислалыг унших боломжтой байх ёстой (Худал.)

Патриархын адислал бол хувийн болоод нандин гэдгийг тайлбарла. Тэд үүнийгээ аюулгүй газар хадгалж, чөлөөтэй ярилцахгүй бусдад дамжуулахгүй байх ёстой. Тэдгээр нь бидний л ашиг тусын төлөө юм. Хэдий тийм ч Сүнсэнд хөтлөгдсөн үедээ бид гэр бүлийнхэнтэйгээ боломжтой цагт хуваалцаж болно.

10. Патриархын адислалаа ойр ойрхон уншиж байх нь та нарыг амьдралдаа тавьсан зорилгодоо хүрэх, илүү сайхнаар амьдрахад чинь урамшуулж чадна (Үнэн.)

Ишлэл

“Патриархын адислалаа ойр ойрхон, ялангуяа шийдвэр гаргах болон гутранги үедээ уншвал та нар үнэн хэрэгтэй хэн бэ, та нар Бурхантай ямар холбоотой вэ, ялангуяа Түүний та нарын төлөө ямар хүсэлтэй вэ гэдгийг сануулж ойлголтыг өгөх болно. Энэ нь та нарыг хайр дутсан, хаягдсан, сэтгэл дундуур, мартагдсан үед чинь тайтгаруулах болно. Энэ нь та нарыг амьдралын чинь онцгой зорилго руу чиглүүлж чадна” (Elaine A. Cannon, “Season of Awakening,” *New Era*, July 1981, p. 10),

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл: “Адислалаа авсан та нар түүнийгээ ойр ойрхон уншдаг уу? Та нар түүнийгээ талаар залбирч тайлбар авдаг уу эсвэл эвхээд хаа нэг аюулгүй газар хадгалдаг уу? Түүнийгээ хувилж аваад халаасандаа хийгээд ойр ойрхон унш,” гэж хэлжээ (in Conference Report, Korea Area Conference 1975, p. 39).

11. Та нар патриархын адислал чинь хэрхэн биелэхийг үргэлж хэлэх ёсгүй (Үнэн.)

Түүх

Ерөнхийлөгч Кимболл энэ хичээлийг хэрхэн сурснаа дараах түүхэнд өгүүлжээ:

“Намайг 11 настай байхад аав минь патриарх дээр авчирч тэр надад хэрэв би итгэлтэй байхаа харуулбал ирэх зарим адислалуудыг өгсөн юм. Тэр, ‘Чи . . . олон хүмүүст ялангуяа Лэмэнчүүдэд сайн мэдээг номлоно. Тэгээд чи тэднийг өсөн нэмэгдэж, зохион байгуулагдахыг нь үзнэ,’ гэсэн юм. Тэгэхэд би дөнгөж 11 настай байсан юм. Тэр надад юу тохиолдохыг хэрхэн мэдэв ээ? Тэр зөвхөн дээрээс Сүнсийг мэдрээд, Их Эзэний түүний зүрхэнд оруулсан бодлыг хэлсэн.

“Би 19 настай байхдаа . . . Швейцарь Германы Номлолд дуудагдсан ба патриархын адислалаа уншиж байхдаа Швейцарь эсвэл Германд аль алинд нь нэг ч Индиан байхгүйг ойлгосон. Тэгээд Дэлхийн нэгдүгээр дайн болсон тул би Нэгдсэн Улсдаа буцаж ирсэн юм. Тэнд би хаана л бол хаана Индианчуудад сайн мэдээг номлож болох байв. Америкт бараг 60.000.000 Индианчууд байсан юм. . . . Гэвч намайг Мизури руу илгээв. Би Мизурид хоёр жил хагас болоод нэг ч Индиан харалгүй гэртээ буцсан юм. Эгэл жирийн нэг хүний хувьд би тэр патриарх л алдаа гаргалаа гэж бодов. Тэгээд би гэртээ буцаж ирээд ажилд орж, гэрлэсэн ба миний гэр бүлд хүн нэмэгдсээр байв. Тэнд бас нэг ч Индиан байсангүй. . . . Тэгээд би Арван Хоёр Дагалдагчийн нэг болж Солт Лэйк Сити руу нүүсэн юм. Би бас гайхаж байлаа. Одоо би 48 настай болсон ч нэг ч Индианд номлосонгүй.

“Гэвч Солт Лэйк Ситид ирснээс хойш удалгүй Сүмийн Ерөнхийлөгч намайг албан өрөөндөө дуудаад намайг Лэмэнчүүдийн хороонд үйлчлэхийг хүссэн юм. Тэгээд удалгүй тэр намайг дахин дуудаад ‘Би таныг Индианы хөтөлбөрийн дарга болгомоор байна,’ гэж хэлэв. Одоо л миний патриархын адислал биеллээ.

“Патриарх үүнд хэдий хугацаа хэрэгтэйг хэлээгүй тул надад зүгээр л түүнийг нь хүлээж дуудлагаа биелүүлэх хэрэгтэй байсан юм. . . . Магадгүй Америк даяар ах нараас хэн нь ч над шиг тийм олон Индианууд дээр очиж номлож байгаагүй байх. Одоо би онгирч байгаа юм биш зүгээр би та нарт хичнээн хэцүү байсан ч бид өөрсдийнхөө үүргийг гүйцэтгэх юм бол патриархын өгсөн адислал биелэх ба Их Эзэнд боломжгүй юм үгүй гэж хэлмээр байна” (in Conference Report, Korea Area Conference 1975, p.39).

12. Та нарын патриархын адислал та нарыг юу хийж байгаагаас үл хамааран ирэх болно. (Худал.)

Патриархын өгсөн адислал бол болзолтой гэдгийг тайлбарла. Энэ нь Бурханд болон түүний хуулиудад дуулгавартай байснаар ирнэ. Их Эзэний ихэнх адислалуудыг авахын тулд бид зохистой амьдрах ёстой.

Ишлэл

Ахлагч Карлос И.Эсэй патриархын адислалыг дүрслэхдээ дараах төстэй зүйлийг хэрэглэсэн:

“Гадасны патриарх та нарын толгой дээр гараа тавьж адислал өгөхдөө бошиглолууд, амлалтуудыг хэлж сэтгэл хөдлөм эхлэлийг бий болгосон. Энэ нь одоо та нарт тэднээс зорилгодоо хүрэх болон зөв шударгаар амьдарч итгэлтэйгээр үйлчилж тэдэнд дагалдах адислалуудад хүрэх замаа эхлэхээр тэдгээр бошиглол, амлалтуудыг оюун ухаандаа боловсруулах л үлдсэн гэсэн үг.

“Энэ үзүүлдэнд патриарх та нартай цуг эхлэлийн хаалган дээр зогсож байна. Тэр урд чинь байгаа уралдааныг хэлж өгдөг. Түүнд өгөгдсөн онцгой бэлгийнхээ тусламжтайгаар тэр уралдааны дүрмийн гол санааг гаргаж, учрах сорилтуудыг дүрсэлж, авч болох шагналуудыг хэлдэг. Хэдий тийм ч та нар уралдагч учраас хэрэв та нар ялалтын шагналыг авахыг хүсвэл тэмдэглэсэн зураасанд зогсож, дүрмүүдийг нь мөрдөж, гүйлтийн зурвасаа дуусгаж, төгсгөлийн шугамыг өнгөрөх ёстой” (“Write Your Own Blessing,” *New Era*, Oct. 1981, p. 4).

Дүгнэлт

Ишлэл

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл хэлэхдээ, “Надад патриархууд ба тэдний адислалуудад агуу итгэл байдаг. *Хэрэв адислал авагч нь итгэлтэй мөн үнэнч бол Их Эзэнтэй ойр байгч, судруудаас судлагч, үнэнч Хожмын Үеийн Гэгээнтэн патриархын онцгой эрх мэдэл ба дуудлагаар өгсөн амлалтууд биелэх болно*” (in Conference Report, Oct. 1977, p. 4; or *Ensign*, Nov. 1977, p. 4; italics added).

Уриалга

Дараах зүйлсийн аль нэгийг залуу эрэгтэйчүүдээр хийлгэхээр уриал.

1. Хэрэв тэд патриархын адислал авч амжаагүй бол өөрсдийгөө үүнийг тохиромжтой үед авахад бэлтгэх.
2. Хэрэв адислалаа авчихсан бол гэртээ хариад түүнийгээ унших. Амлагдсан адислалуудыг нь авахын тулд түүнийгээ ойр ойрхон уншиж зохистой амьдрахаар хичээх ёстой.

Аароны Пристийн Зэргийн Багшийн Үүрэг

18

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр Аароны Пристийн Зэргийн багшийн үүргүүдийг болон эдгээр үүргүүдийг биелүүлэхийн чухал ба нандин болохыг суралцах болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаанууд.
2. Залуу эрэгтэй бүрт “Аароны Пристийн Зэрэгтний Багшийн Үүрэг” тараах материалын хувийг бэлд.
3. Бишопоос Аароны Пристийн Зэрэгтнүүдэд зориулан тэднийг үүргээ сайн гүйцэтгэсэн тухай магтаалын захиа бичихийг хүс. Энэ захиаг хичээлийн төгсгөлд уншихаар төлөвлөнө.

ТАЙЛБАР

Энэ хичээл нь Аароны Пристийн Зэргийн багшийн үүргийг ерөнхийд нь авч үзсэн болно. Үүнийг мөн ариун ёслолын болон гэрийн багшийн бэлтгэл гэх мэт бусад онцгой үүргийн талаарх хичээлүүд дагалдах болно. Эдгээр үүргүүдийн онцлогуудын талаар энэ хичээл дээр удаан ярилцахаас зайлсхий. Энэ хичээл дэх материалууд нь бүх Аароны Пристийн Зэрэгтнүүдэд өөрсдийнхөө дуудлагыг ойлгож, түүнийгээ эрхэмлэн биелүүлэхэд нь тусалж чадна.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Түүх ба ярилцлага

Оршил

Дараах түүхийг ярь:

Энэ бол Ивены ажлын анхны өдөр байлаа. Ноён Роулингс түүнийг энэ зун өөрийнхөө фермд ажиллуулахаар хөлслөв. Тэр хоёр фермийн зүг хуучин ачааны машинаар явж байхдаа Ивен ямар ажил юм бол гэж бодож явлаа. Түүнд юу хийхийг нь заагаад өгчихвөл ажлаа хийж чадна гэж өөртөө итгэж байв.

Ферм дээр ирэхэд Мистер Роулингс Ивенд түүний байх байшинд юмаа оруулахад нь туслав. Дараа нь тэр, “За, би гурав юм уу дөрөв хоногоос чамайг юу хийж байгааг үзэхээр ирнэ. Сайн ажилласан байгаарай, энд ийм ажилд орох зөндөө олон хөвгүүд байгаа шүү,” гэж хэлэв.

Дараа нь Ивенийг юу ч хэлж амжаагүй байхад нь Ноён Роулингс машиндаа суугаад яваад өгөв. Ивен түүний араас итгэлгүй харцаар ширтэн түүний машиныг алсад улам бүр жижигхэн болтол харсаар байв.

- Та нар Ивенийг ямар байсан гэж бодож байна? Яагаад?
- Та нарт юу хийхийг нь хэн ч тайлбарлалгүйгээр хий гэж ямар нэг юм өгч байсан уу?
- Та нарт ямар байх байсан бэ?

Судар ба ярилцлага

С ба Г 107:99–100-г залуу эрэгтэйчүүдээр уншуул.

- Пристийн зэрэгтэн бүрийн хийх ёстой ямар хоёр зүйлийг энэ шүлэгт хэлсэн бэ? (Үүргүүдээ сурах, албаа гүйцэтгэх.)

Залуу эрэгтэйчүүдээр энэ шүлгүүдийг тэмдэглүүл.

Бүх Аароны Пристийн Зэрэгтнүүд Багшийн Үүргийг Ойлгох Ёстой

Судар, самбар,
ярилцлага

• Багшийн ямар ямар үүргүүд байдаг вэ?
Ярилцах цаг гарга. Самбарт залуу эрэгтэйчүүдийн хариултуудыг бич.
Сургаал ба Гэрээ 20:53–59-ийг залуу эрэгтэйчүүдээр уншуулж тэмдэглүүл.
Урьд нь бичигдээгүй санаануудыг самбарт нэмж бич.

Тараах материал

Залуу эрэгтэй бүрт “Аароны Пристийн Зэрэгтний Багшийн Үүрэг” тараах материалыг өг. Тэдэнд чимээгүй унших цаг гарга.

Ярилцлага

Дараах асуултуудыг Аароны Пристийн Зэрэгтний багшийн үүргүүдийг ярилцлагыг өрнүүлэхэд ашигла. Залуу эрэгтэй бүр энэ үндсэн үүргийг ойлгож мөн тэдгээрийг хэрхэн сайн биелүүлж болохыг ойлгоход нь тусал. Тэдний нөхцөлд хамаатай онцгой санаануудыг гаргахад нь Залуу эрэгтэйчүүдэд тусал. Үсгүүд тараах материалынхтай тохирох ёстой.

а. Пристийн зэрэгтний удирдагчийнхаа зөвлөгөөг дага.

- Бишопын зөвлөл болон бусад пристийн зэрэгтний удирдагчид ямар зөвлөгөө өгсөн бэ?
- Хэсэг дэх пристийн зэрэгтний ерөнхийлөгч хэн бэ? (Бишоп.)

б. Ариун ёслол бэлтгэх.

Ерөнхийлөгч Дэвид О.МакКэйн дараах мэдэгдлийг унш:

“Их Эзэний Зоогийн Ариун Ёслолоос Хүртэх нь Христийн Сүмийн хамгаас нандин ёслолуудын нэг юм” (Pathways to Happiness, comp. Liewelyn R. McKay {Salt Lake City: Bookcraft, 1975}, p. 262).

- Энэ яагаад үнэн бэ?
 - Тэгвэл ариун ёслол бэлтгэх нь хэр их чухал вэ?
- в. “Бүгдийг Христэд ирэхэд” ба гишүүдийг үүргээ гүйцэтгэхэд туслах.
- Хүмүүст бид юуг анхааруулах ёстой вэ?
 - *Ойлгуулах, ятгах* гэсэн үгнүүд ямар утгатай вэ?
 - Бид бие биендээ юуг заах ёстой вэ?
 - “Бүгдийг Христэд ирэхэд” урих гэж юу гэсэн үг вэ? Бидэнд үүнийг хийх ямар ямар арга бий вэ?
 - Сайн үлгэр жишээ байх нь яагаад бүх гишүүдэд үүргээ гүйцэтгэхэд нь туслах нэг шилдэг арга болдог вэ?
 - Та нар Зөвлөхдөө хэрхэн үүргээ гүйцэтгэхэд нь тусалж чадах вэ?

г. Сүмд шударга бус байдлыг сэрэмжлүүлэх.

- Сайн үлгэр жишээ байх нь яагаад бусдыг худлаа хэлэх болон бусдын талаар муу сэтгэгдэлтэй байхаа зогсооход урамшуулах хамгийн сайн арга вэ?
- Амар амгаланг тогтоогч болох нь онцгой чухал байдаг ямар ямар нөхцөлүүд байдаг вэ?
- Амар амгаланг тогтоогч байхад яагаад заримдаа зориг шаарддаг вэ?

д. Пристийн зэрэгтний зааварчилгаагаар гэгээрүүлэх, гэгээрэх.

- *Гэгээрэх* гэж ямар утгатай үг вэ?
- Бид бусдыг хэрхэн гэгээрүүлж чадах вэ?
- Бусдаар гэгээрүүлэхийн тулд бид ямар ямар аргаар бэлтгэгдсэн байж болох вэ?

е. Бишопт, түүний цаг зуурын үүргүүдэд нь туслах.

- Хэсэг болон гадсанд та нар ямар төрлийн үйлчлэл хийж болох вэ? Тодорхой хариултуудыг ав. Энэ нь үйлчлэх үйл ажиллагаа санаачлах сайхан боломж болно.

- Барилга ба түүний ойр орчныг харж хамгаалахад та нарын хийж болох ямар ямар энгийн зүйлүүд байж болох вэ?

ё. Пристийн зэрэгтний ажлуудыг гүйцэтгэх

- Хэн нэгэнтэй нөхөрлөх гэж юу гэсэн утгатай үг вэ?
- Идэвхгүй хүмүүстэй нөхөрлөхдөө бид тэдэнд яаж хандах ёстой вэ?

ж. Сүмийн цуглаанууддаа бишрэлтэйгээр хаалгач хийх.

- Хаалгач хийхдээ зохистой болон цэвэр хувцаслах нь яагаад чухал вэ?
- Хаалгач нар ямар боловсон зан байдлын дүрмүүдийг сахих ёстой вэ?

з. Бишопын зөвлөлд бусад аргаар туслах.

- Багшийн гүйцэтгэдэг өөр үүргийг та нар мэдэх үү?

Дүгнэлт

Бишопын захидал

Бишопын талархлын захиаг уншиж, Сүм болон хэсэгт багшийн үүрэг хариуцлагын чухлын талаар гэрчлэлээ хуваалц.

Уриалга

Залуу эрэгтэйчүүдэд Сургаал ба Гэрээ 107:99-ийг цээжилж, үүргүүдтэй тараах материалыг эцэг эхтэйгээ ярилцахыг уриал. Хэрэв цаг үлдвэл Залуу эрэгтэйчүүдэд Сургаал ба Гэрээ 107:99-ийг цээжилж эхлэхэд нь тусал.

Аароны Пристийн Зэргийн Багшийн Үүргүүд

Багш бол хэсэгт “Сүмийг хамгаалж” “Тэдэнтэй хамт байж, тэднийг бэхжүүлэхээр” дуудагдсан маш чухал үйлдэгч юм (С ба Г 20:53; 84:111). Тэр пристийн зэрэгтний удирдлаган доор тодорхой үүргүүдийг гүйцэтгэн үүнийг хийдэг. Багшид диконы бүх үүргүүд мөн зарим нэмэлт үүргүүд байдаг. Багшийн үүргүүдэд дараах хариуцлагууд багтдаг:

- а. Пристийн зэргийн удирдагчдын зөвлөгөө ба удирдамжийг мөрдөх.
- б. Ариун ёслол бэлтгэх.
- в. “Сэрэмжлүүлж, ойлгуулж, ятгаж, зааж бүгдийг Христэд ирэхэд урих” (С ба Г 20:59) болон Сүмд цугтаа ойрхон цуглаж буйг, мөн бүх гишүүд үүргээ гүйцэтгэж буйг харахын тулд (С ба Г 20:55) эдгээрийг хийнэ:
 - 1) Гэрийн багш хийх.
 - 2) Гишүүддээ цуглаануудыг зарлах.
 - 3) Сүмийн цуглаануудад яриа өгөх.
- г. Сүмд нэг ч шударга бус явдал байхгүй, мөн бие биентэйгээ маргалдах, худлаа ярих, хов жив, нүгэл хилэнц ярихгүй байгааг харахын тулд (С ба Г 20:54) эдгээрийг хийнэ:
 - 1) Ёс суртахууны зарчимч болон шударга байдлын жишээ байх.
 - 2) Амар амгаланг тогтоогч байж тайвшруулах нөлөөтэй байх.
- д. Пристийн зэрэгтний сургалтанд оролцож пристийн зэрэгтнүүдээ гэгээрүүлж, мөн тэднээс суралцах (С ба Г 50:22-ыг үз.)
- е. Бишопт “цаг зуурын зүйлсийг гүйцэтгэхэд” нь туслахын тулд (С ба Г 107:68) эдгээрийг хийнэ:
 - 1) Ядуу болон гачигдалтай хүмүүст туслах.
 - 2) Цуглааны байр ба ойр орчныг хамгаалах.
- ё. Нөхөрлөхөд нь туслах болон пристийн зэргийн насны идэвхгүй гишүүдийг идэвхжүүлэх ба пристийн зэрэгтний хороонуудад үйлчлэхэд туслах зэрэг пристийн зэрэгтний ажлыг гүйцэтгэх.
- ж. Гадасны чуулган ба хэсгийн цуглаануудад бишрэлтэйгээр хаалгач хийх.
- з. Багш нарын эрх мэдэлд нийцүүлэн бишопын зөвлөлд туслах.

(*Aaronic Priesthood Leadership Handbook*-ээс авав, pp. 2–3).

ЗОРИЛГО Залуу эрэгтэй бүр харууссан зүрх ба гэмшсэн сэтгэлтэй байхын чухлыг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаанууд.
2. 1 Нифай 2:16; 2 Нифай 2:6–7; Мозая 4:2–8; Алма 36:5–20; 3 Нифай 9:19–22; Морунай 6:2 ба Сургаал ба Гэрээ 59:8-ыг залбирч судал.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Түүх

ОРШИЛ

Дараах түүхийг ярьж өг:

Ваарчин зөөлөн шавраар үзэсгэлэнт хөшөө барьжээ. Харамсалтай нь шавар хатахдаа хагарч, хөшөөнд олон ан цав эвдэрхий гарсан байв. Ваарчин хатсан шавар дээр ан цавыг нь дарахаар шинэ шавар дэмий л түрхэв. Түүний гаргасан чармайлтыг эс тооцвол тэр хөшөөний гоо сайхан сүр жавхланг хуучин хэвэнд нь оруулж чадсангүй.

Тэр зөвхөн хатууруулж, ан цав гаргаж, шаврыг муу болгох зүйлүүдийг л хийжээ. Тэр алхаар хөшөөг эвдэлж, хатуурсан шаврыг тоос болтол нь нунтаглаж, цэвэр ус нэмж, шинээр хөшөө хийж эхлэв.

Судар ба ярилцлага

• Бидний зүрх сэтгэл, сүнснийг ваарчны шавартай хэрхэн харьцуулж болох вэ?

Сударт байнга яригддаг “хатуу сэтгэл”-ийг залуу эрэгтэйчүүдэд ойлгуул. Хатуу сэтгэлтэй залуу эрэгтэйчүүд сүнслэг зүйлийг сонирхдоггүй. Тэр Бурханы хүсэлд өөрийнхөө хүслийг нийцүүлдэггүй ба зөвхөн өөрийнхөө хүсэл сонирхлыг дагахыг боддог.

• Мормоны номын Лихайн хүүхдүүдийн аль нь хатуу сэтгэлтэй вэ? (Лэмэн ба Лэмүүл [1 Нифай 2:18; 15:3-ыг үз].)

1 Нифай 2:16-г залуу эрэгтэйчүүдээр уншуул.

• Хатуу сэтгэлтэй болохоос зайлхийхийн тулд Нифай юу хийсэн бэ? (Нифай мэдлэг олохын төлөө залбирсан ба түний сэтгэл зөөлөрсөн.)

Золиослолын Шинэ Хэлбэр

Судар ба ярилцлага

Есүс Христэд итгэгч эртний хүмүүст “Эцгийн Заяасан Ганцын золиослолыг” төлөөлүүлж амьтны цусыг золиослохыг тушаасан гэж хэл (Мосе 5:5–7). Мормоны Номын бошиглогч Амюлек Есүс Христ бол “агуу ба сүүлчийн золиос болно” гэсэн (Алма 34:14) ба тэр өөрийнхөө амь болон цусыг хүн төрөлхтний гэм нүглүүдийн төлөө урсган цагаатгахыг зөвшөөрнө гэж сургажээ. Энэ агуу сүүлчийн золиослолын дараа цус урсгахыг зогсоосон байна (Алма 34:13). Есүс үхээд дахин амилсныхаа дараа Нифайчууд дээр ирж дахин цус урсган золиослол хийхийг зогсоох ёстойг хэлжээ (3 Нифай 9:19–20).

• Их Эзэн түүнд итгэгч хүмүүсийг ямар золиослол хийхийг шаарддаг вэ?

• Хэрэв байдаг бол ямар золиослол цус урсгах золиослолыг орлодог вэ?

3 Нифай 9:19–20-ийг нэг залуу эрэгтэйгээр уншуул. Залуу эрэгтэйчүүдэд цус урсгахыг орлох золиослол бол харууссан зүрх ба гэмшсэн сэтгэлийн золиослол юм гэдгийг ойлгуул.

Амьтны цусыг урсгах золиослол бол ирээдүйд Бурханы Хүүгийн хийх золиослолыг сануулах зорилготой гаднах ёслол байсан ба мөн энэ золиослолыг хийгч нь дотоод харууссан зүрх ба гэмшсэн сэтгэлийн золиослолыг хийхийг шаарддаг гэдгийг онцлон хэл.

Их Эзэний Нифайчуудад өгсөн заавар бидний үед мөн давтагдсаныг тайлбарла. Сургаал ба Гэрээ 59:8-ыг уншаад ярилц.

Самбар ба
ярилцлага

Харууссан Зүрх ба Гэмшсэн Сэтгэл

- Харууссан зүрхтэй байна гэж ямар утгатай үг вэ? (Харууслыг маш ихээр мэдрэх)
- Гэмшсэн гэж ямар утгатай вэ? (Наманчлалтай.)

Эдгээр тодорхойлолтуудыг самбарт бич.

- Христ биднийг харууссан зүрх ба гэмшсэн сэтгэлтэй байхыг яагаад хүсдэг вэ?

Сударт “харууссан зүрх” гэдгийг ойр дотныхноо болон хайрт нэгнээ алдсан юмуу хувийн амьдралдаа гутарсан гутралыг хэлдэггүй гэдгийг тайлбарла. Харин ч сударт яригддаг харууссан зүрх гэдэг нь тухайн хүний төгс төгөлдөр бус байдал ба гэм нүглээ хүлээн зөвшөөрч буйн ердийн үр дүн юм.

Дараах үнэний мэдлэг нь хүнийг харууссан зүрх ба гэмшсэн сэтгэлтэй болоход хөтөлнө гэдгийг тайлбарла.

1. Бид бүгд энэ дэлхий дээр төрөлхийн нүгэлтэй, уналтын байдалтай учир Бурханы хуулийн эсрэг гэм нүгэл үйлддэг ба үүнийхээ төлөө бид шударга ёсны хуулиар шийтгүүлдэг.
2. Есүс Христ ариун ба нүгэлгүй. Тэр төгс төгөлдөр амьдралаар амьдарсан ба гэм нүглийн шийтгэлийг хүртэх ёсгүй хүн байсан.
3. Есүс Христ бидэнд маш хайртай учраас тэр бидний бүх гэм нүглийн төлөөсийг төлсөн. Тэр бүх хүмүүсийн нүглийн шийтгэлийг үүрсэн.

Есүс төгс төгөлдөр, нүгэлгүй боловч бид бүгдийн төлөө аймшигт шийтгэлийг үүрч гарсан гэдгийг ойлгох ёстойг тайлбарла. Их Эзэний бидний төлөө зовсон тэр аймшигт зовлонг болон өөрсдийнхөө зохистой бус байдлаа эргэцүүлэн бодоход энэ нь зүрх шимшрүүлэм мэдрэмж байх ёстой.

Судар ба ярилцлага

Дараах судар харууссан зүрх ба гэмшсэн сэтгэлтэй байх гэсэн утгыг илүү тод болгогчийг тайлбарла. Нэг залуу эрэгтэйгээр Алма 36:5–20-ийг уншуул.

- Тэнгэрийн элч түүн дээр ирэхээс өмнө Алма юу хийж байсан бэ? (Сүмийг устгахыг санаархаж байсан [6-р шүлгийг үз].)
- Алмад 3 шөнө 3 өдрийн турш юу тохиолдсон бэ? (Тэр мөнхийн зовлонд тарчилсан [12– 13, 16-р шүлгийг үз].)
- Алмагийн зовлонгийн шалтгаан юу байсан бэ? (Тэр бүх нүглүүдээ, Бурханы эсрэг тэмцсэнээ, Түүний ариун зарлигуудыг сахиагүйгээ санасан. Тэр гэм нүгэлтэй байсан учир Бурханы дэргэд очихоос айсан бөгөөд устаж үгүй болохыг хүссэн.)
- Ямар бодол нь Алмаг зовлонгоос ангижруулсан бэ? (Түүний аавын Есүс Христ ирж дэлхийн нүглүүдийг цагаатгах тухай бошиглол [17-р шүлгийг үз].)
- Христийн цагаатгалыг санаж өөрийнхөө зохисгүй байдлыг ойлгосноор Алма юу хийсэн бэ? (Тэр залбирч, “Ай, Есүс, Бурханы Хүү та, намайг нигүүлсээч” гэж зүрхэндээ уйлсан [18-р шүлгийг үз].)
- Түүний залбирлын дараа юу болсон бэ? (Тэр гэм нүглээ санаж айхаа больж, гэрэл, баяр баясгалангаар дүүрсэн [19–20-р шүлгийг үз].)

Зөвлөхийн
танилцуулга

Бага Алма харууссан зүрх ба гэмшсэн сэтгэлтэй болж наманчлан Христэд итгэсэн. Бидний нүглүүд Алмагийнхаас өөр боловч үүний адил бид нүглүүдээ Христийн ариунтай шударгаар харьцуулан харах шаардлагатай. Үүнийг хийснээрээ бид ч харууссан зүрх ба гэмшсэн сэтгэлтэй болж чадна.

Судрын түүх
ба ярилцлага

Бэнжамин Хааны үгийг сонсохоор цугласан хүмүүст бас ийм явдал тохиолдсон гэж тайлбарла (Мозая 2:5–6-г үз). Бэнжамин Хаан Есүс Христийн цагаатгал, Их Эзэний хүмүүсийн нүглийн төлөө зовсон агуу шаналлын тухай хүмүүст ярьсан. Бэнжамин Хаан тэдний нүгэл, гэм буруугийнх нь тухай ярьсан.

Бэнжамин Хааны үгэнд итгэсний үр дүнд хүмүүс, “Тэд өөрсдийгөө зуурдын байдалд буйгаа төсөөлсөн, бүр ертөнцийн тоосноос ч өчүүхнээ буюу. Мөн тэд бүгд нэгэн дугаар чанга хашхирч, хэлрүүн: Ай, нигүүлсэж хайрла, мөн бид өөрсдийн нүглүүдэд өршөөлийг хүлээн авч болох мөн зүрх сэтгэл маань ариуссан байж болохын тул Христийн цагаатгагч цусыг нөлөөлүүлээч.” Тэдний залбирлын хариуд “Их Эзэний Сүнс тэдний дээр ирж, мөн тэд нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авч баяр хөөрөөр дүүргэгдсэн байв” (Мозая 4:2–3).

Бэнжамин Хаан өөрийнхөө хүмүүст юу тохиолдсонд дүгнэлт хийснийг хэл. Нэг залуу эрэгтэйгээр Мозая 4:4–8-ыг уншуул. Тэгээд эдгээр шүлгүүдийн утгыг залуу эрэгтэйчүүдтэй ярилц.

Харууссан зүрх гэдэг нь гэм нүгэлдээ бурханлаг харууслыг мэдэрч өөрсдийнхөө уналтыг ойлгох юм гэдгийг залуу эрэгтэйчүүд ойлгуул.

Бошиглогчид биднийг ертөнцийн тоосноос ч доор гэж хэлж байгаа нь ертөнцийн тоос нь Бурханы дуу хоолойг дуулгавартай дагаж түүнийг хөдөл гэж тушаахад хөдөлдөг гэж хэлж байгааг нь тайлбарла. Харин хүн (ертөнцийн тоосноос бүтсэн) дуулгаваргүй, Бурханы зарлигууд болон зөвлөгөөг байнга эсэргүүцэж, татгалздаг. (Хиламан 12:6–8-ыг үз.)

Христэд итгэдэг хүмүүс өөрийнхөө өчүүхнийг танин мэдсэний үр дүн түүнд нүглээ наманчлах сүнс, гэм нүглийн уучлалыг эрэлхийлэн ирдэг. Энэ бол “гэмшсэн сэтгэл” гэсний утга юм. Гэм ба эсэргүүцлийн хатуурсан зүрхийг номхотгох нь хангалттай биш юм. Их Эзэнийг чин сэтгэлээсээ эрэлхийлэн Христийн цагаатгалын цусаар шинэ зүрх сэтгэлийн төлөө, гэм нүглийнхээ уучлалын төлөө, нигүүлслийнхээ төлөө, бүх зүрх сэтгэлийнхээ хүчээр залбирах ёстой. Бэнжамин Хааны хүмүүсийн гэмшсэн сэтгэлийн залбирал нь “Ай, нигүүлсэж хайрла, мөн бид өөрсдийн нүглүүдэд өршөөлийг хүлээн авч болох мөн зүрх сэтгэл маань ариуссан байж болохын тул Христийн цагаатгагч цусыг нөлөөлүүлээч” (Мозая 4:2). Энэ бол Бага Алмагийн залбирал, “Ай, Есүс, Бурханы Хүү та, шаналлын гүнд буй, мөн үүрдийн сүнсний үхлийн гинжээр ороогдсон болох намайг нигүүлсээч” (Алма 36:18).

Бид Харууссан Зүрх ба Гэмшсэн Сэтгэлээ Өсгөх Хэрэгтэй

Судар ба ярилцлага

Моронай 6:2-ыг залуу эрэгтэйчүүдээр уншуулж тэмдэглүүл.

- Энэ шүлэгт хэлснээр хэн усан баталгаа хийлгэж болох бэ? (Харууссан зүрх ба гэмшсэн сэтгэлтэй хүмүүс.)

Заримдаа усан баталгааны ёслолын өмнө нь эсвэл дараа нь харууссан зүрх ба гэмшсэн сэтгэл түүнийг дагаж ирдэг гэдгийг тайлбарла.

2 Нифай 2:6–7-г залуу эрэгтэйчүүдээр уншуулж тэмдэглүүл.

- Энэ шүлгүүдэд хэлснээр бидэнд харууссан зүрх ба гэмшсэн сэтгэлтэй байх нь хэр чухал вэ? (Зөвхөн харууссан зүрх ба гэмшсэн сэтгэлтэй хүмүүс л Их Эзэний цагаатгалаар ирэх адислалуудыг бүрэн хүртэж чадна.)

Дүгнэлт

Гэрчлэл ба уриалга

Энэ хичээлд заагдсан зарчмууд үнэн гэдэг гэрчлэлийг хуваалц. Залуу эрэгтэйчүүдэд энэ хичээлд үзсэн судруудыг уншиж, мөн бусад харууссан зүрх ба гэмшсэн сэтгэлтэй байсан хүмүүсийн жишээнүүд ба хэсгүүдийг олохыг зөвлө.

“Их Эзэн эмтэрсэн зүрхтэй хүнд ойртон байдаг Сүнсээрээ гэмшигчдийг авардаг” (Дуулал 34:18) гэдгийг гэрчил. Их Эзэн биеэ тоосон, эд материалд дуртай залуу эрэгтэйчүүдэд дуртай байдаггүй.

Залуу эрэгтэйчүүдээс өөрсдийгөө даруусгаж, Аврагчид хүрэх нэн шаардлагатай хэрэгцээгээ мэдэж авахыг хүс. Тэдэнд Христийн зовсон зовлонгийн нэг хэсэг нь тэдний гэм нүглийн төлөө байсныг санаж байхыг уриал.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр ариун ёслолын нандин чанарыг илүү бүрэн дүүрэн ойлгож авч, түүнийг бишрэлтэйгээр гүйцэтгэх болно.

БЭЛТГЭЛ

- Шаардагдах материалууд:
 - Залуу эрэгтэй бүрт судар.
 - Залуу эрэгтэй бүрт харандаа цаас.
- Таныг энэ хичээлийг заахаас ядаж нэг долоо хоногийн өмнө чуулгын удирдагч нар бишопын зөвлөл юмуу салбарын ерөнхийлөгчийн зөвлөлтэй уулзаж ариун ёслол гүйцэтгэхэд гарч буй асуудлуудыг тогтоож, эдгээр асуудлуудыг хэрхэн засахаа шийдсэн байх ёстой. Чуулгын удирдагчид пристийн зэрэгтний цуглааны үеэр ариун ёслолыг хэрхэн зөвөөр гүйцэтгэхийг заахаар бэлтгэх хэрэгтэй.

ТАЙЛБАР

Ариун ёслол бол нандин зүйл. Энэ нь Аврагчаар томилогдсон. Аароны Пристийн Зэрэгтнүүд ариун ёслол гүйцэтгэхдээ Түүнийг төлөөлж байгаа гэдгээ санаж байх ёстой. Тэд Есүс хэрхэн үүнийг гүйцэтгэж, түүний хандлага ямар байх талаар бодох ёстой. Ариун ёслолыг хүндэтгэж Аврагчийн хийнэ гэж мэддэгээр гүйцэтгэдэг залуу эрэгтэй бүр үүнийг нандин хэмээх гэрчлэлийг олж авна.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Түүх ба ярилцлага

Оршил

Ричард дөнгөж багшаар томилогдоод байв. Тэр удирдагчаа гэж хүндэтгэж явдаг 3 өөр багш нартай хамт ариун ёслол бэлтгэхээр болов. Хэдий тийм ч энэ нь түүний урмыг хугалсан явдал байв. Нэгдүгээрт, бусад багш нар оройтож ирсэн учраас тэр хүлээх болно. Тэгээд нэг багш аяганд усаа бишрэл хүндэтгэлтэйгээр хийхийн оронд бусад руу шүршиж байв. Нөгөө багш нь тавиурт талх тавьж байхдаа түүнээс зүсмээр нь авч идэж байлаа. Мацагийн Ням гариг байсан учир тэр өлсөж үхлээ гэж хэлжээ. Нөгөө багш нь үргэлж ариун ёслол бэлтгэхэд томилогддог гэж гомдоллож байв. Тэр хэлэхдээ ойр ойрхон хаалгач хийж, зөөлөн сандалд хүлээх зааланд суухыг хүсэж байна гэжээ.

- Ричардыг ариун ёслол бэлтгэнэ гэсэн бодолд энэ маягийн явдлууд хэрхэн нөлөөлж болох вэ?
- Түүний багшийн дуудлагад энэ хэрхэн нөлөөлөх вэ?
- Тиймэрхүү хандлагатай байвал Аврагчид маань ямар сэтгэгдэл төрнө гэж та нар бодож байна?

Ариун Ёслол бол Нандин Ёслол Мөн

Ишлэл

Бишоп Жоон Х.Вандэнбэрг ариун ёслолын нандин чанарыг дараах байдлаар тайлбарласан:

“Энэ бол маш нандин ёслол, Эзэн өөрөө тогтоосон тийм их нандин зүйл юм. Аврагч өөрөө тэрхүү анхны ариун ёслолыг бэлтгэж адисласан юм. . . .

“Өнөөдөр энэ ёслолын дахин сэргээлтний дагуу Аврагч пристийн зэрэгтнүүддээ түүний оронд энэ нандин бэлэгдлийг адислах эрхийг олгосон. Энэ эрин үед залуу эрэгтэйчүүд энэ нандин үүрэг, итгэл хүлээлгэсэн, Аврагчийн гүйцэтгэсэн ариун ёслолтой ижил үүргийг гүйцэтгэдэг” (The Presiding Bishopric Speaks about the Sacrament,” Improvement Era, Nov. 1967, p. 15).

Бодох асуултууд	<ul style="list-style-type: none"> • Хэрэв та нар анхны ариун ёслолын цуглаанд байсан бол та нар ямар сэтгэгдэлтэй байх байсан бэ? • Их Эзэн та нарт итгэж өөрийнхөө ариун ёслолыг гүйцэтгэх эрх мэдэл өгснийг мэдэх нь та нарт ямар сэтгэгдэл төрүүлж байна вэ?
Судар ба ярилцлага	<p>Матай 26:17–20, 26–28-ыг залуу эрэгтэйчүүдээр уншуул.</p> <p>Үүний дараахан Аврагч дахин амилсан дүрээрээ Дэлхийн Бөмбөрцгийн Баруун Хэсэгт ариун ёслолыг танилцуулсан болохыг тайлбарла. 3 Нифай 18:1–3, 6–8, 10–11-ийг залуу эрэгтэйчүүдээр уншуул.</p>
Ишлэл	<ul style="list-style-type: none"> • Ариун ёслолын талаар ямар нэмэлт зүйлийг энэ судар өгсөн бэ? <p>Ахлагч Дэвид О.МакКэйн дараах мэдэгдлийг унш.</p> <p>“Ариун ёслол гүйцэтгэхээс өөр ямар ч нандин ёслол Христийн Сүмд байдаггүй” (in Conference Refort, Apr. 1946, p. 112).</p>

Ариун Ёслолыг Бишрэл Хүндэтгэлтэйгээр Гүйцэтгэх

Ишлэл	<p>Ахлагч Жоон Х.Гробергийн дараах мэдэгдлийг сонсож өөрсдийнхөө ариун ёслол хэрхэн гүйцэтгэгдээ дүгнэхийг залуу эрэгтэйчүүдээс хүс:</p> <p>“Залуу эрэгтэйчүүд та нар Их Эзэний бидэнд өгсөн хайрын билэгдэл болох талх, усыг тараах нь та нарын ямар давуу эрх вэ гэдгийг ойлгож зохистой байх ёстой. Найдвар, хайр, баяр баясгалан, өршөөл, эрх чөлөө ба мөнхийн амьдрал гэсэн адислалуудыг өгч байгаага бод. Өнөөдөр маш олон залуус уйтгар гуниг, бүтэлгүй байдал, олзлогдмол байдал, аз жаргалын хуурамч нэрийдэл үхэл авчирдаг олон янзын архи, хар тамхи тарааж байгаа нь ямар эрс тэс ялгаа вэ!” (in Conference Report, Apr. 1989, p. 51; or Ensign, May 1989, p. 39).</p>
Ярилцлага	<ul style="list-style-type: none"> • Ариун ёслол гүйцэтгэхдээ зөв зохистой хувцаслах нь яагаад чухал вэ? • Ариун ёслол гүйцэтгэхдээ та нар юу бодох ёстой вэ? • Та нарын Ариун ёслол гүйцэтгэх байдал сэтгэгдэлд тань хэрхэн нөлөөлөх вэ? • Та нарыг ариун ёслол гүйцэтгэж байхад ажиглаж буй хүмүүст гүйцэтгэж байгаа байдал тань хэрхэн нөлөөлдөг вэ? • Та нарын оронд Аврагч байсан бол ариун ёслолыг хэрхэн гүйцэтгэх байсан бэ? • Аврагч яагаад ариун ёслолыг бишрэл хүндэтгэлтэй, замбараатай гүйцэтгэхийг хүсдэг вэ?
Үйл ажиллагаа	<p>Залуу эрэгтэй бүрт цаас харандаа өг. Дараах асуултанд хариулт бичүүл. Би ариун ёслол гүйцэтгэхдээ бишрэл хүндэтгэлээ хэрхэн өсгөж чадах вэ? Залуу эрэгтэйчүүдийг бичиж дууссаны дараа тэдний хариултуудыг самбарт бич.</p>
Дадлага сургалт	<p>Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлд ариун ёслол гүйцэтгэх талаар богино дадлага сургалт явуулах цаг өг (“Бэлтгэл”-ийн 2-р хэсгийг үз). Тэд ариун ёслолыг хэрхэн бишрэл хүндэтгэлтэй ба үр нөлөөтэй гүйцэтгэх талаар ярилцах ёстойг анхаар.</p>

Дүгнэлт

Гэрчлэл	<p>Ариун ёслол нандин гэдгийг гэрчил. Энэ ёслолд залуу эрэгтэйчүүдийн үүрэг ямар чухал вэ гэдгийг дахин онцол. Тэд ариун ёслол гүйцэтгэхдээ бишрэл хүндэтгэлээ дээшлүүлнэ гэдэгт итгэж байгаагаа илэрхийл.</p>
Уриалга	<p>Ариун ёслол гүйцэтгэх байдлаа дээшлүүлэх нэг зөвлөгөөг сонгож, ирэх сард түүнийгээ хөгжүүлэх онцгой чармайлт гаргахыг уриал.</p> <p>Мөн залуу эрэгтэйчүүдийг өөрсдөө ирэх сард чармайлт гаргах өөр нэг зөвлөгөөг сонгож зөвлөмжийн жагсаалтандаа бичихийг хүс.</p>

Мелкизэдэк Пристийн Зэрэгт Бэлтгэх нь

21

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр Мелкизэдэк Пристийн Зэрэгт бэлтгэхэд Аароны Пристийн Зэрэг хэрхэн тусалж чадахыг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Хоёр ширхэг цаас ба хоёр харандаа.
 2. Самбарт эсвэл үзүүлэн дээр Аароны Пристийн Зэрэгтэн ба Мелкизэдэк Пристийн Зэрэгтнүүд юу юу хийж болдгийг жагсааж бич (хичээлийг үз).
 3. Та нар нэг юмуу хоёр залуу эрэгтэйг аавтайгаа эсвэл өөр Мелкизэдэк Пристийн Зэрэгтэнтэй Мелкизэдэк Пристийн Зэргийн чухал болох тухай ярилцаж түүнийгээ хуваалцахыг хүсэж болно.
-

ТАЙЛБАР

Аароны Пристийн Зэрэгтний хувьд Мелкизэдэк Пристийн Зэрэг хүлээн авна гэдэг нь ирээдүйн агуу үйл явдал байх болно. Энэ хичээл Аароны ба Мелкизэдэк Пристийн Зэргүүдийн хоорондох ялгааг ойлгуулах болно. Залуу эрэгтэй бүрийн өмнө Мелкизэдэк Пристийн Зэрэг хүлээн авах мөн ашиглах агуу боломж байгаад итгэх ёстой. Энэ хичээлийг утга төгөлдөр болгохоор сүнслэг хөг оруулахын тулд залбиралтайгаар бэлтгэ. Энэ хичээлийг пристийн зэрэгтний хоёр цуглаан дээр зааж болно.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Үйл ажиллагаа

Оршил

Залуу эрэгтэйчүүдийг хоёр баг болгон хувааж өрөөний хоёр өөр буланд суулга. Багийн ахлагч нарыг сонгож тэдэнд харандаа цаас өг. Цаасаа хоёр хэсэг болгоод нэг талд нь *Аароны Пристийн Зэргийн Хүч ба Мелкизэдэк Пристийн Зэргийн Хүч* гэсэн гарчиг тавиул. Залуу эрэгтэйчүүдэд Аароны болон Мелкизэдэк зэрэгтнүүд юу хийдгийг тохирох баганад жагсаан бич гэж хэл. Тэднийг жагсааж дуустал ойролцоогоор дөрвөн минут өг. Дараах хариулт бичсэн цаасыг самбарт юмуу үзүүлэнд тавьж үзүүл. Баг бүр жагсаалт дээрээ багийнхаа дугаарыг тавина. Ихэнх зүйлийг нь бичсэн багийг тодруулж мэдэгд. Бүх хариултыг дахин уншаад хоорондоо ярилц.

Аароны Зэргийн Хүч

1. Ариун ёслолыг бэлтгэх, гүйцэтгэх, тараах.
2. Усаар батлах (зөвхөн прист).
3. Сахиусан тэнгэрүүдийн үйлчлэлийг хүлээн авах.
4. Гэрийн багшаар явах
5. Гэгээнтнүүдийн материаллаг хэрэгцээг анхаарах
6. Мацгийн өргөл цуглуулах.
7. Бусад прист, багш, диконуудыг томилох (зөвхөн прист).
8. Ахлагч нарыг байхгүйд цуглааныг удирдах.

Мелкизэдэк Пристийн Зэргийн хүч

1. Ариун Сүнсний бэлэг өгөх
 2. Хүүхдэд нэр өгч адислах.
 3. Өвчтөнийг адислах.
 4. Тослох тосыг ариулах.
 5. Булш адислах.
 6. Мелкизэдэк, Аароны зэргийг олгох ба пристийн зэргийн албанд томилох.
 7. Гэгээнтнүүдийн сүнслэг хэрэгцээнд санаа тавих.
 8. Цуглааныг удирдах.
 9. Ариун сүмд орж ариун сүмийн бүх ёслолуудыг хүлээн авах.
 10. Тохирох түлхүүрүүдээр ариун сүмийн бүх ёслолуудыг гүйцэтгэх.
 11. Сүмийн бүх албанд хүч ба эрх мэдэлтэй (С ба Г 107:8-ыг үз).
 12. Аароны Пристийн Зэрэгтний хийдэг бүх ажлыг хийж чадна.
- Аароны Пристийн Зэрэгтнүүд болон Мелкизэдэк Пристийн Зэрэгтнүүдийн гүйцэтгэдэг ёслолуудын гол ялгаа нь юу вэ?

Мелкизэдэк Пристийн Зэрэг нь Сүнслэг Зүйлийг Гүйцэтгэх Хүчтэй

Судар ба ярилцлага

Төлөөлөгч Паул нэгэн удаа Есүсийн талаар хэлэхдээ “Бурханаар Мелкизэдэк хэргэмийн дагуу Тэргүүн Тахилч болон өргөмжлөгдөв” гэжээ (Еврей 5:10). Есүс бол Мелкизэдэк Пристийн Зэрэг дэх агуу дээд Прист байсан юм. Тэрээр Мелкизэдэк Пристийн Зэрэгтэй байх болон түүнийг хэрэглэхийн утга учрыг харуулсан жинхэнэ жишээ байсан юм.

Матай 8:16 ба Марк 1:30–31-ийг залуу эрэгтэйчүүдээр уншуул. Есүс өөрийнхөө үгээр муу ёрын сүнсүүдийг хэрхэн зайлуулж, өвчтөнийг эдгээсэн тухай ярилц.

- Ийнхүү эдгээхдээ Есүс пристийн зэргийн хүчээ хэрхэн хэрэглэсэн бэ?

Лук 6:17–19-ийг хамтдаа унш.

- Аврагч хүмүүсийг эдгээхэд түүнээс юу гарсан бэ?
- Энэ нь ямар утгатай үг вэ?

Түүнээс хүч гарч байсан гэж тайлбарла. Есүст бусдыг эдгээх хүч байсан.

- Мелкизэдэк Пристийн Зэргийн хүчээр та нар хэрхэн адислагдаж байсан бэ?

Ишлэл ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүд Мелкизэдэк Пристийн Зэрэг дэх ахлагч болохоороо Христийн өмнөөс сүнслэг зүйлүүдийг хийх хүчтэй болно гэдгийг тайлбарла. Ахлагч Брус Р.МакКонки Ахлагч нарын талаар ярихдаа: “Ахлагч нар бол Христийн туслахууд; Тэд сүнслэг зүйлсийг гүйцэтгэхээр дуудагддаг (С ба Г 107:12). . . . [Тэд] үүнээс доогуур зэрэгтний гүйцэтгэх бүх үүргийг гүйцэтгэдэг” (С ба Г 20:38–67) гэжээ (*Mormon Doctrine*, 2nd ed. [Salt Lake City: Bookcraft, 1966], p. 215).

Мөн Ахлагч МакКонки хэлэхдээ: “Ахлагч нар бол гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэх, Бурханы сүргийг тэжээх, Сүмийн байгууллагад ажиллах, Эцгийн хаант улс дахь мөнхийн амьдрал руу хүмүүсийг удирдан дагуулах үүрэгтэй” гэжээ (in Conference Refort, Lima Peru Area Conference 1977, p.18).

Хэдэн жилийн дараа залуу эрэгтэй бүр Мелкизэдэк Пристийн Зэрэг хүлээн авах боломжтой болно гэдгийг хэл. Тэд сүнслэг зүйлийн гүйцэтгэгч болно.

- Ямар Аароны Пристийн Зэрэгтнүүд Мелкизэдэк Пристийн Зэргийг хүлээн авах вэ? (Бэлтгэсэн ба зохистой нь.)

Жүжигчилсэн
Тоглолт

Залуу эрэгтэйчүүдээр өөрсдийгөө хорин найман настай, гэрлэсэн, гурван хүүхэдтэй гэж төсөөлүүл.

Нэг багийнхан нь хорин найман настай, гэрлэсэн, гурван хүүхэдтэй ба итгэлтэй Мелкизэдэк Пристийн Зэрэгтэн болно. Нөгөө багийнхан нь хорин найман настай,

гэрлэсэн, гурван хүүхэдтэй боловч Аароны Пристийн Зэрэгт прист хэвээр байгаа болно. Багийн бүх гишүүдээр асуултанд хариулуул.

- Та нар гэр бүлдээ одоо болон ирээдүйд ямар сүнсэлг зүйлүүдийг хийж чадах вэ?

Самбарт “Аароны Пристийн Зэрэг” ба “Мелкизэдэк Пристийн Зэрэг” гэсний доор залуу эрэгтэйчүүдийн хариултыг жагсааж бич.

Хоёр талын бүх аавууд гэр бүлийн залбирал ба гэр бүлийн үдэш хийж, хүүхдүүдээ усаар баталж, тэдэнд зөв зарчмуудыг зааж чадна. Хэдий тийм ч Мелкизэдэк Пристийн Зэрэгтэн аавууд өөрсдийн хүүхдэд нэр өгч, адислаж, хүүхдээ төрүүлэхээс нь өмнө юмуу өвчтэй байхад нь авгайдаа адислал өгч, батлагдах үед нь хүүхдүүддээ Ариун Сүнсний бэлэг өгч, хүүхдүүдээ өвчтэй үед нь адислаж, Мелкизэдэк Пристийн Зэрэг хүртээж, гэр бүлтэйгээ ариун сүмд орж, хүүхдүүдээ ариун сүмд холбоход нь гэрчлэгч болж, мөн хүүхдүүдтэйгээ холбогдож чадна.

Түүх ба ярилцлага

Дараах түүхийг уншаад ярь:

“Алс холын тосгонд Сүмийн салбарыг байгуулж хоёр номлогч сүнсээр дүүрэн нэг өдрийг өнгөрөөлөө. Тэд өглөөний 5:30-ид нэгэн гэр бүлд нөхрийг нь тариан талбай руу явахаас нь өмнө хичээл заав. Дараа нь тэд ханан дээр бужигнах цус сорогч шавьжнуудтай тэмцэв. Долоо хоногийн дундуур тэд шүршүүрт орж цэвэр байхдаа зориулан 5 литрийн саванд шүршүүрны толгойг холбон өлгөж, дор нь цементээр шал хийлээ. Тэд ариутгах төхөөрөмж хийж шинэ хайрга, элсийг ус шүүгчидээ хийв. Өдрийн хагаст нь тэд талбай дээрх эрчүүдтэй дараа нь тэдэнд хичээлээ заахын тулд зэрэгцэн ажиллав. Тэд маш их ядарч амрав.

“Гэнэт модон хаалгыг нь сандарсан байдалтайгаар нүдлээ. Тэнд жижигхэн охин уйлж зогсов. Тэр охин гүйсэн учир амьсгаа нь давхцаж байв. Тэд тэр охины уйлах, хурдан шулганах хоёрын хооронд хэлснийг нь ойлгох гэж оролдож байлаа. Түүний аав харанхуйд илжиг унаж яваад ойчиж толгойдоо шархаджээ. Тэр охин хэрэв ахлагч нар түүний аавыг аврахгүй л бол аав нь үхнэ гэдгийг мэдэж байв. Тосгоны хүмүүс энэ үед түүнийг номлогч нар луу авчирч байв. Тэр охин аавынхаа амийг аврахыг гуйгаад дараа нь түүнд туслахаар гүйв.

“Аргагүй аюултай байдал нь тэднийг айлгаж эхлэв. Тэд ямар ч эмч, эмнэлгийн багажгүй тосгонд байлаа. Мөн тэнд холбоо барих утас ч байсангүй. Голын эргийн дагуух шороон зам нь харилцаа холбооны ганц хэрэгсэл нь байсан боловч тэдэнд ямар ч унаа байсангүй.

“Тосгоны хүмүүс тэдэнд итгэж байлаа. Номлогч нар эмнэлгийн ямар ч мэдлэггүй байв. Хэдийгээр тэд толгойны шархыг хэрхэн эмчлэхийг мэдэхгүй ч тэд үүнийг хийж чадах нэгнийг мэдэж байв. Тэд өвдөг сөгдөн бүхнийг ойлгогч Тэнгэр дэх Эцэгтээ байдлыг хэлэн залбирав. Тэд Түүний тусламжгүйгээр тэр хүний амийг аварч чадахгүйгээ ойлгож түүнээс зааварчилгаа гуйв.

“Тэдэнд тэр хүний шархыг цэвэрлэж боогоод адислал өгөх хэрэгтэй гэсэн мэдрэмж бий болов. Нэг хамтрагч нь, ‘Тэр өвчнөө яаж тэвчих вэ? Түүнийг ийм их зовж байхад нь бид яаж шархыг нь цэвэрлэж, түүнийг адислах юм бэ? гэв’.

“Тэд дахин өвдөг сөгдөн ‘Бидэнд эм байхгүй. Бидэнд мэдээ алдуулах тариа байхгүй. Бидэнд юу хийхийг минь зааж өгөөч. Түүнийг адислаач, Аав аа,’ гэж Эцэгт учирлан залбирав.

“Тэднийг босоход шархадсан хүний найзууд нь түүнийг тэдэн дээр авчрав. Хэдий бүдэгхэн лааны гэрэлтэй байсан ч түүнийг маш хүнд шархадсан байгааг тэд харлаа. Тэр маш ихээр зовж байлаа. Тэднийг шархыг нь цэвэрлэж эхлэхэд ер бусын зүйл болов. Тэр нойронд автав. Болгоомжтойгоор сэтгэл түгшин тэд шархыг нь цэвэрлээд шархыг нь хааж шархны лентээр ороов. Тэднийг түүний толгой дээр гараа тавиад адислахад тэр тайвнаар сэрэв. Тэдний залбирал хариулагдаж түүний амь аврагдав. Хүмүүсийн итгэл өсч, Сүмийн салбар хөгжжээ” (Richard G. Scott, in Conference Report, Apr. 1989, p. 46; or Ensign, May 1989, p. 35).

- Энэ нөхцөлд номлогч нар хэрхэн бэлтгэсэн бэ? (Тэд дуулгавартай итгэлтэй пристийн зэрэгтнүүд байсан.)

- Пристийн Зэргийнхээ дуудлагыг биелүүлэх нь та нарыг хэрхэн адисласан бэ?

Мелкизэдэк Пристийн Зэргийг зохистойгоор, хэрэглэхээр бэлтгэсэн хүмүүст гайхамшигт адислалууд зайлшгүй ирнэ. Аароны Пристийн Зэрэгтэн бүр бэлтгэж, зохистой байж Мелкизэдэк Пристийн Зэрэг хүлээн авахыг эрмэлзэх ёстой.

Илтгэл

Хэрэв та тэднийг аавтайгаа юмуу бусад Мелкизэдэк Пристийн Зэрэгтнүүдтэй Мелкизэдэк Пристийн Зэргийн тухай олж мэдүүлэхээр урьдчилан томилсон бол түүнийг нь яриул.

Мелкизэдэк Пристийн Зэрэг Хүлээн Авахад Бэлтгэх нь

Судар ба ярилцлага

Сургаал ба Гэрээ 84:33–40-д пристийн зэргийн тангараг ба гэрээнүүдийн тухай өгүүлсэн байдгийг тайлбарла. Тэр хэсгийг хамтдаа унш. Шаардлагатай бол уншиж байхдаа шүлэг бүрийг тус тусад нь авч ярилц. Ярилцлагандаа дараахыг онцол:

1. Залуу эрэгтэйчүүд хоёр пристийн зэргийн нэгийг нь авчихсан байгаа ба хоёр дахиа авахаар бэлтгэж байгаа болно.
2. Залуу эрэгтэйчүүд пристийн зэргийнхээ дуудлагыг өсгөх ёстой.

- Томруулдаг шилээр юу хийдэг вэ?
- Бид пристийн зэргийнхээ дуудлагыг хэрхэн өсгөж чадах вэ?

“Өсгөх гэдгийг энд томруулах болон нэмэгдүүлэх, сайжруулах гэсэн утгаар хэрэглэсэн болохыг тайлбарла. . . . Бүх хүмүүсийн нүдэн дээр дуудлагаа нэр төртэй, хүндэтгэлтэй болгон дуудлаганд хамаатай үүргээ гайхал төрүүлэм бөгөөд амжилттай байдлаар гүйцэтгэхийг хэлдэг” гэж тайлбарла (Bruce R. McConkie, Mormon Doctrine, pp. 481-82).

Ишлэл

Аароны Пристийн Зэргийн үүрэг хариуцлагыг биелүүлэх гэдэг бол Мелкизэдэк Пристийн Зэрэг авахад бэлтгэх, түүний агуу их хүчийг бусдад үйлчлэхэд ашиглах гол алхам юм. Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл энэ зарчмыг тодруулж хэлэхдээ: “Өнөөдөр Мелкизэдэк Пристийн Зэргийг Мелкизэдэк Пристийн Зэрэгт ахлагч болон илүү өндөр эрх мэдэлтэн болохоор бэлтгэж байгаа зөв шударга Аароны Пристийн зэрэгтэй хөвгүүдэд өгдөг” гэжээ (Conference Refort, Tahiti Area Conference 1976, p. 21).

- Хэрэв Аароны Пристийн Зэрэг та нарыг Мелкизэдэк Пристийн Зэрэгт бэлтгэдэг бол Аароны Пристийн Зэрэгтний хувьд та нар өөрийгөө бэлтгэхийн тулд юу хийж байна вэ?

Мелкизэдэк Пристийн Зэргийг хүлээн авахаар бэлтгэхэд Аароны Пристийн Зэрэг нь залуу эрэгтэйчүүдэд хэрхэн тусалж чадах вэ гэдгийг ярилц. Та дараах санаануудыг ярилцаж болно:

1. Би Бурханы зарим хүчийг зөв хэрэглэж сурч байна.
2. Надад өгсөн хүчинд би хариуцлагатай байж сурч байна.
3. Би ариун ёслол гүйцэтгэж, гэрийн багшаар явж, халамжийн даалгавруудыг биелүүлэн Аароны Пристийн Зэргээр бусдад үйлчлэхийг сурч байна.
4. Би зохистой байж пристийн зэргийн нэмэлт ёслолуудыг хүлээн авахыг сурч байна.

Идэвхтэй, зохистой Аароны Пристийн Зэрэгтэн байх нь залуу эрэгтэйчүүдийг Мелкизэдэк Пристийн Зэргийг шударга, ашигтайгаар үйлдэхэд нь бэлтгэх болно гэдгийг тайлбарла.

Дүгнэлт

Уриалга

Залуу эрэгтэйчүүдэд аавтайгаа юмуу өөр Мелкизэдэк Пристийн Зэрэгтнүүдтэй Мелкизэдэк Пристийн Зэрэгтэй байснаар ирэх адислуудын талаар ярилцахыг уриал. Эдгээр адислалуудыг харуулах онцгой жишээг ярилцаж буй хүмүүсийнхээ амьдралаас олохыг тэднээс хүс.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр гэр доторх патриархын ёсыг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

- Шаардагдах материалууд:
 - Залуу эрэгтэй бүрт судар.
 - Залуу эрэгтэй бүрт харандаа цаас.
 - “Патриархын Ёсны Тухай Та Нар Юу Мэдэх вэ?” тараах материалын хувийг залуу эрэгтэй бүрт бэлтгэ.
 - Залуу эрэгтэйчүүдийн танилцуулах түүх ба ишлэлүүдийг тусдаа цаасан дээр хувилж бэлтгэ (сонголтоор).
-

ТАЙЛБАР

Та нарын зааж буй залуу эрэгтэйчүүд янз бүрийн гаралтай болон нөхцөл байдалтай гэр бүлээс ирсэн байгаа. Заримынх нь аавууд гэр бүлдээ хүчтэй зөв шударга патриарх байгаа. Бусад нь магадгүй идэвхгүй эсвэл Сүмийн гишүүн бус аавуудтай байгаа. Зарим нь аавгүй ч байж магад. Залуу эрэгтэй бүрийн нөхцөлд уян хатан байгаарай. Гэр бүлийнх нь одоогийн нөхцөл байдлаас үл хамааран энэ хичээл бол пристийн зэрэгтэй хүн бүр Их Эзэний хүссэн шиг эцэг мөн патриарх байхаар өөрсдийгөө бэлтгэх ёстой гэдгийг зааж байгааг онцлон хэл.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Асуулт Хариулт

Патриархын Ёс бол Гэр Бүлүүдэд Зориулсан Их Эзэний Төлөвлөгөө Мөн

Залуу эрэгтэй бүрт харандаа ба “Патриархын ёсны талаар та нар юу мэдэх вэ?” гэсэн сорилтын хувийг өг. Мэдэгдэл бүрт нэгээс илүү зөв хариулт байж болох ба хэн ч залуу эрэгтэйчүүдийн хариултыг харахгүй гэдгийг хэл.

Патриархын ёсны талаар та нар юу мэдэх вэ?

- Патриархын ёс гэдэг бол:
 - Патриархын адислал авах тодорхойлолт.
 - Бишопын агуулахаас эд зүйлс авах захиалга.
 - Их Эзэний засаглан захирах тэнгэрлэг тогтолцоо.
- Сүмийн хамгийн чухал байгууллага бол:
 - Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулга.
 - Тэргүүн Зөвлөлийн Чуулга.
 - Гэр бүл
- Гэр бүлийн тань ерөнхийлөн удирдах эрх мэдэлтэн бол:
 - Сүмийн Ерөнхийлөгч.
 - Бишоп.
 - Та нарын аав (аавгүй бол ээж чинь).
- Гэр бүлийнхээ патриархын тэргүүний хувьд эцгийн хүлээх зарим үүрэг бол:
 - Гэр орныхоо ба гэр бүлийнхээ ажил хэргийг зөв зохистой удирдан чиглүүлэх.
 - Гэр бүлийнхнийхээ материаллаг болон сүнслэг хэрэгцээг хангах.
 - Гэр бүлийнхээ асуудлуудын талаар хувийн илчлэлт авахын тулд Их Эзэнийг эрэлхийлэх ёстой.
- Их Эзэний төлөвлөгөөнд:
 - Эрэгтэй эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй.
 - Эрэгтэй хүн пристийн зэрэгтэй учир илүү чухал.
 - Их Эзэн охидоо хөвгүүдийнхээ адил хайрладаг.

6. Эцэг хүн гэр бүлийнхээ тэргүүн нь, учир нь:
 - а. Тэр илүү зохистой ба дадлага туршлагатай.
 - б. Энэ бол түүний мөнхийн дуудлага.
 - в. Тэр ээжийг бодвол шулуун.
7. Хэдийгээр бүх аавууд гэрийнхээ тэргүүн ч гэсэн гэр бүлийнхээ патриархын тэргүүн байснаар ирэх адислалуудыг хүртэхийн тулд тэр:
 - а. Гэр бүлээ удирдахын тулд тэр коллежийн боловсролтой байх ёстой.
 - б. Гэр бүлээ тэжээхийн тулд сайн цалинтай ажилтай байх ёстой.
 - в. Мелкизэдэк Пристийн Зэрэгтэй байж түүнийгээ зөв хэрэглэх ёстой.

Залуу эрэгтэйчүүдийг хариулж дууссаны дараа асуултуудыг чангаар унш. Хариулт бүрийн дараа залуу эрэгтэйчүүдэр дагалдах ишлэлийг уншуулах юмуу өөрөө унш. Ишлэл бүр зөв хариултын утгыг агуулсан байгаа. Ишлэл бүрийг уншсаны дараа зөв хариултыг буюу холбогдох асуултуудын хариултыг тогтоо.

Ишлэл ба ярилцлага

Асуулт 1 (в)

“Их Зээний засаглал бол мөн чанартаа патриарх юм. Гэр бүл бол . . . төв нь юм” (Bruce R. McConkie, *Mormon Doctrine*, 2 дахь хэв, [Солт Лэйк Сити: Bookcraft, 1966], х.559; бичмэл хэсэг). Патриархын гэдэг нь *аавын* гэсэн утгатай. Аав бол гэр бүлээ удирддаг ба гэр бүлийнхээ бусад гишүүдэд пристийн зэргийн адислалуудыг өгдөг.

Асуулт 2 (в)

“Гэр бүл бол цаг зуурын буюу мөнхийн хамгийн чухал тогтолцоо юм. Амьдралын маань зорилго бол өөрсдийнхөө төлөө мөнхийн гэр бүлийн нэгжийг бий болгох явдал юм” (Joseph Fielding Smith, *Deseret News*, 6 Apr. 1971, p. 6A).

Асуулт 3 (в)

“Гэрт ерөнхийлөн удирдах эрх мэдэл нь байнга эцгийн мэдэлд байдаг бөгөөд гэр орон ба гэр бүлийн бүхий л зүйлд үүнээс чухал өөр ямар ч эрх мэдэл үгүй билээ” (Joseph F. Smith, *Gospel Doctrine* [Salt Lake City: Deseret Book Co., 1939], p. 287).

Асуулт 4 (а, б, в)

“Эцгүүд нь гэр орондоо тэргүүлэх ёстойг Бурхан тогтоосон. Эцэг нь хэрэгцээг хангаж, хайрлаж, сургаж, удирдан чиглүүлэх үүрэгтэй” (Ezra Taft Benson, Conference Report, Oct. 1984, p. 6; or *Ensign*, May. 1984, p. 6).

Асуулт 5 (а, в)

“Сүмд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй. Их Эзэн ариун сургаалыг эрэгтэй, эмэгтэй хүмүүст яг адилхан өгсөн. . . . Эрэгтэй, эмэгтэй хүмүүст сайн мэдээний эрх болон шаардлагууд нь ерөнхийдөө адилхан байдаг. Их Эзэн охидоо хөвгүүдийнхээ адил хайрладаг” (John A. Widtsoe, *Evidences and Reconciliations* [Salt Lake City: Bookcraft, 1960], p. 305).

Асуулт 6 (б)

“[Аавын дуудлага] бол хэзээ ч чөлөөлөгдөхгүй мөнхийн дуудлага юм. Сүм дэх дуудлага нь үүний адил чухал, энэ нь тодорхой хугацаатай байдаг ба хожим нь дуудлагаасаа чөлөөлөгддөг. Харин аав гэсэн дуудлага бол мөнхийн ба үүний ач холбогдол цаг хугацааг давсан байдалтай байдаг. Энэ дуудлага нь цаг үе ба мөнхөд зориулагдсан” (Ezra Taft Benson, in Conference Report, Oct. 1987, p. 59; or *Ensign*, Nov. 1987, p. 48).

Асуулт 7 (в)

“Эцэг бүр гэр бүлийн тэргүүн байдаг хэдий ч *нөхөр нь* Мелкизэдэк Пристийн Зэрэг аваагүй, эхнэр нь нөхөртэйгөө ариун сүмд гэрлэж холболт хийлгээгүй мөн хүүхдүүд нь гэрээ хийсэн гэр бүлд төрөөгүй буюу эцэг эхтэйгээ холболт хийлгээгүй бол Хожмын Үеийн Гэгээнтэн гэсэн үгийн шууд утгаар уг гэр бүлийг патриархын гэж нэрлэхгүй” (*A Light unto the World*, Melchizedek Priesthood Course of Study 1967-68, p. 55).

Дэлхийд олон хүмүүс гэр бүл ямар байх ба юу хийх ёстой тухай тунхагладаг гэдгийг тайлбарла. Их Эзэн зорилгодоо нийцүүлэн ааваар тэргүүлүүлсэн патриархын ёсыг

томилсон. Бид Их Эзэний үйлчлэгчдийн тэнгэрлэг зөвлөгөөг санаж аавуудаа патриархын үүрэгт нь дэмжиж байх хэрэгтэй.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны дараах мэдэгдлийг унш:

“Нэгэн залуу миний албан өрөөнд адислал хүсэж нэг удаа ирсэн юм. Тэрээр жаахан асуудалтай байв. . . . Тэр бодолдоо будлиад бас санаа нь их зовсон байлаа. Хэдэн минут ярилцаад би түүнээс ‘Чи ер нь ааваасаа адислал өгөөч гэж гуйж байсан уу?’ гэж асуув. ‘Тэр иймэрхүү юм хийж чадах эсэхийг би мэдэхгүй. Тэр нэг их идэвхтэй биш,’ гэлээ. Би түүнд, ‘гэвч тэр чинь чиний аав, тийм биз дээ?’ ‘Тийм ээ.’ Тэр пристийн зэрэгтэй юу?’ гэж асуув. ‘Тийм ээ, тэр идэвхгүй ахлагч.’ ‘Чи аавдаа хайртай юу?’ гэж намайг асуухад тэр ‘Тийм ээ, тэр бол гэр бүл, хүүхдүүдийнхээ хувьд маш сайн хүн. Би түүнд хайртай’ гэсэн юм. Би ‘Чи түүнтэй тохиромжтой үеийг тааруулж ярилцаад чамд эцгийн адислал өгөх эсэхийг нь түүнээс асуух талаар оролдоод үзэх үү? Болохгүй бол буцаад ир, би чамд дуртайяа тусална’ гэв.

“Ойролцоогоор гурав хоногийн дараа тэр буцаж ирлээ. Тэр, ‘Бэнсон ах аа, тэр манай гэр бүлд тохиолдсон хамгийн сайхан зүйл байлаа’ гэв. Ээж маань миний дүү нартай хамт суугаад нүднээсээ нулимс урсгаж байсан. Мөн тэр сүүлд нь баярласнаа хэлсэн. Аав надад маш сайхан адислал өгсөн. Би тэр нь түүний зүрх сэтгэлээс гарч байсныг хэлж чадна’ гэж тэр нэмж хэлэв” (*God, Family, Country: Our Three Great Loyalties* {Salt Lake City: Deseret Book Co., 1974}, p. 184).

Патриархын Ёс Дахь Бидний Үүрэг

Самбар ба
ярилцлага

Самбарт *Аавыгаа Дэмжих Арга Замууд* гэж бич.

- Гэр бүлийн патриархынх нь хувьд та нар аавыгаа дэмжих ямар ямар арга зам байдаг вэ?

Залуу эрэгтэйчүүдийн хариултуудыг жагсаа. Тэдний хариултанд дуулгавартай байх, түүнтэй сонирхол, асуудлаа хуваалцах, цагаа хамтдаа өнгөрөөх, эцгийн адислал гуйх, түүнээс зөвлөгөө удирдамж авч түүнийг нь мөрдөх, түүнийг сайн мэдэх, түүнд хайр талархлаа үзүүлэх, түүнийг зоригжуулах, гэр бүлийн үдшээр түүнийг дэмжих болон гэрийнхэндээ тусалж, өөдрөг байх зэрэг багтана.

Самбар дээрх жагсаалтыг дахин уншаад залуу эрэгтэйчүүдээс энэ зүйлсийг хийхийн тулд тэд тодорхой юу хийж чадахыг нь асуу. Байж болох асуултууд:

- Эцэгийн адислалыг та нар хэзээ асууж болох буюу ёстой вэ?
- Та нар аавыгаа хэрхэн илүү сайн мэдэж авах вэ?
- Гэр бүлийн үдшийн үеэр аав чинь ямар дэмжлэгт илүү баярлах вэ?
- Та нар аавтайгаа хамт байх цагийг хэрхэн бий болгож болох вэ?
- Сонирхол ба асуудлаа хэзээ болон хаана хуваалцаж болох вэ?

Судар ба ярилцлага

Зарим хөвгүүд аавынхаа сул тал ба алдаануудыг харсан учир тэд аавтайгаа ярилцаж чадахгүй байж магадгүй. Залуу эрэгтэйчүүдээр 1 Нифай 16:18–27 ба 30–31-ийг уншуул.

Нифайгаас бусад нь Лихай болон өөр бүх хүмүүс Их Эзэний эсрэг гомдоллосон гэдгийг хэл.

- Гомдоллохын оронд Нифай юу хийсэн бэ (23-р шүлгийг үз)?
- Хэдийгээр түүний аав Лихай хүртэл Их Эзэний эсрэг гомдоллосон ч Нифай яагаад түүнээс зөвлөгөөг хайсаар байсан бэ (23-р шүлгийг үз)? (Нифай патриархын ёсыг сайн мэдэж байсан. Лихай Нифайн аав хэвээрээ байсан. Нифай Лихайн хүү хэвээрээ байсан. Нифай аавыгаа хүндлэх зарчимд дуулгавартай байж, түүний зөвлөгөөг эрэх нь итгэлээ үзүүлж буй хэрэг ба гомдоллох нь зөвхөн ууртайгаа болон тааламжтай бус байдлаа харуулах зүйл ба Сатаныг түүн дээр ажиллахыг урина гэдгийг мэдэж байсан.
- Нифайн хийсэн зүйлийн үр дүн юу байсан бэ?

Самбар ба
ярилцлага

- Хэрэв Нифай ах нар шигээ аашилсан бол юу болох байсан бэ?
- Энэ дэлхийг арван таван жилийн дараа ямар байх талаар төсөөлөхийг хичээ. Өв тэгш аав ба патриарх ямар байж болох вэ?

Самбарт *Өөрийгөө Зохистой Патриарх Болгохоор Бэлтгэх Арга Замууд* гэж бич.

• Ирээдүйн гэртээ та нар өөрсдийгөө зохистой патриарх болгохоор бэлтгэхэд ямар ямар арга зам байдаг вэ? (Самбарт залуу эрэгтэйчүүдийн санаануудыг бич. Тэдний хэлж болох санаануудад Аароны Пристийн Зэргээ дээдлэх; аавуудаа, гэрийн багш нараа болон бусад пристийн зэрэгтнүүдийг тэд хэрхэн пристийн зэргээ ашиглаж байгааг харах; судар дээрх хүмүүсийн жишээнүүдийг судлах; Мелкизэдэк Пристийн Зэрэгт томилогдохдоо бэлтгэх; сайн эцэг болох дадлуудыг суралцах зэрэг багтана.)

Залуу эрэгтэйчүүдийн гаргасан санаануудыг ярилц. Дараах асуултууд орж болно:

- Итгэлтэй Мелкизэдэк Пристийн Зэрэгтэн хүнд ямар ямар чанарууд байдаг гэж та нар бодож байна?
- Сайн эцэг эхэд ямар сайн чанарууд байна гэж та нар бодож байна?
- Эдгээр чанарууд байдаг ямар хүнийг та нар мэдэх вэ?
- Судрын ямар хүмүүст ийм чанарууд байсан вэ?

Түүх

Залуу эрэгтэйчүүдээр дараах түүхийг уншуулаад тэднээс дараах асуултуудыг дотроо бодохыг хүс:

- Энэ түүхэнд гарч байгаа аавтай адил болохын тулд залуу эрэгтэй хэрхэн бэлтгэж болох вэ?
- Энэ пристийн зэрэгтэн Сүнстэй нэгэн хэмнэлд байхын тулд хэрхэн амьдрах ёстой байсан бэ?

Ахлагч Брус Р. МакКонки дараах түүхийг ярьсан юм.

“Алимны цэцэрлэг дундуур морьтой давхиж байсан маань бүр хүүхэд насны маань дурсамжуудын нэг юм. Тэр морь их номхон, бас сургууль сайтай байсан бөгөөд би эмээлтэй явахад аюулгүй байх гэж бодсон.

“Гэвч нэг өдөр морь маань ямар нэг юмнаас айсан бололтой цэцэрлэг дундуур үргэн давхисан юм. Би эмээлийн хажуу дахь зөөлөн оосорноос барьсан боловч нэг хөл маань дөрөөний завсраар халтираад орчихлоо. Би бараг тасрах гэж байсан суран оосорноос дүүжигнэж байлаа. . . . Биеийн жин маань оосрыг тасалчихаар байсан боловч яагаад ч юм нэг хэсэг барьсан юм. Өөр ямар нэгэн огцом хөдөлгөөн морийг үргээж сурыг тасалбал энэ нь миний гараас мултарч дөрөөнд орооцолдсон хөлтэйгөө чирэгдэж хүнд гэмтэл, үхэлд ч хүргэж мэдэх байлаа.

“Гэнэт морь зогсож би хэн нэг нь хазаараас чанга барьж дагжсан амьтныг тайвшруулахыг оролдож байгааг мэдсэн юм. Нэн даруйхан аавын маань гар намайг өргөн авлаа.

“Юу болсон бэ? Үргэсэн мориныхоо доогуур халтирч орохын өмнө намайг аврахаар эцгийг минь ямар хүчин ирүүлсэн юм бэ?

“Аавыг гэртээ сонин уншиж байхад нь Ариун Сүнс “Цэцэрлэг рүү оч” гэж түүнд шивнэжээ.

“Тэр ямар гэдгийг нь мэдэхийг хүсэж, эргэлзэлгүй шууд гүйсэн. Ямар учраас цэцэрлэг рүү гүйж очсоноо мэдээгүй хэрнээ давхиж байгаа морийг хараад би энэ морийг зогсоох ёстой гэж бодсон.

“Тэр үүнийг хийж намайг олсон. Би ингэж аюултай гэмтэл, үхэх аюулаас аврагдсан юм” (“Hearken to the Spirit,” *Friends*, Sept. 1972, p. 10).

Түүх уншихаас өмнө өгсөн асуултынхаа хариултуудыг залуу эрэгтэйчүүдтэй ярилц. Ариун Сүнс Ахлагч МакКонкийн аавд гэр бүлээ хамгаалах үүргээ биелүүлэхэд нь

тусалсан ба аавуудын хувьд тэд үүний адил тусламж авахын тулд өөрсдийгөө сүнслэгээр бэлтгэх ёстойг онцол.

Дүгнэлт

Гэрчлэл

Хэрэв цаг гарвал та Сүнсний зааврын дагуу танай гэрийн патриарх болох эцгийнхээ талаар сэтгэгдлээ эсвэл өөрөө гэрийнхээ патриархын хувьд ямар агуу хариуцлага хүлээдэг тухай ярих буюу залуу эрэгтэйчүүдээс аавуудынхаа талаар тэд ямар сэтгэгдэлтэй байдгийг нь яриулж болно.

Уриалга

Залуу эрэгтэйчүүдийг аавуудыгаа тэдний гэрийн патриархын хувьд дэмжих нэг замыг сонгоод ирэх долоо хоногт түүнийг хийхийг уриал. Мөн тэднээс ямар патриарх болохыг хүсэж буйгаа бодоод тэр тэнгэрлэг хариуцлагад бэлтгэж эхлэхийг хүс.

Патриархын Ёсны Тухай Та Нар Юу Мэдэх Вэ?

1. Патриархын ёс гэдэг бол:
 - а. Патриархын адислалаа авах тодорхойлолт.
 - б. Бишопын агуулахаас эд зүйлс авах захиалга.
 - в. Их Эзэний засаглан захирах тэнгэрлэг тогтолцоо.
2. Сүмийн хамгийн чухал байгууллага бол:
 - а. Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулга.
 - б. Тэргүүн Зөвлөлийн Чуулга.
 - в. Гэр бүл
3. Гэр бүлийн тань ерөнхийлөн удирдах эрх мэдэлтэн бол:
 - а. Сүмийн Ерөнхийлөгч.
 - б. Бишоп.
 - в. Та нарын аав (аавгүй бол ээж чинь).
4. Гэр бүлийнхээ патриархын тэргүүний хувьд эцгийн хүлээх зарим үүрэг бол:
 - а. Гэр орныхоо ба гэр бүлийнхээ ажил хэргийг зөв зохистой удирдан чиглүүлэх.
 - б. Гэр бүлийнхнийхээ материаллаг болон сүнслэг хэрэгцээг хангах.
 - в. Гэр бүлийнхээ асуудлуудын талаар хувийн илчлэлт авахын тулд Их Эзэнийг эрэлхийлэх ёстой.
5. Их Эзэний төлөвлөгөөнд:
 - а. Эрэгтэй эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй.
 - б. Эрэгтэй хүн пристийн зэрэгтэй учир илүү чухал.
 - в. Их Эзэн охидоо хөвгүүдийнхээ адил хайрладаг.
6. Эцэг хүн гэр бүлийнхээ тэргүүн нь, учир нь:
 - а. Тэр илүү зохистой ба дадлага туршлагатай.
 - б. Энэ бол түүний мөнхийн дуудлага.
 - в. Тэр ээжийг бодвол шулуун.
7. Хэдийгээр бүх аавууд гэрийнхээ тэргүүн ч гэсэн гэр бүлийнхээ патриархын тэргүүн байснаар ирэх адислалуудыг хүртэхийн тулд тэр:
 - а. Гэр бүлээ удирдахын тулд коллежийн боловсролтой байх ёстой.
 - б. Гэр бүлээ тэжээхийн тулд сайн цалинтай ажилтай байх ёстой.
 - в. Мелкизэдэк Пристийн Зэрэгтэй байж түүнийгээ зөв хэрэглэх ёстой.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр дадлага чадвартай болоход бэлтгэх нь хэрхэн илүү сайн номлогч болоход нь туслах тухай ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Залуу эрэгтэй бүрт харандаа цаас.
2. Самбар буюу үзүүлэн дээр дараах ишлэлийг бичээд хичээлийн турш үзүүл.

“Та нар шийдмэг, үр нөлөөтэй номлогч байх уу эсвэл ердөө л нэг онцгойлон адислагдсан номлогч байх уу?” Энэ нь та нарын бэлтгэлээс шалтгаална” (Spencer W. Kimball, “Advice to a Young Man: Now Is the Time to Prepare,” *New Era*, June 1973, p. 8).
3. Бишопын зөвлөлийн зөвшөөрөлтэйгөөр саяхан буцаж ирсэн номлогч эсвэл бүрэн цагийн номлогчоор номлолын ажилд хэрхэн бэлтгэх тухай товчхон яриулахаар урьдчилан зохион байгуул. (Түүнд зөвхөн гурваас дөрвөн минут ярихыг урьдчилан сануул. Хэрэв та номлолд явсан бол та өөрөө яриа өгч болно.) Та тэр номлогчид хичээл дэх бэлтгэлийн жагсаалтыг үзүүлбэл тэр ярих зүйлийнхээ талаар санаа авах болно. Тэр ердийн өдөр хэдэн цаг ажилладаг болох, тэр үедээ юу хийдэг, хэдэн цаг суралцдаг, юуг суралцдаг, хэн түүний хоолыг бэлтгэж хувцсыг засаж сэлбэдэг, тэр бүсдээ хэр их явсан, номлолд нь хэр их мөнгө сард зарцуулагдаж байсан тухай ярьж болно. Зарим зүйл нь номлол бүрт ялгаатай боловч тэр ярианаас залуу эрэгтэйчүүд бүрэн цагийн номлолын үйлчлэлд хэрэгцээтэй дадлага бэлтгэлийг олж харах болно.
4. Хэрэв танай бүсэд *Family Home Evening Video Supplement 2* (53277) байгаа бол “Номлогчийн Ажил: Бидний Хамгийн Агуу Үүрэг” гэсэн 14 дэх хэсгийг үзүүл.

ТАЙЛБАР

Залуу эрэгтэйчүүд бүрэн цагийн номлолд бэлтгэх олон зүйлийг хийж чадна. Энэ хичээлийн зорилго нь залуу эрэгтэйчүүдэд бэлтгэх хэрэгтэй гэдгийг мэдүүлж бэлтгэх зарим тодорхой зөвлөгөө өгөхөд оршино. Залуу эрэгтэйчүүд өөрсдөө бодож үзээд зөвлөгөөнүүдийг хэрэгжүүлж эхлэх магадлалтай. Хэдэн залуу эрэгтэй оролцохоос шалтгаалан та нар бүгдээрэнг нь ярилцлагад оролцуулах хэрэгтэй.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Илтгэл

Бүрэн Цагийн Номлолын Үйлчлэл нь Маш Олон Талын Бэлтгэл Шаарддаг

Саяхан буцаж ирсэн номлогч (эсвэл танай бүсэд үйлчилж байгаа бүрэн цагийн номлогч)- оор номлолын өдөр тутам хийдэг зүйлийн талаар бага хэмжээний яриа өгүүл. Яриа нь гурав, дөрвөн минутаас илүүгүй байх ёстой. Энэ яриа нь сүнслэг тохиолдлуудаас илүү номлолын ажлын практик тал дээр төвлөрсөн байх ёстой.

Илүү сайн бэлтгэгдсэн залуу эрэгтэйчүүд номлогч болохдоо цагаа илүү үр бүтээлтэйгээр ашиглаж чадна гэдгийг тайлбарла.

Самбар ба ярилцлага

Бүрэн цагийн номлолын ажлын практик хэрэгцээний тухай залуу эрэгтэйчүүд сонсоод тодорхой хэсгүүдэд одооноос хэрхэн илүү сайн бэлтгэж чадахыг нь тэднээс асуу. Самбарт залуу эрэгтэйчүүдийн хариултыг бич. Тэдний хариултанд мөнгө санхүү, биеийн эрүүл мэнд, нийгмийн харилцаа, ажиллах ба сурах зуршил, хэлний чадвар, гэр ахуйн чадвар, хувцаслалт ба ариун цэвэрч байдал зэрэг багтаж болно.

Та нар дараах асуултуудыг ашиглан хариулт болгоны чухал болох талаар товчхон ярилцаж болно.

Ишлэл

- Та нар олсон мөнгөөрөө өөрийн номлолыг санхүүжүүлэх боломжтой бол та нарт ямар санагдах вэ? Хэн нэгэн нь та нарын зардлыг төлснөөс илүүгээр номлолоо үнэлэх үү?
- Номлолд бие сайтай байх нь яагаад чухал вэ? Энэ ажилд биеийн байдлаар тохироогүй номлогч өөрийгөө зовоохоос гадна хамтрагчаа ч зовоох болно гэдгийг сануул.
- Хэрэв та нар энэ дэлхийд өөрийгөө хэн нэгнээр төлөөлүүлэхээр хайж байгаа бол та нар түүнд ямар чанарууд байгаасай хэж хүсэж байна вэ? Та нар түүнийг бусад хүмүүст өөрийгөө хэрхэн ойлгуулахыг хүсэж байна вэ?
- Зарим номлогч нар тэд номлолын талбарт очсоныхоо дараа сайн ажиллах зарчмыг хөгжүүлнэ гэж боддог. Энэ нь ямар уршигтай вэ?
- Хэрэв сурсан хэлээр тань та нарын дуудагдсан номлолд ярьдаггүй байх юм бол энэ нь хэр үнэ цэнэтэй байх вэ?

Ерөнхийлөгч Гордон Б. Хинклийн дараах ишлэл энэ асуултанд хариулахад туслах болно.

“Хэрэв та нар боломжтой бол гадаад хэл сур. Магадгүй та нарыг хэзээ ч хэлийг нь мэддэг газар дуудахгүй байж болох боловч хэл сурах нь та нарт өөрийнхөө хэлийг болон та нараас суралцахыг хүссэн өөр хэлийг илүү сайн ойлгох чадварыг өгнө” (Conference Report, Apr. 1982, p. 63; or *Ensign*, May 1982, p. 42).

- Цэвэр цэмцгэр болон сайхан хувцаслах нь номлогчийн хувьд та нарт ямар нөлөөтэй байх вэ? Энэ нь та нарын өөртөө итгэлтэй байдал, та нарын хамтрагч, биеийн эрүүл мэнд, мөн бусдад үзүүлэх үлгэр дууриалалд ямар үр нөлөөтэй байх вэ?

Бүлгээр хийх
ярилцлага

Аароны Пристийн Зэрэгтнүүд Одооноос Эхлэн Бүрэн Цагийн Номлолд Бэлтгэх Ёстой

Залуу эрэгтэйчүүдийг жижиг жижиг бүлэгт хуваа. Бүлэг бүрт самбарт бичсэн зүйлүүдээс нэг ба түүнээс илүүг хуваарилж өг. Илүү сайн номлогч болохын тулд тэд тэр зүйлийн талаар хэрхэн өөрсдийгөө бэлтгэж чадах тухай хоорондоо ярилцахыг хүс. Залуу эрэгтэй бүрт цаас харандаа өгөөд бүлгийнхээ гаргасан санаануудыг тэмдэглэж авахыг хүс. Бүлэг бүрийн нэг гишүүнээр тэр бүлгийг удирдуул. Тэдэнд ярилцахад нь арван минут өг. Тэгээд бүлгийн ахлагчаар тэдний ярилцсан зүйлийнх нь талаар илтгүүл. Хэрэв цаг гарвал залуу эрэгтэйчүүдээр эдгээр санаануудыг хэлэлцүүл. Дараах зүйлүүдийг онцол:

Мөнгө Санхүү

1. Хэрэв та нар мөнгөний хадгаламжгүй бол одооноос эхлэн тогтмол мөнгө хадгалж эхэл. Хэдий бага ч гэсэн өнөөдөр мөнгөө цааш нь хадгал. Тэгээд та нар мөнгөтэй болохоороо өөрийнхөө номлолын мөнгөн хадгаламж руу ядаж хэсгийг нь хий.
2. Цагийн ажил хийж олсон илүү мөнгөө хадгал.
3. Хувийн сахилга баттай бол. Өөрөө төсөв гаргаж түүнийгээ мөрд.

Биеийн Эрүүл Мэнд

1. Тогтмол дасгал хийж эхэл.
2. Тэжээллэг хоол унд ид.
3. Хангалттай унтаж бай. Залуу эрэгтэйчүүдээр Сургаал ба Гэрээ 88:124-ийг уншуулж энэ санааг батжуул.

Нийгмийн харилцаа

1. Ёс зүйн наад захын дүрмүүдийг сур.
2. Олон төрлийн хоол идэж сур.

3. Цагаа барь.
4. Хүмүүстэй нэг удаа уулзаад нэрийг нь тогтоох дасгал хий.

Ажиллах ба Сурах Зуршил

1. Өдрийг зүгээр өнгөрөөлгүй өдөр бүр өөрийнхөө дургүй ямар нэг зүйлийг хий. Ийм замаар та нар хувийн сахилга батаа дээшлүүлж чадна.
2. Сургуулиас ирэнгүүтээ гэрийн даалгавраа хойшлуулалгүйгээр хий.
3. Сүмийнхээ үүргийг итгэлтэйгээр гүйцэтгэ.
4. Өөрийгөө сургууль болон семинарт зориул. Хэрэгцээнээс нь илүүг унш.
5. Өдөр бүр судраас уншдаг зуршлыг хөгжүүл.
6. Номлогчийн ярилцлагаас судруудыг нь цээжил.
7. Долоо хоног бүр зорилго тавьж түүндээ хүрэх төлөвлөгөө гаргаж цагийг зориул.

Хэлний Чадвар

1. Сургууль дээрээ хэлний хичээлд суу.
2. Хэрэв та нар хэл сурч эхэлсэн бол түүнийгээ илүү чармайлттай суралц.
3. Та нарын сурч байгаа хэлээр ярьдаг хүмүүсийн соёлтой танилц. Залуу эрэгтэйчүүдээр Сургаал ба Гэрээ 90:15-ыг уншуул.

Гэр Ахуйн Чадвар

1. Хоол хийж болон хоолны цэс төлөвлөж сур. Дэлгүүрт худалдаа хий.
2. Өөрийнхөө хувцсыг оёж, нөхөж сур.
3. Өөрийнхөө хувцсыг угааж, индүүдэж сур.
4. Тэжээллэг бөгөөд амархан бэлтгэж болох хоолны жор цуглуул.

Хувцаслалт ба Цэвэрч Байдал

1. Хувийн цэвэрч байдал ба цэвэрхэн хувцаслалтын зарчмуудаар дадлагажиж сур.
2. Одооноос эхлэн Ням Гарагийн хувцаслалт болон үсний засалт зэрэг номлогчийн жишгийг хүндэтгэлтэйгээр судал.
3. Бусдаар хэлүүлэлгүйгээр өөрийнхөө өрөөг цэвэр байлга.

Үйл ажиллагаа

Залуу эрэгтэйчүүдээр тэдэнд байгаа цаасных нь ард чөлөөт цагаараа юу хийдгийг нь бичүүл. Тэгээд дараачийн асуултуудад өөрсдөөр нь хариулуул.

- Эдгээр хийдэг зүйлээс минь аль нь намайг номлолд бэлтгэж байна вэ?
- Би номлолд бэлтгэхдээ цагаа хэрхэн илүү үр ашигтай ашиглаж чадах вэ?

Та нар буцаж ирсэн номлогчоос хэрэв тэр одооноос эхлэн номлолдоо бэлтгэх байсан бол ямар зүйлийг бэлтгэх тухай асууж болно.

- Одооноос эхлэн номлолд бэлтгэх нь яагаад чухал вэ?

Ишлэл

“19 жилийн турш номлолд явахаар төлөвлөж бэлтгэсэн залуу эрэгтэйчүүд илүү өгөөжтэй, илүү үр дүнтэй ба илүү амжилт гаргаж үйлчлэхэд олон хүмүүс Сүмд орох ба тэд илүү урам зориг бий болгож гинжин хэлхээ үүсгэнэ. Ийм гинжин хэлхээ шиг хүмүүст болон хүсэл сонирхолд нь нөлөөлдөг өөр ямар нэгэн зүйл байдаг болов уу?” (Spencer W. Kimball, “ President Kimball Speaks Out on Being a Missionary,” New Era, May 1981, p. 48).

Ишлэл

“Их Эзэний ажилд та нарын хамгийн сайнаа өгөх чадвар хэрэгтэй. Одоо энэ үйлчлэлд бэлтгэх цаг мөн” (Gordon B. Hinckley, Conference Report, Apr. 1982, p. 63; or *Ensign*, May 1982, p. 42).

	Дүгнэлт
Зөвлөхийн танилцуулга	Номлол бол залуу эрэгтэйчүүдэд тулгарах гайхамшигт сорилт гэдгийг хэл. Энэ нь маш их бэлтгэл шаардсан хүнд ажил. Гэвч номлолын бэлтгэл нь залуу эрэгтэйчүүдийн цаашдын амьдралын бэлтгэл болдог.
Ишлэл	“Бидний бошиглогч удирдагч Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл, ‘Номлолд буй залуу эрэгтэй бүр’ номлолын талбарт өнгөрөөсөн саруудаас хамаагүй хол хардаг. Та нар буцаж ирэхдээ илүү сайн бишоп, илүү сайн гадасны ерөнхийлөгч, илүү сайн нөхөр, илүү сайн аав ба ямар ч байдлаар энэ амьдралд болон ирэх амьдралд илүү сайн байх болно” гэжээ (J. Thomas Fayns, in Conference Report, Apr. 1977, p. 56; or Ensign, May 1977, p. 40).
Уриалга	Залуу эрэгтэйчүүдээр тэдний хийж чадна гэж бодож байгаа хоёр, гурван зүйлийг жагсаалтаас сонгуул. Цаасных нь ар талд түүнийг бичүүл. Сонгож авсан зүйлээрээ энэ долоо хоногоос эхлэн номлолд бэлтгэж эхлэхийг тэдэнд уриал. Хэрэв та нар номлолд яваад буцаж ирсэн бол одооноос эхлэн номлолд бэлтгэхийн чухлын талаар өөрийнхөө гэрчлэлийг хуваалцаж хичээлээ төгсгө.

ҮЙЛ АЖИЛЛАГАА Та нар залуу эрэгтэйчүүдийг залуу эмэгтэй болон тэдний ээжүүдтэй уулзуулж хэрхэн хоол хийх, оёх, индүүдэх зэрэг чадваруудаар дадлага хийлгэх үдшийн үйл ажиллагаа төлөвлөж болно. Мөн та нар өөр өөр практик зүйлсийг оролцуулсан “Номлолд Бэлтгэх Олимпын Тоглолт” гэсэн тэмцээн зохиож болно.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр ажлын үнэ цэнэд талархах болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаа.
2. Хичээл эхлэхээс өмнө та зарим залуу эрэгтэйчүүдээр ажлын тухай ишлэл уншуулахаар томилж болно.

ТАЙЛБАР

Биеийн, оюун ухааны, бүтээлч болон сүнслэг зэрэг аливаа сонирхууштай зүйл нь чармайлтгүйгээр хийгддэггүй. Залуу эрэгтэйчүүд ажил бол зугтаж байх уйтгартай хүнд зүйл биш харин өсөх, хөгжих, үйлчлэх, дэвших боломж юм гэдэг ойлголттой болж ангиас гарах ёстой.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Залуу эрэгтэйчүүдийн танилцуулга

Оршил

Урьдчилан томилогдсон залуу эрэгтэйчүүдээр дараах ишлэл тус бүрийн утгыг товч тайлбарлуул (Бүх ишлэлийг Richard Evans' Quot Book [Salt Lake City: Publishers Prees, 1971]-аас авав).

“Би амьдралдаа өдөр тутмын ажил хэзээ ч хийж байгаагүй. Энэ бүхэн нь хөгжилтэй явдал байдаг байсан” (Thomas Edison [p. 43]).

“Бурхан бидэнд бүх зүйлийг хөдөлмөрийн үнэ цэнээр өгдөг” (Leonardo da Vinci [p. 44]).

“Ажил бол сүнслэг хэрэгцээ” (Neal A. Maxwell [p. 50]).

“Хүн бүр энэ дэлхийд ажил хийснээр болон тэр ажлаа хэрхэн хийж байгаагаас аз жаргалыг олох болно” (Brigham Young [p. 50]).

“Ажиллах боломж бол бэлэг юм” (David O. McKay [p. 46]).

Ярилцлага

- Хэрэв бүх хүмүүс ажил хийхээс татгалзвал юу болох вэ?

Юу болох тухай тодорхой жишээ өгүүлэн залуу эрэгтэйчүүдээр энэ тухай хэдэн минут ярилцуул.

Судар унших ба ярилцлага

Дараах судруудыг уншуулаад тэмдэглүүл. Үүнд: Эхлэл 3:19; Сургаал ба Гэрээ 42:42; 68:30; 75:28–29.

- Их Эзэн ажлын талаар юу бодож байна вэ?

Ишлэл

“Амьдралд өөрсдийнхөө болон бусдын хийсэн ажлыг хэрэглэхгүйгээр явах зам үгүй. Бид хэн нэгний ажлыг хэрэглэхгүйгээр идэж чадахгүй. Бид хэн нэгний ажилгүйгээр аялж чадахгүй. Бид хэн нэгний хийсэн ажлыг хүлээн зөвшөөрөхгүйгээр ямар ч үйлчлэлийг хүлээн зөвшөөрч, ямар ч зүйлийг хэрэглэж чадахгүй. Ямар мөн чанартай байх нь, аль эсвэл хүн төхөөрөмжөөр юу хийдэг байх нь хамаагүй, гагцхүү хөдөлмөр л эцсийн бүтээгдэхүүнийг хүмүүст авчрах үйл явцад оролцдог” (Richard L. Evans, *The Everlasting Things* [New York: Harper, 1957], p. 71)

Ажил Биднийг Агуу Их Хариуцлага Хүлээхэд Бэлтгэдэг

Ишлэл

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболлын хэлсэн дараах мэдэгдлийг унш:

“Би аавынхаа зааснаар Кастайл савангаар морины тоног угаах, дараа нь хамгаалахын тулд тосолдог байсандаа талархдаг. Би гадсан хашаа, усны сав, сүйх

Самбар ба
ярилцлага

тэрэгний пин, үр тарианы агуулах, тэргэнцэр, чингэлэг, эцэст нь байшин будаж сурсан. Тэгээд үе үе гар маань цэврүүтэхэд үүнийх нь төлөө би харамсдаггүй байсан” (in Conference Report, Apr. 1976, p. 172; or *Ensign*, May 1976, p. 126).

- Спэнсэр В Кимболл хүүхэд ахуйдаа хийсэн ажилдаа хэрхэн хандсан гэж та нар бодож байна?
- Спэнсэр В.Кимболлыг сүүлд нь номлогч, Төлөөлөгч ба Бошиглогч болоход бэлтгэхэд нь тусалсан ямар юмыг эдгээр зүйлүүдээс сурсан гэж та нар бодож байна? (Байж болох хариултанд хариуцлага хүлээх, ажлаа дуустал хийх, зөвлөгөөг дагах, хийж гүйцэтгэсний дараах бахархал, бусдад үйлчлэх, чадварууд хуримтлуулах зэрэг багтана.)

Хариултуудыг товчлон самбарт бич.

- Та нар ямар төрлийн ажил хийдэг вэ?
- Та нар болон та нарын гэр бүлийг ажил хэрхэн адисласан бэ?

Шударга Болон Шаргуу Хөдөлмөр Зан Чанарыг Төлөвшүүлдэг

Түүх ба ярилцлага

Дараах түүхийг унших буюу өөрийнхөө үгээр ярь:

“Манай Юта хотод Каунтисийнхан хаанаас ирснийг мэдэхгүй ба тэр эмэгтэйн яг таг англи хэл нь түүнийг Америкийн уугуул иргэн биш гэдгийг тодорхойлдог байв. Тэр эмэгтэйн байшингийн хэмжээ, бидний мэдэх зүйлсээс харахад тэр маш баян хүн шиг байдаг боловч хэзээ ч зочломтгой байгаагүй ба хэрэв тэр гэртээ байвал халдах боломжгүй гэдгээ тодорхой мэдэгдүүлдэг байв.

“Каунтис эгч үргэлж таяг тулан явж тэр нь тулгуур болохоосоо илүү өөрөөсөө залуу хүмүүст сургамж өгөхөд нь хэрэг болдог байв. Хааяа хааяа манай хөршийн хүүхдүүдэд тэр хэрэгцээгээ үзүүлдэг юм шиг. Хурдан гүйх буюу сэрэмжтэй байснаараа би түүнд баригддаггүй байв. Гэвч нэг өдөр би арван гуравтай байхдаа түүний бутан дундуур замаа товчилж яваад таяг нь миний толгойг цохиж хүрэхээр ойрхон ирэв. Яая, гэж би хашгирааад бараг метр шахуу үсрэв.

“Тэр, залуу хүү минь би чамтай ярилцмаар байна’ гэж хэлэв. Би түүнээс талбайг нь хөндлөн гарсан тухай муу лекц сонсох байх гэж бодсон боловч тэр бодлоо өөрчилсөн бололтой инээмсэглэсэн царайгаар над руу харав.

“Чи чинь тэр гудамжны уд модтой ногоон байшинд амьдардаг билүү?”

“Тийм ээ, хатагтай.’

“Чи зүлгээ арчилдаг уу? Усалдаг уу? Тайрдаг уу? Засдаг уу?”

“Тийм ээ, хатагтай.’

“Сайн байна. Би цэцэрлэггүй ч болсон. Дөрөв дэх өдрийн өглөө манайд ирээрэй, битгий өөр ажилтай гэж хэлээрэй, би чамайг дөрөв дэх өдөр бүр хийх юмгүй байдгийг харсан шүү.’

“Каунтис тушаал өгч би түүнийг нь биелүүлэв. Би дөрөв дэх өдөр ирэхгүй байж зүрхэлсэнгүй. Би түүний сэтгэл ханатал зүлгийг гурван удаа хадаж дараа нь тэр намайг дөрвөн хөллүүлэн миний өвдгийг зүлэг шиг ногоон болтол зэрлэг зулгаалгав. Дараа нь тэр намайг үүдэндээ дуудав.

“За, залуу хүү минь, Чи өнөөдрийнхөө ажлын хөлсөнд хэдийг авмаар байна?”

“Би мэдэхгүй, магадгүй тавин цент.’

“Чиний өөрийгөө үнэлсэн чинь энэ үү?”

“Тийм ээ, хатагтай. Ойролцоогоор.’

“Маш сайн байна. Чиний өөрийгөө үнэлсэн тавин цент чинь энэ, харин энэ бол би чамайг ажиллуулснаар олсон нэг доллар тавин цент май ав. Одоо би чамд чи бид хоёр хэрхэн хамтран ажиллах талаар ярьж өгье. Маш олон хүн байдаг шиг өвс хадах олон арга бий, арга бүр нь нэг центээс таван доллар хүртэл үнэлэгдэж болно. Тэгэхлээр өнөөдрийн хувьд гурван долларын ажил хийхсэн гэж үзье. Дөрвөн

долларын ажил бол маш төгс, хэрэггүй зүйлдээ гаргах цаггүйгээр зүлэг хадах болно. Таван долларын ажил, за даа энэ бол боломжгүй зүйл хоёулаа энэ талаар мартъя. Одоо тэгэхээр долоо хоног бүр би чамд өөрийгөө үнэлсэн тэр мөнгийг чинь өгөх болно.'

"Дараачийн долоо хоногт тэр дөрвөн долларыг нь авна даа гэж шийдсээр энэ амьдралдаа авч үзээгүй тэр их мөнгө болох хоёр доллараа барьсаар би тэднийхээс явсан юм. Гэвч би гурван долларт хүрсэн ажил хийж чадсангүй. Тэдний талбай дээгүүр хоёр дах удаагаа тойрч байхад миний хүсэл буурч эхэлсэн юм.

"Дахиад л хоёр доллар уу? Ингэж хийсэн ажил чинь чамайг ажлаас чинь салгана шүү залуу хүү минь.'

"Тийм ээ, хатагтай, дараагийн удаа би илүү сайн хийнэ ээ.'

"Тэгээд яагаад ч юм бэ би чадсан юм. Хамгийн сүүлчийн удаа зүлгийг тойрохдоо би маш их ядарч байсан боловч өөрийгөө зоригжуулж чадав. Тэр сэтгэл сэргээсэн мэдрэмжийнхээ хүчээр би Каунтис эгчээс гурван доллар авна гэж ямар ч эргэлзээгүй асуусан юм.

"Дараагийн дөрөв таван долоо хоног би гурав, гурван доллар тавин центийн ажил хийсэн юм. Би түүний зүлэгтэй танил болно жаахан өндөр эсвэл намхан газруудыг, богинохон тайрах хэрэгтэй буюу захаараа зүүн тийш богинохон цэцэрлэгийг тахирласан бус сэтгэлд нийцсэн болгож, сая дөрвөн долларт хүрэх зүлэг болгов. Долоо хоног бүр би яг тийм төрлийн ажил хийхээр хатуу шийдэв. Гэвч гурав буюу гурав хагасын ажил хийх үедээ түүнээс цааш гарах хүслээ санахгүй болтол ядарсан байдаг байв.

"Тэр эмэгтэй надад мөнгө өгөхдөө, 'за чи ч гурав тавиар үнэлэгдэх ажил хийсэн шиг байна' хэмээн хэлдэг байв.

"Тийм юм шиг байна' хэмээн би маш их баярлан хэлдэг байв. Мөнгө хараад маш их баярлан ямар нэгэн том зорилгод хүрсэн юм шиг санадаг байв.

"За за, битгий гутар хэмээн тэр намайг тайтгаруулдаг байв. Бүхний эцэст зөвхөн хэдхэн хүн дөрвөн долларын ажил хийж чадна.'

"Түүний үг эхлээд намайг тайтгаруулав. Гэвч дараа нь юу болж байгааг өөрөө ч мэдэлгүй, түүний тайвшруулалт хэдий намайг алдаг байсан ч гэсэн дөрвөн долларын ажлыг хийхээр шийдэж түүний тайвшруулалт бухимдал төрүүлэв. Миний хатуу шийдсэн хөөрөлд би өөрийгөө түүний зүлгэн дээр амьсгаадан, Каунтис миний дээрээс тонгойн нүдэндээ нулимстай дөрвөн доллар өгөн, намайг хийж чадахгүй гэж бодсондоо уучлал гуйн байгаагаар бодов.

"Тийм хөөрлийн дунд үед, нэг Пүрэв гарагийн орой тэр өдрийнхөө ялагдлаа мартахаар унтахыг хичээж байтал үнэн намайг босож суун баярлалат, хагас ханиалгатал толгойд орж ирэв. Энэ бол миний хийх ёстой дөрөв биш таван долларын ажил байв! Энэ нь боломжгүй учир би хэний ч хийж чадаагүй энэ ажлыг хийх ёстой байсан.

"Би урд тулгарах хэцүү байдлыг сайн мэдэж авлаа. Надад зүлгэн дээрх овгор шороог туулах гэх мэт бэрхшээл байв. Каунтис тэднийг мэдэж амжаа ч үгүй бөгөөд тэд маш жижиг боловч би хөл нүцгэн учир тэднийг мэдэх бөгөөд энэ талаар ямар нэг зүйл хийх хэрэгтэй байв. Би цэцэрлэгийн зах хэсгийг хайчаар тайрч чадах боловч таван долларын өвсний бүх захыг яг талбайн хашаатай тэнцүүлэх, дараа нь үүнийг захтай нь тэгшлэн тайрах шаардлагатайг би мэдэж байв. Мөн зөвхөн би болон миний нүцгэн хөл мэдэх өөр асуудлууд байв.

"Дараачийн Пүрэв гаригаас эхлэн би хүнд замын индүүгээр овгор шороог индүүдэв. Хоёр цаг үүнийг хийсний дараа би өнөөдрийн ажилдаа бууж өгөхөд бэлэн байв. Өглөөний есөн цагт миний хүсэл аль хэдийн алга болжээ. Зөвхөн санаандгүйгээр би хэрхэн хүч нэмж байгаагаа нээв. Өнхрүүлж дууссаныхаа дараа самрын модны доор хэдэн минут сууж байхдаа зүүрмэглэчихэв. Минутын дараа сэрэхэд миний нүдэнд зүлэг маш сайхан харагдаж хөл доор маш сайхан мэдрэгдэж би баяртайгаар ажилдаа эргэн оров.

"Би энэ нууцыг өдрийн турш дагаж цаг тутамд хэдэн минут амарч, миний цаашдын эрч хүч нэмэгдэж хүч минь дахин сэргэв. Түр унтах хооронд би дөрвөн удаа, хоёр

удаа өргөөш хоёр удаа уртааш нь зүлгийг ногоон тансар хилэн шатрын хөлөг шиг харагдтал хадсан байв. Тэгээд би бүх модыг тойруулан ухаж, том шавар шавхайг нь буталж, гараараа сул шороог нь тэгшилж, тэгээд захалж дуусгаад, нямбайгаар бүх цохиуруудыг тэнцүүлж үр дүн нь төгс төгөлдөр тэгш хэмжээтэй байхаар болгов. Би урд талын хаалганы хавтгай чулуунуудын хоорондох өвсийг болгоомжтой тэгшлэв. Хяргадаг хайч хурууны үенүүдийг өвтгөж байсан зам тийм сайн харагдахгүй л байв.

“Эцэст нь тэр орой найман цагийн үед бүх юм дуусав. Би бахархалтайгаар бүүр ядарснаа ч мэдрэлгүй түүний хаалган дээр очив.

“За өнөөдөр хэд вэ?” гэж тэр асуув.

“Би тайван, боловсон байхыг хичээн ‘Таван доллар’ гэж хэлэв.

“Таван доллар оо? Чи дөрвөн доллар гэж хэлэх гэсэн байх, тийм үү? Би чамд таван долларын зүлэг гэж байх боломжгүй” гэж хэлсэн биз дээ.

“Тийм ээ, гэвч би үүнийг хийсэн.”

“За тэгвэл залуу хүү минь, түүхэн дэх анхны таван долларын зүлгийг эргэн тойрон явж үзэх хэрэгтэй байх.”

“Бид хамтдаа явж оройн сүүлчийн гэрэлд зүлгийг явж үзсэн бөгөөд би өөрийн хийсэн зүйлийн боломжтойд итгэж чадахгүй байв.

“Залуу хүү минь,” хэмээн тэр гараа миний мөрөн дээр тавиад “Энэ дэлхий дээр юу чамайг ийм галзуу зүйл хийлгэчих вэ?” гэж хэлэв.

“Би яагаад гэдгийг мэдэхгүй, гэхдээ хэдий би мэдсэн ч өөрийнхөө үүнийг хийсэн гэдгийг сонсоод баярласнаа тайлбарлаж чадахааргүй байв.

“Би чамд боломжгүй гэж хэлэх үед зүлэг хадах энэ санаа чамд анх төрөхөд чи юу бодож байсныг би мэднэ гэж бодож байна хэмээн үргэлжлүүлэв. Энэ санаа анх чамд төрөхөд Чи маш их баярласан, тэгээд жаахан айж байсан. Миний зөв үү?”

“Тэр миний нүүрэн дээр бичээтэй айсан байдлыг хараад өөрийнхөө зөв гэдгийг мэдэж чадахаар байв.

“‘Бараг бүх хүмүүст ижил тохиолддог учраас би чамд ямар сэтгэгдэл төрж байсныг мэднэ. Тэдэнд ямар нэг агуу зүйл хийхийг хүссэн гэнэтийн тэсрэлт мэт сэтгэгдэл төрдөг. Тэдэнд гайхамшигтай тохиолдлууд болно гэсэн сэтгэгдэл төрдөг боловч тэд “Үгүй би үүнийг хийж чадахгүй. Энэ чинь боломжгүй” гэж хэлдэг учраас хийж чаддаггүй. Чи өөртөө “Энэ чинь боломжгүй” гэж хэлэх болгондоо болгоомжтой харахыг сана. Бурхан чамаас үнэхээр ямх, юмуу тохой эсвэл миль өсөхийг хүсэж тэгээд Чи дүүрэн амьдралтай болно.” . . .

“ 25 жилийн тэртээх тэр цагаас хойш, байдлыг сайжруулахын тулд хэрхэхээ мэдэхгүй байсан тэр үедээ, ‘бүтэшгүй’ хэмээх үгийг сонсоод, надад гэнэт нэгэн найдвар төрөхийг мэдэрч, бүтэшгүй тэр зүйлүүдийг хийхийг оролдох нь цорын ганц боломжтой зам болохыг мэдсэн” (Richard Thurman, “The Countess and the Impossible,” Readers Digest, June 1958, pp. 107-10).

• Хэдийгээр энэ түүхэнд хүү хийсэн ажилдаа сайн мөнгө авсандаа баярлаж байсан ч мөнгө түүнд тийм чухал зүйл байсан уу?

• Энэ түүхийн захиас юу вэ? (Ямар ч ажил буюу даалгавраа сайн хийсэн үед агуу амжилт ба баяр баясгаланг мэдэрдэг.)

Залуу эрэгтэйчүүдийг хүнд ажил хийснийхээ дараа амжилт мэдэрсэн тохиолдлоо ярьж өгөхийг хүс. Хэрэв та тэдэнд тийм тохиолдол байсан гэдгийг мэдэж байвал нэг юмуу хоёр залуу эрэгтэйг үүнд томилж болно. Мөн та өөрийнхөө тохиолдлоос ярь.

Дүгнэлт

Уриалга

Залуу эрэгтэйчүүдийг амьдрал, сургуулийн сургалт, Сүмийн үйл ажиллагаанд зохистойгоор таван долларын шагнал авахаар оролцохыг уриалж энэ хичээлийг төгсгө. Тэд эдгээр зорилтуудыг биелүүлэх тодорхой замуудыг болон ямар шагнал авч болох тухай ярилц.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр хувийн сахилга нь түүнийг ариун явдалтай амьдралаар хэрхэн амьдрахад туслахыг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Дараах ишлэлүүд бүхий үгийн хайчилбаруудыг бэлтгэ.
 - а. Бид зарлигуудыг зөрчиж буйгаа зөвтгөхдөө өөрсдийгөө хянах чадвараа сулруулдаг.
 - б. Бид Зарлигуудыг зөрчсөнөөр Их Эзэний Сүнсийг алддаг.
 - в. Бид хувийн сахилгыг алхам алхмаар сурдаг.
 - г. Хэрэв бид Тэнгэрлэг Эцгээс тусламж хүсэж залбирвал тэр биднийг хүчтэй болгоно.
 - д. Хувийн сахилга бидэнд Тэнгэр дэх Эцэгтэй болон өөрсөдтэйгөө нийцэх эв зохицлыг авчирдаг.
 2. *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимлын 14–16-р хуудсан дахь бэлгийн цэвэр байдлын тухай зөвлөгөөг тоймло.
-

ТАЙЛБАР

Ёс суртахуунаа алдаж буй дэлхийд Сатаны уруу таталтанд урьд нь байгаагүйгээр улам хүчтэй орох болсон өсвөрийнхэндээ бид илүү их анхаарал тавих шаардлагатай байна. Сатан Сүмийн өсвөрийнхнийг сүйтгэхийг хичээж байгаа ба энэ нь авралын төлөвлөгөөтэй адил бодит юм. Түүний уруу таталтанд бууж өгөх нь тэднийг сүнслэг амьдралаас салгах болно.

Залуу эрэгтэйчүүдийн зөвлөхийн хувьд та тэднийг Сатаны эсрэг тууштай зогсоход нь туслах ёстой. Энэ хичээл танд Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны нэрлэснээр “энэ эрин үеийн тахал тараагч нүгэл” болох Сатаны садар самууны уруу таталтыг эсэргүүцэх тухай заахад туслах юм (in Conference Report, Apr. 1986, p. 4; or *Ensign*, May 1986, p. 4). Залуу эрэгтэйчүүдийг энэ уруу таталтын талаар өөртэй чинь чөлөөтэй ярилцахыг зөвшөөр. Садар самуун нь аюултай үр дагавартай гэдгийг тайлбарла. Их Эзэнд садар самуун нь ноцтойгийнхоо хувьд хүүхэд төрүүлэх нандин хүчинд гар хүрч буй учир хүн алахын дараа орох гэм нүгэл ба энэ нь тийм амархан наманчилж болох нүгэл биш юм.

Залуу эрэгтэйн бэлгийн харьцаагаа цэвэр байлгах шийдвэр нь түүнийг номлолд хэрхэн бэлтгэснийг тодорхойлох болно. Ерөнхийлөгч Бэнсон зөвлөхдөө, “Бид ёс суртахуунаараа цэвэр залуу эрэгтэйчүүдийг номлолын талбарт байхыг хүсэж байна. Бид та нарыг бүх амьдралынхаа турш цэвэр амьдрахыг хүсэж байна. Бид та нарын амьдралын зам ёс суртахууны цэвэр ариун амьдрал байгаасай гэж хүсэж байна. Тийм ээ, ёс суртахууны гэм нүглийг наманчилж болно. Өршөөлийн гайхамшиг бодит ба үнэн сэтгэлийн наманчлалыг Их Эзэн хүлээн авдаг. Гэвч номлолын өмнө болон өөр ямар ч үед залуу насны сонирхолд хөтлөгдөн ямар ч төрлийн бэлгийн нүгэлд холбогдон, тэгээд Их Эзэнд санаатай үйлдлийнхээ төлөө хурдхан хам хум наманчлах нь Их Эзэний таалалд нийцнэ гэж найдах хэрэггүй” (in Conference Report, Apr. 1986, p. 57; or *Ensign*, May 1986, pp. 44-45).

Залуу эрэгтэйчүүд тийм гэм нүглийн үр дагавар нь зовуурь, шаналгаа гэдгийг ойлгох ёстой. Их Эзэн, “би та нарыг нүглээ наманчил гэж тушааж байна. Үгүй бол би өөрийнхөө аман ташуураар, уур хилэнгээр, уураар ороолгох ба та нарын зовох чинь маш их байх ба ямар их зовохыг та нар мэдэхгүй, хэрхэн өвдөхийг болон та нарт ямар хүнд хэцүү байхыг та нар мэдэхгүй” гэжээ (С ба Г 19:15).

Мөн тэд зөвхөн Есүс Христийн цагаатгалаар гэм нүгэл, өвчин зовлонгоосоо ангижрах боломжтой гэдгийг болон хэрэв тэд садар самуун үйлдсэн бол түүнийгээ наманчлах ёстой ба наманчилж чадна гэдгийг ойлгох ёстой. Наманчилснаар тэд дахин цэвэр болж чадна. Их Эзэн бидэнд наманчлаагүй нүгэл зөвхөн илүү их зовлонг авчирдаг гэдгийг сануулсан:

“Хэрэв тэд наманчлахгүй бол миний зовсонтой адил зовох болно;

“Би хэдий Бурхан, бүхнээс агуу боловч намайг зовоосон зовлонгоос болж дагжин чичирч байсан юм” (С ба Г 19:17–18-ыг үз).

Ёс суртахуунаар цэвэр байхаар шийдэж залуу эрэгтэйчүүд Ерөнхийлөгч Бэнсоны уриалгыг: “Бидэнд илүү олон номлогч нар хэрэгтэй. Гэвч бидэнд илүү сайн бэлтгэсэн номлогч нар хэсгүүд, салбарууд, гэрүүдээс ирэх хэрэгтэй. . . бидэнд бидний захиасанд тохирсон номлогч нар хэрэгтэй,” гэснийг биелүүлж чадах юм (Conference Report, Apr . 1975, p. 96; or *Ensign*, May 1975, p. 65). Исаиа: “Их Эзэний савнуудыг тээгчид ээ, өөрсдийгөө ариун байлга” гэж бичсэн. (Исаиа 52:11.)

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Ярилцлага

Бид Өөрсдийгөө Сахилгатай Байлгахыг Сурч Чадна

Залуу эрэгтэйчүүдээс өөрсдийгөө дараах нөхцөлд тавиад үзэхийг хүс:

1. Ах нь түүн рүү буцааж хашгирмаар бүүр цохиод авмаар болтол нь шоглоод байна. Тийм зүйл хийх явдлыг зогсоож чадах уу?
2. Өнөөдөр мацгийн Ням гариг ба маш их өлсөж байгаа боловч мацгаа зогсоох цаг болоогүй байна. Та нар өөрийнхөө идэх хүслийг барьж чадах уу?
3. Та нарын хамгийн дуртай нэвтрүүлэг зурагтаар гарч байгаа боловч та нарт хийх гэрийн даалгавар байна. Та нар зурагтаа унтраагаад хичээлээ хийж чадах уу?

• Заримдаа та нар өөртэйгээ тэмцэж байгаагаа мэдэрдэг үү? Та нарын нэг тал чинь та нарын дур хүсэл, сэтгэлийн хөөрлийг чинь илтгэж та нарыг “хийлгүүлэх” гэж байхад нөгөө тал чинь дур хүсэл, сэтгэлийн хөөрлийг чинь хянахыг хүсдэг.

Зарим хүмүүс бодол санаагаа хянаж, өөрийгөө сахилгатай байлгаж чадна гэдэгт итгэдэггүй болохыг тайлбарла. Тэд энэ нь нэмэргүй буюу маш хэцүү, үр дүнгүй гэж боддог.

Ишлэл

Дараах ишлэлийг уншаад тайлбарла:

“Зарим нь хорхойтсон зуршлынхаа боол болж, дур хүсэл ба буруу үйлдэлдээ захирагдаж мөн тэд зуршлаа яах ч аргагүй хэмээн шалтаг тоочдог; тэд шахалтанд орсон, ятгалганд орсон; уруу таталт тэдний эсэргүүцлээс хүчтэй гэдэг. Гэвч бид *сонгож чадна*. Бид муу зуршлаа хаяж чадна; бид *сайн* зуршлуудыг олж авч *чадна*; бид тэднийг хийх шийдвэрийг илт гаргаснаар *бодож* буйгаа *сонгож чадна*” (Richard L. Evans, “Self Control,” *Improvement Era*, Dec. 1963, p. 1113).

Зөвлөхийн
танилцуулга

Хэдийгээр өөрийгөө хянах нь заримдаа хэцүү байдаг ч энэ нь бидний сурч чадах зүйл юм гэдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг маань бидэнд бодол, дур хүслээ болон сэтгэлийн хөөрлөө тодорхой хүрээнд барьж байхыг заасан. Бидний Аавын хувьд тэр биднийг хийх боломжгүй зүйлийг хийхийг шаарддаггүй. Бид түүний хүүхдүүд. Бидэнд түүнтэй адил болох хүч чадал байгаа.

Түүх

Залуу эрэгтэйчүүдэд тэдний үеийн нэгэн залуу өөрийгөө хэрхэн удирдаж чадсан тухай дараах бодит түүхийг сонсго. Тэднээс хувийн сахилга баттай байхыг сурахад туслах зүйлийг сонсохыг хүс.

“Бусад бүх хүмүүс л хийгээд байна яагаад би хийх ёсгүй гэж? Зарлиг зөвхөн Их Эзэний нэрийг дэмий дуудаж болохгүй гэж л хэлдэг. Би өөрийнхөө хараал хэлэхийг зөвтгөхийг хичээсэн боловч энэ ямар ч тус болсонгүй. Хэдий миний бүх найзууд хараадаг ч би ингэх нь буруу гэдгийг мэдэж байлаа. Энэ нь намайг зовоож байсан ба эцэст нь би өөрийнхөө асуудалд ямар нэг юм хийсэн нь дээр гэж шийдсэн юм. Би яагаад ч юм бэ Их Эзэнд хандан залбирахад зохисгүй, “заваан” байгаагаа мэдэрсэн юм. Гэвч би нүглээ наманчлахгүй л юм бол бүх зүйл илүү муу болно гэдгийг мэдэж байлаа.

“Би өөрийгөө зөвхөн ганц өдөр хянахаас эхэллээ. Би хараал хэлэх нь миний зуршил болсныг мэдэж байлаа. Би сургууль дээрээ бүх өдрийн турш муухай үг сонсдог нь хараал хэлэх нь ердийн юм мэт надад санагдаж байв. Би хараал хэлэхгүйгээр бүтэн нэг өдөр болохоор шийдсэн юм.

“Эхний өдөр би ухаалгаар хичээж өдрийн хоол хүртэл бүх юм зүгээр байлаа. Тэгтэл хүн бүхэн баярлан чимээ шуугиан ихтэй байсан ба намайг ухаарч амжихаас өмнө миний ам сэтгэлийн хөдөлгөөнөө дагаад дуугарчихсан байв. Би хэлчихсэнээ арай ядан ухаарсан ба дахин би хуучин зуршлаа мэдэж авч миний урам хугарч дотор муухай болсон юм.

“Тэр шөнө би хүч өгөхийг маш их гуйн залбирсан юм. Өглөө нь би сургууль дээрээ хамгийн сайн хоёр найздаа бидний хэлж ярьж буй зүйлийг сайн гэж бодохгүй байгаагаа болон түүнийгээ өөрчлөх гэж буйгаа хэлэх зоригтой байсан юм. Тэгээд би тэр өдөртөө бас хичээсэн юм.

“Би ийм хэцүү байна гэж огт бодоогүй билээ. Яагаад ч юм бэ би сайн мэдээгээр амьдрах нь амархан гэж боддог байлаа. Намайг нэг ч хараал хэлэхгүй байхыг суртал бүтэн дөрвөн өдөр хэрэгтэй болсон юм. Би маш их баярлаж байсан боловч өдөр бүр маш анхааралтай байх ёстойг мэдэж байлаа. Халтирч хуучин зуршилдаа буцаж орох нь маш амархан.

“Энэ бүх хугацаанд би хүч өгөхийг гуйн залбирч байсан юм. Надад ахицтай өөрчлөлт гарч, хараал хэлэхээ больсон ч надад өршөөгдсөн гэж бодогдоогүй юм. Тэгээд гэрчлэлийн цуглаан болсон юм. Би сүнснийг маш хүчтэй мэдэрч гэрчлэлээ хуваалцах хүсэл маш ихээр төрсөн билээ. Би Тэнгэрлэг Эцэг, түүний хүү болон сайн мэдээнд хайртайгаа хэлэв. Намайг ярьж дуусахад мөрөн дээрээс минь маш хүнд ачааг аваад хаях шиг болж би өршөөгдсөнөө мэдсэн юм.”

Дараах асуулт бүрийг ярилцсанаа дараа ярилцлагаас гарах хувийн сахилга баттай холбоотой дүгнэлтийг агуулсан үгийн хайчилбарыг үзүүлэнд байрлуул.

- Энэ түүхэнд гарч буй хүн биеэ авч явах байдлаа хэрхэн зөвтгөхийг оролдсон бэ?
- Бид заримдаа яагаад биеэ авч явах байдлаа зөвтгөхийг оролддог вэ?
- Бид яагаад үүнээс зайлсхийх ёстой вэ?

Самбарт *а* хайчилбарыг байрлуул: “Бид зарлигуудыг зөрчиж буйгаа зөвтгөхдөө өөрсдийгөө хянах чадварыг сулруулдаг.”

- Залуу эрэгтэйг биеэ авч явах байдлаа өөрчлөхөд нь юу нөлөөлсөн бэ?
- Тэр юу бодсон бэ?
- Яагаад тэр ингэж бодсон бэ?

Самбарт *б* хайчилбарыг байрлуул: “Бид зарлигуудыг зөрчсөнөөр Их Эзэний Сүнснийг алддаг.”

- Залуу эрэгтэй өөрийгөө хүмүүжүүлэхийн тулд ямар ямар зүйлийг хийсэн бэ?
- Алхам алхмаар нь сурах нь бидэнд хэрхэн сахилга баттай байхыг сурахад тусалж чадах вэ?

Самбарт *в* хайчилбарыг байрлуул: “Бид хувийн сахилгыг алхам алхмаар сурдаг.”

- Залуу эрэгтэйн өөрийгөө хүмүүжүүлэхийг сурахад хүч чадал олох хамгийн агуу эх булаг нь юу байсан бэ?

Самбарт *г* хайчилбарыг байрлуул: “Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгээс тусламж хүсэн залбирвал тэр биднийг хүчтэй болгоно.”

- Залуу эрэгтэй өөрийнхөө асуудлаа давж гараад ямар сэтгэгдэлтэй болсон бэ?
- Түүний гэрчлэлээ хуваалцсан нь амар амгаланг авчрахад хэрхэн тусалсан бэ?

Самбарт *д* хайчилбарыг байрлуул: “Хувийн сахилга бидэнд Тэнгэр дэх Эцэгтэй болон өөрсөдтэйгөө нийцэх эв зохицлыг авчирдаг.”

Залуу эрэгтэйчүүдээс өөрсдийгөө сахилгатай болгох тухай болон тэдэнд юу тусалсан тухай онцлон сэтгэгдлээ хуваалцахыг хүс. (Тайлбар: хувийн асуудал нь зарим залуу эрэгтэйчүүдийг ичээж магадгүй тул битгий хөнд.)

Үгийн хайчилбар
ба ярилцлага

Өөрсдийгөө Сахилгатай Байлгаснаар Бид Ариун Журамтай Амьдарч Чадна

Хөгжмийн зэмсгээр тоглож сурах, уураа барих, их унтахаа больж өглөө эрт босох зэрэг алийг нь ч сурсан байсан хувийн сахилга бат нь бидэнд ариун журамтай амьдрахад тусална гэдгийг тайлбарла.

Түүх ба ярилцлага

Дараах түүхийг ярьж өг:

“Нэгдсэн Улсын зүүн хэсэгт үйлчилж байсан нэг номлогч сайн мэдээнээс илүү тэр номлогчийн ёс суртахууны чанга мөрдлөгийг сонирхсон коллежийн нэг оюутантай уулзжээ. Оюутан ийм олон хөөрхөн охидууд эргэн тойронд байхад тэр номлогчийг хэрхэн дур хүслээ хянаж чаддаг талаар тохуурхсан байдалтай асуугаад, номлогчийг ямар ч байсан эрүүл бус гэсэн маягийн үг хэлжээ. Ахлагч, ‘Би эрүүл бусдаа биш зөвхөн би өөрийнхөө биеийг хариуцдаг ба ийм үүрэг хүлээснээ мэддэгт л юм. Чи өөрийнхөө дур хүслийн өмнө сул дорой гэж бодож байна. Чи тэднийхэ золиос гэж бодож байна. Би өөртөө өөрийгөө тэдгээр мэдрэмжийг удирдах эзэн гэдгийг харуулсан юм,’ гэжээ” (Terrance D. Olsen, “Teaching Morality to Your Children,” *Ensign*, Mar. 1981, p. 14).

- Ахлагч ба коллежийн оюутан хоёрын хоорондох үзэл бодлын ямар ялгаа байсан бэ? (Оюутан өөрийнхөө байгалийн дур хүслийг хянаж чадахгүй гэж бодож байсан. Ахлагч тэдгээр нь энгийн хүсэл боловч хянах боломжтой гэдгийг мэдэж байсан.)
- Ахлагч бодол ба сэтгэлийн хөдөлгөөнөө яахыг сурсан бэ?
- Хүлээхийн оронд одоо өөрийгөө хянаж сурах нь яагаад чухал вэ?

Судар

Залуу эрэгтэйчүүдээр дараах судруудыг уншуулаад тэмдэглүүл. Дуулал 24:3–5; Алма 5:16–19.

Ёс суртахуунаар цэвэр, ариун журамтай байх нь хувийн сахилга бат ба өөрийгөө хянаж сурахыг шаарддаг гэдгийг тайлбарла. Жишээлбэл, Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл бэлгийн нүгэлт дур хүсэл ба зуршлын тухай тодорхой ярьсан юм. Та Ерөнхийлөгч Кимболлын хэд хэдэн ёс суртахууны болон хувийн сахилга батын тухай ярьсныг уншиж өгөх гэж буйгаа хэл.

Тайлбар: Хэрэв та залуу эрэгтэйчүүд зарим нэг хэллэгийг ойлгохгүй гэж үзвэл тэр хэллэгийг тодорхойлсон доорх тайлбарыг унш. Тэгээд тодорхойлолттой холбогдох ишлэлүүдийг унш. Зөвхөн бошиглогчийн хэлснийг уншиж өг. Хэрэв шаардлагатай бол ишлэлд хэрэглэсэн хэллэгийг тайлбарлаж, хувийн сахилга бат дээр ярилцлагаа төвлөрүүл.

1. Өөрсдийн Биед Хандах Бидний Хандлага

Тодорхойлолт

Мастурбаци: бэлгийн дур хүслээ өдөөх.

Ишлэл

“Доогуур жишигтэй хүний юу ч гэж хэлсэн бай мастурбаци бол Их Эзэн болон түүний сүмд зөвшөөрөгдөхгүй” (*President Kimball Speaks Out* [Salt Lake City: Deseret Book Co, 1981], p. 10).

2. Ижил Хүйстнүүдэд Хандах Бидний Хандлага

Тодорхойлолт

Ижил хүйстэнтэйгээ хавьтах: “эрэгтэй болон эмэгтэийн аль нь ч байсан ижил хүйстний бэлгийн дур хүсэл болон ижил хүйсний хүмүүсийн хоорондох бэлгийн харилцаа” (*The Miracle of Forgiveness* [Salt Lake City: Bookcraft, 1969], p. 78).

Ишлэл

“Ижил хүйстэнтэйгээ хавьтах бузар нүгэл маш хурдан өсөж байна, үүнийг тэвчиж ч байгаа нь сурталчилгааг улам өргөн хүрээтэй болгож байна. . . . Их Эзэн үүнийг буруушааж хориглодог.

“‘Бурхан намайг ингэж бүтээсэн’ гэж зарим нь өөрийгөө зөвтгөж хэлдэг. ‘Би яах ч аргагүй’ гэж бас дээрээс нь нэмдэг. Энэ бол бузар булай зүйл. Хүн Бурханы дүр төрхөөр бүтээгдээгүй гэж үү, арай Бурхан ‘тийм байна’ гэж тэр бодоогүй биз?” (*President Kimball Speaks Out*, pp. 10, 12).

3. Эсрэг Хүйстэндээ Хандах Бидний Хандлага

	<p><i>Садар самуун явдал:</i> хуулиар гэрлэсэн эхнэр нөхрөөсөө өөр хэн нэгэнтэй бэлгийн харьцаанд орох явдал.</p> <p><i>Нууцаар явалдах:</i> “гэрлээгүй байхдаа хэн нэгэнтэй хийх бэлгийн харьцаа” (President Kimball Speaks Out, p. 6).</p> <p><i>Хүзүү хоолойгоороо тэврэлдэх:</i> “тачаадсан үнсэлт ба дотны харьцаа” (President Kimball Speaks Out, p. 8).</p> <p><i>Илж таалах:</i> “биеийн нууц хэсэгт бэлгийн дур хөдөлгөх зорилгоор хүрэх” (President Kimball Speaks Out, p. 8).</p>
Ишлэл	<p>“Залуу эрэгтэйчүүдийн нийтлэг бэлгийн нүгэл бол хүзүү хоолойгоороо тэврэлдэх болон илж таалах байдаг. Эдгээр зохисгүй харьцаа нь нууцаар явалдах, жирэмслэлт, аборт хийлгэх, бүх муу муухай нүглүүд рүү хөтлөөд зогсохгүй, бас эдгээр нь тэднийг устгах нүгэл хилэнцүүд юм” (<i>Miracle of Forgiveness</i>, p. 65).</p> <p>Та <i>Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө</i> товхимлын 14–16-р хуудсан дахь бэлгийн цэвэр байдлын тухай зөвлөмжийг Ярилцлагынхаа хэсэг болгон тоймлож болно.</p>
Ишлэл ба ярилцлага	<p>Ихэнх хүмүүс өөрсдийнхөө хувийн сахилга бат алдсанаа энэ гурван зүйлээр тайлбарладаг. Ерөнхийлөгч Кимболл тэдний тайлбарыг дараах байдлаар тайлбарласан.</p> <p><i>“Хүн өөрийнхөө гэм нүгэлд хариуцлага хүлээдэг Тэр эсэргүүцэж, өөрчилж чадна.</i> Уруу таталт хүн бүхэнд ирдэг. Зохисгүй ба зохистой хүн нь нэг нь эсэргүүцэж нөгөө нь бууж өгдөгт л ялгаа нь байгаа юм” (President Kimball Speaks Out, p.12; italics added).</p>
Ярилцлага	<ul style="list-style-type: none"> • Та нарын үйлдэлд хэн хариуцлага хүлээдэг вэ? <p>Залуу эрэгтэйчүүдэд хэрэв бид хувийн сахилгатай байвал сүнс бидний биеийг хянах явдлыг хүчтэй болгодог гэдгийг ойлгуул. Биднийг зөв сонголтууд хийх тусам өөрийгөө хянах чадварууд маань нэмэгддэг ба нэмэгдсэн хувийн хяналт нь бидэнд илүү сайн сонголт хийж илүү аз жаргалтай болоход тусалдаг гэдгийг онцлон хэл.</p>
Нөхцлийн судалгаа ба ярилцлага	<p>Дараах Нөхцөлийн судалгааг унших буюу заримыг өөрийнхөөрөө зохиож болно. Нөхцөл бүрийг уншсаны дараа: Энэ нөхцөлд хүн хэрхэн хувийн сахилга батаа хэрэглэж болох вэ? Хэрэв хүн түүнийгээ хэрэглээгүй бол яах вэ? гэсэн асуулттай адил асуултыг тавь.</p> <ol style="list-style-type: none"> 1. Миний сургуулийн зарим найзууд намайг үдэшлэгт оролцохыг урьсан юм. Надад таалагддаг охин намайг тэнд очихыг уриад тэр ч өөрөө тэнд байна гэж хэлсэн учраас би очихыг маш их хүсэж байсан юм. Би түүнтэй байхыг маш их хүсэж байлаа. Тэгээд намайг найзуудтайгаа тэнд очиход бид эцэг эх нь байхгүй ба үдэшлэг хариуцах хүнгүй байхыг олж мэдэв. Маш бүдэг гэрэлтэй байлаа. Зарим хүүхдүүд бүжиглэн, зарим нь хос хосоороо үнсэлцэн тэврэлдэж байв. Надад таалагддаг охин намайг орж ирэхийг харав. • Энэ залуу эрэгтэй юу хийх ёстой вэ? Яагаад? 2. Арван зургаа хүртлээ хүнтэй болзож болохгүй гэдгийг мэдэх боловч би сургууль дээрээ охидуудтай ярьж бас тоглоом хийх нь надад маш зугаатай байсан юм. Тэр охидын нэг нь намайг тоосон шинжтэй байсан ба энэ хөөрхөн охин Барбара байсан юм. Нэг өдөр өдрийн хоолны үеэр бид нар дэлгүүр дээр уулзаад кинонд явах тухай ярилцсан юм. Тэр өдөр хэсгийн үйл ажиллагаатай байсан боловч би за гэж хэлсэн юм. Эцэг эхдээ үйл ажиллагаандаа явлаа гэж хэлж гараад автобусанд суугаад дэлгүүр рүү явах нь амархан байх байлаа. Би үйл ажиллагаа дуусах тэр үеэр гэртээ буцаад ирэх байв. Би гэрээсээ гарах цаг болоход би маш их сандарч байлаа. Ээж минь намайг дуудаж гадуур хувцсаа өмссөн эсэхийг шалгаад “Цагаа сайхан өнгөрүүлээрэй” хэмээгээд гэртээ буцаж орлоо. • Энэ залуу эрэгтэй юу хийх ёстой вэ? Яагаад? <p>Хувийн сахилга батын тухай санаа бүхий үгийн хайчилбаруудыг тоймлон үз.</p>

Дүгнэлт

Ишлэл

Залуу эрэгтэйчүүдэд бид бүгд зарим үед хувийн сахилга баттай байхыг хичээхээр тэмцэх хэрэгтэй болдог яагаад үүнийг хийж чадна гэдгийг анхааруул. Бид өөрсдийгөө хүмүүжүүлэх бүртээ ариун журамтай амьдралаар амьдрах боломжоо хүчтэй болгодог. Хичээлээ дараах мэдэгдлээр дуусга. Залуу эрэгтэйчүүдээс хэрэв бид хувийн сахилга баттай байхаар хичээвэл бидэнд өгөгдөх амлалтыг сонсохыг хүс.

“Та нар алдаа хийж, мэдээжийн алдаанд бодолгүйгээр орж, та нарт муу ёрын шохоорхол дүүрэн бөгөөд үүнд бууж өгөхийг хүсэж байвал түүнийгээ зогсоож, Бурханы та нарын табернеклд оруулсан сүнсэнд та нарыг хөтлөхийг зөвшөөр. Хэрэв та нар ингэвэл нүгэл хилэнцийг давж мөнхийн амьдралыг хүртэх болно гэдгийг би та нарт амлаж байна” (Brigham Young, *Journal of Discourses*, 2:256).

Уриалга

Залуу эрэгтэйчүүдэд биеэ хянаж өөрсдийгөө нүглээс хол байлгахыг уриал. Тэд уруу таталтыг эсэргүүцэх чадвартай гэдэгт та итгэж байгаа бөгөөд байнга тэдний сайн сайхны төлөө болон биеэ хянах байдлын төлөө залбирах болно гэдгээ хэл. *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимолд өгсөн жишгүүдийг дахин уншихыг тэдэнд зөвлө.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэйчүүд ариун бодлууд нь ариун журамтай амьдрал руу хөтөлдөг гэдгийг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

- Шаардагдах материалууд:
 - Залуу эрэгтэй бүрт судар.
 - Кино гаргах зүйл ба хуурцаг (*Worthy Music, Worthy Thoughts* (meetinghouse library, 51129).
 - Кино гаргах проектор, хуурцаг тоглуулагч ба дэлгэц (хичээл эхлэхээс өмнө эдгээрийг бэлтгэ).
- Энэ хичээлийг заахаас өмнө *Worthy Music, Worthy Thoughts* киног урьдчилан үз. Киног үзүүлэх боломжгүй бол киноны тайлбарыг ярилцлагынхаа үндэс болгон ашигла.
- Залуу эрэгтэйчүүд бүрт зориулан “Ариун журам бодол санааг чинь зогсолтгүй чимэн гоёг” (С ба Г 121:45) гэсэн судартай тараах материал бэлд.
- Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* дэх 13, 14-р хуудаснаас хөгжмийн тухай өгсөн зөвлөгөөг тоймло.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Бодлоо Хянах нь Бидэнд Ариун Журамтай Амьдрах Хүч Өгдөг

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр Мозая 4:30-ийг уншуул.

- Биднийг өөрсдийгөө харж явах талаар ямар зөвлөгөөг энэ судар өгсөн бэ? (Бодол, үг, үйлдэл)
- Бодол, үг, үйлдлийн хооронд ямар холбоо байдаг вэ?

Сургаал ба Гэрээ 121:45-ыг залуу эрэгтэйчүүдээр уншуул.

- Чимэн гоёх гэж юу гэсэн үг вэ? (Тохижуулах, чимэглэх, засах)
- Бид бодлоо хэрхэн ариун журмаар чимэх вэ?

Кино

Worthy Music, Worthy Thoughts кинонд Ахлагч Бойд К. Пакер ариун журам нь бидний бодлыг хэрхэн гоёдог ба бодол санаагаа хянаж сурах нь ариун журамтай амьдрахад бидэнд хэрхэн тусалдаг болохыг тайлбарласан. Залуу эрэгтэйчүүдээс бодол санаагаа хөгжүүлж чадах тодорхой аргуудыг олж авахыг хүс.

Кино үзүүл. (Хэрэв кино үзүүлэх боломжгүй бол киноны тайлбар ба *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* дэх зөвлөмжийг ярилцлагынхаа үндэс болгон ашигла.) Кононы төгсгөлд залуу эрэгтэйчүүд бодол санаагаа хянах чадварыг хэрхэн хөгжүүлж чадах тухай ярилц.

Ярилцлага

Та нар дараах ярилцлагын асуултуудыг хэрэглэж болно:

- Мөнх бус амьдралд тохиолдож болох хамгийн хэцүү сорилтыг Ахлагч Пакер юу гэж хэлсэн бэ? (Бодол санаагаа хянаж сурах.)
- Бодол санаагаа хянаж сурах нь ямар ашигтай вэ? (Зуршлаасаа салж, зориг нэмж, айдсыг ялж, аз жаргалтай амьдралтай байна.)
- Та нарыг юу бодохыг хэн шийдэх вэ? (Та нар өөрсдөө.)
- Зөв зохисгүй бодлууд үнэхээр гэмгүй ба аюулгүй гэсэн мэдрэмж төрүүлж байсан жишээнүүдийг та нар бодож олж чадах уу?
- Ямар төрлийн үйл ажиллагаанууд цэвэр бус бодлуудыг дэмждэг вэ?

6. Та нар ухаан бодлоосоо цэвэр бус бодлуудыг зайлуулахын тулд юу хийж чадах вэ?
7. Ахлагч Пакер бодлоо хянахад туслах юуг хэрэглэхийг зөвлөсөн бэ? (Зохистой хөгжим.)
8. Зохисгүй хөгжим юугаараа аюултай вэ? (Зохисгүй бодлуудыг урьдаг ба ихэнхдээ олиггүй зүйл, хүндэтгэлгүй байдал, ёс суртахуунгүй байдал, хорхойсохыг зөвлөх буюу дагалдана)
9. Та нар ямар төрлийн хөгжим хайх хэрэгтэй вэ? (Сүнслэг байдал, хүндэтгэл, аз жаргал, гоо сайхныг харуулсан зоригжуулж урам хайрласан хөгжим.)
10. Хэрэв бид оюун ухаанаа сайн сайхан, гоо үзэсгэлэн, урам хайрласан зүйлээр бялхам дүүргэвэл бидэнд ямар адислал амлагдсан бэ? (Ариун Сүнсний байнгын заавар ба илчлэлт.)
11. Ахлагч Пакер бодлуудаа хянахад туслах ямар онцгой үйлдлийг зөвлөсөн бидэнд бэ? (Дуулал сонгож түүнийгээ сурах мөн түүнийгээ бодлуудынхаа үндэс болгон хэрэглэх.)

Залуу эрэгтэйчүүдээс Ахлагч Пакерийн зөвлөсний дагуу хэрэглэж болох дууллыг сонгохыг хүс. Залуу эрэгтэйчүүдийг дууллын үгнүүдийг цээжилж тэдгээрийг бодолдоо төвлөрүүлэх зориулалтаар хэрэглэхээр мөрдөхийг уриал.

Тараах материал

Залуу эрэгтэй бүрт дараах судрын хэсэгтэй тараах материалыг өг: “Ариун журам бодол санааг чинь зогсолтгүй чимэн гоёг” (С ба Г 121:45). Залуу эрэгтэйчүүдэд тараах материалын ар талд өөрсдийнхөө сонгосон дууллыг бичихийг зөвлө.

Судар

Нэг залуу эрэгтэйгээр Сургаал ба Гэрээ 121:45-ыг чангаар уншуулахаар дууд.

Дүгнэлт

Гэрчлэл ба уриалга

Бодлуудаа хянаснаар ирэх адислалуудын тухай гэрчлэлээ хуваалц. Залуу эрэгтэйчүүдэд *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* дэх бодлоо зохистой байлгахад туслах зөвлөгөөг уншихыг уриал. Залуу эрэгтэйчүүдийг гэртээ байгаа хөгжмүүдийг хянан дүгнэж тэдэнд зохистой бодолтой байхад нь үл туслах цуглуулгыг хаяхыг уриалан дэмж.

Зохистой Хөгжим, Зохистой Бодлууд

Ахлагч Бойд К. Пакерын кинонд зориулсан яриа:

“Намайг хүүхэд байхад бид жимсний цэцэрлэгээр хүрээлэгдсэн гэрт амьдардаг байсан юм. Тэнд моднуудад хангалттай ус хэзээ ч байгаагүй мэт санагддаг. Хавар дөнгөж ухсан шуудуунууд дорхноо хогийн ургамлаар дүүрдэг байв. Нэг өдөр усалгааны ээлжээ хариуцаж байхдаа би хэцүү байдалд орсон юм. Ус доошоо мөрнүүд рүү урсахдаа хогийн ургамлаар дүүрчихсэн хэсэгт хүрээд тал тал тийш урсав. Би хашлага барихаар шавартай ноцолдов. Намайг дөнгөж нэгийг нь барингуут нөгөөх нь нурж байлаа. Хөрш маань жимсний цэцэрлэгт хүрч ирэв. Тэр харснаа шуудууны шаврыг хүрэээр хүчтэй цохиж өөрийнхөө гаргасан сувгаар ус урсахаар болгов. Тэр, ‘Хэрэв чи усыг нэг чигт урсгахыг хүсэж байвал түүнд урсах замыг нь хийж өгөх хэрэгтэй,’ гэв.

“Хэрэв бид явах газрыг гаргаад өгчихвөл бидний бодол яг устай адил нэг чигтээ урсана гэдгийг би мэдэж авсан юм. Өөрөөр хэлбэл, бидний бодлууд бага эсэргүүцэлтэй урсгалыг дагаж, үргэлж доогуур түвшнийг хайж байдаг. *Магадгүй, та нарын мөнх бус амьдралд тулгарах хамгийн агуу сорилт, хамгийн хэцүү зүйл бол бодлоо хянаж сурах байх болно.* Библид хэлсэнчлэн хүн “Дотроо боддогтойгоо адил юм” гэжээ (Сургаалт үгс 23:7). *Бодлоо хянаж чадсан нэгэн өөрийгөө ялна.*

“Бодлоо хянаж сурснаар та нар зуршлуудаа, бүр өөрийг нь гутаадаг хувийн зуршлуудыг давж чадна. Та нар зоригтой болж, айдсыг ялж, аз жаргалтай амьдралтай болж чадна. Намайг өсөж том болтол зуугаад удаа, түүнээс ч илүүтэй бодлыг хянаж байх ёстой боловч хэн ч надад хэрхэн гэдгийг хэлж байсангүй. Би үүний тухай олон жилийн турш боддог байсан ба оюун ухаан бол яг тайзтай ижил

гэсэн дүгнэлтэнд хүрсэн юм. Сэрэх бүрт хөшиг байнга нээгддэг. Тэр тайзан дээр үргэлж ямар нэг тоглолт болж байдаг. Та нарын оюун ухааны тайзан дээр хошин, эмгэнэлт, сонирхолтой, уйтгартай, сайн, муу боловч үргэлж ямар нэгэн үзэгдэл тоглож байдаг.

“Тэр тайзан дээр тавигдаж буй зүйлийн бараг дундаас зохисгүй жижиг бодлууд та нарын анхаарлыг татахаар та нарт үнэхээр нөлөөлөхгүйгээр далавчнуудаас гэгдэгийг мэддэг үү? Энэ томоогүй бодлууд хүн бүрийг дарахыг хичээдэг. Хэрэв та нар тэднийг цааш явахыг зөвшөөрвөл бүх ариун бодлууд тайзыг орхих болно. Зөв бус бодлуудыг нөлөөлөхийг зөвшөөрсөн учраас та нар ганцаар үлдэнэ. Хэрэв та нар тэдэнд бууж өгвөл тэд та нарын оюун ухааны тайзан дээр тэвчээрийг чинь хязгаарлаж тоглоно. Тэд хорон үг, атаархал, болон үзэн ядалтын сэдвүүдээр тоглоно. Тэд магад бохир, ёс суртахуунгүй, бүр бузрын байна. Хэрэв та нар зөвшөөрч, тэд тайзан дээр байвал та нарын анхаарлыг татах хамгийн ухаалаг ятгалгыг бодож боловсруулах болно. Тэд үүнийг сонирхолтой болгож бүүр тэд гэмгүй, ердөө л бодол гэдэгт та нарыг итгүүлж чадна. Та нарын оюун ухааны тайз чинь бохир бодлуудаар саарал боловч бараг цэвэр мэт санагдах буюу бохир боловч эргэлзэх ямар ч зай үлдээгээгүй нэгэн хутган үймүүлэгчээр удирдуулсан ийм үед та нар юу хийх вэ? Хэрэв та нар оюун ухаанаа цэвэр, бүтээлч бодлуудаар дүүргэвэл тийм бөх голтой хутган үймүүлэгчид зайгүй болж тэд зайлах болно.

“Би өнөөдрийн энэ дэлхийд оюун ухаанаа зохистой бодлуудаар дүүрэн байлгах нь ихэнхдээ хэцүү гэдгийг ойлгож байна. Үүнд маш их анхаарал хэрэгтэй. Хэдий тийм ч та нар бодлуудаа очих аюулгүй газрыг бий болговол үүнийг хийж болно. Би та нартай хуваалцах тийм газрыг олсон. Үүнийг хөгжимтэй, зохистой хөгжимтэй хийх хэрэгтэй. Нэг мэргэн хүн нэг удаа, “Хөгжим бол оюун ухааныг жолоодох хамгийн хүчтэй зэмсэг юм,” гэжээ. Энэ нь зергээр ч бай эсрэгээр ч бай бидний оюун ухааны тайзан дээр юу авчрахаас тодорхойлогдоно. Хэрэв дуу сүнслэг урам хайрласан бөгөөд тэр нь чамаас өөрийгөө илүү хүнлэг байдлаар харахыг шаардаж буй бол тэр хөгжим та нарт хэрэгтэй. Хэрэв энэ нь ердөө л зугаацуулж буюу сүнсийг чинь өргөж байвал энэ ч бас хэрэгтэй газар гэсэн үг. Гэвч хэрэв энэ нь та нарт тачаангуй, мэдрэмтгий байдалтай хандлагыг бий болгож буюу зөв бус хүсэл төрүүлж байгаа бол тэр хөгжмөөс зайлсхийх ёстой. Энэ бол зохисгүй юм.

“Сайхан зүйлсийг авч эвддэг хүмүүс үргэлж байдаг. Энэ нь байгальтай, уран зохиолтой, жүжиг, урлаг, мэдээж хөгжимтэй тохиолддог. Буруу зүйлийг уриалсан үгтэй хөгжим, дуунууд хүнийг буруу зам руу оруулдаг нь зуу зуун жилийн турш илэрхий байсан. Хөгжим дангаараа, тоглож байгаа янзаараа, хэмнэлээрээ, эрчмээрээ сүнслэг мэдрэмжийг муудуулж чадна.

“Бид бүгд нийгэмд нарийн бөгөөд хүчтэй өөрчлөлт болж байгаа цаг үед амьдарч байна. Энэ үзвэр үйлчигээнээс юуг хүлээн авах нь улам чөлөөтэй болж байна. Үр дүнд нь өнөөдөр нэр хүндтэй зугаацуулагчийн хөгжим тоглох байдал нь тайтгаруулахаас илүү сэтгэл түгшээн, тайвшруулахаас илүү хөөргөдүүлдэг. Зарим хөгжимчид зүй бус бодлууд ба үйлдлийг нээлттэйгээр сурталчилдаг.

“Залуу хүмүүс ээ, та нар оюун ухаанаа өнөөдрийн зохисгүй хөгжмөөр дүүргэж болохгүй. Энэ бол аюулгүй биш. Энэ нь та нарын оюун ухааны тайзан дээр зохисгүй бодлуудыг урьж, тэдний бүжиглэх ая болон тэдний үйлдэл хийх хөгийг тааруулна. Чи тийм төрлийн хөгжмийн олиггүй, хүндэтгэлгүй, ёс суртахуунгүй, хорхойтуулсан тэдгээр зүйлстэй өөрийгөө адилтгавал та нар өөрсдийгөө доромжилсон хэрэг болно. Тийм хөгжим та нарт зохисгүй юм.

“Та нар сонсож байгаа буюу зохиож буй зүйлдээ сонголттой бай. Энэ нь та нарын хэсэг болдог. Энэ та нарын бодлуудыг хянаж бусад хүмүүсийн амьдралд ч бас нөлөөлдөг. Би та нарт хөгжмүүдээ шалгаж үзээд гутаах бодлуудыг дэмждэг хөгжмүүдээ хаяаарай гэж зөвлөж байна. Тийм хөгжим сүнслэг хөгжилтөндөө анхаардаг залуу хүмүүст хамаарах ёсгүй.

“Би үүгээрээ өнөөдрийн зохиож буй хөгжмүүд бүгд зохисгүй бодлуудыг төрүүлдэг гэж хэлэх гээгүй юм. Өнөөдөр хүмүүсийн ойлголтыг нэмэгдүүлдэг; урам зоригийг сэргээдэг; сүнслэг, хүндэтгэх, аз жаргал, гоо сайхны мэдрэмжийг сэргээдэг хөгжмүүд байгаа.

“Их Эзэн хэлэхдээ: ‘миний бодгаль зүрх сэтгэлийн дуунд баярладаг, тийм ээ, зөв шударгын дуунууд надад залбирал болж тэдэнд адислал болон хариулагдана’ (С ба Г 25:12). Сүмийн Тэргүүн Зөвлөл бидний амьдрал дах хөгжмийн нөлөөллийн талаар ийн тайлбарласан:

“Хүн хөгжмөөр дамжуулан ярианы хэлний хязгаарыг даван нарийн ба хүч чадалтайгаар өөрийгөө илэрхийлэх чадвар нь өргөждөг. Хөгжим өргөж, урам оруулахаар хэрэглэгдэж болох ба мөн гутаах буюу сүйрэлд оруулах захиасыг авчирч болно. Тиймээс Хожмын Үеийн Гэгээнтнүүд бид ямагт сайн мэдээний зарчмуудыг ашиглаж, өөрийгөө хүрээлүүлэх хөгжмийг сонгохдоо Сүнсний удирдамжийг хайх нь чухал” (*Priesthood Bulletin*, Dec. 1970, p.10).

“Бид Сүмийн өсвөр үеийнхэн та нарт маш их итгэж байна. Бид хөтөлбөрүүд болон үйл ажиллагаанууд зохиохдоо та нарын хүсэл эрмэлзлийг илүү их харгалзан үздэг. Эдгээр нь та нарт болон ялангуяа удирдагчаар дуудагдсан хүмүүст агуу хариуцлага хүлээлгэж байна. Залуу удирдагч та нарт үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хийхдээ маш их анхааралтай бай гэж хэлэхийг надад зөвшөөрнө үү. Хийсэн сонголтынхоо талаар зөвлөх нартайгаа зөвлөлд. Та нарт тэдний мэргэн ухааны дэмжлэг хэрэгтэй, учир нь өнөө үед дэлхийн болон Сүмийн хоорондох зөрчилдөөн нь хөгжмийнхээ хамтаар өнгөрсөн үеүдийг бодвол улам гүнзгийрч байна.

“Манай Сүмийн агуу удирдагчдын нэг Ерөнхийлөгч Рюбен Ж.Кларк энэ маягаар тайлбарласан:

“Хэрэв бид хангахгүй бол залуучууд өөр хаа нэг газар очоод авах болно гэсэн онолоор бид үүргийнхээ дагуу эрүүл мэндэд хортой зугаа цэнгэлийг хангах буюу зөвшөөрч болохгүй. Хэрэв бид залуучууддаа үүнийг хангаж өгөхгүй бол тэд өөр хаа нэг газар очоод мөрийтэй тоглох болно гэдэг шалтаг гаргаж бид сүмд мөрийтэй тоглох зорилгоор эргэдэг ширээ тавьж зугаа цэнгэлийн байр болгож чадахгүй л байх. Бид үнэхээр ийм маягаар залуучууддаа хэзээ ч барьж чадахгүй.

“Дэлхийн залуучуудын сэтгэлийг татах орчин ба хөгжмөөр хангах нь ч зохимжгүй. Та нар тууштай байж өөрсдийнхөө мэдэх сайн, зөв зүйлдээ буулт хийх ёсгүй; та нар гэрэл асаагаад зохистой бодол төрүүлэх орчныг бий болгодоггүй хөгжмийг зогсоох зоригтой байх ёстой ба та нар оролцогч болон зохион байгуулагчдаас хувцаслал болон үзвэр үйлчилгээнийхээ талаар өндөр жишгийг шаардах ёстой. Би та нарт Сүмийн жишгийг бусад залуучуудын жишигт тааруулан солих нь залуу ч бай насанд хүрсэн ч бай бидний болон удирдагч байхаар дуудагдсан хүмүүсийн давуу эрх биш гэдгийг сануулж байна. Сүм зохион байгуулагдаж зангуугаа хаян үнэнд бат бэхлэгдэж бүгд дотор нь аюулгүй байдаг юм. Бидний зорилго бол залуучуудын дагах, тэдэнд жишгээр өсөж, дэлхийн зохисгүй нөлөөллөөс тэднийг хамгаалах тийм цэвэр сувгийг бүтээх удирдлагаар хангах явдал юм. Би та нарт авьяасаа хөгжүүлэхийг, хэрэв та нар хөгжмийн авьяастай бол: зохиох хэрэгтэй, тоглох хэрэгтэй маш олон хөгжим байгаа гэдгийг бодож байхыг зөвлөж байна. Урам зориг оруулах, сайн мэдээг түгээх, зүрхэнд хүрэх, зовсон сэтгэлд хүч чадал ба тайтгарлыг өгөх зохистой хөгжим нь та нарынх байж чадна.

“Хөгжмийн зөв шударга нөлөөг гэрчилсэн хуучны болон орчин үеийн олон жишээ байдаг. Анхдагч нарыг бэрхшээлтэй тулгарахад нь “Ирцгээ, Ирцгээ Гэгээнтнүүд ээ” дууллын үгс зүрх сэтгэлийн амар амгалангаар дүүргэхэд урам орж байсан. Энэ дуу олон жил хүмүүст сүнслэг урам болсоор байна. Нэг удаа би аз сорьсон нислэгээс дөнгөж ирээд байгаа нисгэгчтэй уулзсан юм. Бид зориг, айдсын тухай ярилцсан ба би түүнээс нүүр тулсан зүйлээ тэсэхдээ хэрхэн өөрийгөө авч гарч байсан тухай асуусан юм. Тэр ‘надад дуртай дуулал байдаг бөгөөд аргаа барсан үедээ, бид эргэж ирнэ гэсэн бага найдлага байгаа үедээ дуугаа санаандаа төсөөлөхөд онгоцны мотор надад хариу дуулах мэт санагддаг гэсэн юм.

“Ирцгээ ирцгээ Гэгээнтнүүд ээ,
Учрах бүхнээс эс халшран ирцгээгээч,
Урамтай аялцгаая,
Аялах зам тань бартаатай санагдавч
Амьдрал тань ивээгдэнэ

“Үүнээс эхлэн тэр зоригийн хамгийн чухал бүрэлдэхүүн болох итгэлд наалдсан юм.

“Их Эзэн өөрөө хөгжмийн нөлөөгөөр агуу шалгуурт бэлтгэгдсэнийг сударт ‘дуулал дуулсныхаа дараа тэд Чидун уул өөд явцгаав,’ гэж тэмдэглэжээ (Марк 14:26).

“Залуу хүмүүс ээ, санаж яваарай, би та бүгдийг энэ бол та нарын Сүм, тэр бол та бүгдийн Их Эзэн ба та бүгдийн удирдагч Аврагч гэдгийг санаж байхыг хүсэж байна. Та нар оюун ухаанаа бялхсан сайн сайхан, гоо үзэсгэлэн, сүнслэг урмаар дүүрэн байлгах юм бол түүний зааварчилга ба сүнслэг урам байнга боломжтой байх болно. Энэ бол үүнийг хийх нэг зам. Яг миний нисгэгч найзтай адил үгнүүд нь зориг оруулам ба хөгжим нь хүндэтгэлтэй, та нарт илчлэлттэй холбоотой сэтгэгдэл төрүүлэх дуртай дуулал буюу дууг сонго. Сонгож болох сайхан дуу маш олон байдаг. Сонголт хийхдээ Сүнсийн зааврыг хай. Дууг оюун ухаандаа анхааралтай дуул. Цээжил. Хэдий та нар хөгжмийн дадлагагүй ч энгийн дууг бодож чадна. Одоо та нар үүнийг бодлоо дагах чиглэл болгон хэрэглэ. Үүнийг өөрийнхөө яаралтай суваг болго.

“Та нар оюун ухааныхаа тайзан дээр та нарын бодлын хажуугаар зохисгүй жүжигчид гулсаж орж ирэхийг мэдсэн үедээ тэр дуугаа бод. Энэ нь та нарын бүх л сэтгэл санааг өөрчилнө.

“Хөгжим зориг оруулам цэвэр учраас зохисгүй бодлууд ичгүүртэйгээр гулсан алга болно. Ариун нь бохир бузар зүйлтэй хамт нэгддэггүй тул нүгэл хилэнц гэрлийг тэвчдэггүй. Хэрэгтэй үед та нар өөрөө хөгжмийг аман дотроо аялахад, бараг автоматаар зохисгүй бодлуудаа хөөхийн тулд аялж буйгаа мэдэх болно. Та нар өөрийгөө зөв шударга ба сайн сайхан зүйлд оролцуулахдаа оюун ухаанаа зохистой бодлуудаар дүүргэ, залуу хүмүүс ээ. Учир нь хүн дотроо боддогтойгоо адил ба та нарын амьдралд сэтгэл ханамжийг авчрах зүйлсийг гүйцэтгэх чадвартай байх болно.

“Та нар бол Бүхнийг Чадагч Бурханы хөвгүүд охид билээ. Би Бурхан бидний Эцэг бөгөөд бид бүгд түүний хүүхдүүд ба тэр бидэнд хайртай бөгөөд тэр бидний энэ амьдралыг агуу ба гайхамшигтай зүйлсээр хангаж өгсөн гэдгийг гэрчилж байна. Би үүнийг мэднэ. Би бодлуудад минь нөлөөлж, сүнсийг минь өргөж амьдралд минь зориг оруулдаг сайн хөгжмийн нөлөөнд нь түүнд баярлаж байна ” (See Boyd K. Packer, in Conference Report, Oct. 1973, pp. 21-25; or *Ensign*, Jan. 1974, pp. 25-28).

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр Их Эзэний эрүүл мэндийн хуулийг зөвөөр сахих нь түүний бие, оюун ухааныг хүчтэй болгож материаллаг болон сүнслэг шагналд хэрхэн хүргэхийг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Залуу эрэгтэй бүрт харандаа цаас.
2. Хэрэв танай бүсэд *Family Home Evening Video Supplement* (53276) байгаа бол “Итгэлдээ Үнэнч Байх” гэсэн 19-р хэсгийг үзүүл.
3. *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимлын 12, 13-р хуудсан дахь оюун ухааны болон биеийн эрүүл мэндийн талаар өгсөн зөвлөгөөг тоймло.

ТАЙЛБАР

Ихэнх Аароны Пристийн Зэрэгтнүүд Мэргэн Ухааны Хуулийг мэддэг гэж боддог. Хэдий тийм ч, зарим нь энэ бол дарамттай ба хэтэрхий хориглодог гэж боддог байх. Энэ хичээл тэдэнд Мэргэн Ухааны хууль өдөр тутмын амьдралын үнэтэй удирдамж ба тэдний амьдралын бүх талд Их Эзэний санаа зовсон нотолгоо гэдгийг ойлгоход тусална.

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

Сорилт

Оршил

- Их Эзэний эрүүл мэндийн хуулийг ер нь юу гэж нэрлэдэг вэ? (Мэргэн Ухааны Үг.)

Залуу эрэгтэйчүүдийг Мэргэн Ухааны Үгийн талаар хэр их мэддэгийг нь мэдэхийн тулд сорих асуулт тавина гэдгээ хэл. Тэдэнд харандаа цаас өгөөд дараах асуултыг өг.

1. Мэргэн Ухааны Үгийг ямар судраас олж болох вэ? (Сургаал ба Гэрээ 89-р бүлэг.)
2. Мэргэн Ухааны Үгэнд кофе уух нь хориотой юу? (Тийм.)
3. Мэргэн Ухааны Үгэнд зөвшөөрөгдсөн нь олон уу хориглосон нь олон уу? (Зөвшөөрөгдсөн нь.)
4. Мэргэн Ухааны Үгэнд шаардлагагүйгэр эм хэрэглэхийг хориглосон уу? (Тийм.)
5. Мэргэн Ухааны Үгэнд бидэнд идэх хэрэгтэй хоол хүнсийг жагсаасан байдаг уу? (Тийм.)
6. Та нар их идсэнээр Мэргэн Ухааны Үгийн сүнсийг хадгалсаар байж чадах уу? (Үгүй.)

Энэ хичээлд эдгээр асуултын хариулт байгаа гэдгийг хэл. Залуу эрэгтэйчүүдэд хичээлийн үеэр анхааралтай сонсож хариултуудыг олж авна гэдгийг зөвлө.

Их Эзэн Бидэнд Эрүүл Мэндийн Хуулийг ӨгсөнСамбар ба
ярилцлага

Их Эзэний эрүүл мэндийн хуулийг Сургаал ба Гэрээ 89-өөс олж болно гэдгийг хэл. Хичээлийн явцад самбарын үзүүлэнг харуул.

Мэргэн Ухааны Үг (С ба Г 89)

1-р хэсэг: Зорилго (С ба Г 89:1–4)

1. Гэгээнтнүүдэд тусална
2. Хамгийн наад захын хууль
3. Хүмүүсийн хуйвалдааныг анхааруулан сэрэмжлүүлдэг

2-р хэсэг: Хоригууд (С ба Г 89:5–9)

Хортой бодисоос зайлсхий

3-р хэсэг: Зөвшөөрөгдсөн зүйлүүд (С ба Г 89:10–17)

Тэжээллэг хоол хүнс хэрэглэх

4-р хэсэг: Амлалтууд: (С ба Г 89:18–21)

1. Эрүүл мэнд
2. Мэргэн Ухаан ба мэдлэг
3. Сүйтгэх тэнгэрийн элч нар биднээс зайлан өнгөрнө

Мэргэн Ухааны Үгэнд дөрвөн гол хэсэг байдаг гэдгийг хэл.

Залуу эрэгтэйчүүдээр Сургаал ба Гэрээ 89:1–4-ийг уншуул. Энэ бол илчлэлтийн нэгдүгээр хэсэг гэдгийг хэл. Эдүгээр шүлгүүдийн утгыг ярилцан дараах санаануудыг самбарт жагсааж бич.

1. *Мэргэн Ухааны Үгийг Гэгээнтнүүдийн тусын төлөө өгсөн.*

2. *Энэ нь амьдрахад амархан хамгийн наад захын хууль.*

3. *Энэ нь нүгэл болон хүмүүсийн хуйвалдаанаас хамгаалдаг.*

• Мэргэн Ухааны Үгийн хамгийн нийтлэг хэсэг нь юу вэ? (Архи, тамхи, халуун унд (цай, кофе) ууж хэрэглэхгүй байх зарлиг.)

Залуу эрэгтэйчүүдээр Сургаал ба Гэрээ 89:5–9-ийг уншуул.

Энэ бол Мэргэн Ухааны Үгийн хоёр дахь хэсэг гэдгийг тайлбарла. Эдгээр шүлгүүдийн утгыг ярилцаад, энд дурьдсан хортой хоол, эмнүүдийг нэрлүүл. Тэдний хэлснийг самбарт бич. Хэрэв “халуун унд”-ны талаар асуулт гарвал энэ нь цай болон кофе гэдгийг тайлбарла. Хэдийгээр эмнүүдийн талаар тодорхой бичигдээгүй ч орчин үеийн бошиглогчид энэ сэдвээр ярьсан юм.

Ишлэл

“Сүм эм болон түүнтэй төстэй бодисыг буруу, хортойгоор хэрэглэж донтуулах байдалд хүргэх бие махбод, оюун ухааныг муутгах болон ёс суртахууны доогуур жишигт хүргэх байдалтайгаар хэрэглэхийн эсрэг үргэлж байдаг. Бид энэ хэлснийгээ дахин баталж байна” (Spencer W. Kimball, in Conference Report, Apr. 1974, p. 8; *Ensign*, May 1974, p. 7).

Судар ба ярилцлага

Их Эзэн хүмүүст муу зүйлээс илүү сайн зүйлийн талаар зөвлөгөө өгсөн гэдгийг хэл. Залуу эрэгтэйчүүдээр уншуулах буюу өөрөө Сургаал ба Гэрээ 89:10–17-г унш. Эдгээр шүлгүүдийг ярилцаад Их Эзэн хүмүүст юу идэхийг зөвлөснийг онцол. Самбарт *тэжээллэг хоол идэх* гэж бич.

• Дэлхийн сайн зүйлсийг бид болгоомжтой ба талархалтайгаар хэрэглэ гэж 11-р шүлэгт бичсэн нь ямар учиртай вэ?

Нэг залуу эрэгтэйгээр Сургаал ба Гэрээ 88:124-ийг уншуул.

• Бидэнд эрүүл мэндийн талаар ямар зөвлөгөөг энд өгсөн бэ?

Их Эзний Эрүүл Мэндийн Хуулинд Дуулгавартай Байх нь Адислалуудыг Авчирдаг

Судар ба ярилцлага

• Энэ хуулийн дагуу амьдарсан хүмүүсийн бие махбодийг сайн байлгах ямар адислалуудыг Тэнгэрлэг Эцэг өгөхөөр амласан бэ?

Нэг залуу эрэгтэйгээр Сургаал ба Гэрээ 89:18, 20-ийг уншуул. Залуу эрэгтэйчүүдтэй энэ шүлгүүдийн талаар ярилцаж, тэдэнд адислалуудыг онцолж тусал. Самбарт бич:

1. *Эрүүл мэнд*

Шинжлэх ухаан Мэргэн Ухааны Үгийн эрүүл мэндийг сайжруулсан нотолгоог үргэлжлүүлэн цуглуулсаар байна гэдгийг хэл. Мэргэн Ухааны Үгт нэмэрлэх сүүлийн

үеийн мэдээллийг тэдэнтэй хуваалц. Ямар ч спортын дасгалжуулагч тамирчнаа энэ зарчмуудыг тоохгүй байхыг зөвлөхгүй. Энэ зарчмуудыг сахих нь бидний биеийг илүү их эрүүл бас хүчтэй болоход бидэнд тусална.

- Мэргэн Ухааны Үгийг сахиагүй хүмүүст ямар сүнслэг адислалууд өгөгдөхгүй вэ? (Хариултанд Ариун Сүнсний нөхөрлөл, пристийн зэрэгт өсөх, номлол, ариун сүмд орох зэрэг багтана.)

Аароны пристийн зэрэгтэн сүнслэгээр цэвэр байхын тулд бие махбодио цэвэр байлгах ёстой гэж онцол. Залуу эрэгтэйчүүдэд, ариун сүмийн зөвшөөрөл авах, номлолд явах, усан баталгаа хийлгэх, пристийн зэргээ ахиулахын өмнө бишоптой ярилцлаганд орсон байх ёстой гэдгийг сануул. Ярилцлагаар бишопын асуух ёстой нэг зүйл бол тэр хүн Мэргэн Ухааны Үгийг сахиж байгаа эсэх юм.

Судар ба ярилцлага

Нэг залуу эрэгтэйгээр Сургаал ба Гэрээ 89:19, 21-ийг уншуул.

- Энэ шүлгүүдэд ямар нэмэлт адислалуудыг дурдсан вэ?

Дараах зүйлүүдийг самбарт нэмж бич.

2. *Мэргэн ухаан ба мэдлэг*

3. *Сүйтгэгч тэнгэр элчүүд биднээс зайлан өнгөрнө.*

Ишлэл

Ерөнхийлөгч Н.Элдон Таннер энэ адислалуудыг хүлээн авах өөр нэг түлхүүр өгснийг хэл:

“Би энэ илчлэлтийн сүүлчийн дөрвөн шүлгийг Их Эзэний бидний ашиг тусын тулд өгсөн хамгийн гайхамшигт адислалуудын нэг гэж боддог.

“Бид ихэнхдээ Мэргэн Ухааны Үгийг сахиснаар адислалууд ирнэ гэж боддог боловч хэрэв та нар эхний өгүүлбэрийн “зарлигуудад дуулгавартай явах” гэснийг анхаарвал энэ нь зөвхөн энэ илчлэлт дэх зөвлөснийг бус харин адислал авахын тулд бусад зарлигуудыг ч сахих хэрэгтэй гэсэн утгатайг илтгэдэг” (“Trusting the Lord’s Promise,” *Ensign*, Aug. 1981, p. 2).

Залуу эрэгтэйчүүдэд Их Эзэний мэдлэг, эрүүл мэнд, сүүлчийн үеийн хамгаалалтуудын адислалууд зөвхөн Мэргэн Ухааны Үг биш түүний бүх зарлигуудыг сахиснаар ирэх болно гэдгийг ойлгуул.

- Мэргэн Ухааны Үгийг сахиснаар та нар хэрхэн адислагдсан бэ?

Түүх

Маш олон хүмүүс Их Эзэний амласан адислалуудыг хүртэхүйцээр зохистой амьдарснаар ирэх ёс суртахуун болон биеийн зориг ба хүч чадлын адислалуудаар адислагдсан гэдгийг хэл. Энэ байдлаар адислагдсан Айлз оф Мэн арлын нэг залуу эрэгтэйн тухай дараах түүхийг унш.

“Би бага зэрэг хичээллэсэн боловч тэр орой хадан дээр байсан хүч чадалдаа итгэдэггүй. Би дагасан хүн бүхэнд амлагдсан Мэргэн Ухааны Үгийн амлалт надад ирснийг мэдэрсэн юм.

“Би нутгийн Барбара Глэн клубээс ирж явахдаа хэсэг найзтайгаа тааралдсан юм. Зарим нэг нь архи уучихсан, тэд хэвийн биш байв. Хоёр нь өөр замаар гэртээ харихаар яваад өгөв.

“Хоёр замаар буцаж болох байв. Нэг бол илүү аюулгүй болох ердийн замаар явж болно. Эсвэл салхитай боловч сайхан харагдаж байгаа далайн эргийн замаар явж болно. Миний найзууд хоёр дахь замыг нь сонгов. Би голдуу зам даган алхдаг боловч найз нарыгаа харж явахаар тэдэнтэй хамт явав.

“Тэдний нэг нь гуйвж эхэлснээ гэнэт хад руу уначихав. Нөгөө нэг залуу түүнд туслахаар очсон боловч өөрөө бас уначихав. Энэ хад бүр цэх, шулуун биш боловч нэлээд өндөр байсан ба тэд нэг гараараа дүүлжгдсэн байв. Тэд амархан доош унаж болох байсан ба тэд буцаж дээш гарч чадах байсан эсэхийг би мэдэхгүй.

“Би тэдний гараас нь нэгэн зэрэг барьж аваад дээш нь татав. Би зөвхөн татах биш тэднийг бүүр зам дээр гартал нь суга татсан байв. Сургаал ба Гэрээ 89-р хэсгийн Мэргэн Ухааны Үгийн амлалтын ‘гүйгээд ядрахгүй ба алхаад цуцахгүй’ (шүлэг 20) гэсэн амлалтын үгнүүд миний толгойд орж ирсэн билээ.

“Тэд гайхацгааж байв. Би ч бас гайхаж байлаа. Тэд, ‘За за, өнөө орой чи архи уугаагүй нь ямар сайн болж,’ гэж хэлэв. Би тэдэнд, ‘энэ чинь үнэндээ миний шүтлэг та нарыг аварлаа даа,’ гэж хэлсэн юм.

“Би бүх амьдралынхаа турш Мэргэн Ухааны Үгийг сахихыг хичээж байна. Энэ арал дээр хэдий архи, хар тамхи, тамхи хэрэглэх нь улам ихэсч байгаа ч үүнийг сахих нь амар болохыг би мэдсэн юм. Би бага байхдаа Ерөнхийлөгч Спэнсэр В. Кимболлын жишгүүдийг дагахаар шийдвэл уруу таталттай тулгарах үед түүнээс хол байх шийдвэр гаргахад хялбар болдог гэж ярьсныг сонссон юм.

“Би үнэхээр тэр хэлсэн зүйлийг нь амьдралдаа хэрэгжүүлэхийг хичээсэн ба тэр шөнө далайн эргийн зам дээр үүнийг хэрэгжүүлсэндээ үнэхээр баярлаж байв. Мэргэн Ухааны Үгийг сахиснаар тэр үед надад илүү хүч чадал өгөгдсөн гэдэгт би итгэдэг юм ” (Daniel Johnson, “Cliff Hanger,” New Era, Nov. 1992, pp. 14-15).

- Энэ залуу эрэгтэйн хэлснээр тэр шөнө яагаад тэр хүч чадал хүлээн авсан бэ?
- Хэрэв энэ эрэгтэй Мэргэн Ухааны Үгийг сахиагүй бол юу болох байсан гэж та нар бодож байна?

Дүгнэлт

Оршлын сорилтыг тоймлоод залуу эрэгтэй бүр зөв ойлгосныг бататга. Та нэг залуу эрэгтэйгээр *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө товхимлын* хуудас 12–13 дахь оюун ухаан болон биеийн эрүүл мэндийн талаар өгсөн зөвлөгөөг уншуулж болно.

Уриалга

Залуу эрэгтэйчүүдийг одооноос эхлэн Мэргэн Ухааны Үгийг сахихыг уриал. Тэдэнд үүнийг сахвал агуу адислал ирнэ гэдгийг хэл. *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө товхимлын* хуудас 12–13 дахь оюун ухаан болон биеийн эрүүл мэндийн талаар өгсөн зөвлөгөөг дахин уншихыг зөвлө.

Гэрчлэл

Мэргэн Ухааны Үгийг сахихын үнэ цэнэ болон бие махбодио зөв анхаарч байхын чухлын талаар гэрчлэлээ хуваалц.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр хүндэтгэлийн өдрөөр зөв зохистой үйл ажиллагааг хэрхэн сонгох талаар мэдэх болно.

БЭЛТГЭЛ

- Шаардагдах материалууд:
 - Залуу эрэгтэй бүрт судар.
 - Залуу эрэгтэй бүрт цаас харандаа.
- Ахлагч Жийн Р.Күүкийн ярьсан түүхийг нэг залуу эрэгтэйгээр уншуулахаар томил.
- Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимлын 16–17-р хуудсан дахь Ням гарагт биеэ авч явах талаарх зөвлөмжийг тоймло.

ТАЙЛБАР

Бид Хүндэтгэлийн Өдөр нь өдөр тутмын ажил ба зугаа цэнгэлд мар хурднаар автагдан Хүндэтгэлийн Өдрийнхөө чухал ба ариун чанарыг алдаж байгаа дэлхийд амьдарч байна. Залуу хүмүүс Хүндэтгэлийн Өдрөөр олон замаар уруу татагдан зөрчиж байна. Хэрэв тэдэнд гарч болох нөхцөл бүрт зориулсан 'болно,' 'болохгүй'-н жагсаалт биш харин Хүндэтгэлийн Өдрийг сахих журмын жагсаалт байвал тэд магадгүй илүү аюулгүй байх байсан. Сүнслэг байдлаар боловсорсон хүн Хүндэтгэлийн Өдрийн үйл ажиллагааны нийцтэй байдлыг судрын удирдамж болон сүнсний зааврыг сонсож дүгнэн шинжлэхийг сурдаг. Залуу эрэгтэйчүүдэд энэ удирдамжууд нь юу болохыг ойлгуул.

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

Нөхцлийн судалгаа

Оршил

Сэм Хүндэтгэлийн Өдрийг ариунаар сахих тухай будилж байлаа. Тэр Их Эзэнд хайртай ба түүнд бишрэх гэж тогтоон өгсөн өдөр түүнд зөвөөр үйлчлэхийг хүсэж байсан боловч тэр сүмд очихоос өмнө болон дараа нь юу хийхээ мэдэхгүй байв. Түүний зарим найзууд Хүндэтгэлийн Өдөр гадуур огт гардаггүй байхад нөгөө хэсэг нь гадаа нэлээд их цагийг өнгөрүүлдэг байв. Зарим найзууд нь Хүндэтгэлийн Өдөр хичээлээ хийдэг байхад нөгөө хэсэг нь хийдэггүй байв. Сэм Хүндэтгэлийн Өдрийг ариунаар хэрхэн сахихын тулд юу хийх ёстой талаар будилж байв.

- Та нарт Сэм шиг санагдаж байсан уу?
- Хүндэтгэлийн Өдөр ямар нэг юм хийх нь зөв гэдгийг бид хэрхэн мэдэх вэ?

Судрууд Бидэнд Зохистой Хүндэтгэлийн Өдрийн Үйл Ажиллагааны Заавар Өгдөг

Судар ба ярилцлага

- Ням гаригуудад ер нь та нар юу хийдэг вэ?

Асуултыг товчхон ярилцаад, сүүлд энэ хичээлийн дундуур эргэн энэ асуулт руу орно гэдгээ хэл.

Залуу эрэгтэйчүүдээр Египтээс гарсан нь 20:8-ыг уншуул.

- Их Эзэн Хүндэтгэлийн Өдрийн талаар ямар зарлиг өгсөн бэ? (Ариунаар нь сахих.)
- Бид *ариун ариун сүм* болон *ариун пристийн зэрэг* гэж ярьдаг. *Ариун* гэж юу гэсэн утгатай вэ? (Бурханы үйлчлэлд зориулан онцгойлон адисласан буюу ариусгасан.)

Самбарын танилцуулга

- Бид ямар нэгэн зүйлийг бид Ням гаригийн үйл ажиллагаанд тохирч байгаа эсэхийг шийдэхийн тулд ямар асуултууд тавьж болох вэ?

Дараах үгсийг самбарт бич:

Хүндэтгэлийн Өдрийн Үйл Ажиллагааг Дүгнэн Шинжлэх

Миний үйлдэл ариун буюу Бурханд үйлчилж байна уу?

Та нэг залуу эрэгтэйгээр *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө товхимлын 16–17-р* хуудсан дахь Ням Гаригаар бишрэх тухай зөвлөгөөг уншуулж болно.

Судар ба ярилцлага

Есүс Хүндэтгэлийн Өдрийг зөвөөр баримтлах хууль өгөхөөсөө илүү Хүндэтгэлийн Өдөр зохистой үйл ажиллагааг сонгоход биднийг удирдах ёстой зарчмуудыг зааж өгсөн.

Залуу эрэгтэйчүүдээр Марк 3:1–5-ыг уншуул.

- 4-р шүлэг дэх Аврагчийн асуултанд та нар хэрхэн хариулах вэ?
- Хүндэтгэлийн Өдрүүдэд сайныг хий гэдгийг та нар юу гэж ойлгож байна вэ? (Бид Сүнсний зааврыг сонсвол сайн зүйлийг хийж байгаа эсэхээ хэлж чадна гэдгийг анхааруул.)

Дараах асуултыг самбарт нэмж бич: Энэ нь *сайныг хийж байна уу?*

Залуу эрэгтэйчүүдээр Сургаал ба Гэрээ 59:9–13-ыг уншуулж тэмдэглүүл.

- Ням Гаригуудад биднийг хаашаа явахыг тушаасан бэ? (“Залбирлын гэр” болох Сүм рүү.)
- Тэнд бид юу хийдэг вэ? (Ариун ёслолоос хүртэж Бурханд сүсэглэнэ)
- Их Эзэн бидэнд яагаад энэ зарлигийг өгсөн бэ? (“Биднийг дэлхийн нүглээс” хамгаалахын тулд.)
- Хэрэв Ням Гаригт үзвэр үйлчилгээний газар руу болон дэлгүүр явбал өөрсдийгөө дэлхийн нүглээс хол байлгаж чадах уу?
- Хүндэтгэлийн Өдрийг зөв сахиж мөрдөх нь биднийг дэлхийн нүглээс өөрсдийгөө хамгаалахад хэрхэн туслах вэ? (Бодол санаагаа Бурхан ба мөнхийн ач холбогдолтой зүйл рүү төвлөрүүлэхэд бидэнд тусалдаг.)

Самбар, судар
ба ярилцлага

Дараах асуултыг самбарт нэмж бич: Энэ нь *намайг дэлхийн нүглээс хамгаалж байна уу?*

Нэг залуу эрэгтэйгээр Исаиа 58:13–14-ийг уншуул.

- Хүндэтгэлийн Өдрийг ариунаар сахих ямар заавруудыг Исаиа бидэнд өгсөн бэ?
- Хөл нь дагахын билэг тэмдэг бөгөөд “өөрийн таашаалыг үйлдэхээс татгалзан хөлөө татах” гэдэг нь Хүндэтгэлийн Өдөр өөрийнхөө хүслийг бүү дага гэсэн үг болохыг тайлбарла.

Самбарт дараах асуултыг нэмж бич: Энэ нь *Их Эзэнийг хүндэтгэж байна уу эсвэл хувиа бодож өөрийнхөө хүслийг дагаж байна уу?*

Самбар дээрх зааврууд Хүндэтгэлийн Өдрийн үйл ажиллагааны зохистой байдлын хэмжүүр болно гэдгийг хэл. Ийм заавар нь бүх нөхцөлд тохирсон дүрэм байхаас илүүтэйгээр илүү хөгжиж боловсорсон байхыг шаарддаг. Хэрэв та нар Хүндэтгэлийн Өдөр сайн зүйл хийхийг эрмэлзэн Ариун Сүнсний удирдамжийг сонсож эргэлзээтэй үедээ дараах асуултуудыг өөрөөсөө асуувал Хүндэтгэлийн Өдрийг сахихад илүү амархан байх болно:

1. Миний үйлдэл ариун буюу Бурханд үйлчилж байна уу?
2. Энэ нь сайныг хийж байна уу?
3. Энэ нь намайг дэлхийн нүглээс хамгаалж байна уу?
4. Энэ нь *Их Эзэнийг хүндэтгэж байна уу эсвэл хувиа бодож өөрийнхөө хүслийг дагаж байна уу?*

Та энэ жагсаалтыг залуу эрэгтэй бүрт өгч болно.

Ярилцлага

- Ням Гаригуудад ер нь та нар юу хийдэг вэ?
- Эдгээр үйл ажиллагаануудын аль нь энэ самбар дээрх заавруудтай тохирч байна вэ? (Тэдний хариултуудыг самбарт бич. Тэдний хариултанд сүмд явах, найз нөхөд

болон хамаатныдаа очих, гэр бүлийнхэнтэйгээ сайн мэдээний тухай ярилцах, тэмдэглэлийн дэвтэртээ бичих, гэрийн багшаар явах, судар болон бусад сайн мэдээтэй холбоотой номнууд уншиж судлах, ирэх долоо хоногийнхоо зорилгыг тодорхойлох зэрэг багтаж болно.)

• Та нар эдгээр зааврыг баримтлах өөр ямар зүйлийг Ням Гаригт хийж болох вэ? Хариултыг самбар дээрх жагсаалт дээр нэмж бич.

Үйл ажиллагаа

Залуу эрэгтэй бүрт цаас харандаа өг. Самбар дээр бичсэн үйл ажиллагаанаас хүн бүрээр Ням Гарагт хийхийг хүсэж байгаа үйл ажиллагааг нь бичүүл.

Хүндэтгэлийн Өдрийг Ариунаар Сахиx нь Бидний Сүнслэг Өсөлтөнд Нөлөөлдөг

Бодох асуултууд

• Хүндэтгэлийн Өдрийг зөв баримтлах нь бидний сүнслэг өсөлтөнд хэрхэн нөлөөлдөг вэ? Буруу хандлага нь бидний сүнслэг өсөлтийг хэрхэн бууруулдаг вэ?

Түүх

Далын нэгдүгээр чуулгын ахлагч Жийн Р. Күүк залуудаа сонины газар ажилладаг байхдаа Хүндэтгэлийн Өдрийг ариунаар нь сахиxын үнэ цэнийг хэрхэн сурсан түүхээ ярьсан юм. Урьд өмнө нь томилсон залуу эрэгтэйг энэ түүхийг ярьж өгөхийг хүс.

“Нэг бямба гарагийн үдээс хойш ажил дууссаны дараа миний менежер, намайг ирэх долоо хоногийн Ням гаригаас эхлэн Ням гариг бүрийн өглөө ажиллах хэрэгтэй байна гэж надад хэлэв. Дараа нь тэр намайг Ням гаригт ажилладаггүй зарчмаа өөрчилж магад гэж бодсон бололтой миний сонирхлыг татах гэсэн шиг цалин чинь 30 хувь нэмэгдэнэ гэж хэлэв.

“Тэр үг нь маш хүчтэй сонсогдсон боловч би “Би Ням гаригт ажиллаж чадахгүй гэдгээ баттай мэдэж байна” гэж хариулснаа мөн санаж байна.

““За, яахав, чи Ням гаригт ажиллахгүй бол би өөр туслах менежер олох болно,” гэж тэр хэлэв.

“Тэр өдөр би нүдэндээ нулимстай өрөөнөөс нь гарч билээ. Их Эзэнээс яагаад би Сүмээс болоод ажлаа алдах ёстой юм бэ? гэж асууж байснаа санаж байна. Би номлолдоо бэлтгэн ахиухан мөнгө хадгалахын төлөө маш их шаргуу ажиллаж байсан хэрнээ одоо би Ням гаригт ажиллахгүй юм бол ажлаа алдахад хүрэв.

“Би аавтайгаа зөвлөгөө авахаар ярилцахад тэр, ‘юу ч болсон бай чи зөв юм хийнэ гэдэгт би итгэж байна,’ гэж л хариулсан юм.

“Дараачийн хагас сайн өдөр нь очоод менежертээ Ням гаригт ажиллахгүй гэдгээ хэлэв. Тэрээр энэ нь нэгэнт миний сонголт учраас би нэг долоо хоног ажиллаад туслах менежер байхаа болих бөгөөд миний оронд ‘үнэхээр ажиллахыг хүссэн’ нэг залууг авна гэдгээ мэдэгдэв.

“Тэр өдөр би тав зургаан хоногийн дараа ажилгүй болно гэж маш их сэтгэл зовон ажлаасаа гарч билээ. Нэг жил хагасын дараа би номлолд явах байсан бөгөөд хангалттай мөнгөтэй болоогүй байв. Тэр долоо хоногт би маш их залбирав.

“Дараачийн ажил дээр өнгөрүүлсэн өдрүүд маш урт удаан юм шиг санагдаж дарга бид хоёр маш цөөхөн ярьсан юм. Би миний хамгийн сүүлчийн өдөр болох хагас сайн өдрийг хүлээж байв.

“Эцэст нь тав дахь өдөр ирлээ. Тэр орой намайг ажлаа дуусаж байхад менежер над дээр ирж сэтгэл нь их хөдөлчихсөн, ‘Жийн, чиний хийж байгаа чинь зөв бөгөөд миний чамайг Ням гаригт ажилла гэдэг нь буруу юм байна. Уг нь би нэг өөр шүтлэгтэй Ням гаригт ажиллахад бэлэн залуу олсон боловч чамайг миний туслах менежерээр ажиллаасай гэж би хүсэж байна. Үүнээс гадна, хэдийгээр чи долоо дахь өдөр ажиллахгүй ч гэсэн би цалинг чинь 30 хувь нэмж өгөх болно. Чи бол маш сайн залуу,’ гэж билээ” (At Any Cost, Keep the Commandments,” New Era, May 1977, p. 5).

• Ахлагч Күүкийн Хүндэтгэлийн Өдрийг ариунаар сахиx шийдвэр нь түүний сүнслэг өсөлтөнд хэрхэн нөлөөлсөн бэ? (Түүний итгэл болон гэрчлэлийг хүчтэй болгосон)

Зөвлөхийн танилцуулга	<p>Эмч, сувилагч нар гэх зэрэг зарим хүмүүс Ням гарагт ажиллах шаардлагатайг тайлбарла. Бид бүгдээрээ Их Эзэний тусламжтайгаар тэр шийдвэрийг гаргах ёстой. Хэрэв бид Хүндэтгэлийн Өдрийг ариунаар сахихыг эрмэлзэх юм бол Их Эзэн биднийг адислах болно. Хэрэв бид Хүндэтгэлийн Өдрийг ариунаар сахихгүй байх юм бол бид агуу адислалуудыг алдаж сүнслэг өсөлт маань буурах болно.</p> <ul style="list-style-type: none"> • Хүндэтгэлийн Өдрийг сахиснаар та нар хэрхэн адислагдаж байсан бэ?
Ярилцлага	<p>Хүндэтгэлийн Өдрийг сахих нь бидний сүнслэг өсөлтөнд бас өөрөөр нөлөөлж болно гэдгийг хэл. Хүндэтгэлийн Өдөр нь бидэнд бусдад үйлчлэх хамгийн сайхан боломжийг өгдөг.</p> <ul style="list-style-type: none"> • Та нарт Хүндэтгэлийн Өдөр бусдад үйлчилсэн ямар тохиолдол байсан бэ? • Хүндэтгэлийн Өдөр бид бусдад ямар байдлаар үйлчилж болох вэ? (Хариултанд өвчтэй хүн эргэх, номлогч болон үйлчлэгч хүнд захиа бичих, мацгийн өргөл цуглуулах, гэрийн багшаар явах зэрэг багтаж болно. Залуу эрэгтэйчүүдэд өөрсдийнхөө жагсаалтанд Хүндэтгэлийн Өдрийн эдгээр зохистой үйл ажиллагаануудаас нэмж бичихийг зөвлө.)

Дүгнэлт

Ишлэл	<p>Ерөнхийлөгч Жорж Алберт Смитийн дараах ишлэлийг унш:</p> <p>“[Их Эзэн] ачаа болохын тулд бус харин бидний амьдралд баяр баясгалан авчрахын тулд нэг өдрийг долоон өдрөөс онцгойлон адисласан” (“Obey the commandments,” <i>Improvement Era</i>, Jan. 1949, p. 9).</p>
Уриалга	<p>Залуу эрэгтэйчүүдэд Ерөнхийлөгч Смитийн хэлснээр энэ хичээлээр сурсан Ням гарагийн үйл ажиллагааг судрын заавруудыг ашиглан сонгож авахыг уриал. Тэгээд Хүндэтгэлийн Өдөр бүрийн төгсгөлд тэр өдрийнхөө тухай мэдрэмжээ тэмдэглэлийн дэвтэртээ бичиж болно.</p> <p>Залуу эрэгтэй бүрээр <i>Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө</i> товхимлын зааврыг бодуулан Хүндэтгэлийн Өдрийг ариун байлгах тодорхой зүйлсийг нь бичүүл.</p>

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр мөнх бус амьдралынхаа зорилгыг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд: залуу эрэгтэй бүрт судар.
2. Хүсвэл та зарим ишлэл болон шүлгийг залуу эрэгтэйчүүдэд урьдчилан даалгаж өгч болно.
3. Энэ хичээлийг заахад танд хоёр долоо хоног хэрэгтэй байж болно.

ТАЙЛБАР

Энэхүү хичээлд, та залуу эрэгтэйчүүдтэй хамт амьдралын зорилгыг тоймлох болно. Үүнд дараах арван хэсгээр амьдралын тухай өөрсдийн мэдлэг болон сэтгэгдлийг хуваалцах боломжийг тэдэнд өгнө. Залуу эрэгтэйчүүдийг амьдралын хэсэг бүрийн талаар өөрсдийгөө чөлөөтэй илэрхийлэхэд нь урамшуул. Энэ бол давтлагын хичээл юм. Ярилцлагын нэг хэсэг дээр тогтож ярилцахын оронд цааш нь үргэлжлүүл, тэгвэл залуу эрэгтэйчүүд авралын төлөвлөгөөг бүхлээр нь ойлгох болно.

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

Самбар ба
ярилцлага

Төлөвлөгөөг Давтах нь

Самбарын дээд талд *Амьдралын Зорилго* гэж бич. Залуу эрэгтэйчүүдээс амьдралын зорилгоо өөрийн үгээр тайлбарлахыг хүс.

Энэ хичээлээр амьдралын арван хэсгийг нарийвчлан үзнэ гэдгээ залуу эрэгтэйчүүдэд хэл.

Таны ярилцлаганд туслахын тулд зөвлөх бүрийн танилцуулга нь (1) амьдралын тухайн үе шатанд юу чухал болох талаар товч тайлбар, (2) холбогдох судар эсвэл ишлэлүүд, (3) ярилцлагыг өрнүүлэхэд дэмжих асуултуудаас бүрдсэн байна.

Хичээлд гарч буй санаа болгоныг самбарт бич. Тэгээд өөр өөр залуу эрэгтэйгээр холбогдох судар буюу ишлэлээс нэг хоёрыг уншуулж, хамтдаа ярилц. Эцэст нь, залуу эрэгтэйчүүдийн амьдралын тодорхой үе шатны тухай ойлголтыг тэлэхэд нь зөвлөмж болгосон асуултууд болон та нарын бэлтгэсэн бусад асуултуудыг авч үз.

Зөвлөхийн
танилцуулга

1. Төрөхийн Өмнөх Амьдрал

Бурхан тунхаглахдаа, “Би бол Бурхан, бүх хүмүүсийг бие махбодтой байхаас өмнө би энэ дэлхийг бүтээсэн” (Мосе 6:51). Бидний сүнс биднийг бие махбодтой болж төрөхөөс өмнө Тэнгэр дэх Эцгийн дэргэд амьдарч байсан гэдгийг тайлбарла. Бидний энд хийж буй зүйл дараагийн амьдралд шагнал эсвэл саад болохтой адил тэнд хийж байсан зүйл маань энэ амьдралд нөлөөлдөг. Энэ агуу үнэн нь мөнх бус амьдралын зорилго болдог.

Судрууд ба
ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр дараах судруудыг уншуулж ярилц: Иеремиа 1:4–5; Сургаал ба Гэрээ 93:21–23; Абрахам 3:22–27.

- Анхны байдал гэж юу вэ?
- Хоёр дахь байдал гэж юу вэ?
- Анхны байдлаа хадгалснаар та нар ямар адислал авсан бэ?
- Дэлхийд ирнэ гэдгээ мэдээд та нарт ямар сэтгэгдэл төрсөн гэж та нар бодож байна вэ?

Зөвлөхийн танилцуулга	<p>2. <i>Төрөлт</i></p> <p>Төрөлт бол Бурханаас өөрийн хүүхдүүдэд өгсөн гол төлөвлөгөөний нэг алхам гэдгийг тайлбарла.</p> <p>Нэг залуу эрэгтэйгээр Вилиам Вордсвортын “магтаал: мөнх бус амьдралын өмнөх амьдралын нуулга, хүүхэд насны дуртгалаас” хэсгийг уншуул. Залуу эрэгтэйчүүдэд энэ шүлгийн утгыг ойлгуул.</p> <p style="padding-left: 40px;">“Бидний төрөлт бол унталт ба марталт; Бидэнтэй хамт босох Сүнс бидний амьдралын од, Өөр хаа нэгтэйгээс эхлэн, Холын холоос ирсэн; Бүгдийг ор тас марталгүй Бүүр нүцгэн байгаагүй Харин сүр жавхлангийн үүлийг нэвтлэн Бидний гэр болох Бурханаас бид ирдэг.”</p> <p>Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл ийн тодорхойлсон:</p> <p>“Хүүхэд мэндлэх нь санамсаргүй хэрэг биш юм. Энэ бол нарийн төлөвлөгдсөн хөтөлбөр юм. Их Эзэн өөр замыг бий болгож чадах байсан боловч тийм нөхцөлд эцэг эхчүүд хүүхдүүдээ хэрхэн хайрлаж тэднийгээ өсгөж чадах вэ? . . .</p> <p>“Энэ нь сүнснүүдийг дэлхийд авчирч тэдэнд өсөн бойжих боломжийг олгох бүхэл бүтэн хөтөлбөрийг хамгаалах энгийн бөгөөд зөв арга байсан юм” (The Lord’s Plan for Man and Women,” Ensign, Oct. 1975, p. 4).</p> <ul style="list-style-type: none"> • Яагаад олон Эцэг эхчүүд хүүхэд төрөх үед Тэнгэрлэг Эцэгт маш ойрхон байгаагаа мэдэрдэг вэ? • Вордсвортын бид “сүр жавхлангийн үүлийг нэвтлэн ирдэг” гэж ямар утгатай гэж та нар бодож байна вэ?
Зөвлөхийн танилцуулга	<p>3. <i>Итгэл</i></p> <p>Эцэг эхчүүд хүүхдүүддээ Их Эзэн Есүс Христэд итгэлтэй байх болон Их Эзэний өмнө зөв шударгаар алхах ёстойг заах хариуцлагатай гэдгийг хэл. Үүнийг эртнээс зааж эхлээд бүх амьдралынх нь турш заах ёстой. Хүүхэд өсөж том болох явцдаа сайн мэдээний олон зарчмуудыг сурч, итгэлээ хөгжүүлж, наманчлалыг хэрэглэх тухай сурч, дуулгавартай байдлын агуу хуулийг суралцдаг.</p>
Судрууд ба ярилцлага	<p>Залуу эрэгтэйчүүдтэй уншиж ярилцах хоёр буюу түүнээс дээш судрыг сонго. Матай 17:19–20; Ром 10:17; Еврей 4:2; 11:6, Сургаал ба Гэрээ 68:25.</p> <ul style="list-style-type: none"> • Энэ хэсэгт итгэлийн тунхагийн 4-р хэсэг яаж тохирох вэ? • Их Эзэн Есүс Христэд итгэлтэй байх гэж юу гэсэн үг вэ? (Алма 32:21; Ифэр 12:6-г үз). • Аароны Пристийн Зэрэгтэн итгэлээ хэрхэн хөгжүүлж чадах вэ?
Зөвлөхийн танилцуулга	<p>4. <i>Боловсрол</i></p> <p>Дараах хэсгийг унш:</p> <p>Бурханы алдар суу бол оюун ухаан билээ (С ба Г 93:36-г үз).</p> <p>Энэ амьдралдаа олж авсан оюун ухааны ямар ч зарчмууд нь дахин амилалтаар бидэнтэй хамт байх болно (С ба Г 130:18-ыг үз).</p> <p>Бид амьдралынхаа турш мэдлэг болон мэргэн ухааныг эрэлхийлж байх ёстойг тайлбарла.</p>
Судрууд ба ярилцлага	<p>Залуу эрэгтэйчүүдтэй уншиж ярилцах хоёр буюу түүнээс дээш судрыг сонго: Иохан 17:3; Сургаал ба Гэрээ 88:78–80, 118; 90:24; 130:18–21; 136:32–33.</p> <ul style="list-style-type: none"> • Та нарын сурсан болон сураагүй зүйлс мөнхийн ирээдүйд чинь хэрхэн нөлөөлөх вэ? • Хүн амьдралынхаа турш үргэлжлүүлэн суралцахаа бататгахын тулд юу хийж чадах вэ?

- Хэрэв та нар энэ амьдралыг өнөөдөр орхих гэж байгаа гэж бодвол боловсрол олж авах боломжоо хэрхэн ашигласан талаар юу гэж дүгнэх вэ?
- Ямар мэдлэг эзэмших нь бид бүгдэд илүү чухал вэ? Яагаад?

Зөвлөхийн танилцуулга

5. Мөнхөд Гэрлэх нь

Бидний бие махбодь болон сүнснүүд мөнх учраас гэр бүлийн хүрээ нь сайн мэдээний зарчим болон хуулиудад дуулгавартай байснаар мөнхийн болж болдог гэдгийг тайлбарла. Эдгээр зарчмуудын дотроос хамгийн гайхамшигтай нь цаг хугацаа болон мөнхөд гэрлэх юм. Энэ нандин ёслол ба зарчмаар дамжуулан зохистой хосууд зөвхөн үхтлээ бус харин үүрд хамтдаа байж болно.

Судрууд, ишлэл ба ярилцлага

1 Коринт 11:11, Сургаал ба Гэрээ 131:1–4-ийг уншаад ярилц.

Нэг залуу эрэгтэйгээр Ахлагч Брус Р. МакКонкийн дараах мэдэгдлийг уншуул:

“Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүний энэ дэлхийд хийх хамгийн чухал зүйл нь: 1. Зөв хүнтэйгээ зөв газар, зөв эрх мэдлээр гэрлэх; 2. Дуулгавартай хүмүүст Сэлэсчел хаант улсын өргөмжлөлийн өвийг батлан өгсөн Гэрлэлтийн энэ ариун болон төгс ёс журамтай холбогдуулан хийсэн гэрээгээ сахих явдал юм” (*Mormon Doctrine*, 2nd ed. {Salt Lake City: Bookcraft, 1966}, p. 118; italics deleted).

- Их Эзэн энэ зарчмыг яагаад чухалчилдаг вэ?
- Та нар амьдралынхаа энэ чухал үед хэрхэн бэлтгэж чадах вэ?
- Та нар Ариун сүмийн гэрлэлтэнд бэлтгэхдээ Их Эзэний тусламжийг хэрхэн авч чадах вэ?

Зөвлөхийн танилцуулга

6. Ажил ба Үйлчлэл

Дараахийг унш:

“Өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэн, газрыг эзэмш!” (Эхлэл 1:28). Энэ бол Бурханы дэлхий дээрх хүүхдүүддээ өгсөн анхны зарлиг байсан. Энэ нь чин сэтгэлээсээ хүн төрөлхтний нэр хүнд болон сайн сайхны төлөө шударга хөдөлмөрлөх нь чухал хэмээн бүгдэд өгсөн зөвлөмж юм.

Судрууд ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдтэй уншиж ярилцах хоёр буюу түүнээс дээш судрыг сонго: Эхлэл 3:19; Иохан 9:4; Филемон 2:12; Мозая 2:16–17; Сургаал ба Гэрээ 68:30–31; 75:29; 88:124; Мосе 1:39.

- Өнөөдрийн хийж буй зүйл чинь хэрхэн маргаашийн хийх зүйлийг чинь тодорхойлдог вэ?
- Гараа хумхин зогсох, амрах хоёрын ялгаа юу вэ?
- Үйлчлэл нь хүнийг хэрхэн өсгөдөг вэ?
- Үйлчлэл нь хайрыг хэрхэн өсгөдөг вэ?

Зөвлөхийн танилцуулга

7. Гэр Бүлийн Нэгдмэл Байдал

Эхнэр нөхөр болон тэдний хүүхдүүд тэнгэрлэг хуулийг сахиснаар тэдний гэр бүлийн нэгдмэл байдал ба аз жаргал нас барсны дараа ч үргэлжилнэ гэдгийг тайлбарла.

Судрууд ба ярилцлага

Дараах судруудыг уншаад ярилц: Египетээс гарсан нь 20:12; Ефес 6:1–4; Сургаал ба Гэрээ 121:41–42.

- Гэр бүлийнхээ нэгдмэл байдлыг хөгжүүлэхийн тулд та нар гэртээ юу хийж чадах вэ?

Зөвлөхийн танилцуулга

8. Саад Тотгор

Амьдрал асуудалгүй байна гэж үгүй гэдгийг хэл. Бид бэрхшээлийг даван туулж мөн муу ёрын сүнсийг эсэргүүцэж байж хүчтэй болдог. Төлөөлөгч Паул, “Их Эзэн хайрладаг хүнээ сахилгажуулдаг юм” гэжээ (Еврей 12:6).

Судрууд ба ярилцлага	<p>Залуу эрэгтэйчүүдтэй уншиж ярилцах хоёр буюу түүнээс дээш судрыг сонго: 2 Нифай 2:11; Сургаал ба Гэрээ 29:39; 31:9.</p> <ul style="list-style-type: none"> • Их Эзэн эсрэг тэсрэгийг яагаад амьдралын нэгэн хэсэг болгосон бэ? • Саад тотгорт та нар хэрхэн адислагдсан бэ? • Амьдрал ямар талаараа дэндүү амархан байж болох вэ?
Судар	<p>Абрахам 3:25–26-г дахин уншаад зарлигуудыг сахих нь залуу эрэгтэйчүүдийн амьдралд хэрхэн нөлөөлөхийг тэднээс асуу. Зарлигуудыг одооноос сахьвал аз жаргал авчирна гэдгийг ойлгуул. Үнэндээ зарлигуудыг сахих нь аз жаргал олох цорын ганц зам юм.</p>
Зөвлөхийн танилцуулга	<p>9. <i>Үхэл</i></p> <p>Үхэл нь төрөхтэй адил мөнхийн амьдралын нэг хэсэг гэдгийг тайлбарла. Эрт орой хэзээ нэгэн цагт бид үүнтэй тулгарах болно. Бид хайрладаг хүмүүс болон найз нөхөдтэйгөө дахин амьдарч болно гэсэн итгэл нь бидэнд агуу их тайтгарал болж чадна.</p>
Судрууд ба ярилцлага	<p>Залуу эрэгтэйчүүдтэй уншиж ярилцах хоёр буюу түүнээс дээш судрыг сонго: Алма 11:42; 12:24; Сургаал ба Гэрээ 29:42–43; 42:46–47.</p> <ul style="list-style-type: none"> • Хүмүүс яагаад үхлээс айдаг вэ?
Зөвлөхийн танилцуулга	<p>10. <i>Үхлийн Дараах Амьдрал</i></p> <p>Амьдрал бол мөнх гэдгийг сануул. Бидний сүнс хэзээ ч үхдэггүй ба сүнс болон биеийн нэгдэх нь бүгдэд амлагдсан: “Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьдруулагдах болно” (1 Коринт 15:22).</p>
Судрууд ба ярилцлага	<p>Залуу эрэгтэйчүүдтэй уншиж ярилцах хоёр буюу түүнээс дээш судрыг сонго: Алма 11:42–44; 40:4; 41:13–15; Мосе 1:39.</p> <ul style="list-style-type: none"> • Бүх дэлхийн Дахин амилалтын тухай мэдлэг нь та нарын хувьд ямар утгатай вэ? • Та нарт өгсөн энэ мэдлэгийн бэлэгтэй хамт Аврагчийг хайрлах та нарын хайр хэрхэн өссөн бэ? • Та нар одоо талархлаа илэрхийлэхийн тулд юу хийж чадах вэ?

Дүгнэлт

Ишлэл	<p>Дараах ишлэлийг унш:</p> <p>“Та өмнө нь юу болсныг санахгүй ба дараа нь юу болох тухай зөвхөн итгэл л бидэнд шивнэх дэлхийд амьдарч байна. Тохиолдлоор болон боломж олдоод бус харин мөнхийн агуу төлөвлөгөөний хэсэг учраас энд байгаадаа итгэлтэй бай.</p> <p>“Бидний доторхи чимээгүй, намуухан шивнээ болон сонгогдсон бошиглогчдынхоо илчлэлтээр дамжуулан Бурхан, Мөнхийн Эцэг өөрийнхөө хүүхдүүдийн үйл хэргийг удирдан залдаг.</p> <p>“Та нар энэ дэлхийд Тэнгэрлэг Эцгийнхээ хүслээр хийснээр ирэх бүрэн дүүрэн баяр баясгаланг олж суралцахаар ирсэн. Арван нэгэн төлөөлөгчиддөө зарлигуудыг сахих тухай ярьсныхаа дараа Есүс хэлэхдээ: ‘Миний баяр баясгалан та нар дотор байж, та нарын баяр баясгалан нь дүүрэн болохын тулд энэ бүхнийг Би та нарт хэлэв’ гэжээ (Иохан 15:11).</p> <p>“Дахин амилалт нь хүн бүрт Есүс Христээр дамжин ирсэн бэлэг боловч хамгийн дээд мөнхийн шагналыг та нар өөрсдөө олж авах ёстой. Есүс Христэд зөвхөн итгэх нь хангалттай биш. Та нар ажиллаж, сурч, хайж, залбирч, наманчилж, хөгжиж, түүний хуулиудыг мэдэж түүгээр амьдрах ёстой.</p> <p>“Энэ бол амар амгалан, аз жаргал, бүрэн дүүрэн мөнхийн амьдралд хүрэх зам юм. Энэ бол та нарын Тэнгэрлэг Эцгийн зам юм. . . .</p> <p>“Та нар Бурханы сүнслэг хүүхэд гэдэгтэй итгэлтэй бай. Та нар түүний үр удам. Түүнд та нарт болон өөрийнхөө бүх хүүхдүүдэд зориулсан хөгжил дэвшлийн төлөвлөгөө байдаг.</p>
-------	--

“Хүн хаанааас ирсэн бэ? Одоо та нар үе үеийн хүмүүсийн сониуч оюун ухааныг сорьж байсан энэ агуу асуултын хэсгийг ойлгож авлаа. Илүү гүн гүнзгий ойлголт нь та нарын энэ амьдрал болон үүрдийн амьдралд чинь илүү их агуу утга, зорилго, баяр баясгалан өгөх болно” (*Your Pre-Earth Life* [Salt Lake City: The Church of Jesus Christ of Latter-day Saints, 1976], p. 9).

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр Матай 25:31–34-ийг уншуул. Нэг залуу эрэгтэйг судар уншиж байхад бусад залуу эрэгтэйчүүдийг судар тэдэнд хэрхэн хамаарч байгааг бодохыг хүс.

- Хэрэв ирээдүйн нэг өдөр Есүс Христ “Эцгээр минь адислагдсан та нар нааш ир ертөнцийн үүслээс та нарт зориулан бэлтгэсэн хаант улсыг өвлөгтүн” гэж хэлбэл та нарт ямар санагдах вэ?
- Та нар одоо мөнхийн ирээдүйдээ бэлтгэн юу хийж байна вэ?

Гэрчлэл

Залуу эрэгтэйчүүдэд тэд мөнх бус байдлын өмнөх амьдралд шийдмэг байсан гэдгийг онцлоод Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт амьдрахын тулд энэ амьдралдаа зарлигуудыг сахихын чухлын талаар өөрийнхөө гэрчлэлийг хуваалц.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр энэрэл буюу Христийн ариун хайр бүх пристийн зэрэгтнүүдийн биеэ авч явах байдал ба үйлдлийг залж хөтлөх ёстой гэдгийг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

Шаардагдах материалууд:

1. Залуу эрэгтэй бүрт судар.
2. Судар тэмдэглэх харандаанууд.

ТАЙЛБАР

Христийн, амьдралдаа бусдад үзүүлсэн хайраас илүү ил тод ямар ч зарчим байхгүй. “Би та нарыг хайрласан шиг бие биенээ хайрла” гэсэн нь (Иохан 15:12) түүний бидэнд өгсөн зарлиг байсан. Энэрэл буюу Христийн ариун хайр нь бидний ирээдүйд хэзээ нэг цагт амьдарна гэж найддаг эрхэм дээд зарчим юм. Энэ хичээл залуу эрэгтэйчүүдэд энэрлийг одооноос эхлэн хөгжүүлж үүнийгээ өдөр тутмын үйл ажиллагааныхаа хэсэг болгохыг ойлгоход нь туслах ёстой.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Судар ба ярилцлага

Оршил

- Энэрэл гэдэг үгийг сонсоод та нарт юу бодогдож байна вэ?

Ярилц. Тэгээд Аврагч үүнийг сургаалт үлгэрээр заасныг хэл. Залуу эрэгтэйчүүдээр Лук 10:30–37 дахь сургаалт үлгэрийг уншуул.

- Прист ба Леви хүн яагаад өнгөрөөд явчихсан гэж та нар бодож байна вэ?
- Бусдад туслахгүй байгаа хүмүүс өөрийгөө хэрхэн зөвтгөдөг вэ?
- Самари хүн тэр хүнд яагаад тусалсан гэж та нар бодож байна вэ?

Энэ түүхэн дэх зовсон хүнийг тоохгүй өнгөрсөн хоёр хүн бол хэрэгцээтэй хүмүүст туслах үүргийг төрөхөөсөө хүлээн авсан ба тэр хүнд тусалсан Самари хүн бол Еврейчүүдээр гадуурхагдсан үндэстэн байсан гэдгийг ойлгуулдгаараа маш их хүчтэй түүх юм хэмээн тайлбарла (James E. Talmage, *Jesus the Christ* 3rd ed. {Salt Lake City: The Church of Jesus Christ of Latter Day Saints, 1924}, pp. 430-32-ыг үз).

- Энэ түүх самари хүнээр ямар зарчмыг үзүүлсэн бэ? Энэ бол Аврагчийн заасан хамгийн чухал зарчмуудын нэг юм. (Энэрэл хайр гэсэн үг.)

Ишлэл

Ахлагч Марион Д.Ханксын дараах мэдэгдлийг унш:

“Саяхан надад булчин болон мэдрэл нь өвчинд нэрвэгдсэн нэг хүүтэй уулзах боломж гарсан юм. . . . Тэр үргэлж бусдын хийдгийг хийхийг хүсдэг байжээ. . . .

“Жэй дикон байхдаа хэсгийнхээ бусад диконуудтай хамт ариун ёслол түгээдэг байжээ. Тэр алхаж, хөл дээрээ зогсож чадахгүй учир түүний аав Жэйг бүсэлхийгээр нь тэврээд бусад хөвгүүдийн ард зогсож, түүний гар тавиур барих тэнхээгүй учир түүнд тавиур барихад нь тусалдаг байв. Жэйгийн аав хүүгээ эгнээнээс эгнээнд ариун ёслол тараахад нь тусалдаг байв. Жэй мөн мацгийн өргөл цуглуулах диконы ажлыг хийдэг байв. Аав нь түүнийг хаалганаас хаалга руу өргөн явдаг байжээ.

“Жэй маш хүчтэй гэрчлэлтэй ба түүний зан төлөв болон биеэ авч яваа нь гайхалтай. Тэр маш сайхан яриа өгдөг байв. Тэр мөн Сүмд дуулдаг ба түүнийг энэ бүгдийг хийхэд аав нь түүнийг гар дээрээ өргөж дэргэд нь байж, дэмждэг байв” (in Conference Report, Tahiti Area Conference 1976, pp. 10-11).

- Энэ аав хүүдээ ямар зарчмыг үзүүлж байна вэ? (Хайр.)

Энэ аавын хүүдээ үзүүлсэн хайр бол Аврагчийн бидэнд үзүүлсэн болон түүний биднээс бусдад үзүүлэхийг хүссэн зүйл мөн гэдгийг хэл. Энэ бол энэрэл юм.

Судар, самбар
ба ярилцлага

Энэрэл бол Христийн Ариун Хайр

Залуу эрэгтэйчүүдээр Моронай 7:47-гоос энэрлийн тодорхойлолтыг уншуул. Залуу эрэгтэйчүүдэд энэ шүлгийг доогуур нь зурахыг зөвлө.

- Моронай энэрлийг юу гэж хэлсэн бэ? (Христийн ариун хайр.)

Энэ тодорхойлолтыг самбарт бич: *Энэрэл бол Христийн ариун хайр.*

- Энэрэл яагаад зүгээр “хайр” биш харин “ариун хайр” гэж нэрлэгддэг гэж та нар бодож байна?

Шинэ гэрээнд энэрлийг бас тодорхойлсон байдгийг хэл. Залуу эрэгтэйчүүдээр судраас 1 Коринт 13:4–6-г олуул. Та энэ шүлгүүдийг уншиж байхад залуу эрэгтэйчүүд энэрлийн янз бүрийн талуудыг олох болно. Тэдний олсныг самбарт хураангуйлан бич.

Энэрэл удаан тэвчдэг.

- *Удаан тэвчих* гэж юу гэсэн үг вэ? (Тэвчээртэй байх.)
- Удаан тэвчих нь биднийг Аврагчтай хэрхэн илүү адил болгох вэ? (Христийн хайр бол тэвчдэг, ойлгодог, мөнх ба биднийх мөн тийм байх ёстой.)
- Тэвчээртэй байх нь ямар үед хамгийн хэцүү вэ?
- Бид тэвчээрээ хэрхэн хөгжүүлж чадах вэ?

Энэрэл бол эелдэг.

- Хэнд эелдэг байхад илүү амархан бэ? Яагаад?
- Бид хүн бүхэнд хэрхэн эелдэг байж сурах вэ?

Энэрэл атаархдаггүй.

Бил сургуулийнхаа хөл бөмбөгийн багийн гишүүнээр сонгогдов. Түүний хөрш Алан бас хичээсэн боловч чадсангүй.

- Алан уг нь юу хийж болох вэ? (Атаархах, жөтөөрхөх.)
- Хэрэв тэр энэрэнгүй бол юу хийх вэ? (Найзынхаа амжилтанд баярлах.)

Энэрэл их зан гаргадаггүй ба ихэрхдэггүй.

Роберт дүнгийн хуудсаа авахаар явахдаа найздаа “Би үнэндээ хуудсаа авах хэрэггүй үргэлж л А-нууд байдаг юм чинь,” гэж хэлжээ.

- *Их зан* гэж юу вэ? (Онгирах.)
- Онгирахын муу тал нь юу байж болох вэ? (Бид онгирах буюу сагсуурах үедээ бид бусдаас илүү гэж хэлдэг ба бусдыг доош нь хийж, бусад хүмүүс бидэнтэй адил сайн биш гэж хэлдэг.)
- Энэ нөхцөлд энэрэнгүй хүн юу хийх вэ?

Онгирах нь ихэнхдээ өөрсдийгөө бусдаас илүү гэж харуулах оролдлого ба бидний ахан дүүсийн болон хайрын сэтгэлийг устгадаг гэдгийг сануул.

Энэрэл зохисгүй авирладаггүй.

- Яаж зохисгүй авирлаж болох вэ? (Бүдүүлэг, боловсон бус, үзэмжгүй болон доромжилсон зан ааш).
- Ийм зан ааш нь яагаад энэрэнгүй бус байдаг вэ? (Хэрэв хүн үнэхээр бусдад хайртай бол тэдэнтэй бүдүүлэг харьцахгүй.)

Энэрэл өөрийнхийгөө эрдэггүй.

Өөрийнхийгөө эрдэггүй гэдэг нь хувиа боддоггүй гэсэн үг юм.

- Хувиа бодохгүй байгаагаа ямар замаар үзүүлж болох вэ? (Залуу эрэгтэйчүүдийн хариултанд гэрийнхэн, сургууль дээрээ, Сүм дээрээ болон бусад хүмүүст үйлчлэх байж болно.)

Залуу эрэгтэйчүүдээс гэр болон сургууль дээрээ хувиа боддог болон хувиа боддоггүй жишээнээс үзүүлэхийг хүс.

Энэрэл амархан уурладаггүй.

Нэгэн маш хүйтэн өдөр Жэф өөрийнхөө гадуур хувцсыг олохоор яарч байлаа. Тэр сургуулиасаа хурдан явж найзуудтайгаа кинонд явахыг хүсэж байв. Жэф гадуур хувцсаа авахаар очтол хувцас нь өөрийнх нь өлгүүрт болон тэр хавиар байхгүй байв. Тэр байж болох бүх газраар хайж эцэст нь хагас цагийн дараа хогийн савны араас олжээ. Түүнийг гэртээ ирэхэд найзууд нь явчихсан байв. Түүнийг гэрийнхээ урд довжоон дээр уруу царайлан сууж байхад нь хөрш Данни нь толгойгоо хаялан баясгалантайгаар “Хөөе Жэф чи хувцсаа олсон уу?” гэж асуув. Данни үргэлж дүрсгүйтдэгийг мэдэх боловч энэ мөчийг хүртэл хөгжилтэй биш юм байна гэдгийг Жэф ойлгоогүй явжээ.

- Даннигийн дүрсгүйтсэнд Жэйф хэрхэн хандах вэ?

Хэрэв Жэф Даннид *энэрэл* үзүүлбэл хэдий тэр гомдсон ч гэсэн түүнд уурлахгүй байх болно гэдгийг залуу эрэгтэйчүүдэд ойлгуул.

Энэрэл нүгэл хилэнцийг боддоггүй.

Нүгэл хилэнц боддог жишээнүүд бидний эргэн тойронд өдөр бүр байдаг.

- *Нүгэл хилэнц бодно* гэж юу гэсэн үг вэ?

Хоорондоо ярилцаад *нүгэл хилэнц бодно* гэдэг хоёр утгатай болохыг анхааруул. Нэгд, ариун бус зохисгүй бодол бодох. Хоёрт, бусад хүмүүс үргэлж зөв шударга бус зорилгоор юм хийж, ярьж байна гэж бодох.

- *Нүгэл хилэнц бодох нь та нарын зан чанарт хэрхэн нөлөөлөх вэ?* (Учир нь тэр дотроо боддогтойгоо адил. [Сургаалт үгс 23:7].)

Энэрэл зөв бус байдалд баярладаггүй харин үнэнд баярладаг.

- Зөв бус байдалд баярладаггүй гэж юу гэсэн үг вэ?
- Зарим хүмүүс зөв бус байдалд хэрхэн баярладаг вэ?
- Үнэн яагаад бидний амьдралд тийм их чухал вэ?

Зөвлөхийн
танилцуулга

Христ бол хайрын агуу жишээ байсан гэдгийг хэл. Тэр бидэнд өөрийн жишээгээр хөршөө хэрхэн хайрлахыг заасан. Энэрэл бол түүний биднийг хайрласан хайр юм. Энэ нь нөхцөл шаардаагүй, ариун хайр юм. “Энэ бол эзэмшигч нь өөрийн болон түүнийг хүрээлэн байгаа бусдын мөнхийн сайн сайхнаас өөр ямар ч хүсэл зорилгогүй зөв шударга дээр төвлөрсөн хайр юм” (Bruce R. McConkie, *Mormon Doctrine*, 2nd ed. [Salt Lake City: Bookcraft, 1966], p. 121). Энэ бол Христийн заасан бусад бүх зарчмуудын адил хамгийн чухал зарчим юм.

Судар ба ярилцлага

1 Коринт 13:1–3-ыг унш.

- Бид хэрхэн энэрэнгүй болон хайрладаг байж чадах вэ?

Залуу эрэгтэйчүүдээр хариулуулаад Моронай 7:48-ыг уншиж, ярилцаж, энэ шүлгийг тэмдэглүүл.

Энэрэл Бол Мэдрэмжийнхээ Адилаар Хийдэг

Түүх

Ле Гөүтс Ахын аавынхаа тухай ярьсан Бишоп Ван Фитерстөүны энэрэлийн тухай түүхийг унш:

“Тэр жил өвөл [1918] эрт болж . . . хөрсөндөө байсан чихрийн манжингийн ихэнхийг хөлдөөлөө. Аав, Францис ах хоёр өдөр бүр хөлдүү хөрснөөс нэг тэрэг чихрийн манжин ухан гаргаж, нэг нэгээр нь оройг нь таслан, чихрийн манжингийн том улаан тэргэнд ачин чихрийн үйлдвэр лүү зөөдөгсөн. Флойд ах бид хоёр цэрэгт байсан тул энэ нь хөрс хөлдсөний дараа туслах хүчээр дутмаг хэцүү ажил байлаа. . . .

“Тэд гэр бүлдээ мөнгө олох ганц зүйл болох ургацын ажилд өдрийн ганц хоолтойгоор зүтгэж байхад Чарлс ахын есөн настай хүү Кеннет хүнд хатгаа хүрч хэдхэн цагийн дараа эцгийнхээ гар дээр амьсгаа хураасан тухай том ах (ойролцоогоор 60 мильд орших Юта Мужийн Огдэний Аж Үйлдвэрийн Сургуулийн захирал) Жорж Алберт муу мэдээ дуулгаж, аавыг Огдэнд ирж, хүүг гэр бүлийнх нь булш, Лихайн оршуулгын Газарт хүргэхийг хүсэн утсаар ярьжээ.

“Бяцхан ачийнхаа цогцсыг оршуулахаар гэртээ авчрах гэж аав минь Шевролет машиндаа суугаад Огдэнийг зорив. Гэрт нь хүрэхдээ, тэрээр Чарлсын чих, хамраас нь муухай хүрэн юм гоожиж халуундаа шатан, нас барсан хүүгээ тэврээд сульдан хэвтэж байхыг нь олсон байна.

“Үхэлтэй тулгарсан залуу эцэг, ‘Хүүг минь аваад яв, гэр бүлийн булшинд аваачиж тавьчихаад миний хойноос маргааш ирээрэй’ гэж бувтнажээ.

“Аав Кеннетийг гэртээ авчирч, мужааны өрөөндөө авч хийж, ээж эгч нарын маань хамт даавууг нь бэлдэн, дараа нь аав, Францис хоёр, хоёр найрсаг хөршийнхөө хамтаар булшны нүх ухахаар явжээ. Маш олноор үрэгдэж байсан тул гэр бүлүүд нь өөрсдөө нүх ухдаг байлаа. Оршуулгын товчхон залбирал л тэр үед хийгдэж байсан ганц ёслол юм.

“Тэднийг оршуулгын газраас дөнгөж ирсний дараа утас дуугарч, Жорж Алберт бас нэгэн зүрх зүсэм мэдээ сонсгожээ: Чарлс нас барсан бөгөөд 7 настай Вэста, 5 настай Илаин гэх хоёр охин нь хүнд өвдсөн, мөн 4 настай Рэлдон, 3 настай Полин хэмээх хоёр нялх нь үхэх сэхэхийн даваан дээр байлаа.

“Бидний сайн үеэл Ларкиных нь Чарлсд авч бэлдэж, түүнийг төмөр замын ачаа тээврээр гэр лүү явуулсан юм. Аав залуу Францисын хамт цогцсыг нь төмөр замын зогсоолоос авчирч хуучирсан хөдөөний байшингийнхаа довжоон дээр тавьж ах дүү нар маань хар өвчний золиос болсон цогцост ойртож очихоос айж байлаа. Аав, Францис хоёр хөршүүдтэйгээ хамт явж оршуулгын газрыг бэлэн болгоод Чарлс Хайрам Гоатесын агуу энэрэнгүй сүнснийг Бүтээгчид даатгасан багахан хэмжээний оршуулгыг хийв.

“Дараагийн өдөр нь ядарч туйлдсан настай аав маань энэ удаа тас хар үстэй, цэнхэр нүдтэй, инээмсэглэлээр дүүрэн байдаг Вэстаг авчрах гашуудалт үүрэгт дуудагджээ.

“Тэнд очихдоо аав маань цэнхэр нүдтэй алтан үстэй Бурханы бяцхан элч болсон Илаиний өлгийнх нь хажууд сөгдөн суугаа гашуудалд сөхөрсөн залуу эх Жулиетийг олжээ. Жулиет сэтгэл эмтрэмээр мэгшин, ‘Тэнгэрлэг Эцэг минь, үүнийг л биш шүү гуйя! Надад нялх хүүхдийг минь үлдээгээч! Хайртай хүмүүсийг минь дахиж битгий аваач!’ хэмээн залбирч байв.

“Аавыг Вэстагийн цогцсыг гэртээ авчрахынх нь өмнө гашуудлын үг дахин иржээ. Илаин, аав, Кеннет ах, Вэста эгчтэйгээ нэгдэхээр одсон байлаа. Энэ нь аавын минь нэг долоо хоногийн дотор гэр бүлийнхээ дөрөв дэх гишүүнийг авчран нутаглуулахаар хийсэн зүрх зүсэм бас нэгэн аялал байлаа

“Илаинийг оршуулсан тэр үдэш ч, маргааш өглөө нь ч үхлийн гамшигт мэдээ дуулгахаар утас дахин дуугарсангүй. Энэ нь Жорж А. болон түүний зоригтой хамтрагч Дела хоёр зовж зүдэрсэн бяцхан Релдон, Паулин хоёрыг аврах боломжтой байжээ гэсэн үг байсан бөгөөд сувилагч үеэл Рэва Маннс ирж туслах боломжтой байсан нь маш их сэтгэл тайвшруулсан явдал байв.

“Өглөөний ундны дараа аав Францист хандан, ‘Хүү минь, бид талбайд очиж, улам илүү хөлдөхөөс нь өмнө ахин нэг тэрэг чихрийн манжин ухаж гаргахыг бодъё. Морьдоо хөллө, замдаа гаръя,’ гэжээ.

“Францис дөрвөн морь хөллөсөн тэргээ замд оруулахад аав хажуунаас нь авиран гарчээ. Тэднийг Саратога замаар явж байхад нь хөрш тариаланчдынх нь хөтөлсөн чихрийн манжин овоолсон тэрэгнүүд ар араасаа цуван зөрж өнгөрлөө. Хажуугаар нь өнгөрөхдөө хүн бүр нэгийг хэлнэ: ‘Сайн байна уу, Жорж ахаа,’ Бид гүнээ эмгэнэж байна, ‘Жорж оо, Танд олон нөхөд бий шүү’ гэх зэргээр даллан мэндчилж байв.

“Сүүлчийн тэргэнд Жаспэр Ролф явлаа. Тэр сэтгэл өндөр мэндлэн, ‘Энэ эцсийнх нь, Жорж ах аа,’ гэж хэлэв.

“Аав маань Францис ахад хандан, ‘Энэ бүгд манайх байсан ч болоосой,’ гэжээ.

“Талбайдаа ирээд Францис чихрийн манжингийн том улаан тэрэгнээсээ үсрэн бууж талбайнхаа хаалгыг дэлгэн орлоо. Тэрээр зогсож, хэдэн хором зүүн баруун, урагш хойш талбайг гүйлгэн харав. Бүх л талбайд нэг ч чихрийн манжин байсангүй. Тэр үед л, Жаспэр Ролфийн ‘Энэ эцсийнх нь, Жорж ах аа,’ гэж хэлсний учрыг тэрээр ухаарчээ.

“Аав маань тэрэгнээс бууж, өөрийнхөө үргэлж биширдэг тэрхүү шим тэжээлт бор хөрснөөс атган авч, дараа нь эрхий хуруугүй зүүн гараараа чихрийн манжингийн таслагдсан оройг өргөж хөдөлмөрийнхөө бэлэг тэмдэг нь болсон бүхэл тийш нүдэндээ итгэхгүй байгаа мэтээр ширтэв.

“Аав зургаа хоногийн дотор хайрлан хүндэтгэдэг гэр бүлийнхээ дотно дөрвийг оршуулахаар авчирсан: авс хийж, булшний нүх ухан; тэр ч бүү хэл оршуулгын хувцас бэлдэлцсэн-энэ эр, тарчлал авчирсан энэ бүх л мөчүүдийн туршид бүдэрч, няцан ухарч, эргэлзэн тээнэгэлзээгүй энэ гайхамшигт эр чихрийн манжингийн оройг таслан хураасан овоон дээр суун баярлаж талархсандаа хүүхэд шиг цурхиран уйлжээ.

“Тэрээр өндийж том улаан алчуураараа нүдээ арчин, тэнгэр өөд ширтээд, ‘Эцэг минь, хэсгийнхээ ахлагч нарын төлөө тандаа баярлалаа’ гэж хэлэв” (in Conference Report, Apr. 1973, pp. 36-37).

Ярилцлага

- Энэ аав бусдад хэрхэн энэрэл үзүүлсэн бэ?
- Түүний хөршүүд хэрхэн энэрэл үзүүлсэн бэ?
- Бусдын энэрлээр та нар хэрхэн адислагдсан бэ?

Дүгнэлт

Зөвлөхийн танилцуулга

Бусдад үйлчилснээр бусдыг хайрладаг ба үйлчилснээрээ энэрлийн утгыг сурдаг гэдгийг тайлбарла.

ЗӨВЛӨМЖ БОЛГОЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААА

Залуу эрэгтэйчүүдэд дараах үйл ажиллагааг санал болго.

Өглөө бүр нэг жижиг зүйлийг зүүн талынхаа халаасанд ямар нэг энэрэнгүй зүйл хийх буюу хэн нэгэнд хайраа үзүүлтлээ хийх. Дараа нь баруун талынхаа халаасанд хий. Үүнийг долоо хоногийн турш хийж дараагийн пристийн зэрэгтний цуглаан дээр чармайлтынхаа үр дүнг илтгэ.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр бусдыг уучилснаар Тэнгэрлэг Эцэг, өөрсөдтэйгээ болон бусадтай илүү нийцтэй амьдарч чадна гэдгийг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаа.
2. Та нар хэдэн залуу эрэгтэйчүүдээр Матай 18:23–35-ыг уншихын оронд жүжигчилсэн тоглолт үзүүлэхээр бэлтгэ.

ТАЙЛБАР

Бурхан уучилдаг. Магадгүй үүнээс илүү хүчтэй захиас сударт байхгүй байх. Хэрэв бид түүнтэй адил болохыг хүсвэл бусдыг уучлах ёстой хэмээн судруудад тодорхой бичсэн. Мэдээж, Бурханы уучлал бидний наманчлалын үр дүнд ирдэг боловч биднээс бүх хүмүүсийг уучлахыг шаарддаг (С ба Г 64:10-ыг үз). Энэ хичээлээр залуу эрэгтэйчүүд өдөр бүр уучлалын зарчмыг ашиглаж сурна. Одоогоор магадгүй тэд цөөн уучилсан байж болох хэдий ч яаж ч гомдсон бай гомдоосон хүнийг уучилж сурах ёстой гэдгийг сурах ёстой.

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

Нөхцөлийн судалгаа
ба ярилцлага

Оршил

Дараах нөхцөлөөс нэг буюу түүнээс илүүг дүрсэл. Тэгээд залуу эрэгтэйчүүдээс хэрэв тэд ийм нөхцөлд байсан бол юу хийх байсан тухай асуу. Тэдний хариултыг ярилц.

1. Сагсан бөмбөгийн тэмцээний дараа Жоон биеийн тамирын зааланд түрийвчээ мартсан байлаа. Тэр буцаж ирээд авах гэтэл түрийвч нь байсангүй. Дараагийн өдөр нь тэдний хэсэгт саяхан нүүж ирсэн Крис түүний гэрт ирэв. Тэр түрийвчийг нь авсан гэдгээ хүлээжээ. Түүнийг нь буцааж өгөөд уучлаарай гэж хэлсэн байна. Тэр Жооноос уучлахыг гуйсан байна. Жоон, 'Мэдээж, ийм явдал болсныг мартлаа,' гэж хэлжээ. Дараачийн өдөр Жоон хэсэг найзуудтайгаа ярьж байлаа. Тэдний нэг нь Крисийг мэдэх үү гэж асуув.
2. Жеф найз Чаддаа түүнд Кати үнэхээр таалагддаг тухай хэлжээ. Тэр Чадад энэ нууцыг хадгална гэж итгэж байв. Сүүлд нь Жеф Чад Катигийн сайн найзад хэлсэн болохыг дам сонсжээ. Тэр ч бүү хэл Чад мөн түүнд Жеф, Кати хоёрын тухай худал юм ярьсан байв.
3. Хагас сайн өдөр гадагш гарахаасаа өмнө Камерон, түүний ах хоёр өрөөгөө цэвэрлэх ёстой байв. Хагас сайн өдрийн өглөө Камерон өрөөгөө цэвэрлэв. Тэр өдөр найзууд нь түүнийг хамт кинонд явахыг урьжээ. Ээж нь өрөөг шалгахаар ортол замбараагүй байгааг олж харжээ. Камерон түүний ах ийм замбараагүй болгосныг мэдсэн боловч ах нь юу ч мэдээгүй мэт дүр эсгэжээ. Хоёр хүү замбараагүй болгосон гэдгээ хүлээгээгүй учир ээж нь тэднийг тэр өдөр гэрт нь үлдээсэн байна.

Уучлагдахын Тулд Бид Бусдыг Уучлах Ёстой

Сургаалт үлгэр
ба ярилцлага

Уучилдаггүй зарчмын тухай Матай 18:23–35 дахь сургаалт үлгэрийг уншиж буюу жүжигчлэн үзүүлээд ярилц. Залуу эрэгтэйчүүдэд сургаалт үлгэрийг илүү сайн ойлгуулахын тулд өртэй хоёр хүнийг сөргүүлэн тавь. Энэ нь хаан зарцынхаа зургаан зуун долларын өрийг уучилж зарц нь нэг долларын өрийг уучлаагүйтэй адил юм.

- Сургаалт үлгэр дэх хаанаар хэнийг төлөөлүүлсэн бэ? (Тэнгэрлэг Эцэг.)
- Уучлаагүй зарцаар хэнийг төлөөлүүлсэн бэ? (Бид бүгдийг. Бид бүгдээрээ нүгэлтэй ба Их Эзэнд өртэй.)
- Бусад зарчмаар хэнийг төлөөлүүлсэн бэ? (Биднийг гомдоосон бүх хүмүүсийг.)
- Энэ сургаалт үлгэрт Есүс бидэнд юу заасан бэ? (Хэрэв бид Бурханаар өөрсдийгөө өршөөлгөхийг хүсвэл бусдыг уучлах ёстой.)
- Бусдыг уучлах нь яагаад чухал вэ?
- Бусдыг уучлахад та нар ямар сэтгэлтэй болдог вэ?

Ишлэл

“Бусдыг уучилдаггүй хүн өөрийнхөө гарах гүүрийг нурааж буй хэрэг” (Spencer W. Kimball, *The Miracle of Forgiveness* {Salt Lake City: Bookcraft, 1969}, p. 269).

- Бусдыг уучлахгүй байх нь биднийг хэрхэн сүнслэгээр зовоох вэ?

Матай 18:34–35-ыг дахин унш.

- Та нарыг гомдоосон хүн та нараас уучлалт гуйхгүй бол яах вэ? Яагаад та нар түүнийг нүглээ наманчлахыг хүсээгүй байсан ч гэсэн уучлах ёстой вэ?

Ишлэл ба ярилцлага

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл: “Гомдоогч уучлал авахаасаа өмнө уучлал гуйж өөрийгөө даруусгах хэрэгтэй гэдэг санаа нь хамгийн гол алдаа юм. Мэдээж, алдаа гаргасан нэгэн бүх л алдаагаа засах ёстой боловч бусдын хандлагаас шалтгаалахгүйгээр гомдсон нэгэн гомдоосон хүнээ уучлах ёстой. . . .

“Тийм ээ, зөв байхын тулд бид уучлах ёстой. Бидний дайсан нүглээ наманчилсан ч бай үгүй ч бай, түүний өөрчлөлт нь хэр үнэн сэтгэлээсээ ч бай үгүй ч бай, тэр уучлалт гуйсан ч үгүй ч бид уучлах ёстой” (*The Miracle of Forgiveness*, pp. 282- 83).

- Ерөнхийлөгч Кимболлын мэдэгдэл та нарын хувьд ямар утгатай вэ?

Уучлал нь Бидэнд Бурхантай, Өөрсөдтэйгөө ба Бусадтай Нийцтэй Амьдрах Боломжийг Олгодог

Нөхцлийн судалгаа ба ярилцлага

Хичээлийн эхэнд танилцуулсан Нөхцөлийн судалгааг тоймло. Бүх Нөхцөлийн судалгаанд зориулан дараах төстэй асуултыг асуу:

- Хэрэв та нар үнэхээр бусдыг уучилсан бол та нар юу хийх вэ?
- Нөгөө хүнд хэрхэн хандах вэ?
- Та нар өөрсдийнхөө талаар ямар мэдрэмжтэй байх вэ?
- Хэрэв та нар түүнийг уучлаагүй бол юу мэдрэх вэ?
- Хэрэв та нар түүнийг уучлаагүй бол Тэнгэрлэг Эцэг та нарын гэм нүглийг уучилна гэж үнэнээсээ найдах уу?

Ишлэл

“Бидний мөнхийн аврал нь зөвхөн бидний эсрэг хийсэн буруу зүйлсийг уучлах чадвар, бэлэн байдлаас шалтгаалахгүй. Бидний энэ амьдралын баяр баясгалан, сэтгэл ханамж ба бидний жинхэнэ эрх чөлөө үүнийг хийснээс хамаардаг. . . .

“Хэн нэгнийг үзэн ядаж, дургүйцэх нь зүй ёсны байсан ч энэ нь биднийг ямар болгодгоос шалтгаалан бидний хэн нь ч үзэн ядалт дургүйцлийн төлөөсийг төлж чадахгүй.

“Бурхан бидэнд дургүйцэл, хорон санаа, мунхаг, биеэ тоосон байдлаас салж Их Эзэнтэй, өөрсөдтэйгээ, бусадтай найзууд байхын тулд хайрлаж, уучлахад тусалдаг” (Marion D. Hanks, ““ Even As Christ Forgave,” *New Era*, June 1974, p. 6).

- Бид уучлахаа умартаж, харамслыг авчрахад бид яадаг вэ? (Энэ нь бидэнд дургүйцэл биеэ тоосон байдлыг дүүргэдэг. Бусдыг хайрлахад улам хэцүү болдог. Бидний Тэнгэр дэх Эцэгтэйгээ харьцах харьцааг сүйтгэдэг.)

Түүх ба ярилцлага

Бид бүгдээрээ хэзээ нэгэн цагт гомдоогдож зовж байсан гэдгийг тайлбарла.

Та нарын гэр бүлийн хэн нэгнийх нь үхлийн шалтгаан болсон хүнийг та нар уучилж чадах уу? Залуу эрэгтэйчүүдээс уучлал бидний Бурхантай харьцах харьцаа, мөн өөр

хоорондоо болон бусдын хоорондох харьцаанд хэрхэн нөлөөлснийг дүрсэлсэн дараах түүхийг анхааралтай сонсохыг хүс.

Кори тен Буум ба түүний эгч Бэтси хоёр Дэлхийн Хоёрдугаар дайны үеэр Еврейчүүдийг гэртээ нуусан тул баригджээ. Тэднийг Равенсбургийн хорих лагерьт явуулсан байна. Тэнд байхдаа Кори эгчийгээ хүнлэг бус зовлон эдэлсний улмаас нас барахыг харжээ.

Дайны дараа Кори Германд “Бурхан уучилдаг юм гэсэн мэдээтэй” эргэн иржээ. Тэр хаа ч явсан гэсэн, бид нүглээ илчилж, наманчлахад “Бурхан нүглийг маань гүн далайн ёроолд үүрд хаядаг юм” гэдгийг тайлбарлаж байв.

Нэг удаа түүний ярианы дараа нэг эрэгтэй хүн түүнтэй ирж уулзжээ. Тэр эмэгтэй түүнийг хорих лагерийн нэг хамгаалагч байсныг таньсан байна. Тэр эмэгтэйн өмнө зогсоод, гараа алдлан: “Маш сайн яриа хатагтай. Таныг хэлснээр бидний бүх нүгэл далайн гүнд хаяагддаг гэдгийг сонсох ямар сайхан юм бэ!” гэж хэлэв.

Тэрээр хариу юу гэж хэлснээ дурсан ярихдаа:

“Тэгээд өршөөлийн тухай уран цэцнээр ярьсан хүн би тэр гарыг барихын оронд халаасан дахь номоо тэмтчин зогсов. Тэр намайг мэдээж санахгүй байгаа, тэр олон мянган эмэгтэйчүүд дундаас яаж ганц хоригдлыг санах билээ дээ?”

“Харин би түүнийг мөн түүний бүснээс унжсан суран ташуурыг санаж байлаа. Би олзлогчдынхоо нэгэнтэй нь нүүр тулаад цус минь царцах шиг болж байв.

“Тэр: ‘Та яриандаа Равенсбургийг дурдсан, би тэнд харуул байсан’ гэлээ. Үгүй ээ, тэр намайг санахгүй байлаа.

“Гэвч би түүнээс хойш Христийн шашинтан болсон” хэмээн тэр үргэлжлүүлэв. ‘Бурхан миний тэнд хийсэн хэрцгий зүйлүүдийг уучилсан гэдгийг би мэднэ, гэвч би үүнийг бас таны амнаас сонсохыг хүсэж байна, хатагтай’ гээд дахин гараа сунгаж, ‘Та намайг уучлах уу?’ гэлээ.

• Ийм нөхцөлд та нарт ямар сэтгэгдэл төрөх вэ? Та нар юу хийх вэ? Та нар уучилж чадах уу?

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр Сургаал ба Гэрээ 64:9–11-ийг уншуулж тэмдэглүүл.

- Их Эзэн бидэнд, бид хэнийг уучлах ёстой гэж хэлсэн бэ? (Хүн бүрийг.)
- Хэрэв бид уучлахгүй бол хэн нь хамгийн их нүгэлтэй байх вэ? (Бид.)
- Хэрэв Кори тен Буум зовоогчоо уучлаагүй бол юу болох вэ?

Түүхийн үргэлжлэл

Тэр эмэгтэй үргэлжлүүлэн:

“Гэм нь дахин дахин өршөөгдөх ёстой ч, би тэнд уучилж чадахгүй зогсож байв. Бэтси тэнд үхсэн. Тэр зүгээр л уучлал гуйгаад түүнийг удаан аймшигт үхлээс нь босгоно гэж үү?”

“Тэр гараа сунган удаан зогсоогүй боловч би хийх ёстой хамгийн хэцүү зүйлийг хийх гэж зогсоход миний хувьд олон цаг өнгөрөх шиг санагдав.

“Би үүнийг хийх ёстой гэдгээ мэдэж байлаа. Бурхан өршөөдөг гэсэн захиас урьдчилсан нөхцөлтэй байдаг билээ. Энэ нь биднийг зовоож, гомдоосон хүмүүсийг бид уучлах явдал юм. ‘Та нар хүмүүсийн гэмийг уучлахгүй бол тэнгэр дэх Эцэг тань та нарын гэмийг өршөөхгүй’ гэж Есүс хэлдэг.

“Энэ нь зөвхөн Бурханы зарлиг ч биш, бас өдөр тутамд тохиолдох зүйл гэдгийг би мэдэж байлаа. Дайн дууссаны дараа би Голландад Нацистуудын харгислалд хохирогчдод зориулсан орон байртай байсан юм. Урьдын дайснуудаа уучилж чадсан хүмүүс биеийн шархаа үл хайхран гадаад ертөнцөд эргэн очиж амьдралаа дахин сэргээх чадвартай байв. Харгис чанараа өөгшүүлсэн хүмүүс тахир дутуугаараа үлдэв. Энэ нь үүний адил энгийн бөгөөд аймшигтай байсан юм.

“Би тэнд зүрхээ базлуулан хүйт оргиулан зогссоор л байв. Гэвч уучлал нь сэтгэлийн хөдөлгөөн биш гэдгийг би бас мэдэж байлаа. Уучлал бол хүслээр хийгддэг үйлдэл бөгөөд хүсэл нь зүрхний хэмээс үл хамааран хийж чаддаг. . . . Туслаач! гэж би

аяархан залбирав. 'Би гараа өргөж чадна. Би үүнийг олон хийж чадна. Харин мэдрэмжийг нь өгөөч.'

"Тэгээд би мод шиг, албан хүчээр надад сунгасан гар руу гараа өглөө. Үүнийг хийтэл гайхалтай зүйл боллоо. Миний мөрнөөс цахилгаан тог гүйж гараар маань дамжин бидний нийлсэн гаранд хүрэв. Тэгээд энэ эдгэрүүлэх дулаахан зүйл бүх биеэр маань тарах шиг болж нүдэнд минь нулимс цийлгэнэв.

"'Ах минь, би таныг уучиллаа' гээд би уйлав. 'Бүх зүрх сэтгэлээрээ шүү!'

"Урьдын харуул ба урьдын хоригдол бид хоёр бие биеийнхээ гарыг чангаар маш удаан атгав. Би урд өмнө нь Бурханы хайрыг хэзээ ч ийм хүчтэй мэдэрч байсангүй" ("I'm Still Learning to Forgive"-ээс Corri ten Boom иш татав. Guideposts Magazine-ы зөвшөөрлөөр дахин хэвлэв. *Guideposts Associates, Inc.*, 1972 бүх эрхийг эдэлнэ, Carmel, New York 10512).

Уриалга

Дүгнэлт

Залуу эрэгтэйчүүдээс тэднийг гомдоосон болон хар буруу санаж буй хэн нэгнийг бодохыг хүс. Тэднийг ирж буй долоо хоногт тэр хүнээ уучлахыг хичээж залбирахыг уриал.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр өөрийн болон гэр бүлийнхээ төлөө, мөн бусдын ашгийн тулд сүнслэг бэлгүүдийг ашиглах хүсэлтэй болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Гурван цаас ба гурван харандаа.
2. Хаагддаг хайрцаг буюу тийм хайрцгийг самбарт зурж үзүүлэхээр бэлтгэ.
3. 1 Коринт 12; Моронай 10:8–18 ба Сургаал ба Гэрээ 46:8–29-ийг судал.

ТАЙЛБАР

Сүнслэг бэлгүүд Сүмийн гишүүн тус бүрт бүх гишүүдийн тусын тулд өгөгдсөн байдаг. Маш олон Сүмийн залуу эрэгтэй тийм сүнслэг бэлэг байдаг гэдэгт эргэлздэг байх. Залуу эрэгтэй бүрт тийм бэлэг өгөгдсөн гэдгийг баттай мэдэх хэрэгтэй. Тэр тэвчээртэй ба оролдлоготой байж өөрийн болон эргэн тойронд байгаа хүмүүсийн амьдралыг адислах бэлгүүдээ нээж хөгжүүлж чадна гэдгийг мэдэх хэрэгтэй.

Өөрийнхөө сүнслэг бэлгүүдтэй холбоотой тохиолдлуудыг чөлөөтэй хуваалц. Тийм тохиолдлуудыг хуваалцахдаа Ариун Сүнсэнд найдаж хөтлүүл.

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

Түүх

Оршил

Хожим нь Төлөөлөгч болсон Матай Каулигийн ярьсан дараах түүхийг унш. Арван долоон настай байхдаа Ахлагч Каули Шинэ Зеландад номлолд дуудагдаж Маори хэл сурах болжээ. Тэр болсон явдлаа Ахлагч Каули ингэж ярьсан юм:

“Бараг хүүхдээрээ шахуу би 3 сарын турш хамтрагч үгүй ганцаараа нутгийн хэлийг ойлгохгүй, хэрхэн 6 цагт босч мод руу явж арван нэгэн цагийн турш суралцаж, мацаг барин залбирч байснаа санаж байна. Эцэст нь 11, 12 долоо хоногийн дараа би намайг зоригжуулах номлогчгүй цор ганцаараа нутгийн хүмүүсийн дунд зогсоод тэдний хэлээр сайн мэдээг номлож эхлэх зоригтой байв. Би урьд нь уншиж, сонсож байгаагүй үгнүүдийг хэрэглэн амьдралдаа урьд өмнө нь болон дараа нь хэзээ ч мэдэрч байгаагүй цээжинд минь дүрэлзэх галыг мэдэрч байв. Миний ухаан санаа хүүхдийнх шиг байсангүй. 17 настай залуу хүү надаар дамжуулан Бурханы хүч ярьж байсан юм ” (Henry A. Smith, *Matthew Cowley—Man of Faith* [Salt Lake City: Bookcraft, 1954], p. 48).

Энэ түүх нь Сүнсний бэлгүүд буюу сүнслэг бэлгийн нэг жишээг үзүүлсэн гэдгийг хэл.

Бүх Аароны Пристийн Зэрэгтнүүдэд Сүнслэг Бэлгүүд Өгөгдсөн

Судар ба ярилцлага

Нэг залуу эрэгтэйгээр итгэлийн тунхагийн долоодугаарыг уншуулах буюу цээжээр нь хэлүүл. Нэг залуу эрэгтэйгээр Сургаал ба Гэрээ 46:11–12-ыг уншуул. Бүх залуу эрэгтэйчүүдэд түүний доогуур нь зурахыг зөвлө.

- Хэнд Бурханы Сүнсээр бэлэг өгөгдсөн бэ?
- Энэ бэлэгний зорилго нь юу вэ?

Ангиа гурван бүлэгт хуваа. Бүлэг бүрт дараах судруудын заалтуудыг даалга.

1-р бүлэг: 1 Коринт 12:4–11

2-р бүлэг: Моронай 10:8–18

3-р бүлэг: Сургаал ба Гэрээ 46:8–29

Бүлэг бүрт цаас харандаа өгөөд залуу эрэгтэйчүүдийг судраас олсон сүнслэг бэлгүүдийг жагсааж бич гэж хэл. Судар дээрээ тэдгээрийн доогуур зурахыг тэдэнд зөвлө. Залуу эрэгтэйчүүдийг зураад дууссаны дараа тэдний хэлсэн сүнслэг бэлгүүдийг самбарт жагсааж бич. Нэг сүнслэг бэлгийг нэгээс илүү бичих шаардлагагүй. Гэвч хэдэн удаа тэр бэлэг давтагдаж байгааг нь онцолж болно.

Дараах жагсаалт нь таныг сүнслэг бэлгүүдийн тухай ярилцахад туслах болно.

Илчлэлт	Эдгээх итгэл
Гэрчлэл	Эдгэрэх итгэл
Шүүлт	Гайхамшгууд
Мэдлэг	Бошиглох
Мэргэн ухаан	Үзэгдлүүд
Заах	Сүнсийг ялгаж мэдэх
Итгүүлэх	Гадаад хэлээр ярих
Номлох	Гадаад хэлнээс орчуулах

Залуу Эрэгтэй Бүр Сүнслэг Бэлэг нь Юу Болохыг Мэдэж Чадна

Үзүүлэнтэй хичээл
ба ярилцлага

Авчирсан хайрцгаа сандал дээр буюу ширээн дээр ангийн өмнө тавих буюу самбар дээр зур.

• Энэ хайрцган дотор юу байгааг та нар ямар хоёр замаар мэдэж болох вэ? (Байж болох хариулт нь хайрцгийг онгойлгох, хайрцгийг бэлтгэсэн хүнээс юу байгааг нь асуух.)

Үүнтэй бараг ижил замаар бид сүнслэг бэлгүүдийг мэдэж болно.

• Та нарт ямар сүнслэг бэлэг өгөгдсөн болон өгөгдөх вэ гэдгийг та нар хэрхэн нээж олж чадах вэ? (Туршлагаар - хайрцгийг нээх болон илчлэлтээр - бэлгийг бэлтгэсэн хүнээс асуух.)

• Бид бэлгүүдээ нээж олж болох ямар ямар онцгой аргууд бий вэ? (Байж болох хариултанд нь мацаг барин залбирах; сүнслэг бэлгүүдийг хэлж болох патриархын адислалаа авч ойр ойрхон унших; бидэнд төрөлхийн мэт санагдах зүйлсээ ажиглаж судлах; пристийн зэрэгтний удирдагчдаас өгсөн дуудлагыг хүлээн зөвшөөрөх; бусдын хэлсэн магтаалын үгийг анхаарах; эцгийн адислал авах зэрэг багтана.)

Залуу эрэгтэй бүрийн сүнслэг бэлгүүд энэ удаа илэрч гарч ирэхгүй байж болно гэдгийг анхааруул. Мөн тэдэнд хэрэгцээтэй үед бусад сүнслэг бэлгүүд өгөгдөж болно. Хэрэв та нар Матай Каулийн түүхийг ашигласан бол тэр хэлний бэлгээр адислагдахаасаа өмнө арван долоон настай байсан гэдгийг анхааруул. Их Эзэн Ахлагч Каулид тэр үед энэ бэлгийг өгөх хэрэгтэй байсан ба энэ нь итгэл, бацаг барилт ба залбирлаар ирсэн.

Сүнслэг Бэлгүүд нь Бусдын Адил Бидний Тусын Тулд Өгөгдсөн

Түүхүүд ба
ярилцлага

Бэлэг бүрийг гүнзгий ярилцах цаг байхгүй. Дараах түүхүүдэд өгүүлэх бэлгүүдийг ярилцах хэдэн минут гарга. Дууссаны дараа доорх асуултын дагуу ярилц:

1. Ямар бэлэг өгөгдсөн бэ?
2. Бэлгийг авсан хүнд хэрхэн тусаа өгсөн бэ?
3. Бусад хүмүүст хэрхэн тусаа өгсөн бэ?

Бошиглох бэлэг

1903-1933 онд Нэгдсэн Улсын сенатч байсан Ютагийн Рийд Смуут жижигхэн хүү байхдаа Бригэм Янгийн бошиглолыг сонсож тэр нь хэдэн жилийн дараа үгчлэн биелсэн билээ.

“Бригэм Янг Провод ирж, тэрээр чуулган дээр хүний дуу хоолойг Нью-Йоркоос Сан Францискод сонсох цаг ирнэ гэж хэлжээ. . . .

“Рийдийн ээж түүнийг энэ чуулганд авчирсан ба тэр гэртээ харих замдаа ингэж хэлжээ (Ерөнхийлөгч Бригэм Янгийн хэлсэнтэй холбоотой), ‘Энэ чинь шал худлаа. Тэр бол яасан ч боломжгүй. Байж болшгүй.’ Түүний ээж маш их агуу итгэлтэй байсан бөгөөд хүүдээ ингэж хэлжээ, ‘Тийм ээ, Чи Ерөнхийлөгчийн өнөөдрийн хэлсэн зүйлийн биелэлтийг харахаар амьдрах болно.’ Тэр үүнд итгээгүй ажээ. Цаг хугацаа өнгөрч, түүнийг АНУ-ын Сенатад байх үед нэвтрүүлэх систем байгуулагдсан учир Нью-Йоркоос Сан Франциско руу ярьжээ. Сенатын гишүүдийн /хамт ажиллагчдын/ нэг нь энэ санаачилгыг хариуцаж байсан ба дуусмагц тэд нар хамтдаа энэ үйл явдлыг тэмдэглэж, тэр сенатч Смуүтийг Нью-Йорк хотод ирэхийг урьсан байна, тэрээр хийж дуусгасан сүлжээгээр дамжуулан ярих анхны хүн болсон бөгөөд түүний дуу хоолой тив даяар тод хийгээд тодорхой сонсогдсон билээ.

“Ийнхүү олон жилийн өмнө Провод Ерөнхийлөгч Бригэм Янгийн амласан амлалтыг тэр үнэхээр биелүүлэхийн төлөө амьдарчээ” (Bryant S. Hinckley, *The Faith of Our Pioneer Fathers* [Salt Lake City: Bookcraft, 1956], p. 207).

Эдгэрэх Итгэлийн Бэлэг

Энэ түүх 1906 онд Ерөнхийлөгч Жозеф Ф. Смитийг Голландад айлчилсны дараахан Датч Стар-д гарсан юм.

“1906 оны 8 сарын 7-ны өдөр байлаа. Хоёр өдрийн өмнө Антвэрпээс завиар ирчихээд Ерөнхийлөгч Смит болон түүний хүмүүс Роттердамт хүрэлцэн иржээ. Тэр хотод арван нэгэн настай Жон Рүтхофф гэдэг олон жилийн турш нүднээсээ болж маш ихээр зовж шаналсан нэгэн жаал хүү аж төрдөг байжээ. Аажмаар хараагүй болж, сургуульд сурах чадваргүй болсон хүүтэйгээ адил түүний ээж ч бас Сүмийн итгэлтэй гишүүн байлаа. Хүү ээждээ: ‘Бошиглогчид Дэлхий дээрх номлогчдын хамгийн их хүч чадалтай нь байдаг. Хэрэв та намайг цуглаанд авч явбал, тэр миний нүд рүү харвал нүд маань эдгэрнэ гэдэгт би итгэж байна’ гэж хэлжээ. Ээж нь зөвшөөрч түүний хүссэнээр цуглаан руу дагуулж явав. Цуглааны төгсгөлд заншил ёсоор, Ерөнхийлөгч Смит хаалга руу очиж, хүмүүстэй гар барьж, танхимаас зөрөн гарч байгаа хүмүүст урам хайрлаж байв. Нүд нь боолттой Жон Рүтхофф ээжээрээ хөтлүүлэн түүн рүү дөхөж очиход Ерөнхийлөгч Смит түүний гарыг барьж түүнтэй дотно ярьлаа. Дараа нь тэр боолтыг аажуухнаар сөхөж, цоггүй нүд рүү нь энэрэнгүй харж хүүд англиар нэг зүйлийг хэлсэнд хүү ойлгосонгүй. Хэдийгээр ойлгоогүй боловч тэр сэтгэл хангалуун байв. Ерөнхийлөгч Смит хүүгийн итгэлийн дагуу хийсэн ба түүний итгэлийн дагуу болж өнгөрлөө. Тэр гэртээ ирэхдээ их баяр баясгалантайгаар, ‘Ээж ээ, миний нүд зүгээр болчихлоо. Надад ямар ч өвчин алга. Би одоо харж чадаж байна, холыг ч бас харж байна,’ гэж хашгирчээ. Энэ үйл явдлын дараа хүү сургуульдаа дахин явж чадсан” (*Life of Joseph F. Smith, comp. Joseph Fielding Smith* [Salt Lake City: Deseret Book Co., 1969], x. 397).

Гэрчлэлийн Бэлэг

Дараах түүх хоёр залуу хүү сайн мэдээний гэрчлэлээр хэрхэн адислагдсан тухай хэлдэг:

“Нэг өдөр миний найз Дон утасдаад манай гадасны ерөнхийлөгч биднийг Колорадын Юраваны ойр байдаг ураны уурхайдаа зун ажиллуулахыг хүсэж байгаа тухай хэлэв. Би тэр дор нь зөвшөөрөв. . . .

“Ажил нь хүнд байсан боловч бид сэтгэл хангалуун байж хагас сайн өдөр Гранд Жанкшин руу сүмдээ очдог байв. Замд Дон надаас, ‘Боб чи гэрчлэлтэй юу?’ гэж асуув.

“Би толгойгоо сэгсэрч, ‘Би тэгж бодохгүй байна,’ гэв.

“‘Чи Мормоны Номыг уншиж байсан уу?’

“‘Үгүй.’

“‘Би ч гэсэн үгүй. Яагаад бид хамтдаа уншиж гэрчлэлтэй болох нь уу гэдгээ үзэж болдоггүй юм бэ,’ гэж тэр хэлэв.

“Тэр санаа нь надад таалагдаж, бид Юраванд Ням гарагийн орой эргэж ирэхдээ хоёулаа цаасан гадартай Мормоны Номтой буцаж ирэв. Өдөр бүр ажлын дараа бид нэг буюу хоёр цаг уншиж, ярилцаж, юу уншсаныхаа тухай залбирч байв.

“Мормоны Номыг дуусгах болсон нэг орой Дон бид хоёр урьд өмнөх шигээ залбирч дараа нь хоёулаа өвдөг сөгдөн чимээгүйхэн залбирав. Тэр орой би Мормоны Номыг үнэн үү гэж мэдэхийн төлөө урьд нь залбирч байснаасаа илүү сэтгэлээсээ залбирав.

“Гэнэт миний сүнс угаагдаж, цэвэрлэгдэж, ариусгагдаж буй мэт дүрсэлж боломгүй цэвэрлэх мэдрэмж намайг нөмрөн авав. Тэр мэдрэмж маш хүчтэй байсан тул тэнгэрлэг биет харна гэж найдан би нүдээ нээн дээш харав. Гэвч миний нүд бүрэлзэж, нулимс хацрыг минь даган урсав.

“Би ичиж Доныг залбирч байна уу гэж эргэн харав. Би түүний хацрыг даган нулимс урсаж байгааг хараад айв.

“‘Яасан бэ?’ гэж би асуув.

“‘Чамтай адил зүйл боллоо.’

“Тэр орой би Сүм бол үнэн, Иосеф Смит бол бошиглогч, Их Эзэн залбиралд хариулдаг гэдгийг мэдэж авсан юм” (Robert M. Hogge, “A Friend in Church,” *Ensign*, Oct. 1992, pp. 25- 26).

Ишлэл

“Бидний бэлгүүд болон боломжууд, өөр зарим нь илүү илт мэдэгддэг. . . . Бид бүгд *наанадаж* нэг бэлэг ба хамгийн сайн бэлгүүдийг буурьтай хайх нээлттэй урилгатай байдаг (С ба Г 46:8)” (Neal A. Maxwell, in Conference Report, Oct. 1976, p. 15; or *Ensign*, Nov. 1976, p. 14).

• Биднийг “буурьтайгаар хамгийн сайн бэлгүүдийг хайхыг” уриалсан. Бид хэрхэн тэднийг хайх вэ?

Байж болох хариулт:

1. Залбирлаар дамжуулан бэлэг асуух.
2. Бэлгийн төлөө мацаг барих.
3. Сүмийн удирдагчдын захиаснаас бэлгийн тухай судлах.
4. Бэлгийг хэрэглэх дадлага хийх.
5. Бэлэг өгөгдсөн хүмүүсийг ажиглах.
6. Зарлигуудыг сахиж, өөрсөддөө байгаа бэлгүүдийг хэрэглэх.
7. Их Эзэн бидэнд бэлэг өгнө гэдэгт итгэлтэй байх.
8. Бусдад үйлчлэх.

Дүгнэлт

Ишлэл

“Сүнслэг бэлгүүдийн зорилго бол итгэлтэй хүмүүсийг гэрэлтүүлэх, урам өгөх ба гэгээрүүлэх юм. Тэгснээр тэд ирэх болон энэ амьдралд амар амгаланг өвлөж, ирэх мөнхийн амьдрал руу хөтлөгдөх юм. Тэдгээрийн байгаа нь Их Эзэний тэнгэрлэг ажлын баталгаа юм. Тэдгээр нь байхгүй газарт Сүм болон Бурханы хаант улс байхгүй. Дэлхий энэ хэвээрээ байсан цагт итгэлгүй байхаас өөрөөр амлалт нь үгүй болохгүй (Моронай 10:19)” (Bruce R. McConkie, *Mormon Doctrine*, 2nd ed. [Salt Lake City: Bookcraft, 1966], p. 314).

Гэрчлэл ба уриалга Сүнслэг бэлгүүдийн тухай сэтгэгдэл болон гэрчлэлээ хуваалц. Залуу эрэгтэйчүүдийг уриал:

1. Тэдэнд ямар сүнслэг бэлгүүд өгөгдсөнийг нээж олох.
2. Тэнгэрлэг Эцэгтэй сүнслэг бэлгүүдийн тухай сэтгэгдлээ ярилцах.
3. Эцэг эхтэйгээ сүнслэг бэлгүүдийн тухай сэтгэгдлээ ярилцах.
4. Бусдад өгөгдсөн сүнслэг бэлгүүдэд талархах ба мэдэж авах.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр оюун санаагаа хөгжүүлж, тэлэх нь түүний ойлголт болон хүмүүс, газар орнууд, дэлхийд баярлахыг нь нэмэгдүүлж түүнд Сүм болон нийгэмд хувь нэмрээ оруулахад нь тусална гэдгийг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

Шаардлагатай материалууд:

1. Залуу эрэгтэй бүрт судар.
2. Судар тэмдэглэх харандаа.
3. Залуу эрэгтэй бүрт цаас харандаа.

ТАЙЛБАР

Суралцсанаар оюун ухаан шинэчлэгдэж, тэлж, урамшдаг. Анхны удаа нарны системийн агуу уудмыг сурч байснаа, цахилгаан эрчим хүч хэрхэн ажилладгийг ойлгосноо болон яруу найргийн сайхныг үнэхээр мэдэрснээ, уран зургийн агуу хүчийг мэдэрсэн зэрэг суралцсан явдлаасаа дурсан ярь. Энэ хичээлийн үеэр залуу эрэгтэйчүүдэд сурахын баяр баясгаланг, Бурхан тэдэнд суралцахыг зарлиг болгосон ба аз жаргал нь суралцснаар нэмэгддэг гэдгийг ойлгуул.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Түүх ба ярилцлага

Оршил

Дараах түүхийг унших буюу өөрийнхөө үгээр ярьж өг:

Америкийн гайхамшигт эрдэмтэн Жорж Вашингтон Карвэр (1864-1943) мэдлэгтэй болохыг маш их хүсдэг байжээ. Түүний өвөг эцэг нь урьд нь зарц байжээ. Найман настай жижигхэн туранхай хүү маш том ботаникийн цэцэрлэгтээ янз бүрийн цэцэг ургамлуудыг зөвхөн сониуч зангаа хангахын тулд л ургуулдаг байжээ. Түүний аав нь түүнийг уншиж сурч цэцэгнүүдийн тухай асуултандаа хариулт олохын тулд түүнд Цагаан толгой авч өгчээ.

Арван настай байхдаа тэр гэрээсээ арван милийн цаана байдаг сургуульд сурдаг байв. Тэрээр мөнгөгүй, очих газаргүй байсан боловч боловсрол олохоор хаашаа ч хамаагүй явсан байна. Тэр жижигхэн хотхонд ирээд сургууль олж ороод өөрийгөө тэжээхийн тулд тэр дороо янз бүрийн (ихэнхдээ мод хөрөөдөх) ажил хийж эхлэв. Нэг жилийн дотор сургуулийнхаа багш эмэгтэйн зааж чадах бүх л зүйлийг сурчээ. Тэгээд тэр эмэгтэй Жоржид, түүний гэрээс жаран милийн зайтай дунд сургуульд ороход нь тусалсан байна. Дахиад л мөнгөгүй арван нэгэн настай хүү шинэ сургуульд оржээ. Тэр энэ сургуульд зургаан жил суралцаад арван долоон настайдаа амжилттай төгссөн байна. Тэрээр угаалгын газар ажиллаж коллежид ороход хангалттай мөнгө цуглуулсан байна.

Эцэст нь тэр самар, амтат төмс ба шошны талаар хийсэн ажлаараа дэлхийд танил болсон алдартай эрдэмтэн болсон байна. Дан ганц самарнаас л гэхэд бэх, тос, сүү, саван ба өглөөний цайны будаа оролцуулан гурван зуу гаруй төрлийн бүтээгдэхүүнийг гаргаж авсан байна.

- Жорж Вашингтон Карвэрийн юу нь та нарын сэтгэлийг хөдөлгөж байна вэ?
- Суралцах нь та нарын хувьд хэр их чухал вэ?
- Та нар мэдлэг олж авахыг их хүсдэг үү?
- Та нар арван настайдаа өөрөө яваад боловсрол олж авахыг хүсэх байсан уу?

Бодох асуултууд

Бидэнд Бүгдэд нь Суралцах Боломж Байгаа

Судар, самбар
ба ярилцлага

Дараах судруудын заалтуудыг самбарт бич: С ба Г 88:78–80, 118, 90:15. Залуу эрэгтэйчүүдээр судруудыг уншуулж тэмдэглүүл.

- Эдгээр судруудын хамгийн гол захиас юу вэ?
- Их Эзэн биднийг ямар зүйл сурахыг хүсдэг вэ?

Самбарт залуу эрэгтэйчүүдийн хариултыг бич.

Ишлэл ба ярилцлага

Ерөнхийлөгч Н.Элдон Таннэр хэлэхдээ: “Сүм үргэлж гишүүд биднийг сайн боловсрол олж авч өөрсдийнхөө тухай боломжтой бүх зүйлийг, түүх, газарзүй, шинжлэх ухаан, огторгуй ертөнц, ялангуяа Есүс Христийн сайн мэдээг сурахыг үргэлж зөвлөдөг” гэжээ (address at Regional Representatives seminar, Apr. 1971).

- Бид суралцах ёстой зүйлээ ямар замаар сурч чадах вэ? (Сургуульд явж, уншиж, зурагтын боловсролтой холбоотой хөтөлбөр үзэж, бидний сурахыг хүсэж буй зүйлийг мэддэг хүмүүстэй ярих.)
- Эдгээр зүйлийг бид хаана очиж сурч болох вэ? (Сүм, сургуулиуд, номын сангууд, музейнүүд.)

Түүх

Заримдаа бид, энд сураад байх ямар ч юм алга гэж бодож болох боловч үүнд хангалттай суралцаж эрмэлзэл болон ухаанаа зориулбал бараг бүх зүйл гайхамшигтай байж чадна гэж хэл. Бид албан ёсны хэр бага боловсролтой байх нь хамаагүй бид ямар нэг зүйлийг хийснээр сурч чадна.

Дараах түүхийг унш.

“Нэгэн эмэгтэй алдар эрдэмтэн доктор Луис Агассизид хандан түүнд хэзээ ч сурах боломж байгаагүй гэж хэлжээ. Тэр эгчтэйгээ хамт хоолны газар ажиллуулдаг байсан учраас өөр зүйлд зарцуулах цаг түүнд байгаагүй гэж тэр докторт хэллээ. Тэр түүнээс ямар төрлийн ажил байсныг нь асуухад тэр ингэж хариулжээ:

“Би төмс арилгаж сонгино хэрчдэг байсан,” гэжээ.

“Үүнийг хийхдээ та хаана суудаг вэ?” гэж тэр асуув.

“Гал тогооны шатны доод гишгүүр дээр”

“Та хөлөө хаана тавьдаг вэ?”

“Гөлгөр тоосгон дээр.”

“Гөлгөр тоосго гэж юу вэ?”

“Би мэдэхгүй ээ, ноёнтон.”

“Та хэр удаан тэнд сууж байна вэ?”

“Арван таван жил.”

“Хатагтай, миний хаяг энэ байна. Та сайн санаа гарган надад гөлгөр тоосгоны шинж чанарын талаар захиа бичиж явуулахгүй юу?” гэж Агассиз доктор хэлэв.

“Тэр түүнд буурьтай хандав. Тэр толь бичгээс ‘тоосго’ гэдэг үгийг хараад алдартай эрдэмтэнд явуулах гэсэн тодорхойлолт нь хэтэрхий энгийн юм шиг санагдав. Тэгээд тэр нэвтэрхий толиос үзэв. Тоосгоны талаар уншиж эхэлтэл түүнд ойлгогдохгүй олон үг байв. Тэр мөн үүнийг номноос үзэв. Дараа нь тэр сурч байсан зүйлдээ маш их сонирхолтой болсон учраас музейд болон тоосгон хашаануудад очиж үзсэн юм. Судалгаагаа дууссаны дараа тэр сууж, Агассиз докторт гөлгөр тоосгоны сэдвийн дагуу гучин зургаан хуудас захиа бичив.

“Агассиз доктор бага зэргийн цөөхөн өөрчлөлт хийж, түүний захиаг хэвлэсэн тухай түүнд мэдэгдэж 250 доллар илгээсэн захиаг хүлээн авчээ. Захианы доод хэсэгт ‘Тэдгээр тоосгоны доор юу байсан бэ?’ гэж тэр асуусан байлаа.

“Тэр үзэв. Тоосгоны доор шоргоолжнууд байлаа. Тэр шоргоолжны талаарх судалгаагаа эхлэв. Найман зуун хорин таван төрлийн шоргоолж байдгийг тэр олж мэдлээ. Олон төрлийн шоргоолж болон тэд хаана, хэрхэн амьдарч байсан нь

түүний гайхлыг төрүүлж эхлэв. Өргөн хүрээтэй уншиж судлан анхааралтай судалгаа хийсний үр дүнд тэр Агассиз докторт энэ сэдвээр гурван зуун жаран хуудас бичив. Тэр үүнийг ном болгон хэвлүүлж түүнд илүү их мөнгө илгээв.

“Хүлээж авсан мөнгөөрөө тэр өөрийн мөрөөдөл болсон бүх газруудаар аялахаар явав” (*Пристийн Зэргийн Үүрэг ба Адислалууд*, Б Хэсэг, хх. 230-31; adapted from Marion D. Hanks, *The Gift of Self* [Salt Lake City: Bookcraft, 1974], pp. 151-53).

- Мөнгө авхаас гадна тэр эмэгтэйн амьдрал хэрхэн баяжин өөрчлөгдсөн бэ? (Мэдлэг нь нэмэгдэж түүний эргэн тойрондох дэлхийн шинэ сонирхолтой зүйлүүдийг олсон.)

Ишлэл

“Бид ч гэсэн энэ дэлхий ба эргэн тойронд маань байгаа хүмүүсийг сонирхон их зүйлийг сурч чадна. Бид өөрсөддөө байгаа туршлагаа анхаарч, тэдгээрийг сэтгэл зүрх болон оюун ухаандаа сайтар тунгааж, судалгаагаар дамжуулан ойлгохыг эрэлхийлснээр олон зүйлийг амархан сурч чадна. Бид сурч ажиллан гүн гүнзгий бодож сурснаар олон үнэтэй зүйлийг мэдэж, тэдгээрийг өдөр тутмынхаа амьдралд хэрхэн хэвшил болгохыг сурдаг” (*Пристийн Зэргийн Үүрэг ба Адислалууд*, Б Хэсэг, р. 231).

Үйл ажиллагаа

Залуу эрэгтэйчүүдэд харандаа цаас өгөөд тэднээр илүү их сурахыг хүссэн хоёр зүйлийг нь жагсааж бичүүл. Залуу эрэгтэй бүрээр тодорхой нэг сэдвийг яагаад сонирхож буйгаа бусад залуу эрэгтэйчүүдтэй хуваалцуул.

Суралцах нь Бидэнд Агуу Үйлчлэл Хийхэд Тусалж Чадна

Ишлэл ба ярилцлага

Дараах ишлэлийг хуваалц:

“Бид Бурхан, бусад хүмүүс ба өөрийн гэрт байгаа хүмүүстээ үйлчлэх боломжоо нэмэгдүүлэхийн тулд боловсролтой болох ёстой” (Neal A. Maxwell, “Common Concerns and Commitments in Church Education,” divotional assembly address at Education Week, Brigham Young University, June 1971, Provo Utah).

“Түүх, математик, англи хэл гэх зэргийг сурах нь Их Эзэний үгтэй хамт Хожмын Үеийн Гэгээнтэн залуучуудад нэмэлт утгыг өгдөг. Сайн боловрол эзэмшиж номлол, түүний хаант улсыг босгох үүрэг болон дуудлагаа эрхэмлэн гүйцэтгэхийг Их Эзэн та нараас хүсэж байна” (John H. Vandenberg, “The Presiding Bishop Talks to Youth about Education,” *Improvement Era*, Jan. 1968, p. 79).

- Сайн боловсрол эзэмших нь Их Эзэнд илүү сайн үйлчлэхэд бидэнд ямар замаар тусалж чадах вэ? (Залуу эрэгтэйчүүд магадгүй гадаад хэл сурах нь тэднийг номлолд үйлчлэхэд тусалж чадах; хөгжмийн авьяасаа хөгжүүлэх нь хэсэгт үйлчлэхэд тусалж чадах; ярих, заах чадвар нь тэднийг яриа өгөх, заах даалгавар ба номлолд үйлчлэхээр бэлтгэхэд нь тусалж чадна.)

Та залуу эрэгтэйчүүдийн хариулыг самбарт бичиж болно.

Зөвлөхийн танилцуулга

Бидний эргэн тойронд байгаа хүмүүс ба дэлхийг мэдсэнээр Бурханы хаант улсыг барихад тусалж чадна гэдгийг хэл. Энэ нь бидэнд сайн мэдээг илүү сайн заах замыг олоход тусална. Дээр нь Хожмын Үеийн Гэгээнтнүүд мэргэжилдээ үнэлэгдэж, амьдрахын тулд тэд ямар ч зүйл хийсэн бусад хүмүүст Сүмийн тухай илүү сурахад нөлөөлөх жишээ болдог.

Ишлэл

“Мэдлэг олж авах нь бидэнд бусад хүмүүст үйлчлэхэд тусалж чадна. Бид мэдлэгээрээ дамжуулан хүмүүст зовлон ба өвчнөөс салахад нь тусалж, амьдралаа илүү үр бүтээлтэй болгох замыг олж гэр бүлээ хэрэгцээтэй хоол хүнс, хувцас хунар, гэр орноор хангадаг. Хамгийн гол нь бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ адил болоход мэдэх ёстой зарчмууд ба хуулиудыг суралцаж, бусадтай хуваалцах боломжтой болдог” (*Duties and Blessings of the Priesthood, Part B*, p. 225).

- Энэ ишлэлийн дагуу сайн боловрол нь бидэнд ямар замаар бусдад үйлчлэхэд тусалж чадах вэ?

Уриалга

Дүгнэлт

Залуу эрэгтэйчүүдийг уриал:

1. Нэг долоо хоногийн турш өдөр бүр сурах цагийн хуваарь гаргаад түүнийгээ мөрдөх.
2. Мэдэхийг хүсэж байгаа нэг сэдвээ тогтоогоод түүнийхээ тухай номноос уншиж, тэр сэдвээр мэргэжилтэнтэй ярилцах.
3. Суралцсан зүйлийнх нь талаар товч илтгэл эцэг эхэд нь зориулж бэлтгэх.

ЗОРИЛГО Залуу эрэгтэй бүр сайн үлгэр жишээ үзүүлснээр Сүмийн гишүүд ба гишүүн болж амжаагүй сонирхож буй хүмүүсийг хүчтэй болгож чадах болно гэдгийг сурах болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардлагатай материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаа.
2. Алма 17–20-ыг уншиж Лэмэнчүүдэд үзүүлсэн Амоны үлгэр жишээний нөлөөг үз.
3. Хэрэв танай бүст *Family Home Evening Video Supplement* (53276) байгаа бол та “Жинхэнэ Нөхөрлөл” хэсгийг үзүүлж болно.

ТАЙЛБАР Энэ хичээлээр та нар залуу эрэгтэйчүүдэд үлгэр дууриалал бол хүчтэй багш ба тэд найз нөхөддөө үлгэр дууриалаараа багш нь байх болно гэдгийг ойлгоход нь туслах болно. Тэднийг сайн мэдээний үнэний амьд гэрч болоход нь урамшуул.

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

ААРОНЫ ПРИСТИЙН ЗЭРЭГТЭН САЙН ЗҮЙЛИЙН ҮЛГЭР ЖИШЭЭ БАЙХ ЁСТОЙ

Ишлэл

Дараах ишлэлийг хуваалц:

“Сүмийн гишүүдийн хувьд бид бүгд үйлдлээрээ Сүмийг төлөөлдөг. Бидний захиас юу вэ?” (O. Leslie Stone, “The Importance of Reputation,” *New Era*, Feb. 1978, p. 43).

Судар ба ярилцлага

Их Эзэн бидний захиасыг ямар байхыг хүссэн нь тодорхой. Самбарт 1 *Тимот 4:12* гэж бич. Залуу эрэгтэйчүүдээс 1 *Тимот 4:12*-ыг уншаад тэмдэглэхийг хүс.

- Паулын “Хэн ч чамайг залуу хүн хэмээн дорд бүү үзэг” гэсэн нь ямар утгатай вэ? (Хүн залуу байна гэдэг нь ухаан муутай гэсэн үг биш.)
- Паул биднийг итгэгчдэд үлгэр жишээ байхыг хэрхэн зөвлөсөн бэ? (Хэлж буй үг, яриа, энэрлийн үйлсээр, зүрх сэтгэл, итгэл, цэвэр байдлаараа.)
- Бид ямар замаар бусдад сайн үлгэр жишээ болж чадах вэ?
- Амьдарч байгаа байдлаараа сайн үлгэр жишээ үзүүлж байгаа хүмүүсийн тухай Их Эзэн ямар сэтгэгдэлтэй байдаг гэж та нар бодож байна вэ?

Түүх ба ярилцлага

Дараах бодит түүх сайн үлгэр жишээ байхын чухлыг харуулсан юм.

“Солонгосын Таежонон ойролцоох цэргийн баазын эмч намайг инээмсэглэн угтав. Би түүнд болон түүний хамтран зүтгэгч нарт нүүрсхүчлийн дан ислийн хордлогыг гайхалтай давсанд нь баяр хүргэв. . . .

“Түүний майхан дотор бид тийм цэргүүдийн дунд болсон хордлогын тухай ярилцав. Солонгос айлууд гэрийнхээ нэг булангийн доогуур байрлах зууханд том тоосго болгон шахсан *янтан* гэж нэрлэдэг зөөлөн нүүрсээр гэрээ галладаг. Утаа, тоос нь шавар болон паалантай шалаар дамжин барилгын эсрэг талын яндан руу явж байшин болон хүмүүсийг дулаацуулдаг зориулалттай байв. Хэрэв шингэн улам их гоожвол нүүрсхүчлийн исэл байшин руу ордог байв.

АНУ-ын цэргүүд томиллоотоороо цэргийн баазын ойролцоох тосгонд очиж согтоод янтан зуухны ойр олонтаа унтдаг байв. Заримдаа тэд нүүрсхүчлийн хийн исэлд хордон цэргийн бааз дээрээ ухаангүй хүргэгддэг байлаа. Эмчилгээний явцад тэдний цусан дахь спиртийн түвшинг шалгах нь ёс байв.

“Би эмчээс энэ цэргийн цусан дах спиртийн түвшин ямар байгааг асуусан бөгөөд түүний хариулт аймаар бас санаанд нийцэхээр байсан юм.

“‘Аа, би Христэд итгэгч цэргийн цусан дах спиртийг шалгаагүй юм байна. Тэр бол Мормон,’ гэж эмч хэлэв.

“Тэр чинь үүнтэй ямар холбоотой юм бэ? Тэр хот руу яваад ухаангүй ирсэн. Түүний ухаангүй байсан нь архины хордлоготой холбоогүй гэж та яаж мэдэж байгаа юм бэ?”

“‘Яагаад гэвэл тэр бол Христэд итгэгч. Тэр хэзээ ч зөв бус, үлгэр жишээ болохгүй зүйлийг хийхгүй,’ гэж эмч хариулав.

“Цэргийн баазад байдаг бараг бүх хүн түүнийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн буцаж ирсэн номлогч гэдгийг мэднэ гэж эмч тайлбарлаж өгөв. Тэр Солонгост номлолд үйлчилж тэдний хэлээр ярьдаг болсон ба чөлөөгөөрөө тэр байн байн тосгон руу явж хүмүүстэй уулздаг юм. Тэр тэдний заримд нь өөрийнхөө сүмийн тухай зааж өгсөн ба тэд нэгдсэн байна. Тэд цэргийн баазын дэргэд жижигхэн сууринд амьдардаг ба Христэд итгэгч хүмүүстэй хамт Таежон руу шашны цуглаандаа явдаг байв.

“Цэрэг Ням гарагийн орой тэдэнтэй хамт гэртээ буцаж ирсэн ба тэд түүнийг тэр шөнө хонохыг урьжээ. Тэр хүндэт зочин нь байсан тул түүнд цогшсон янтны ойролцоо газар оногджээ. Гэвч маш хүйтэн шөнө байсан ба байшингийн бүх онгорхой хэсгийг хаасан байв. Шалан дээрх онгорхой мэдэгдсэнгүй. Америк цэрэг унтаж хийнд хордсон байна.

“Би эмчийг энэ залуу цэргийг сайн мэдэж байгаад гайхаж байв. Тэр тийм ч олон цэргийг сайн мэддэггүй, харин тэр, ‘Христэд итгэгч цэргийн амьдрал цэргийн бааз доторх бусад залуучуудаас ангид байсан бөгөөд энэ нь түүнийг бусдаас ялгаруулж байсан юм,’ гэж хариулав” (Archie M. Brugger, “Because This Is Christian,” *New Era*, June 1978, p. 7).

- 1 Тимот 4:12-т Паулын зөвлөгөөг Христэд итгэгч цэрэг хэрхэн биелүүлсэн бэ?
- Түүний үлгэр жишээ бусад цэргүүд болон Солонгос хүмүүст ямар нөлөө үзүүлсэн гэж та нар бодож байна вэ?

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр Алма 17:11-ийг уншуулж тэмдэглүүл.

- Их Эзэн Аммонд юу амласан бэ?

Аммоны Лэмэнчүүдийн дунд хийсэн аялал ба түүний үлгэр жишээ тэднийг хөрвүүлэгдэхэд нь хэрхэн хөтөлсөн тухай ярьж өг (Алма 17:20-ийг үз).

Пристийн Зэрэгтний Сайн Үлгэр Жишээ Бусад Хүмүүсийн Сүмийн Тухай Үзэл Бодолд Нөлөөлдөг

Ишлэлүүд ба ярилцлага

Ахлагч Чарлс А. Дадьер зөвлөхдөө: “Сүмийн залуучууд та нарын нөлөө, та нарын үлгэр жишээ хэн нэгний хөрвүүлэгдэхэд нь эсвэл дахин сэргээгдсэн сайн мэдээний захиасыг сонирхохгүй байхад нь тодорхойлох хүчин зүйл болж чадна” гэжээ (The Power of Example,” *New Era*, Oct. 1978, p. 5).

- Энэ нь бид бүхэнд ямар хариуцлага хүлээлгэж байна вэ?

Бусад хүмүүс биднийг үлгэр жишээ болгон харж байж болно гэдгийг тайлбарла. Бид тэдэнд юу өгөх вэ гэвэл Сүмийн тухай зөв буюу буруу сэтгэгдэл төрүүлж болно. Сүмд орсон гучин найман залуучуудыг судлахад тэдний гучин нэг нь Хожмын үеийн гэгээнтэн найзуудынхаа сайн үлгэр жишээнээс болж сонирхож эхэлсэн байна (Ron Woods, “Young Converts Were ‘Mormon Watchers,’ ” *Church News*, 27 Oct. 1979, p.12-ыг үз).

- Гэр бүлийн гишүүн, найз нөхөд, бусад хүмүүсээс Сүмийн гишүүний үлгэр жишээнээс болж Сүмд орсон жишээ та нарт байна уу?

Залуу эрэгтэйчүүдээс тийм хөрвүүлэгдсэний жишээ байвал хуваалцахыг хүс. Танд мөн тийм тохиолдол байвал хуваалцаж болно.

Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Н. Элдон Таннер дараах түүхийг ярьсан юм:

“Би гэр бүлээсээ ганцаараа ирэх сард усан баталгаа хийлгэх гэж буй залуу эрэгтэйтэй ярилцаж байхдаа, ‘Чамайг Сүмийг сонирхоход юу нөлөөлсөн бэ?’ гэж асуусан юм.

“Танай сүмийн гишүүн нэг залуутай хамт би сургуульд явдаг байсан ба түүний амьдрах байдал миний сонирхлыг татсан юм. Тэр бусад хөвгүүдээс онцгой байсан юм. Тэр аз жаргалтай байсан ба намайг гэртээ урьж, би тэр гэр бүл доторх хайрыг, мөн хэрхэн амьдардгийг нь хараад илүү их сонирхсон юм. Тэр намайг сүмдээ аваачиж, тэгээд би сагсан бөмбөгийн багт орсон ба тэр сүмд өөр газраас мэдэрч байгаагүй өөр мэдрэмжийг олсон юм. Мөн сагсан бөмбөгийн багийн гишүүд бүгд Мэргэн Ухааны Үгийг сахиж, цэвэр ариун амьдралаар амьдардаг нь миний сэтгэлийг хөдөлгөж би Сүмд орохоор шийдсэн юм,’ гэж хариулсан билээ” (in Conference Report, Apr. 1972, p. 114; or *Ensign*, July 1972, p. 100).

Түүх

Өөр нэг “Мормончуудыг ажиглагч” залуу итгэлтэй Мормонд талархан энэ захидлыг *Ensign* сэтгүүлд бичжээ.

“1953 оны зун би арван зургаан настайдаа Виржиниа Авингдоны Бартер театрт дагалдан жүжигчин байв. Манай гол жүжигчин Нью Йоркод болсон гол дүрийн тэмцээнд түрүүлсэн улаан үстэй хөөрхөн охин байв. Түүнийг Жүн Монкэ гэдэг боловч магадгүй тэр нь түүний тайзны нэр байсан байх. Бид хоёр хувцасны өрөөгөө дундаа эзэмшдэг байсан ба би өглөө бүр сэрээд Жүнийг орон дээрээ суугаад уншиж байгааг хардаг байв. Хэдэн цагт ч сэрсэн дөрвөн сарын турш би тийм байдлыг хардаг байв.

“Түүнийг Мормон гэсэн мэдээ хурдан тарсан ба ёс суртахуун зүгээр байгаагүй орчинд тэр цас шиг цэвэр байв. Архи уудаггүй, тамхи татдаггүй, тоглолтонд ч тийм зүйл байхгүй ба түүний өрөөнд ямар ч эрэгтэй байдаггүй байв. Тэр хэдий од ч гэсэн маш найрсаг нөхөрсөг, хүн бүхэнд хайртай байв. Өглөө бүр бичмэлээ биш ч харин өөрөө авчирсан бусад ном сэтгүүлүүдийг уншиж байдаг байсан юм.

“Тэр надад өөрийнхөө шүтлэгийн тухай юу ч ярьдаггүй байсан ба би ч юу ч асуудаггүй байлаа. Гэвч би түүнийг хэзээ ч мартаагүй юм.

“Олон жилийн дараа би гэрлээд хоёр хүүхэдтэй болсныхоо дараа нөхөр бид хоёр өөрсдийнхөө сүнслэг амьдралд сэтгэл дундуур байх болов. Бид шашны хичээл заалгаж олон янзын сүмүүдээр явсан боловч сэтгэл дундуур хэвээрээ байв.

“Тэгээд би Жүнийг санав. Түүнийг тэд хэлэхдээ Мормон гэсэн бил үү. Надад мормон гэж юу байдаг тухай ямар ч төсөөлөл байгаагүй бөгөөд тэдний тухай сургуульд түүхийн хичээл дээр үзэж байсныг ч би санахгүй байлаа. Тэгээд би Алабамын жижигхэн Опелика хотын нийтийн номын санд очиж тэндээс Мормоны номыг олсон юм. Номон дээр номлолын хаягууд байсан ба тэднээс хамгийн ойрхон нь болох Жоржиа руу бичиж хөрвүүлэгчдийг хүлээн авах эсэхийг нь асуусан юм. Үлдсэн хугацаа нь бол манай гэр бүлийн түүх юм.

“Тэр охин надад мартагдахааргүй байдлаар өөрийнхөө шашин шүтлэгийн дагуу амьдарснаас болж бидний хоёр талын гэр бүлийн гучин долоон хүмүүс Сүмийн гишүүн болсон гэдгийг би тэр залуу охиныг олж хэлэх боломж надад ерөөсөө олдоогүй юм.

“Бид хэзээ ч мэдэхгүй, үнэхээр бид, биднийг ажиглаж байна, тэд биднээс юу сурч байна гэдгийг хэзээ ч мэдэхгүй” (Ann Fowler Lehne, “ Missionary Example,” *Ensign*, Dec. 1977, p. 62).

Судар ба ярилцлага

Захиан дээрх тэр охинтой адил гэрэл цацруулан түүний сүмийн жишгээр амьдарч байхыг Аврагч биднээс хүсдэг гэдгийг тайлбарла. Биднийг бусдад үлгэр жишээгээрээ зааж, тэднийг дагуул гэсэн хүслээ Тэр Матай 5:14–16-д илэрхийлжээ. Нэг залуу эрэгтэйгээр энэ хэсгийг уншуул. Залуу эрэгтэйчүүдэд энэ шүлгүүдийг тэмдэглэхийг зөвлө.

• Аврагч дагалдагч нараа дүрслэхдээ “дэлхийн гэрэл” гэсэн нь ямар утгатай вэ? (Бид бусдыг өөрсдийнхөө үлгэр жишээгээр Христ рүү хөтөлж чадна.)

Ишлэл *Заавар* гэдэг нь *санаа* гэдэг утгатай болохыг тайлбарла. Тэгээд Ерөнхийлөгч Н. Элдон Таннерын дараах ишлэлийг унш:

“Хүн зааврын дагуу заахаасаа илүү үлгэр жишээгээр заадгийг бид санаж үргэлж сэрэмжтэй байх нь маш чухал юм. Бүгдээрээ “Та нарын үйлдэл маш чанга ярьж байгаа тул би та нарын юу хэлж байгааг сонсож чадахгүй байна” гэсэн хуучны үнэн үгийг мартажгүй байцгаая ” (Teaching Children of God,” *Ensign*, Oct. 1980, p. 4).

Дүгнэлт

Бодох асуултууд Залуу эрэгтэйчүүдээс, дараах асуултуудыг өөрсдөөсөө асууж дотроо хариулахыг хүс.

• Би бусдыг Сүмд орох хүслийг төрүүлэхээр тийм гэрэл буюу үлгэр жишээ болохоор амьдарч байна уу?

• Би хийж буй зүйлээ номлохыг хүсэж байна уу?

• Миний үлгэр жишээ юу зааж байна вэ?

• Бусад хүмүүс надаас юу олж харах вэ?

• Би ямар жишээ болдог вэ?

1. Сургууль дээр?

2. Спортод?

3. Гэртээ ?

4. Найзуудтайгаа байхдаа?

5. Хэн нэгэн надад найрсаг бус үг хэлэхэд?

6. Учраа олохгүй байхдаа?

7. Хүссэн зүйлээ хийх завтай байхдаа?

8. Пристийн зэргийн дуудлагадаа нэмэлт томилт авахаар дуудагдахдаа?

Уриалга Залуу эрэгтэйчүүдээс ямар нэг байдлаар үлгэр жишээ болж чадахгүй байгаа нэг жишээг бодож олоод тэр жишээгээ сайжруулахыг хүс. Энэ зорилгоо тэмдэглэлийн дэвтэртээ бичихийг залуу эрэгтэйчүүдэд зөвлө.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр хуулийг дуулгавартай дагаж, хүндэтгэн дээдэлж, мөрдөн дэмжих нь сайн мэдээгээр хэрхэн амьдрахын нэг хэсэг болох ба тэдний амьдарч буй газрын хүмүүс, хөршүүдэд хэрхэн нөлөөлдөг болохыг харах болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардлагатай материалууд.
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Зураг 4, Олон Улсын Замын Тэмдгүүд.
 - в. Судар тэмдэглэх харандаа.
2. Боломжтой бол залуу эрэгтэй бүрт өгөх Итгэлийн Тунхгийн жижиг хувийг олж ав.

ТАЙЛБАР

Залуу эрэгтэй бүрт улсынхаа хуулийг ойлгож, мөрдөх хүсэлтэй болоход нь тусал. Бурханы хуулинд дуулгавартай байхын нэг хэсэг болох иргэний хуулиудыг дуулгавартай мөрдөхөд нь хүсэлтэй байх хандлага, иргэний хуулийг үл ойшоосноос гарч болох үр дагавар, нийгэм дэх хууль, ёс журмын чухал болох тал дээр төвлөр.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

ОРШИЛ

Ярилцлага

Залуу эрэгтэйчүүдийн сайн мэдэх спортын төрлийг сонгоод түүнтэй холбоотой дараах асуултуудыг асуу.

- Энэ спортод дүрмүүд яагаад чухал вэ?
- Хэрэв спортод дүрэм байхгүй бол ямар байх байсан бэ?
- Хэрэв дүрмийг нь хэн ч мэдэхгүй бол юу амархан болж болох вэ?
- Манай улсын хуулиуд нь спорт тоглоомын дүрмүүдтэй юугаараа адил вэ?

Зураг ба ярилцлага

Олон улсын замын хөдөлгөөний тэмдгийн зургуудыг үзүүл. Тэд юунд хэрэглэгддэг болох, тэд юуг холбодог, яагаад тэд хэрэгтэй, тэд хэрхэн тусалдаг талаар ярилц.

- Том хотод хөдөлгөөн ихтэй цагаар гэрлэн дохио, замын хөдөлгөөний төхөөрөмжүүд эсвэл замын хөдөлгөөний зохицуулагч байхгүй бол юу болж болох вэ?
- Улс орон ба орон нутгийг дэг журамтай, амар амгалан байлгахын тулд өөр ямар хуулиуд хэрэгтэй вэ?
- Хэрэв ийм хуулиуд байхгүй бол юу тохиолдож болох вэ?

Судар ба ярилцлага

Судруудын хувийг үзүүл:

- Эдгээр номнуудад хуулийн номтой адил ямар зүйлүүд бий вэ? (Судрууд Их Эзэний хуулиудыг; хуулийн ном нь иргэний хуулиудыг агуулдаг.)

Сүмийн гишүүдэд Их Эзэн энэ хоёр төрлийн хуулийн талаар зөвлөдөг гэдгийг хэл. Нэг залуу эрэгтэйгээр Сургаал ба Гэрээ 58:21-ийг уншуул.

- Бурханы хуулиудыг сахиx нь улсын хуулийг дуулгавартай дагахад бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Яагаад бидэнд зохион байгуулалттай засгийн газар хэрэгтэй вэ, яагаад хүмүүс ганц ганцаараа байж болохгүй вэ?

Сүмийн Гишүүн Хуулийг Дуулгавартай Дагаж, Хүндэтгэн Дээдэлж, Мөрдөн Дэмжих Ёстой

Зөвлөхийн танилцуулга

Агуу Их Үнэт Сувдын ард талд байдаг Итгэлийн Тунхаг буюу Итгэлийн тунхгийн жижиг хувийг залуу эрэгтэйчүүдэд өг. Залуу эрэгтэйчүүдээр арван хоёр дахь итгэлийн тунхгийг уншуул.

• Бид хуульд яаж хандах ёстойг ямар гурван үг тодорхойлсон бэ? (Дуулгавартай Дагаж, Хүндэтгэн Дээдэлж, Мөрдөн Дэмжих.)

Самбар ба ярилцлага

Самбар дээр *дуулгавартай дагаж, хүндэтгэн дээдэлж, мөрдөн дэмжих* гэж бич.

• Энэ гурван үг ямар утгатай вэ?

Үг бүрийг ярилцаж тодорхойл. Залуу эрэгтэй бүрт дуулгавартай дагах гэдэг нь улсынхаа хуулиудыг мөрдөх гэдгийг ойлгуул. Хуулийг хүндэтгэн дээдэлнэ гэдэг нь хууль хувийн сонирхлоос илүү чухал гэдгийг мэдрэх. Энэ нь хууль үгүй бол замбараагүйдэл үүснэ гэдгийг ойлгосныг харуулдаг. Бид хуулийг мөрдөн дэмжихдээ түүнийг баримтлан хамгаалж үл хүндэтгэх байдлаас хамгаалдаг. Бид хуулийг чухал гэдэгт итгэдэг ба бусдыг хуулийг дуулгавартай дагахыг дэмждэг.

Ишлэл, самбар ба ярилцлага

Ерөнхийлөгч Дэвид О.МакКэйн дараах мэдэгдлийг унш:

“Хуулийг дэмжих нь үүнийг хүчгүй болгох болон үр нөлөөгүй болгох аливаа зүйлийг хэлэх буюу хийхийг цээрлэнэ гэсэн үг юм ” (in Conference Report, Apr. 1937, 28).

• Та нарын үеийн залуу эрэгтэйчүүд ихэнхдээ ямар хуулиудыг үл ойшоож зөрчдөг вэ?

Самбарын зүүн талд ихэнхдээ тоодоггүй ба зөрчдөг хуулиудыг жагсааж бич. Жагсаасан хууль бүрийг залуу эрэгтэйчүүд хэрхэн дуулгавартай дагаж, хүндэтгэн дээдэлж, мөрдөн дэмжиж болохыг тэдэнтэй ярилц.

Залуу эрэгтэйчүүдээс хуулиудыг зөрчсөн буюу зөрчихийг оролдсон тохиолдол харсан бол хуваалцахыг хүс. Дараах асуулт ярилцахад чинь тусалж болно.

• Хэрэв зарим найзууд чинь эдгээр хуулиудыг зөрчүүлэхээр та нарт дарамт үзүүлбэл та нар юу хийж чадах вэ?

Судар ба ярилцлага

Сургаал ба Гэрээ 134-т засгийн газар болон хуулиудад Сүмийн хандах байр суурийг тодорхойлсон гэдгийг хэл. Залуу эрэгтэйчүүдээс нэгдүгээр шүлгийг уншаад тэмдэглэхийг хүс.

• Засгийн газруудыг хэн тогтоосон вэ?

• Тэр яагаад үүнийг тогтоодаг вэ?

• Орон нутаг болон улсын хуулиудын талаар бидний хандлага ямар байх ёстой вэ? 3 ба 5-р шүлгийг уншаад ярилц.

• Бид хууль сахиулагчидтай хэрхэн харьцах ёстой вэ?

• Тэднийг үүргээ гүйцэтгэхэд нь бид хэрхэн тусалж чадах вэ?

• Орон нутагтаа амьдрахад илүү сайхан, аюулгүй болгож буй тэдний оролдлогод нь баярласнаа бид хэрхэн үзүүлж чадах вэ?

Ишлэл ба ярилцлага

Ерөнхийлөгч Н. Элдон Таннер хуулийг дуулгавартай дагахын чухлыг дараах мэдэгдэлд онцолсон:

“Бурханы бүх хуулиуд ба байгалийн хууль, улсын хууль нь хүмүүсийн ашиг тус, тав тух, баяр жаргал, аюулгүй байдал, сайн сайхан байхад зориулсан ба эдгээр хуулиудыг суралцаж ба хуулийг мөрдөж зарлигуудыг сахиснаар ашиг тусыг хүртэх эсэхээ шийдэх нь хувь хүнээс шалтгаалдаг. Миний бүхэл зорилго бол хууль бол бидний ашиг тусын төлөө байдаг ба аз жаргалтай, сайн сайхан байхын тулд бид бидний үйл ажиллагаануудад хамааралтай хууль болон дүрэм зааврыг дуулгавартай дагах ёстой; бидний үйлдлээс шалтгаалан хуулиуд бидний баяр баясгалан, сайн сайхан, эсвэл хор хөнөөл, харууслын аль нэгэнд үйлчилдэг гэдгийг үзүүлэх явдал юм ” (in Conference Report, Apr. 1970, p. 62; or Improvement Era, June 1970, p. 31).

- Ямар хуулиуд бидний ашиг, тав тух, аюулгүй байдалд зориулагдсан гэж та нар бодож байна вэ?

Нөхцөлийн судалгаа Дараах нөхцөлийн судалгааг унш:

Кевин халаасны хутгатай болохыг маш их хүсэж байсан боловч мөнгө байсангүй. Аароны Пристийн Зэргийн зугаалгын үйл ажиллагаа дөнгөж долоо хоногийн дараа болох байв. Кевин дэлгүүрт очоод үзүүлэнгийн хутгануудыг харав. Тэр яагаад нэгийг нь авчихаж болохгүй юм бэ гэж бодож зогсов. Ядахдаа бүх зүйл маш үнэтэй байсан ба түүний цагийн ажил маш бага хөлс төлсөн байв. Түүнээс гадна хэн ч мэдэхгүй. Түүний гэр бүлийнхэн нь үүнийг авахыг маш их хүсэж байсныг нь мэднэ. Тэд бараг хүрэлцэхүйц мөнгөтэй болсныг нь мэднэ. Хэрэв тэр гэртээ үүнийг аваад үчвол тэд юу ч хэлэхгүй. Хэрэв чи шударга байдаг гэсэн нэр хүндтэй бол тайлбарлах ч хэрэггүй. Кевин хутгыг авч гартаа түүний жинг мэдрэв. Тэгээд тэр хутгыг байранд нь тавиад дэлгүүрээс гарав.

Сүүлд нь тэр орой орондоо орсон хойноо бараг юу болох шахсан тухай бодов. Тэр шударга байдлаа хутганы үнээр солиогүйдээ баяртай байлаа. Тэр Сатан түүнээс жижиг зүйлүүдэд, цаашилбал, энэ нь магадгүй том зүйлүүдэд хуулийг зөрчихөд хүргэж болох ба хуулийг зөрчүүлэхийг хүсэж байсан гэдгийг мэдэж байсан.

Зөвлөхийн танилцуулга

Залуу эрэгтэйчүүдэд бид бүгд Кевинтэй адил шийдвэр гаргах үетэй тулгардаг ба хэрэв бид зөв шийдвэр гаргавал амьдралынхаа турш сайн сайхныг мэдрэх болно гэдгийг тайлбарла.

- Иргэний хуулиудыг дуулгавартай дагаж, хүндэтгэн дээдэлж, мөрдөн дэмжих нь бидэнд сайн мэдээний хуулиудыг сахихад хэрхэн тусалж чадах вэ?

Бид Иргэний Хуулийг Дагаснаар Ойр Орчин Болон Нийгмээ Бэхжүүлдэг

Ярилцлага

- Хуулийг дуулгавартай дагаж, хүндэтгэн дээдэлж, мөрдөн дэмжих нь хэрхэн ойр орчин болон нийгмээ амьдрах сайхан газар болгодог вэ?
- Нийгэмдээ бид өөр ямар үүрэг хариуцлага хүлээдэг вэ?

Есүс Христийн Сүмийн гишүүний хувьд бид дэлхий дээрх бүх үндэстэн, хүмүүст болон ялангуяа өөрсдийнхөө ойр орчин, нийгэм, улс үндэстэнд ахан дүүгийн хайрыг үзүүлэх ёстой хэмээн хэл. Бид улс орон, хүмүүст үнэнч шударга байж засгийн газрын удирддаг хүмүүсийнхээ хэрэгцээг хангах үйлсэд нь тусалж чадах бүхнээ хийх ёстой. Мэдээж бидний хамгийн том үүрэг хариуцлага бол сайн мэдээний дагуу амьдрах. Ингэснээр бид өөрсөддөө туслаад зогсохгүй бусдад тусална. Бидний үлгэр жишээ бидний хэлэх үгнээс илүү бусдад нөлөөлөх болно.

Их Эзэн биднийг хөршдөө болон найз нөхөддөө тусалж тэднийг хайрлахыг хүсдэг. Энэ нь агуу золиослолыг шаарддаггүй ба нөхөрлөл нь ихэнхдээ сайн санааны жижиг үйлс дээр тулгуурладаг. Сайн хөрш байхын нэг хэсэг бол бусдын, тэр тусмаа бэлэвсэн ба өнчин хүмүүсийн хэрэгцээг анхаарах юм. Бидний хөршүүддээ хийж чадах агуу үйлчлэл бол тэдэнд сайн мэдээг танилцуулах болно. Гэвч тэд үүнийг хүлээн зөвшөөрсөн ч бай үгүй ч бай бид тэднийг хайрлаж тэдэнд үйлчлэх ёстой. Манай нийгэмд бусдад туслахад бэлэн, найдвартай, үнэнч иргэн маш их хэрэгтэй.

Ярилцлага

- Аароны Пристийн Зэрэгтэн тосгон, хот, улсдаа дараах замаар хэрхэн үйлчилж чадах вэ (эдгээрийг орон нутгийнхаа нөхцөлд тааруул)?

1. Замын хөдөлгөөний дүрмүүд
2. Улаан Загалмайн үйл ажиллагаа
3. Улс төрийн кампанит ажилтай холбоотой хэвлэл, сонгууль
4. Залуучуудын чуулга уулзалт

Дүгнэлт

Уриалга

Залуу эрэгтэйчүүдийг улсынхаа хуулиуд болон сайн мэдээний хуулиудыг дуулгавартай дагаж, хүндэтгэн дээдэлж, мөрдөн дэмжихийг өөрсөддөө амлахыг уриал.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр талархлыг мэдрэх ба илэрхийлэхийн чухлыг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

Шаардагдах материалууд: залуу эрэгтэй бүрт судар.

ТАЙЛБАР

Талархлын сүнс амьдралыг Бурхантай ойрхон болгодог. Та нарын хариуцсан залуу эрэгтэйчүүд үг ба үйлсээрээ Тэнгэрлэг Эцэг болон өөртэйгөө холбоотой хүмүүстээ үргэлж талархлаа илэрхийлэхийн чухлыг мэдрэх хэрэгтэй. Тэд талархлыг мэдрэх ба илэрхийлэх нь зарлиг ба хүнлэг хүний шинж гэдгийг мэдэх хэрэгтэй. Та нар залуу эрэгтэй бүрт өөрийн талархлаа тогтмол илэрхийлэх боломжийг хайж, түүний энэ зан чанарыг хөгжүүлэх оролдлогод нь таларх.

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

Самбар ба
ярилцлага

Оршил

Самбарт *Талархал бол* _____ гэж бич. Залуу эрэгтэйчүүдээс хамгийн сайн тодорхойлолтыг нэг нэгээр нь өгүүл. Тэдний хариултын гол санааг нь самбарт бич.

- Бид ямар үед баярладаг вэ? (Бусад хүмүүсийн бидний төлөө хийсэн зүйлийг нь мэдээд.)
- Бид яагаад талархах ёстой вэ?
- Талархлаа илэрхийлэх нь яагаад чухал вэ?

Ишлэл

Ахлагч Ховард В.Хантер хэлэхдээ: “Адислалаар ирэх аз жаргал, баяр баясгалан нь бидний дотор баярласнаа илэрхийлэхийг дэмжих талархлын гүн мэдрэмж төртөл хэзээ ч бүрэн дүүрэн болохгүй” гэжээ (in Conference Report, Denmark, Finland, Norway, and Sweden Area Conference 1974, p. 27).

Бид Бусдад Талархлаа Илэрхийлэх Ёстой

Зөвлөхийн
танилцуулга

Энэ хичээлийн явцад залуу эрэгтэйчүүд *Хүн хэрхэн баярласнаа илэрхийлэх вэ?* гэсэн асуултанд хариулахад бэлтгэж байх ёстойг хэл. Энэ асуултыг самбарт бич.

Түүх ба ярилцлага

Ахлагч Хенри Д. Тэйлорын иш татсан дараах түүхийг унших буюу ярьж өг:

“Колумбия дүүргийн цагдаа Баасан гаригт ойролцоогоор 100 гаруй унадаг дугуйг үнэ хаялцуулан худалджээ. Эхний дугуйг нэг доллар хэмээн арван нэгэн настай хүү үнэ хаялцан эхлүүлэв. Хэдий тийм ч үнэ хаялцаа маш өндөр үнээр төгсөв. Өөр дугуй гарч ирэх бүр хүү найдсан янзаар ‘Нэг доллар’ хэмээн давтаж байв.

“Алдагдсан ба хулгайлагдсан дугуйнуудыг 43 жил үнэ хаялцуулан худалдаж буй худалдагч уралдааны дугуй гарч ирэх бүрт хүүгийн найдвар алга болж буйг анзаарав.

“Ганцхан уралдааны дугуй үлдчихэв. Тэгээд үнэ нь найман долларт хүрэв. ‘Тэнд зогсож буй хүүд 9 доллараар худалдлаа’ гэж худалдагч хэлэв. Тэр өөрийнхөө халааснаас найман доллар гаргаж хүүгийн нэг долларыг нэмж авав. Бяцхан хүү нэгтийн зоос, аравтын зоос, хорин тавтын зооснуудыг өгөөд дугуйгаа авч явав. Гэвч тэр хэдхэн алхам холдов. Шинэхэн өмчөө байрлуулж тавьчихаад тэр буцаж ирээд баяртайгаар худалдагчийг хүзүүнээс нь тэврэн уйлав” (in Conference Report, Apr. 1959, p. 56).

- Талархал нь хүү худалдагч хоёрт хоёуланд нь ямар нөлөө үзүүлсэн бэ? (Энэ нь тэдэнд баяр баясгалан авчирсан. Тэр хоёр ижилхэн зүйл мэдэрч энэ нь тэднийг ойртуулсан.)
- Хэрэв хүү буцаж ирээгүй бол худалдагч юу мэдрэх байсан гэж та нар бодож байна вэ? (Магадгүй урам хугарч гунигтай болох байх.)
- Ямар шалтгааны улмаас зарим хүмүүс талархсанаа илэрхийлдэг ба зарим нь үгүй вэ? (Магадгүй зарим хүмүүс бардам байдаг ба бусад нь тэдэнд өгөх ёстой гэж боддог; зарим нь хувиа бодсон, бодлогогүй, мартамхай; зарим хүмүүс байх л ёстой зүйл гэж боддог.)

Түүх

Дараах үнэн түүхийг ярьж өг:

Настай хос номлогчийн талбар руу явах гэж байв. Тэднийг явахаас өмнөх ариун ёслолын цуглаан дээр бишоп тэднийг яриа өгөхийг хүсэв. Тэд өсөж том болсон хүүхдүүдийнхээ төлөө талархсанаа илэрхийлж ярихдаа ээж нь гэртээ байдаг бага хүүгийнхээ тухай ярихад, Тэр эмэгтэйд хүүгийнх нь хамгийн сайхан санагддаг зүйл бол өглөө, өдөр, оройн хоол бүрийн дараа хүү, “Баярлалаа ээж ээ, сайхан хоол хийж өгсөнд баярлалаа” гэж хэлдэг нь байв.

- “Баярлалаа ээж ээ” гэж хэлдэг зуршил нь энэ ээжид ямар сэтгэгдэл төрүүлсэн бэ?
- Хоол бүрийн дараа “Баярлалаа ээж ээ” гэж хэлдэг нь хүүд хэрхэн тусалсан гэж та нар бодож байна вэ?
- Бусад хүмүүсийн бидний төлөө байнга хийдэг ямар ямар зүйлд нь бид талархахаа санаж байх ёстой вэ?

Түүх ба ярилцлага

Дараах бодит түүхийг чанга унш:

“Бид хүүхдүүдийнхээ багш нартай хичээлийн шинэ жилийн өмнө уулзахаар эцэг эхийн хуралд очсон байлаа. Хэд хэдэн багш манай хүүхдүүдэд сүүлийн хэдэн жил хичээл зааж буй тул бид тэдэнтэй танил болсон байв. Нэг багш бидэн дээр ирж гар бариад, “Танай хүү надад чухал шийдвэр гаргахад тусалсанд би их баярлаж явдаг гэдгийг би та нарт хэлэхийг хүсэж байна. Хоёр жилийн өмнө би нийтийн сургуульд багшилж эхэлсэн юм. Хүү чинь миний ангид сурдаг байсан ба тэр жил надад маш хэцүү жил болж би их эргэлзэж байсан юм. Хэдэн сарын дараа би өөртөө багшлах нь маш хүнд юм, энэ жил заагаад багшлахаа больё гэж шийдсэн билээ. Сургуулийн сүүлчийн өдөр би танай хүүгээс сайхан бэлэг бас онцгой захидал авсан юм. Захидалдаа тэр надад би хэзээ ч ийм сайн багштай байгаагүй хэмээн талархлаа иэрхийлсэн байсан. Тэр захидал ямар их чухал байсныг би та нарыг мэдэхийг хүсэж байна. Би үлдэхээр шийдсэн юм.”

- Энэ хүү яагаад бэлэг, захидал өгсөн бэ? (Тэр багшдаа талархсан ба магадгүй хэрэв багшийнхаа оронд байсан бол бэлэг, захидал авахдаа баярлах байсан гэж мэдсэн байх.)
- Зөвхөн ганц удаагийн талархлаа илэрхийлэх нь хэн нэгний амьдралыг хэрхэн өөрчилсөн бэ? (Багш багшаараа үлдэхээр шийдсэн.)

Бодох асуулт

- Та нарт талархсанаа илэрхийлж тус болох багш, удирдагч, хөрш, гэр бүлийн гишүүн, найз нөхөд байна уу?

Ярилцлага

Мацаг болон гэрчлэлийн цуглаан дээр бид гэрчлэлүүдийн хамт бас маш олон талархал илэрхийлэх үгсийг сонсдог гэдгийг хэл.

- Хүмүүс баярласан зүйлийнхээ талаар өөр юу юу ярихыг та нар сонссон бэ?
- Та нар юунд талархаж явдаг вэ?

Залуу эрэгтэйчүүдэд хүн талархлаа мэдрэх нь ердийн хэрэг ба тэр сэтгэлээ илэрхийлэх нь зөв зүйтэй юм гэдгийг хэл. Талархлаа илэрхийлэхгүй байх нь талархаагүйн шинж юм.

Самбар ба ярилцлага

- Бид өөр ямар замаар талархаж болох вэ?

Хариултуудыг товчлон самбарт бич. Залуу эрэгтэйчүүдийн хариултанд тэврэх, сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх, гэр бүлийнхэндээ талархдагаа хэлэх, тусламж

үзүүлсэн хүнд баярлалаа гэж хэлэх, талархлын захидал бичих, бэлэг өгөх, гэрчлэлийн цуглаан дээр баярласнаа илэрхийлэх, тусалсан хүмүүстээ сайхан зүйл хийх, утсаар ярих, хурдан ба үнэн санаанаасаа инээмсэглэх багтаж болно.

Бид Их Эзэнд Талархсанаа Илэрхийлэх Ёстой

Түүх ба ярилцлага

Дараах түүхийг нэгэн сэтгүүлийн ууланд авирах тухай өгүүллэгээс авсан:

Орой дээр зогсох ууланд авирагч олсыг барьж доор буй хүнийг хамгаалахын тулд бүхнийг хийдэг бөгөөд хэрэв хэрэгсэл эвдэрвэл доор буй уулчны амь түүнээс хамааралтай гэдгийг тэр мэднэ. Нэг удаагийн буултанд уулчныг тогтоож байсан хэрэгсэл эвдэрчээ. Дээр нь байсан түүний хамтрагч олсыг аюулгүй болгож доош унахыг нь зогсоохын тулд чадах бүхнээ хийжээ. Эцсийн эцэст орой дээр байсан хамтрагч нь уулчныг толгойгоороо газар ойчихоос нь өмнө, үхэж ч магадгүй байсан аюулаас аварчээ. Аврагдсан уулчин “Тийм залууд та нар юу хэлэх вэ? Тэр олсоо зул сарын баярын бэлэг болгон өгөх үү? Үгүй, түүнийг дурсан санах болно. Түүнийг үргэлж дурсан санах болно” гэжээ (Eric G. Anderson, “The Vertical Wilderness,” *Private Practice*, Nov. 1979, p.21; as quoted in *The Growing Edge* [publication of the Church Educational System], Feb. 1982, p.1).

- Амийг нь аварсан найзыгаа дурсан санахдаа ууланд авирагч юу боддог гэж та нар бодож байна вэ? (Олс барьж байхад тэр ямар байсан; олсыг барих нь ямар хэцүү байсан; хоёулаа нийлээд ямар их баяр баясгалантай байсан тухай.)
- Хэн нэгнийг үргэлж санах нь баярласны шинж хэрхэн болдог вэ?
- Долоо хоног бүр бид хэнийг үргэлж дурсан санана гэж гэрээ хийдэг вэ?

Судар ба ярилцлага

Та Сургаал ба Гэрээ 20:77, 79-ийг уншиж байхад дагуулан харахыг залуу эрэгтэйчүүдээс хүс.

- Ариун ёслолын залбиралд *дурсан санах* буюу *дурсгал* гэсэн үгс хэдэн удаа давтагдсан байдаг вэ? (Дөрвөн удаа.)
- Бид Аврагчийг хэрхэн үргэлж дурсан санах вэ? (Түүний бидэнд ямар чухал болохыг үргэлж бодох. Түүнд үйлчлэх. Түүний хүссэнээр амьдрах.)
- Ариун ёслол түгээх бүрд бид ямар сэтгэгдэлтэй байх ёстой вэ? (Бид Их Эзэнд болон түүний зарлигуудыг сахих амлалтандаа гүн гүнзгийгээр баярлах ёстой)

Залуу эрэгтэйчүүдээр Сургаал ба Гэрээ 59:7-г уншуулж тэмдэглүүл.

Бид яагаад Их Эзэнд бүх зүйлд талархах ёстой вэ?

Ишлэл

Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Марион Ж.Ромни хэлэхдээ: “Талархал бол хайр хишиг буюу тус дэм хүлээн авсандаа талархсан мэдрэмж хэмээн тодорхойлогддог. Талархал бол хүний хүнлэг шинж юм. Талархдаггүй хүн нь хаанаас ирж байгааг нь харахын тулд хэзээ ч дээш харалгүй модны доор боргоцой идэж буй гахайтай адил гэж хэлдэг билээ” (in *Conference Report*, Bogota Colombia Area Conference 1977, p. 28).

Түүх ба ярилцлага

Испанид үйлчилж байсан нэг бүрэн цагийн номлогч дараах түүхийг ярьсан юм.

“Би нутагтаа үйлчилж буй Испани хамтрагчид томилогдсон юм. Өглөө бүр боссоны дараа хамтрагч маань өрөөний аль нэг газар руу явж алга болоод хорь гучин минутын дараа буцаж ирдэг байв. Хамтдаа идэж, залбирч, судраас суралцах нь дүрэм байсан тул би нэг өдөр хамтрагчаасаа хаашаа алга болдог болон яагаад тэгдэг тухай асуусан юм. Тэр тайлбарлахдаа: ‘Би Сүмийг олж, номлогчоор үйлчлэх боломжтой болсон цагаас миний бүхэл амьдрал сайнаар өөрчлөгдсөн юм. Би энэ Сүмд байх боломжтой болсондоо болон одоо Их Эзэний номлогч байгаадаа их баяртай байдаг. Түүнийг надад хайртай гэдгийг би мэдэх ба хэрэв өдөр бүр Их Эзэний хамт түүний өгсөн адислалуудыг эргэж санаж түүний надад өгсөн бүхэнд залбиралдаа талархах цаг гаргахгүй юм бол үнэхээр тус мэддэггүй талархалгүй хүн байх болно гэж боддог,’ гэж хэлсэн юм.

- Энэ номлогчийн тухай Их Эзэн юу бодож байгаа гэж та нар бодож байна?
- Та нар зөвхөн баярласнаа илэрхийлэхийн тулд залбирч үзсэн үү?

Бодох асуулт

Түүх ба ярилцлага	<p>Дараах бодит түүхийг ярьж өг:</p> <p>Хэсэг хөвгүүд хоногоор явган аялалаар явахаар зуслан руу хүргүүлжээ. Жолооч тэр газрыг сайн мэддэггүй учир тэднийг очих ёстой газраас нь хэдэн милийн зайнд буулгаж орхив. Хөвгүүд замаа товчлохоор шийдсэн боловч удалгүй төөрчихөв. Цаг явсаар харанхуй болж ирэхэд тэд айж бас будилж эхэллээ. Нэг хүү өвдөг сөгдөн залбирья гэж санал гаргав. Тэд дугуйран залбирахыг санал болгосон хүүг залбирахыг санал болгов. Залбирсныхаа дараа тэд удалгүй зөв замаа олж маш хурдан аюулгүйгээр зусландаа ирэв. Хэдэн минут баярласнаа тэмдэглэсний дараа өмнө нь залбирахыг санал болгосон хүү, 'Бид нэг юм мартчихлаа,' гэж хэлэв.</p> <ul style="list-style-type: none"> • Тэд юу хийхээ мартсан гэж та нар бодож байна вэ? (Тэд зуслангаа олж, аюулгүй ирэх боломжтой байсандаа талархаж залбирахаа мартсан.) • Их Эзэн бидний тусламж хүссэн залбиралд хариулсны дараа бид яагаад талархлын залбирал хийхээ мартдаг вэ?
Судар ба ярилцлага	<p>Залуу эрэгтэйчүүдээс Лук 17:11–19-ийг уншихыг сонсохыг хүс.</p> <ul style="list-style-type: none"> • Аврагчид уяман өвчтэй есөн хүн яагаад эргэн ирж баярласнаа хэлээгүй гэж та нар бодож байна вэ? (Магадгүй тэд өөрсдийнхөө аз завшаанд баярлаад бусад хүмүүсийн мэдрэмжийг мартсан байх. Тэд магад дэндүү биеэ тоосон ба тус мэддэггүй эсвэл магадгүй буцаж очихоосоо айсан байх.) • Аврагч буцаж ирэн талархлаа илэрхийлсэн уяман өвчтэй хүний тухай ямар сэтгэгдэлтэй байсан гэж та нар бодож байна вэ? • Тэнгэрлэг Эцэг болон Аврагчид бид хэрхэн баярласнаа үзүүлж чадах вэ? (Баярласан болон талархсан залбирал өргөх, үргэлж Их Эзэнийг болон бидний төлөө юу хийснийг нь санах, судруудаа судлах, бусдад үйлчлэх, ариун ёслолоос хүртэх болгондоо талархах, өөрсдийнхөө сэтгэгдлийг тэмдэглэлийн дэвтэртээ бичих, цуглааны үеэр болон өөртөө Их Эзэнийг магтсан дуу болон дуоллуудыг дуулах.) <p>Залуу эрэгтэйчүүдийн хариултыг самбарт нэмж бич.</p>

Дүгнэлт

Зөвлөхийн
танилцуулга

Та залуу эрэгтэйчүүдэд тэдний нөхөрлөл ба сүнслэг урмынх нь төлөө талархсанаа илэрхийлж болно. Мөн та талархах сэтгэл болон түүнийгээ илэрхийлэхийн чухлын тухай гэрчлэлээ хуваалцаж болно. Мөн залуу эрэгтэйчүүдээс эцэг эх болон өөр сонгосон хүмүүстээ талархлын захиа бичихийг зөвлөж болно.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр эмэгтэй хүний Сүм, нийгэм, гэр дэх үүргийг нь ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардлагатай материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт жишиг бүтээл.
 - б. Залуу эрэгтэй бүрт цаас харандаа.
 - в. Судар тэмдэглэх харандаа.
2. Бишоп буюу салбарын ерөнхийлөгчийн зөвшөөрөлтэйгээр гурван эмэгтэйгээр доорх сэдвүүдийн талаар тус бүр 3–5 минутын яриа өгүүлэхээр төлөвлө.
 - а. Бурханы охин байхын ач холбогдол ба адислалууд.
 - б. Эхнэр байхын ач холбогдол ба адислалууд.
 - в. Ээж байхын ач холбогдол ба адислалууд.
3. Хуучин Гэрээний Естер ба Рутын түүхийг тоймлоод эдгээр эмэгтэйчүүдийн түүхийг эмэгтэй байхын онцгой жишээ болгон товч ярихад бэлтгэ.
4. Эмма Смит, 5-р зураг (мөн Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга [34730] дахь 405-р зураг)-ийг үзүүлэхээр бэлтгэ.

ТАЙЛБАР

Залуу эрэгтэй бүрийн амьдралд эмэгтэйчүүд маш их нөлөө үзүүлсэн. Аароны зэрэгтний амьдрал ба түүний одоогийн бие болон оюун ухааны байдал түүний ээжийн маш их хэмжээний хүч чармайлт үр дүн юм. Түүний амьдралынхаа тухай мэддэг болон бодож явдаг олонх зүйл нь багш найз нөхөд зэрэг зохистой эмэгтэйчүүдийн тэнгэрлэг нөлөөллөөр ирдэг. Энэ хичээл залуу эрэгтэйчүүдэд тэдний амьдралд өгсөн Бурханы үүргэнд хариулсан эмэгтэйчүүдийн ачаар ирсэн адислалуудыг нь сануулах болно. Ээж нь тэдэнтэй хамт амьдардаггүй зарим залуу эрэгтэйчүүдэд анхааралтай ханд.

Та энэ хичээлийг хоёр долоо хоног зааж болно. Эхний долоо хоногт хичээлийн материалуудыг; дараагийн долоо хоногт гурван яриа ба сэдвийн талаар ярилцлагыг оруулж болно.

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

Судар, самбар
ба ярилцлага

Оршил

Залуу эрэгтэйчүүдэд судруудад маш олон агуу эрэгтэй эмэгтэй хүмүүсийн жишээнүүд байдаг гэдгийг хэл. Энэ хичээл агуу эмэгтэй хүмүүсийн жишээн дээр төвлөрсөн.

Залуу эрэгтэйчүүдээс Бурханы итгэлтэй охидын жишээ болсон зарим эмэгтэйчүүдийг нэрлэхийг хүс. Самбар дээр *Бурханы итгэлтэй охид* гэж бичсэний доор тэдний хариултуудыг бич. Нэр хэлэх бүрт нь залуу эрэгтэйчүүдээс яагаад Бурханы агуу охин болсныг нь асуу. Хариултанд Ева, Сарай, Ребека, Рахел, Естер, Леа, Рут, Мариа, Сариа, Наоми, Ханна, Эмма Смит орж болно.

Эмма Смитийн зургийг үзүүл. Сургаал ба Гэрээ 25 нь Бошиглогч Иосеф Смитийн эхнэр Эмма Смитэд өгсөн илчлэлт гэдгийг тайлбарла. Залуу эрэгтэйчүүдээр 1-3р шүлгийг уншуул.

- Энэ илчлэлтийг өгөхдөө Эмма Смитийг Их Эзэн зөвшөөрсөн гэдгийг бид яаж мэдэх вэ? (Тэр түүний гэм нүглийг уучилж түүнийг сонгогдсон эмэгтэй гэж нэрлэсэн.)

Бурханы Хаант Улсад Эмэгтэйчүүд Чухал Үүрэгтэй

Ишлэлүүд
ба самбар

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл Сүмийн эгч нарт хандан Бурханы хаант улсад эмэгтэй хүний гурван чухал үүргийг онцлон хэлэхдээ: Бурханы эмэгтэйг мэдэхтэй адил агуу эрхэм зүйл энэ дэлхийд та нарт ирэхгүй. Жинхэнэ эгч байх, эхнэр байх, ээж байх болон өөр бусад хүмүүсийн амьдралд нөлөөлөх шалгууруудыг амссан Бурханы охин байхаас илүү зэрэг та нарт олгогдоогүй” (The Role of Righteous Women,” *Ensign*, Nov. 1979, p. 102).

Самбарт *Бурханы охин*, *Эхнэр*, *Эх* гэж жагсааж бич.

Дэлхий дээр боловсрол, аж үйлдвэр, бизнес, засгийн газар, бусад ажлын талбарт эрэгтэй эмэгтэй хүмүүс аль аль нь хийдэг олон ажил байдаг ч Бурхан зарим онцгой үүрэг хариуцлагыг эмэгтэй хүнээр хийлгэхээр болон бусдыг нь эрэгтэй хүнээр хийлгэхийг хүсдэг гэдгийг тайлбарла. Эдгээр үүрэг хариуцлага нь онцгой чухал.

Ерөнхийлөгч Кимболл тайлбарлахдаа:

“Энэ Сүмийн эмэгтэй хүмүүст хэдий ялгаатай ч эрэгтэй хүний хийдэг ажилтай ижил маш чухал ажил байдаг. Хэдий бидний үүрэг, томилогдсон ажил ялгаатай ч тэдний ажил нь бидний хийдэг ажилтай ижилхэн үндсэн ажил юм” (in Conference Refort, Oct. 1979, pp. 71- 72; or *Ensign*, Nov. 1979, p. 49).

Эрэгтэй хүмүүст мөн ижилхэн Бурханы өгсөн үндсэн хариуцлагууд байдаг. Үүнд Бурханы зөв шударга хүү, нөхөр, аав байх багтана. Эдгээрийг самбарт эмэгтэй хүмүүсийн хариуцлагын дэргэд жагсааж бич.

Хэрэв бид Бурханы эрэгтэй ба эмэгтэй хүмүүст даалгасан энэ зорилтуудыг харвал эмэгтэй хүн нь эрэгтэй хүнээс илүү чухал биш мөн эрэгтэй хүн нь эмэгтэй хүнээс илүү чухал биш байгааг харах болно.

Судар, самбар,
ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр 1 Коринт 11:11-ийг олуулж, уншуулж, тэмдэглүүл.

- Энэ судраас бид юу сурах вэ? (Эрэгтэй эмэгтэй хүмүүс нь хоёулаа Бурханы хаант улсад хэрэгтэй. Их Эзэний үзэлд дэлхий дээрх тэнгэрлэг үүргээ биелүүлэхийн тулд эрэгтэй эмэгтэй хүмүүс хамтран ажиллах оролцогч байх ёстой.)

Самбар дээрх итгэлтэй эмэгтэйн жагшаалтаас залуу эрэгтэйчүүдээр энэ эмэгтэйчүүд (1) Бурханы зөв шударга охидууд; (2) сайн итгэлт эхнэрүүд, болон (3) хайр бүхий эхчүүд шиг байсан тохиолдлуудыг яриул.

Судрын түүх
ба ярилцлага

Естерийн доорх түүхийг өөрийнхөө үгээр ярь.

Есүсийг төрөхөөс хэдэн зуун жилийн өмнө олон тооны Иудейчүүд Бабилоны хавьд амьдарч байжээ. Тэдний нэгийг Естер гэдэг байв. Тэр маш үзэсгэлэнтэй залуу эмэгтэй байсан учир хаан түүнийг эхнэрээ болгохоор сонгожээ.

Түүнээс хойш хэсэг хугацааны дараа хааны нэг зөвлөхөд Мордехаи гэдэг Иудей мэхийн ёслохыг татгалзан түүнийг гомдоосон байна. Зөвлөх Иудейчүүдийг итгэлгүй, улсын хуулийг дагадаггүй гэж хаандаа итгүүлсэн байна. Тэгээд тэднийг алах хэрэгтэй гэж зөвлөжээ. Хаан зөвшөөрсөн байна.

Естер Иудейчүүдэд юу тохиолдох ёстой болохыг сонсоод хэцүү шийдвэр гаргах хэрэгтэй болжээ. Тэр хаан түүний Иудей гэдгийг мэдэж авахгүй байхад найдах буюу эсвэл хэдий өөрийнх нь аминд аюултай ч өөрийнхөө ард түмнийг аврахын тулд ямар нэг зүйл хийхийг хичээх хэрэгтэй болов.

Тэр өөрийнхөө ард түмэнд туслахаар шийджээ.

Естер 4:16-г унш.

- Тэр улсад байгаа бүх Иудейчүүдийг Естер юу хийхийг хүссэн бэ? Яагаад?
- Тэр юу хийхээр төлөвлөсөн бэ?

Хуулиар бол хэрэв хэн нэгэн хаан дээр ярих эрхгүйгээр очсон бол эрэгтэй эмэгтэй ямар ч хүн байсан алуулдаг байсан тул Естер айж байв. Гэвч Естер амиа өөрийнхөө ард түмний төлөө золиослоход бэлэн байсан ба хаан түүнд ярих зөвшөөрөл өгчээ. Тэр хатан зоригтой байсан учир Иудейчүүд эцэст нь аврагджээ.

Тусгай танилцуулга Судрууд ба ярилцлага	<ul style="list-style-type: none"> • Естериийг Бурханы итгэлтэй охин болоход нь ямар зан чанар түүнд тусалсан бэ? • Өөрийнхөө зориг, шударга байдлыг харуулахын тулд Естер юу хийсэн бэ? <p>Өмнө нь томилсон гурван эмэгтэйгээр танилцуулга хийлгэ.</p> <p>Залуу эрэгтэйчүүдээр Сургаалт үгс 31:10–13, 20, 26–28, 30-ийг уншуул.</p> <ul style="list-style-type: none"> • Эмэгтэй хүний ямар чанарыг энэ шүлгүүдэд дурьдсан байна вэ? • Яагаад ийм эмэгтэй хүний нөхөр ба хүүхдүүд түүнийг магтана гэж та нар бодож байна вэ? • Та нар амьдралдаа зөв шударга эмэгтэйн нөлөөгөөр хэрхэн адислагдаж байсан бэ?
---	--

Эмэгтэй Хүмүүс Тэдэнд Бурханы Өгсөн Ээжийн Үүргийг Биелүүлэхдээ Бидний Амьдралд Хувь Нэмрээ Оруулдаг

Ишлэл	<p>Хүн бүр Бурханы тэднээр хийлгэхийг хүссэн зүйлийг хийж буй эмэгтэйгээс тусламж авсан. Ийм эмэгтэйчүүдийн тухай Ерөнхийлөгч Кимболл хэлэхдээ: “Бид бүгдээрээ амьдралдаа бидэнд гүн гүнзгий үргэлжлэх нөлөө үзүүлсэн онцгой эмэгтэйчүүдээр адислагдсан. Тэдний хувь нэмэр бидэнд чухал байсан, одоо ч чухал байгаа ба мөнхөд үнэ цэнэтэй хэвээр байх хамгийн чухал зүйл байх ч болно” (in Conference Refort, Oct. 1979, p. 71).</p>
Үйл ажиллагаа	<p>Залуу эрэгтэй бүрт цаас харандаа өг. Тэднээс цаасан дээрээ 1–4 хүртэл дугаарлахыг хүс. Дугаарласан тооныхоо хажууд тэдний амьдралд тусалсан болон хувь нэмрээ оруулсан эмэгтэйчүүдийн нэрийг бич гэж залуу эрэгтэйчүүдэд хэл. Тэд гэр бүл доторх, хөрш, багш, найз эмэгтэйчүүдийн нэрийг бичих болно. Нэр бүрийн хажууд тэдний яаж тусалсан болон хувь нэмэр оруулсан тухай товч мэдээлэл байх ёстой. Тэдэнд үүнийг хийхэд нь дөрвөн минут өгөөд тэдэнд дөрвийг хийхийг сануулж шалга.</p> <p>Залуу эрэгтэй бүр нэрс болон мэдээллийг бичсэний дараа хүн бүр түүний амьдралд хувь нэмэр болсон нэг эмэгтэйг сонгож дүрслүүл. Залуу эрэгтэйчүүд нэрийг нь хэлэх ёсгүй боловч дүрсэлснээ хуваалцах ёстой. Зөвлөхийн хувьд та өөрөө жагсаалт хийж залуу эрэгтэйчүүдэд хялбар болго. Хэрэв цаг үлдвэл хариуд нь аль болох олон хувь нэмрээ өгсөн эмэгтэйчүүдийн талаар яриул.</p>
Уриалга	<p>Залуу эрэгтэйчүүдийн хийсэн жагсаалт руу дахин анхаарлыг нь хандуул. Эдгээр эмэгтэйчүүдийг хүндэтгэж байгаагаа үзүүлэх ямар нэг зүйлийг өнөөдөр хийхийг уриал. Залуу эрэгтэй бүрийн хийх зүйл:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ээждээ чин сэтгэлийн баярласнаа илэрхийлэх. 2. Хичээл заадаг Сүмийн эгчтэй ярилцаж талархсанаа хэлэх. 3. Амьдралд нь онцгой болон сайн нөлөө үзүүлсэн эмэгтэйд талархлын захидал бичих. 4. Түүнд ямар нэг байдлаар тусалсан эгчдээ талархсанаа илэрхийлэх.

Шударга Бус Дэлхийд Зөв Шударгаар Амьдрах нь

38

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр хэдий дарамт байдаг ч зарлигуудыг сахих хүсэлтэй болох болно.

БЭЛТГЭЛ

Шаардлагатай материалууд:

1. Залуу эрэгтэй бүрт судар.
2. Даниел Хааны Мах Болон Дарснаас Татгалзсан нь, зураг 6 ба Даниел Арслангийн Үүрэнд, зураг 7 (мөн зураг 114, 117 Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга [34730]).
3. Залуу эрэгтэй бүрт дууллын ном.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Түүх

Бид Шударга Бус Дэлхийд Зөв Шударга Амьдарч Чадна

Дараах түүхийг ярьж өг.

Табэрнэклийн найрал дууны удирдаач байсан Профессор Ивен Стефанс ерөнхий чуулганы нэг хэсэг дээр найрал дуу удирдаад дуусчээ. Тэр чимээгүйхэн суудалдаа очиж суугаад бага зэрэг урагш бөхийн баяртайгаар Ерөнхийлөгч Иосеф Ф.Смитийн захиас өгөхийг хүлээв. Тэр бошиглогчийн дэлхийн шахалттай тулгарах ба тэд сайн мэдээний зааж буй зүйлд үнэнч байхын чухлын талаар залуучуудад өгсөн номлолд баярлаж суув. Чуулганы дараа профессор Стефанс Солт Лэйк Ситийн захад орших Крик Канионоор Ерөнхийлөгчийн урам хайрласан үгсийг эргэцүүлэн ганцаараа салхинд алхаж байв. Тэр доороос нь хүчтэй даралтаар оргилон гарах усны дээр хөдөлгөөнгүй байрлах чулуун дээр суув. Чулуу түүнд өглөөний сонссон зүйлийн бэлэгдэл мэт санагдав. Гэнэт Сүмийнхний дуртай дууллын нэг болсон дууллын үг хөгжим түүний толгойд орж ирэв. Чулуун дээр сууж байхдаа тэр “True to the Faith” (Hymns, no.254) дууллын үг хөгжмийн нооргийг бичив. Тэр яг бошиглогчтой адил залуучуудад хайртай байсан ба энэ дуу бол түүний тэдэнд өгөх сүнслэг зөвлөмж юм хэмээн хэлжээ (J. Spencer Cornwall, *Stories of Our Mormon Hymns* [Salt Lake City: Deseret Book Co., 1961], pp. 172-74-ийг үз).

Дуулал ба ярилцлага

Залуу эрэгтэй бүрт дууллын ном өгч “True to the Faith” (Hymns, no. 254) ыг олуул. Залуу эрэгтэйчүүдээс ээлжээр дөрвөн мөрийг уншаад дуулахыг хүс.

- Бошиглогчийн ямар захиасыг Стефанс ах энэ дуулалдаа оруулахыг хичээсэн бэ?

Зурагнууд ба судрын түүх

Цаг хугацааны эхнээс аваад эрэгтэй эмэгтэй хүмүүс тэдний эргэн тойронд байгаа шударга бус дэлхийн шахалтын дунд зөв шударгаар амьдрахыг сонгох гайхамшигтай зоригийг харуулж байсан гэдгийг хэл. Судрын сонгодог жишээ бол Хуучин Гэрээний Даниел юм.

Залуу эрэгтэйчүүдээс Хуучин гэрээнээс Даниелын номыг гаргахыг хүс.

Даниелыг бага байхад нь хачин соёл, хачин хэл, хачин орчин, хачин шашинтай газар авчирсан гэдгийг тайлбарла. Бабилонд авчирсан хүмүүсийг хаан сайн дарснаасаа ууж, элбэг дэлбэг хоолноос нь идэх ёстой болоход түүний анхны шалгуур иржээ. Даниел Их Эзэний зарлигуудыг мэддэг ойлгодог байсан. Түүнд эдгээр зүйлсийг идэх нь буруу ба Бурханы зарлигуудыг сахь хэмээн заасан байжээ (Хааны хоолыг эсэргүүцэж байгаа Даниелийн зургийг үзүүл). Даниел хааны зарцаас найзуудтайгаа хамт Их Эзэний эрүүл мэндийн хуулийг сахихыг зөвшөөрөхийг гуйжээ. Зарц арван өдөр юу болохыг нь шалгахаар зөвшөөрчээ.

- Даниелийн хоол сойсны үр дүн юу байсан бэ (Даниел 1:15 г үз)?
- Даниел ба түүний найзуудыг итгэлтэй байж эрүүл мэндийн хуулийг сахисны төлөө Бурхан тэднийг хэрхэн адисласан бэ (Даниел 1:17 г үз)?

Небухаднезар хаан зүүд зүүдлэхэд түүнийг тайлах өөр нэг шалгуур иржээ. Хаанд ордны нэг ч шидтэнүүд болон зурхайчид түүний зүүдний учрыг хэлж чадсангүй. Энэ нь хааныг уурлуулж тэр Вавилоны бүх ухаантай хүмүүс ба Даниелыг оролцуулан бүгдийг нь алахыг тушаав.

- Хааны хийх гэж төлөвлөж буй зүйлийг сонсоод Даниел юу хийсэн бэ (Даниел 2:16 г үз)?
- Хааны зүүдтэй холбоотой хэрэгтэй байсан хариулыг Даниел хэрхэн хүлээж авсан бэ (Даниел 2:17–20-ийг үз)?
- Даниел, хааны зүүдний тайллыг түүнд хэлсний дараа хаан яасан бэ? Даниелын шагнал юу байсан бэ? (Даниел 2:46–47-г үз)

Даниелд өөр шалгуур ирлээ. Түүнд хааны хүндтэй хэргэм цолыг өгчээ. Түүнийг хааны хун тайж нарын ахлагчаар томилсон ба тэд бүгд түүнд атаархаж байв. Тэд түүнийг ямар нэг буруу зүйл хийхийг нь хүлээн ажиглаж, хэрэв тэгвэл хааны өмнө буруутгах байв. Тэд юу ч олоогүй болохоор өөр хуйвалдаан бодож олов. Муу санаат хун тайж нар хаант улс дотор гуч хоногийн дотор хэнийг ч залбирахыг зөвшөөрөхгүй байх шинэ хуулийг хаанд танилцуулжээ. Үүнд хүмүүс зөвхөн хааныг магтах ёстой гэж заажээ. Хаанд тэр сайхан санаа мэт санагдаж тэр хуулийг зөрчсөн хүн шийтгэгдэх болно гэж зарлиг болгов. Даниел энэ шинэ хуулийг сонсоод маш ихээр санаа зовов, учир нь Бурханд залбирах нь түүнд маш чухал байв.

- Энэ хуулийг зөрчих нь ямар шийтгэлтэй вэ? (Даниел 6:7-г үз)
- Хэдий гаргасан хууль ба шийтгэлийг нь мэдсэн ч Даниел юу хийсэн бэ? (Даниел 6:10-ыг үз)

Даниелд атаархсан хүмүүс түүнийг гэрт нь тагнаж залбирч байхыг нь хараад хаанд хэлжээ. Хаан Даниелд хайртай байсан ба санаа муутай хун тайж нар түүгээр аюултай заль мэх хэрэглэснийг ойлгожээ. Тэр Даниелыг арслангаас аврахын тулд хуулийг өөрчлөх гэсэн боловч хун тайж нар хаанд ямар ч хуулиа өөрчилж болохгүй гэснийг нь сануулав.

- Тэд Даниелыг арслангийн үүр рүү шидэхэд нь хаан юу хэлсэн бэ? (Даниел 6:16-г үз)
- Арслангийн үүрэн дотор буй Даниелын зургийг үзүүл.

Даниел хааны өмнө агуу жишээг үзүүлсэн. Даниелын Бурхан түүнийг арслангийн үүрнээс аварна гэдэгт хаан итгэж байсан. Хаан бүхэл шөнөжингөө Даниелын төлөө мацаг барьсан ба өглөө нь үүр рүү яаравчлан очоод түүнийг дуудаж хашгирсан.

- Хаан Даниелээс юу асуусан бэ? (Даниел 6:20-ийг үз) Даниел юу гэж хариулсан бэ? (Даниел 6:22-ыг үз)
- Энэ гайхамшиг болон Даниелын Бурхандаа үнэнч байсны гэрчлэлийн дараа хаан ямар зарлиг гаргасан бэ? (Даниел 6:26–27-г үз)
- Хэрэв та нар Даниелтэй адил шахалтанд байсан бол юу хийх вэ?
- Даниелын жишээнээс бид юу сурч болох вэ?
- Өнөөдөр залуу эрэгтэй Бурханы зарлигуудыг сахихгүй байх шахалтанд хэрхэн орж болох вэ?

Залуу эрэгтэйчүүдээс өөрсдийнхөө амлалтуудыг Даниелын амлалттай харьцуулахыг хүс. Даниел зөв шударгаар амьдрахыг сонгосноор бүхэл бүтэн хаант улсад үзүүлсэн гайхамшигт нөлөөг онцолж хэл.

Өнөөдөр биднийг итгэдэг зүйлээ хамгаалсны төлөө өлсгөлөн арслангийн үүр рүү чулуудахгүй боловч үүний адил чухал шийдвэрүүд ба үр дагавруудад бид янз бүрээр соригдох болно гэдгийг хэл. Олон залуу эрэгтэйчүүд өнгөрсөн үед болон одоо үед дэлхийн шахалтуудыг даван туулсаар байгаа ба зөв зохистой үйлс хийсээр байгаа.

Түүх ба ярилцлага

Дараах түүх дэлхийн шахалтыг давж гарсан жишээ үзүүлдэг.

“Намайг хамгийн их зоригжуулсан, урам хайрласан тохиолдлын нэг бол өөрсдийгөө үнэхээр олж, ямар хүн болох шийдвэр гаргасан, нийгмийн шахалтыг даван гарах зоригтой, Бурханы хүсэлд нийцэх хүүхэд гэдгээ үзүүлдэг залуу эрэгтэй эмэгтэй хүмүүстэй уулзах явдал юм. Ийм залуу хүмүүстэй уулзах нь миний гэрчлэлийг хүчтэй болгож итгэл болон ирээдүйд итгэх итгэлийг минь нэмэгдүүлдэг.

“Нэг удаа би Шотландад байрлалтай атомын шумбагч онгоцны багийн гишүүн залуу усан цэрэгтэй уулзсан юм. Тэр баг дотроо ганцаараа Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн байсан юм. Шумбагч онгоц олон долоон хоногийн сунгасан аялалд тойргоор явах байв. Энэ залуу Сүмийн гишүүн анхныхаа аялалд томилогдсон ба багийн бусад гишүүд нь ханан дээрээ эмэгтэйчүүдийн зохисгүй зурагнууд наасан байхыг харав. Энэ нь түүнийг сэтгэлээр унагав. Тэр бүх зургнуудыг хуулж аваад устгав. Тэр бусад хүмүүсээс ирэх хариултыг уамсарлаж байсан боловч тэр хийх ёстой зүйлээ хийх зоригтой байв. Нэг ч зураг дахиж наагдсангүй. Үнэнийг хэлэхэд тэр эхний аялалд өөр хоёр гурван хүн оролцсон Ням гаригийн хичээл заав. Ерөнхийд нь хэлэхэд, тэрээр зөв гэж бодсоноо хийхээс айдаггүй хүнийг бусад нь хүндэлдэг гэсэн чухал сургамж сурав.

“Өөр нэг удаа би 14 настай гайхалтай теннисчин залуу эрэгтэйтэй уулзсан юм. Тэр хэд хэдэн муж оролцсон бүсийн тэмцээнд өөрийнхөө төрөлд түрүүлсэн байна. Тэр хамгийн чухал хагас шигшээ тэмцээнд оролцохоор нэлээд зайтай хотод очих болов. Тэнд хүрч очсоныхоо дараа тэр ням гаригт тоглохоор хуваарилагдсанаа олж мэдэв. Тэр зохион байгуулагчид дээр нь очоод тэдэнд Ням гаригт тоглодоггүй гэдгээ хэлэхэд, түүнд хэрэв тэр энэ тэмцээнд тоглохыг хүсвэл Ням гаригт тоглох ёстой гэдгийг мэдэгджээ. Тэр тэмцээнд оролцох эрхээ алдана гэдгээ мэдсэн ч дахиад Ням гаригт тоглохгүй гэдгээ хэлэв. Тэгснээр тэмцээн Ням гаригаас хойшлов. Тэр Даваа гаригт тоглоод хожив.

“Тэгээд тэр бас нэг өөр том хот руу Нэгдсэн Улсын бүх Атлантын далайн эрэг орчмыг хамарсан аваргын төлөө шигшээ тэмцээнд өрсөлдөхөөр автобусаар явав. Тэд Ням гаригт ирэв. Дасгалжуулагч ирсэн дороо бүх оролцогчид теннисний талбай дээр очиж бэлтгэл хийхийг хэлсэн байна. Энэ залуу эрэгтэй теннисний талбай руу яваагүй байна. Дасгалжуулагч түүнээс яагаад бэлтгэл хийхгүй байна гэхэд тэр, ‘Би теннис Ням гаригт тоглодоггүй,’ гэж хариулжээ. Дасгалжуулагч яагаад гэж асуув. Тэр, ‘Би Мормон,’ гэж хариулжээ.

“Тэрээр аваргын төлөө тэмцээнд өөрийнхөө насны бүлэгт ялахыг юунаас ч илүү хүсэж байсан боловч Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих нь теннисний аварга болохоос илүү чухал гэж шийдсэн байна. Тэр өөрийгөө таньж, заалгасан зарчмуудынхаа дагуу амьдрах зориг, зарчимч байдалтай байж, нийгмийн шахалтаас хамаарахгүйгээр шийдвэр гаргасныг та нар харж байгаа байх” (Victor L. Brown, “A Light on a Hill,” New Era, Sept. 1980, p. 4).

- Усан цэрэг ба теннисчин хоёрын хувьд итгэл шүтлэг нь тийм их яагаад чухал байсан гэж та нар бодож байна вэ?
- Тэдний хийсэн зүйлийг хийхэд хэр зэрэг хэцүү байсан гэж та нар бодож байна вэ?
- Итгэлийнхээ төлөө зогссоноор та нар хэрхэн адислагдсан бэ?

Зөв Шударгаар Амьдрах Тусламжийг Эрэх

Самбар ба ярилцлага

Түүхэнд гарч байгаа Даниел болон энэ хоёр залуу эрэгтэй зөв шударгаар амьдрахыг сонгосноор тусламжгүй үлдээгүйтэй бид ч бас адилхан байх болно гэдгийг тайлбарла. Их Эзэн бид бүгдийг хайрлаж, биднийг амжилт гаргахыг хүсдэг бөгөөд тусламжгүй амь тэмцүүлэн үлдээдэггүй. Хэдий тийм ч тэр биднээс туршлагаасаа суралцаж, зөв шударгаар амьдрах зоригтой, мэдлэгтэй болохыг хүсдэг.

- Биднийг зөв шударгаар амьдрахад туслан Тэнгэрлэг Эцэг тусламжийн ямар эх сурвалжийг өгсөн бэ?

Самбарт залуу эрэгтэйчүүдийн хариултыг жагсааж бич. Зарим хариултанд залбирал, эцэг эх болон бусад гэр бүлийн гишүүд, Ариун Сүнс, судрууд, пристийн зэрэг ба Сүмийн удирдагч нар, сайн найзууд зэрэг багтаж болно.

- Бид зөв шударгаар амьдрахын тулд эдгээр эх сурвалжуудыг янз бүрийн нөхцөлүүдэд хэрхэн ашиглаж болох вэ?

Залуу эрэгтэйчүүдээс дэлхийн шахалтын дунд зөв шударгаар амьдрахаар оролдож байсан тохиолдлоос хуваалцуул.

Дүгнэлт

Гэрчлэл

Дэлхийн ихэвчлэн зурдаг баргар зургийг үл харгалзан бидний дунд орчин үеийн Даниелууд олон байдаг гэдгийг гэрчил. Бид ч мөн Даниелтай адил эргэн тойрондоо байгаа шахалтын дунд Тэнгэрлэг Эцэг маань үргэлж биднийг дэмжиж адислаж байдаг гэдгийг мэдэн зөв шударгаар амьдарч чадна. Бид итгэлдээ үнэнч, хазайхгүй байж чадна.

Дуулал

“True to the Faith” дууллыг дуулах буюу дахин унш.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр ёс суртахууны зоригийг хөгжүүлэх болно.

БЭЛТГЭЛ

- Шаардагдах материалууд:
 - Залуу эрэгтэй бүрт судар.
 - Судар тэмдэглэх харандаа.
- Түүх ба Нөхцлийн судалгаануудыг анхааралтай унш, тэгээд залуу эрэгтэйчүүдэд ярьж өгвөл зүгээр уншсанаас илүү үр дүнтэй байх болно.
- Энэ хичээлд багтсан материалуудаас гадна та нар ёс суртахууны зоригийн тухай дараах судрын ишлэлүүдээс нэг буюу түүнээс илүүг ашиглаж болно: Давид (1 Самуел 17); Шадрах, Мешах, Абед-него (Даниел 3); Иосеф Смит (ИС-Т: 1–1-25).
- Зураг 8, Дэвид Голиатыг Алсан нь, зураг 9, Галтай Зуухан Доторх Гурван Хүн (112 ба116, Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга, [34730]).

ТАЙЛБАР

Энэ хичээл дээр бие бялдрын зориг болон ёс суртахууны зориг хоёрын хоорондох ялгааг товч тоймлон үзэх болно. Мөн залуу эрэгтэйчүүдийг зоригжуулснаар тэд сайн мэдээний жишигт нийцсэн хувийн жишгийг тогтоож түүнийгээ ажил хэрэг болгох болно.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Ёс Суртахууны Зоригийг Хөгжүүлснээр Бид Амьдралын Шалгууруудтай Илүү Сайнаар Тулгарч Чадна

Түүх

“Нэг өдөр залуу цэрэг харуулд гарч байв. Түүний зайлсхийдэг хараалч дэслэгч түүн дээр ирэв. Шинэ цэрэг сүүлд нь оюун ухаанаа цэвэрлэх хэрэгтэй болох зуршил болсон хараалын үгээр бөмбөгдүүлэхэд өөрийгөө бэлтгэв. Дэслэгч үүний оронд, ‘Чи Мормон, тийм үү?’ гэж хэлэв. Шинэ цэрэг гайхан баталж толгой дохин, ‘Би та нарын тухай юу гэж боддогийг чи мэдэх үү? Та нар ямар ч үед сайнаараа байдаг’ гэж хэлэхийг сонсоод тэр балмагджээ” (Douglas D. Alder, “Swimming Upstream,” New Era, July 1977, p.19).

- Дэслэгч ямар утгатай зүйл хэлсэн гэж та нар бодож байна вэ?

Самбар ба ярилцлага

Самбарт *Зориг* гэж бич.

- Зориг гэж юу вэ? (Аюул тулгарсан үед сайн дураараа үйлдэл хийх зүрх сэтгэл ба оюун санааны чанар.)

Самбар дээрх зориг гэж бичсэний урд *ёс суртахуун* гэж бич.

- Ёс суртахууны зориг гэж юу вэ?

Ёс суртахууны зориг гэдэг нь үргэлж зөвийг хийхэд бэлэн байх онцгой төрлийн зориг гэдгийг залуу эрэгтэйчүүдэд ойлгуул.

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр Мозая 18:9-ийг уншуулж, тэмдэглүүл.

- Хаана ч, хэзээ ч Бурханы гэрч байна гэдэг нь юу гэсэн утгатай вэ?
- Ёс суртахууны зоригтой байх нь үүнд заримдаа яагаад шаардлагатай байдаг вэ?

Бие бялдрын зоригтой үйлдэл нь ихэнхдээ алдар суу амжилт авчирдаг гэдгийг хэл. Ёс суртахууны зоригтой үйлдэл нь үргэлж алдар суу амжилт авчирдаггүй.

- Ямар шалтгааны улмаас ёс суртахууны зоригтой байдал нь доромжлол шахалт хавчилтыг авчирч болох вэ?

Ишлэл

Дараах мэдэгдлийг хуваалц:

“Сургуулийн талбар дээр нэг залуу хүү сайн үйлсийн хүчтэй нөлөө үзүүлж чадна. Нэг залуу эрэгтэй Сайн мэдээгээр амьдарч пристийн зэргээ дээдэлж зөв шударгын төлөө зогссоноороо хөл бөмбөгийн багт болон сургуулийн хотхонд, мөн хамт ажиллагсдынхаа дунд гайхамшигтай сайныг хийдэг. Тэр бүү хэл та нарын хийж буйд итгэдэг хүмүүс ч, та нарын зөвийг хийж буйд хүндэлдэг хүмүүс ч гэсэн та нарыг шүүмжилж, тохуурхахыг та нар олонтаа харах болно. Гэвч Аврагч Өөрөө итгэлдээ гуйвалтгүй байснаасаа болж шийтгэгдэж, тохуурхагдаж, нулимуулаад, эцэст нь цовдлогдсон гэдгийг санагтун. Та нар түүнийг сульдаж, “Энэ ер нь ямар хэрэгтэй юм бэ?” гээд үүргээсээ няцсан бол яах байсан бол гэж бодож байсан уу? Бид үүргээ умартагч болохыг хүсэх үү, аль эсвэл дэлхий дээрх бүх муу зүйл болон нүгэл хилэнцийг үл харгалзан шийдэмгий үйлчлэгчид болохыг хүсэх үү? Бүгдээрээ босож, Христийн үнэнч, шударга дагагчид гэж тооцогдох зоригтой байцгаая” (N. Eldon Tanner, Conference Report, Oct. 1975, p. 113; or Ensign, Nov. 1975, pp.74-75).

Нөхцлийн судалгаа

Дараах нөхцөлийн судалгааг уншаад ярилц.

Нөхцлийн судалгаа 1

Хэсэг хөвгүүд зааланд, үдийн хоолны цаг дуусах хонх дуугарахыг хүлээн хоорондоо ярилцаж байв. Өөр нэг хүү тэдэн дээр очив. Инээж, эргэн тойрноо харснаа “Надад хэлэх балиар онигоо байна. Эмэгтэйчүүд энд байна уу?” гэж хэлэв.

- Та нар ийм нөхцөлд яах вэ?

Нөхцлийн судалгаа 2

Кен сургуулийнхаа номын санд нэлээд хэдэн цаг сууж байна. Тэр маш их ядарч бас санаа зовж байв. Тэр материалаа сайн ойлгоогүй ба маргааш сүүлчийн шалгалт нь болох байв.

Хэдэн хөвгүүн хүрч ирэн түүнтэй нэг ширээнд сууцгаав. Рэй Кен рүү инээмсэглээд “Хөөе, найз аа сайн мэдээтэй. Надад маргаашийн шалгалтын таван асуултын гурав нь байна. Би үүнийг яг тестнээс нь авчихсан. Би эднийг багшийг өрөөндөө ороход нь ширээн дээр байхад нь харсан юм. За май би чамд нэгийг өгье,” гэж хэлэв.

- Иймэрхүү нөхцөлд ёс суртахууны зориг яагаад шаардагдах вэ?
- Ийм байдалд Кен юу хийх ёстой вэ?

Нөхцлийн судалгаа 3

Паул хоёр найзтайгаа киноны дараалалд зогсож байна. Театр үргэлж гэр бүлийн холбогдолтой кино үзүүлдэг тул тэр болгоомжилсонгүй. Тасалбар түгээх цонхонд ойртож иртэл тэр киноны ангилал нь пристийн зэрэгтэн хүн үзэхэд зохимжгүй болохыг олж мэдэв.

- Паул маш чухал шийдвэр гаргах боллоо. Тэр юу хийх ёстой вэ?

Ишлэл

Дараах ишлэлийг унш:

“Жинхэнэ шийдэмгий пристийн зэрэгтнийг олж мэдэхэд хэцүү биш гэдгийг та нар мэднэ. Та нар тийм хүнтэй хаана ч тааралдана. Бусад нь ням гаригт кино үзье гэхэд үгүй гэдэг бөгөөд ёс суртахуунгүй үзвэрийг бол хэзээ ч үгүй гэх нэгэн байдаг (ийм уруу таталтанд орохгүй байх ёстой гэдгийг тэр мэддэг). Тэрээр ямар ч үед ёс суртахуунгүй ном сэтгүүл, зураг, түүх үздэггүй нэгэн. Тэрээр ням гаригт загасанд явдаггүй, усанд сэлдэггүй, завиар явдаггүй нэгэн байдаг. Хэдий ганцхан удаа үз л дээ гэж бусад нь хэлсэн ч тамхи, пивийг хэзээд эсэргүүцдэг нэгэн байдаг. Энэ зоригт дайчин Ням гарагийн өглөөний пристийн зэрэгтний цуглаан, ариун ёслолын цуглаан, аравны нэгээ төлөх, өдөр бүрийн залбирал, институт, семинарын хичээлийг бусад нь үгүй гэхэд ганцаараа тийм хэмээн хэлэх нэгэн байдаг. Бусад нь номлолд явахгүй гэхэд ганцаараа явна гэж хэлэх тэр няцашгүй нэгэн залуу эрэгтэй юм” (H. Burke Peterson, in Conference Report, Oct. 1974, p. 97; or Ensign, Nov. 1974, pp. 68-69).

Ёс суртахууны зориг шаардсан зөв шийдвэр гаргаснаар тэд илүү аз жаргалтай, илүү сайн сайхан амьдрах болно гэдгийг залуу эрэгтэйчүүдэд сануул.

Ёс Суртахууны Зоригийг Хөгжүүлсэн Хүмүүс Есүс Христийн Сайн Мэдээгээр Амьдарч Түүнийг Хамгаалдаг

Зөвлөхийн
танилцуулга

Дараах түүхийг ярь:

A Man for All Seasons жүжигт Томас Моорын ёс суртахууны эр зоригийг маш хүчтэй дүрсэлсэн байдаг. Моороос Английн 8-р Хенри хаан өөрийнхөө хийсэн үйлдлийг зөвшөөрсөн тангараг өгөхийг хүсдэг. Гэвч хааны хийсэн үйлдэл буруу гэдэгт Моор итгэж байсан. Тангараг авахын тулд хаан Моорд маш их шахалт үзүүлдэг. Түүнээс газар нутаг, эрх мэдлийг нь авав. Тэгээд түүнийг шүүж шоронд хорьжээ. Эцэст нь тэр өөрийнхөө итгэж буй зүйлийнхээ эсрэг явахгүй байсан учир түүнийг алсан байна.

Моорын болон хийсэн зүйлийг нь олон хүмүүс биширч байсан гэдгийг хаан мэдэж байв. Хаан хүртэл түүнийг үнэхээр үхүүлэхийг хүсээгүй. Хенри хаан Моорын бодол санааг өөрчлөхөөр сүүлчийн оролдлого болгон түүний эхнэр болон охин Мэгийг уулзуулахаар шорон руу явуулав.

Амиа аврахын тулд тангараг өгөхийг тэд түүнээс гуйв. Тэр охиндоо үргэлж Бурхан амаар ярьсныг бус зүрх сэтгэлийг үнэлдэг хэмээн сургасан болохыг Моорын охин түүнд сануулав. Тэгээд “Тангаргийн үгийг хэлээд зүрх сэтгэлдээ өөрийг бодооч,” хэмээн түүнээс гуйв.

Моор, “Гэвч тангараг болон Бурханд хэлэх үг нь ямар ялгаатай вэ?” хэмээн хариулаад, “Хүн тангараг өргөхдөө, Мэг, тэр өөрийгөө алгандаа тогтоож барьдаг юм. Яг ус шиг. Хэрэв тэр хуруунуудаа хөдөлгөх л юм бол түүнд өөрийгөө дахин олох гэсэн найдвар хэрэггүй болно” (Robert Bolt, *A Man for All Seasons* [New York: Random House, 1960], p. 140).

Моор өөрийнхөө итгэж буй зүйлийнхээ эсрэг байхыг хүсээгүй учир эцэст нь тэр алагджээ.

Ишлэл

Нэг удаа бошиглогч Иосеф Смит болон хэсэг ах нар Миссурийн Ричмондын шоронд хоригдож байсныг хэл. Тэд шоронд их удаан байжээ. Нэгэн орой харуулууд Сүмийн гишүүдийн тухай хэрцгий, муухай харьцдаг тухайгаа онгирон ярьж байгааг Иосеф Смит сонсжээ.

Залуу эрэгтэйчүүдээс сайхан уншдаг нэгнээр Ахлагч Парли П. Праттын энэ тухай тэмдэглэснийг нь уншуул:

“Гэнэт тэр босож ирээд хүнгэнэсэн дуугаар буюу архирах арслан адилаар, миний санахаар дараах үгсийг хэлсэн юм.

“**ЧИМЭЭГҮЙ**, *тамын эрлэгүүд ээ*. Есүс Христийн нэрээр би та нарт болихыг сануулж, тушааж байна. Ингэж ярихыг сонсож би дахин нэг минут ч амьдрахгүй. Ингэж ярихаа зогсоо, үгүй бол ЭНЭ МӨЧИД би эсвэл та нар үхэх болно.

“Тэр ярихаа болив. Тэр цэх шулуунаар маш сүр жавхлантай зогсож байв. Гинжлэгдсэн, зэвсэггүй, дуугүй бөгөөд тэнгэрийн элч шиг өргөмжлөгдсөн тэр зэвсгээ газарт буулгасан буюу унагаж өвдөг нь чичирсэн буланд шигдсэн бөгөөд хөл нь атийж уучлалт гуйсан айсан харуулуудыг харан зогсож байсан бөгөөд харуул солигдтол тэр чимээгүй байлаа” (Autobiography of Parley P. Pratt [Salt Lake City: Deseret Book Co., 1938], p. 211).

Ишлэл

Далын гишүүн Ахлагч Дийн Л. Ларсени пристийн зэрэгтэн хүнээс ямар зан төлөв шаарддаг тухай дараах мэдэгдлийг таны уншихыг сонсохыг залуу эрэгтэйчүүдээс хүс.

“Зөвийг мэдэж үүнийг сайн гэдэгт итгэх нь хангалттай биш юм. Бид түүний төлөө зогсож, тоологдоход бэлэн байх ёстой. Ямар ч нөхцөлд бид үйлдлээ итгэдэг зүйлийнхээ дагуу хийхэд бэлэн байх ёстой. Хэрэв бид хувийн үйлс болон нийтийн ажилд итгэдэг зүйлийнхээ эсрэг зүйлийг хийдэг бол бидний итгэл ямар ч үнэ цэнэгүй юм” (in Conference Refort, Oct. 1978, p. 49; or Ensign, Nov. 1978, pp. 34-35).

Ёс суртахууны зоригийн жинхэнэ түлхүүр бол “ямар ч нөхцөлд” гэдгийг онцлон тэмдэглэ.

Ишлэлийн үргэлжлэл:

“Өнөөдөр үнэнч Хожмын Үеийн Гэгээнтэн байхад агуу их зориг шаарддаг. Олон хүмүүст энэ нь амархан биш бөгөөд амар биш байх болно. Өнөөдрийн шалгуурууд маш хүнд. Энэ нь ялангуяа манай Аароны пристийн зэрэгтэн залуу эрэгтэйчүүдийн хувьд тийм юм. Их Эзэний бидэнд өгсөн амьдрах байдалд үнэнч байх нь биднийг үргэлж олон нийтийн өмнө баатар болгодоггүй. Хэдий тийм ч үзэл бодолдоо зоригтой байх нь бидэнд шагнал болдог. Германы 13 настай хүү Армин Сүков үүнийг харуулсан юм. *Тэрээр New Era* сэтгүүлд нэгэн сонирхолтой явдлыг бичиж ирүүлсэн. Армин, ‘Би зул сарын баярын үеэр сургуулийнхаа нэг багштай Есүсийн тухай ярьж байсан юм. Есүс нас барсныхаа дараа дэлхийгээс явсан бөгөөд одоо тэр үхсэн гэж тэр хэлсэн юм. Багшийг ярьж байхад би өөрийнхөө сүмийн тухай бодож, Есүс гурав хоногийн дараа дахин амилсныг нь олон хүмүүс харсан бөгөөд дараа нь, тэр тэнгэр рүү явсан гэдгийг мэдэж байлаа. Багш болон оюутнуудад үнэн нь багшийн хэлснээс хамаагүй өөр гэдгийг хэлэх ёстой гэсэн сэтгэгдэл надад төрөв. Багш миний хэлснийг сонсохыг хүсэхгүй байсан ч би үүнийг тоолгүй тэдэнд Есүс дахин амилсан гэж хэлсэн. Би түүний хэлснийг зассан нь багшид таалагдаагүй боловч үргэлжлүүлсэн билээ. Тэгээд тэр энэ бол зүгээр л нэг санаагаа хэлж байгаа явдал гэж хэлэв. Энэ болсон явдлыг хэн ч судраас уншиж чадах бөгөөд хэн ч миний хэлснээс өөр түүх бодож дүрсэлж чадахгүй гэдгийг тод дүрсэлсэн хэмээн би түүнд хэлсэн юм. Хичээл тарсны дараа багш миний аль сүмд явдгийг мэдэхийг хүсэв. Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд явдаг гэж түүнд хэсэн юм. Тэр өдөр миний дотор үнэхээр сайхан мэдрэмж төрж билээ” (“The Savior Lives!” *New Era*, Dec. 1977, p. 18)” (in Conference Report, Oct. 1978, p. 49; or *Ensign*, Nov. 1978, pp. 34-35).

Дүгнэлт

Уриалга

Энэ хичээл дээр гарсан ёс суртахууны зоригийн тухай нэг жишээг түүх болон Нөхцөлийн судалгаанаас сонгож аваад тэр төрлийн ёс суртахууны зоригийг өөрийнхөө амьдралд хэрэгжүүлэхийг залуу эрэгтэйчүүдэд уриал.

Уруу Таталтаас Зайлсхийх ба Даван Туулах

40

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр уруу таталтаас хэрхэн зайлсхийх мөн үүнийг хэрхэн даван туулж чадахыг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардлагатай материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаа.
2. Хэрэв танай бүст *Family Home Evening Video Supplement 2* (53277) байгаа бол “Сорилт” гэсэн 10-р хэсгийг үзүүл.

ТАЙЛБАР

Залуу хүмүүст хүчтэй уруу таталтыг эсэргүүцэх чадалгүй байгаа мэт санагдаж болно. Гэвч Их Эзэний тусламжтайгаар зөвийг сонгож чадна. Тэр Сатаныг ялж чадна. Мөн тэр уруу таталтыг даван туулж чадна. Мэдээж одоо уруу таталттай тулгарахаас өмнө шийдвэр гаргах нь хамгийн сайн үе юм. Залуу хүмүүст уруу таталтаас зайлсхийж, эсэргүүцэхийг сурахад нь тусал.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Түүх ба ярилцлага

Оршил

Ахлагч Бойд К.Пакер Африкт болсон явдлын талаар дурсан ярьсан:

“Бид устай нүхний дэргэд зогсоод амьтдыг ирж ус уухыг ажиглаж байв. Энэ үе нь маш хуурай улирал байсан учир бараг усгүй байсан ба үнэндээ зүгээр л шавартай хэсэг байсан юм. Заануудыг зөөлөн шавар дээгүүр явахад үүссэн хонхорт нь ус шүүрч тэгээд зааны гаргасан мөрнөөс амьтад ус ууж байв.

“Ялангуяа гөрөөснүүд маш их сандарч байв. Тэд шавартай нүхэнд хүрч очингуутаа маш их айн зугтаж байв. Би ямар ч арслан байхыг хараагүй тул тэд яагаад ус уухгүй байгааг хөтчөөс асуулаа. Тэр, ‘Матар,’ гэж хариулав.

“Би түүнийг тоглож байгаа байх гэж бодоод, ‘Нээрэн юу болсон юм бэ?’ гэж асуухад Тэр дахиад л, ‘Матар,’ гэж хариулав.

“‘Үгүй байлгүй дээ, ямар ч матар тэнд алга байна шүү дээ,’ гэж би хэлэв. Хэн ч түүнийг харахгүй байна шүү дээ.’ . . .

“Зааны мөрөнд матар нуугдаж чадахгүй гэдгийг хэн ч мэднэ.

“Тэр намайг өөрт нь итгээгүйг мэдэж байсан ба надад хичээл зааж өгье гэж шийдсэн бололтой. Бид цааш өөр нэг шавартай нүхний дээрх овгор шороон дээр зогсоод доош харж болох байрлалд очив. ‘Тэр байна. өөрөө үз,’ гэж тэр хэлэв.

“Би холоос шавар, жаахан ус, сандарсан амьтаас өөр юу ч харж чадахгүй байв. Тэгээд гэнэт шавар дотор маш том матар түүний байгааг мэдээгүй цангасан амьтад ирж ус уухыг хүлээж байгааг олж харав.

“Гэнэт би итгэлээ. Намайг түүний ярьсныг сонсоход бэлэн байгааг тэр хараад хичээлээ цааш нь үргэлжлүүлэв. ‘Зөвхөн голд ч биш, энэ паркаар дүүрэн матар байдаг,’ бидэнд матар байхгүй ус гэж энэ хавьд байхгүй, чи үүнийг санаж байх нь зүйтэй” гэж тэр хэлэв (Conference Report, Apr. 1976, p. 45; or Ensign, May. 1976, pp. 30–31).

- Уруу таталт аль талаараа матартай адилхан бэ? (Тэр дандаа аюулгүй, дур татам, бүр байхгүй мэт дүрд хувирдаг. Гэвч хоёулаа биднийг хөнөөж чадна.)

- Хөтөч түүнд матар ойрхон байгаа гэж хэлэхэд Ахлагч Пакер ямар хандлагатай байсан бэ? (Итгээгүй. Тэр илүү мэдэж байгаа ба аюул байхгүй гэж мэднэ гэж бодож байсан.)
- Та нар урьд нь уруу таталтын талаар тийм бодолтой байсан уу?
- Яагаад тийм бодол аюултай вэ? (Энэ нь биднийг биеэ тоосон, анхаарал, болгоомжгүй хандахад хүргэнэ.)
- Бид “Сүнсэн матрууд” болох уруу таталтанд баригдахаас хэрхэн хол байж чадах вэ? (Бид уруу татагдахаас болгоомжилж, бидний мэдэх уруу татах газруудаас хол байж чадна. Мөн бид Их Эзэний бидэнд өгсөн заавруудыг сонсож чадна.)
- Биднийг “сүнсэн матруудаас” болгоомжлох заавруудыг Их Эзэн хэнд өгсөн бэ? (Бидний эцэг эх, багш нар, пристийн зэрэгтний удирдагч болон бошиглогчид.)

Ишлэлүүд ба ярилцлага

Уруу Таталтыг Эсэргүүцэх Хамгийн Сайн Арга бол Түүнээс Зайлсхийх

Сатаны тэр олон арга барил, зэмсгүүдийг мэдсэнээр Сатаны уруу таталтыг хэрхэн эсэргүүцэх вэ гэж бодож магадгүйг тайлбарла. *Бид хүчгүй биш*. Бошиглогч Иосеф Смитийн мэдэгдлийг хуваалц: “Бие махбодтой болгон нь бие махбодгүйг дийлэх хүчтэй. Хэрэв бид түүнд боломж олгохгүй бол муу ёрын сүнсэнд биднийг дийлэх хүч байхгүй” (*Theaching of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [Salt Lake City: Deseret Book Co., 1976], p. 181; italics added).

- Бид Сатаны хүчинд биднийг дийлэх боломж хэрхэн олгодог вэ? (Түүний уруу таталтыг сонсох ба өөрсдийгөө уруу татагдах нөхцөлд тавьснаар.)

Уруу таталтыг давах зарчмын чухлыг Далын гишүүн Ахлагч Хартман Ректор заасан:

“Би өөрийнхөө туршлагаас модны орой дээгүүр нисэх нь хэрхэн аюултай болохыг олж мэдсэн. Би хорин зургаан жил цэргийн онгоцоор ниссэн юм. Модны оройд хир ойрхон нисэхээ үзэх нь маш их сэтгэл хөдөлгөж байсан ба энэ нь маш их аюултай байсан юм. Модноос дөнгөж дээгүүр нисэж байх үед мотор чинь нэг л хүч алдах юм бол та нар модон дээр бууна.

“Одоо армид, ‘Та нар модон дээгүүр нисч болохгүй,’ гэсэн зарлиг гарлаа гэж бодье. Үнэндээ тэнд тийм зарлиг гарсан. Энэ зарлигаас чөлөөтэй болохын тулд надад өөрийнхөө ‘Та нар модноос дээгүүр 5000 метрээс доош нисч болохгүй’ гэсэн зарлигийг нэмэх хэрэгтэй болсон юм. Ингэснээр та нар модон дээгүүр нисэхгүй байх зарлигаар амьдрахад амархан болж, аюулгүй байдал чинь ихээр нэмэгдэнэ” (in Conference Report, Oct. 1972, p. 172; or Ensign, Jan. 1973, p. 131).

- Ахлагч Ректорын зөвлөснөөр Мэргэн Ухааны үгээр илүү амархан амьдрахын тулд та нар өөртөө ямар дүрмийг зохиож болох вэ? (Боломжтой хариултуудад сайн найзууд сонгох, хүмүүс архи ууж, мансууруулах бодис хэрэглэдэг үдэшлэгт явахгүй байх, та нар өөрсдөө нөхцөл байдал, идэх уух юмаа зохицуулж болох өөрийнхөө үдэшлэгийг хийх зэрэг багтаж болно.)
- Цэвэр ариун явдалтай байхын тулд та нар ямар дүрмүүд зохиож болох вэ? (Хариултанд зохистой бус кинонд явахгүй байх, порнографи хэзээ ч үзэхгүй байх, эсрэг хүйсний хүнтэй айлд ганцаараа орохгүй байх зэрэг багтаж болно.)

Урьднаас Чухал Шийдвэрүүдийг Гаргах нь Бидэнд Уруу Таталтыг Эсэргүүцэхэд Тусалдаг

Зөвлөхийн танилцуулга

Бид зөвхөн уруу татах нөхцөлөөс зайлсхийх ёстой биш мөн эртнээс хэрэв бид хэцүү нөхцөл байдалд орох юм бол хэрхэн уруу таталтыг эсэргүүцэхээ шийдэх ёстойг сануул. Бид уруу таталттай тулгарахаа хүлээх биш харин өмнө нь шийдвэр гаргах ёстой.

Ишлэл ба ярилцлага

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболлын дараах ишлэлийг хуваалц:

“Би жижигхэн хүү байхдаа багш нарынхаа ‘Бид архи уух ёсгүй, тамхи татах ёсгүй, цай юмуу кофе уух ёсгүй, Их Эзэн тэдгээрийг хориглосон’ гэхийг олонтаа сонссон билээ.

Тэгээд би ганцаараа үнээ саах юмуу өвс хурааж байхдаа боддог байв. Би үүнийг дотроо бодоод: 'Би, Спэнсэр Кимболл, архийг ямар ч байдлаар хэзээ ч амсахгүй. Би, Спэнсэр Кимболл, тамхинд хэзээ ч гар хүрэхгүй. Би хэзээ ч кофе юмуу цай уухгүй, Их Эзэн болохгүй гэснээс эсвэл надад болохгүй гэж зааснаас биш харин би өөрөө бодсон учраас' ийм шийдвэр гаргасан юм.

"Тэр бол миний хийх гэсэн зүйл. Би өөртөө жижигхэн хүү байхдаа, 'Би эдгээр зүйлсийг хэзээ ч амсахгүй,' гэсэн шийдвэр гаргасан юм. Тэгээд ийм шийдвэр гаргасан учир тэдгээрийг дагахад амархан байсан ба хэзээ ч бууж өгөөгүй юм. Маш олон уруу таталтуудтай тулгарч байсан боловч би хэзээ ч би үүнийг хийх үү болих уу гэж бодож байгаагүй. Харин би өөртөө, 'Би үүнийг хийхгүй гэж шийдчихсэн тиймээс үүнийг би хийхгүй' гэж хэлдэг байв" (in Conference Refort, Stockholm Sweden Area Conference 1974, p. 86).

- Хэрэв найзууд чинь та нарт тамхи татахыг санал болговол та нар яах вэ? Та нар тэр үед нь шийдэх үү, эсвэл Ерөнхийлөгч Кимболл шиг ямар ч үед Мэргэн Ухааны Үгийг сахина гэж шийдвэр гаргачихсан байх уу?
- Та нар уруу таталтаас шалтгаалахгүйгээр өөр ямар зарлигуудыг сахихаар шийдсэн бэ?
- Нэгэнт зохистой байж номлолд явна гэж шийдсэнээс гадна та нар өөр ямар шийдвэрүүд гаргасан бэ? (Мэргэн Ухааны Үгийг зөрчихгүй байх, Цэвэр ариун байх гэх мэт.)

Бурхан Биднийг Уруу Таталтаас Аварч Чадна

Судрууд, самбар,
ярилцлага

Уруу таталтыг бид өөрсдийнхөө хамгийн сайнаар эсэргүүцсэн ч заримдаа уруу татагдана гэдгийг тайлбарла.

1 Коринт 10:13-ыг залуу эрэгтэйчүүдээр уншуулж тэмдэглүүл.

- Энэ шүлгэнд хэлснээр бидэнд юу амлагдсан бэ? (Бурхан бидэнд үргэлж уруу таталтаас хол байх замыг зааж өгдөг. Энэ хол байх гэдэг нь мэдэлгүйгээр өөрийгөө уруу татагдах нөхцөлд аваачиж болно гэсэн утгатай. Бид уруу таталтыг эрж хайн, Их Эзэн биднийг хамгаалахыг хүлээх ёсгүй.)

Их Эзэн бидэнд үргэлж уруу таталтаас хол байх замыг зааж өгдөг боловч түүний замыг сонгох нь биднээс шалтгаална. Бид хол байх замыг сонгох ёстой.

Сургаал ба Гэрээ 31:12-ыг уншаад доогуур нь зур.

- Энэ судар бидэнд уруу таталттай тэмцэх ямар зөвлөгөө өгсөн бэ? (Үргэлж залбир. *Залбирал* гэж самбарт бич.)
- Уруу таталтыг даван туулахын тулд бид өөр ямар зүйлүүд хийж болох вэ? (Бид дууллууд аялах юмуу дуртай судраа цээжээр хэлэн муу бодлоо сайн бодлоор солиж болно. Хэрэв бидний орчин уруу татах нөхцөлтэй бол түүнийгээ өөрчилж болно. Жишээлбэл, бид телевизрээ унтрааж юмуу киноноос гараад явчихаж болно. Заримдаа бид найзууддаа утасдах юмуу эцэг эхтэйгээ ярилцах нь уруу таталттай ганцаараа тулгарахгүй байхад тусалдаг.)

- Уруу таталтыг эсэргүүцэхэд чинь та нарт юу тусалсан бэ?

Залуу эрэгтэйчүүдийн хариултыг самбарт бич.

Нөхцлийн судалгаа

Дараах нөхцөлийн судалгааг өөрийнхөө үгээр ярь.

Робертийн найзууд түүнийг шинэ кинонд явахыг урьжээ. Роберт тэр кинонд зарим муу хэсэг байгааг мэдэж байсан тул явах ёсгүй гэж шийджээ. Гэвч түүнийг үгүй гэхэд нь найзууд нь түүнийг шоолж, янз бүрээр нэрлэж байв. 'Хүн бүхэн тэр киног үзсэн, энэ чамд муу юм болохгүй,' гэж тэд хэлэв.

- Энэ нөхцөлд Роберт юу хийх ёстой вэ?

Эцэст нь Роберт тэдний ятгалганд орж явахаар болов. Дараагийн долоо хоногт Сүмд очиход нь болон түүнээс хойш Робертийн санаагүй байсан үед нь нөгөө киноны муу үгс болон дүр зургууд түүний бодолд орж ирээд байв. Тэр үүнийг

бодохыг оролдоогүй, бодохыг ч хүсээгүй боловч үүнийг толгойноосоо гаргаж хаяхад хэцүү байв.

- Роберт муу ёрын сүнсний хүч түүнийг ялахыг хэрхэн зөвшөөрсөн бэ? (Найз нарынхаа маргааныг сонссоноор өөрийгөө буулт хийх нөхцөлд оруулсан.)
- Үр дүнд нь юу болсон бэ?
- Тэр киног үзсэн л бол толгойноосоо тэр муу дүрсийг хэрхэн авч хаяж чадах вэ?
- Тэр уруу таталтаас хэрхэн зайлсхийж чадах байсан бэ?

Дүгнэлт

Ишлэл

Бид уруу таталтанд орох ёсгүй. Ерөнхийлөгч Дэвид О.МакКэй ийн хэлсэн:

“Пристийн Зэрэгтэн ах нарт би энэ зөвлөмжийг өгмөөр байна. Сатан та нарыг уруу татахыг оролдож та нарыг дийлэх гэж оролдох тал нь та нарын хамгийн сул тал байх болно. Тэгээд та нарыг Их Эзэнд үйлчлэх амлалт авахаас чинь өмнө, хэрэв та нар сул талаа султгавал тэр түүн дээр чинь нэмэх болно. Түүнийг эсэргүүц тэгвэл та нар хүчтэй болно. Тэр та нарыг өөр сул тал дээр чинь уруу татах болно. Түүнийг эсэргүүцвэл тэр улам хүчгүй болж та нар та нарын эргэн тойронд юу ч болж байсан ‘ Сатан надаас зайл, учир нь сударт бичсэнчлэн ‘өөрийн Бурхан Их Эзэнээ шүтэж зөвхөн Түүнд үйлчил’ гэж хэлж чадах хүртлээ хүчтэй болно (Лук 4:8)” (in Conference Refort, Apr. 1969, p. 94; or Improvement Era, June 1969, p. 28).

Уриалга

Залуу эрэгтэйчүүдийг уруу таталтаас зайлсхийж, урьдаас чухал шийдвэрүүд гаргаж, Сатан, түүний уруу таталтуудыг даван гарч мөнхийн амьдралд хүрэхийн тулд үргэлж залбирч байхыг уриал.

Ариун Ёслол: Түүнийг Дурсан Санахад Зориулагдсан

41

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр зохистойгоор, даруухнаар ариун ёслолын ажиллагаанд оролцох болно.

БЭЛТГЭЛ

Шаардагдах материалууд:

1. Залуу эрэгтэй бүрт судар.
2. Судар тэмдэглэх харандаанууд.

ТАЙЛБАР

Бид долоо хоног бүр ариун ёслол хүртдэг учраас заримдаа бид түүний нандин чанарыг алддаг. Энэ хичээлээр залуу эрэгтэйчүүдэд энэ ариун ёслолын ач холбогдлыг мэдрүүлэх болно.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Судар ба ярилцлага

Оршил

Иохан 1:29-ийг залуу эрэгтэйчүүдээр уншуул. Хуучин Гэрээний үед Их Эзэнд анхны төрсөн хургыг золиос болгон өргөдөг байсан гэдгийг тайлбарла. Хурга бол Аврагчийг сүүлчийн золиос болохоос өмнө түүнийг билэгдсэн билэгдэл ба ариун ёслол нь түүний бидний төлөө хийсэн золиослолыг дурсахад зориулагдсан гэдгийг анхааруулан хэл. Залуу эрэгтэйчүүдээр талх ус юуг билэгдэж байгааг хэлүүл.

Ариун Ёслол Бидэнд Есүсийн Золиослол болон Бидний Гэрээг Сануулдаг

Судар, самбар,
ярилцлага

Лук 22:19–20-ийг унш.

- Есүс ариун ёслолыг эхлүүлэх явдалтай ямар үйл явдалхолбоотой вэ? (Сүүлчийн Зоогийн дараа түүний Гетсэмэн дэх шаналлын өмнө.)
- Есүс яагаад ариун ёслолыг эхлүүлсэн бэ? (Бидэнд өөрийгөө тодорхой сануулахын тулд.)

Дараах өгүүлбэрийг самбарт бичиж ярилцлагыг хураангуйл: *Ариун ёслол нь бидэнд Есүсийг болон бидний төлөө хийсэн түүний золиослолыг сануулдаг.*

Зөвлөхийн
танилцуулга

Ариун ёслол нь зөвхөн Есүсийн золиослолыг сануулах биш мөн Их Эзэнтэй түүний биднээр хийлгэхийг хүссэнийг нь хийнэ гэж гэрээ байгуулах гэсэн хоёр талт зорилготой юм гэдгийг тайлбарла. Ариун ёслолын залбирал бидний хийх гурван онцгой амлалтыг дурддаг.

Судар, самбар,
ярилцлага

- Ариун ёслолын залбирлыг хаанаас олж болох вэ? (Сургаал ба Гэрээ 20:77, 79 ба Моронай 4:3; 5:2.)

Сургаал ба Гэрээ 20:77 (эсвэл Моронай 4:3)-ыг уншаад доогуур нь зур.

- Бид ариун ёслол хүртэхдээ ямар гурван зүйлийг “гэрчлэх” буюу амладаг вэ?

Гурван амлалтыг самбарт бич.

Бидний амлалт:

1. Христийн нэрийг өөртөө авах.
2. Түүнийг үргэлж дурсан санах.
3. Түүний зарлигуудыг сахих.

Бодох асуулт Ярилцлага	<ul style="list-style-type: none"> • Та нар энэ амлалтуудыг дагахыг үнэхээр хичээдэг үү? • Та нар анх удаа хэзээ энэ амлалтуудыг хийсэн бэ? (Усан баталгаа хийлгэхдээ.) <p>Үүнтэй адил түүх болон асуултуудыг ашиглан бүх амлалтуудыг товч ярилц.</p> <ul style="list-style-type: none"> • Христийн нэрийг өөртөө авна гэж юу гэсэн үг вэ? (Хаана ч хэзээ ч Христийн зааснаар амьдрахад бэлэн байх. Мозая 5:5–7; 18:8–10-ыг үз.) • Бид Христийн нэрийг өөртөө авахад хүмүүс биднээс юуг хүсэн хүлээх вэ? (Биднийг Христийн зааснаар амьдарч түүнд хүндлэл авчрах.) • Хэрэв түүний дагалдагчийн хувьд бидний юу хийж байгаагаар түүнийг дүгнэвэл Христийг бусад хүмүүс юу гэж бодох вэ?
Нөхцлийн судалгаа	<p>Чи дөнгөж шинэ газар нүүж ирлээ. Хичээлийн өмнө, хэсэг хөвгүүд танилцахаар ирэв. Тэд өөрсдийгөө танилцуулаад чамаас чиний гэр бүл, хуучин сургууль, сонирхол, шүтлэгийн чинь талаар асуув.</p> <ul style="list-style-type: none"> • Чи яах вэ? Чи бахдалтайгаар Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд явдгаа хэлэх үү, эсвэл ямар шүтлэгтэйгээ хэлчихвэл тэд чамтай найзлахгүй байх гэж айгаад чимээгүй өнгөрөх үү? • Хэрэв Есүсийн нэрийг өөртөө авна гэсэн амлалтаа дээдэлбэл чи юу хийх вэ? • Есүсийг үргэлж дурсан санана гэж юу гэсэн үг вэ? (Түүний тухай үргэлж бодож өдөр тутмынхаа амьдралд түүний заасныг дагах.) • Есүсийг үргэлж дурсан санах нь Сатаны уруу таталтуудыг давж гарахад биднийг хэрхэн хүчтэй болгодог вэ?
Бодох асуулт Ярилцлага	<ul style="list-style-type: none"> • Та нар өнгөрсөн долоо хоногт Есүсийг ямар үед хаана дурсан санасан бэ? • Ариун ёслолын үеэр Аврагчийн тухай бодоход заримдаа бидэнд юу саад болдог вэ? • Ариун ёслолоос хүртэж байхдаа Есүсийг дурсан санахад бодлоо төвлөрүүлэхийн тулд бид юу хийж чадах вэ? (Та хариултуудыг самбарт бичиж болно. Байж болох хариултуудад Есүсийн амьдрал, үүрэг, түүний бидэнд зориулсан агуу их хайр, ариун ёслолын бэлэгдлийг эргэцүүлэн бодох, ариун ёслолын дууллын үгнүүд дэх захиасыг бодох гэх мэт багтана.) • Есүсийг дурсан санана гэсэн амлалтаа дагахын тулд долоо хоногийн үеэр бид юу хийж болох вэ? (Судраас суралцах, залбирах, семинар болон бусад Сүмийн цуглаануудад оролцох, Есүсийг бидэнтэй хамт байгаа мэт үйлдэх, түүний зарлигуудыг дуулгавартай дагах, гэр бүлийнхэн болон бусад хүмүүст хайраа үзүүлэх.)
Судрууд ба ярилцлага	<p>Иохан 14:15-ыг унш. Залуу эрэгтэйчүүдтэй яагаад Есүсийн зарлигуудыг сахиснаар түүнд хайраа үзүүлж байгаа болохыг ярилц.</p> <ul style="list-style-type: none"> • Есүсийг үргэлж дурсан санах нь түүний зарлигуудыг сахихад хэрхэн амар болгодог вэ? <p>Усны адислалыг унш (С ба Г 20:79 эсвэл Моронай 5:2). Энэ ёслолд анхандаа дарс хэрэглэж байсныг тайлбарла (Сургаал ба Гэрээ 27 бүлгийн санааг ба 1-2-р шүлгүүдийг үз).</p> <ul style="list-style-type: none"> • Энэ хоёр залбиралд ямар амлалтыг дурдсан бэ? (Есүсийг үргэлж дурсан санах.) • Хэрэв бид энэ амлалтын сүнс ба захиасыг итгэлтэйгээр хадгалбал бид яаж үйлдэх вэ? Нөгөө хоёр амлалтыг биелүүлэхийг бидэнд сануулах хэрэгтэй болох уу?

Ариун Ёслолыг Зохистойгоор Хүртсэн Хүмүүстэй Их Эзэний Сүнс Хамт Байна

Самбар ба ярилцлага	<ul style="list-style-type: none"> • Ариун ёслол хүртсэнээр хийсэн гэрээгээ сахвал Их Эзэн бидэнд юу амладаг вэ? (Бидэнд түүний Сүнс үргэлж байна.) <p>Дараах зүйлийг самбарт нэмж бич: <i>Бурхан бидэнд өөрийнхөө Сүнсийг өгөхөөр амласан.</i></p> <ul style="list-style-type: none"> • Их Эзэний Сүнс чамтай хамт байвал чиний амьдралд ямар өөрчлөлт орох вэ? (Сүнсний үр жимс болох мэдлэг, тайтгарал, удирдамжтай байна.)
------------------------	--

Судар ба ярилцлага	<ul style="list-style-type: none"> • Сүнс чамд сайн мэдээгээр амьдрахад чинь хэрхэн тусалж чадсан бэ? <p>Зөвхөн ариун ёслолоос хүртэх нь байнга Ариун Сүнсний удирдамжтай байхад хангалттай биш гэдгийг тайлбарла. Бид үүнийг зохистойгоор хүртэх ёстой.</p> <p>1 Коринт 11:27–30-ийг унш.</p> <ul style="list-style-type: none"> • Ариун ёслолыг зохисгүйгээр хүртсэн хүмүүсийн тухай Паул юу хэлсэн бэ? (Тэр хэлэхдээ тэд нар Христийн “бие ба цусны” буруутан болдог бөгөөд тэд үүнийг өөрсдийнхөө гэм зэмлэлийн төлөө хийж байна гэжээ.) • Энэ нь бид төгс байж ариун ёслолоос хүртэх ёстой гэсэн үг мөн үү? (Үгүй, гэхдээ бид сайн мэдээний дагуу амьдрахаар хичээж, ямар нэг буруу хийсэн зүйлээ наманчлах ёстой.) • Ариун ёслолоос зохистойгоор хүртэхэд бид өөрсдийгөө хэрхэн бэлтгэж чадах вэ? (Өдөр бүр наманчилж, гомдоосон хүмүүсээсээ уучлал эрж, Христ ба түүний золиослолыг байнга санаж байснаар. Ариун ёслолын үйлчлэлийн үеэр бид ариун ёслолын залбирлыг дотроо давтан хэлж, өөрсдийнхөө гэрээг сахихад хүчтэй болгохын төлөө залбирч байх ёстой.) • Сударт хэлэхдээ ‘Хүн өөрийгөө шалгаг’ гэжээ. Өөрийнхөө амьдралыг байнга шалгах нь бидэнд зөв сэтгэлээр ариун ёслолоос хүртэх байдлыг хэрхэн амархан болгох вэ? • Ариун ёслолын үе нь яагаад бидний өөрсдийгөө шалгах сайн үе вэ?
Ишлэл	<p>Ариун ёслолоос хүртэхийн нэг адислал нь энэ нь биднийг сүнслэг байдлаар дахин сэргээж, биднийг сайн мэдээгээр бүрэн дүүрэн амьдрахад хүч нэмдэг болно. Ахлагч Мэлвин Ж.Баллард хэлсэн нь:</p> <p>“Би үргэлж энэ адислагдсан боломжийг, сүнслэг өсөлт гэж үздэг ба Их Эзэний Зоог болох ариун ёслолыг зохистойгоор хүртэхүйц хүмүүст сүнслэгээр нь өсөхөд тусалдаг өөр ямар ч боломж үгүй билээ. Бид хоол хүнсийг бие махбодидоо зориулан иддэг. Хоол идэхгүйгээр бидний бие сул дорой болж, өвчинд өртөмтгий болдог. Яг үүний адил ариун ёслолоос хүртэж сүнслэг хоол хүнсийг олж авах нь сүнслэг биед маань шаардлагатай. . . .</p> <p>“Бидэн дундаас сүнсээ үгээр, бодлоор болон үйл ажлаараа Хүндэтгэлийн өдрөөс Хүндэтгэлийн өдөр хүртэл гомдоодоггүй хэн байна вэ? Бид харамсмаар, уучлагдахыг хүсмээр буюу хэн нэгний эсрэг алдаа гаргаж гомдоох зүйлсийг хийдэг. . . . Уучлалыг авах арга зам бол дахин усан баталгаа хийлгэх биш; энэ нь гэм нүглээ наманчилж, гомдоосон буюу буруу зүйл хийсэн хүмүүс дээр очиж тэднээс уучлалт эрж тэгээд хэрэв бид чин сэтгэлээсээ наманчилж өөрсдийгөө зөв байранд нь оруулсан бол ариун ёслолын ширээн дээр очсоноор уучлагдах бөгөөд сүнслэг эдгэрэлт бидний сүнсэнд ирэх болно” (<i>Sermons and Missionary Services of Melvin J. Ballard</i>, comp. Bryant S. Hinckley {Salt Lake City: Deseret Book Co., 1949}, pp.148–49).</p>

Дүгнэлт

Уриалга	<p>Залуу эрэгтэйчүүдэд дараах уриалгыг уншиж өг.</p> <p>“Ариун ёслолын үүрэг хариуцлагыг хүлээсэн Аароны Пристийн Зэрэгтэн залуу эрэгтэйчүүд та нар үүний зорилго, үүний нандин чанар, энэ агуу боломжийн хамт ирэх нандин хариуцлагын талаар судалцгаа” (John H. Vandenberg, “The Presiding Bishop Speaks about the Sacrament,” <i>Improvement Era</i>, Nov. 1967, p. 16).</p>
Гэрчлэл	<p>Ариун ёслолын нандин байдал, ариун ёслолыг зохистойгоор хүртэхэд бэлтгэхийн чухал болон зохистойгоор хүртсэнээр ирэх адислалуудын талаар гэрчлэлээ хуваалц.</p> <p>Пристүүд байнга хэлдэг учраас залуу эрэгтэйчүүдэд ариун ёслолын залбиралтай судрыг цээжлэхэд нь урамшуул.</p>

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр Бурханаас томилогдсон удирдагчаа дагах шийдвэр гаргах болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаа.
2. Цуглааны байрнаас эсвэл хэсэг ба салбарын гишүүдээс Сүмийн удирдагчдын яриатай чуулганы илтгэлийг эсвэл Тэргүүн Зөвлөлийн захиас бичгүүдийг олж ав (Залуу эрэгтэй бүрт нэг илтгэл).
3. Цаас буюу картон дээр саяхны чуулганы илтгэлүүдийн ишлэлүүдийг бэлтгэ.
4. Ахлагч Гробергийн хичээл дэх түүхийг хичээлийн үеэр залуу эрэгтэйчүүдийн нэгээр уншуулахаар өмнө нь бэлтгэ (сонголтоор).

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

Түүх ба ярилцлага

Их Эзэн Томилсон Удирдагчдаараа Хүсэл, Оюун Санаагаа Мэдүүлдэг

Номхон далайн арлуудад номлогч байхдаа тохиолдсон явдлаа ерөнхий чуулганы үеэр Далын ахлагч Жоон Гроберг ярьсан юм.

“Би салангид 15 жижиг арал дээр сайн мэдээг номлохоор болон Сүмийн ажил хэргийг гүйцэтгэхээр дүүргийн ерөнхийлөгчөөр дуудагдсан юм. Бид ихэнхдээ зөвхөн завиар аялдаг байв. . . .

“Нэг удаа бид нэлээн хол арал дээр нэгэн номлогч маш хүнд өвчтэй байна гэсэн сураг сонссон юм. Цаг агаар маш аюултай байлаа. . . . Маш хүчтэй далайн салхи бидний урагшлах замд саад болсоор бид тэнд үдээс хойш очсон юм. Номлогч маань үнэхээр хүнд өвчтэй байсан. Маш хурдан залбирлын дараа адислал өгч байхад төв арал руу түүнийг эмнэлэг рүү яг одоо аваад яв гэсэн бодол орж ирсэн юм.

“Тэр үед харанхуй, далайн шуурга, аймшигт далайн хад чулуу маш нарийхан хоолойгоор орох боломжтой боомт гээд ярих юм их байсан боловч удалгүй өвчтэй номлогч, маш туршлагатай онгоцны ахмад, санаа нь зовсон дүүргийн ерөнхийлөгч гээд найман хүн усан онгоцонд суусан билээ.

“Биднийг задгай тэнгист гарахаар шийдсэний дараа удалгүй далайн шуурганы хүч долоо дахин нэмэгдэх шиг санагдав.

. . . Харанхуй байсан ертөнц улам хав харанхуй болж, зузаан үүл болон хүчтэй борооны эрч нэмэгдэж, од ч үгүй, сар ч үгүй, амралт ч үгүй зөвхөн үймээн сандраан л болж байв. . . .

“Тэгээд бид өнхрөн, шидэгдсээр хад руу улам ойртож ирэхэд, бүх нүднүүд бидний гэр лүү аваачих цорын ганц үүд нээгдэхийн шинж болох гэрлийг хайцгааж байв. Тэр Хаана байна? . . . Бороо бидний нүүр болон хий дэмий амьдрал өгөх гэрлийг хайж буй нүдийг шавхуурдан нүднээс нулимс гаргаж байлаа.

“Тэгээд хад руу цохигдож зажлах давалгааны хүйтэн хөндий чимээг сонслоо! Энэ нь их ойрхон, маш ойрхон байлаа. Тэр гэрэл хаана байна? Хэрэв бид онгорхойг л олохгүй бол хаданд няцлагдаж мянган шүдэт мангасанд тас татагдаж, урагдах байлаа.

“Зарим нь гасалж, бусад нь гашуудан уйлж, ганц хоёр хүн бүр сандран хашгирч эхлэв. Энэ үймээн сандрааны ид үед олонх нь зүүн тийш буюу баруун тийш эргэ хэмээн шуугилдаж байхад нь би ахмад руу харав. Тэгээд би урагшаа харанхуй руу

анхаарлаа хандуулсан тайван царайг харлаа. Энэ бол нас тогтсон, мэргэн ухаан туршлага суусан хүний царай байсан юм. Түүний омголтсон чимээгүй уруул хөдөлсөн бөгөөд гөлөрсөн чигээрээ зөвхөн жолоогоо мэдэгдэхүйц эргүүлсээр, 'Тэнд гэрэл байна,' хэмээн амьдрал хайрласан үгийг хэлэв.

“Ахмадын харж байгаа гэрлийг би олж харахгүй байв. Түүнийг харж чадна гэдгийг би мэдэж байлаа. Тэгээд хамгийн сүүлчийн агуу том давалгаагаар бид онгорхойгоор тогтуун ус руу хар хурдаараа давхин оров.

“Бид далайн аюулгүй боомтдоо ирлээ. Бид гэртээ ирчихсэн байлаа.

“Агуу их сургамж нь гэвэл: Олон жилийн туршлага болон дадлагатай хүмүүс онцгой тэнгэрлэг дуудлагын ач буянаар илүү хол, илүү сайн, илүү тод харж биднийг өөрсдөө харахаас өмнө биднийг сүнс болон бие махбодийн аль аль үхэлд хүргэж болох аюултай нөхцөлд авардаг” (in Conference Refort, Oct. 1976, pp. 61–63; or *Ensign*, Nov. 1976, pp. 44– 45).

• Ахлагч Гроберг энэ түүхийнхээ хамгийн сүүлчийн хэсгийг хэнд хандуулсан бэ? (Сүмийн удирдагч нарт)

Хэрэв шаардлагатай бол хамгийн сүүлчийн хэсгийг дахин унш.

- Бурханы сонгосон удирдагч нар яагаад илүү хол, илүү сайн, илүү тод харж чаддаг вэ?
- Манай пристийн зэрэгтэн удирдагч нар Их Эзэний замыг мэддэг ба өнөөдрийн шуургатай далайгаар биднийг хөтөлж чадна гэсэн ямар баталгаа бидэнд байдаг вэ?

Залуу эрэгтэйчүүдээр Сургаал ба Гэрээ 1:38 ба 68:2–4-ийг уншуулж тэмдэглүүл.

- Эдгээр судруудад Их Эзэний ямар үйлчлэгчдийн тухай өгүүлдэг вэ?

Залуу эрэгтэйчүүдээр тэдний тусын төлөө заавар, зөвлөмж хүлээж авдаг Сүмийн зарим удирдагч нарыг нэрлүүл.

Залуу эрэгтэйчүүдийн хариултаар самбарт дараах хүснэгтийг бэлтгэ.

Пристийн Зэрэг дэх удирдагчид		
Сүмийн Ерөнхийлөгч Тэргүүн Зөвлөл Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулга Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөл (Далын гишүүд) Ерөнхийлөн Удирдах Бишопын Зөвлөл	Гадасны Ерөнхийлөгчийн Зөвлөл	Бишопын болон Салбарын Ерөнхийлөгчийн Зөвлөл Дээд пристийн бүлгийн удирдлага Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл Аароны Пристийн Зэрэгтний чуулгын Ерөнхийлөгчийн зөвлөл

Залуу эрэгтэйчүүдэд дараах асуултуудад хүснэгттэй холбон хариул гэдгийг хэл.

- Их Эзэн дараах мэдээллийг аль томилогдсон удирдагчаар дамжуулан мэдэгдэх вэ?
1. Сүмд зориулсан шинэ илчлэлт. (Тэргүүн Зөвлөл.)
 2. Залуу эрэгтэйг чуулгын ерөнхийлөгчөөр дуудагдахыг батлах. (Бишоп.)
 3. Бишопоор үйлчлэх дуудлага. (Гадасны ерөнхийлөгч.)
 4. Залуу эрэгтэй болон залуу эмэгтэй номлолоор үйлчилж болох зохистой байдлын дүгнэлт. (Бишоп ба гадасны ерөнхийлөгч.)
 5. Номлогчийн тодорхой талбарт хөдөлмөрлөх дуудлага. (Тэргүүн Зөвлөл.)
 6. Хувийн зохистой байдлын ярилцлага хөтөлж явуулах илчлэлт ба зааварчилгаа. (Бишоп.)
 7. Аборт хийх, порнографи, мансууруулах бодистой холбоотой Сүмийн бодлого. (Тэргүүн Зөвлөл.)
 8. Та нарын амьдралд хэрэгтэй зөвлөгөө. (Бишоп.)

Судар, самбар,
ярилцлага

Ишлэл Их Эзэн хүсэл ба оюун санаагаа өөрийнхөө томилсон удирдагч нараар дамжуулан мэдүүлдэг гэж тайлбарла: “Тэргүүн Зөвлөл болон хаант улсын түлхүүрийг атгасан бусад хүмүүсийн нэгдсэн дуу хоолой үргэлж Их Эзэний ямар байхыг хүссэн замаар Гэгээнтнүүдийг болон дэлхийг удирдах болно” (Joseph Fielding Smith, Conference Report, Apr. 1972, p. 99; or Ensign, July 1972, p. 88).

Сүмийн Удирдагчид Бидний Ашиг Тусд Зориулсан Удирдамжийг Өгдөг

Түүх ба ярилцлага

Ерөнхийлөгч Дэвид О. МакКэйн ярьсан дараах түүхийг хэл.

“Саяхан би ой хамгаалагч модноос уясан уяа ой мод руу хөтөлснийг мэдсэн тухай нийтлэл уншсан юм. Тэр энэ уяаг дагаж ямар ач холбогдолтой болохыг нь мэдэхээр шийджээ. Зулзаган ой, унжсан мөчрүүдийн дундуур тэр чадлынхаа хэрээр явж байсан ба эцэст нь гартаа үлдсэн бөөрөнхийлсөн төмөр утас барьсан анчин дээр хүрч иржээ. Уяа юунд хэрэгтэйг сонирхон асуувал анчин “Ой модонд төөрсөн хүмүүсийн тухай сонсоод хэрэв би зүг чигээ алдвал үүгээр замаа буцаад олж болно гэж шийдсэн юм” хэмээн хариулав” (Treasures of Life [Salt Lake City: Deseret Book Co., 1962], p. 404).

- Бид энэ дэлхийд замаа хэрхэн алдахгүй байж чадах вэ? (Бид Пристийн Зэрэгтэн удирдагчдын удирдамжийг дагаж чадна.)
- Та нарыг зөв зам дээрээ үлдэхэд чинь пристийн зэрэгтний удирдагч чинь хэрхэн тусалсан бэ?

Үйл ажиллагаа ба ярилцлага

- Орчин үеийн асуудлуудад хандах Сүмийн байр суурийн тухай хамгийн сүүлийн мэдээллийг бид хаанаас олж болох вэ? (*Тэргүүн Зөвлөлийн Захиас болон олон улсын сэтгүүлүүд*).

Залуу эрэгтэй бүрт ерөнхий чуулганы илтгэлтэй тэргүүн зөвлөлийн захиас бичгийг тарааж өг. Залуу эрэгтэй бүрийг саяхны чуулганаар яригдсан зүйлсийн жагсаалтыг унш гэж хэл. Залуу эрэгтэй бүрээр тэдэнд хэрэгтэй зүйлийн талаар зөвлөсөн яриануудыг олуул.

- Энэ мэдээлэл бидэнд хэрхэн тусалж чадах вэ? (Бидэнд хэрхэн бэлтгэх талаар хэлж, зайлсхийх зүйлсийг анхааруулж, мөн бидэнд ойлголтоо нэмэгдүүлэхэд тусална.)
- Бошиглогчдын зөвлөгөөг дагаснаар та нар хэрхэн адислагдсан бэ?

Ишлэл

Ахлагч Марион Ж. Ромнигийн дараах мэдэгдлийг унш.

“Өнөөдөр Их Эзэн өөрийнхөө хүслийг ертөнцийн бүх оршин суугчдад ялангуяа Сүмийн гишүүдэд тэргүүнд нь байдаг Тэргүүн Зөвлөлтэй, амьд бошиглогчоор дамжуулан өнөөдрийн асуудлуудыг илчилж байна. Их Эзэн хэрэв энд байсан бол юу хэлэх байсан тэр бүгдийг, ерөнхийлөгчийн зөвлөл хэлдэг . . . ба энэ нь судар юм” (in Conference Report, Apr. 1945, p. 90).

Дэлхийн Жишгээс Өөр Жишгээр Амьдрахыг Сүмийн Удирдагчид Бидэнд Зөвлөдөг

Ишлэл

Ахан дүүсийн зөвлөгөөг дагаснаар бид дэлхийд нийтлэг бус жишгээр амьдрахыг биднээс шаарддаг болохыг мэдэж авдаг. Ерөнхийлөгч Жорж К. Канон итгэлтэй Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд нэг шалгуур санал болгожээ: “Хэрэв дэлхий болон бидний хоорондох харьцаа (зай) өдөр тутамд өргөсөж байвал бидний өсөлт хэдий удаан ч гарцаагүй гэдгийг мэдэж авна. Нөгөө талаар бидний мэдрэмж болон хүсэл, дур сонирхол бидний эргэн тойронд буй дэлхийтэй дуу нэгтэй байвал бид өөрсдийгөө дүгнэх талаар илүү их зүйл хийх ёстой болно” (in Millennial Star, 5 Oct. 1861, p. 645).

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр 1 Иохан 2:15–17-г чангаар уншуул.

- Дэлхий дээр бидний эргэн тойронд байгаа хүмүүсээс бидний хүсэл, дур сонирхол яагаад өөр байх ёстой вэ?
- Дэлхийн бусад хүмүүсээс Хожмын Үеийн Гэгээнтнүүд юугаараа ялгарах ёстой вэ? (Тэд ариун бодолтой байж; үнэнд хайртай; хувцас болон биеэ даруу төлөв засаж;

зөв шударга зүйл хийж энэрэл үзүүлж; Мэргэн ухааны үгийг сахиж; дуулгавартай байж, Христийн жишээг үзүүлэх ёстой.)

Залуу эрэгтэйчүүдээр 1 Петр 2:9-ийг уншуул. Энэ судрын Бурханы эзэмшлийн буюу өв ард түмэн гэдэг нь зөв шударга, ариун, энэрэнгүй ба Христийн адил гэсэн утгатай юм гэдгийг тайлбарла. Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Жэймс Хааны Библид “худалдагдсан хүмүүс” гэж орчуулагдсан. Бид Аврагчийн зовлонгоор худалдагдсан учраас зөв шударгаар амьдрахын сайн үлгэр жишээг үзүүлэх ёстой.

Үйл ажиллагаа

Чуулгыг жижиг жижиг бүлэгт хуваа. Бүлэг бүрт саяхны чуулганы ярианаас түүвэрлэн авсан хэсгийг буюу доорх яриануудыг өг. Залуу эрэгтэйчүүдээр зөвлөгөөг уншуулаад бошиглогчийн зөвлөгөөг дагаснаар дэлхийгээс хол буюу ялгаатай байх замуудыг хэлүүл.

1. “Бид өөрсдийгөө бүх төрлийн шударга бус зүйл түүн дотор дэлгүүрээс хулгай хийхдээ хүртэл зөвтгөхийг оролддог. . . .

“Шударга бус байдал нь олон өөр янзаар ирдэгт кассны мөнгө дээрэмдэх буюу ажилчдын эд зүйлсийг хулгайлах; мөнгө болон бусад үнэтэй зүйлсийг гэрээс буюу гудамжнаас дээрэмдэх; нийтийн тээвэрт мөнгийг нь төлөхгүйгээр суух; болон бусад бүх газар дахь бүх төрлийн шударга бус байдал орно.

“Бүх хулгайлах болон шударга бус үйлдэлд Их Эзэн ‘Хулгай бүү хий’ хэмээн хэлжээ” (Spencer W. Kimball, in Conference Report, Oct. 1976, p. 7; or Ensign, Nov. 1976, p. 6).

2. “Дэлхийн зугаа цэнгэлийг эрэх нь манай олон залуучуудыг, зуршил болдог архи, тамхи, мансууруулах бодис мэтийг хэрэглэх буруу зам руу хөтөлдөг бөгөөд эцэстээ тэд нар эдгээр зүйлтэй холбоотой бусад олон муу ёрын зүйлд автах болно. Телевизийн нөлөө, ялангуяа хамгийн хортой архи, тамхи болон сексийг хүн бүр хэрэглэдэг нийтлэг зүйл болгон дүрслэн үзүүлэхэд хувь нэмэр оруулдаг нь үүнийг энэ хортой бүлгийн нэг болгодог” (N. Eldon Tanner, in Conference Report, Oct. 1976, p. 113; or Ensign, Nov. 1976, p. 75).

3. “Порнографи өргөн болж байгаа нь бүх талаараа буруу нөлөөтэй. Тэд юу вэ гэдгийг та нар мэднэ. Насанд хүрсэн хүн ч байсан залуучууд ч байсан порнографи зүйлийг үзэж, сонсож, үүний тухай ярихдаа олон нийтийн ёс суртахуунд аюул учруулах буюу бохирдуулахгүй байж чадахгүй гэдгийг хэлмээр байна” (N. Eldon Tanner, in Conference Report, Oct. 1976, p. 113; or Ensign, Nov. 1976, p. 75).

4. “Ёс суртахуунгүй байдал, садар самуун явдал маш их түгээмэл болж өнөөдөр манай залуучууд олон төрлийн гажуудлуудыг зурагт, киногоор үзэж энэ нь зөвшөөрөгдсөн амьдрах хэв маяг мэт сэтгэгдэл төрүүлдэг болохыг харж болно. Бид өөрсдийгөө цэвэр, ариун, ариун явдалтай байлгахын чухлыг үүнээс илүү хүчтэйгээр илэрхийлж чадахгүй” (N. Eldon Tanner, in Conference Report, Oct. 1976, p. 113; or Ensign, Nov. 1976, p. 76).

Ишлэл

Дараах ишлэлийг унш:

“Бид Энэ дэлхийд амьдарч байгаа ч үүний нэг хэсэг нь байх ёсгүй гэдгийг бид үргэлж санах ёстой. Дэлхийн замыг бид үнэхээр дагаж чадахгүй. Бид өөр байх зоригтой байх хэрэгтэй. Биднийг өв, ард түмэн гэж нэрлэж байгаа хүмүүсийн нөлөөнд бид орох ёсгүй. Их Эзэн Израилын хүүхдүүдэд хэлэхдээ:

“Чи бол Их Эзэн Бурханыхаа ариун ард түмэн. Их Эзэн дэлхий дээр байгаа бүх ард түмнүүдийн дотроос чамайг Өөрийнхөө өв, ард түмэн болгохоор сонгосон билээ” гэжээ (Дэд хууль 14:2)” (N. Eldon Tanner, in Conference Report, Oct. 1976, p. 113; or Ensign, Nov. 1976, p. 76).

Дүгнэлт

Гэрчлэл ба уриалга

Олон улсын сэтгүүл болон Тэргүүн Зөвлөлийн Захиас бичгийг залуу эрэгтэйчүүдэд үзүүлж тэднийг самбар руу дахин хандуул. Тэд Их Эзэний хүсэл, оюун санааг өнөөдөр Их Эзэний сонгосон удирдагчид болон Ерөнхий эрх мэдэлтнээс зааварчилгаа хүлээн авдаг орон нутгийн удирдагч нараа сонссоноор тэдний үгийг уншиж судалснаар мэдэж чадна гэдгийг онцлон хэл. Өнөөдөр асуудлуудын талаар

зааварчилгаа болон зөвлөмж авах боломжтой тухай гэрчлэлээ хуваалцаж, хэрэв зохимжтой бол хувийн тохиолдлоо хуваалц.

**ЗӨВЛӨМЖ
БОЛГОСОН ҮЙЛ
АЖИЛЛАГАА**

Дараах үйл ажиллагаануудаас нэг буюу түүнээс илүүг хийхийг залуу эрэгтэйчүүдэд зөвлө:

1. Орон нутгийн эсвэл ерөнхий чуулганд оролц.
2. Тэргүүн Зөвлөлийн саяхны зөвлөгөө чиглэлээс Сүмийн үйлчлэл дээр ирээдүйд яриа өгөхөөр бэлтгэ.
3. Ерөнхий чуулган болохоос өмнө өөртөө байгаа асуултуудыг бичиж аваад Тэргүүн Зөвлөлийн ярианаас хариултуудыг сонс.
4. Хамгийн сүүлчийн олон улсын сэтгүүлээс (Лиахона) чуулганы материалыг уншиж асуулттай байгаа зүйлийнхээ талаарх Сүмийн сургаал номлол, бодлогын талаар сурч ав.
5. Хамгийн сүүлчийн олон улсын сэтгүүлээс Тэргүүн Зөвлөлийн захиас бичгийг товчилж аваад бусад залуу эрэгтэйчүүддээ илтгэ.
6. Олон улсын сэтгүүлд асуулт явуул.

Номлолд Сүнслэг Байдлаар Бэлтгэх нь

43

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр номлолд амжилттай сайн үйлчлэхийн тулд сүнслэгээр бэлдсэн байх ёстой гэдгийг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаа.
 2. “Номлолд Сүнслэгээр Бэлтгэх Замууд” тараах материалыг залуу эрэгтэй бүрт.
-

ТАЙЛБАР

Энэ хичээл залуу эрэгтэйчүүдэд номлолдоо сүнслэгээр бэлтгэх боломжийг олгоно. Залуу эрэгтэйчүүд одоо хөгжүүлж байгаа сүнслэг байдал нь сүүлд тэднийг Их Эзэний номлогчоор үйлчлэхэд хэрэгтэй гэдгийг мэдэх шаардлагатай. Цагийн боломжоос шалтгаалан та энэ хичээлд хоёр долоо хоногийг зориулж болно.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Оршил

Залуу эрэгтэйчүүдээс орчин үеийн машинууд, тооны машинууд, компьютерүүд ба роботуудын эрин үед Сүм робот-номлогчийг бүтээж Ахлагч Кал Кү Лэйтэр гэдэг нэр өгчээ гэж төсөөлөхийг хүс.

- Номлогчийн хувьд Ахлагч Кал Кү Лэйтэр ямар зүйлийг илүү сайн хийж чадах вэ?
- Номлогчийн ажил хийлгэхээр дэлхий даяар мянга мянган Ахлагч Кал Кү Лэйтэрийг илгээвэл ямар давуу талтай байх вэ? (Байж болох хариултанд тэд номлогчид тулгардаг бие махбодийн асуудлуудыг амархнаар давж гарч чадна; тэдэнд номлогч нарын заах ёстой бүх хичээлүүдийг программчилж болно; тэднийг ямар ч хэлээр төвөггүй ярихаар программчилж болно; тэд номлогч нараас асуудаг нийтлэг асуултанд хариулах программтай байж болно; тэд очсон газрынхаа нийгмийн байдал болон хүмүүсийн соёлд тааруулан сайхан харьцаа төрүүлэх хариулт өгч чадна; тэдэнд идэх хоол болон унтах газрын мөнгө төлөх хэрэггүй; тэд ядрахгүйгээр дараалсан олон номлолд явж чадна гэх мэт орно.)
- Та нар ийм санаа нь хэрэгжинэ гэж бодож байна уу? Яагаад үгүй вэ?
- Зөвхөн хүн байснаар ямар зан чанаруудыг номлогч нар амжилттайгаар хөгжүүлж чадах вэ? (Хайр, сүнслэг байдал, гэрчлэл, баяр хөөр, ариун сүнсний урам.)

Эдгээр нь сүнслэг зан чанарууд ба Номлолын ажилд амин чухал гэдгийг тайлбарла. Жишээлбэл, Сүмийг сонирхогчид Ариун Сүнснээс өгөгдсөн гэрчлэлийг сонсох хэрэгтэй. Номлолын ажилд номлогч бие бялдар, оюун ухаан, нийгмийн чадвартай байх хэрэгтэйн адил сүнслэг хүч чадалтай байх учир робот хэзээ ч тохирох номлогч байж чадахгүй.

Аароны Пристийн Зэрэгтэн Номлолд Хэрхэн Бэлтгэж Чадах вэ?

Ярилцлага

Амжилттай байхын тулд номлогч бүр сүнслэг хүчтэй байх ёстой гэдгийг тайлбарла. Залуу эрэгтэй бүр амжилттай сайн номлогч байхад хэрэгтэй сүнслэг хүчийг хөгжүүлэх чадвартай гэдэгт итгэж байгаагаа илэрхийл.

- Сүнслэг байна гэж юу гэсэн үг вэ? (Бурханаас ирдэг хайр, уучлал, сүнслэг урам, гэрчлэл, илчлэлт болон гярхай байдал гэх мэт сүнслэг тусламжийг ашиглаж болон түүнтэй хөг нэг байх).
- Бурхан яагаад номлогчдыг номлолдоо явахаар онцгойлон адислах үед нь автоматаар адисладаггүй вэ? (Сүнслэг байдал нь бидэнд байдаг бусад чадавхитай адил хөгжүүлэх ёстой зан чанар юм.)
- Яагаад номлолынхоо талбарт очсоныхоо дараа сүнслэг байдлаа хөгжүүлэхийг хүлээх ёсгүй вэ? (Номлолд сайн үйлчлэх сүнслэг чадваргүйгээр номлолдоо нэлээд хэдэн сарыг өнгөрөөнө гэдэг нь цаг дэмий үрдэг.)
- Номлолд сүнслэгээр бэлтгэх хамгийн тохиромжтой цаг нь хэзээ вэ? (Аароны Пристийн Зэрэгтэн байхдаа.)

Ишлэл

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл хэлэхдээ:

“Би илүү олон номлогчийг хүсэхдээ гэрчлэлгүй буюу зохисгүй олон номлогчийг хүсдэггүй юм. . . .

“Маш олон номлогчийн насны залуу эрэгтэй номлолд явах бэлтгэлгүй ирдэг бөгөөд мэдээж тэднийг илгээх ёсгүй юм. Гэвч тэд бүгд бэлтгэсэн байх ёстой” (“When the World Will Be Converted,” Ehsign, Oct. 1974, pp. 7–8).

Нөхцлийн судалгаа ба ярилцлага

Сүнслэг байдлаар бэлтгэх нь роботод хэзээ ч байж чадахгүй тийм чанаруудыг номлогчид өгдөг гэдгийг хэл. Дараах нөхцөлүүдийг уншсаныхаа дараа энэ хоёр асуултын дагуу ярилц. Энэ нөхцөлд робот яагаад зөв хариулж чадахгүй вэ? Хэрэв та сүнслэгээр бэлтгэсэн номлогч байвал юу хийж чадах вэ?

1. Номлогчдын зааж буй айлын хүүхэд машины осолд орж яаралтай мэс засалд орохоор болов.
2. Нэг эцэг хэзээ ч залбирч байгаагүй бөгөөд Бурхан залбиралд хариулдаг гэдэгт итгэлгүй байна гэж хэлэв.
3. Нэг залуу эрэгтэй архи ууж тамхи татахаа болихыг шаардлагатай гэж үзэхгүй байна.
4. Сонирхогч айлын ээж ямар ч сүмд очсон түүнийг хүлээн зөвшөөрсөн сэтгэгдэл төрж байгаагүй гэж хэлэв.

Дараах санаануудыг гарга: Робот хүн чаддагтай адил хайрлаж, адислаж, залбирлынхаа хариултыг авч, итгэлээ хөгжүүлж, гэрчлэлээ өсгөж чадахгүй. Аароны Пристийн Зэрэгтнүүд эдгээрийг сайн хийж сурч чадах бөгөөд тэгснээр номлолд явахдаа сүнслэг хүчний бэлтгэлтэй байж чадна.

Судар ба ярилцлага

Сургаал ба Гэрээ 42:14-ийг залуу эрэгтэйчүүдээр уншуулж, тэмдэглүүлж, ярилц.

• Энэ судраас бид юу сурч чадах вэ? (Бид заахын тулд Их Эзэний сүнстэй байх ёстой.)

• Бусдад заахдаа сүнстэй байх ямар төрлийн бэлтгэл бид хийж чадах вэ?

Ишлэл ба ярилцлага

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл ирээдүйн номлогч нарт ийн тайлбарласан:

“Судраас сурч, судалж, эргэцүүлэн бодсоноор болон гэрчлэлээ хөгжүүлснээр тэр хүн заах сургахад бэлэн болж болно. Их Эзэн “Хэрэв та нар бэлтгэсэн бол та нар айхгүй” хэмээн хэлжээ. . . . Номлолд дөхөж очсон хүн бүр номлолын ажилд цаг алдалгүй зөвөөр оролцохын тулд дадлага сургууль хийж сургаалыг сурсан байх ёстой.

“Залуу эрэгтэй арван есөн нас хүрэнгүүтээ гэртээ хийдэг байсан заншсан үүргээсээ хөндийрч номлолын чухал үүрэг рүү өөрийн амьдрал, жишиг, сургалтын ямар ч үндсэн өөрчлөлт дахин хийлгүйгээр алхан орох бэлтгэлтэй байх ёстой нь мэдээж” (“Advice to Young Men: Now Is the Time to Prepare,” *New Era*, June 1973, p. 9).

• Номлогч гэрчлэлтэй байх нь яагаад чухал вэ?

• Ерөнхийлөгч Кимболлын асуусан бэлтгэл хэзээ хийгдэх ёстой вэ? (Яг одоо, Аароны Пристийн Зэрэгтэн байхдаа.)

Аароны Пристийн Зэрэг бол бэлтгэл пристийн зэрэг гэдгийг тайлбарла. Энэ нь түүнд бусдыг адислах болон бусдад заах сүнслэг хүч өгдөг Мелкизедек Пристийн Зэрэгт бэлтгэдэг.

Түүхүүд ба
ярилцлага

Сүнслэгээр Бэлтгэгдсэн Номлогчдод Агуу Шагнуууд Байдаг

Дараах сүнслэгээр бэлтгэгдсэн номлогчдын үнэн түүхийг хуваалц. Залуу эрэгтэйчүүдээс номлогч нарын бэлтгэсэн замууд болон бэлтгэсэн учраас тэд хэрхэн шагнагдсан тухай сонсохыг хүс.

Яриа 1

“Энэ бол Хойт Вейлз дахь Сүмийн шинэ салбарт томилогдсон миний номлолын анхны Ням гариг байв. Би хамтрагчтайгаа хамт тэр бүсийн ганц гишүүн гэр бүлтэй хамт амьдардаг байв. Тэдний гэр нь шүтээний байр байв. Манай жижигхэн унтлагын өрөө хүүхдийн анги байв. Энэ өдөр сонирхогч Вилкинсийн гэр бүлийнхэн анх удаа Сүмд ирэх байлаа. Тэд наймаас доош насны хоёр хүү хоёр охин дөрвөн хүүхдийн эцэг эх юм. Хамтрагч маань ‘Би Ням гаригийн хичээлийг насанд хүрэгчдэд зочдын өрөөнд зааа, чи унтлагын өрөөндөө хүүхдүүдэд заа,’ гэж хэлэв. Би урьд өмнө нь хэзээ ч хэнд ч зааж байгаагүй боловч надад Есүсийн хэлсэн олон жилийн турш дуртай хэвээр байдаг хэдэн түүх байв. Судраас тэр түүхүүдийг би амархан олж дахин нэг удаа ерэн есөн хонио орхиод алдсан нэг хонио хайхаар явсан сайн хоньчны тухай уншив. Хүүхдүүд надтай адил тэр түүхэнд дуртай байж чадна гэсэн урам зоригтой байв. Би даавуун дүрс хийв. Тэгээд би жижигхэн өрөөндөө өвдөг сөгдөн энэ хоёр охин хоёр хүүд Сүмийн анхны хичээл таалагдаасай хэмээн залбирав. Гэр бүлийг ирэхэд Сүм эхэлж удалгүй би Ням гаригийн хичээл хийх анги болгон зассан өрөө рүүгээ оров. Намайг өөрийнхөө орон дээр суугаад тэдэнд зааж байхад хүүхдүүд миний хамтрагчийн орон дээр суух нь таалагдав. Их Эзэний Сүнс бид бүгдэд хүрсэн билээ. Арван найман жилийн дараа одоо хөвгүүдийн нэг нь номлолоос буцаж ирснийхээ дараа бишопын ерөнхийлөгчийн зөвлөлд үйлчилж байна. Нөгөө хүү нь гэрлэж түүний эхнэр Сүмд орсон. Хоёр охин хоёулаа ариун сүмд гэрлэж хүүхдүүдээ Сүмд өсгөн хүмүүжүүлж байна.

- Номлолынхоо анхны долоо хоногт энэ номлогч ямар сүнслэг зорилтуудыг биелүүлэх ёстой байсан бэ? (Судрууд ашиглах, залбирах, сүнсээр заах.)
- Энэ номлогчийн сүнслэг бэлтгэлийн үр дүн нь юу байсан бэ? (Хэдий урьд өмнө хийж үзээгүй ч тэр хүүхдүүдэд сайн мэдээг заах чадвартай байсан.)
- Энэ номлогчтой адил сүнслэг бэлтгэлтэй болж чадахын тулд та нар одоо юу хийж чадах вэ?

Яриа 2

“Вилкинс ах эгч хоёрыг Атлантын далайд усан баталгаа хийлгэсний дараа Хойт Вейлзэд гурван долоо хоног гаран болж байхдаа би Английн Честер лүү шилжсэн юм. Шинэ хамтрагчтайгаа би шинэ бүс нээхээр маш хурдан ажилдаа оров. Бид олон хүмүүстэй уулзаж удахгүй амжилт олох сэтгэгдэлтэй байв. Энэ нь шинэ бүс учраас өөр пристийн зэрэгтэн байгаагүй бөгөөд арван хоёр милийн дотор өөр номлогч нар ч байгаагүй. Ажил маань сайн явж байлаа. Гэтэл нэг өглөө эрт хамтрагч маань маш их өвдөж сэрэв. Түүний мухар олгой хагарахад бэлэн байв. Надаас тэр адислаж өгөхийг гуйв. Хэдий би хэнийг ч адислаж үзээгүй боловч Их Эзэн түүнийг надаас адислал авахыг хүсэж байгааг би мэдэрсэн юм. Би тусламж гуйн залбирсан бөгөөд Есүс Христийн нэрээр түүнийг адислав. Түүний дараа миний хамтрагчид бүх юм сайнаар төгссөн юм. Түүнийг би эмнэлэгт амьд сэрүүн хүргэсэн бөгөөд тэнд тэр маш сайн халамжлагдсан юм.”

- Энэ тохиолдолд сүнслэг бэлтгэлийн шагнал нь юу байсан бэ? (Есүс өөрөө тэнд байсантай адил номлогч Есүсийн өмнөөс үйлдэхэд бэлтгэгдсэн.)
- Энэ номлогчтой адил байхын тулд одоо та нар ямар сүнслэг бэлтгэл хийж чадах вэ? (Мелкизедек Пристийн Зэргийн ба тэр пристийн зэргийн ёслолуудыг хэрхэн гүйцэтгэх тухай сурах мөн зохистойгоор ариун пристийн зэргийг хэрэглэхэд хүнд ямар сүнслэг чанарууд тусалдаг болохыг сурах.)

Яриа 2-ын үргэлжлэл

“Миний хамтрагч мухар олгойн хагалгаа хийлгэсэн тул би зуун милийн зайтай Английн Мансфил руу шилжиж очив. Тэнд шинэ хамтрагч маань хоёр сар болсон байсан бөгөөд нэлээд хэдэн хүнд заасан ч тэд нар нь Сүмийг нэг их сонирхохгүй байв. Шинэ гэр бүлүүдэд заахын төлөө мацаг барьж залбирья хэмээн хамтрагч маань надад санал болгов. Тэр үед ойролцоогоор хорин таван гишүүн сүмд тогтмол ирдэг байв. Мацаг барьж дуусахдаа Их Эзэн илүү олон хүмүүст заахыг биднээс хүсэж байна гэсэн итгэлийн мэдрэмж бид хоёрт төрөв. Гурван долоо хоногийн дотор ойролцоогоор дөчин таван хүн ирж байсны бараг тал хувь нь бидний шинэ сонирхогчид байв. Зааж мөн усан баталгаа хийн олон сар бид завгүй байсан юм.”

- Энэ нөхцөлийн сүнслэг бэлтгэлийн шагнал нь юу байсан бэ? (Хэсэг хугацаанд тэр хэсэгт Сүм маш хурдан өссөн.)
- Ямар төрлийн сүнслэг бэлтгэл эдгээр хоёр номлогчийг өөрчилсөн бэ? (Тэд зорилготойгоор мацаг барьж залбирах боломжтой байсан ба тэдний дунд нэгдмэл байдал байсан.)

Дүгнэлт

Тараах материал
ба уриалга

Хүмүүс мөнхийн амьдралынхаа замд тусламж авах нь номлолын жинхэнэ үр жимс гэдгийг тайлбарла. Залуу эрэгтэйчүүдийн одоо хөгжүүлж буй сүнслэг чадамжууд тэднийг амжилттай сайн номлогч болоход нь тусална.

“Номлолд Сүнслэгээр Бэлтгэх Замууд” тараах материалыг ангид буюу гэртээ бөглөж болно

Залуу эрэгтэй бүрийг дараах зүйлсийг хийхийг хүс:

1. Тараах материалын хуудсаны доод тал дахьсудруудыг уншаад хоосон зайд нь сүнсэг бэлтгэлийн төрөлд тохирох судрын заалтыг бичих. Төрөл бүртэй хамт явах асуултуудад хариулах. Номлолд сүнслэгээр бэлтгэхийн тулд хийх зарим зүйлийг сануулах газар цаасаа байрлуулах.
2. Сүнслэгээр бэлтгэсэн номлогч байхад туслахыг өнөөдрөөс эхлэн өдөр бүр Тэнгэрлэг Эцгээс гуйх.
3. Ирэх долоо хоногт номлогчийн хувьд хэн нэгэнд зааж болох хоёр түүх судраас олох.

Номлолд Сүнслэгээр Бэлтгэх Замууд

Хуудасны доод тал дахь судар бүрийг олоод унш. Зөв бэлтгэлийн төрөлтэй нь тохируулж тухайн төрлийн сүнслэг бэлтгэлийн тухай асуултанд хариул.

1. Хувийн Зохистой Байдлаар

Судар _____

Бусдад сайн мэдээг заах чадвартай байхад зохистой байх нь яаж туслах вэ?

2. Мацаг болон Залбирлаар

Судар _____

Сүнслэгээр хэрэгтэй номлогч байхад мацаг барьж болон залбирч сурах нь хэрхэн туслах вэ?

3. Дуулгавартай байдал ба Бүхнээ Зориулснаар

Судар _____

Хэрэв дуулгавартай байдал ба бүхнээ зориулахыг сурчихвал та нар хэрхэн роботыг бодвол сүнслэгээр бэлтгэгдсэн байж чадах вэ?

4. Судар Уншсанаар

Судар 1 _____

Судар 2 _____

Судраас уншиж судалснаар та нар хэрхэн илүү сүнслэгээр бэлтгэгдсэн номлогч байх вэ?

Судрууд:

Алма 17:2

Алма 17:3

Сургаал ба Гэрээ 4:2

Сургаал ба Гэрээ 42:12

Сургаал ба Гэрээ 105:35

ЗОРИЛГО

Ариун сүмийн гэрлэлтийн адислалуудад зохистойгоор бэлтгэх нь залуудаа бодолтойгоор төлөвлөхийг шаарддаг гэдгийг залуу эрэгтэйчүүд ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаа.
2. Бишоп буюу салбарын ерөнхийлөгчөөсөө ариун сүмийн ярилцлагын асуултуудын хувь олж авах.
3. *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимлын 7-р хуудсан дахь болзооны тухай зөвлөмжийг тоймло.

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

Түүх

Ариун Сүмийн Гэрлэлт Бол Адислал

Та ахлагч Брус Р. МакКонкийн дараах түүхийг ярих үед тэдний хамгийн агуу адислал нь юу байсан тухай дотроо бодохыг залуу эрэгтэйчүүдээс хүс.

“Бидэнд ирсэн олон адислалуудаа тоолон эхнэр бид хоёрын хооронд чухал ярилцлага болж байв. Бид Сүм байгаа учраас, бидний гэр бүл байгаа учраас, агуу мөнхийн үнэний дахин сэргэлт энэ өдрүүдэд болсны улмаас бидэнд ирсэн олон зүйлсийг нэрлэж байсан бөгөөд тэр ярилцлагыг өндөрлөж ‘Амьдралд чинь ирсэн хамгийн агуу адислал чинь юу вэ?’ хэмээн асуув.

“Би нэг ч хором эргэлзэлгүй, ‘Надад ирсэн агуу адислал бол 1973 оны арван сарын арван гурванд 11:20 цагт намайг.’ . . .

Энэ үед түүхээ зогсоогоод дараах асуултыг асуу:

- Ахлагч МакКонкийн агуу адислал нь юу байсан гэж та нар бодож байна вэ?

Залуу эрэгтэйчүүдийг хариулахыг хүлээгээд түүхээ дуусга.

“ . . . Солт Лэкийн ариун сүмд өвдөглөн суугаад чамайг мөнхийн хамтрагчаа болгон авч байсан тэр давуу эрх.”

“‘За, чи шалгалтаа давлаа,’ хэмээн тэр хэлсэн юм.

“Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн энэ дэлхийд хийдэг хамгийн чухал нэг зүйл бол зөв хүнтэйгээ, зөв газар, зөв эрх мэдлээр гэрлэх явдал бөгөөд Хожмын Үеийн Гэгээнтэн ямар ч хүнд үлдсэн хамгийн чухал хийж чадах зүйл бол гэрээнүүдийн хугацаа ба болзол нь . . . одоо бөгөөд үүрдийн мөнхөд . . . холбоотой байх явдал юм” (Bruce R. McConkie, “Agency or Inspiration?” *New Era*, Jan. 1975, p. 38).

- Тэнгэрлэг Эцэг яагаад өөрийнхөө хөвгүүд охидоос Ариун сүмд гэрлэхийг хүсдэг вэ?

Самбарт залуу эрэгтэйчүүдийн хариултыг жагсаа.

Энэ асуултанд хариулахад нь туслахын тулд Сургаал ба Гэрээ 131:1–4-ийг залуу эрэгтэйчүүдээр уншуулж тэмдэглүүл. Ариун сүмийн гэрлэлт нь хамгийн дээд хаант улсад ороход хэрэгтэй гэдгийг онцлон хэл. Тиймээс, ариун сүмийн гэрлэлт нь Тэнгэрлэг Эцэгээс ирсэн сонгомол адислал юм.

Самбар, судар
ба ярилцлага

Ишлэл

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл ийн хэлсэн:

“Их Эзэн Адам Ева хоёрыг хамтад нь авчирч, ариун гэрлэлтийг гүйцэтгэж, тэднийг эхнэр нөхөр болгожээ. . . .

“Гэрлэх нь ердийн зүйл бөгөөд хүүхэд төрүүлэх нь ч ердийн юм. . . .

“Хүн бүр гэрлэхийг хүсэх ёстой бөгөөд хүн бүр гэрлэхээр төлөвлөх ёстой. . . .

“Гэрлэлт бүх шийдвэрүүдийн дотроос магадгүй хамгийн амин чухал бөгөөд алс ирээдүйн нөлөөтэй учир нь зөвхөн цаг зуурын аз жаргал бус харин мөнхийн баяр баясгалантай холбоотой ” (address given at Salt Lake Institute of Religion, 22 Oct. 1976).

Зөвлөхийн танилцуулга

Бид Ариун Сүмийн Гэрлэлтийн Адислалуудыг Хүлээн Авахуйц Зохистой Байх Ёстой

Ариун Сүмийн цаг зуурын аз жаргал, мөнхийн баяр баясгаланг хүлээн авахын тулд бид ариун сүмд орж эдгээр адислалуудыг хүлээн авахуйц зохистой байх ёстой гэдгийг тайлбарла.

Ариун сүмд орохыг хүссэн Сүмийн гишүүд бишоп буюу салбарын ерөнхийлөгч болон гадас буюу номлолын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнтэй ярилцлаганд орох ёстой.

Түүний дараа жил бүр гишүүд ариун сүмд үргэлжлүүлэн орохыг хүсвэл эдгээр пристийн зэргийн удирдагчидтай ярилцлагад орж хувийн зохистой байдлаа тодорхойлуулдаг. Хэрэв эдгээр ахан дүүс тухайн гишүүнийг зохистой гэж үзвэл тэр эрэгтэй эсвэл эмэгтэйд ариун сүмийн зөвшөөрлийг өгнө.

• Ариун сүмийн зөвшөөрлийн ярилцлагын үеэр ямар асуултууд асуудаг вэ?

Залуу эрэгтэйчүүдийн хариулахыг хүлээгээд, ариун сүмийн зөвшөөрлийн ярилцлагын үеэр асуудаг гол асуултуудыг уншиж өгнө гэдгээ залуу эрэгтэйчүүдэд хэл. Залуу эрэгтэй бүр асуултуудад дотроо шударгаар хариулах ёстой. Эдгээр асуултуудад чангаар хариулахгүй гэдгийг ойлгуул. Асуултуудын дараа залуу эрэгтэйчүүд үргэлжлүүлэн хийх болон сайжруулах шаардлагатай зүйлүүдээ мэдэж авах ёстой.

Залуу эрэгтэйчүүдэд ариун сүмийн зөвшөөрлийн асуултуудыг уншиж өг.

Эдгээр нь Их Эзэний гэрт ороход зориулан бидэнд тогтоож өгсөн жишиг гэдгийг залуу эрэгтэйчүүдэд сануул. Эдгээр шаардлагуудыг хангах нь бидэнд баяр баясгалан, аз жаргал авчирдаг.

Ишлэл

• Та нар хэзээнээс эхлэн ариун сүмийн гэрлэлтэнд бэлтгэх ёстой вэ?

Энэ асуултанд хариулахад нь туслахын тулд Ахлагч Харолд Б. Лигийн дараах мэдэгдлийг унш:

“Залуучууд Их Эзэний Гэр лүү зөв цагт явахдаа зохистой байж ариун сүмийн ёслолуудаар ариусгагдаж урамшуулагдахын тулд өнөөдрөөс эхлэн амьдралаа зохион байгуулах ёстой” (“Enter a Holy Temple,” *Improvement Era*, June 1967, p. 114).

Яг одоо ариун сүмд орохуйц зохистой байхад бэлтгэх цаг мөн гэдгийг тодотгон хэл. Их Эзэн биднээс юу шаардаж байгааг бид мэдэх ба үүнийг хийх ёстой.

Ярилцлага

Сэлэсчел Гэрлэлтэд Бэлтгэхэд Хувийн Хичээл Зүтгэл Шаарддаг

Их Эзэний ариун сүмд орох шаардлагад биднийг тохирохгүй байлгахын тулд Сатан бид нараар нүгэл хийлгүүлэхийг маш шаргуу хичээдэг гэдгийг онцлон хэл. Ийм учраас сэлэсчел гэр бүл болоход хувийн хичээл зүтгэл хэрэгтэй.

• Сэлэсчел гэрлэлтэнд бэлтгэхийн тулд одоо та нар ямар зүйлсийг хийж чадах вэ?

Хариултуудад : Их Эзэний тушааснаар Бурхан болон хөршөө хайрлах, шударга байх, цэвэр ариун байх, тогтмол залбирах, пристийн зэрэгтнийг дэмжих, хүндэтгэх,


аравны нэгээ бүрэн төлөх, мацгийн хуулийг биелүүлэх, Мэргэн Ухааны Үгийг сахих, сайн үлгэр жишээ үзүүлэх, цэвэр үг хэллэг хэрэглэх, эцэг эхээ хүндэтгэх зэрэг багтаж болно.

Хэрэв зарлигуудыг нь сахвал Их Эзэн тэдэнд ариун сүмд гэрлэх амлалтыг нь биелүүлэхэд нь тусална гэж залуу эрэгтэйчүүдэд баталж хэл.

Залуу эрэгтэйчүүдийн нас болон нөхцөл байдлаас шалтгаалан *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимлын 7-р хуудсан дахь болзооны тухай зөвлөгөөг ярилцаж болно.

Самбар, ишлэл
ба ярилцлага

Самбарт дараах схемийг зурж Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболлын өгсөн ариун сүмийн гэрлэлтийн хувийн бэлтгэлд туслах дараах зөвлөмжийг анхааруул. Схемийг харуулсны адил зурж таныг ишлэлийг унших үед залуу эрэгтэйчүүдээр хэсэг бүрийг гарчиглуул.



“Сионы гадаснууд руу очиж надад хамгийн чухал гэж санагдах зүйлсийг яруу тодоор үзүүлэхийн тулд Би самбар ашигладаг. . . . Би самбарт хэдэн тойргууд зурах бөгөөд хамгийн дээд талд нь ‘Мөнхийн амьдрал буюу Өргөмжлөл’ гэж бичдэг. . . .

“Цөөхөн хэд маань олох мөнхийн амьдрал руу хөтөлсөн нарийн ба шулуун шугамыг доош дагавал хоёр дахь тойрогт ‘Мөнхийн Гэрлэлт’ байна. Тэр бол өргөмжлөл рүү орох хаалга юм. . . .

“Тэгээд би ерөнхийдөө гурав дахь тойргийг самбарт зурах ба Сүм доторх сонголтуудаас мөнхийн амьдралд хүрэх хойшлуулшгүй зорилт болох мөнхийн гэрлэлтэнд энэ тойргийг бөглөхөд аль нь хамгийн хойшлуулашгүй буюу чухал хувь

нэмэр оруулах вэ хэмээн асуудаг. Тэд бодож чадах бүх зүйлийг хэлдэг . . . Эцэст нь, бид мөнхийн амьдралд хамгийн чухал нөлөө үзүүлэх тэд бүгдийн хүлээн зөвшөөрсөн нэг сонголт дээр тогтоно. Тэр бол мэдээж, номлол. . . .

“Номлолд нэр төртэй үйлчилж хүндэтгэлтэйгээр буцаж ирсэн бүх залуу эрэгтэй болон залуу эмэгтэйчүүдийн 80–90 хувь нь эцэстээ ариун сүмд гэрлэдэг. . . .

“Бид мөнхийн амьдралд хүргэдэг энэ нарийн ба шулуун замаас доош нь дахин нэг тойрог зурна. Дараагийн тойрогт та нар юу бичих вэ? гэсэн асуулт гарч ирдэг.

“За ингээд, тэнд зөвхөн ганцхан зүйлийг бичих л үлдлээ . . . тэр бол семинар ба институтын хөтөлбөр юм” (Circles of Exaltation, “summer school devotion address, Department of Seminaries and Institutes of Religion, Brigham University, 28 June 1968).

- Номлолд үйлчлэх нь та нарыг гэрлэлтэнд хэрхэн бэлтгэж чадах вэ?
- Та нар гэрлэлтэнд туслах ямар зүйлийг номлолоос сурна гэж найдаж байна вэ?
- Семинар ба институт ариун сүмийн гэрлэлтэнд та нарыг хэрхэн бэлтгэж чадах вэ?
- Семинарт явах нь та нарт хэрхэн тусалсан бэ?

Залуу эрэгтэй бүр шулуун бөгөөд нарийн замаар явах чадвартай бөгөөд энэ замаар явахад нь туслах хайрт эцэг эх, Сүмийн удирдагч нар тэдэнд байгаа гэдгийг онцлон хэл.

Дүгнэлт

Ишлэл	Төгсгөлд нь Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболлын бодлыг хуваалц: “Гэрлэлт, гэр бүл, орон гэр, хүүхдүүд, ач нар болон гайхамшигтай, үзэсгэлэнтэй бүхэн нь Мормонизмын эрхэмлэх зүйлс юм. Охид хөвгүүдийг, мөн хөвгүүд охидыг харж гэрлэхээр асууж цаг нь болохоор гэрлэж, мөнхөд холбогдох нь ердийн юм. Энэ нь байгалаас заяасан. Их Эзэн үүнийг хийсэн арга зам юм” (address at Young Women Seminar Banquet, Salt Lake City, 28 Apr, 1977).
Гэрчлэл	Ариун сүмийн гэрлэлтийн агуу адислалуудад баярлах ёстой гэдгийг залуу эрэгтэйчүүдэд сануул. Их Эзэн өөрийнхөө гэрт оруулах жишгийг тогтоосон бөгөөд аз жаргал, баяр баясгалан авчрах сэлэсчел гэрлэлтэнд хичээнгүйлэн бэлтгэж эхлэх цаг бол одоо юм.
Уриалга	Ариун сүмийн гэрлэлтэнд ирэх долоо хоногт бэлтгэж чадах нэг зүйл бодож олохыг залуу эрэгтэйчүүдээс хүсээд, ариун сүмийн бэлтгэлийг өдөр тутмынхаа амьдралын хэсэг болгохыг тэдэнд уриал.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр үр нөлөөтэй гэрийн багшлалтын үндсэн зарчмууд болон үүрэг хариуцлагуудыг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаа.
 - в. Залуу эрэгтэй бүрт харандаа цаас.
2. “Судрын Дүн Шинжилгээ” тараах материалын хувийг залуу эрэгтэй бүрт.

ТАЙЛБАР

Энэ хичээл сайн гэрийн багш байна гэж юу вэ гэдгийг тайлбарлах бөгөөд залуу эрэгтэй бүр хэрхэн илүү сайн гэрийн багш байхыг ойлгох болно.

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

Самбар ба
ярилцлага

Юу хийж сайн гэрийн багш болдог вэ?

- Ямар чанарууд болон дадал зуршлууд сайн хөлбөмбөгчин (буюу үндэснийхээ онцлогт тааруул) болгодог вэ? Самбарт залуу эрэгтэйчүүдийн хариултыг жагсаа.

Ямар ч сонирхолтой үйл ажиллагааг сайн болгодог чанарууд болон дадал зуршлууд байдаг гэдгийг жагсаалт хийснийхээ дараа тайлбарла.

- Ямар чанарууд болон дадал зуршлууд нь сайн гэрийн багш болгох вэ?

Самбарт залуу эрэгтэйчүүдийн хариултыг жагсаа. Тэдний хариултанд нөхөрсөг байх, бэлтгэлтэй байх, сэргэлэн байх, залбиралтай байх, тогтвортой байх, цагаа барьдаг, хамтач, сониуч, тусламтгай болон сайн үлгэр жишээ үзүүлэх зэрэг багтана.

Самбарт жагсаасан санаануудыг ярилцаж, авч үзэх шаардлагатай гэсэн зүйлээ нэм. Жишээлбэл, *залбиралтай* байхын тухай ярилцлага тань эдгээр асуултаар хөтлөгдсөн байж болно:

- Сайн гэрийн багш залбирлыг хэрхэн ашиглаж чадах вэ? (Айлчилж буй айлуудынхаа төлөө хувиараа залбирал хийх, гэрийн багшаар явахаасаа өмнө хамтрагчтайгаа хамт залбирдаг, айлчилсны төгсгөлд айлынхантайгаа хамт залбирах {гэрийн тэргүүний зөвшөөрөлтэйгээр}.)

- Илүү сайн гэрийн багш байхад залбирал хэрхэн тусалж чадах вэ?

Гэрийн багш заадаг гэр бүлийнхээ гишүүн бүрийн талаар санаа тавьдаг тухай ярилцахдаа тэр өөрийнхөө санаа зовж буйгаа харуулахаар хийж чадах зүйлсийг нь самбарт жагсааж бич. Жагсаалтанд төрсөн өдөр болон усан баталгаа, сүм дээрх яриа, ёслолууд, адислалууд, нас баралтууд гэх зэрэг онцгой тохиолдлууд; сургууль дээр, ажил дээр, сүм дээр болон олон нийтэд хийсэн амжилтуудыг; тэдэнд хувь хүний хувьд байдаг бусад хувийн сонирхлыг мэдэж байх зэрэг багтана.

Ярилцлага

- Гэрийн багшийн хувьд та нар юу заах ёстой вэ?

Айлчилж буй айлдаа зориулан чухал ач холбогдолтой захиас бичгийг бэлтгэсэн байхын чухлыг ярилц. Захиас бичгийг судруудаас, олон улсын сэтгүүлийн Тэргүүн Зөвлөлийн захиас бичгээс болон бусад Ерөнхий эрх мэдэлтнүүдийн ярианаас, пристийн зэрэгтний удирдагчаас, хэсгийн бишопоос, гэрийн багшаар явдаг гэр бүлийнхээ тэргүүний хүсэлтээс олж болно.

- Гэр бүл бүрт заах захиас бичгийг бодол санаандаа бэлтгэсэн байх нь яагаад чухал вэ? (Гэр бүл бүр тэдэнд туслахаар ач холбогдолтой бөгөөд тэдний хэрэгцээнд тохирсон онцгой захиас бичгийг зүй ёсоор хүртэх ёстой.)

Гэрийн Багшлалт бол Пристийн Зэргийн Үүрэг

Судар ба ярилцлага

Гэрийн багшлалт бол зөвхөн сайхан замаар хөршүүддээ айлчлах буюу бишоптоо туслах биш харин Их Эзэнээс пристийн зэрэгтнүүдэд илчилсэн хариуцлага юм гэдгийг тайлбарла. Залуу эрэгтэйчүүдээс Сургаал ба Гэрээг нээж 20-р хэсгийн оршлыг харахыг хүс.

- Энэ илчлэлтийг хэзээ өгсөн бэ? (Сүм дөнгөж байгуулагдаж байсан эхний үед буюу 1830 оны дөрвөн сард.)
- Иосеф Смитэд энэ илчлэлтийг хэн өгсөн бэ? (Есүс Христ.)

Есүс Христ бол Сүмийн тэргүүн гэдгийг залуу эрэгтэйчүүдэд сануул.

Залуу эрэгтэйчүүдээр 38-р шүлгийг уншуулж “прист, багш, диконы үүрэг” гэснийг тэмдэглүүл. Тэгээд тэднээр 53–59-р шүлгүүдийг уншуулж гэрийн багштай холбоотой: *анхааруулах, ойлгуулах, уриалах, заах, урих* гэсэн түлхүүр үгнүүдийг тэмдэглүүл.

Залуу эрэгтэй бүрт “Судрын Дүн Шинжилгээ” гэсэн тараах материалын хувийг өгч доогуур нь зурсан үгнүүдийг ярилц.

Үйл ажиллагаа

Самбарт 59-р шүлгэн дэх доогуур нь зурсан таван түлхүүр үгийг бич. Тэгээд залуу эрэгтэй бүр нэгийг бусад залуу эрэгтэйчүүддээ ярихаар сонгож авна. Бүгд “Би өөрийгөө хэрхэн илүү (сонгосон үг) бэлтгэж чадах вэ?” гэсэн асуултанд хариулах буюу дараахыг гүйцээнэ: “Гэрийн багшийн хувьд би (сонгосон үг) байх нь чухал, яагаад гэвэл. . . .”

Залуу эрэгтэйчүүдэд цаасан дээр анхныхаа бодсон зүйлийг бичих хоёр минут өг. Тэгээд тэднийг нэг нэгээр нь дуудаж хариулуул. Хэрэв чамд таваас бага залуу эрэгтэй байвал та тэдний сонгож аваагүй үгнүүдийн тухай ярилцах хэрэгтэй. Хэрэв ангид чинь таваас илүү залуу эрэгтэй байвал бүгдэнд нь оролцох боломж олгож зарим үгийг нэгээс илүү залуу эрэгтэйгээр ярилцуул.

Түүх

Та хичээлээ 53–59-р шүлэгт жагсаасан хариуцлагуудыг жинхэнэ ёсоор авч үзсэн гэрийн багшийн үнэн түүхээр төгсгөж болно. Түүнд Бошиглогч Иосеф Смит болон түүний гэр бүлд айлчилж очих давуу эрх байсан.

“Бошиглогч болон түүний гэр бүлд айлчлан очих багшийн үүргээсээ айх мэдрэмж төрсөн юм. Би бараг үүргээсээ зугтах сэтгэгдэл төрсөн. Эцэст нь түүний хаалган дээр очиж тогшиход минутын дараа Бошиглогч хаалган дээр ирэв. Би сүрдсэн байдалтай зогсоод түүнд:

“‘Иосеф ах аа, хэрэв энэ танд тохиромжтой бол би танайд багшийн хувьд ирлээ,’ хэмээн хэлэв.

“Тэр, ‘Виллиам ах аа, та ороод ир, би таныг харж байгаадаа баяртай байна, та тэр сандал дээр сууж бай, би яваад гэр бүлийнхнийгээ дуудаад ирье,’ гэв.

“Тэд удалгүй ирж сууцгаав. Тэгээд тэр, ‘Виллиам ах аа, би өөрийгөө болон гэр бүлээ таны гарт өглөө,’ хэмээн хэлээд суудалдаа суув. ‘Одоо, Виллиам ах аа, та өөрийнхөө асууя гэж байгаа бүх асуултыг асуу,’ гэж хэлэв.

“Тэр үед миний бүх айдсууд болон чичрэх зогсож би, ‘Иосеф ах, та өөрийнхөө шүтлэгээр амьдрахыг хичээж байгаа юу?’ гэж асуув.

“‘Тийм,’ гэж тэр хариулав.

“Тэгээд би, ‘Та гэртээ залбирдаг уу?’ гэж асуув.

“‘Тийм’ гэж тэр хэлэв.

“‘Та гэр бүлийнхэндээ сайн мэдээний зарчмуудыг заадаг уу?’

“‘Тийм, би тэгэхийг хичээж байгаа,’ хэмээн тэр хариулав.

“Та хоолоо адисладаг уу?”

“Тийм, хэмээн тэр хариулав.

“Та гэр бүлийнхээ бүх хүнтэй амар амгалан таарамжтай амьдрахыг хичээж байгаа юу?”

“Тэр, ‘тэгж байгаа,’ хэмээн хариулав.

“Тэгээд би түүний эхнэр Эмма эгч рүү эргэн, ‘Эмма эгч та өөрийнхөө шүтлэгээр амьдрахыг хичээж байгаа юу? Та хүүхдүүддээ эцэг эхдээ дуулгавартай байхыг заадаг уу? Та тэдэнд залбирахыг заадаг уу?’ гэж асуув.

“Бүх асуултанд тэр, ‘тийм, би тэгэхийг хичээж байгаа,’ хэмээн хариулж байв.

“Тэгээд би Иосеф руу эргэн хараад, ‘Би багшийнхаа асуултуудыг асууж дууслаа; хэрэв танд надад өгөх зөвлөгөө байвал би түүнийг чинь баяртайгаар хүлээн авна,’ гэж хэлэв.

“Бурхан таныг адислаг, Виллиам ах аа, хэрэв та даруу бөгөөд итгэлтэй байвал багшийн үүргээ гүйцэтгэхэд өмнө чинь тулгарах бүх хэцүү зүйлийг шийдэх хүчтэй байх болно,’ хэмээн тэр хэлэв.

“Тэгээд би багшийн хувьд түүнд болон түүний гэр бүлд өөрийнхөө адислалыг үлдээгээд явсан билээ” (William Farrington Cahoon, “Recollections of the Prophet Joseph Smith,” *Junvenile Instructor*, 15 Aug. 1892, pp. 492-93).

Дүгнэлт

Уриалга

Залуу эрэгтэйчүүдийг илүү үр нөлөөтэй гэрийн багш байх замуудыг хайхыг уриал. “Судрын Дүн Шинжилгээ” тараах материалыг эцэг эх болон гэрийн багшийн хамтрагч нартайгаа санаа олохоор ярилцахыг залуу эрэгтэйчүүдэд зөвлө.

Зөвлөхөд
анхааруулах нь

Тараах материал дээрх судрууд нь онцгойлон Аароны Зэрэг дэх багшийн үүрэгт хамаатай. Хэдий тийм ч, пристүүдэд багшийн бүх үүргүүд болон нэмэлт үүргүүд байдаг бөгөөд диконууд дуудагдвал багш нарт туслах болно.

Судрын Дүн Шинжилгээ

С ба Г 20

53. *“Багшийн үүрэг бол Сүмийг байнга харах бөгөөд хамт байж, тэднийг хүчтэй болгох юм.”*
Багшийн үүрэг: Их Эзэн үүнийг өөрөө өгсөн гэдгийг сана.
Харах: Багшийн харж болох нэг зам бол гэрийн багш.
Байнга: Сард нэг удаа айлчлах нь байнгынх уу?
54. *“Сүмд нэг ч шударга бус явдал байхгүй байгааг, мөн бие биендээ хатуурхах, мөн худал хэлэх, хов жив, болон муу ёрын зүйл ярихгүй байгааг харах.*
55. *Сүм тогтмол хамтдаа цугларч, мөн бүх гишүүд өөрсдийнхөө үүргийг биелүүлж байгааг харах.*
56. *“Ахлагч эсвэл прист байхгүй үед тэр цуглааныг удирдах болно.*
57. *“Хэрэв шаардлагатай тохиолдолд Сүм дэх бүх ажил үүрэгтээ байнга диконуудаар туслуулах болно.*
Харах: Энэ бол гэрийн багшийн “харах” хэсэг. Их Эзэний хар хэмээн хэлсэн долоон зүйлийг дугаарлаж доогуур нь зур.
Хов жив, болон муу ёрыг ярих: эдгээр шүлгүүд болон сэдвийн хөтөч хов жив, муу ёрыг ярихын утгыг бид ойлгоход хэрхэн тусалдаг вэ?
58. *“Гэвч багш болон дикон хоёрт усан баталгаа хийх, ариун ёслолыг адислах буюу гар тавин адислах эрх мэдэл байхгүй.*
59. *“Тэд анхааруулах, ойлгуулах, уриалах, заах бөгөөд бүгдийг Христэд ирэхийг урьдаг.”*
Ойлгуулах: Энэ нь хамгаалах буюу гүн гүнзгий тайлбарлах гэсэн утгатай үг юм.
Уриалах: Энэ нь хүчтэйгээр зоригжуулах гэсэн утгатай үг юм.
 Багшийн хийдэг таван зүйлийг үргэлжлүүлэн дугаарлаж доогуур нь зур.

46

Мэдээллийн Хэрэгслийн Зохисгүй Нөлөөнөөс Зайлсхийх

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр амьдралдаа мэдээллийн хэрэгслийн зохисгүй нөлөөллөөс зайлсхийхийг чармайх бөгөөд түүнийг танин мэдэх болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд:
 - а. Залуу эрэгтэй бүрт судар.
 - б. Судар тэмдэглэх харандаа.
2. (Сонголтоор.) Хэрэв боломжтой бол нэг чанасан цагаан өндөг, өндгийг давахаар ус дүүргэсэн сав; халбага; нотолгоонд зориулсан хүнсний будаг бэлтгэх. Усандаа хоолны халбага цагаан цуу хийвэл будаг өндгөнд илүү сайн шингэх болно.
3. “Мэдээллийн Нөлөөллүүдийг Үнэлж Дүгнэх Заавар” -ын гурван хэсгээс гурван зурагт хуудсыг хичээлийн төгсгөлд хэрэглэхээр бэлтгэ. Хэрэв та нар зөвхөн нэг хэсгийг нэг удаа илрүүлэхээр зохион байгуулбал самбарт бичиж болно.
4. “Мэдээллийн Нөлөөллүүдийг Үнэлж Дүгнэх Заавар” тараах материалын хувийг залуу эрэгтэй бүрт бэлтгэ.
5. *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимлын 11-12-р хуудсан дахь мэдээллийн тухай зөвлөмжийг тоймло.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Ярилцлага


Мэдээллийн Хэрэгслийн Зохисгүй Нөлөөллүүд Бол Сатаны Хамгийн Хүчтэй Зэвсэг Мөн

- Гэр доторх бүтээгдэхүүнүүдээс ашигтай болон хортой ямар зүйлийг та нар нэрлэж чадах вэ? (Шавьж устгах бодис, спрей, химийн ба цэвэрлэх бодисууд, бензин, эм.)
- Эдгээр бүтээгдэхүүнүүд юугаараа ашигтай вэ?
- Эдгээр нь юугаараа хортой байж болох вэ?

Яаж хэрэглэж байгаагаас шалтгаалан эдгээр нь ашигтай эсвэл хортой байж болно гэдгээр төгсгө.

Самбар ба
ярилцлага

Самбарт гавал болон зөрүүлсэн хоёр яс зур.



• Хэрэв бүтээгдэхүүн дээр энэ нийтлэг тэмдгийг харвал та нар юу боддог вэ? (Энэ нь хэрэв хортой бодисыг буруугаар хэрэглэвэл бие махбодид юу болж болохыг сэрэмжлүүлэн үзүүлсэн зураг.)

Бидний амьдралд ашигтай, урамшуулам хүчирхэгжүүлэх зүйлээс гадна хортой, бүр бидний үхэлд хүргэхээр өөр олон зүйлс байдаг гэдгийг тайлбарла.

• Эдгээр нөлөөнүүдийг юу байж болно гэж та нар бодож байна вэ?

Залуу эрэгтэйчүүдэд бодох болон саналаа хэлэх цаг гарга. Тэднийг олон нийтийн хэвлэл мэдээлэл болох сэтгүүл, хөгжим, зурагт, кино зэргийг санал болгоход нь хөтөл. Самбарт залуу эрэгтэйчүүдийн саналуудыг самбарт бич.

• Эдгээр нь сайн зүйлд хэрхэн хэрэглэгдэж болох вэ?

• Эдгээр нь хэрхэн хортой байж болох вэ? (Эдгээр нь ёс суртахуунгүй бөгөөд бузар зүйлд хэрэглэгддэг.)

Ишлэл ба ярилцлага Тэргүүн Зөвлөлийн дараах мэдэгдлийг унш:

“Бузар зүйлийн хохирол учруулах нөлөөллийн асар олон нотолгоо байдаг. . . .

“Энэ бузар зүйлс нь хэвлэгдэж, хальс хуурцганд бичигдэж, зурагтаар буюу кинонд гарах нь ихээр өсөж байгаад бид маш их сэтгэл зовж байна. . . .

“Бид Хожмын Үеийн Гэгээнтнүүдийг эдгээр хор хөнөөлтэй бүх бузар зүйлсээс зайлсхийхийг зөвлөж байна ” (First Presidency statement, *Church News*, 7 Oct. 1972, p. 5).

• Тогтмол өдөөсөн хөгжим, порнографи сэтгүүл, ёс суртахуунгүй кино, зурагтын хөтөлбөр болон архи тамхины сурталчилгаа ямар хортой нөлөө үзүүлдэг гэж та нар бодож байна вэ?

Оюун санаанд ургасан бодлууд тэндээ үүрд үлддэг гэдгийг залуу эрэгтэйчүүдэд ойлгуул. Муу ёрын бодлууд сайн муу хоёрыг ялгах мэдрэмжгүй болгодог. Тэд эрүүл санаануудыг шахан зайлуулж Ариун Сүнснийг бидэнтэй үлдэж чадахааргүй болгодог.

Ишлэл

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл биднийг мэдээллийн хэрэгслийн зохисгүй нөлөөллүүдэд өртөх аюулын үр дагавраас сэрэмжлүүлэхдээ: “Мэдээж, эмгэнэлтэй явдал нь . . . ихэнхдээ (порнографи) кино театрт очих буюу бузар сэтгүүлийг эргүүлснээр эхэлдэг. Нууцаар явалдах, садар самуун явдал, ижил хүйстэнтэйгээ явалдах эмгэнэлтэй нүгэлд хүрэх зам нь одоо телевиз буюу телевизийн сүлжээгээр гаргаж буй секс-хүчирхийллийн чиглэлийн хөтөлбөрүүдийг үзсэнээр эхэлдэг” гэжээ (in Conference Report, Oct, 1976, p. 6; or Ensign, Nov. 1976, p. 6).

Залуу эрэгтэйчүүдэд мэдээллийн хэрэгслийн зохисгүй нөлөөллүүдийн үр нөлөө нь гэнэт гарч ирдэггүй гэдгийг ойлгуул. Бид аажим аажмаар, бага багаар, өдөр өдрөөр, долоо долоо хоногоор бодитойгоор харж чадахгүй болтлоо сохорч Их Эзэний Сүнсэнд мэдрэмжгүй болтлоо сүнслэгээр өөрсдийгөө зэврүүлэн нүгэл рүү хөтлөх нүгэл хилэнцийн нөлөөнд хучигдан орно.

Зурагт хуудас

“Сатаны Зэвсгүүд” зурагт хуудсыг үзүүлэх буюу самбар дээрээс эхний жагсаалтыг ав.

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл энэ сүнслэг элэгдэл хэрхэн бий болдгийг дүрслэхдээ: “Люцифер бузар төлөвлөгөөгөөрөө болгоомжгүй нэгнийг хуурдаг бөгөөд өөртөө байгаа бүх л багаж зэвсгээ ашигладаг. . . .

“Тэр (зурагт хуудас руу заа) [1]логикоороо будлиулан [2] оновчтой явдлаараа сүйтгэдэг. Тэрээр [3] утгыг саармагтуулж [4] хаалга үүдийг бага багаар онгойлгож [5] хамгийн цэвэр цагаанаас сааралтуулан хав харанхуй руу хөтөлдөг” (“President Kimball Speaks Out on Morality,” *Ensign*, Nov. 1980, p. 94; numerals added).

Жагсаасан “зэвсгүүдийг” ярилц.

Сонголтоор хийх нотолгоо ба ярилцлага

Люциферийн багажнууд болон арга барилууд хэрхэн бага багаар бидэнд үнэхээр нөлөөлдгийг харуулахаар дараах нотолгоонуудыг гүйцэтгэ. Хүнсний будганд чанасан өндгийг зөвхөн ганц удаа дүр. (Энэ нь порнографи зураг ганц удаа харахыг төлөөлж болно.) Өндөг ялимгүй будагдсан байна. Тэгээд өндгийг дахин будаж шингэнийг халбагаар олон удаа түүн дээр асга. (Энэ нь Балиар онигоо,

порнографи кино, уруу татсан дууг төлөөлж болно.) Өндгийг хүнсний будгаар будах бүрт түүний хальс бараан сүүдэртэй болж байгааг залуу эрэгтэйчүүдэд үзүүл.

• Ийм тасралгүй зэврэлт нь хаашаа хөтөлж болох вэ?

“Энэ бүхэн надад ямар хамаатай вэ? Би тийм зүйл намайг өөрчлөхийг зөвшөөрөхгүй. Би түүнээс хүчтэй,” хэмээн залуу эрэгтэйчүүд бодож байж болно гэдгийг хэл.

• Ингэж бодох нь ямар буруу талтай вэ?

Залуу эрэгтэйчүүд магад тэд бусдад нөлөөлдөгтэй адил энэ нь биечлэн тэдэнд нөлөөлөхгүй хэмээн бодож магадгүй. Хэдий тийм ч энэ нь Ерөнхийлөгч Кимболлын хэлсэнчлэн хамаарлын хэм хэмжээ байж болно. Эдгээрийн муу нөлөө нь анзаарагдахааргүй нэвтэрсээр сүүлд нь арилгахад ч боломжгүй болж мэднэ.

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр 2 Нифай 28:20–22 ба Моронай 9:20-ийг уншуулж тэмдэглүүл.

• “Зарчим үгүй, мөн мэдрэхээс өнгөрсөн” гэж юу гэсэн утгатай вэ?

• Бид сайн, мууг ялгаж салгах чадвараа алдталаа эргэн тойронд ийм нөлөөлөлтэй хэрхэн дассан байж болох вэ?

• Зохистой жишгүүд бидэнд энэ аюулаас зайлсхийхэд хэрхэн тусалж чадах вэ?

Бид Мэдээллийн Нөлөөллүүдийг Шүүн Дүгнэж Зохисгүй Нөлөөллөөс Зайлсхийх Ёстой

Зурагт хуудас ба ярилцлага

• Ямар нэг юмны сайн мууг шүүх ямар жишгийг бид хэрэглэж болох вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон бидэнд мэдээллийн нөлөөллүүдийг шүүж дүгнэх заавар болгон зарим жишгийг өгсөн. Хэдий тэр голчлон бидний уншдаг ном руу хандсан ч эдгээр жишгийг бусад мэдээлэлд мөн ашиглаж болно.

“Мэдээллийн Хэрэгслийн Нөлөөллүүдийг Дүгнэх Жишгүүд” гарчигтай зурагт хуудсыг үзүүлэх буюу самбарт өмнө нь бичсэн дараах жишгүүдийг нээ:

“Өнөөдрийн ном элбэг байгаа үед юу уншихгүй байхаа мэдэх нь жинхэнэ боловсролтой хүний шинж юм. . . . Жоон Вислийн ээж түүнд ийнхүү зөвлөжээ: “[1] ухаан бодлыг чинь доройтуулж, [2] зөв бурууг ялгах мэдрэмжийг чинь мохоож, [3] Бурханыг мэдрэх мэдрэмжийг чинь бүдгэрүүлж, [4] сүнслэг зүйл хийх урам зоригийг чинь авч, . . . [5] бие чинь ухааныг чинь давамгайлан захирах эрх мэдлийг өсгөх бүх л зүйлээс зайлсхий.

“Ном хуучных байна гэдэг нь заавал энэ нь үнэ цэнэтэй сайн байх ёстой гэсэн үг биш юм. Нэг зохиолч нэг сайн бүтээл хийсэн байлаа гэхэд энэ нь түүний бүх ном сайн байна гэсэн үг биш юм. Өөрийнхөө оюун санааг бусад хүмүүсийн хогоо хаядаг газар бүү болго. Биеийг муу хүнснээс цэвэрлэхээс оюун санааг уншсан муу зүйлээс цэвэрлэх нь илүү хэцүү байдаг бөгөөд энэ нь сүнсийг илүүтэйгээр сүйтгэдэг” (“In His Steps,” 1979 *Devotional Speeches of the Year* [Provo, Utah: Brigham Young University Press, 1980], p. 61).

Оюун ухаан, ухамсар, сүнслэг байдалд нөлөөлдөг таван нөлөөлөл тус бүрийг ярилц. Мэдээллийн зохисгүй нөлөөллүүд нь Ариун сүнсийг зайлуулж биднийг хамгаалалтгүй үлдээдэг гэдгийг ойлгоход нь залуу эрэгтэйчүүдэд тусал.

• Ямар зүйл үзэж болон уншихаа шийдэхдээ та нар энэ таван жишгийг хэрхэн хэрэглэх вэ?

Моронай 7:15–17-г залуу эрэгтэйчүүдээр уншуулж тэмдэглүүл.

• Энэ судар кино болон телевизийн хөтөлбөрийг шүүх талаар бидэнд ямар заавар өгч байна вэ?

• Анх тааралдсан газартаа бид ийм нөлөөллүүдээс хэрхэн зайлж чадах вэ?

• Муу ёрын болон зохисгүй нөлөөллүүдийг илрүүлэхдээ бид юу хийж болох вэ?

Зурагт хуудас
ба ишлэл

“Мэдээллийн хэрэгслийн зохисгүй нөлөөллөөс хэрхэн зайлах вэ?” гэсэн гарчигтай зурагт хуудсыг үзүүл.

Бишоп Х. Бүрк Петерсон дараах зөвлөмжийг өгсөн юм:

“Бид зохисгүй кино үзэж буюу түүний тухай ярих ёсгүй юм. Порнографи сэтгүүл, зурагнууд, болон түүх байх ёсгүй. Та нар зохисгүй киноноос гараад явах зоригтой юу, аль эсвэл та нар үзэж сонсоод өөртөө ‘Энэ удахгүй дуусна,’ эсвэл ‘Хүн бүхэн л ингэдэг; ийм үзвэр үйлчилгээ байх ёстой,’ хэмээн хэлдэг үү? Гэртээ секс яриа болон тэр ч бүү хэл үйл явдалтай телевизийн хөтөлбөрийг байлгахгүй байх зориг та нарт байгаа юу? Хамгийн хүчтэй сүнсэнд ч нэвтрэн ороход эдгээр үзвэрүүд нөлөөлдгийг бодож үзсэн үү? Бид өөрсдийгөө өдөр тутмын хогоор тэжээх ёсгүй” (in Conference Report, Oct. 1980, pp. 56–57; or Ensign, Nov. 1980, pp. 38–39).

Нөхцлийн судалгаа
ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээс дараах Нөхцөлийн судалгаан дахь асуудлуудад эдгээр санаануудыг заавар буюу боломжтой шийдвэр гаргахаар бодож байхыг хүс.

Дэвид дүрс бичлэгийн хуурцаг үзүүлж байсан үдэшлэгт уригджээ. Өмнө нь тэр кино зохимжгүй байсныг олж мэдээд найзуудыгаа үүнийг солихыг ятгаж чадсан байна. Гэвч дараа нь адилхан нөхцөлд Дэвид ямар үзүүлбэр байгааг урьдчилан мэдээгүй байна. Энэ кино нь сонинд маш сайхнаар бичигдэж түүнийг ихэнх найзууд аль хэдийн үзчихсэн байв. Түүнийг тэд үзүүлж эхлэнгүүт Дэвид дэлгэцэн дээр түүнийг тайван бус байлгах зүйлийг сонсож харж байв.

- Ийм нөхцөлд Дэвид юу хийх ёстой вэ?

Кэлигийн хамгийн сайн найз нь шинэ чихэвчээ байнга зүүн өөрийнхөө хамгийн дуртай радиогийн сувгийг сонсож байх шиг байв. Нэг өдөр Кэли тэр хоёр тэр радиогийн сувгаар байнга юу явдаг тухай ярилцав. Даринаас, хөгжим нь олон янзын ёс суртахуунгүй зүйл зөвлөдөг байхад яагаад үүнийг сонсдогийг нь Кэли асуужээ. Дарин хөгжмийн хэмнэл аялгуунд нь дуртай бөгөөд үгийг нь нэг их анзаардаггүй хэмээн хариулжээ.

- Хэдий тэр байнга тэднийг сонсдоггүй ч Даринд дууны үг ямар нөлөө үзүүлж болох вэ? Кэли Даринд юу хэлж болох байсан вэ?

Залуу эрэгтэйчүүдийг бусдыг гомдоохгүй хариулт руу хөтөл. Тэд бусдыг буруушаахгүйгээр хэрхэн өөрсдийнхөө жишгийг бий болгохыг сурах хэрэгтэй.

Нэг гэр бүлийн аав гэр бүлээрээ үзэхээр төлөвлөсөн кино нь гарч буй театр руу утасдав. Менежер түүнд “гэр бүлээрээ үзэж болохоор” хэмээн хэлжээ. Тэд хүрч ирээд хамгийн эхний үйл явдал нь илэрхий унтлагын өрөөний үйл явдал байв. Тэд гэр бүлээрээ театраас гарч явжээ.

- Энэ аав хүүхдүүддээ юу заасан бэ?

- Сатан ямар зэвсэг хэрэглэж байна вэ?

Росс хэсэг найзуудынхаа хамт саяхан тэнд нүүж ирсэн Паулинд айлчилж байв. Паул шүүгээнийхээ шургуулга руу гараа явуулан хэдэн порнографи сэтгүүлүүд гаргаж ирэв. Тэрээр, ‘Үүнийг үзэцгээ!’ гэв.

- Росс юу хэлж юу хийх ёстой байсан вэ?

- Энэ яагаад хэцүү байж болох вэ?

Ишлэл ба ярилцлага

Ерөнхийлөгч Бэнсон: “Та нарт тулгарах хамгийн агуу тулаан бол өөрийнхөө бие доторх чимээгүй зайнуудтай байлдах явдал байх болно” гэжээ (“In His Steps,” p. 60).

Зарим үед зөвхөн бид л телевизийн хөтөлбөр үзэж буй болон хүнсний дэлгүүрт тавьсан сэтгүүлүүдийг үзэж буй хүн байдаг. Залуу эрэгтэйчүүдээс гэртээ өөр хэн ч байхгүй үед ямар телевизийн хөтөлбөр үздэг вэ гэдгээ дотроо бодохыг хүс.

- Ийм нөхцлүүдэд ямар нэг зохимжгүй зүйл үзэхийг ятгахаар ямар зэвсгийг Люсифер хэрэглэх вэ?

Хэрэв танд цаг гарвал *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө товхимлын* 11, 12-р хуудсан дахь мэдээллийн тухай зөвлөмжийг ярилцаж болно.

Дүгнэлт

Зөвлөхийн
танилцуулга

Мянга мянган хүмүүсийн амьдралд ирдэг тул олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нөлөөлөл газар авч байна. Энэ нь сайн эсвэл муугийн агуу хүч болж чадна. Бид мэдээллийн хэрэгсэлд сайныг нь хайж дэмжиж зохисгүйгээс нь зайлах ёстой. Бид хүсүүштэй бүтээгдэхүүн ба номнуудыг хайж мөн хүлээх хэрэгтэй. Бид өдөр бүрийн сонголтондоо хязгаарлал, хувийн сахилга баттай байж, уншиж буй, үзэж буй, сонсож буй зүйлдээ сонголттой байх хэрэгтэй.

Уриалга

“Мэдээллийн Нөлөөллүүдийг Дүгнэх Заавар” тараах материалын хувийг залуу эрэгтэйчүүдэд өг. Тэднийг амьдралдаа энэ зааврыг мэдээллийн зохисгүй нөлөөллөөс зайлсхийхэд хэрэглэхийг уриал. Энэ тараах материалыг тэмдэглэлийн дэвтэрдээ хийхийг тэдэнд зөвлө. Зохистой сонголт хийхийн тулд *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө товхимол* дахь мэдээллийн тухай зөвлөмжийг байнга давтаж байхыг залуу эрэгтэйчүүдэд хэл.

Мэдээллийн Нөлөөнүүдийг Дүгнэх Заавар

САТАНЫ ЗЭВСГҮҮД

Будлиулахын тулд логик ашигладаг.

Оновчтой явдлаараа сүйтгэдэг.

Утгыг саармагтуулдаг.

Хаалга үүдийг бага багаар онгойлгодог.

Хамгийн цэвэр цагаанаас сааралтуулан хав харанхуй руу хөтөлдөг.

(Spenser W. Kimball, "President Kimball Speaks Out on Morality," *Ensign*, Nov. 1980, p. 94-ыг үз.)

МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН НӨЛӨӨЛЛҮҮДИЙГ ДҮГНЭХ ЖИШГҮҮД

Дараахаас зайлсхий—

Ухаан бодлыг чинь доройтуулах,

Зөв бурууг ялгах мэдрэмжийг чинь мохоох,

Бурханыг мэдрэх мэдрэмжийг чинь бүдгэрүүлэх,

Сүнслэг зүйл хийх урам зоригийг чинь авах,

Бие чинь ухааныг чинь давамгайлан захирах эрх мэдлийг өсгөх бүх л зүйлээс зайлсхийх.

(Ezra Taft Benson, "In His Steps," in *1979 Devotional Speeches of the Year* {Provo, Utah: Brigham Young University Press, 1980}, p. 61-ыг үз.)

МЭДЭЭЛЛИЙН ЗОХИСГҮЙ НӨЛӨӨНҮҮДЭЭС ХЭРХЭН ЗАЙЛСХИЙХ ВЭ?

Та нар—

Зохисгүй кинонуудыг үзэж буюу түүний тухай ярихгүй байх,

Порнографи сэтгүүлүүд, зурагнууд болон түүхүүдээс зайлсхийх,

Өдсөн үгтэй хөгжим сонсохгүй байх,

Зохисгүй киноноос гараад явах зоригтой байх,

Гэртээ өдсөн яриа болон үйл явдалтай телевизийн хөтөлбөрүүдийг байлгахгүй байх ёстой.

(H. Burke Peterson, in *Conference Report*, Oct. 1980, pp. 56–57; or *Ensign*, Nov. 1980, pp. 38–39-ыг үз.)

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр байнга цэвэр боловсон хэл яриа хэрэглэх хүсэлтэй байх болно.

БЭЛТГЭЛ

1. Шаардагдах материалууд: Залуу эрэгтэй бүрт судар.
2. Хичээлийн эхэнд байгаа дөрвөн түүх бүрийн хувиудыг “Дөрвөн Түүх” гэсэн гарчигтай тараах материалаас бэлтгэ. Пристийн зэргийн цуглаан дээр түүх бүрийг уншихаар бэлтгэ хэмээн өөр өөр залуу эрэгтэйчүүдийг томил.
3. Дараах судрын заалтуудыг салангид цааснууд дээр бич. Тэднийг дугаарлахаа мартаж болохгүй.
 - (1) Египетээс гарсан нь 20:7
 - (2) С ба Г 63:61–62
 - (3) С ба Г 63:64
 - (4) Иаков 3:8–11
 - (5) Матай 12:36–37
 - (6) Матай 15:17–18
4. *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө товхимлын* 10, 11-р хуудсан дахь хэл ярианы тухай зөвлөмжийг тоймло.

ТАЙЛБАР

Хүний идэж байгаа зүйл нь бус харин түүний зүрхнээс гардаг муу ёрын бодлууд, үгнүүд, үйлдлүүд нь түүнийг бузарлаж, цэвэр бус болгодог хэмээн Аврагч заасан (Матай 15:17–18- ыг үз).

Энэ хичээл залуу эрэгтэйчүүдэд юу хэлж байгаагаа хянахын чухал болон хараал, бохир яриа, бохир түүх буюу онигоо нь пристийн зэрэгтний үгсийн санд байх газаргүй гэдгийг сануулах учиртай.

**ХИЧЭЭЛ ЗААХ
ЗӨВЛӨМЖ**

Түүх

Хараал Бол Өвчин

“1939 оны зун хоёр найзтайгаа хамт бид бүгд пристийн зэргийн багш Аризонагийн Месад саравчны ажилд орсон юм. Ажиллаж байхдаа бид ярьж инээж хөхрөх нь маш их байсан боловч харамсалтай нь хэл яриа маань бүдүүлэг бөгөөд онигоо маань зохимжгүй байв. Бидний багийн дөрөв дэх нь ямар ч байсан хараал хэлэх болон онигоо ярихад оролцдоггүй залуу эрэгтэй байсан бөгөөд ковейерыг завсарлах үеэр би түүнээс яагаад гэдгийг асуув. Түүний хариулт нь миний нүдний хоорондуур цохих шиг болсон юм. Тэр ‘Би Пентекосталын Сүмд явдаг. Бид тийм зүйл хийх нь зөв гэж боддоггүй,’ гэж хэлсэн юм.

“Өглөөжингөө чимээгүй байсан бөгөөд үдийн хоолны үеэр ичсэн гурван Мормон хөвгүүн бусдаас зайдуу суух газар хайв. Ерөнхийдөө сэтгэгдэл маань, ‘За ингээд, Бурханы пристийн зэрэгтэн бидэнд, өөр хэн нэгэн сайн үлгэр жишээ үзүүлж байдаг. Бид яах вэ?’ Хэрэв бидний хэн нэг нь муу үг хэлбэл нөгөө хоёр нь гаран дээр нь цохихоор бид тохиролцов.

“Ингээд гурван залуу багш нэг хэсэг гар нь хөндүүр байсан боловч энэ муу зуршлыг бие биенээсээ хөөж гаргахад амжилт гаргав. Би үүндээ үргэлж баяртай байдаг ” (Richard T. Harris, letter to the editor, Ensign, July 1981, p. 73).

Түүхүүд	Өмнө нь томилсон залуу эрэгтэйчүүдээр Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболлын хэлсэн азгүй тохиолдлуудыг яриул. Залуу эрэгтэйчүүдийг сонсож байхдаа үүнтэй төстэй тохиолдлууд тэдэнд байсан эсэхийг нь санахыг хүс.
Түүх 1	“Саяхан би хамгийн их зарагдсан, маш их магтагдсан, бест селлер болсон ном авсан бөгөөд түүн доторх хараал, бүдүүлэг яриануудад нь миний цус зогсох шиг болсон ба Бурханы ариун нандин нэр муухайгаар хэрэглэгдсэнд би цочирдов” (“President Kimball Speaks Out on Profanity,” Ensign, Feb. 1981, p. 4).
Түүх 2	“Миний сууж явсан автобусанд хэдэн залуу сагсан бөмбөгчин орж ирэв. Тэд бие биентэйгээ хэн хамгийн заналтайгаар харааж чадахаараа өрсөлдөж байх шиг санагдав. Магадгүй тэд үүнийгээ том хүмүүсээс сурсан байх. Тэд тэдгээр үгнүүдийнхээ ноцтойг бүрэн ухаараагүй байсан гэдгийг би мэднэ ” (“President Kimball,” p. 4).
Түүх 3	“Нэг өдөр далайн эрэг дээр хэдэн залуу хүмүүс машинаараа элсэн дээгүүр маш хол явж элсэнд гүнзгий суусан байв. Тэд хүчээ нийлүүлсэн боловч үүнийг гаргаж чадахгүй юм шиг байлаа. Би туслахыг хүссэн боловч тэдний хэрэглэж буй ой гутам яриа намайг болиулсан юм” (“President Kimball,” p. 4).
Түүх 4	“Хэдэн жилийн өмнө Сан Францискогийн театрын тайзан дээр тавигдсан тоглолтыг би үзсэн юм. Тоглолт маш их таалагдаж Нью Йоркт маш удаан үргэлжилжээ. Гэвч Их Эзэний гутлын үдээсийг тайлахад ч зохисгүй жүжигчид нийтлэг, заваан яриандаа түүний нандин нэрийг хараан зүхэж байв. Тэд Бүтээгчийнхээ ариун нэрийг гутаасан жүжгийн зохиолчийн үгнүүдийг дахин дахин давтаж байв. Хүмүүс инээж, алга ташицгааж байсан бөгөөд зохиолч, тоглогчид, үзэгчид надад гэмт хэргийн цэнгүүнд хүрэлцэн ирсэн мэт сэтгэгдэл төрүүлж байсан юм” (“President Kimball,” p. 4).
Ярилцлага	<p>Залуу эрэгтэйчүүдэд үүнтэй төстэй тохиолдлууд тохиолдож байсан бол түүнийг нь хуваалцуул.</p> <ul style="list-style-type: none"> • Тийм нөхцөлүүд та нарт ямар сэтгэгдэл төрүүлдэг вэ? <p>Зарим залуу эрэгтэйчүүдэд энэ нь маш энгийн зүйл учир ямар ч сэтгэгдэл төрөхгүй байна хэмээн хэлж магад. Энэ хариулт нь та нарын дараачийн сэдвэнд зөвхөн хүч нэмэх болно.</p>
Түүх	<p>Дараачийн түүх нь Ахлагч Бойд К.Пакерт тохиолдсон явдал гэдгийг тайлбарла.</p> <p>“Хэдэн жилийн өмнө би нэг ахын аваарт орсон машиныг чирэхээр очсон юм. Энэ нь бут ниргэгдсэн боловч гэмтээгүй жолоочийг эмнэлэгт тайвшруулах эмчилгээ хийхээр буюу шинжлэхээр авч явсан ганц тохиолдол байв.</p> <p>“Дараачийн өглөө тэр замдаа гарахаар тэсэж ядан машинаа асууж ирсэн юм. Түүнд аваарт орсон машиныг харуулахад түүний дотор нь байсан сэтгэлийн хөдөлгөөн болон урам хугаралт нь магадгүй түүний азгүйдэлт нь энэ байдлыг нь хурцатгаж энэ нь маш урт хараал болон урсан гарч ирэв. Тийм ичгүүргүй, түүний хэлсэн үгс олон жилийн хараалын дасгал болсон нь илт байв. Түүний үгийг бусад үйлчлүүлэгчид сонсож байсны дотор эмэгтэйчүүд байсан ба энэ нь тэдний чихэнд хүчил хүрэхтэй адил байсан нь лавтай.</p> <p>“Миний ах нарын нэг машин доороос ажиллаж байсан том түлхүүртэйгээ гарч ирэв. Тэр ч бас дургүй нь хүрч түлхүүрээрээ занган (механикууд 16-ийн хавирган сар хэлбэрийн түлхүүр сүрдмээр зэвсэг гэдгийг мэднэ) тэр хүнийг байрнаасаа хөөж гаргав. ‘Энд бид ийм хэл яриа сонсох ёсгүй,’ гэж тэр хэлэв. Үйлчлүүлэгч урьдынхаасаа илүү муухайгаар хараасааар яваад өгөв.</p> <p>“Нэлээн хойно тэр дуу шуугүй, нүглээ наманчлагч дахин гарч ирсэн бөгөөд бусад хүмүүсээс зайлсхийн миний ахыг олов.</p> <p>“Бүх л өдрийн турш би зочид буудлын өрөөнд орон дээрээ тарчлан хэвтлээ. Өнөө өглөө болсон явдалд би ямар их ичиж байгаагаа хэлж чадахгүй байна. Миний биеэ авч явсан байдал уучлагдашгүй байсан. Би өөрийгөө зөвтгөх ямар нэг зүйл олохыг хичээсэн боловч зөвхөн нэг л зүйл олж чадлаа. Миний бүх л амьдралын турш хэзээ ч хэн ч миний хэл яриаг зохисгүй байна хэмээн хэлж байгаагүй. Би үргэлж ингэж л ярьдаг байсан. Миний хэл яриа зүй бус болохыг хэлсэн анхны хүн бол та юм.</p>

“Хүн ийм ой гутам зуршлын золиос болж насанд хүрсэн бөгөөд хэзээ ч эсэргүүцэлтэй тулгарч байгаагүй нь сонирхолтой байгаа биз дээ? Бид ямар хүлцэнгүй байж ямар хурдан зохицдог юм бэ. Саяхан л сонины сэтгүүлч, сэтгүүлийн эрхлэгчид болон тэр тусмаа кино хийгчид болгоомжтойгоор хараалын болон бузар үгийг хянадаг байжээ.

“Болгоомжтойгоор (бид үргэлж болгоомжтой хөтлөгддөг байсан) бузар үг нь ямх ямхаар ёворч зогсолгүйгээр кинонд, сэтгүүлд, одоо бүр сонинд ч түрж орон саяхан л тэвчишгүй хэмээн тооцогдож байсан үг бүрчилсэн санааг хэвлэдэг болжээ.

“Бидний ихэнхэд маань засварын газар доторх энэ хүнтэй адил бузар муу үг нь ямар ноцтой гэмт хэрэг болохыг хэлж байгаагүй байж болно. Үүнийг мэдэхээс өмнө бид ой гутам зуршлын золиос буюу хэлнийхээ боол болсон байдаг” (in Conference Report, Oct. 1967, pp. 126–27; or Improvement Era, Dec. 1967, p. 96).

Ярилцлага

- Хүмүүс хараал болон гутаасан үг яриа нь бусдад төвөг учруулж байгааг мэдэхгүйгээр хэрэглэдэг талаар та нар юу гэж бодож байна вэ?
- Хараалын үг болон зүй бус хэл яриагаар доромжлогдсон хүмүүс яагаад доромжилсон хүмүүст юу ч хэлдэггүй вэ?

Хэдий зарим хүмүүс өөрсдөө үүнийхээ тухай бодолгүй байнга харааж буюу өөр зохисгүй хэл яриа хэрэглэдэг ч түүний эргэн тойронд байгаа хүмүүс түүнийг юу гэж сонсож ба харснаараа дүгнэдэг гэдгийг онцлон хэл. Тэд түүний хэлж ярьж байгаагаас нь өөр түүний тухай, түүний бодож санаж байгаа тухай юу ч мэдэхгүй байж болох бөгөөд зүй бус ярьж бичиж байгаа хүн хэзээ ч сайхан сэтгэгдэл төрүүлдэггүй.

Та *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө товхимлын* 10, 11-р хуудсан дахь хэл ярианы тухай зөвлөмжийг уншиж ярилцаж болно.

Бидний Зүрх Сэтгэлд Юу Байгааг Хэл Яриа Маань Илчилдэг

Судрууд, самбар ба ярилцлага

Их Эзэн хараалын тухай юу хэлснийг одоо олж мэдэх болно гэдгийг залуу эрэгтэйчүүдэд хэл.

Бэлтгэсэн судрын заалтуудаа залуу эрэгтэй бүрт өг. Тэднийг чангааар уншихаар дуудагдталаа судрыг олоод тэмэглэхийг зөвлө.

1, 2-р судруудыг уншихыг хүс.

Самбарт *дэмий хоосон* гэж бич.

- Их Эзэний нэрийг дэмий хоосон дуудах гэдэг нь ямар утгатай вэ?

Дэмий хоосон дуудах гэдэг нь жинхэнэ үнэ цэнэгүй буюу чухал бус, хий хоосон, зогсонги, ашиггүй, хээгцээгүй, ач холбогдолгүй гэсэн утгатай юм. Эдгээр тайлбарыг самбарт бич.

- Бурхан, бидний Эцэг буюу Есүс Христ, бидний Аврагчид эдгээр үгнүүдийн аль нэг нь ашиглагддаг уу?

Их Эзэний нэрийг хэрэглэж байгаа бидний зам бол бид түүний талаар ямар сэтгэгдэлтэй байгааг илэрхийлдэг гэдгийг залуу эрэгтэйчүүдэд сануул. Бид түүнийг үнэхээр хайрлаж хүндэтгэдэг бол бид өөрсөддөө түүний нэрийг муухай байдлаар хэрэглэхийг зөвшөөрөхгүй.

- Их Эзэний нэрийг хэзээ ашиглавал зохих вэ?

3-дахь судар уншихыг хүс.

Энэ шүлгийг залуу эрэгтэйчүүдтэй ярилцаж Их Эзэний нэрийг бид түүний нэрээр ярих эрх мэдэлтэй үедээ бишрэлтэй залбиралд болон сүнс мэдэрсэн үедээ болгоомжтойгоор зөв зүйтэй хэрэглэдэг гэдгийг онцлон хэл.

Ишлэл

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболлын дараах мэдэгдлийг хуваалц: “Их Эзэний нэрийг бишрэл хүндэтгэлтэйгээр хэрэглэх нь Сүмийн гишүүдийн хувьд бидний амьдралын ердийн нэг хэсэг байх ёстой. Жишээлбэл, сайн Хожмын үеийн Гэгээнтнүүдийн хувьд бид тамхи татдаггүй. Архи уудаггүй. Бид цай, кофе хэрэглэдэггүй. Үүний адил

Судрууд ба ярилцлага	<p>бид тэнэг хэл яриа хэрэглэдэггүй. Бид хараах буюу муулдаггүй. Бид Их Эзэний нэрийг дэмий хоосон хэлдэггүй” (“President Kimball,” p. 5).</p> <ul style="list-style-type: none"> • Хожмын Үеийн Гэгээнтэн байнга цэвэр бус хэл яриа хэрэглэж цэвэр ариун сэтгэлтэй байх нь боломжтой юу? Яагаад үгүй вэ? <p>Энэ асуултанд хариулахад нь туслахын тулд залуу эрэгтэйчүүдээр 4, 5, 6-р шүлгүүдийг уншуулж ярилцуул.</p> <p>Бидний ам зүрх сэтгэлийг маань илчилдэг гэдгийг залуу эрэгтэйчүүдэд ойлгуул. Цэвэр ариун зүрх сэтгэл цэвэр бус хэл яриатай байдаггүй.</p>
Ишлэл	<p>Ахлагч Брюс Р. МакКонки “Хараал бол өвчтэй хүний нотолгоо юм” хэмээн бичсэнийг залуу эрэгтэйчүүдэд хэл (<i>Mormon Doctrine</i>, 2nd ed. {Salt Lake City: Bookcraft, 1966}, p. 602).</p>

Ишлэлүүд ба ярилцлага	<p>Хэл Яриа Маань Бидний Сул Талыг Илчилдэг</p> <ul style="list-style-type: none"> • Хувийн ямар сул талыг бүдүүлэг байдал илчилдэг вэ? <p>Бишоп Х.Бүрк Петерсоны дараах мэдэгдлийг унш:</p> <p>“Зарим хүмүүс биеийн хэсэг оролцсон онигоо буюу түүх хэлж, эмэгтэй хүн болон охидуудын тухай онигоо хэлэх буюу өдөөсөн санаа гаргахдаа, ариун нандин зүйлийн тухай хамаагүй байснаар хувийн сул дорой талаа харуулдаг буюу илэрхийлдэг. . . .</p> <p>“Зарим нь бохир сэтгүүл уншиж, заваан кинонууд болон телевизийн хөтөлбөр үзэж, эсвэл цэвэр бус яриа болж буй газарт үлдсэнээр хувийн сул дорой байдалдаа нэмэрлэдэг. Эдгээр бүх төрлийн тохиолдол бүр нь ямар ч хүнийг сул дорой болгодог бөгөөд ‘хортны галт сумнаас’ хамгаалах боломжгүй болгодог” (in <i>Conference Report</i>, Oct. 1980, p. 56; or <i>Ensign</i>, Nov. 1980, p. 38).</p> <ul style="list-style-type: none"> • Хүн цэвэр бус хэл яриа хэрэглэснээр өөрийнхөө тухай өөр юуг илчилдэг вэ? <p>Хараал хэлэх нь бид биеэ барих чадваргүй болохыг, харилцаандаа зөв зүйтэй үгс хэрэглэх чадваргүй болохыг болон бусдыг хүндэлдэггүй болохоо харуулдаг гэдгийг онцлон хэл.</p> <p>Бидэнд жижигхэн нүгэл мэт санагддаг муу үлгэр жишээ маань бусдыг илүү ноцтой зүйлд өөрсдийнхөө жишгийг тоохгүй байхыг дэмжиж мэднэ гэдгийг залуу эрэгтэйчүүдэд сануул. Хожмын үеийн гэгээнтнүүдийн хувьд бид үргэлж зэмлэлгүй амьдарч бүх боломжоороо ах нараа дэмжиж тэдэнд тусалж байх ёстой.</p> <p>Ахлагч Чарльс Дидиер “Үг бол хувийн илэрлийн нэг шинж юм. Тэр нь биднийг хурууны хээтэй маань адил ялгаж өгдөг. Тэр биднийг ямар хүн бэ гэдгийг харуулж бидний гарал үүслийг хэлж, амьдралын замыг дүрсэлдэг. Тэд бидний дотоод сэтгэлийг ч, бодлыг маань ч дүрсэлдэг” гэжээ (in <i>Conference Report</i>, Oct. 1979, p. 35; or <i>Ensign</i>, Nov. 1979, p.25).</p>
-----------------------	---

Самбар ба ярилцлага	<p>Бид Ярианыхаа Орчныг Хянаж Чадна</p> <ul style="list-style-type: none"> • Яагаад зарим залуу эрэгтэйчүүд муу үг хэллэг хэрэглэдэг вэ? <p>Самбарт залуу эрэгтэйчүүдийн хариултыг бич. Тэд зуршил, буруу гэдгийг нь боддоггүй, биеэ барьдаггүй, анхаарал татахыг оролддог, хүлээн зөвшөөрүүлэхийг оролддог, сэтгэлээ илэрхийлэх илүү сайн арга мэддэггүй зэргийг оролцуулж болно.</p> <p>Залуу эрэгтэйчүүдээр тэдний муу үг хэллэг хэрэглэдэг гурван гол шалтгааныг жагсааж бичүүл.</p> <p>Залуу эрэгтэйчүүдийн гаргасан шалтгаан бүрийг ярилцах цаг гаргаж, “Энэ яагаад сайн шалтгаан биш вэ?” гэсэн асуултыг нөхцөл бүрт асуу. Залуу эрэгтэйчүүд өөрсдөө хариултыг өгнө. Тэдний хариултыг самбарт бич.</p> <ul style="list-style-type: none"> • Муу үг хэллэг хэлэх асуудлыг болиулах ямар ямар арга зам бий вэ? (Хувийн амлалт авах, залбирал, судар ба дуулал цээжлэх, судраас судлах, эерэг болон сэтгэл сэргээм бодолд анхаарлаа төвлөрүүлэх, биеэ барих, анхаарал татах илүү үр дүнтэй арга олох.)
---------------------	---

Түүх ба уриалга	<p>Хэрэв асуудал зөвхөн залуу эрэгтэйчүүдийн хаяхыг хүсэж буй муу зуршил юм бол Ахлагч Пакер тэдэнд муу үг хэллэг хэлэх бүрдээ бие биендээ тодорхой хэмжээний мөнгө төлж байх зөвлөгөөг санал болгож байна (in Conference Report Oct. 1980, p. 57; or Ensign, Nov. 1980, p. 39-ийг үз).</p> <p>Ямар ч үед цэвэр зөв зүйтэй хэл яриа хэрэглэж сайн үлгэр үзүүлэх буюу бусдаас мөн ижил зүйл хийхийг хүсэж байхыг залуу эрэгтэйчүүдэд уриал. Ахлагч Далин Х.Өүксийн ярьсан дараах түүхийг унш:</p> <p>“Мормоны ном бидэнд Бурханы шүүх суудлын өмнө биднийг авчрахад “үгс маань биднийг буруутгах болно; бодлууд маань ч биднийг буруутгах болно” (Алма 12:14) гэж өгүүлдэг. Бүгдээрээ бохир яриа юу болохыг ойлгоцгооё. Тэдгээр нь биднийг Бурханаас тусгаарлах гэм нүглүүд бөгөөд Ариун Сүнснийг биднээс холдуулан бидний сүнслэг хамгаалалтыг зэрэмдэглэдэг.</p> <p>“Бид ийм бүх сэтгэлийн илэрхийллээс зайлсхийх ёстой.</p> <p>“Мөн бид бусдыг ингэж байхыг дэмжиж чадна. Нөхөрсөг хүсэлт тавих зоригтой байснаар бид ихэнхдээ хүндэтгэсэн буюу нөхөрсөг хариулт хүлээн авдаг. Илиноисд амьдардаг миний нөхөрт гарсан охинд ийм явдал тохиолдсон юм. 12 настай хүүхдүүдийг хөл бөмбөгийн тоглолтоос нь гэр лүү хүргэж өгөх ээлж болоход түүний шуугиантай зорчигчид хараалын үгээр агаарыг дүүргэжээ. Хатуу боловч хошигносон маягтайгаар тэр, ‘Манай гэрийнхэн энэ нэрийг зөвхөн сүсэг бишрэлдээ хэрэглэдэг учраас би та нараас миний машин дотор тэр нэрийг битгий хүндэтгэлгүйгээр хэлээч гэж гуйя,’ хэмээн хөвгүүдэд хэлжээ. Хөвгүүд тэр дороо чимээгүй болж хамгийн гайхалтай нь түүний машин барих ээлж болохыг ихэнх нь санадаг байжээ” (in Conference Report, Apr. 1986, p. 65; or Ensign, May 1986, p. 52).</p> <ul style="list-style-type: none"> • Бид найз нөхөддөө тэднийг гомдоохгүйгээр хэрхэн зааж чадах вэ? <p>Хэрэв бид юуг зөвшөөрөх болон зөвшөөрөхгүйгээ шийдчих юм бол бусад нь бидний үлгэр жишээг дагах урам зоригтой болдог гэж хэл. Бид байр сууриа найрсаг нөхөрсөг замаар илэрхийлж гомдоогчийг ичээх буюу басамжлахгүйгээр илэрхийлж чадна.</p>
Үйл ажиллагаа	<p>Ютагийн Зүүн гадасны Хиберийн хэсэг залуус хараал хэлэх талаар ямар нэг зүйл орон нутагтаа хийхээр шийдэцгээжээ. Тэд өөрсдийнхөө кампанит ажлыг хотын хүмүүсийн анхааралд хүргэх хэд хэдэн үйл ажиллагаа төлөвлөжээ. Тэд “ХЗХ” гэж товчилсон “Хараах Зуршлыг Халъя” гэсэн утгатай эмблемтэй майк өмсөцгөөжээ. Тэд хүүхдийн хэсэгтэй ярилцаж хөвүүртэй парад хийж, зурагт хуудасны тэмцээн зохиож, кампанит ажлын үеэр хэн ч хараахгүй байх үдэшлэг зохиожээ. Кампанит ажил гэрчлэлийн цуглаанаар өндөрлөжээ. Энэ нь олон хүмүүст нөлөөлж тэд хараал хэлэх зуршлаа халжээ” (“Concerned Youth Launch Campaign to Stop Profanity,” <i>Church News</i>, 21 Oct., 1978, p. 11-г үз).</p> <p>Чуулгыг гурав буюу дөрвөөр нь жижиг бүлэгт хувааж тэдэнд гол санаа гаргах хэдэн минутыг өг. Тэдний шалгуур бол “өөрсөддөө болон бусдад цэвэр ариун яриа хэрэглэхэд та нар юугаар тусалж чадах вэ?” гэсэн асуултанд дээрх зөвлөмжийг болон <i>Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө товхимол</i> дахь зөвлөгөөг бодож хариулах явдал юм.</p>

Дүгнэлт

Уриалга

Хэрэв цаг гарвал залуу эрэгтэйчүүдээр гаргасан гол санаануудаас нь хуваалцуул. Ирэх долоо хоногт дагах нэг буюу хоёр санааг сонгож авахыг тэднээс хүс.

Дөрвөн Түүх

Түүх 1

“Саяхан би хамгийн их зарагдсан, маш их магтагдсан, бест селлер болсон ном авсан бөгөөд түүн доторх хараал, бүдүүлэг яриануудад нь миний цус зогсох шиг болсон ба Бурханы ариун нандин нэр муухайгаар хэрэглэгдсэнд би цочирдов” (“President Kimball Speaks Out on Profanity,” Ensign, Feb. 1981, p. 4).

Түүх 2

“Миний сууж явсан автобусанд хэдэн залуу сагсан бөмбөгчин орж ирэв. Тэд бие биентэйгээ хэн хамгийн заналтайгаар харааж чадахаараа өрсөлдөж байх шиг санагдав. Магадгүй тэд үүнийгээ том хүмүүсээс сурсан байх. Тэд тэдгээр үгнүүдийнхээ ноцтойг бүрэн ухаараагүй байсан гэдгийг би мэднэ” (“President Kimball,” p. 4).

Түүх 3

“Нэг өдөр далайн эрэг дээр хэдэн залуу хүмүүс машинаараа элсэн дээгүүр маш хол явж элсэнд гүнзгий суусан байв. Тэд хүчээ нийлүүлсэн боловч үүнийг гаргаж чадахгүй юм шиг байлаа. Би туслахыг хүссэн боловч тэдний хэрэглэж буй ой гутам яриа намайг болиулсан юм” (“President Kimball,” p. 4).

Түүх 4

“Хэдэн жилийн өмнө би Сан Францискогийн театрын тайзан дээр тавигдсан тоглолтыг үзсэн юм. Тоглолт маш их таалагдаж Нью Йоркт маш удаан үргэлжилжээ. Гэвч Их Эзэний гутлын үдээсийг тайлахад ч зохисгүй жүжигчид нийтлэг, заваан яриандаа түүний нандин нэрийг хараан зүхэж байв. Тэд Бүтээгчийнхээ ариун нэрийг гутаасан жүжгийн зохиолчийн үгнүүдийг дахин дахин давтаж байв. Хүмүүс инээж, алга ташицгааж байсан бөгөөд зохиолч, тоглогчид, үзэгчид надад гэмт хэргийн цэнгүүнд хүрэлцэн ирсэн мэт сэтгэгдэл төрүүлж байсан юм” (“President Kimball,” p. 4).

48

Зөв Шударга Жишгүүдийг Баримтлах нь

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр эргэн тойрондоо байгаа дэлхийн тухай сурах ёстой бөгөөд материаллаг, муу муухай нүгэлт зүйлд оролцохгүй байхыг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

Шаардагдах материалууд:

1. Залуу эрэгтэй бүрт судар.
2. Судар тэмдэглэх харандаа.

ТАЙЛБАР


Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн нэг агуу сорилт бол улам улам гэм нүгэлтэй болж байгаа дэлхийд сайн мэдээний жишгээ чанга барьж байх явдал юм. Гэвч хариулт нь бид өөрсдийгөө дэлхийгээс тусгаарлах гэсэн үг биш юм. Бидэнд дэлхийн гэрэл байж, сайн үйлст идэвхтэй оролцож улс орон болон нийгэмдээ зөв шударгыг дэлгэрүүлэхэд туслахыг хичээхийг заасан. Энэ хичээл залуу эрэгтэйчүүдэд тэд хэрхэн дэлхийд байж бусармаг явдалгүй үлдэж болохыг ойлгуулах болно.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Самбар ба
ярилцлага

Бид Дэлхийд Байхдаа Дэлхийн Бусаар Байх Ёстой

Самбарт дараах бүдүүвчийг зур:



- Самбар дээрх бүдүүвч ямар захиас агуулж байна вэ? (Дэлхийн жишиг Сүмийн жишгээс холдож байна. Дэлхийн жишиг улам бусармаг болж байхад Сүмийн жишиг хэвээрээ байсаар байна.)

Самбарт *дэлхийд байхдаа дэлхийн бусаар байх* гэж бич.

- Дэлхийд байхдаа дэлхийн бусаар байх гэдэг нь ямар утгатай вэ?

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр хариулуулаад тэднээс Матай 5:14–16-г уншиж тэмдэглэхийг хүс.

- Бид ямар замаар дэлхийн гэрэл байж чадах вэ?

Зөвлөхийн
танилцуулга

Хэдэн зууны өмнө Европт хэсэг хүмүүс өндөр ууланд өөрсдийнхөө шашныг байгуулсан гэдгийг тайлбарла. Тэд тэндээ ажиллаж, сурч, хамгийн гол нь тэд өөрсдийгөө дэлхийгээс тусгаарласан байна. Тэд дэлхийтэй ямар ч хамааралгүй байжээ. Тэд нийгмээс өөрсдийгөө тусгаарлаж өөрсөддөө байсан дээр үеийн судрыг судалснаараа Бурханд хамгийн сайнаар үйлчилж чадна гэж үзжээ. Тэд

амьдрах бат бөх орон гэр барьж, цэцэрлэг жимсний мод ургуулж, дээр үеийн судар уншиж, хувилж өдрийг өнгөрөөж байв. Ингэж тэд дэлхийтэй холбоотой байхаас зайлсхийж амьдарч ажиллаж, үхэцгээж байжээ.

Судар ба ярилцлага

- Есүс энэ дэлхий дээр байхдаа өөрийгөө бусармаг хүмүүсээс тусгаарласан уу?
- Дэлхийд байхын тухай Есүс төлөөлөгчиддөө юу заасан бэ?

Энэ асуултанд хариулахын тулд Иохан 17:15–18 дахь Есүсийн төлөөлөгчдийнхөө төлөөх залбирлыг унш.

Залуу эрэгтэйчүүдэд харьцангуй болгоомжтой байх хэрэгтэйг ойлгуул. Тэдэнд бусдаас илүү гэсэн хандлага байх ёсгүй ба тэд муу ёрын зүйлд оролцох ёсгүй. Тэднийг харж байгаа бүхэнд тэд үлгэр жишээ үзүүлэх ёстой.

Түүх ба ярилцлага

Дэлхийд байхдаа дэлхийн бусаар байх боломжтой байсан хүүгийнхээ тухай нэгэн аавын ярьсныг унших буюу ярьж өг. Хүүг дунд сургуульд байхад тэдний гэр бүл түүний ихэнх хожмын үеийн гэгээнтэн найз нь байдаг Солт Лэйк Ситигээс нүүж хэдхэн сүмийн гишүүн байдаг Кентакид очжээ. Хожим нь түүний аав энэ болсон явдлын тухай бичсэн юм:

“Түүнийг муждаа хамгийн том сургуулийн наймдугаар ангид ордог жил бид Кентакид ирсэн юм. Түүний танилууд нь гэвэл бараг долоо хоногийн өмнө сүм дээр танилцсан гурав дөрвөн Мормон залуус байв. Эхний хэдэн долоо хоног тэр суралцахдаа шамдаж байсан бөгөөд түүний сурлага маш сайн байв. Гэвч түүний нийгмийн амьдрал нь хэцүү байдалтай байв. Тэр тэнд амьдардаггүй мэт сэтгэгдэлтэй байв. Түүнд жинхэнэ найз байсангүй. Тэр маш олон зовиуртай өдрүүдийг хуучин найзуудтайгаа байхыг хүсэн өнгөрөөж байв.

“Тэр санаагаар унаж эхлэв. Удахгүй сагсан бөмбөгийн баг сонгох байсан учир түүнд найдвар байв. Энэ нь аз жаргалын үүд гэдэгт тэр эргэлзэхгүй байв. Тэр дунд ангийн багт орсон боловч ихэнхдээ сэлгээний сандал дээр сууж байв. Түүний наймдугаар ангийн тэр жил тийм ч баяртай байсангүй.

“Түүний дунд ангийн жил эхэллээ. Тэр нэлээд өссөн бөгөөд бүх зуны турш сагсан бөмбөгийн бэлтгэл хийсэн байв. Тэр үргэлж ‘А’ дүн авдаг учир сургуулийн ихэнх нь түүнийг хүндэлдэг бөгөөд энэ нь сагсан бөмбөгийн багт ер бусын зүйл байлаа. Тэр үүнд нь сэтгэл ханаж байсан боловч өөр төрлийн сэтгэл ханамжийг тэр хүсэж байв. Тэр нийгмийн болон биеийн тамирын сэтгэл ханамжуудыг хүсэж байв. Тэр өөртөө үүнийг батлах ёстой гэсэн сэтгэгдэлтэй байв. Түүний хувьд үүнийг хийх газар бол сагсан бөмбөгийн талбай байв.

“Сургуулийн багийг сонгох цаг ирэв. Тэр маш сайн тоглож байсан ба гол тавд орно гэж найдаж байлаа. Тэр урам зоригтойгоор биеийн тамирын заал руу дасгалжуулагчийн наасан хамгийн чухал жагсаалтыг харахаар орж ирэв. Тэр бусадтай хамт нэрнүүдийг харан зогсов. Тэр дээрээс нь доош бүгдийг уншив. Түүний нэр ерөөсөө байсангүй. Түүнийг багаас хассан байв.

“Тэр сургууль тарахаас өмнө гэртээ ирж өрөөндөө орж тэндээ байсаар л байв. Би түүнийг маш их зовж байгааг мэдсэн ч хэрхэн туслахаа мэдэхгүй байв. Түүний зовж шаналсан хоёр дахь өдөр би доод давхар луу түүний өрөөнд очив. Гэрэл нь асаалттай байсан ба тэр дээшээ тааз ширтэн хэвтэж байлаа. Бид ярилцав. Бид маш удаан ярилцав. Тэр надад өөрийнхөө маш их зовж байгааг болон дахин сургуульдаа очиж чадах эсэхээ яриу. Их Эзэнд багт ороход нь туслаач хэмээн залбирснаа тэр надад хэлсэн билээ. Тэгээд тэр, ‘би хүч чадлын төлөө залбирсан,’ гэж хэлэв. Гэвч ямар ч тусламж, ямар ч найдвар үгүй юм шиг санагдаж байв.

“Жаахан байзнаснаа ‘Аав, би бүхнийг эхнээс нь эхэлмээр байна. Би өөр ямар нэг юмнаас барьж авмаар байна. Би үүнийг хэн ч миний өмнөөс хийхгүй гэдгийг мэднэ. Би үүнийг өөрөө хийх ёстой’ гэлээ. Тэр номлолд үйлчилж байсан нэг ахлагчийг нэрлэв. Тэрээр, ‘би түүнтэй адил болмоор байна. Би түүн шиг инээж, хайрлаж, тусалж сурмаар байна. Би сургуульдаа буцаж очоод бүхнийг эхнээс нь эхэлнэ,’ хэмээн үргэлжлүүлэв. Бид хамтдаа өвдөг сөгдөн залбираад би түүнд хайртай гэдгээ мөн түүгээр маш их бахархдагаа хэлсэн юм.

“Дараагийн өдөр тэр сургуульдаа явав. Тэр улирлын үеэр тэр сүмийн багт сагсан бөмбөг тоглож од болж байв. Сургууль дээрээ тэр олон найзуудтай болов. Тэр тайвширсан юм шиг байсан бөгөөд буцаж ирэн түүний дуртай хошигнолоо үргэлжлүүлэн хөгжүүлсэн юм. Цаг хугацаа өнгөрч би түүний ‘Аав, энэ залуус агуу сайн! Би энэ сургуульд дуртай. Би энэ хотод мөн Кентакид дуртай,’ хэмээн хэлэхийг сонссон билээ.

“Ахлах ангид орох жил болов. Тэд тэр жилийнхээ сурагчдын зөвлөлийн ерөнхийлөгчийг сонгож амжаагүй байв. Тэр ерөнхийлөгчид нэр дэвшихээр шийдэв. Одоо түүнд олон найзууд байлаа. Тэр эерэг хөгжилтэй зүйл дээр тулгуурласан сургуулийг хэрхэн хайр татам сайхан газар болгох тухай агуу кампанит ажил зохиов. Тэр олонхийн саналаар сонгогдов. Мэдээж тэр маш их баярлаж байв.

“Гэвч түүнд эцсийн ганц мөрөөдөл байв. Тэр сагсан бөмбөгийн багт байхыг хүсэж байв. Дасгалжуулагч дунд ангидаа тоглож байгаагүй дунд ангийнхныг авахгүй хэмээн зарласан байжээ. Тэр түүнд ирээдүйд туслах дунд ангийнхныг багтаа авахыг хүссэн юм. Тиймээс ахлах ангийн Матад ямар ч найдлага үгүй болов. Хэдий тийм ч тэр маш их удаан чармайлт гарган бэлтгэл хийж байсан ба багийн од болсон залуус түүнийг хайрлаж хүндэтгэж эхлэв.

“Жагсаалт гарахад дахиад л түүний нэр гарсангүй. Өөрийгөө өөр чиглэлээр хөгжүүлэхээр маш их хичээсэн түүний зүрх дахиад л эмтрэв. Тэр гэртээ ирээд надад өөрийнхөө зовлонг ярьж өгөв. Яг тэр үед би таван өдрөөс нааш эргэж ирэхгүй аялалд явах гэж байв. Явсан хойноо миний хийж чадах бүх л зүйл бол залбирах байв.

“Буцаж ирээд би Матыг гэртээ байхгүй байхыг мэдэв. Тэр сагсан бөмбөгийн бэлтгэлд явсан байв. Би түүнийг сүмийнхэнтэй бэлтгэл хийж байгаа юмуу гэж асуухад надад түүнийг сургуулийнхантай бэлтгэл хийж байгаа гэж хэлэв. Тэр үед тэр гэртээ ирэв. ‘Чи яагаад багынхантай хамт бэлтгэл хийх болов? Чи хасагдсан гэж хэлсэн биз дээ,’ гэж би асуув.

“‘Аав аа, багийн залуус дасгалжуулагч дээр очоод намайг багтаа авахыг хүсэж байна гэж хэлжээ. Дасгалжуулагч урьд нь хийж байгаагүй зүйлийг хийсэн юм. Залуус ‘бидэнд Мат хэрэгтэй,’ гэсэн учир тэр намайг багт оруулсан юм гэж хэлэв. Тэд дасгалжуулагчид итгүүлсэн учраас би багт орсон. . . .’

“Тэр ихэнхдээ сандалд сууж байсан учир Мат сагсан бөмбөгийн талаар сэтгэл дундуур хэвээр байв. Нэгэн орой багийн цуглаан дээр үзүүлэхээр төлөвлөж байсан тоглолтын бичлэгийн кино гаргах аппарат эвдэрчээ. Багийнхан болон дасгалжуулагч тойрч суугаад ярилцжээ. Мат бараг багийнхныг зугаацуулав. Анх удаагаа дасгалжуулагч Матыг үнэхээр хэн байсан бэ гэдгийг мэдэж авав. Дараачийн тоглолт дээр тэр хагасаас илүү тоглолтонд тоглов. Түүнээс хойш тэр олон тоглолтын гол хүч болж гайхамшигт тамирчин гэдэг нь хүлээн зөвшөөрөгджээ.

“Эцэст нь сургуулийн төгсөлт болов. Тэр нэг яриа өгөхөөр сонгогджээ. Яриан доторх хошигнол нь маш ихээр инээлгэж байлаа. Гэвч энэ нь бас нухацтай яриа байв. Ярианыхаа төгсгөлд тэр энд мэдэрсэн баяр баясгалан, хүмүүсийн дулаахан уур амьсгал, бусад оюутнуудыг хайрлах хайрын тухай яриу. Тэр яриагаа дуусган: ‘Миний хайрт найз нар аа, хэдэн өдрийн дараа би эцэг эхтэйгээ Юта руу буцаж явна. Та нар намайг Мормон гэж мэднэ. Би яриагаа Мормоны агуу бошиглогч Бригэм Янгийн мартаж боломгүй үгээр төгсгөө. Түүний үг миний сэтгэгдлийг дүрсэлж байгаа юм. Би надад та бүхний хандаж байсан байдал болон энд эдэлсэн аз жаргал баяр баясгалангийн улмаас та бүхэнд хайртай. Тиймээс та бүхэнд түүний нэгэн удаа хэлснээр “Энэ бол тэр газар” хэмээн хэлмээр байна,’ гэлээ. Оюутнууд болон цугласан олон босож түүнд нижигнэсэн алга ташилт өгөв” (George D. Durrant, Someone Special, Starring Youth {Salt Lake City: Bookcraft, 1976}, pp. 49–53).

- Энэ залуу эрэгтэй “дэлхийд байхдаа дэлхийн бусаар байх” гэсэн зөвлөмжөөр хэрхэн амьдарсан бэ?
- Тэр сургууль дээрээ бусдад ямар нөлөө үзүүлсэн гэж та нар бодож байна вэ?

- Хэрэв тэр ганцаардмал бөгөөд хол хөндий өөрийгөө өрөвдөж байсан бол ямар нөлөөлөл үзүүлэх байсан гэж та нар бодож байна вэ?
- Түүнд жишгээ зөрчин амжилт гаргах хэрэг байсан уу?
- Та нар сургууль болон нийгэмдээ хэрхэн сайн нөлөөлөл үзүүлж чадах вэ? Самбарт залуу эрэгтэйчүүдийн хариултыг жагсааж бич.
- Бид дэлхийн ямар зүйлээс зайлсхийж явах ёстой вэ? Тэдний хариултыг самбарт бич.

Судар, самбар
ба ярилцлага

Бурханы Бүрэн Хуяг Дуулгыг Өмсөх

- Эрт үед байлдаж байгаа хүн яагаад хуяг дуулга өмсдөг байсан бэ?
- Өнөөдөр бид ямар тулалдаанд хамрагдаж байгаа вэ? (Нүгэл хилэнцийн эсрэг.)
- Бид ямар төрлийн хуяг дуулга хэрэглэх ёстой вэ?

Энэ асуултанд хариулахын тулд залуу эрэгтэйчүүдээр Сургаал ба Гэрээ 27:15–18-ыг уншуул.

Бурханы хуяг дуулгын төрөл бүрийн хэсгийг болон энэ хуяг дуулгыг өмссөнөөр бидэнд ирэх ашиг тусыг ярилц. Хуяг дуулгын шинэ хэсэг бүрийг дурьдахдаа ямар утгатай болон яагаад чухал болох тухай санааг залуу эрэгтэйчүүдэд өгөхийг зөвшөөр. Дараа нь хичээлд өгөгдсөн санааг хуваалц. Энэ судрын хэсэг бүрийг ярилцахдаа самбарт зохих өгүүлбэрийг бич. Дууссаны дараа самбар ийм байх ёстой:

Бэлхүүсээрээ (боолттой, хамгаалалттай)
үнэнийг бүсэл
Зөв байдлын хуягийг өмс
Амар тайвны сайн мэдээний бэлэн байдлыг
хөлдөө өмс
Итгэлийн бамбай
Авралын дуулга
Сүнсний сэлмийг ав

Ишлэл

Бурханы хуяг дуулгыг тайлбарлахдаа дараах санаануудыг ашигла.

“Бэлхүүс гэж юу вэ? Сударт Их Эзэний хүүхдүүддээ шинэ амьдрал эхлүүлэхээр өгсөн хүчийг төлөөлдөг. Бэлхүүс нь богино хавирга болон ташаа хоёрын хоорондох биеийн хэсэг юм. Их Эзэн үнэнийг бүсэл гэсэн нь энэ хүчийг шинэ амьдрал эхлүүлэхэд хэрэглэхийг хэлсэн юм. ‘Мэдлэгийн үнэн бол одоо байгаа, байсан, мөн ирээдүйд болох зүйлсийн мэдлэг’ юм (С ба Г 93:24).

“Ямар нэг зүйлийг бүслэхдээ та нар юу хийдэг вэ? Хэрэв би бугуйндаа бүслэх гэж буй бол би үүнийг тойруулан ямар нэг зүйлээр бооно. Жишээлбэл, би бугуйгаа алчуураар бооё. Хэрэв би түүнийг бугуйгаа тойруулан чанга боовол энэ нь миний бугуйг хүчтэй болгоно. Их Эзэн бэлхүүсээрээ үнэнийг бүсэл гэж хэлжээ. Миний бодлоор энэ нь энэ хүч ямар нандин бэ гэдгийг болон түүнийг ашиглах нөхцөл ба зааврыг ойлгох гэсэн утгатай юм. . . .

“Их Эзэн дараачийн өмсөх хуяг дуулгыг тайлбарлахдаа: “Зөв байдлын хуягтай бай ” гэжээ (С ба Г 27:16). Хуяг нь та нарын цээжийг халхалж зүрх болон уушгийг хамгаалах хэсэг байна. Та нар зүрхгүйгээр их удаан амьдарч чадахгүй. Хэрэв сум та нарын зүрх рүү орж ирвэл та нар байлдахаа болих хэрэгтэй болно. . . .

“Гэмтээхгүйн тулд Их Эзэн биднээс тэр амин чухал хэсгийг халхлахыг хүссэн. Хүн зөв байдлын хуягийг хэрхэн өмсөх вэ? Миний бодлоор хуяг дуулгын энэ хэсэг зарлигуудыг сахиснаар ирнэ. Их Эзэний зарлигуудад дуулгавартай байх нь агуу адислалуудыг авчирдаг. . . .

“Их Эзэн, ‘Амар тайвны сайн мэдээний бэлэн байдлыг хөлдөө өмс,’ хэмээн хэлжээ (С ба Г 27:16). Та нар үүнийг хэрхэн хийх вэ? Бидний бие махбод бол гайхамшигтай зүйл. Үйлдлийг нэлээд хэдэн удаа хийхэд энэ нь зуршил болж, бараг мэдрэх нөлөөгүйгээр зуршил нь автоматаар бидний төлөө ажиллахаар зохион байгуулагдсан байдаг. Бид өөрсдийнхөө зуршлын загварыг бий болгодог.

“Жишээлбэл, хэрэв бид залбирах зуршлыг бий болгосон бол залбирахгүй байснаас залбирах нь амархан байх болно. Бид зуршлыг бидний эсрэг бус харин бидний төлөө автоматаар ажилладаг болгож чадна. Тэдгээр нь хамгаалах хамгийн хүчтэй эх сурвалж болдог. Бид амар тайвны сайн мэдээний бэлэн байдлыг хөлдөө өмсвөл бид зарлигуудыг сахиж зуршлууд бидний төлөө ажиллаж байна гэсэн утгатай билээ.

“Хуяг дуулгын дараагийн хэсэгт орьё. ‘Муу нэгний бүх галт сумыг унтрааж чадах итгэлийн бамбайг ав’ (С ба Г 27:17). Бамбай бол дайсны чинь чам руу явуулсан юмнаас та нарыг хамгаалж чадах, ихэвчлэн зүүн гарт чинь байдаг зүйл юм. Баатруудын үед энэ нь чулуу, сум, зэвсэг болон жаднаас хамгаалдаг байжээ.

“Сүнслэг хуяг дуулгын энэ хэсэг бол Их Эзэнд итгэх итгэл юм. Энэ нь та нарын Их Эзэний үгийг ойлгох ойлголт буюу мэдлэгээс чинь ирдэг баталгаа юм. Та нар судар уншиж байхдаа Их Эзэний үгийг сонсдог. Түүний бошиглогчдыг сонсож байхдаа та нар Их Эзэний үгийг сонсдог. Залбирч байхдаа Их Эзэний үгийг мэдэрдэг. та нар итгэлийг хөгжүүлж чадна.

“Их Эзэн дараа нь, “Авралын дуулгыг ав ” гэсэн (С ба Г 27:18). Дуулга толгойг хамгаалдаг. . . .

“Минийхээр бол авралын дуулга нь бид хэн бэ, бид яагаад энд байгаа вэ, бид хаашаа явах вэ болон бид юу хийж чадах вэ буюу ямар болж чадах вэ гэдгээ мэдэх нь юм.

“Одоо хамгийн сүүлчийн хэсгийг Их Эзэн хэлэхдээ, ‘миний Сүнсний сэлмийг ав,’ гэжээ.

“Хэрэв бид бэлтгэгдсэн, Сүнстэй, дуулгавартай, өөрсдийнхөө үүргийг биелүүлбэл ямар гайхамшигтай зүйл болохыг мэдэж байна уу? Их Эзэний биднээс үүрэхийг хүссэн ачааг бид үүрч чадна. Энэ нь тийм амархан биш. Хэрэв энэ амархан байсан бол үүнийг хийлгэхээр энд онцгой залуу эрэгтэйчүүдийг илгээх хэрэггүй байсан юм. Тэр та нарыг бэлтгэж та нарыг нөөцөндөө байлгаж сургаж, та нарт энэ өдөр ирэх боломжийг бий болгосон. Их Эзэнийг та нарын нэг нь ч гомдоохгүй гэдэгт би найдаж байна. Та нарыг энэ итгэлийг хүлээн түүний бүрэн хуяг дуулгыг өмсөн энэ сорилтын өдрүүдэд зогсож чадна гэдэгт би найдаж байна ” (Rex C. Reeve, Sr., “The Whole Armor of God,” *Brigham Young University 1981–82 Fireside and Devotional Addresses* {Provo, Utah:Brigham Young University Press, 1983}, pp. 189–97).

- Зөвхөн нэг хэсгийг нь бус харин Бурханы бүрэн хуяг дуулгыг өмсөх нь яагаад чухал вэ?
- Энэ хуяг дуулга нь биднийг дэлхийд байхдаа дэлхийн бусаар байхад хэрхэн тусалж чадах вэ?

Дүгнэлт

Уриалга

Залуу эрэгтэй бүрд өөрсдийнхөө хуяг дуулгыг хянаж үзээд, дараах зүйлээс ирэх долоо хоногт илүү сайн суралцахаар сонгохыг зөвлө. Үүнд: үнэн, шударга ёс буюу зөв байдал, итгэл, аврал, Сүнс.

Тэднийг Мормоны Номын Сэдвүүдийн Лавлагаанаас судруудыг уншиж юу сурснаа эцэг эхтэйгээ ярилцахыг зөвлө.

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр өөрийгөө үнэлэхийг ойлгож эрэлхийлж мөн шударга байснаар ирэх хүч чадлыг ойлгох болно.

БЭЛТГЭЛ

- Шаардлагатай материалууд:
 - Залуу эрэгтэй бүрт судар.
 - Залуу эрэгтэй бүрт судар тэмдэглэх харандаа.
- Тус бүрд нь дараах жишээнүүдийг бичсэн таван хуудсыг бэлтгэ:
 - Утас дуугарав. Жоон 'Боб байвал намайг гэртээ байхгүй гэж хэлээрэй!' гэв.
 - Аав унтчихжээ. Тэр арван таван минут ажлаасаа хожигдчихов. Тэр даргадаа 'автобус маань хожигдсон' гэж тайлбарлав.
 - Тоод наснаасаа жижигхэн харагддаг ба кино театрт хагас үнээр ордог. Тэр, 'Зүгээр ээ, яагаад гэвэл кино театр маш их мөнгө олдог юм чинь,' гэж хэлжээ.
 - Роберт шалгалтанд их сайн оноо авах хэрэгтэй боловч бэлтгээгүй байна. Тэр түүний хажууд суудаг Жакаас хуулж болно. 'Зөвхөн энэ удаа хуулахад юу нь буруу байх вэ' гэж Роберт хэлэв.
 - 'Би үүний тухай өөр ямар ч хүн бүү сонсоосой гэж бодож байна' гэж Престон Стивд нууцаа хэлжээ. 'Битгий санаа зов. Би хэнд ч хэлэхгүй' гэж Престон хэлсэн ч аль хэдийн Филд хэлэхээр төлөвлөж байна.
- Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө товхимлын 9, 10-р хуудсан дахь шударга байх тухай зөвлөмжийг тоймло.

ТАЙЛБАР

Ихэнх залуу эрэгтэйчүүд шударга байх ёстой гэдгийг сайн мэддэг боловч тэдний шударга байхыг шалгасан янз бүрийн нөхцөлийг болон шударга амьдралд агуу адислалууд ирэх болно гэдгийг сануулах ёстой байдаг. Хичээл зааж байх үед болон амьдралдаа шударга байдалд хандах таны хандлага тодорхой байх болно. Та шударга байх хүслээ болон Их Эзэний энэ чухал хандлагыг үнэлсэн байдлыг залуу эрэгтэйчүүдэд мэдүүл.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Үйл ажиллагаа
ба ярилцлага

Бид Ямар ч Үед Шударга Байх Ёстой

Хуудсуудыг тарааж жишээнүүдийг чангаар уншуул.

- Эдгээр нөхцлүүд ямар талаараа төстэй вэ?

Нөхцөл бүрийг болон үр дагавар бүрийг ярилц.

Эдгээр жишээнүүдийн шударга бус үйлдэл нь хүнийг шоронд оруулж, бие бялдрын гэмтэл учруулж буюу сайн торгууль оногдуулдаггүй гэдгийг онцлон хэл. Гэвч үйлдэл тус бүр нь буруу бөгөөд энэ нь зуршил болж цаашдаа бусад буруу зүйл рүү хөтөлж мэднэ. Иймэрхүү үйлдлүүд бусдад шударга бус байхыг заадаг.

Судар ба ярилцлага

Дараах судруудад Их Эзэн шударга байдлын тухай юу хэлснийг уншуулж тайлбарлуулах хоёр залуу эрэгтэйг сонго: Египетээс гарсан нь 20:15–16; Сургаал ба Гэрээ 136 :25–26.

Ишлэл

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл хүмүүс шударга бус байдлыг янз бүрээр зөвтгөдөг тухай ярихдаа:

"Практикт бүх шударга бус байдал нь бидний өөрийгөө зөвтгөх хэмээн нэрлэдэг энэхүү дотоод гуйвуулалтанд оршиж, өсдөгөөрөө өртэй. Энэ бол хуурах явдлын

анхны, хамгийн адгийн, хор хөнөөлтэй, сүйтгэгч хэлбэр болох өөрийгөө хуурах явдал юм.

“Аяга кофе уудаггүй боловч төмөр замын задгай вагоноос нүүрс хулгай хийдэг хүн байдаг. Сүмийнхээ бүх үйл ажиллагаанд оролцдог мөртлөө ажиллуулагчаасаа таван зуун доллар хулгайлдаг охин байдаг. Ням гарагт ариун ёслолыг адисладаг мөртлөө өмнөх хагас сайны орой нь нүгэлтэй янаглалд оролцсон залуу эрэгтэй байдаг. Зээлээд буцааж төлөхөө умартдаг олон хүмүүс байдаг” (in Conference Report, Mexico and Central America Area Conference 1972, p. 27).

Ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр бид өөр ямар замаар шударга бус байдалд уруу татагддаг болон шалтгаануудыг ярилцуул. Та замын хөдөлгөөний дүрэм зөрчих, зөвшөөрөлгүй бусдын эд зүйлийг хэрэглэх, үнэнийг хэлэхгүй байх, өөрсдийгөө болон бусдыг хамгаалах үүднээс мэдээллийг нуун дарагдуулах ба хуурах зэргийг ярилцаж болно.

- Шударга бус байх уруу таталтуудыг та нар хэрхэн даван гарах вэ?

Ариун Сүнсээр удирдуулахын төлөө залбирч, бид хатуу байх боловч бусдад өөрсдийгөө бүхнээс дээр хэмээн үзүүлэхгүй ба бусдыг хүндэтгэх ёстой гэдгийг тайлбарла.

Итгэлийн тунхаг

- Итгэлийн хэддүгээр тунхагт шударга байдлын тухай бидний итгэлийг харуулдаг вэ?

Залуу эрэгтэйчүүдээр арван гурав дахь итгэлийн тунхгийг олж уншуул. *Бид шударга байна гэдэгт итгэдэг* гэсэн өгүүлбэрийн доогуур зуруул.

Дараах шударга байх шалтгаануудад залуу эрэгтэйчүүдээр дотроо хариулуул.

Та нарын шударга байх нь

1. Усан баталгаа хийлгэсэн учраас уу?
2. Та нарын эцэг эх та нарыг шударга байхыг хүсдэг учраас уу?
3. Энэ нь итгэлийн тунхагт байдаг учраас уу?
4. Найзууд чинь болон харилцдаг хүмүүс чинь шударга учраас уу?
5. Гэр бүлд чинь шударга ёс, зарчимч байх нь уламжлагдсан учраас уу?
6. Та нар баригдахаас айдаг учраас уу?
7. Хэрэв та нар шударга бус байвал цээрлэгдэх учраас уу?
8. Энэ бол Бурханы зарлиг учраас уу?
9. Эргэн тойронд байгаа хүмүүс чинь та нарыг шударга гэж боддог, тиймээс та нар тэднийг гомдоохыг хүсдэггүй учраас уу?
10. Та нар пристийн зэргийг атгадаг учраас уу?

Одоо хийсэн жагсаалтаа дахин харж залуу эрэгтэйчүүдтэй шударга байх шалтгаан бүрийг ярилц.

- Аль нь шударга байхад сайн шалтгаан биш вэ?
- Аль нь шударга байхад сайн шалтгаан бэ?
- Аль нь хамгийн чухал шалтгаан бэ?

Түүх

Дараах түүхийг уншаад залуу эрэгтэйчүүдэд ангийн багш хэрхэн ангиа шударга байгааг шалгасныг сонсго.

“Ангийнхаа оюутнуудад би ихэнх үед бидний зарчимч байдал шалгагдаж байгааг мэддэггүй гэдгийг тайлбарлаж, шударга байх хэрэгтэйг онцлон хэлсэн юм.

“Тиймээс манай анги Пүрэв гарагийн үдээс хойш өгсөн жижигхэн сорилтын асуултанд бэлтгэлтэй байх ёстой байв. Энэ бол долоо хоногийн үеэр бидний ярилцаж байсан материалуудыг хамарсан үнэн- худал гэсэн хорин асуулттай сорилт байв. Тэд сорилтоо дөнгөж завсарлах хонх дуугарахаас өмнөхөн дуусгав.

“Цааснуудаа эгнээнийхээ гол руу дамжуулаарай,’ хэмээн би заавар өгөв.

“Дараа нь тэр орой би маш анхааралтой цаас бүрд оноо өгч онооныхоо дэвтэрт бичсэн боловч ч тэдний цаасан дээр юу ч тэмдэглэсэнгүй.

“Маргааш өглөө ангийг цуглахад нь би цааснуудыг буцааж өгөөд урьдынх шигээ оюутан бүрээс цаасан дээрээ ямар оноо авсныг нь асуув.

“Би асуулт бүрийг зөв хариултыг тайлбарласан үгтэй хамт чанга уншиж өгөв. Хариулт бүр оюутнуудын зөв юмуу буруу хариулт өгсөн ёлох буюу сэтгэл тайвшран санаа алдахтай дагалдаж байв.

“Нийт зуун онооноос орхисон болгондоо тавыг хасаарай’ гэж би заавар өгөв.

“Оноогоо хэл.’

“‘Жоон?’

“‘85!’

“‘Сузан?’

“‘95!’

“‘Хэролд?’

“‘80!’

“‘Арнолд?’

“‘90!’

“‘Мэри?’

“‘45,’ гэсэн хариулт арайхийн сонсогдов.

“Би цааш нь оноонуудыг өөрийнхөө онооны дэвтэрт бичиж, урьд шөнө нь тавьсан онооныхоо хажууд амаар өгснийг нь анхааралтай тэмдэглэв. Харьцуулалт нь тодорхой байв.

“Намайг юу хийснээ тайлбарлахад ангид чив чимээгүй байдал бий болов. Олонхи нь ширээнээсээ дээш хараагүй ба бусад нь нэг нэг рүүгээ хяламхийсэн харц, хурдан инээмсэглэл шидэлцэв.

Би оюутнуудтайгаа намуухнаар ярилцав.

“Зарим нэг нь надтай өнөөдрийн тохиолдлын тухай ганцаарчлан уулзахыг хүсэх байх. Тэгвэл би дуртай байх болно.’

“Энэ бол өөр төрлийн сорилт байсан юм. Энэ бол шударга байдлын сорилт юм. Та нар шударга байсан уу, үгүй юу? Та нарын олонх нь Мэрийг өөрийнхөө оноог 45 гэж хэлэхэд түүн рүү харсныг би анзаарсан юм. Хэрэв чи зөвшөөрвөл босохгүй юу Мэри? Та бүхнийг би миний дэвтэр дээр Мэри ангидаа хамгийн дээд оноог авсан гэдгийг мэдээсэй гэж хүсэж байна. Мэри чи надад их бахархал төрүүллээ.’

“ Мэри эхлээд ичиж байснаа болиод дээш харан түүний гялалзсан нүд инээмсэглэж хөл дээрээ цэх зогсов. Мэрийг тийм өндөр цэх болж зогсож байгааг би хэзээ ч хараагүй юм” (Wayne B. Lynn, “True. . . or. . . False,” New Era, 1978, p. 11).

Бодох асуулт

- Та нар тэр сорилтыг давах байсан уу?

Ярилцлага

Маш олон хүн хэн ч үнэнийг мэдэхгүй л бол шударга бус байдлыг тоохгүй байдаг гэдгийг тайлбарла.

- Үнэнийг хэн үргэлж мэддэг вэ? (Бид ба Тэнгэрлэг Эцэг.)

Судрын уншлага

- Бүх зүйл дээр шударга байх нь боломжтой юу?

Энэ асуултанд хариулахын тулд Антай- Нифай- Лихайн хүмүүсийг дүрсэлсэн Алма 27:27 мөн Хоёр мянган дайчдын тухай өгүүлдэг Алма 53:20-ийг залуу эрэгтэйчүүдээр уншуулж тэмдэглүүл.

Шударга Байсны Адислалууд

Ярилцлага

• Шударга байсны ямар нэмэлт адислалууд байдаг вэ?

Залуу эрэгтэйчүүдээр хариулуулаад дараах санаануудыг онцлон хэл:

1. Бид өөрсдийнхөө болон бусдын талаар сайн сэтгэгдэлтэй байна.
2. Бусад хүмүүс бидэнд итгэж бид ч мөн бусдад итгэж чадна.
3. Бид Ариун Сүнсээр удирдуулахуйц зохистой байна.
4. Бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ илүү үр дүнтэйгээр харьцаж чадна.

• Шударга байснаар та нар хэрхэн адислагдсан бэ?

Та Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө товхимлын 9,10-р хуудсан дахь шударга байх тухай зөвлөмжийг уншиж ярилцаж болно.

Ишлэл

Нэгдсэн Улсын сангийн нарийн бичгийн дарга бөгөөд Сүмийн хуучин элчин сайд асан Дэвид М.Кеннидийн дараах мэдэгдлийг унш: “Хүний зарчимч байдал нь түүний зан чанар ааш авирыг бусад хүмүүс дүгнэх эцсийн хэмжүүр болдог.”

Түүх

Шударга байдлын нөлөөг харуулсан дараах түүхийг ярь:

“Намайг арван хоёр орчим настай байхад манай гэр бүл Юта Канабад амьдардаг байв. Пают Индианы бүлэг ширгэсэн голын цаад талд хэдэн милийн зайтай буудаллав. Миний аав Индиан номлогч Жаков Хамблин надад ‘хүү минь, би та нарыг индианы буудалласан газар руу үдээс хойш очоод давжаа хээр мориор бидэнд энэ өвөл хэрэг болох зарим хөнжлөөр солиод ирээсэй гэж хүсэж байна’ гэв.

“Үдийн хоолны дараа би хөгшин Били дээрээ мордоод давжаа хээр морио хөтөлж, Индианы буудалласан газар чиглэн талыг гатлан зайдан давхив.

“Намайг давхин ирэхэд гэрийн омгийн ахлагч намайг мориноос буухад минь туслангаа ‘Чи Жакобын хүү юу? Юу хүссэн юм бэ?’ хэмээн асуув.

“Намайг түүнд хүсэлтээ хэлэхэд солио хийх давжаа мориог харж, зөвшөөрснөө шуухитнав. Тэр намайг гараар хийсэн Индианы хөнжлөөр дүүрэн урцанд дагуулан ирэв. Тэднээс тэр нэлээд хэдийг давхарлав. Би аавдаа сайн наймаачин болохоо үзүүлэхийн тулд дахин нэг хөнжил нэхэв. Омгийн ахлагч намайг нүднийхээ булангаар харангаа дахин нэгийг миний овоолсон дээр нэмэв. Тэгээд би дахин нэг нэгээр нэмсээр байв. Тэгсэн ч омгийн ахлагч инээмсэглэсээр миний шаардсан хөнжлүүдийг нэмсээр байв.

“Би үнэхээр сайн наймаа хийсэндээ сэтгэл ханаж наймаагаа зогсоов. Омгийн ахлагч хөнжлүүдийг хөгшин Билигийн нуруун дээр овоолж намайг өргөж өгөв.

“Аав надтай хашаан дотор уулзаад хөнжлүүд рүү харав. Тэгээд тэр хоёр овоолсон тэнцүү хэсэгт хуваав. Нэг овоолгоотойг нь морин дээр тавиад намайг буцааж мордуулаад ‘Буцаж очоод омгийн ахлагчид үүнийг буцааж өг. Та нар хоёр моринд хүрэхэд хангалттай хөнжил авчихсан байна’ гэв.

“Би буудалласан газар хүрч ирээд омгийн ахлагчийг харав. Намайг мориноосоо буухад тэр чангаар инээгээд ‘Жаков та нарыг буцаагаад явуулна гэж би мэдэж байсан юм. Тэр шударга хүн. Тэр та нарын аавтай адил миний ч аав’ гэж хэлэв.

“Сүүлд нь хэдэн жилийн дараа Жаков ганцаараа дайсагнасан ууртай Индиануудын бүлэгтэй тулгарахад түүний үргэлж шударга байдаг нь амийг нь аварчээ” (Jacob Hamblin, Jr., as told by Louise Lee Udall, “A Horse Trade Story,” in *A Story to Tell* [Salt Lake City: Deseret Book Co., 1946], pp. 359–60).

Ярилцлага

Хичээлийн эхэнд өгсөн таван жишээ залуу эрэгтэйчүүдээр тоймлуул. Хэн нэгнээр жишээ бүрийг уншуулж тэгээд залуу эрэгтэйчүүдээр нөхцөл бүрийг шударга байдлын жишээгээр солиул.

Гэрчлэл ба уриалга

Бүх зүйл дээр шударга байх нь залуу эрэгтэйчүүдэд агуу их адислалуудыг авчрах бөгөөд тэднийг амьдралынх нь бүх тал дээр өсгөх болно гэдгийг гэрчил. Ирэх долоо хоногийн өдөр бүр бүрэн шударга байхаар сайжрах болон тэд амьдралдаа шударга байх загварыг тогтоохыг тэдэнд уриал. *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө товхимлоос* шударга байх тухай зөвлөмжийг уншихыг тэдэнд зөвлө.

Тахир Дутуу Хүмүүсийг Үнэлж, Урамшуулах нь

50

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр тахир дутуу хүмүүсийг хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэгдэлтэй болох, сайн мэдээг сурах, амжилттай оролцох ба бусдад үйлчлэхэд нь туслах үүрэг хариуцлага хүлээн зөвшөөрөх болно.

БЭЛТГЭЛ

- Шаардагдах материалууд:
 - Залуу эрэгтэй бүрт судар.
 - Залуу эрэгтэй бүрт харандаа.
- ТАХИР ДУТУУ ХҮМҮҮС гэсэн том үсгээр бичсэн хувийг залуу эрэгтэй бүрт бэлтгэ.
- Хэрэв танай бүсэд *Family Home Evening Video Supplement 2* (53277) байгаа бол “Тахир Дутуу Хүмүүст Талархах нь” гэсэн 13-р хэсгийг үзүүлж болно.

ХИЧЭЭЛ ЗААХ ЗӨВЛӨМЖ

Үйл ажиллагаа
ба ярилцлага

Тахир Дутуу Хүмүүсийг Ойлгох

ТАХИР ДУТУУ ХҮМҮҮС гэсэн үгтэй хувийг тараа.

Залуу эрэгтэйчүүдийг ТАХИР ДУТУУ ХҮМҮҮС гэсэн үгийн үсгүүдийг бичдэггүй гараараа яг зөв боловч маш хурдан дагуулан бичихийг уриал. Тэд удаан бөгөөд хэцүү үйл явцтай тулгарах ёстой. Тэдэнд хугацаа өг. Тэднийг хурдлахыг шамдуул. Сайн ажилласаныг нь магт. Ард хоцорсон дээр шахалт үзүүл. Цаг болсныг хэл.

- Та нарын боломжоос хол хэцүү даалгаврыг гүйцэтгэх шахалтан доор ажиллахад та нарт ямар санагдаж байна вэ?

Энэ нь суралцаж тахир дутуу хүн ихэнхдээ сүмийн болон сургуулийн хичээл дээр ямар сэтгэгдэлтэй байдагтай адил юм.

Бидний эргэн тойронд бие бялдрын, оюун ухааны, сэтгэл санааны чадваргүй хүмүүс байдаг. Зарим тахир дутуу хүмүүст түшлэг, дугуйтай сандал болон сонсголын багаж хэрэглэхийг шаарддаг. Тэдгээр зүйлс нь тахир дутуу хүний харагдах шинж болдог. Тахир дутуу хүмүүсийн бусад олон шинж нь тийм ч илэрхий биш юм. Тахир дутуу хүмүүст бидний үйлдэл ба хандлага нөлөөлдөг. Бид ер нь тэдний асуудлыг шийдвэрлэж чадахгүй ч бид тэдэнтэй хэрхэн хандаж байгаагаас тэдэнд тусалж бас тэднийг гомдоож болдог.

Христийн Адил Нигүүлсэл Үзүүлэх

Судар ба ярилцлага

Залуу эрэгтэйчүүдээр 3 Нифай 17:7–10-ыг уншуул.

- Тахир дутуу хүмүүст Есүс хэрхэн хандаж байсан бэ?
- Бид үүнтэй адил хандлагыг хэрхэн хөгжүүлж чадах вэ?

Үйл ажиллагаа

Хэрэв танай бүсэд *Family Home Evening Video Supplement 2* (53277) байгаа бол “Тахир Дутуу Хүмүүст Талархах нь” гэсэн 13-р хэсгийг үзүүл.

Багшийн
танилцуулга

Бид тахир дутуу хүмүүст энэрэл үзүүлэх ёстой. Бидний ихэнх маань амьдралын явцад өвчин буюу ослоос болж удаан хугацааны тахир дутуу болох болно. Магадгүй бид биологийн оюутан Кентэй адил хараагүй болж болох байх. Тэр “би ихэнх зүйлийг бусдын адил хийж чадах боловч надад өөр зэмсэг, өөр арга зам хэрэгтэй. Надад зэмсгүүд болон арга замуудыг олоход минь туслаач. Битгий миний өмнөөс юм хий, харин надад чадамжаа ашиглахад минь туслаач,” хэмээн хэлжээ.

Судар ба ярилцлага	<p>Залуу эрэгтэйчүүдээр Иохан 13:34–35-ыг уншуул.</p> <ul style="list-style-type: none"> • Хэрэв бид үнэхээр Христийн төлөөлөгчид юм бол юу хийх ёстой вэ? (Бие биенээ хайрлах.) • Тахир дутуу хүмүүстэй харилцахдаа бид энэхүү хайраа хэрхэн үзүүлж чадах вэ? (Бид биднээс ялгаатай хүмүүсийг ойлгох болон хүлээн зөвшөөрөхийг сурч чадах бөгөөд тэдний чадамжийг эрэх болно.) • Тахир дутуу хүмүүст бид тэднийг хүлээн зөвшөөрч тэдний төлөө санаа зовж байгаагаа хэрхэн үзүүлж чадах вэ? (Тэдний өөдөөс эгцлэн харж, инээмсэглэж, бусад хүмүүстэй адил харьцана.)
Жишээнүүд	<p>Суга таягтай явдаг нэг охин: “Намайг танхим уруудаад явж байхад хүмүүс хажуугаар өнгөрөхдөө миний нүд рүү хардаггүй. Тэгэхээр надад яг, ‘Чамайг би зүгээр болгож чадахгүйгээс хойш чамайг болон асуудлыг чинь хараагүй дүр үзүүлнэ’ гэж хэлж байгаа юм шиг санагддаг,” хэмээн ярьсан юм.</p> <ul style="list-style-type: none"> • Илэрхий эрхтэн дутуу хүмүүсээс зугтаж дөлөхийн оронд бид юу хийж болох вэ? <p>Оюуны хомсдолтой нэг хүү: “Хүн бүр миний сэтгэл санааг ямар байгаа, миний юунд дуртайг эцэг эх юмуу найз нөхдөөс маань миний толгой дээгүүр ярилцаж олж мэддэг. Тэд намайг яг тэнд нь зогсож байхад ‘Жэррид энэ хэрэгтэй юу?’ гэж асуухын оронд надтай яагаад ярьдаггүй юм бэ?” гэж ярьжээ.</p> <ul style="list-style-type: none"> • Ийм хүнтэй бид өөрөөр яаж харьцаж болох вэ? <p>Сонсгол муутай нэг залуу эмэгтэй: “Хүмүүс надтай мэндлээд, дараа нь яараад яваад өгдөг. Хэрэв хэн нэг хүн яриад эхэлбэл, надад үнэхээр сайхан санагдахсан. Хэрэв хүн над руу эгцлэн хараад, амаа даралгүйгээр тодорхой яривал, би уруулынх нь хөдөлгөөнийг сайн уншдаг. Би та нарт ойлгогдохоор хариулж чадна. Нэг нэгэнтэйгээ ярилцсанаар нөхөрлөл эхэлдэг,” гэж хэлжээ.</p> <ul style="list-style-type: none"> • Та нар ийм хүнтэй яаж илүү сайн харилцах вэ? <p>Хувийн болон эерэг хэллэг хэрэглэ. Учир нь хувь хүний тухай яригдаж байгаа болохоос биш тахир дутуу хүний тухай буюу тэд юу хийж чадахгүй тухай биш юм.</p> <p>Зарим хүмүүс тахир дутуу хүмүүсийн тухай ярихдаа сөрөг, хор хөнөөлтэй сэдвүүдийг ашигладгийг тайлбарла. Дараахь хэллэгүүдийг самбар дээр бичээд, эдгээр хэллэг нь тахир дутуу хүнийг ичээх юмуу гомдоохоос хэрхэн зайлсхийж байгаа талаар ярилц.</p> <ul style="list-style-type: none"> • <i>Дугуйтай сандал хэрэглэдэг хүн</i> • <i>Суга таяг, таяг ашигладаг хүн</i> • <i>Оюун санааны болон сэтгэцийн гажигтай хүн</i> • <i>Оюун санааны гажигтай хүн</i> • <i>Дүлий эсвэл сонсголын гажигтай хүн</i> • <i>Дультраа хэлтэй хүн</i> <p>Тахир дутуу биш хүмүүс нь “хэвийн” гэсэн утга илэрхийлсэн хэллэгийг бид ашиглаж болохгүй. Бид тэднийг тахир дутуу биш хүмүүс гэж энгийнээр хэлж болно.</p> <p>Тахир дутуу хүмүүст анхаарал халамж гарган хандвал бид тэднийг бидний нэг адил хэрэгцээтэй Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд мэт харж эхлэх болно.</p>
Самбар ба ярилцлага	<p>Зарим хүмүүс тахир дутуу хүмүүсийн тухай ярихдаа сөрөг, хор хөнөөлтэй сэдвүүдийг ашигладгийг тайлбарла. Дараахь хэллэгүүдийг самбар дээр бичээд, эдгээр хэллэг нь тахир дутуу хүнийг ичээх юмуу гомдоохоос хэрхэн зайлсхийж байгаа талаар ярилц.</p> <ul style="list-style-type: none"> • <i>Дугуйтай сандал хэрэглэдэг хүн</i> • <i>Суга таяг, таяг ашигладаг хүн</i> • <i>Оюун санааны болон сэтгэцийн гажигтай хүн</i> • <i>Оюун санааны гажигтай хүн</i> • <i>Дүлий эсвэл сонсголын гажигтай хүн</i> • <i>Дультраа хэлтэй хүн</i> <p>Тахир дутуу биш хүмүүс нь “хэвийн” гэсэн утга илэрхийлсэн хэллэгийг бид ашиглаж болохгүй. Бид тэднийг тахир дутуу биш хүмүүс гэж энгийнээр хэлж болно.</p> <p>Тахир дутуу хүмүүст анхаарал халамж гарган хандвал бид тэднийг бидний нэг адил хэрэгцээтэй Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд мэт харж эхлэх болно.</p>

Тахир Дутуу Хүмүүст Үйлчлэх

Түүх ба ярилцлага	<p>Тахир дутуу хүмүүст үйлчлэхдээ бид Аврагчид хайраа болон түүнтэй адил болох хүслээ үзүүлдэг. Ахлагч Ж.Ричард Кларк Аврагчийн жишээг дагаж тахир дутуу залуу эрэгтэйг хайрлаж, түүнд үйлчлэхийг сурсан зарим Аароны пристийн зэрэгтнүүдийн тухай ярьжээ:</p> <p>“Жоон Андерсон булчин задрах өвчний эсрэг зоригтой тэмцэгч гайхамшигтай залуу эрэгтэй байв. Тэр Аароны пристийн зэргийнхээ хугацаанд хэдэн жилийн турш дугуйтай тэрэг хэрэглэдэг байв.</p>
-------------------	--

“Жоон хэдий хөл бөмбөг хэзээ ч тоглоогүй ч, тэдэнтэй хамт зугаалгаар яваагүй ч, бүжиглээгүй ч, жирийн өсвөрийнхний үйл ажиллагаанд оролцоогүй ч түүний (пристийн) чуулгадаа үзүүлсэн нөлөө нь гүн гүнзгий байсан юм. Энэ нь түүний Сүмд өгсөн тангараг нь түүний чуулгынхныг татсан байна. Өөр нэг юм нь Жоон чуулгандаа хайраар үйлчлэх боломжийг олгосон явдал юм.

“Жоон дикон байхдаа ариун ёслол түгээхийг хүсжээ. Жоон тавиурыг өвөр дээрээ тавиад явахад нь нэг хүү тэргийг нь түрэх даалгавар авчээ. Эхлээд энэ төвөгтэй мэт байсан боловч удалгүй бусад нь түүнд пристийн зэргийнхээ үүргийг гүйцэтгэхэд нь туслахдаа дуртай болов.

“Жоон Пристээр томилогдох үед маш сул дорой байсан тул ариун ёслолыг өвдөглөн адислаж чадахгүй байв. Түүний чуулга шийдвэр олов. Тэд түүний тэргийг ариун ёслолын ширээний хажууд байрлуулав. Нэг нь талхыг хувааж тэрэгнийх нь дэргэд түүний өмнөөс өвдөглөн Жооныг тэр нандин үгнүүдийг хэлж байхад нь түүнд микрофон барьж өгдөг байв. Үүнийг тэд ахдаа хийж өгөх нь удалгүй чуулга дахь хүн бүрийн хувьд хүндэтгэл болжээ.

“Тэд пристийн чуулгын нэгдүгээр туслахын хувьд түүний удирдлагыг баяртайгаар дагав. Жоон Ийгл скаут болох мөрөөдлөө хэрэгжүүлж чадахгүй байсан тул пристүүд мөнгө цуглуулж онцгой зорьсондоо хүрэх дарцаг ариун ёслолын цуглаан дээр өгчээ. Үүнд: ‘Жоон Андерсонд, чуулгадаа үйлчилсэн чиний гарамгай үйлчлэл болон бидэнд агуу үлгэр жишээ болсны төлөө гардуулав’ гэсэн байв.

“Олон жилийн турш Жооны чуулгынхан олон төрлийн хөгжилтэй үйл ажиллагаануудад дуртай байсан боловч тэдний хэнд нь ч найз Жоонтой хуваалцахаар сонгосон энэ тохиолдлоос нь илүү агуу нөлөө үзүүлж, пристийн зэргийн дуудлагаа гүйцэтгэх тухай зааж өгсөн тохиолдол байгаагүй юм” (in Conference Refort, Apr. 1991, pp. 56–57; or Ensign, May 1991, p. 42).

- Энэ залуу эрэгтэйн чуулга түүнд хэрхэн тусалсан бэ?
- Аароны пристийн зэрэгтний хувьд бид тахир дутуу хүмүүст үйлчлэхээр юу хийж чадах вэ?

Самбарт залуу эрэгтэйчүүдийн хариултыг бич. Дараах санаануудыг онцлон хэл:

1. Тэдний найз бай. Тахир дутуу хүмүүсийг бусадтай ижилхэн урьж, тэдний хажууд сууж, тэднийг сонсож, тэднийг хүндэтгэн харьц.
2. Пристийн зэрэгтний цуглаан дээр сайн үлгэр жишээ байж, хэрхэн харьцахаа мэдэхгүй байгаа залуу эрэгтэйчүүдэд пристийн зэрэгтний цуглаан дээр хэрхэн зөв оролцохыг сурахад нь туслах.
3. Зохимжгүй зан төлвийг тоохгүй бай. Үймүүлэхийн оронд хичээл болон пристийн зэргийн удирдагч руу анхаарлаа хандуул.
4. Зөв байдлаар хувь нэмэр оруулбал тэднийг магт.

Зөвлөх бүх тахир дутуу гишүүдэд хэрхэн үйлчлэхийг залуу эрэгтэйчүүдэд зааж өгөх ёстой. Үүнийг хийхийн тулд залуу эрэгтэйчүүд үр ашигтайгаар төлөвлөж, хуваалцахад бэлэн байх ёстой.

Тахир Дутуу Хүмүүсийг Бусдад Үйлчлэхэд нь Туслах

Есүс Христийн сайн мэдээгээр амьдрагчдын ихэнх хэсэг нь бие биендээ үйлчилж сурдагт байдаг. Бид тахир дутуу хүмүүст бусдад чадамжийнхаа бүх хэмжээгээр үйлчлэхэд нь туслах ёстой.

Түүх

Бие бялдрын чадваргүйгээ үл харгалзан идэвхтэй үйлчилсэн Ахлагч Жо Фолкетийн дараах түүхийг унш:

“[Жо Фолкет арван дөрвөн настай байхдаа нуруундаа цусны нөжтэй болж зовжээ.] Зөвхөн саяд ганцхан хүн энэ өвчнөөр зовдог. Ихэнхдээ тэд дунд хирийн насных байдаг бөгөөд оюун ухааны гажигтай тархины гэмтэлтэй болдог буюу бүр үхдэг байна.

“Жогийн хөлнөөс бусад нь бүрмөсөн аврагджээ. . . .

“Сүүлд нь ангид номлолын тухай ярилцлага болоход түүний үйлчилнэ гэсэн эрмэлзэл огцмоор анхааралд нь орж иржээ. Түүнийг ганцааранг нь үлдээхгүй буюу ичээхгүйн тулд багш, ‘Мэдээж Жо чөлөөлөгдсөн. Тэр тэрэгтэй явах боломжгүй,’ гэж хэлэв.

“‘Тэгж хэлсэн нь үнэхээр намайг бүр ч асаасан юм,’ гэж Ахлагч Фолкет уулга алдав. Миний хамгийн түрүүний хариулт ‘Өө, би явна,’ гэдэг байв. Түүнээс хойш удалгүй шийдвэрийг нь баталсан сайн мэдээг тунхаглахаар үйлчлэхийг мэдэгдсэн патриархын адислалаа авчээ.

“Жо 19 настай байхдаа Английн Манчестерт номлолд явжээ.

“Тэр тэрэгтэй үйлчлэхийн тустай талуудыг олжээ. ‘Би бол хоёр жилийн турш ганцхан хос гуталтайгаар үйлчлэх номлогч байх нь,’ гэж тэр хошигнож байв. ‘Үүнийг би Лисестерийн зах дээр 13 паундсаар (ойролцоогоор 12 америк доллар) авсан бөгөөд тэд шинэ юм шиг л сайн.’ . . .

“Жо номлолдоо олон удаа адислагджээ. Жишээ нь, түүний Кевин Смиттэй уулзсан өдөр. . . .

“Кевин хожмын үеийн гэгээнтэн охиноор . . . дамжуулан Сүмийг сонирхож Мормоны Ном . . . авахыг хүсжээ. Жо болон түүний хамтрагч хоёр түүний судрыг сайн дураараа аваачиж өгөхөөр болов.

“‘Тэр үед би номлогчдыг гэртээ урихад хүрэн Сүмийг сонирхож байлаа’ гэж 16 жил дугуйтай сандалд сууж байгаа Кевин хэлэв. ‘Миний Мормон ахлагч нарын тухай хэвшмэл төсөөлөл бол коллежоос дөнгөж ирсэн сайхан костюм пиджак өмссөн ооны сурталчилгаан дээрхтэй адил инээмсэглэсэн өндөр залуу Америк хүү байв. Хэрэв тэд тийм харагдсан бол би магадгүй хаалгаа онгойлгохгүй байх байсан. Гэвч хоёр ердийн хүн нэг нь тэрэгтэй байсан нь миний гайхшлыг төрүүлсэн юм.

“‘Кевин маш сайн залуу,’ хэмээн дугуйтай сандалд суусан сонирхогчоо хараад Ахлагч Фолкет онцлон хэлэв. ‘Бид түүний гэр рүү явахаас өмнө надад тохиолдох зүйлийн талаар сайхан сэтгэгдэлтэй байсан.’

“Ахлагч Фолкет Кевин хоёр уулзсан цагаасаа сайн найзууд болсон бөгөөд тэр эхний ярилцлагаас хойш нэг их удалгүй Жо Кевинийг усаар баталсан.

“Тахир дутуу хүн хил хязгаарын гадна аялж саад бэрхшээлийг адислал болгон эргүүлэх (Ахлагч Фолкетын) гэрчлэлийн оч энэ юм” (Anne C. Bradshaw, “A Mobile Work and a Wonder,” *New Era*, Mar. 1991, pp. 28–32).

- Номлогчийн хувьд Ахлагч Фолкет хүмүүсийн амьдралыг хэрхэн адислаж чадсан бэ? (Тэр нэр хүндтэйгээр үйлчилж, яг бусад номлогчийн адил сайн мэдээг түгээсэн.)
- Их Эзэнд болон бусдад амжилттай сайн үйлчлэх боломжтой байхдаа бид ямар сэтгэгдэлтэй болдог вэ?
- Тахир дутуу хүмүүст бусдад үйлчилж, бидэнтэй адил сэтгэл ханамжтай байхад нь бид хэрхэн тусалж чадах вэ? (Бид бусдад тусалдагтай адил тэдэнд үйлчлэл хийхэд бэлтгэхэд нь туслах ёстой.)

Дүгнэлт

Уриалга

Тахир дутуу хүмүүсийг ойлгож, тэдэнд сайн мэдээг сурахад нь тусалж, чуулгын хичээл болон үйл ажиллагаануудад оролцоход нь тусалж, тэднийг зоригжуулж, бусдад үйлчлэхэд нь тэдэнд туслахыг залуу эрэгтэйчүүдэд уриал. Тийм хүч чармайлтаар ирэх адислалуудын талаар гэрчлэлээ хуваалц.

Зөвлөхөд хандах нь: Ерөнхий Чуулганы Яриануудаар Хичээл Бэлтгэх нь

51

ЗОРИЛГО

Залуу эрэгтэй бүр Их Эзэн Түүний сонгосон удирдагчаар амьдралаа хөтлүүлэх тухай юу хэлснийг сурах болно.

БЭЛТГЭЛ

Уг гарын авлагын хичээлүүдийг заахдаа эдгээр хичээлүүдийг бэлтгэж заах адилхан журмыг дага. Үүнээс гадна бэлтгэл хийх дараах алхмууд тустай байх болно:

1. Сонгосон үгэнд сайн мэдээний ямар зарчим эсвэл гол санааг заасан болохыг залбиралтайгаар бод. Гол санаанд орж байгаа хоёр, гурван туслах санааг илэрхийл.
 2. Хичээлийн үр дүн болгож та нар юу хийхийг хүсч байгаагаа бод. Тухайлбал та ангийн гишүүдэд зарчмыг ойлгоход нь, итгэлээ хөгжүүлэхэд нь, хандах хандлагаа төлөвшүүлэх буюу ааш зангаа өөрчлөхөд нь туслахыг хүсч байна уу?
 3. Хичээлийнхээ материалуудыг бэлтгэ. Англиас бусад хэл дээр судрын нэмэлт ишлэлүүдийг олохын тулд байгаа Жэймс Хааны Библийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хэвлэл дэх гол Сэдвийн Удирдамжийг ашигла. Цуглааны байрны номын санчаас тохирох үзүүлэнгүүдийг асуу.
 4. Сонгосон ишлэлүүд болон хандаж хэлсэн үгэн дэх судруудын талаарх асуултуудаа бэлтгэ. Ишлэл ба судрууд ямар утгатай вэ? Тэдгээрийг залуу эрэгтэйчүүдтэй харьцуул.
 5. Залуу эмэгтэйчүүдийг хамруулах заах аргуудыг сонгож, оролцох ангийн гишүүдийг томил. Заах аргуудын талаар тайлбар олохын тулд Teaching –No Greater Call (33043)-ын заах арга барилын тайлбар руу ханд.
-

ТАЙЛБАР

Амьд бошиглогчдын үгс бол нэмэлт хичээлүүдэд сайхан эх сурвалж болдог. Ensign болон олон улсын сэтгүүлүүдэд хэвлэгдсэн тухайн үеийн чуулган дээр өгөгдсөн яриануудыг сонго. Эдгээр хичээлүүдийг бэлтгэж, заах нь та нарт Сүнсээр удирдуулан ангийн гишүүдийн онцгой хэрэгцээнд хандаж ярих боломжийг өгнө. Залуу эрэгтэйчүүдэд ярилцлагад бэлтгэлтэй байхын тулд хэлсэн ямар үгнүүдийг заахыг урьдчилан мэдэгдсэн байх хэрэгтэй. Эдгээр хичээлүүдийг өрнүүлэхдээ Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн сургаалууд, чуулганаас хандаж хэлсэн үг ба судруудыг ашигла.

ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Дараах үзүүлэн болон хэлсэн үгнээс хичээл бэлтгэхэд тустай байж болно.

Өгсөн ярианы гарчиг: _____

Сайн мэдээний зарчим буюу гол санаа: _____

Туслах санаа: _____

<p>1. Сайн мэдээний зарчим ба туслах санааг танилцуул.</p>	<ul style="list-style-type: none"> • Самбар дээр сайн мэдээний зарчим болон туслах санаануудыг бич. Хичээлээ танилцуулахдаа үзүүлэнтэй хичээл, түүх, зураг, судар эсвэл бодоход өдөөх асуултуудыг ашигла.
<p>2. Хичээлийн гол санааг танилцуул.</p> <ul style="list-style-type: none"> • Сайн мэдээний тухай Их Эзэн юу хэлсэн бэ? • Өнөөдөр энэ тухай бошиглогчид юу хэлдэг вэ? • Өдөр тутмынхаа амьдралд сайн мэдээний зарчмыг бид хэрхэн ашиглаж чадах вэ? Энэ зарчмаар амьдрах нь бидний итгэлийг хэрхэн нэмэгдүүлэх буюу зөв шударга шийдвэр гаргаж асуудлуудаа шийдвэрлэхэд тусалж чадах вэ? 	<ul style="list-style-type: none"> • Сайн мэдээний зарчмыг тодруулахын тулд яриа юмуу нэмэлт судрууд дахь судруудыг олж, ярилц. • Ярилцлагаас ишлэлүүдийн тухай асуултууд тавь. Сайн мэдээний зарчмыг үзүүлэхийн тулд ярианаас түүх ба жишээнүүдийг ярь. • Асуултууд асууж, залуу эрэгтэйчүүд сайн мэдээний зарчмыг амьдралдаа хэрэглэхэд туслах ярилцлага руу чиглүүл. • Ярилцаж байгаа сэдвээрээ ангийн гишүүдийг туршлага, мэдрэмж, гэрчлэлээ хуваалцахыг урь. Өөрийнхөө сэтгэгдлийг нэмж хэл.
<p>3. Заасан зүйлээ хураангуйлан дүгнэлт хий.</p>	<ul style="list-style-type: none"> • Заасан сайн мэдээний зарчмынхаа үнэнийг мөн өөрийнхөө амьдрал дахь сайн мэдээний үнэ цэнийг гэрчил.

















ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮГИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

